



**АВЛИГАТАЙ  
ТЭМЦЭХ ГАЗАР**

ШУДАРГА ЁС, ХӨГЖИЛ ДЭВШИЛД

**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ХУУЛЬ  
ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ,  
АВЛИГЫН ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ-2019,  
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ  
ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ (I ҮЕ ШАТ)**

**2020 он**



# 110

Гомдол, мэдээлэл хүлээн авах  
утас /үнэ төлбөргүй/

# ГАРЧИГ

## АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

### БҮЛЭГ

Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгчийг хамгаалах тухай хуулийн Төслийн саналыг УИХ-ын даргад хүргүүлэв.....	8
Авлигын эсрэг хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулахаар хуулийн төслийн санал боловсруулав.....	8
Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн цахим мэдээллийн нэгдсэн сантай болов.....	9
Дүрэм, журам, шийдвэр хянасан байдал.....	10
Ёс зүйн дүрмийн төслийг хянав.....	11
Зөвлөмж хүргүүлэв.....	11
Гэмт хэрэг гарсан шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар мөрдөгчийн мэдэгдэл хүргүүлэв.....	12
Төрийн байгууллагуудад ажиллав.....	13
Төрийн таван байгууллагын цахим мэдээллийн нэг хайлтын системд орууллаа.....	14
110 тусгай дугаарын утсыг ажиллуулж эхэллээ.....	14
Сахилгын шийтгэл хүлээсэн этгээдийг нийтэд мэдээлж байна.....	15
Элсэлтийн бүртгэлийн явцыг хянав.....	15
“Үнэт зүйлийн боловсрол” арга хэмжээг зохион байгуулав.....	16
Залуус авлигын эсрэг “Цахим шийдэл” сэдвийн дор чууллаа.....	17
Хуулийн байгууллагуудын нэгдсэн зөвлөгөөн зохион байгуулав.....	22
“Авлигатай тэмцэх газар–Танай хороонд” соён гэгээрүүлэх өдөрлөг зохион байгуулав.....	25
“Найзын яриа” өдөрлөг зохион байгуулав.....	25
Авлигын эсрэг номын булан нээв.....	26
Хэлэлцүүлгүүд зохион байгуулав.....	27
Иргэний хяналтын төв.....	31
Оюутан залуусын дунд “Түлхүүр” уралдаан.....	32
“Хүн болох багаасаа” эссэ бичлэгийн уралдаан.....	32
“Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд дэвшилтэт аргыг нэвтрүүлэх нь” илтгэлийн уралдаан.....	33
“Миний мэдэх шударга ёс” гар зургийн уралдаан.....	33
Нийслэлийн 170 хороонд авлигын эсрэг самбар байршуулав.....	34
“Авлигыг мэдээлж, Жигш” клубыг байгуулав.....	34
Авлигын эсрэг сургалт.....	35
Сургалтын бүртгэлийн нэгдсэн системийг нэвтрүүллээ.....	36
Хөрөнгө орлогын мэдүүлэгч гаргагч нарт зориулсан сургалт.....	36
Тусгайлсан сургалтууд.....	37
Гарын авлага, сурталчилгааны материал бэлтгэж хэвлүүлэв.....	39
Урлаг, спортын төлөөлөл авлигын эсрэг сурталчилгаанд манлайлан оролцож байна.....	41
Иргэний хяналтын зөвлөл.....	42
Хэвлэл, мэдээлэлтэй харилцах чиглэлээр.....	42
Ази, номхон далайн орнуудын хөрөнгө буцаах байгууллагуудын сүлжээ/ARIN-AP/-ний VI бүгд хурлыг зохион байгуулав.....	43
Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага Монгол Улсын авлигын эсрэг орчин, үйл ажиллагааны тайланг танилцуулав.....	46
“Авлигатай тэмцэх газар–Танай аймагт” соён гэгээрүүлэх өдөрлөг.....	53
“Олон нийтийн хяналт ба шударга ёс” сэдэвт уулзалт.....	54
Гомдол, мэдээлэл хүлээн авч, боломжтой тохиолдолд газар дээр нь шийдвэрлэн, зөвлөгөө, мэдээлэл өгөв.....	55
Нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллагын албан тушаалтнуудад	



Тусгайлсан сургалт зохион байгуулав.....	55
Зөвлөмжийн хэрэгжилттэй танилцав .....	56
Орон нутагт илэрч буй нийтлэг зөрчлүүд.....	57
ХАСХОМ-ийн хяналт шалгалтын талаар .....	59
Хууль бус, нуугдмал орлогыг илрүүлэхээр татварын байгууллагатай хамтран ажиллаж байна.....	59
Давхар ажил эрхлэлтэд хяналт тавив .....	61
Ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийн хяналт шалгалт.....	62
ХАСУМ-ийг цахимаар авч, хянаж эхэллээ .....	64
Ашиг сонирхлын зөрчилтэй этгээдийг нийтийн албанд томилохгүй байх бодлогын хэрэгжилт.....	65
Мэдүүлгийн дүн бүрдүүлэлт.....	66
Нийтийн албан тушаалтны ХОМ-т иргэд хяналт тавих аргачлалд сургав .....	66
Мөрдөн шалгах ажиллагаа.....	67
Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн тоо .....	68
Мөрдөн шалгасан хэргийн шийдвэрлэлт .....	69
Дүгнэлт, санал.....	71

## АВЛИГЫН ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ-2019

Төрийн байгууллагын шударга байдлын үнэлгээ.....	85
Авлигын ерөнхий нөхцөл байдлын талаарх төсөөлөл.....	87
Авлига тархсан институцийн талаарх төсөөлөл.....	88
Төрийн байгууллагуудын авлигын эрсдэлийн үнэлгээ .....	88
Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгаа .....	89
“Дээд боловсролын салбар, орчин дахь ёс зүйн асуудал” судалгаа .....	90
Хүүхдийн шударга байдлын судалгаа.....	91
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн авлигын талаарх ойлголт хандлагыг тодорхойлох судалгаа.....	92
Авлигын төсөөллийн индекс .....	93
Авлигын хяналтын үзүүлэлт .....	94
“TRACЕ” хээл хахуулийн эрсдэлийн матрицын үнэлгээ.....	95



## АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР, ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ (I ҮЕ ШАТ)

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт (I үе шат) .....	96
ДҮГНЭЛТ, САНАЛ.....	249

# НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Авлигатай  
ТЭМЦЭХ хууль  
ТОГТООМЖИЙН  
ХЭРЭГЖИЛТ





## МОНГОЛ УЛСЫН АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ



*Авлигатай тэмцэх газар нь Монгол Улсад шударга ёсыг бэхжүүлэх, төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах, хүнд суртал, чирэгдлийг арилгах, авлигын гэмт хэргийг илрүүлэх, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах, хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах, хянан шалгах талаар цогц арга хэмжээг хэрэгжүүлэн, авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх ажлыг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллага, иргэдийн өргөн оролцоотойгоор улсын хэмжээнд зохион байгуулав.*

*Монгол Улсын Их Хуралд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Эрцүгийн болон Эрцүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, УИХ-ын 2007 оны 07, 2008 оны 13, 2011 оны 55, 2012 оны 55, 2016 оны 51, 84, 2019 оны 67 дугаар тогтоол, УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 5 дугаар тогтоолын биелэлт болон авлигын ерөнхий нөхцөл байдал, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг мэдээлж байна.*

## Авлигатай тэмцэх газрын даргаар З.Дашдаваа, дэд даргаар Ж.Батсайхан нар томилогдов

Монгол Улсын Их Хурлын 2019 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Авлигын эсрэг хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалтыг үндэслэн Зандраагийн Дашдавааг Авлигатай тэмцэх газрын даргаар, Жанжаагийн Батсайханыг Авлигатай тэмцэх газрын дэд даргаар томиллоо.



## Бүтэц, орон тоо, албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоов

УИХ-ын хаврын чуулганы хуралдаанаар “Авлигатай тэмцэх газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлж, төслийг хуралдаанд оролцсон гишүүдийн 69.6 хувь нь дэмжиж баталгаажуулав.



## УИХ-ын дарга Г.Занданшатар Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагаатай танилцав

Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар (2019.05.14) Авлигатай тэмцэх газрын удирдлагуудтай уулзаж, үйл ажиллагаатай нь танилцлаа. УИХ-ын дарга байгууллагын үйл ажиллагаатай биечлэн танилцан, үүрэг өгөв. Тэрээр "Хахууль авсныг илрүүлж шийтгэхээс илүү авахаас нь өмнө урьдчилан сэргийлэх ажил та бүхний гол зорилго. Тиймээс соён гэгээрүүлэх ажилд онцгой анхаарах шаардлагатай" байгааг онцлов. УИХ-ын даргыг АТГ-ын үйл ажиллагаатай танилцахад УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан болон албаны бусад хүмүүс оролцлоо.






## НИЙТИЙН АШИГ СОНИРХЛЫН ТӨЛӨӨ ШҮГЭЛ ҮЛЭЭГЧИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН САНАЛЫГ УИХ-ЫН ДАРГАД ХҮРГҮҮЛЭВ

УИХ-ын даргын өгсөн чиглэлийн дагуу Авлигатай тэмцэх газраас Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг хамгаалах тухай хуулийн төслийг боловсруулав. Энэ хүрээнд Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.2-т заасан бүрдүүлбэрт хамаарах “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааны тайлан”, “Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч (илчлэгч)-ийг хамгаалах тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ”, “Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч (илчлэгч)-ийг хамгаалах тухай хуулийн төслийн зардлын тооцоо” зэрэг үнэлгээ, судалгааны ажлыг гүйцэтгүүлэн УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргад хүргүүлэв.

Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгчийг хамгаалах тухай хуулийн үзэл баримтлалын төсөл, хуулийн төсөл, дагалдан гарах хуулиуд болох Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай зэрэг хуулийн төслийг боловсруулан УИХ-д хүргүүлээ.

Хуулийн төслүүдийг цахим хуудсанд байршуулан олон нийтийн саналыг авч байна.

### Авлигыг мэдээлээгүй шалтгаан юу вэ?




## АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬ ТОГТООМЖИД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХААР ХУУЛИЙН ТӨСЛИЙН САНАЛ БОЛОВСРУУЛАВ

Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр судалгаа хийж, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн саналыг хууль санаачлагчдад уламжлаад байна.




# АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНТАЙ БОЛОВ

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр нь “Төрийн байгууллага, албан тушаалтан, хувийн хэвшил, иргэний нийгэм, улс төрийн нам, бүлгийг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, олон нийтэд шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх, ил тод, нээлттэй, хариуцлагатай нийгмийг хөгжүүлэх” зорилгоор Улсын Их Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн 51 дүгээр тогтоолоор батлагдсан билээ. Үг зорилгод хүрэхээр 11 зорилтыг дэвшүүлж, 83 үйл ажиллагааг 2016-2023 он хүртэл 2 үе шаттайгаар хэрэгжүүлж байна.



Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх тайлан, мэдээг цахимаар авч, хяналт шинжилгээ, үнэлгээ хийж байна. Өөрөөр хэлбэл, цаасан тайланг халж байгууллагууд үндэсний хөтөлбөрийн хэрэгжилттэй холбоотой мэдээ тайланг цахимаар ирүүлэх, тухай бүр баяжилт хийх боломжийг бүрдүүллээ.





## ДҮРЭМ, ЖУРАМ, ШИЙДВЭР ХЯНАСАН БАЙДАЛ

Авлигатай тэмцэх газрын ажлын хэсэг 2017, 2018 онуудад 21 аймагт ажиллахдаа төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан тушаал, шийдвэр, баталсан дүрэм, журмыг хянаж, тухай бүрт зөвлөмж хүргүүлсэн. 2019 онд өмнөх онуудад хүргүүлсэн зөвлөмжийн биелэлттэй танилцав.

Хүргүүлсэн зөвлөмжид тусгагдсан тушаал, шийдвэр, дүрэм, журмыг хүчингүй болгох, хууль тогтоомжид нийцүүлэх, улсын бүртгэлд бүртгүүлэх арга хэмжээг аймгууд нийтлэг байдлаар авч хэрэгжүүлж, зөвлөмжийн биелэлтийг ханган ажилласан байна.


Тухайлбал, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-т “хуульд заасан хязгаар, шаардлагад нийцүүлэн орон нутгийн зарим татвар, төлбөр, хураамжийн хувь хэмжээг тогтоох” эрхийг зөвхөн ИТХ-д олгосон байхад дээрх заалтыг зөрчин Иргэдийн

Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчид өөрт олгогдоогүй эрхийг хэрэгжүүлж, шийдвэр гаргасныг хүчингүй болгох тогтоол гарган, дахин Иргэдийн төлөөлөгчдийн хурлаараа хэлэлцэж баталсан байна.

Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсэгт “Захиргааны хэм хэмжээний актыг хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллага батална” гэж заасныг зөрчсөн, мөн хуулийн 65 дугаар зүйлийн 65.1-д заасны дагуу хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлж, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлээгүй хэм хэмжээний зөрчилтэй актыг нөхөн бүртгүүлж, заримыг нь хүчингүй болгожээ.

Хууль бус төлбөр хураамж тогтоосон дүрэм, журмыг хүчингүй болгож, хэм хэмжээ тогтоосон зарим актыг дахин хэлэлцэж, хууль тогтоомжид нийцүүлэн баталсан байв.

### Дүрэм, журам хүчингүй болгох, өөрчлөх санал хүргүүлсэн дүнг аймгуудаар харуулбал:



Орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, аймгийн Засаг даргын захирамж, Засаг даргын Тамгын газрын даргын тушаалаар батлан мөрдүүлсэн хууль тогтоомжид нийцээгүй, хуулиар эрх олгоогүй байхад дүрэм, журам тогтоон мөрдүүлсэн, үндэслэлгүй төлбөр, хураамж тогтоосон нийт **91** журмыг хянан үзэж өөрчлөх, хүчингүй болгох саналыг хүргүүлсэн.

## ЁС ЗҮЙН ДҮРМИЙН ТӨСЛИЙГ ХЯНАВ

Авлигатай тэмцэх газраас 2019 онд төрийн болон төрийн өмчит байгууллагаас ирүүлсэн ёс зүйн дүрмийн төслийг хянан үзээд төслийг сайжруулах, чанаржуулахад чиглэсэн нийт 19 заалтад өөрчлөн найруулах, 25 заалт нэмэх, 1 заалтыг хуульд нийцүүлэх, 1 заалтыг хасах санал гаргасан байна. Төсөлд санал өгсөн байгууллагуудаас Нийслэлийн газрын албанаас ирүүлсэн Нийслэлийн газрын албаны албан хаагчийн ёс зүйн дүрмийг дахин боловсруулалтад буцаав.

Ёс зүйн дүрэмд санал өгсөн байдлаас үзэхэд төрийн захиргааны байгууллагын ёс зүйн дүрэмд дүрмийн нэршил өөрчлөх чиглэлээр 1, заалтын утга агуулга тодорхой болгох, хэл зүйн хувьд дахин

найруулах чиглэлээр 8, ёс зүйн хорооны ажиллах журмын зохицуулалт бий болгох чиглэлээр 1, Засгийн газрын тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм”-д нийцүүлэх чиглэлээр 1 заалт байна.

Төрийн өмчит хуулийн этгээдэд давхардсан утга агуулга бүхий заалтыг нэгтгэхээр 1, өөрчлөн найруулахаар 4, нэмж тусгахаар 3 саналыг тус тус гаргасан байх бөгөөд 1 байгууллагад нь төслийг “дэмжсэн” санал хүргүүлжээ.

Салбарын албан хаагчдын ёс зүйн дүрмийн төсөлд нэмэлт зохицуулалт оруулах 22, өөрчлөн найруулах 3 санал байх бөгөөд улс төрийн албан тушаалтны ёс зүйн дүрмийн төсөлд өөрчлөн найруулах 5, өөрчлөх болон хасах санал тус тус нэгийг гаргасан байна.

### Тухайлбал,

Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрмийн төсөл

Эрчим хүчний салбарын төрийн өмчит байгууллагын ажилтны ёс зүйн дүрэм

Нийслэлийн газрын албаны албан хаагчийн ёс зүйн дүрэм



Таван толгой түлш ХХК-ий ёс зүйн дүрмийн төсөл

Дулааны 2 дугаар цахилгаан станци төрийн өмчит хувьцаат компаний ажилтнуудын ёс зүйн дүрмийн төсөл

УИХ-ын гишүүний ёс зүйн дүрмийн төсөл

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний албан хаагчдын ёс зүйн дүрмийн төсөл

## ЗӨВЛӨМЖ ХҮРГҮҮЛЭВ

Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор 21 аймагт нийт 236, Монгол Улсын Засгийн газарт 47, Гадаад харилцааны яаманд 2, Зам, тээврийн хөгжлийн яаманд 13, Эрүүл мэндийн яаманд 11, БСШУСЯ-нд 13, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид 11 асуудал бүхий зөвлөмж хүргүүлэн, хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих, биелэлтийг тооцох чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллав.

Зөвлөмжийг хэрэгжүүлэх хүрээнд илэрсэн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх, эрсдэлээс хамгаалах чиглэлээр арга зүйн туслалцаа үзүүлэх, албан хаагчдыг авлигын эсрэг сургалтад хамруулах, чадавхжуулах, цахимжуулах чиглэлээр хамтран ажилласны дүнд төрийн үйлчилгээний хүнд суртлыг арилгах, нээлттэй, ил тод байдлыг хангах, хариуцлагыг дээшлүүлэх, шударга ёсны үнэлэмжийг сайжруулах чиглэлээр ахиц гарч байна.



## ГЭМТ ХЭРЭГ ГАРСАН ШАЛТГААН, НӨХЦӨЛИЙГ АРИЛГУУЛАХААР МӨРДӨГЧИЙН МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭВ

### Мөрдөгчийн мэдэгдэл хүргүүлсэн байгууллага:

1. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар;
2. Зам, тээврийн хөгжлийн яам;
3. Цагдаагийн ерөнхий газар;
4. Автотээврийн үндэсний төв ТӨҮГ;
5. Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан;
6. Нийгмийн даатгалын ерөнхий газар;
7. Гаалийн ерөнхий газар;
8. Дорноговь аймгийн Засаг дарга;
9. Говь-Сүмбэр аймгийн Засаг дарга;
10. Сүхбаатар аймгийн Засаг дарга;
11. Төв аймгийн Засаг дарга;
12. Баян-Өлгий аймгийн Засаг дарга;
13. Сэлэнгэ аймгийн Цагдаагийн газар;
14. Сүхбаатар аймгийн Цагдаагийн газар;
15. Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Цагдаагийн хэлтэс;
16. Дорноговь аймгийн Цагдаагийн газар;
17. Дундговь аймгийн Цагдаагийн газар;
18. Говь-Алтай аймгийн Цагдаагийн газар;
19. СХД-ийн Цагдаагийн газрын III хэлтэс;
20. СХД-ийн Цагдаагийн газрын I хэлтэс;
21. БЗД-ийн Цагдаагийн I хэлтэс;
22. Чингэлтэй дүүргийн Цагдаагийн газрын II хэлтэс;
23. БЗД-ийн Цагдаагийн газрын III хэлтэс;
24. Налайх дүүргийн Цагдаагийн хэлтэс;
25. ХУД-ийн Замын цагдаагийн хэлтэс;
26. ЦЕГ-ын Мөрдөн байцаах алба;
27. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар;
28. Төрийн банк;
29. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламж ХХК;
30. Хил хамгаалах ерөнхий газар;
31. Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газар зэрэг 43 байгууллагад авлигын гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар мөрдөгчийн мэдэгдэл хүргүүлэв.

Авлигатай тэмцэх газраас мөрдөгчийн мэдэгдэл хүргэгдсэн байгууллагад ажиллаж гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгасан байдлыг шалгав. Тухайлбал,

“Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ нь тухайн авлигын гэмт хэрэг гарах болсон шалтгаан, нөхцөлийг бүрэн арилгаагүй, мөрдөгчийн мэдэгдэл дурдсан зарим арга хэмжээг огт хэрэгжүүлээгүй байна. Иймд авлигын гэмт хэрэг давтан гарахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөмж хүргүүлж, зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж ажиллав.

Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас мэдэгдлийн мөрөөр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлсэн нь сайшаалтай боловч хариуг хуулийн хугацаанд ирүүлээгүй байна. Авлигатай тэмцэх газраас өгсөн чиглэлийн дагуу тус Сангаас зээл олгох журмыг шинэчлэн Засгийн газрын хуралдаанаар батлуулав.

Төв аймгийн Сэргэлэн, Эрдэнэ сумдын ИТХ, Засаг дарга хууль зөрчсөн шийдвэрүүдээ хүчингүй болгосон байх боловч, авлигын гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг бодитой арилгах талаар удирдлагын зүгээс ямар ч санал, санаачилга гаргаагүй байна. Тухайлбал, гэмт хэрэг гарснаас хойшхи иргэд, аж ахуйн нэгжид газар эзэмшүүлэх, ашиглуулах, өмчлүүлэхдээ Газрын тухай хууль, журам, дүрмийг баримтлахгүйгээр, газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй газарт олголт хийх, дуудлага худалдааг “Газрын цахим бирж”-ээр зарласан гэх ч оролцогчгүй явуулах, иргэдэд мэдээллийг хүртээмжтэй хүргэхгүйгээр зохион байгуулах, хувийн хэргийн бүртгэлийг журмын дагуу хөтөлдөггүй, газар зохион байгуулалтын үйл ажиллагаа эмх цэгцгүй, хүсэлт, өргөдөл, гомдол шийдвэрлэх тогтсон арга барилгүйгээс иргэдээс ирүүлсэн асуудлыг хугацаанд нь шийдвэрлэх, хариуг хуулийн дагуу иргэнд өгөх ажил туйлын хангалтгүй зэрэг ноцтой зөрчлүүд арилаагүй, давтагдсан хэвээр байна.

## ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДАД АЖИЛЛАВ

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт төрийн үйлчилгээний нээлттэй, ил тод байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар, хүртээмжийг нь сайжруулах, мэдээллийг ил тод байлгах талаар тусгасан. Энэ хүрээнд Авлигатай тэмцэх газрын албан хаагчид яам, агентлаг, нийслэл, дүүргүүдэд ажиллаж, төрийн үйлчилгээний шат дамжлагыг бууруулах, авлига ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллав.



Гадаадын иргэн, харьяатын газрын Виз, зөвшөөрөл, харьяатын газарт ажиллаж, үйл ажиллагаа, мэдээллийн ил тод байдал, хүнд суртал, чирэгдэлтэй үйл ажиллагааны шалтгаан, нөхцөлийг тодорхойлох, хууль тогтоомж зөрчиж байгаа эсэхэд хяналт, шалгалт хийж “Хилийн боомт дээрх визийн зөвшөөрөл”, “Олон удаагийн бизнес ангиллын орох, гарах визийн зөвшөөрөл” гэсэн хоёр үйлчилгээг цахимаар шууд бүртгэж, хүлээн авч, олгохоор шийдвэрлүүлээ.



Амьтан, ургамал тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх тохиолдолд импортын мэдэгдэл, экспорт, импортын гэрчилгээ олгох үйлчилгээний нөхцөл байдлыг тодорхойлж, 8 зүйл бүхий зөвлөмжийг хүргүүлсэн.

“Экспорт, импортын гэрчилгээ, мэдэгдэл авахаар гаргасан хүсэлтийг шийдвэрлэх журам”-ыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2019 оны А/81 дүгээр тушаалаар баталж, иргэд, аж ахуйн нэгжид учирдаг хүндрэл, чирэгдлийг арилгасан байна.



Жолооны үнэмлэхний бэлдэц тасарсан гэдэг шалтгаанаар үнэмлэх хэвлэгдэхгүй, түр үнэмлэх олгодог, иргэдэд хүнд суртал, чирэгдэл учирдаг энэ байдлыг арилгах, жолооны үнэмлэх захиалах, олгох үйл ажиллагааг цахимжуулах, нээлттэй болгох боломжийг бүрдүүлэхээр Цагдаагийн ерөнхий газрын Бүртгэл, хяналтын төвд ажиллав.



ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ЯАМ

Төрийн захиргааны удирдлагын газрын тусгай зөвшөөрлийн асуудал хариуцсан албан хаагч, орон тооны бус шинжээчид аж ахуйн нэгжүүдээс тусгай зөвшөөрлийн хүсэлт, төслийг хүлээн авч, шийдвэрлэхдээ зохиомол хүнд суртал гаргаж, хясан боогдуулах замаар хахууль авсан, хамаарал бүхий иргэний нэр дээр компани үүсгэн байгуулж, эм, эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэх тусгай зөвшөөрлийг хууль бусаар гаргуулж, эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашигласан хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж буйтай холбогдуулан гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг тогтоох, дахин гарахаас урьдчилан сэргийлж, таслан зогсоох зорилгоор Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн хөгжлийн төвд ажиллав. Ажиллах явцад авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэгч 9 төрлийн шалтгаан, нөхцөлийг илрүүлэн тогтоож, эрсдэл, зөрчлийг арилгуулахаар Эрүүл мэндийн сайдад зөвлөмж хүргүүлсэн.



## 110 ТУСГАЙ ДУГААРЫН УТСЫГ АЖИЛЛУУЛЖ ЭХЭЛЛЭЭ



Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 4.1.5.5-д “Авлига албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийн талаар мэдээлэл авах үйл ажиллагааны арга хэлбэрийг сайжруулах, гомдол, мэдээлэл утсаар өгөх боломжийг бүрдүүлэх” зорилт тусгагдсан билээ.

Авлигатай тэмцэх газар нь гомдол, мэдээлэл хүлээн авах зорилгоор 2007 оноос 1969, 2014 оноос 1800-1969 дугаарын утсыг ажиллуулж байсан бөгөөд тус газар нь 2019 оны эхний 9 сарын байдлаар нийт 1416 гомдол, мэдээлэл хүлээн авсны 192 буюу 13 хувийг утсаар ирсэн нь мэдээллийн сувгийг өөрчлөх, урсгалыг нэмэгдүүлэх шаардлага байгааг харуулж байсан тул 2019 оны 4 дүгээр улирлаас иргэдийн гомдол, мэдээллийг 110 тусгай дугаарын утсаар хүлээн авах болмоо. Гомдол, мэдээлэл хүлээн авах цээжлэхэд амар, тогтооход хялбар, ярианы төлбөргүй “110” тусгай дугаарын утсыг ажилд оруулснаар иргэд авлига,

ашиг сонирхлын зөрчил, авлигын гэмт хэрэг, хүнд сурталтай үйлчилгээ, албан тушаалтны ёс зүй, зүй бус шаардлагын талаарх мэдээллийг түргэн шуурхай хүргэх боломжтой болсон. Энэхүү мэдээллийн суваг нь гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үйл ажиллагааг шинэ арга хэлбэрт шилжүүлэхэд дэмжлэг болохын зэрэгцээ системийн тусламжтайгаар мэдээллийн сан үүсгэж, түүн дээр суурилан авлигын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх сургалтыг үе шаттайгаар, илүү үр дүнтэй, давхардал, хийдэлгүй зохион байгуулах нөхцөл бүрдэж байна. Гомдол мэдээлэл хүлээн авах “110” дугаарын утсыг олон нийтэд таниулах ажлыг өргөн хүрээнд зохион байгуулсны дүнд гомдол, мэдээлэл хүлээн авах утасны програмд 2017 оны сүүлийн хагас жилд нийт 125, 2018 онд 249 дуудлага ирж байсан бол 2019 онд 110 тусгай дугаарын утсаар зөвхөн 2019 оны 10 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 4464 удаагийн дуудлага бүртгэгдсэн байна.

## ТӨРИЙН ТАВАН БАЙГУУЛЛАГЫН ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙГ НЭГ ХАЙЛТЫН СИСТЕМД ОРУУЛЛАА

Авлигатай тэмцэх газар, Нээлттэй нийгэм форум зэрэг байгууллагуудын дэмжлэгтэйгээр “Гэр, иргэдийн оролцоотой амьдрах орчны зураглалын төв” ТББ санаачлан төрийн таван байгууллагын нээлттэй, цахим мэдээллийг нэг хайлтын системд орууллаа.

www.opendatalab.mn хайлтын систем нь анхдагч эх сурвалжийн мэдээллийг засваргүй, ашиглахад хялбар, хүртээмжтэй байдлаар нэгтгэсэнээрээ онцлог юм. Энэхүү хайлтын системд хөрөнгө, орлогын мэдүүлэг, худалдан авах ажиллагаа, улсын бүртгэл,

уул уурхайн лиценз, сонгууль гэсэн категори бүхий 197,085 байгууллага, 489,494 хувь хүн, 17,026 тендер, 73,189 албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлэг, 3,356 уул уурхайн лиценз, 16 визуал дата, бүх сонгуулийн мэдээллийг багтаажээ.



## САХИЛГЫН ШИЙТГЭЛ ХҮЛЭЭСЭН ЭТГЭЭДИЙГ НИЙТЭД МЭДЭЭЛЖ БАЙНА

Авлига, ашиг сонирхлын зөрчлийн эсрэг хууль тогтоомжийг зөрчсөний улмаас сахилгын шийтгэл хүлээсэн нийтийн албан тушаалтан энэ тухайгаа өөрийн зардлаар нийтэд мэдээлэх зохицуулалтыг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлд тусгасан билээ.

“Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам”-ын 4.2-т зааснаар сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийн нэгдсэн сан үүсгэв.

Авлигатай тэмцэх газрын [www.iaac.mn](http://www.iaac.mn) цахим хуудсанд “Сахилгын шийтгэл” хэмээх шинэ цэс үүсгэж, мэдээллийг тогтмол шинэчилж нийтэд мэдээлж байна.

Сахилгын шийтгэл хүлээсэн этгээдийн овог, нэр	A.Мөнхгэрэл
Байгууллагын нэр	Баянзүрх дүүргийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс
Албан тушаал	Хэлтсийн дарга
Сахилгын шийтгэл хүлээлгэсэн үндэслэл	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 23 дугаар зүйлийн 23.5 дахь хэсгийг зөрчсөн Баянзүрх дүүргийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтсийн даргаар томлогдохоор нэр дэвшихэд "Аргабилиг төгөлдөр" ХХК-ийн захирлаар бүртгэлтэй, давхар ажил эрхлэхтэй холбоотой хориглолт хязгаарлалтыг зөрчсөн
Сахилгын шийтгэлийн төрөл	албан тушаал бууруулах
Сахилгын шийтгэл ногдуулсан огноо	11/4/2019
Сахилгын шийтгэл ногдуулсан албан бөмгийн дугаар	01/364
Нийтэд мэдээлсэн огноо	11/28/2019
Нийтэд мэдээлсэн хэлбэр	Цахим хуудас
Нийтэд мэдээлэхэд гарсан зардал	үгүй
АТГ-т ирүүлсэн огноо	11/28/2019

АСУУВАЛ ХАРИУУЛЬЯ  
ГАДААД МЭДЭЭ  
НИЙТЛЭЛ  
НЭВТРҮҮЛЭГ  
ХЭН КЛУ ХЭЛБЭТ  
ЦАХИМ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ  
ИННОГРАФИК  
ӨРГӨДӨЛ ГӨМДЛӨН ШАЙДЭЭЛЭЛТ  
ЗЭҮҮГИЙН ХЭРГИЙН ШАЙДЭЭРЛЭЛТ  
МЭДЭЭЛЛИЙН ХУУДАС  
ҮЙЛ ЯВДЛЫН ТОЙМ  
ОЛОН НИЙТИЙН ЗӨВЛӨЛ  
**САХИЛГЫН ШИЙТГЭЛ**  
ИННОГРАФИК  
21.1% 28.2% 13.6% 17.8% 17.1%  
14.2% 36.2% 48.1% 43.9% 38.1%  
15.2 17.1% 18.2%  
АВЛИГЫН ТӨВЧЛӨЛӨЙН БАРИЛГА

## ЭЛСЭЛТИЙН БҮРТГЭЛИЙН ЯВЦЫГ ХЯНАВ

Авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 2019-2020 оны хичээлийн жилийн элсэлтийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллалаа. Нийслэлийн 6 дүүргийн 29 сургууль, 20 цэцэрлэгийн элсэлтийн бүртгэлийн үйл ажиллагаатай танилцаж, зөрчил дутагдал, түүний шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгахад чиглэсэн арга хэмжээг авав. Өөрөөр хэлбэл, сургууль, цэцэрлэгт шинээр хүүхэд элсүүлэхдээ авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд, ил тод нээлттэй зохион байгуулах талаар зөвлөн туслаж, хяналт тавьсан юм.



# СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

## “ҮНЭТ ЗҮЙЛИЙН БОЛОВСРОЛ” АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАВ



Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг иргэд, оюутан, залуучуудад, төрийн бус байгууллага, хувийн хэвшил, төрийн байгууллагуудад гэсэн зорилтот хэлбэрээр зохион байгуулж байна. 11 дүгээр сарын 23-нд 3000 орчим оюутан, залуучуудад зөв шударга байх, өв уламжлалаа дээдлэн эрхэмлэх, хадгалах, түүчээлэх, үлгэр дүүрайл авах, эерэг, зөв хандлага,



харилцааны соёл, амьдралд сурсан сурааггүйн ялгаа хэрхэн гардаг, хувь хүн хичээх юм бол боломжгүй газар ч боломж байдаг, хэрхэн амжилттай оюутан байж манлайлах вэ зэрэг сэдвийн хүрээнд илтгэл, лекцийг салбар бүрийн төлөөлөл бүхий, олны танил эрхмүүдээр сургалт, ярилцлагын арга хэмжээ зохион байгуулж, “Үнэт зүйлийн боловсрол” илтгэлүүдийн эмхтгэл гаргав.



## ЗАЛУУС АВЛИГЫН ЭСРЭГ “ЦАХИМ ШИЙДЭЛ” СЭДВИЙН ДОР ЧУУЛЛАА

Авлигатай тэмцэх бодлого, зорилтыг хэрэгжүүлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх, шинэ залуу үеийн хандлагыг эерэгээр өөрчлөх, иргэдийн оролцоо, идэвх санаачилгыг дэмжих зорилгоор “Цахим шийдэл” Авлигын эсрэг чуулганыг Авлигатай тэмцэх газраас Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, “Транспэрэнси интернэшнл Монгол” төрийн бус байгууллагатай хамтран 2019 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр зохион байгууллаа.

Шударга ирээдүй рүү тэмүүлсэн эрч хүчтэй, асуудлын шийдлийг олох хүсэлтэй залуус цуглан, сайн засаглал, шуурхай үйлчилгээ, дижитал гарц, олон нийтийн хяналт, тэр дундаа залуусын оролцооны талаар санал, туршлагаа солилцов.

Цаг шаарддаг, олон шат дамжлагатай, дараалал үүсгэн чирэгдүүлдэг, хүнд сурталтай төрийн үйлчилгээг халах дэвшилтэт технологи, дижитал шилжилтийн боломж, шийдлийг танилцууллаа.

### “ЦАХИМ ШИЙДЭЛ” авлигын эсрэг чуулганы онцлох ишлэлүүд

#### *Авлигатай тэмцэх газрын Тамгын хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар З.Баасанням*

...Авлигатай үр дүнтэй тэмцье гэвэл цахим засаглалын асуудлыг шийдвэрлэх ёстой. Төрийн үйлчилгээг иргэнд нээлттэй, хүртээмжтэй хүргэхэд цахим шийдэл, гарцыг олж, цахим засаглалыг хөгжүүлэх нь бидний хийвэл зохих нэн тэргүүний ажил. Төрийн үйлчилгээг цахимжуулснаар төсвийн болон иргэдийн хөрөнгө, санхүүг хэмнэнэ, төрийн алба, албан тушаалтны хүнд суртал, шударга бус, зүй бус харилцаа байхгүй болно. Төрийн үйлчилгээ авахаар аймаг, сум, багаасаа олон арван км хол газар явах шаардлага гарахгүй. Цахим шийдэл нь зөвхөн авлигын эрсдлийг бууруулах, орон зайн болон бусад саад бэрхшээлээс ангид амьдрах, хөгжих боломж олгохоос гадна иргэдийн эрүүл мэнд, амь нас, мөнгө санхүү, хамгийн гол нь юугаар ч үнэлж баршгүй цаг хугацааг хэмнэнэ...



#### *“Цахим эрин дэх Монгол Улс” төслийн менежер С.Тэнгис:*

#### **“Цахим эрэн ба Монгол Улс: өнөөдөр ба маргааш”**

...Авлигын талаарх олон нийтийн судалгаанд хамрагдсан иргэдийн 60-аас дээш хувь нь төрийн албаны хүнд сурталд сөхөрч хахууль өгсөн гэж хариулсан байдаг. Хэрэв төрийн үйлчилгээ дижиталд шилжвэл хүнд суртал арилж, авлига буурна. Монгол Улсад төрийн үйлчилгээ дижиталд шилжих дэд бүтэц нь бэлэн болсон. Харин одоо хүний нөөцөө бэлтгэх хэрэгтэй...





**Жүжигчин Б.Амарсайхан:**

### **“Иргэдийн хяналт”**

...Монгол Улсад 192 мянган төрийн албан хаагч байна. Өргөсөн тангарагаасаа няцсан ӨРГӨС шиг, ХУВАЛЗ шиг төрийн албан хаагчидтай тэмцэх ёстой. Ингэхийн тулд тэдгээрийг иргэд хянах хэрэгтэй...



**“ICT групп” компанийн гүйцэтгэх захирал Г.Лхамсүрэн:**

### **“Блокчэйн болон хиймэл оюун ухааны технологи: Авлигын тогтолцооны эсрэг”**

...Авлига бол хүний үйл ажиллагаатай холбоотой учраас амь бөхтэй оршоор байгаа юм. Харин блокчэйн бол хүний үйл ажиллагаагүй учир авлигын эсрэг тэмцэхэд, авлигыг зогсооход үр дүнтэй. Блокчэйн технологи хэрэглэснээр авлига 95 хувь буурна. Дахиад цаг хугацааг 68 хувь, зардлыг 80 хувь хэмнэнэ гэсэн тооцоолол бий...



**“Транспэрэнси интернэшнл Бангладеш” байгууллагын салбар хариуцсан захирал Фархана Фердоус:**

### **“Авлигын эсрэг сайн туршлага-иргэдийн бүлэг”**

...Авлигын эсрэг үйл ажиллагаанд иргэд хамгийн хүчтэй оролцож, гол үүргийг гүйцэтгэж чаддаг. Бангладеш улсын хэмжээнд 45 иргэдийн бүлэгт 6000 хүн сайн дураараа ажиллаж байна. Өөр өөр насны, өөр өөр мэргэжилтэй эдгээр сайн дурын иргэдийн гол зорилго нь АВЛИГАГҮЙ Бангладешийг бүтээх явдал юм...



**Эдийн засагч, судлаач Ө.Ганзориг:**

### **“Хөрөнгийн зах: Авлигатай тэмцэх механизм”**

...Хөрөнгийн захад компани гэх институцийн нэр ашиглаж хулгай, дээрэм хийдэг хүмүүс 5%-г эзэлдэг. Харин үлдсэн 95% нь баялаг бүтээх чин хүсэл зорилготой хүмүүс бий. Компанийн баялаг бүтээх дөнгө тушаа нь авлига юм. Хөрөнгийн захыг түргэн хөгжүүлж, компаниудыг жинхэнэ утгаар нээлттэй, баялгийг бий болгодог институци болгох хэрэгтэй...



**“Гэр, иргэдийн оролцоотой амьдрах орчны зураглалын төв” ТББ-ын тэргүүн Г.Батдорж:**

### **“Ил тод байдал: opendatalab.mn**

...Мэдээлэлтэй, мэдлэгтэй иргэд хариуцлага, ил тод байдлыг шаардаж чаддаг. Төрийн таван байгууллагын нээлттэй, цахим мэдээллийг нэг хайлтын системд нэгтгэн [www.opendatalab.mn](http://www.opendatalab.mn) сайтыг нээсэн. Энэ хайлтын систем дээр нэг хүний мэдээллийг бичихэд таван байгууллагын мэдээлэл зэрэг гарч ирнэ. Энэ нээлттэй өгөгдлийн сангаар дамжуулан иргэд авлига, ил тод байдалд хяналт тавих боломжийг бүрдүүлж өгч байна...



**Дэлхийн банкны засаглалын мэргэжилтэн  
Д.Амарбаясгалан:**

**“Нийгмийн эгэх хариуцлага, иргэдийн оролцоо,  
орон нутгийн туршлага”**

...Цахим ил тод байдлын индексийн нэгдсэн оноо улсын хэмжээнд 0.612 гарсан нь төрийн байгууллагуудын цахим ил тод байдал нийтээрээ сул байна. Тодруулбал, Монгол Улсын төрийн байгууллагуудын хувьд цахим ил тод байдлыг бий болгох, сайжруулахтай холбоотой үндсэн баримт бичигтэй ч, бодлого, стратеги нь тохиромжгүй, хэрэгжилт сул хэмээн дүгнэж болохоор байна. Түүнчлэн төрийн байгууллагуудад мэдээллийг цахимаар нийтлэх процедур, нөөц, хариуцлага байгаа ч ил тод байдлыг цаашид тогтвортой хангах чадавхыг зарим талаар бэхжүүлэх шаардлагатай нь харагдана...

**“Эм Ди Эс энд Хаанлекс” ХХН-ийн удирдах партнер,  
хуульч Ж.Майзориг**

**Монголын анхны робот хуульч Агирэ**

...Хуулийн үйлчилгээний чиг хандлага хаашаа явж байна вэ? гэхээр хуульчийг орлохуйц технологи руу чиглэж байна. Агирэ бол сайт, аппликэйшн ашиглаад хуулийн талаарх хүссэн мэдээлээ, орон зай, цаг хугацаа хамаарахгүйгээр авч болох технологи юм. Бид Агирэ-ээр дамжуулан хүмүүст хуулийн мэдлэг олгохыг хүссэн. Хуулиа мэддэг хүн эрхээ мэднэ, хууль бус зүйлээс ангид байж, хуулийн хүрээнд аж төрнө. Том цар хүрээгээрээ авлигатай тэмцэхэд сайн нөлөөтэй...

**Япон судлаач Д.Төмөрбаатар**


**Хүчтэй төрийн үндэс-Хүчирхэг иргэн**

... Монгол хүн хүнийхээ хувьд бол маш хүчирхэг. 300 сая, 100 сая, 30,0 сая хүнтэй улс орнуудтай оюун ухааны, спортын, урлагийн тэмцээн уралдаанд оролцоод ялаад, түрүүлээд ирдэг. Харин Монгол хүн иргэнийхээ хувьд бол маш сул дорой байна. Иргэд улс төрийн төлөвшлийг хүлээхгүйгээр өөрсдөө хичээж, хүчтэй болох ёстой.


Иргэн хүн гэдэг бол нийгэмдээ санаа зовдог, нийгэм ямар байхыг мэддэг, түүний төлөө зүтгэдэг, шүүмжилдэг, хууль журмыг нь судалдаг хүнийг хэлнэ.

Иргэн боловсролтой байх ёстой. Төрөөс үйлчилгээ авах гэж байгаа хүн өөрөө жирийн хүн байх ёсгүй, иргэн хүн байх ёстой. Ямар үйлчилгээ авах гэж байгаагаа өөрөө судлах хэрэгтэй. Ямар ямар бичиг баримт цуглуулах уу, хаана, хэдэн цагаас очих уу, хэнтэй уулзах вэ? гэдгээ судалж мэдэх хэрэгтэй. Та тэгэх ёстой, таны үүрэг ийм, миний эрх ийм гээд хэлэх ёстой...



 **#ЖиргээМэдээ : Tumurbaatar.  
JS @JapanSudlaach**

Авлигачдыг шахаж чадах, улс төрчдийг ичээж чадах ухамсар, мэдлэгтэй хүчтэй ИРГЭН, ийм иргэдээс зохион байгуулагдах хүчирхэг ИРГЭНИЙ НИЙГЭМ бий болоогүй цагт “улс төрчид бидний дээрээс угаадсаа асгасаар” байх болно. ИРГЭНИЙ НИЙГЭМ гэдэг бол зөвхөн жагсаал, цуглаан биш шүү.



# “ЦАХИМ ШИЙДЭЛ” АВЛИГЫН ЭСРЭГ ЧУУЛГАН







## ХУУЛИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН НЭГДСЭН ЗӨВЛӨГӨӨН ЗОХИОН БАЙГУУЛАВ

НҮБ-аас зарлан тунхагласан авлигын эсрэг олон улсын өдрийг тохиолдуулж “Шударга байдал ба олон нийтийн итгэл” сэдвээр хуулийн байгууллагуудын нэгдсэн зөвлөгөөнийг зохион байгуулаа.

Авлигатай тэмцэх газрын санаачилгаар зохион байгуулсан нэгдсэн зөвлөгөөнд Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын Ерөнхий прокурорын газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбоо зэрэг байгууллагын удирдах албан тушаалтнууд оролцов.

### ХЭЛЭЛЦҮҮЛСЭН ИЛТГЭЛҮҮД:

- Авлигын гэмт хэргийг мөрдөн шалгахад тулгарч буй асуудал, олон нийтийн итгэл
- Албан тушаалын гэмт хэргийн шийдвэрлэлт, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тулгарч буй хүндрэл бэрхшээл, шийдвэрлэх арга зам
- НҮБ-ын Авлигын эсрэг конвенци ба Шүүх эрх мэдэл
- Авлигын эсрэг эрх зүйн шинэтгэл
- Цагдаагийн байгууллагаас иргэд, олон нийтийн үнэлэмжийг нэмэгдүүлэх, итгэлийг ахиулах, дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулж буй арга хэмжээ
- Авлигын гэмт хэрэг үйлдэж хорихоос өөр төрлийн ял шийтгэгдсэн этгээдэд тавих хяналт, тулгамдсан асуудал
- Шийдвэр гүйцэтгэгчийн урамшууллын эерэг ба сөрөг үр дагаварт хийсэн шинжилгээ
- Өмгөөлөгчийн ёс зүй, хариуцлага
- Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт: Шүүхийн сахилгын хороо
- Шүүхэд итгэх олон нийтийн итгэл
- Шүүхэд итгэх иргэдийн итгэл: Шүүхийн ил тод, нээлттэй байдал
- Шүүгчийн ёс зүйн гомдол хянан шийдвэрлэлт: Олон нийтийн итгэл

Авлига, албан тушаалын гэмт хэргийг Авлигатай тэмцэх газар харьяаллын дагуу мөрдөн шалгадаг боловч хуулийн бусад байгууллагуудын хамтын ажиллагаа, ажлын уялдаа холбоо, амьд харилцаа зайлшгүй шаардлагатай. Авлигын гэмт хэргийг үр дүнтэй шалгаж шийдвэрлэх нь дан ганц АТГ-ын үйл ажиллагаанаас биш, хуулийн байгууллагуудын хамтын ажиллагаанаас ихээхэн хамааралтай тул хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагуудын үйл ажиллагаанд тулгарч буй хууль зүйн болон практик хүндрэлүүдийг хэрхэн шийдвэрлэх талаар хэлэлцлээ.

Хэрэг маргааныг хянан шийдвэрлэхэд хиймэл оюун ухааныг ашиглах нөхцөл боломж бүрдээгүйгээс хойш хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын албан хаагчид мэргэжлийн өндөр ёс зүйтэй байж, хуулийн хүрээнд, хараат бусаар, аливаад алагчлалгүйгээр хандан шийдвэр гаргаж ажиллах нь хуулийн байгууллагуудад итгэх олон нийтийн итгэлийг дээшлүүлэх, түүнийг хадгалах гол гарц юм.

Урьд өмнө нь хуулийн байгууллагуудын төлөөлөл нэг дор хуран цуглаж өөрсдийнх нь үйл ажиллагаа ба шударга байдал иргэд, олон нийт хэр зэрэг итгэлтэй байдаг талаар ярилцаж байсан удаагүй. Энэ зөвлөгөөн цаг үеэ олсон арга хэмжээ болмоо гэдгийг оролцогчид тодотгон тэмдэглэж байв.



### **Авлигатай тэмцэх газрын дарга, тэргүүн комиссар З.ДАШДАВАА:**

...Сүүлийн үед иргэд, олон нийтийн зүгээс төрийн байгууллагуудын шударга байдалд эргэлзэж, төрд итгэх итгэл алдарч байгаа талаар ярьж, бичих нь ихэслээ. Иргэд шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагад хариуцлага тооцохыг шаардах боллоо. Нийгэмд авлигын шинжтэй мэдээлэл түгээмэл тархахын зэрэгцээ иргэд, олон нийт АТГ-аас, прокуророос, шүүхээс багагүй мэдээллийг шаардах боллоо. Бид шүүх, хуулийн байгууллагуудын нэр хүнд олон нийтийн дунд унасныг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй юм. Энэ цаг үед нийгмийн шаардлагыг харгалзан тулгарч буй хүндрэл бэрхшээл, бодит нөхцөл байдлын талаар зөвлөлдөн, бодлого, стратеги, арга механизмаа ярилцах боломжийг олгохоор АТГ-аас санаачлан Хуулийн байгууллагуудын нэгдсэн зөвлөгөөнийг зохион байгуулж байгааг онцлон тэмдэглээд нийгэмд анхаарал татсан, нийтийн ашиг сонирхлыг хохироосон эрүүгийн хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх чиглэлээр хуулийн байгууллагуудын хамтын ажиллагааг шинэ шатанд гаргаж ажиллахыг уриаллаа...



### **Улсын дээд шүүхийн шүүгч Ч.ХОСБАЯР:**

...Хараат бус байдал нь шүүхийн шударга байдлыг өсгөхөд үйлчилж байна уу, эсвэл эсрэгээр саадгүй авлигажих боломж болж байна уу гэдэг нь улс оронд тогтсон улс төрийн манлайлал, ашиг сонирхол, үнэт зүйлсийн шинж чанараас ихээхэн хамааралтай. Жишээлбэл, Индонезид баталсан шүүхийн хараат бус байдлын талаарх дагнасан хууль нь шүүхийг хяналтаас бүрэн гаргаж авлигыг шүүн таслах ажиллагаанд дахь хэвийн үзэгдэл болтол гажуудсан байхад Латин Америкийн улс орнуудад шүүхэд тавих хяналтыг чангатган улмаар шүүхийн ерөнхий зөвлөлийн эрх хэмжээнд хамааруулснаар шүүх дэх хөндлөнгийн нөлөөлөл хэрээс хэтэрч шүүн таслах ажиллагаа нь гацах хэмжээнд үйл ажиллагаа нь хямарсан юм. Шүүх нь шүүхийн шийдвэр, шүүн таслах ажиллагааны болон төсвийн тайлан мэдээ, судалгааны үр дүнг хэвлэн нийтлэх замаар өөрийн үйл ажиллагааг олон нийтэд байнга танилцуулж байх нь шүүхийн өөрийн хариуцлагатай байдлыг дээшлүүлэхээс гадна улс төрийн шинжтэй олныг турхирсан гадны дайралт, давшилтаас сайн дархлаажуулалт болдгийг шүүхийн шинэчлэлийг ажиглагчид тэмдэглэсэн байна...



### **АТГ-ын Мөрдөн шалгах хэлтсийн ахлах мөрдөгч, ахлах комиссар Ч.ЖАРГАЛБААТАР:**

... Дэлхийн улс орон бүр авлигатай тэмцэх хүсэл сонирхлоо хүн төрөлхтөнд зарлаж мэдээлэл солилцох, харилцан туслалцаа үзүүлэх сүлжээг байгуулсаар байна. Цагийн аясаар тун удахгүй хулгайлагдсан хөрөнгө байрших газаргүй, хулгай хийсэн этгээд орогнох газаргүй болох цаг айсуу гэдэгт би итгэдэг...





## **Нийслэлийн прокурорын газрын хяналтын прокурор Р.БАТНАСАН:**

... Авлигын гэмт хэргийг шалгаж шийдвэрлэхэд хохирол нөхөн төлүүлэх, хор уршгийг арилгах асуудалд онцгой анхаарах ёстой. Авлигатай тэмцэхэд авлигачдыг шийтгэх нь гол асуудал мөн боловч гэмт хэрэг үйлдсэн этгээдийг шийтгүүлсэн ч олон хүн, улс хохирсон хэвээр үлдэж байна. Тийм учраас хохирол нөхөн төлүүлэх, хор уршгийг арилгах асуудлыг орхигдуулж болохгүй юм. Иймд зарим тохиолдолд албан тушаалын хэрэгт төр, нийтийн эрх ашигт учирсан хохирлыг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай зэрэгцүүлэн, урьдчилан шийдүүлэх арга замыг эрэлхийлэх хэрэгтэй байна...



## **АТГ-ын дэргэдэх Олон нийтийн зөв- лөлийн гишүүн И.МӨНХЖАРГАЛ:**

...Шүүхээс гарч байгаа хоёр хэрэг тутмын нэг шийдвэр нь алдаатай байна. Гэтэл шүүгч нарын ажиллаж байгаа орчин, хэрэглэж байгаа хууль, ёс зүйн дүрэм нэг... Ардчилсан нийгэмд хүний алдаа оноог дэнсэлдэг эрх мэдэл шүүгч, бурхан хоёрт л бий. Шүүхэд итгэх итгэл байхгүй болчихвол хүн бол бурханд найдаад орхино, нэг бол өөрсдөө шүүхийг орлож, өөрсдийн шүүхийг байгуулна. Энэ бол хамгийн том эмгэнэл...



## **Монголын Өмгөөлөгчдийн холбооны гишүүн, өмгөөлөгч Б.ГАНБОЛД:**

...Зөвхөн дүрэм, журам төдийхнөөр бус өмгөөлөгчийн ёс зүй, хариуцлагын асуудлыг бие даасан хуулиар зохицуулах, өмгөөлөгчдийг дагнан мэргэшүүлэх, зэрэглэл тогтоох, үйлчлүүлэгч нарт хүнд сурталгүй байх тогтолцоог бүрдүүлэх, өмгөөлөгчид тавигдах суурь шаардлагыг эрс нэмэгдүүлэх, ёс зүйг хүчтэй хариуцлагаар ачаалж өгөх, эрх хасах туйлын санкц тогтоох шаардлагатай байна. Хэрэв ингэж чадвал хүний хууль зүйн туслалцаа авах эрх хангагдаж, өмгөөлөгчдийн нэр хүнд өсч, хариуцлага, сахилга бат нэмэгдэж, шударга ёс тогтож, олон нийтийн итгэл баталгаажих, авлигаас ангид байх боломж бүрдэнэ...



## **ШЕЗ-ийн Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн захирал Ц.МАНДАХ:**

...Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь хэд хэдэн байгууллагын үйл ажиллагааг дамждаг хэрнээхэрэг, маргааныг эцэслэн шийдвэрлэдэг гэдэг агуулгаараа энэхүү ажиллагааны эцсийн үр дүн шүүх байгууллагын нэр хүнд дээр буудаг. Иймд итгэлийн асуудлыг аль нэг байгууллага гэхээсээ илүү тогтолцооны түвшинд авч үзэх судлах, энэ талаар хамтран ажиллах шаардлагатай байна...





## “АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР-ТАНАЙ ХОРООНД” СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ӨДӨРЛӨГ ЗОХИОН БАЙГУУЛАВ

Авлигын нийгмийн хор аюулыг олон нийтэд ухуулан таниулах, тэдэнд авлигыг үл тэвчих ёс суртахуун төлөвшүүлэх, уг ажиллагаанд татан оролцуулах, Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааг сурталчлан таниулах, эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл өгөх зорилгоор “Танай хороонд” иргэн төвтэй соён гэгээрүүлэх өдөрлөгийг Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 6 болон Баянзүрх дүүргийн 9, Хан-Уул дүүргийн 14 дүгээр хорооны иргэдийг хамруулан зохион байгууллаа.



Өдөрлөгийн үеэр Авлигатай тэмцэх газрын ажилтнууд авлигын нийгэм, эдийн засгийн хор хөнөөлийг ойлгуулах, авлигатай тэмцэхэд иргэд ямар үүрэгтэйг тайлбарлан таниулж, авлигын гэмт хэргийн талаар мэдээлэл хийж, иргэдийн дунд бичил хэлэлцүүлэг, асуулт, хариултын тэмцээн явууллаа. Түүнчлэн төрийн албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлэгтэй хэрхэн танилцаж, хяналт тавих боломжтой талаар зөвлөгөө, мэдээлэл өгөв.

Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан соён гэгээрүүлэх өдөрлөгт Улсын гавьяат жүжигчин Ш.Дэлгэржаргал оролцож, шударга ёсны төлөө санаа зориг нэгтэй байж, дуу хоолойгоо нэгтгэн тэмцэхийг иргэдэд уриаллаа. СУИС-ийн Театрын урлагийн сургуулийн оюутнууд жүжигчилсэн тоглолт үзүүлж, авлигын хор хөнөөлийг иргэдэд урлагийн хэлээр ойлгуулав.

Авлигатай тэмцэх үйл хэрэгт иргэдийг өргөнөөр татан оролцуулах, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, төрийн албан тушаалтны үйл ажиллагааг иргэд, олон нийтийн зүгээс эрч хүчтэйгээр хянах үйл ажиллагаанд уриалах, дэмжих зорилготой “Авлигатай тэмцэх газар танай хороонд” иргэн төвтэй соён гэгээрүүлэх өдөрлөгийг цаашид нийслэлийн бүх хороонд зохион байгуулахаар төлөвлөж байна.



### Урдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар Д.Дуламсүрэн:

Авлигаас урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй явуулахад олон нийтийн дэмжлэг нэн чухал. Гэтэл иргэдийн авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаарх ойлголт, мэдлэг муу, авлигатай тэмцэх ажилд хэрхэн, яаж оролцох арга хэлбэрээ олж чадахгүй байгаагаас идэвх санаачилга гаргаж чадахгүй байна. Иймд иргэдэд авлигын хор хөнөөлийг тайлбарлан таниулах, шаардлагатай мэдлэг, мэдээлэл олгох зэргээр төрийн үйл ажиллагаанд хяналт тавих чадавхийг бий болгож, тэдэнтэй хамтран ажиллахыг чухалчилж байна.



## “НАЙЗЫН ЯРИА” ӨДӨРЛӨГ ЗОХИОН БАЙГУУЛАВ



Хүүхдүүдэд шударга, зөв зан үйл төлөвшүүлэх, шударга ёсны үлгэр дуурайл бий болгох зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн бага, дунд ангийн сурагчдад зориулан “Найзын яриа” комикс номыг зохиож, Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Сүхбаатарын талбайд “Найзын яриа” соён гэгээрүүлэх өдөрлөг зохион байгуулав. Өдөрлөгийн үеэр “Найзын яриа” комикс номыг танилцуулахын зэрэгцээ “Би шударга хүүхэд” хөтөлбөрт арга хэмжээг зохион байгуулав. Энэ хүрээнд хүүхэд багачуудын дунд шударга ёсыг гар зураг, шүлэг, дуу хөгжим, жүжиг зэрэг урлагийн төрлөөр илэрхийлэх сургамжит, хөгжөөнт, танин мэдэхүйн сургалтыг хөтлөн явууллаа.

## АВЛИГЫН ЭСРЭГ НОМЫН БУЛАН НЭЭВ

Авлигатай тэмцэх газраас Үндэсний номын сан, Д.Нацагдоржийн нэрэмжит Улаанбаатар хотын нийтийн төв номын сан, МУИС-ийн номын сангуудад авлигын эсрэг номын булан нээлээ. Түүнчлэн 21 аймгийн номын сан, 30 их, дээд сургуулиудын номын санд Авлигатай тэмцэх газраас гаргасан судалгаануудын эмхэтгэл, төрийн албан хаагчдад зориулсан гарын авлагууд, гадаад улс орнуудын авлигатай тэмцэж буй туршлага зэрэг 30 гаруй төрлийн 500 ширхэг номыг олон нийтийн хүртээл болгох зорилгоор хүргүүлээд байна. Оюутан, судлаач, эрдэмтэд дээрх материалуудтай танилцаж, эрдэм шинжилгээ судалгааны эмхэтгэл ашиглах боломж бүрдэв.



## ХЭЛЭЛЦҮҮЛГҮҮД:

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор төрийн байгууллагуудтай хамтран авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулж, хүнд суртлаас ангид байлгах зорилгоор хэлэлцүүлэг зохион байгуулж, зөвлөмж хүргүүлэв.

Үндэсний аудитын газартай хамтран аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх дотоод аудитын нэгжийн албан хаагчид, холбогдох яам, агентлагийн асуудал хариуцсан нэгжийн удирдлагуудыг оролцуулан зохион байгуулсан **“Төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх арга зам”** сэдэвт хэлэлцүүлэг; 2019.10.21



Канадын Засгийн газрын дэмжлэгтэйгээр Азийн сан, Авлигатай тэмцэх газар, Нийслэлийн Боловсролын газар, “Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг” ТББ хамтран зохион байгуулсан **“Шударга ёсыг бэхжүүлэх нь”** хөтөлбөрт хамрагдсан багш, сурагчид, тэдгээрийн эцэг эхийн төлөөллийг оролцуулсан сургалтын үр дүнг тооцох, сайн туршлага солилцох уулзалт, хэлэлцүүлэг; 2019.10.28



Барилга, хот байгуулалтын яамтай хамтран салбарын яам, агентлагийн асуудал хариуцсан нэгжийн удирдлагууд, барилгын салбарын ТББ-ын төлөөлүүд, барилгын компанийн удирдлагуудыг оролцуулан зохион байгуулсан **“Мэргэжлийн холбоодод шилжүүлсэн барилгын тусгай зөвшөөрлүүд: Асуудал, шийдэл”** сэдэвт хэлэлцүүлэг; 2019.11.08



Нийтийн албаны сургалтын институт байгуулах, албан тушаалтныг давтан сургах боломжийг бүрдүүлэх чиглэлээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газартай хамтран зохион байгуулсан **“Төрийн байгууллагуудын өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авах ажилтнуудын форум”** 2019.11.20





---

**“Аудитын байгууллагын зарим чиг үүргийг аудитын бусад байгууллагаар гүйцэтгүүлэх хэрэгцээ, шаардлага”** сэдэвт хэлэлцүүлэг; 2019.11.25

---



Цагдаагийн ерөнхий газар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, төрийн бус зарим байгууллага, Иргэний хяналтын зөвлөлийн гишүүдийн төлөөллийг оролцуулан **“Жолоодох эрхийн үнэмлэх олгох, нөхөн олгох, үйл ажиллагааг цахимжуулах, ил тод болгох нь: асуудал ба шийдэл”** сэдэвт хэлэлцүүлэг; 2019.01.30

---



Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтран **“Гадаадаас ажиллах хүчин, мэргэжилтэн авах зөвшөөрлийг цахим болгох нь”** сэдэвт хэлэлцүүлэг; 2019.01.21

---



Зам, тээврийн хөгжлийн яам, Авто-тээврийн үндэсний төв салбарын иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран **“Улс хоорондын байнгын ачаа тээвэр эрхлэх “С” зөвшөөрөл олгох үйл ажиллагаан дахь хүндрэл бэрхшээл, авлига гарах нөхцөлийг бууруулах нь”** сэдэвт хэлэлцүүлэг; 2019.03.26

---



Улсын бүртгэлийн ерөнхий газар, Нийслэлийн Захирагчийн ажлын алба, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, Дүүргийн үйлдвэр үйлчилгээний хэлтэс, дүүргийн Онцгой байдлын газар болон аж ахуйн нэгжийн төлөөллийг оролцуулан **“Нийтийн хоолны үйлчилгээн дэх эрсдэлд суурилсан мэргэжлийн хяналт шалгалт ба аж ахуйн нэгжийн дотоод хяналтыг бэхжүүлэх”** сэдэвт хэлэлцүүлэг; 2019.04.11

---

Уул уурхайн салбарын гэрээний ил тод байдлыг сайжруулж, эцсийн өмчлөгч буюу ашиг хүртэгчийг ил тод болгох Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд Нээлттэй нийгэм форум, Транспэрэнси Интернэшнл Монгол, Хууль тогтоомж, бодлого судалгааны төв, Байгалийн баялгийн засаглалийн хүрээлэн хамтран **“Олборлох салбарын ил тод байдал”** сэдэвт хэлэлцүүлэг; 2019.12.17



---

“Мэдээлэл өгч байгаа иргэн, сэтгүүлчийг хамгаалах эрх зүйн орчинг бүрдүүлэх”, “мэдээлэл өгч байгаа иргэнийг урамшуулах тогтолцоо бүрдүүлэх” ажил, арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор зохион байгуулсан **“Мэдээлэгч (Шүгэл үлээгч)-ийг хамгаалах бодлого, арга зам”** сэдэвт хэлэлцүүлэг; 2019.06.11



---

“Транспэрэнси интернэшнл Монгол”, “Шилэн нам” авлигын эсрэг түншлэл ТББ-тай хамтран улс төрийн намын болон сонгуулийн үйл ажиллагааны санхүүжилтийн ил тод байдлыг сайжруулах, хяналт хариуцлагын тогтолцоо бүрдүүлэх асуудлаар **“Улс төрийн намын тухай хууль: тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам”** сэдэвт хэлэлцүүлэг; 2019.06.26



---

Боловсролын салбар дахь ёс зүйн орчин, мэргэжлийн ёс зүйн байдал, төлөвшил, ёс зүйн хичээлийн хөтөлбөрт үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид сургалтын хөтөлбөрийн чанар, үр өгөөжийг дээшлүүлэх зорилгоор зохион байгуулсан **“Боловсролын салбар дахь ёс зүйн асуудал”** сэдэвт хэлэлцүүлэг; 2019.12.03





---

Албан тушаалтны хөрөнгө, орлогод тавих иргэдийн хяналтыг хэрхэн нэмэгдүүлэх, дан ганц орлого, хөрөнгийг бүртгэхээс гадна зарлагын асуудлыг хэрхэн тусгах, олон улсад төрийн албан хаагчдын хөрөнгө, орлогыг хэрхэн бүртгэж, хянадаг, манай улсад ХОМ-ийг хянан шалгахад гарч байгаа хүндрэл бэрхшээл, тулгамдаж байгаа асуудал, хэрэгцээ шаардлагын талаар санал солилцох зорилгоор зохион байгуулсан **“Албан тушаалтны хөрөнгө, орлогод иргэдийн хяналтыг нэмэгдүүлэх, ХОМ-ийн маягтыг боловсронгуй болгох нь”** сэдэвт хэлэлцүүлэг; 2019.11.22

---

“Монгол HD” телевизтэй хамтран **“Монголчууд бид авлигаас ангижирч чадах уу?”** сэдэвт “Нүүдэл шийдэл” телевизийн хэлэлцүүлэг зохион байгуулав. 2019.12.09

---

“Транспэрэнси интернэшнл Монгол”, “Шилэн нам” авлигын эсрэг түншлэлтэй хамтран зохион байгуулсан **“Улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдлыг хангаж, авлигын эрсдлээс сэргийлэх эрх зүйн орчин бүрдүүлэх нь”** сэдэвт хэлэлцүүлэг; 2019.12.09

---

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгасан улс төрийн намын санхүүжилтийн ил тод болгох, хяналт, хариуцлагын тогтолцоог сайжруулах зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд Нээлтэй нийгэм форум ТББ, Олон улсын IDEA байгууллага, Европын холбооны дэмжлэгтэйгээр зохион байгуулсан **“Улс төрийн санхүүжилтын хяналтын тогтолцоо: олон улсын туршлага”** сэдэвт хэлэлцүүлэг; 2019.12.05-06

---

“Гэр, иргэдийн оролцоотой амьдрах орчны зураглалын төв” ТББ-тай хамтран **“Хоёр хотын цадиг- 2019”** үзэсгэлэнг зохион байгуулав. Тус үзэсгэлэнгээр авлигыг бууруулахад мэдээллийн ил тод, хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэхийн ач холбогдол, иргэдийн оролцоотой хөгжүүлсэн хувь хүний агаарын бохирдолд өртөлт, хотын хүртээмжтэй үйлчилгээ зэрэг сэдвүүдээр хийсэн газрын зураг, бусад бүтээлүүдийг дэлгэн үзүүлэв. Үзэсгэлэнгийн үеэр сэдэвчилсэн хэлэлцүүлгүүд болон богино хэмжээний сургалтууд зохион байгуулав. 2019.11.04-08

## ИРГЭНИЙ ХЯНАЛТЫН ТӨВ

Төрийн байгууллагуудад илэрч байгаа зөрчил, дутагдлууд нь төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтны авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл бага, хариуцлага, хяналтын тогтолцоо муу байгааг илтгэн харуулж байна.

Авлигатай тэмцэх газрын зүгээс авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилт тавин ажиллаж байгаа. Энэ ажлын хүрээнд төрийн байгууллага, албан тушаалтны хүнд сурталтай үйлчилгээ, авлига, ашиг сонирхлын зөрчил, авлигын гэмт хэргийн талаар гомдол, мэдээлэл хүлээн авах, эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл өгөх, сургалт, сурталчилгаа явуулах зорилго бүхий “Иргэний хяналтын төв”-ийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран байгууллаа.



“Иргэний хяналтын төв”-ийн өдөр тутмын үйл ажиллагаанд Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөл хяналт тавьж, авлигын эсрэг хууль, тогтоомжийг сурталчлан таниулах, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, иргэдийн гомдол, мэдээллийг хүлээн авах, санал хүсэлтийг сонсох зэрэг үйл ажиллагааг удирдлагаар ханган ажиллаж байна.



Авлигатай тэмцэх газрын  
Иргэний хяналтын төв  
/Драгон дахь салбар/



Авлигатай тэмцэх газрын  
Иргэний хяналтын төв  
/6 буудал дахь салбар/



Авлигатай тэмцэх газрын  
Иргэний хяналтын төв  
/Дүнжингарав дахь салбар/



Авлигатай тэмцэх газрын  
Иргэний хяналтын төв  
/Мишээл дэх салбар/



# УРАЛДААН, ТЭМЦЭЭН

## ОЮУТАН ЗАЛУУСЫН ДУНД “ТҮЛХҮҮР” УРАЛДААН



Нийгмийн амьдралд оюутан залуусын бодит оролцоог нэмэгдүүлэх, идэвх санаачилгыг өрнүүлэх, дэмжиж хамтран ажиллах замаар шударга, бүтээлч иргэдийг төлөвшүүлэх зорилгоор “Түлхүүр” уралдаан зохион байгуулав.

Уг уралдаанд 14 сургуулийн бие даасан 41, хамтарсан 6, нийт 47 баг оролцсон ба тэргүүн байрт Шихихутуг их сургуулийн “Mindset”, хоёр дугаар

байрт Монгол Улсын их сургуулийн “Тусгал”, гуравдугаар байрт Дотоод хэргийн их сургуулийн “Серендипити” баг шалгарч, тусгай байрт Монгол Улсын их сургуулийн “No corruption”, Монгол Улсын шинжлэх ухаан, технологийн их сургуулийн “MUST”, Дотоод хэргийн их сургуулийн “Key” багууд шалгарлаа.

Уралдааны явцад оюутнууд бие даан нийгмийн харилцаанд оролцох, нийгэм дэх авлига, хүнд суртал зэрэг сөрөг үзэгдэлд шүүмжлэлт байдлаар хандах, асуудлыг танин мэдэх, шийдвэрлэх арга зүй, чадварыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлснээрээ ач холбогдолтой арга хэмжээ болсон юм.

## “ХҮН БОЛОХ БАГААСАА” ЭССЭ БИЧЛЭГИЙН УРАЛДААН

Ерөнхий боловсролын сургуулийн 9-12 дугаар ангийн сурагчдын дунд “Шударга ёс: Хүн болох багаасаа” сэдэвт эссэ бичлэгийн уралдаан зарласан юм.

Ахлах ангийн сурагчид шударга ёсны тухай үзэл бодлоо эссэ бичлэгээр дамжуулан илэрхийлэх боломж олгох, шударга бус байдлын эсрэг тэдний дуу хоолойг олон нийтэд хүргэх нь уг уралдааны гол зорилго байв. Уралдаанд нийт 129 эссэ ирүүлсэн байна.




- Тэргүүн байрт нийслэлийн Хан-Уул дүүргийн 52 дугаар сургуулийн 10г ангийн сурагч Э.Хүслэн;
- Дэд байрт нийслэлийн Сүхбаатар дүүргийн 1 дүгээр сургуулийн 116 ангийн сурагч Б.Гоомарал;
- Гуравдугаар байрт Баян-Өлгий аймгийн “Дарын” цогцолбор сургуулийн 10а ангийн сурагч Б.Жантолхын нар шалгарлаа.



## “АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ДЭВШИЛТЭТ АРГЫГ НЭВТРҮҮЛЭХ НЬ” ИЛТГЭЛИЙН УРАЛДААН

Авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх хүрээнд залуу судлаач, эрдэмтэн, багш, оюутнууд, төрийн албан хаагч, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд шинэ технологи, шинэлэг санааг нэвтрүүлэх, авлигын эсрэг санаачилгыг өрнүүлэх зорилгоор “Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд дэвшилтэт аргыг нэвтрүүлэх нь” илтгэлийн уралдаан зохион байгуулав.

Уг уралдаанд ирсэн 46 бүтээлээс онооны дарааллаар Сити их сургуулийн дэд профессор П.Мөнхтогтын «Хэрэглэгч төвтэй төр» илтгэл, С.Солонгын «Эрүүл мэндийн салбарын авлига, хээл хахууль» илтгэл тус тус шалгарав.




## “МИНИЙ МЭДЭХ ШУДАРГА ЁС” ГАР ЗУРГИЙН УРАЛДААН

Бага, дунд ангийн сурагчид шударга ёсны тухай өөрсдийн үзэл бодлыг зургаар дамжуулан илэрхийлэх, нийгэмд буй шударга бус байдлын эсрэг дуу хоолойгоо олон нийтэд хүргэх үйл ажиллагааг дэмжих зорилгоор “Миний мэдэх шударга ёс” гар зургийн уралдаан зохион байгууллаа.

Уралдаанд нийт 194 бүтээл ирүүлсэн. Бага ангийн сурагчдын төрөлд 68 бүтээлээс тэргүүн байрт Баян-Өлгий аймгийн Дарын сургуулийн 5Б ангийн сурагч А.Камила, дэд байрт Орхон аймгийн Жаргалант сумын 5А ангийн сурагч Э.Санчиррагчаа, гуравдугаар байрт Хобби сургуулийн 5А ангийн сурагч Г.Хулаа нар тус тус шалгарлаа.

Дунд ангийн сурагчдаас ирүүлсэн нийт 126 бүтээлээс тэргүүн байрт Нийслэлийн 2-р сургуулийн 7е ангийн сурагч Б.Цэцэн, дэд байрт Орхон аймгийн Жаргалант сумын сургуулийн 9б ангийн сурагч Э.Санчирдамба, гуравдугаар байрт Оюуны ундраа цогцолбор сургуулийн 8/5 ангийн сурагч Э.Намжирмаа нар тус тус шалгарлаа.





## НИЙСЛЭЛИЙН 170 ХОРООНД АВЛИГЫН ЭСРЭГ САМБАР БАЙРШУУЛАВ

Нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран Нийслэлийн 9 дүүргийн 170 хороонд авлигын эсрэг хууль тогтоомж, авлигыг мэдээлэх 110 утсыг сурталчилсан мэдээллийн самбар байршуулж мэдээлэл хүргэх ажлыг зохион байгуулав.



## “АВЛИГЫГ МЭДЭЭЛЖ, ЖИГШ” КЛУБЫГ БАЙГУУЛАВ



Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлийн дэргэд Авлигын эсрэг иргэд залуучуудын авлигыг мэдээлж, жигш буюу “АМЖ клуб”-ыг байгуулаа. Их Британийн Засгийн газраас 2010 онд ашигласан сайн туршлага болох авлигыг мэдээлэхэд хэрэглэж буй Мэдээлж, Жигш аргад тулгуурласан юм. “АМЖ клуб” нь фэйсбүүк ( <https://www.facebook.com/naming.shaming> ) сувгийг ашиглан мэдээлэл, санал, хүсэлтийг хүлээн авч, олон нийтийг соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулахаас гадна авлигыг мэдээлэх арга замыг түгээн ажиллаж байна.

Тус клуб нь олон улсын чанарын удирдлагын тогтолцоо ISO/MNS 9001:2015 стандартыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилладаг бөгөөд тус стандартыг дагаж мөрдөх нь “Авлигыг мэдээлж, Жигш” клубын давуу тал байх болно. Дээрх олон улсын стандарт нь тухайн байгууллага, клубын үйл ажиллагааны чанарыг удирдах, хянах тогтолцоо ба олон улсын стандартын шаардлагад нийцсэн болохыг баталгаажуулдаг бөгөөд байгууллагын үйл ажиллагаа хэрэглэгч, үйлчлүүлэгчийн эрэлт, шаардлагад нийцсэн байлгахад нь туслах зорилготой, дэлхийн 178 орны 1064000 байгууллагад хэрэгжсэн, дэлхийн хамгийн түгээмэл удирдлагын тогтолцооны стандарт юм.

Цаашид авлигын эсрэг олон улсын стандарт, тэргүүн туршлагыг судалсан үр дүнг байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх, авлигагүй нийгэм, шударга ёсыг сурталчлах цахим хуудас тогтмол ажиллуулах, нийгэмд шударга ёс тогтоох олон талын ажил санаачилж иргэдийн идэвхи оролцоог нэмэгдүүлэх зорилго тавин ажиллаж байна.

# АВЛИГЫН ЭСРЭГ СУРГАЛТ

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлагдснаар соён гэгээрүүлэх ажлыг илүү өргөн хүрээнд, үе шаттай зохион байгуулах боломж бүрдсэн.

## АВЛИГЫН ЭСРЭГ СУРГАЛТАД

2017 онд **11345**

2018 онд **21574**

2019 онд **25007** хүн хамруулжээ.

2019 онд тухайн байгууллага дээр болон аймаг орон нутагт зохион байгуулсан сургалтад

**17380** албан хаагч

**3580** оюутан, сурагчид

**3693** иргэд

**354** төрийн бус байгууллага, хувийн хэвшлээс тус тус хамрагдсан байна.

Олон нийтийн төвд зохион байгуулсан Авлигын эсрэг сургалтад оролцогчдыг салбар, байгууллагаар нь авч үзвэл

Ерөнхийлөгчийн Тамгын газар, түүний харьяа байгууллагаас	32
Улсын Их Хурал, түүний харьяа байгууллагаас	572
Шүүхийн 3 байгууллагаас	121
Прокурорын 11 байгууллагаас	254
Засгийн газар болон Ерөнхий сайд, Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний 17 байгууллагаас	582
Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний 3 байгууллагаас	31
Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын хүрээний 4 байгууллагаас	429
Гадаад харилцааны яамнаас	67
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний 4 байгууллагаас	128
Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 5 байгууллагаас	216
Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 2 байгууллагаас	16
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний 5 байгууллагаас	132
Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 11 байгууллагаас	1971
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 7 байгууллагаас	108
Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 3 байгууллагаас	724
Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 2 байгууллагаас	185
Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагаас	51
Нийслэлийн төр захиргааны 30 байгууллагаас	345



Төрийн болон төрийн бус **68** байгууллагын **6381** албан тушаалтанд тухайн байгууллагын хүсэлт, хэрэгцээ шаардлагыг харгалзан сургалт зохион байгуулсан.



## СУРГАЛТЫН БҮРТГЭЛИЙН НЭГДСЭН СИСТЕМИЙГ НЭВТРҮҮЛЭЭ

Бүртгэлийн цахим систем нэвтэрснээр цаас, цаг үрсэн гар ажиллагааг халж, төрийн байгууллага, албан хаагчдад чирэгдэл багатайгаар сургалтыг зохион байгуулах боломж бүрдлээ. Төрийн байгууллагууд сургалтад хамруулах албан тушаалтны захиалга өгөх, сургалт зохион байгуулж байгаа өдөр, цаг


хугацааны мэдээллийг авах, бүтэн өдрийн турш ажлаас чөлөөлөгдөж сургалтад хамрагдсан ажилтныхаа ирцийн байдалд хяналт тавих боломжтой ба энэ талаарх нэгдсэн тоо, тайлан гаргах ажлыг хөнгөвчлөх ач холбогдолтой юм.



## ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ ГАРГАГЧ НАРТ ЗОРИУЛСАН СУРГАЛТ

Мэдүүлэг гаргагч болон мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтнуудыг чадавхжуулах чиглэлээр зохион байгуулсан сургалтад оролцогчдын тоон үзүүлэлтийг сүүлийн 3 жилээр харьцуулав.

Сургалтад оролцогчдын тоон үзүүлэлтийг харьцуулбал:



## ТУСГАЙЛСАН СУРГАЛТУУД

### Хууль сахиулах байгууллагын албан хаагчдад зориулсан сургалт

Хууль сахиулах байгууллагын ажилтан, албан хаагчдад эрэн сурвалжлах сэтгүүл зүй, сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах талаар сургалт хийх, тэдний мэдлэг ойлголтыг дээшлүүлэх” арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2019 оны 11 дүгээр сард хууль сахиулах байгууллагын ажилтан, албан хаагчдад зориулан “Эрэн сурвалжлах сэтгүүл зүй, сэтгүүлчийн аюулгүй байдлыг хангах нь” сэдэвт бүтэн өдрийн сургалтыг Хэвлэл мэдээллийн зөвлөлтэй хамтран зохион байгуулав. Сургалтад Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын ерөнхий прокурор, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газрын 57 албан хаагч хамрагдав.

Авлигатай тэмцэх газар, Үндэсний аудитын газрын дарга нарын баталсан “2019 онд авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтран хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний 6-д заасан “Төрийн аудитын байгууллагаас хяналт шалгалтын талаар шаардлагатай сургалтыг зохион байгуулах” ажлын хүрээнд “Төрийн аудитын тухай ойлголт” сэдвээр Авлигатай тэмцэх газрын албан хаагчдыг чадавхжуулах сургалтыг 2019 оны 11 дүгээр сард зохион байгуулаа.

### Авлигатай тэмцэх газрын албан хаагчдыг чадавхжуулах сургалт

### “Вагонтой сургалт” зохион байгуулав

Улаанбаатар төмөр замын 1200 гаруй ажилтанд хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, гэмт хэрэг гарах шалтгаан, нөхцөлийг арилгах, авлига албан тушаалын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх зорилгоор төмөр замын урд, хойд чиглэлд Вагонтой сургалт зохион байгуулсан.

Авлигатай тэмцэх газар, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн боловсролын газар хамтран Сонгинохайрхан, Хан-Уул дүүргийн 44 сургуулийн захирал, 77 цэцэрлэгийн эрхлэгч, нийт 121 албан тушаалтанд Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх бүтэн өдрийн сургалт зохион байгуулсан.

### Захирал, эрхлэгч нарт зориулсан сургалт

### “АТҮХХ ажлыг зохион байгуулж, хяналт тавих орон тооны бус зөвлөл”-ийг гишүүдийг чадавхжуулав

Цагдаагийн ерөнхий газрын “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавих орон тооны бус зөвлөл”-ийн гишүүд, хүний нөөцийн мэргэжилтэн, хөрөнгө орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтэд хяналт тавих эрх бүхий албан тушаалтнуудыг чадавхжуулах сургалтыг 2019 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгуулав.



### “Сайн туршлага: Иргэдийн бүлэг” сургалт

“Транспэрэнси Интернэшнл - Бангладаш” байгууллагын Иргэдийн хяналт, оролцоо хариуцсан захирал хатагтай Ferhana Ferdous “Сайн туршлага: Иргэдийн бүлэг” сэдэвт сургалтыг зохион байгуулаа. Сургалтад 89 иргэн, төрийн бус байгууллагын төлөөлөл оролцов.

Цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагын хэмжээнд буюу улсын хэмжээнд 9880 цагдаагийн албан хаагчид авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх асуудлаар сургалт явуулах сургагч багш нарыг бэлтгэх сургалтыг Цагдаагийн ерөнхий газартай хамтран 2019 оны 11 дүгээр сарын 28-29-ний өдрүүдэд зохион байгуулаа. Цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагын 21 аймаг болон нийслэлийн нийт 65 цагдаагийн алба хаагч хамрагдаж, “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдвээр сургагч багш бэлтгэх сургалтад хамрагдсантай нь холбогдуулан гэрчилгээ олгов.

### Цагдаагийн алба хаагч нарыг СУРГАГЧ БАГШ-аар бэлтгэв

### Эрэн сурвалжлах сэтгүүлчдийг сургалтад хамруулав

Авлигын болон бусад төрлийн гэмт хэргийг эрэн сурвалжлах, хууль зүйн мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх, зорилгоор 90 гаруй сэтгүүлчдэд 2 удаагийн сургалт (2019.04.08, 2019.04.26)-ыг зохион байгуулав. Авлигын гэмт хэргийн шинж, нийгмийн хор аюул, авлига ба эрэн сурвалжлах сэтгүүл зүйн олон улсын туршлага, чиг хандлага, оффшор бүс нутаг болон улс дамнасан санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа, олон улсын эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ, эрэн сурвалжлах ярилцлага хийх тактик, хөрөнгө оруулалтын гэрээ, түүн дэх авлигын эрсдэл, давхар татварын гэрээ, Засгийн газрын тусгай сангийн гэрээ гэсэн сэдвийн хүрээнд мэргэжлийн багш, судлаач, шинжээч, мөрдөгч нар сургалт хийж чадавхжуулав.

Авлигатай тэмцэх газар Дэлхийн банк болон НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны хамтарсан түншлэл болох СТАР буюу “Хулгайлагдсан хөрөнгийг буцаан олгох санаачилга”-тай хамтран иргэдэд нийтийн албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянах, задлан шинжилгээ хийх чадавх эзэмшүүлэх сургалтыг дөрөвдүгээр сарын 15-16 өдрүүдэд зохион байгуулав.

Нийтийн албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлэгт хяналт тавьж, дүн шинжилгээ хийх мэдлэг, чадвар эзэмшихээс гадна авлигын шалтгаан, хор хөнөөл, шүгэл үлээх соёл, төрийн албаны уламжлал, шинэчлэл ба ёс зүй зэрэг сэдвийн хүрээнд мэдлэгээ гүнзгийрүүлсэн юм. Онол, дадлага хосолсон хоёр өдрийн чадавхжуулах сургалтад 65 иргэн хамрагдлаа.

### Чадавхтай иргэн үр дүнтэй хяналтыг хэрэгжүүлнэ

## ГАРЫН АВЛАГА, СУРТАЛЧИЛГААНЫ МАТЕРИАЛ БЭЛТГЭЖ ХЭВЛҮҮЛЭВ

Авлигын эсрэг сурталчилгааны материал боловсруулж, түгээх ажлын хүрээнд олон нийтэд шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх, авлигын нийгэмд учруулж буй хор аюулыг ухуулан таниулах, авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах болон гомдол, мэдээлэл хүлээн авах 110 утсыг сурталчлах зорилгоор хэвлэмэл бүтээгдэхүүний эхийг боловсруулан хэвлүүлж, түгээх ажлыг зохион байгуулав.

Орон нутаг, нийслэлд сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах явцад 20 орчим төрлийн 48275 ширхэг ном, гарын авлага, тараах материалыг иргэд, төрийн байгууллага, аймаг, нийслэлийн Иргэний танхим болон Эрх зүйн туслалцаа үзүүлэх төв, нийтийн номын сангуудад түгээсэн байна.



Нийслэлийн ИТХ, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран гомдол, мэдээлэл хүлээн авах 110 дугаарын утасны сурталчилгааны материалыг хэвлүүлэн түгээв.





Хувийн хэвшилд зориулан “Авлигаас урьдчилан сэргийлэх 9 зөвлөмж”, “Хувийн хэвшлийн ёс зүй ба авлига” гарын авлагуудыг боловсруулав.

Оюутан, залууст зориулан зохион байгуулсан “Үнэт зүйлийн боловсрол” арга хэмжээний илтгэлүүдийг эмхэтгэн хэвлэв.

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн “Монгол Улсад мэргэшсэн, иргэн төвтэй төрийн албыг бэхжүүлэх нь” төслийн дэмжлэгтэйгээр “Төрийн албан хаагчийн ёс зүй”, “Нийтийн албанд ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах нь” гарын авлага боловсруулав.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Авлигын эсрэг сүлжээнээс Монгол Улсын авлигын эсрэг эрх зүйн орчин, институци, үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгч, холбогдох зөвлөмжийг боловсруулан гаргасан. 2019 онд Монгол Улсын авлигын эсрэг орчинд хийсэн үнэлгээний тайланг хэвлүүлэв.

Улаанбаатар хотын 6 дүүргийн 40 байршилд байрлах сурталчилгааны байгууламжид гомдол, мэдээлэл хүлээн авах 110 тусгай дугаарын утасны сурталчилгаа байршуулав.

“110 дугаарын утсыг сурталчлах ажлын хүрээнд Нийслэлийн ХУД-ийн нутаг Үндэсний цэцэрлэгт хүрээлэн, “Оргил” худалдааны төв, “Мишээл Экспо” худалдааны төв, БЗД-ийн нутаг, автозамын шалган нэвтрүүлэх товчоо, “Дүнжингарав” худалдааны төв, “Нарантуул” худалдааны төв, СХД-ийн нутаг, автозамын шалган нэвтрүүлэх товчоо, СБД-ийн нутаг, “Санктпетрбург” төв, 5 буудлын автозам дагуух нийт 9 байршилд сурталчилгаа байршуулав.

Байгууллагын үйл ажиллагааг сурталчлан таниулах, мэдээлэх [www.iaac.mn](http://www.iaac.mn) мэдээллийн хуудасны дөрвөн дугаар хэвлүүлэн /6000 ш/ олны хүртээл болгов.





## УРЛАГ, СПОРТЫН ТӨЛӨӨЛӨЛ АВЛИГЫН ЭСРЭГ СУРТАЛЧИЛГААНД МАНЛАЙЛАН ОРОЛЦОЖ БАЙНА

Авлигатай тэмцэх газрын хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргийн тэргүүлэх чиглэл нь авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын нийгэмд учруулах хор аюулыг олон нийтэд ухуулан таниулах, иргэдийг авлигатай тэмцэх арга барилд сургах, энэ төрлийн үйл ажиллагаанд татан оролцуулах явдал юм.

Энэхүү чиг үүргийг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор авлигын эсрэг сургалт, сурталчилгаа, олон нийтийг хамарсан арга хэмжээг шинэлэг арга, хэлбэрээр зохион байгуулж байна. Үүний нэг нь авлигыг мэдээлэх 110 утасны сурталчилгаа, авлигын хор хөнөөлийг ухуулан таниулсан видео контент бүтээхэд олны танил урлаг, соёлын алдартнуудыг татан оролцуулж, хамтран ажиллаж байна.

Сагсан бөмбөгийн “SBL Хасын хүлгүүд” багийн тамирчин Т.Санчир, “Үүргэвчтэй аялал” нэвтрүүлгийн хөтөлгөч Г.Ганхүү, дуучин Д.Отгонжаргал, жүжигчин Б.Амарсайхан, С.Ариунбямба нар авлигыг мэдээлэх 110 утасны сурталчилгаанд нийгмийн хариуцлагын хүрээнд оролцов. Тэд “авлигатай тэмцэх нь бүх нийтийн үйлс” хэмээн дүгнээд шударга бус үйлдлийг заавал илчилж байхыг сануулан, “Чи бол Авлигатай тэмцэх газар. Ягштал мөрд, шалга, мэдээл. Яг одоо 110 руу залгаарай, Бид бүгдээрээ АТГ” хэмээн иргэдийг уриалав.

Залууст авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх, шударга ёсны үйл хэрэгт уриалах, тэдний дуу хоолой, хүч, оролцоог бий болгох зорилгоор дуучин А Cool, PacRap нартай хамтран “Саарал хүмүүс” дууг бүтээв.

2020 онд авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллагын идэвхи, санаачилгыг нэмэгдүүлэх, хамтран ажиллах, олон нийтийн хяналтын тогтолцоог илүү боловсронгуй болгох, судалгаагаар тодорхойлогдсон авлигын эрсдэлтэй салбар, байгууллага руу чиглэсэн ажлуудыг иргэдтэй хамтран хэрэгжүүлэх зорилгыг дэвшүүлж байна.



ШУДАРГА ЁС, ХӨГЖИЛ ДЭВШИЛ





## ХЭВЛЭЛ, МЭДЭЭЛЭЛТЭЙ ХАРИЛЦАХ ЧИГЛЭЛЭЭР



### “АТГ-ын мэдээлэл” нэвтрүүлгийн 20 дугаарыг бэлтгэв

“АТГ-ын мэдээлэл” нэвтрүүлгийн 20 дугаарыг бэлтгэн МҮОНТ-ээр олон нийтийн хүртээл болгов. Мөн “Авлигатай тэмцэх газрын ажилтны нэг өдөр” 60 минутын нэвтрүүлгийн 2 дугаарыг олон нийтэд хүргэв.

### Байгууллагаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар мэдээлэх хэвлэлийн бага хурал 10 удаа зохион байгуулав.

### Байгууллагын цахим хуудсанд 534 мэдээ, мэдээлэл байршуулав

Байгууллагын цахим хуудасны ил тод байдал, гадаад мэдээ, мэдээ мэдээлэл, инфографик, нэвтрүүлэг, тоон график мэдээлэл зэрэг цэснүүдийн мэдээллийг тогтмол шинэчилж, нийт 534 мэдээ, мэдээлэл байршуулсан байна.

Байгууллагын твиттер, фэйсбүүк хуудсыг эрхлэн хөтөлж, нийгмийн сүлжээний орчинд албан ёсны мэдээллийг тухай бүрт түгээж ажиллав.

### Радио сонсогчдод зориулсан контент

Радио сонсогчдод зориулан авлигын мөн чанар, шалтгаан, хор хөнөөлийг таниулах, урьдчилан сэргийлэх үүднээс Дэлхийн Монголчуудын MGLRADIO 88.3 радиотой хамтран “Нэг дусал”, “Радио зөвлөгөө”, Гэр бүлийн радио 104.5-тай хамтран “Ашигтай халдвар”, “Ашигтай уриалга” зэрэг цуврал контентуудыг бэлтгэн, оюун санааны “ашигтай халдвар” тараав.

### АТГ-Олон нийтийн төв фэйсбүүк хуудас нээв

Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх мэдээ, мэдээллийг олон нийтэд энгийн ойлгомжтой, шуурхай, хүртээмжтэй хүргэх зорилгоор “АТГ-ын Олон нийтийн төв” фэйсбүүк хуудсыг нээн ажиллуулж, уг нийгмийн сүлжээний онцлогт тохирсон агуулга, контентийг мэргэжлийн байгууллагууд, уран бүтээлчидтэй хамтран боловсруулж, хөгжүүлэлтийг хийж байна.

## ИРГЭНИЙ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ

Төрийн байгууллагын үйл ажиллагаа, албан тушаалтны ёс зүй, төсөв, санхүү, худалдан авалт, нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхол, хөрөнгө, орлогын байдал хяналт тавих, авлигаас урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий Иргэний хяналтын зөвлөлийг яам, агентлаг болон орон нутгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дэргэд байгуулан, 2019 оны 5-р сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд төрийн байгууллагын 41 нэгжид 152 хүн иргэний хяналтыг хэрэгжүүлэн ажиллав.



# ГАДААД ХАРИЛЦАА ХАМТЫН АЖИЛЛАГАА

## АЗИ, НОМХОН ДАЛАЙН ОРНУУДЫН ХӨРӨНГӨ БУЦААХ БАЙГУУЛЛАГУУДЫН СҮЛЖЭЭ/ARIN-AP/-НИЙ VI БҮГД ХУРЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ

Индонези улсын Бали хотноо 2018 онд зохион байгуулагдсан Ази, номхон далайн орнуудын хөрөнгө буцаах байгууллагууд хоорондын сүлжээний Удирдах зөвлөлийн уулзалт, Бүгд хурлаас Монгол Улс удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдож, сүлжээний VI Бүгд хурал болон Удирдах зөвлөлийн хурлыг Улаанбаатар хотноо



*БНСУ-ын Ерөнхий прокурорын газрын  
Олон улсын хамтын ажиллагааны  
төвийн дэд дарга ВҮҮК ЖИН РА*

Манайх зургаан жилийн өмнө байгуулагдаж байхад 12 гишүүн улстай, 6 байгууллагыг эгнээндээ нэгтгэж байв. Өнөөдөр 25 улс, 9 байгууллагыг эгнээндээ нэгтгэж чадсан томоохон байгууллага болжээ. Манай сүлжээнд олон орон нэгдэж байгаагаас үзэхэд үр дүнгээ өгч байгаа нь харагдах байх. Сүлжээний гол ач холбогдол нь албан бус шугамаар мэдээлэл солилцох юм. Нэг улсын хуулийн байгууллагаас нөгөө улсын хуулийн байгууллага руу холбогдож маш хурдан хугацаанд мэдээлэл солилцох боломж олгодоггоороо давуу талтай. Дан ганц Ази, номхон далайн хөрөнгө буцаах байгууллага биш дэлхий даяар тархсан бүс нутаг бүрт хөрөнгө буцаах сүлжээ байгаа. Тэгэхээр манай Өмнөд Солонгосын ерөнхий прокурорын дэргэдэх Нарийн бичгийн сүлжээний газраар дамжуулаад бусад дэлхийн сүлжээнүүдтэй мэдээлэл солилцох давуу талтай.

зохион байгуулах эрхийг авч, олон улсын арга хэмжээнүүдэд тус сүлжээний 2019 оны даргалагч улсаар томилогдов. Ази, номхон далайн орнуудын хөрөнгө буцаах байгууллагууд хоорондын сүлжээний даргалагч улсын хувиар 2019 оны 9 дүгээр сарын 23-27-ны өдрүүдэд Ази, номхон далайн орнуудын хөрөнгө буцаах байгууллагууд хоорондын сүлжээ (ARIN-AP)-ний Удирдах зөвлөлийн VI Бүгд хурал, Австрали Улсын Дотоод хэргийн яамтай хамтран Олон улсын сургалтыг Улаанбаатар хотноо зохион байгуулав.



*НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй  
тэмцэх албаны зөвлөх КРИС БАТТ*

Монгол Улс бүс нутгийнхаа хэмжээнд авлигатай тэмцэх үйлсэд идэвхтэй байж, үр дүнтэй манлайлж оролцдог. Үүний нэг жишээ нь энэ том хурлыг эх орондоо зохион байгуулж буй явдал юм. Сүүлийн жилүүдэд гэмт хэргийн замаар олсон хөрөнгөө гадны улсад нуун далдлах явдал ихсэж байна. Маш нарийн зохион байгуулалт, арга хэлбэрээр энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгддэг. Үүнтэй зэрэгцүүлээд хууль сахиулах байгууллагууд ийм хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах чиглэлээр нарийн зохион байгуулалттай, үр дүнтэй ажиллах ёстой. Ийм зорилгоор анх хөрөнгө буцаах сүлжээ байгуулагдсан. Хөрөнгө буцаах сүлжээнд цагдаагийн байгууллага, прокурор, мөрдөн шалгах мэргэжилтнүүд нэгдэн ажилладаг. Ингээд албан бус шугамаар хоорондоо мэдээллийг шууд солилцож, үр дүнтэй ажилладаг юм.



Арга хэмжээнд  
гадаадын  
**24** улс, **5**  
олон улсын  
байгууллагын  
**70**, Монгол  
улсын **7** хууль  
сахиулах  
байгууллагын  
**56** төлөөлөгч  
буюу нийт  
**126** хүн  
оролцов.



## ХӨРӨНГӨ БУЦЛААХ БАЙГУУЛЛАГУУДЫН СҮЛЖЭЭ/ARIN-AP/-НИЙ VI БҮГД ХУРАЛ







## ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА, ХӨГЖЛИЙН БАЙГУУЛЛАГА МОНГОЛ УЛСЫН АВЛИГЫН ЭСРЭГ ОРЧИН, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГ ТАНИЛЦУУЛАВ

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (Organisation for Economic Co-operation and Development, OECD), Дэлхийн банк болон НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны Хулгайлагдсан хөрөнгө буцаах санаачилга (StAR) болон бусад гадаад улс орны ижил чиг үүрэг бүхий бусад байгууллагуудтай харилцан мэдээ,

хурлын үеэр Сангийн яам, Улсын ерөнхий прокурорын газрын төлөөлөгчдийн хамт тайланг хамгаалсан. Энэ үеэр Монгол Улсын авлигын эсрэг орчны үнэлгээний тайланг тус сүлжээнээс эцэслэн баталж, Монгол Улсын Ерөнхий сайд, Авлигатай тэмцэх газрын дарга нарт хүргүүлсэн. Монгол Улсын авлигын эсрэг орчинд хийсэн мониторингийн тайланг баталсны



мэдээлэл туршлага солилцох, албан хаагчдыг сурган дадлагажуулах, чадавхжуулах зэрэг чиглэлээр байнгын харилцаа холбоогоо бэхжүүлэн хамтран ажиллалаа.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Зүүн Европ, төв Азийн Авлигын эсрэг сүлжээнээс Монгол Улсын авлигатай тэмцэх тогтолцоо, эрх зүйн орчинд хийсэн 4 дэх удаагийн үнэлгээний тайланг бэлтгэн хүргүүлж, 2019 оны 3 дугаар сард Парис хотод зохион байгуулагдсан тус сүлжээний Бүгд

мөрөөр Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Авлигын эсрэг сүлжээний зөвлөхүүд 2019 оны 7 дугаар сарын 29, 30-ны өдөр Монгол Улсад айлчлал хийж, мониторингийн тайлан, зөвлөмжийг олон нийт болон төрийн байгууллагуудад танилцуулах хэвлэлийн бага хурал хийсэн.

Тус сүлжээнээс гаргасан үнэлгээний тайланг монгол хэлээр орчуулж, тусгагдсан зөвлөмжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр ажиллаж байна.

### Монгол Улсын авлигатай тэмцэх тогтолцоо, эрх зүйн орчинд хийсэн хийсэн 4 дэх удаагийн үнэлгээний зөвлөмж:

#### Авлигаас урьдчилан сэргийлэх ажиллагаа

##### Зөвлөмж 9

1. Шүгэл үлээгчийг хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлэх болон шүгэл үлээхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах практик механизм бий болгох;
2. Шүгэл үлээгчийг хамгаалах статистик тоо, мэдээлэл, баримтыг цуглуулах, дүн шинжилгээ хийх;
3. Шүгэл үлээхийг дэмжих зорилгоор хамгаалалтын механизм, мэдээлэх сувгийн талаар олон нийтийг соён гэгээрүүлэх, мэдлэгийг нэмэгдүүлэх;

##### Зөвлөмж 10

1. Өндөр түвшний улс төрийн албан тушаалтнуудад чиглэсэн шударга ёсны зохицуулалтуудыг идэвхтэй, үе шаттай, тууштай мөрдөх байдлыг хангах;

- Улс төрийн албан тушаалтнуудын хөрөнгө, орлогын мэдүүлгийг системтэй, тууштай, объектив байдлаар хянах, шалгах явдлыг хангах, ингэхдээ иргэдийн өгсөн мэдээлэлд үндэслэх, хуулийн дагуу дараа дараагийн хяналтыг хэрэгжүүлэх;
- Улс төрийн албан тушаалтнуудын ёс зүйн дүрмийг батлах;
- Шударга ёсны болон ёс зүйн дүрмийн зохицуулалтыг бодит байдалд улс төрийн албан тушаалтан сахин биелүүлэхэд зориулан сургалт, зөвлөгөө, гарын авлагаар хангах;

#### Авлигын гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага ногдуулах

##### Зөвлөмж 16

- Авлигын гэмт хэрэгтэй тэмцэхэд хүндрэл учруулж болзошгүй, олон улсын стандартад нийцээгүй, шинэ хуулийн зүйл, заалтууд дахь дутагдалтай талыг олж тогтоох зорилгоор шинэ Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалтуудад дүн шинжилгээ хийж, холбогдох оролцогч талуудын уулзалт, ажлын хэсгийн үйл ажиллагааг үргэлжлүүлэх;
- Энэхүү санал солилцох хамтын ажиллагаанд шүүгч, прокурор, АТГ-ын ажилтнууд болон бусад холбогдох дотоод, гадаадын шинжээчдийн үндэслэл бүхий санал бодлыг анхаарч авч үзэх нөхцөлийг хангах;

##### Зөвлөмж 17

- Хээл хахууль өгөх, авах гэмт хэргийн бүрэлдэхүүнийг олон улсын стандартад нийцүүлэх, ялангуяа хээл хахууль өгөх, авах гэмт хэргийн найруулгад нэг ижил бүрэлдэхүүнийг тусган оруулах, гуравдагч этгээдийн ашиг сонирхлын төлөө хээл хахуулийн гэмт хэрэг үйлдэх, хээл хахууль санал болгохыг хүлээн зөвшөөрөх гэмт хэргийг тодорхой заах;
- Хээл хахууль өгөх, авах гэмт хэрэгт зориулагдан хэрэглэгдэх, мөнгөн бус болон биет бус ашиг хонжоог багтаасан “хээл хахууль”-ийн гэмт хэргийн тодорхойлолтыг Эрүүгийн хуульд нэмж оруулах;
- Бүх төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллагын албан тушаалтнууд, төрийн чиг үүргийг хэрэгжүүлж байгаа этгээд болон сонгуульд албан тушаалд нэр дэвшигчийг багтаасан дотоодын нийтийн албан тушаалтны тодорхойлолтыг Эрүүгийн хуульд нэмж тусгах;
- Эрүүгийн хууль дахь бүх авлигын гэмт хэргийн найруулгыг дахин нягталж, хууль зүйн техникийг сайжруулж, хуулийн томъёоллыг илүү тодорхой, ойлгомжтой болгох;

##### Зөвлөмж 18

- Эрх нөлөөгөө худалдах үйлдлийг гэмт хэрэгт тооцох, хувийн хэвшил дэх хээл хахуулийн гэмт хэргийн зохицуулалтыг олон улсын стандартад нийцүүлэх;
- Эрх зүйн тодорхой, ойлгомжтой байдлыг хангаж, эрх мэдлээ урвуулах гэмт хэргийн хамрах хүрээг тодорхой болгох арга хэмжээг авах;
- Мөнгө угаах гэмт хэргийг мөрдөн шалгах, ялах, шүүхээр хэлэлцэхэд хавсарга шинжтэй үйлдэгдсэн гэмт хэрэгт гэм буруутайг нотлох шаардлагагүй болгохын тулд хууль эсхүл практикт шаардлагатай арга хэмжээг авах;
- Хууль бусаар хөрөнгөжих гэмт хэргийн холбогдох зохицуулалтыг Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн 20 дугаар зүйлд нийцүүлэх;

##### Зөвлөмж 19

- Хуулийн этгээдэд хариуцлага тооцох тухай хуулийн зохицуулалтыг дахин хянаж, дүйцэхүйц бөгөөд тохирохуйц ял шийтгэлийг тусгах, ялангуяа зохих хяналт тавиагүй удирдлагад хариуцлага тооцдог болох, хувь хүний үйлдсэн гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах, ялах ажиллагаанаас хамааралгүйгээр компанид хариуцлага тооцох нөхцлийг хангах. Авлигын эсрэг бодлого, хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлж байгаа компаниудыг хариуцлагаас чөлөөлөх заалтыг тусгах;
- Гадаад орнуудын жишээн дээр хуулийн этгээдэд хариуцлага ногдуулах тухай мөрдөгч, прокурор, шүүгч нарт зориулсан сургалтын хөтөлбөрийг боловсруулах;

##### Зөвлөмж 20

- Гадаадын болон олон улсын байгууллагын албан тушаалтантай холбогдох хээл хахуулийн гэмт хэргийн тайлбарыг олон улсын стандартад нийцүүлэн сайжруулж, Эрүүгийн хуульд ийм албан тушаалтныг тодорхой заах;



### **Зөвлөмж 21**

1. Үнэлгээнд суурилсан хөрөнгө хураан авах ажиллагаа болон түүнийг зохицуулах тодорхой журмыг батлах;
2. (Эрүүгийн эсхүл иргэний) өргөтгөсөн хөрөнгө хураан авах ажиллагааг нэвтрүүлж, авлигын гэмт хэрэг үйлдсэн сэжиг бүхий тохиолдол илэрсэн бол нотолгоо гаргах үүргийг хариуцагч талд шилжүүлдэг болох;
3. Мэдэж байсан гуравдагч талын өмчлөлд байгаа нь тогтоогдсон хөрөнгө (авлигын гэмт хэргээс олсон хөрөнгө орлого, хэрэгсэл тэдгээрийн үр шим)-ийг хураан авах ажиллагаа явуулах эрх зүйн үндэслэлийг тодорхой болгох;

### **Зөвлөмж 22**

1. Нийтийн албан тушаалтны халдашгүй байдлыг дахин авч үзэх, ардчилсан улсад байх ёстой хэмжээнд халдашгүй байдлыг эдэлдэг албан тушаалтнуудын тоог бууруулж, халдашгүй байдлын хамрах хүрээг багасгах; ингэж авч үзсэний дараа байх ёстой гэж үзсэн халдашгүй эрх дархыг зөвхөн тухайн албан тушаал хаших явцад эдэлдэг байхаар зохицуулж, гэм буруу нь үйлдэл дээрээ тогтоогдсон бол халдашгүй байдлыг цуцлах, халдашгүй байдлыг эдэлж байгаа этгээдийг мөрдөн шалгах үр дүнтэй арга хэмжээг хүлээн зөвшөөрөх, тодорхой шалгуур дээр үндэслэж халдашгүй байдлыг тэр даруй цуцлах журмыг бий болгох;
2. Авлигын гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг нэмэгдүүлэх; гэмт хэргийн хүнд, хөнгөнөөс үл хамааран бүх төрлийн авлигын гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг хангалттай хэмжээгээр сунгах; хариуцлага тооцох, бусад процессын ажиллагаа болон халдашгүй байдалд байгаа этгээдийн хөөн хэлэлцэх хугацааг түдгэлзүүлэх зохицуулалтыг тусгах;

### **Зөвлөмж 23**

1. Гэм буруугаа хүлээхэд ялаас хөнгөлж, чөлөөлөх хуулийн зохицуулалтын хамрах хүрээг дахин хянан үзэж, энэхүү заалтын шууд хэрэгжих шинжийг халж, хээл хахууль өгөгч этгээд энэ тухайгаа мэдэгдсэний улмаас хариуцлагаас чөлөөлөгдөх боломжит хугацааг хязгаарлах;

### **Зөвлөмж 24**

1. Мөнгө угаах, авлигын гэмт хэргийн ял шийтгэлийг дахин хянан үзэж, ялын үр нөлөөтэй, дүйцэхүйц, тохирохуйц байдлыг хангах;
2. Авлигын гэмт хэрэгт ногдуулах ял шийтгэлийн хэрэглээний талаарх тоон мэдээг нэгтгэн гаргах, дүн шинжилгээ хийх (тухайлбал, тэнсэн харгалзах ялыг оногдуулсан тоо, ноцтой гэмт хэрэгт ногдуулах үндсэн ял нь хорих ял байгаа эсэх гэх мэт), практик дээр тэдгээр ял шийтгэл нь үр нөлөөтэй байгаа эсэхийг судлах;

### **Зөвлөмж 25**

1. Татвар, гааль болон бусад төрийн бүртгэл, мэдээллийн сан, аудитын тайлан болон бусад дүн шинжилгээ бүхий эх сурвалжаас мэдээлэл авч ашиглан, авлигын гэмт хэргийн илрүүлэлтийг идэвхжүүлэх нөхцөл байдлыг хангах. Санхүүгийн мэдээллийн албаны сэжигтэй мөнгөн гүйлгээний тайлан болон гадаад улсын санхүүгийн мэдээллийн албадын тайлан мэдээг ашиглаж, авлигын гэмт хэргийг илрүүлэх тал дээр АТГ болон Санхүүгийн мэдээллийн алба хооронд үр бүтээлтэй хамтын ажиллагааг хангах;
3. АТГ-ын мөрдөгч нар холбогдох төрийн бүртгэл мэдээллийн сангаас шууд мэдээлэл авах эрхийг хангаж, эдгээр мэдээллийг нотлох баримт болон мөрдөн шалгах ажиллагааны бусад зорилгоор ашиглах боломжийг бүрдүүлэх;
5. АТГ-т санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа, дүн шинжилгээ хийх чиг үүрэг бүхий нэгжийг тусад нь байгуулах;
7. Авлигын гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах чиглэлийн чадавхийг бэхжүүлэх зорилгоор Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (тухайлбал, хамтран ажиллах)-иар олгосон мөрдөн шалгах ажиллагааны шинэ арга, хэрэгсэл болон бусад сэдвээр АТГ-ын мөрдөгч болон тэдгээрт хяналт тавьж ажилладаг прокуроруудад зориулж үе шаттай сургалт зохион байгуулах;



8. Хөрөнгө хураах эсхүл хураагдсан хөрөнгийг удирдах чиг үүрэг бүхий тусгай байгууллага эсхүл нэгжийг байгуулах, авлигын гэмт хэргийн гаралтай хөрөнгө орлогыг мөрдөх, тогтоох, хураах, удирдах үр нөлөөтэй журмыг хэрэгжүүлэх;

#### **Зөвлөмж 26**

1. Авлигын гэмт хэргийг мөрдөн шалгах, ялах ажиллагаан дахь олон улсын эрх зүйн харилцан туслалцааг үр дүнтэй явуулах нөхцөл байдлыг хангах;
2. Авлигын гэмт хэрэгт олон улсын хамтын ажиллагаа явуулах чиглэлээр бусад улс оронтой байгуулах хоёр талт гэрээний тоог нэмэгдүүлэх;
4. Холбогдох олон улсын авлигын эсрэг сүлжээ, олон улсын хамтын ажиллагааны шинжээчдийн уулзалтад АТГ болон прокуроруудын оролцоог нэмэгдүүлэхэд шаардлагатай эх үүсвэрээр хангах;
5. Үндэсний эрх бүхий байгууллагын цахим сан болон Засгийн газар хоорондын шинжээчдийн нээлттэй уулзалт гэх мэт Авлигын эсрэг НҮБ-ын конвенцид заасан авлигын гэмт хэргийг мөрдөн шалгах чиглэлийн олон улсын хамтын ажиллагааны арга хэрэгслийг ашиглаж, олон улсын хамтын ажиллагаагаа сайжруулах;
6. АТГ-ын холбогдох гадаад улсын авлигын эсрэг байгууллагуудтай байгуулсан хоёр талт хамтын ажиллагааг өргөжүүлэх;
7. Хамтарсан ажлын хэсэг байгуулах, хүсэлт хүлээн авагч улсын эрх бүхий байгууллагад хүсэлтийг биелүүлэхэд нь туслалцаа үзүүлэх, хүсэлт илгээхээс өмнө албан бусаар зөвлөгөө авах, хүсэлтийг биелүүлэх явцад зохицуулалтын арга хэмжээ авахад чиглэсэн төрөл бүрийн хэлбэрийн шууд хамтын ажиллагааг авлигын гэмт хэрэг дээр, түүний дотор хөрөнгө буцаах ажиллагаан дээр өрнүүлэх ажлыг хөхиүлэн дэмжих;
8. Эрх бүхий төв байгууллага дахь олон улсын хамтын ажиллагаа хариуцсан нэгжийн албан хаагчид болон эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт боловсруулж, ирүүлсэн хүсэлтийг биелүүлдэг АТГ-ын мөрдөгч, прокуроруудыг сургалтад сайтар хамруулж, орчуулагч, шаардлагатай харилцааны арга хэрэгсэл зэрэг зохих эх үүсвэрээр тэднийг хангах; сургалтын хөтөлбөрт сайн туршлага, үүсч болох хүндрэл бэрхшээл, тэдгээрийг давж гарах арга зам, бусад улсын туршлага, түүнчлэн олон улсын байгууллагаас олгодог боломж болон арга хэрэгслийг үр дүнтэй ашиглах зэрэг сэдвийг тусгасан байх;
9. Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн 53 дугаар зүйлд заасны дагуу хөрөнгө шууд буцаах ажиллагаа, түүнчлэн уг Конвенцийн 57 дугаар зүйлд заасан хөрөнгө буцаах болон зарцуулах нөхцөл, журмыг хууль тогтоомжид тусгах;

#### **Зөвлөмж 27**

1. Шалгагдсан болон шүүхэд шилжүүлсэн авлигын гэмт хэргийн тоонд гарч байгаа зөрүүтэй байдалд дүн шинжилгээ хийх, шүүхээс өмнөх шатанд хэргийг хэрэгсэхгүй болгож байгаа үндэслэлтэй холбоотой асуудал гарч байгаа бол түүнийг шийдвэрлэх.
2. Шүүхийн шатанд хариуцлага тооцсон шийдвэр гаргахад дөхөм үзүүлэхүйц мөрдөн шалгах, хэрэгт хяналт тавих ажиллагааг хангах;
3. Авлигын хэрэг бүр дээр гэмт хэргээс үүсэлтэй хөрөнгө орлого, хэрэгсэл, тэдгээрийн үр шимийг хураан авахыг эрэлхийлэх;
4. Дээд түвшний авлигын гэмт хэргийг шуурхай, үр дүнтэй шалгах, түүнчлэн гадаад улсын албан тушаалтан оролцсон хээл хахууль, мөнгө угаах, хууль бусаар хөрөнгөжих гэмт хэргийг идэвхтэй илрүүлэх, мөрдөн шалгах, ял ногдуулахад онцгой анхаарал хандуулах;
5. Дээд түвшний авлигын гэмт хэргийг шалгаж, гэм бурууг тогтоон, гэмт хэргийн үүсэлтэй хөрөнгийг хураан авсан ажиллагааны үр дүнгийн талаар олон нийтэд мэдээлэх;

#### **Зөвлөмж 28**

1. Авлигын гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааг мэргэжлийн өндөр түвшинд явуулахад шаардлагатай хүний нөөц, санхүү төсөв түүний дотор мөрдөгчдийн тоог хангалттай нэмэгдүүлж, эдийн засаг, санхүүгийн болон техникийн чиглэлийн мэргэжилтнүүдээр Авлигатай тэмцэх газрыг хангах;



Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын үнэлгээний тайлан, зөвлөмжийг бүрэн эхээр нь <https://www.iaac.mn/news/ediin-zasgiin-khamtiin-ajillagaa-khugjliin-baiguullagii-unelgeenii-tailan-zuwlumj-2sh19?menu=82> холбоосоор хүлээн авна уу.

3. Орон нутагт үйл ажиллагаа явуулдаг мөрдөгчийн орон тоо бүхий АТГ-ын салбар (байгуулагдахаар шийдвэрлэсэн)-ыг бүс нутагт байгуулах;
4. Авлигад хамгийн их өртдөг гэж тодорхойлогдсон салбарыг тэргүүлэх чиглэлээр тодорхойлж, түүний дагуу АТГ-ын Мөрдөн шалгах хэлтсийн нөөц, бололцоог хуваарилах. Тэргүүлэх чиглэлийг тодорхойлох эх сурвалжуудын дунд тус газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн эрсдэлтэй салбарыг тодорхойлохоор хэрэгжүүлсэн дүн шинжилгээний ажлын үр дүнг хэрэглэхийг харгалзан үзэх;
6. АТГ-ын мөрдөн шалгаж байгаа гэмт хэрэгт хяналт тавьдаг Нийслэлийн прокурорын газрын холбогдох нэгжийг мэргэшсэн болгож, уг нэгжийг шаардлагатай төсөв, хүний нөөц, хараат бус байдлаар хангаж, авлигын гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаа, санхүүгийн гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаа, гүйцэтгэх ажиллагаа зэрэг сэдвээр тогтмол сургалтад хамруулах;
7. Авлигын гэмт хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралд оролцох шүүгч болон тухайн шүүх хуралд Нийслэлийн прокурорын газрыг төлөөлөн улсын ялагчаар оролцох орон нутгийн прокуроруудыг мэргэшүүлэх ажлыг анхаарч, тэдгээрийг мэргэшүүлэх сургалтад хамруулах;

### Улс төрийн намын санхүүжилт

#### Зөвлөмж 29

1. Гишүүний татварт хязгаар тогтоох, “хандив” гэх нэр томъёог өргөн хүрээтэй тодорхойлж, мөнгөн бус туслалцаа гэх ойлголтыг хамруулах, улс төрийн нам болон түүний төлөөлөгчийн харьяалалд, тэдгээртэй холбоотой ажилладаг бүх этгээдүүдийг хандивын хязгаарлалтын хүрээнд оруулах, хандивын талаарх мэдээллийг хэвлэн нийтлэх журмыг заах, төрийн худалдан авах ажиллагаа болон бусад төрийн эх үүсвэрээс санхүүжилт авсан аж ахуйн нэгжүүдээс хандив авахыг хязгаарлах замаар улс төрийн намын санхүүжилтийг зохицуулах тогтолцоог бэхжүүлэх;
2. Улс төрийн намд олгох хувийн болон төрийн санхүүгийн дэмжлэгийн тэнцвэрт харьцааг хангаж, төрөөс хүлээн авсан санхүүжилтийг зарцуулахад хязгаарлалт тогтоох;
3. Санал хураалтын босго хязгаараас доогуур байсан ч үндэсний хэмжээний сонгуулиар тодорхой түвшинд олон нийтийн дэмжлэгийг авсан улс төрийн намуудад төрөөс санхүүгийн дэмжлэг олгодог байх;
4. Улс төрийн намын санхүүжилтийг бүрэн ил тод болгож, хандив өгсөн бүх этгээд, тэдгээрийн хандив, түүнчлэн намын тайлагнасан зардлыг тусгасан жилийн санхүүгийн нэгдсэн дэлгэрэнгүй тайланг гаргуулдаг болох;
5. Улс төрийн намын санхүүгийн нэгдсэн дэлгэрэнгүй тайланг стандартад оруулж, интернетэд нийтэлдэг болгох;
6. Санал хураалтын өдрөөс өмнө санхүүгийн дэлгэрэнгүй тайланг хүргүүлэх, хэвлэн нийтлэх зэргээр сонгуулийн үйл ажиллагааны санхүүгийн мэдээллийг ил тод болгох журмыг болвсронгүй болгох;
7. Улс төрийн намын болон сонгуулийн санхүүжилтэд хяналт тавих, үнэлгээ хийх хараат бус, зохих нөөц бололцоо, эрх мэдэл бүхий, түүнчлэн гаргасан зөрчилд дүйцэхүйц болон тохирохуйц хариуцлага ногдуулах эрх хэмжээтэй тогтолцоог даруй бий болгох;
8. Улс төрийн намын санхүүжилтэд хяналт тавих эрх мэдлийг авлигатай тэмцэх байгууллагад өгөх асуудлыг авч үзэх;
9. Сонгуулийн ерөнхий хороог мэргэшсэн, хараат бус, чадахуйн зарчимд суурилсан, хэрэв боломжтой бол нээлттэй сонгон шалгаруулалтаар авсан орон тооны гишүүдтэй байх нөхцлөөр хангах;
10. Улс төрийн намын санхүүжилт (улс төрийн нам, тэдгээрийн удирдлагаас хийсэн санхүүгийн шилжүүлэг)-ийг дотоодын мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх дэглэмийн хүрээнд хамруулах;

## ГАДААД ХАРИЛЦАА ХАМТЫН АЖИЛЛАГАА

Гадаад улсын авлигатай тэмцэх байгууллагатай тогтоосон хамтын ажиллагааг, бэхжүүлэх хүрээнд 2019 оны 7 дугаар сарын 9-12-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Азербайжан Улсын Ерөнхий прокурорын газрын дэргэдэх Авлигын эсрэг газрын дарга Камран Алиев тэргүүтэй төлөөлөгчид албан ёсны айлчлал хийв.



БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Хонг Конгийн Авлигатай тэмцэх бие даасан хорооны төлөөлөгчдийг 2019 оны 6 дугаар сарын 3-4-ний өдрүүдэд хүлээн авч харилцан туршлага солилцов. Авлигатай тэмцэх газар нь Хонконгийн Авлигатай тэмцэх бие даасан хороотой 2007 онд харилцаа, хамтын ажиллагаа эхлүүлснээс хойш уулзалт, сургалт зохион байгуулж, харилцан туршлага солилцон ажиллаж байна.



БНСУ-ын Авлигын эсрэг, иргэний эрхийн хорооны төлөөлөгчд 2019 оны 5 дугаар сарын 22-23-ны өдрүүдэд Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагаатай танилцахын зэрэгцээ өөрийн авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга, туршлагаас хуваалцаж, сургалт зохион байгуулав. Тухайлбал, БНСУ-ын авлигын эсрэг соён гэгээрүүлэх ажил, авлигын нөлөөллийн үнэлгээ, төрийн бодлогын болон эрх зүйн аливаа баримт бичиг батлагдахын өмнөх шатанд хийгдэх эрсдэлийн үнэлгээ болон шүгэл үлээгчийг хэрхэн хамгаалдаг талаарх туршлагаасаа хуваалсан байна.



Авлигатай тэмцэх газраас тавьсан хүсэлтийн дагуу НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба болон Дэлхийн банкны хамтарсан түншлэл болох “Хулгайлагдсан хөрөнгийг буцаах санаачилга”-ын төлөөлөгчид Монгол Улсад хүрэлцэн ирж, санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны дунд шатны сургалтыг 2019 оны 4 дүгээр сарын 8-11-ний өдрүүдэд зохион байгуулаа.

Сургалтад Авлигатай тэмцэх газар, Тагнуулын Ерөнхий газар, Улсын Ерөнхий Прокурорын газар, Нийслэлийн Прокурорын газар, Цагдаагийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Монголбанкны Санхүүгийн мэдээллийн алба, Гаалийн ерөнхий газрын албан хаагчид хамрагдав.





“Хулгайлагдсан хөрөнгийг буцаан олгох санаачилга”-тай хамтран иргэдэд нийтийн албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянах, задлан шинжилгээ хийх чадавх эзэмшүүлэх сургалтыг 4 дүгээр сарын 15-16 өдрүүдэд зохион байгуулав. Онол, дадлага хосолсон хоёр өдрийн чадавхжуулах сургалтад 60 гаруй иргэн, ТББ-ын төлөөлөл хамрагдлаа.



Авлигатай тэмцэх газрын дэд дарга, эрхэлсэн комиссар Ж.Батсайхан БНХАУ-д суугаа Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Элчин сайдын яамны дэргэдэх тус улсын Гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний газрын суурин төлөөлөгч Давид Күүпэрийг 2019 оны 9 дүгээр сарын 5-ны өдөр хүлээн авч ажил хэргийн уулзалт хийв.



Авлигатай тэмцэх газрын дарга, тэргүүн комиссар З.Дашдаваа 2019 оны 8 дугаар сарын 29-ний өдөр Америкийн Нэгдсэн Улсын Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны хороо (Хельсинки хороо)-ны Ажлын албаны дарга Алекс Жонсон, зөвлөх Паул Массаро, Элчин сайдын яамны дэд тэргүүн Грегори Мэй, Улс төрийн хэлтсийн дарга Андреа Гудман нарыг хүлээн авч уулзав.



Авлигатай тэмцэх газрын дарга, тэргүүн комиссар З.Дашдаваа, Тамгын хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар З.Баасанням нар Бүгд Найрамдах Казахстан Улсын Нур-Султан хотноо 2019 оны 10 дугаар сарын 2-4-ний өдрүүдэд болсон Авлигын эсрэг олон улсын академийг Олон улсын байгууллага болгон өөрчлөх тухай хэлэлцээрт Оролцогч талуудын 8 дахь удаагийн чуулга уулзалтад оролцлоо.



# ОРОН НУТАГТ

2019 онд Авлигатай тэмцэх газрын ажлын хэсэг орон нутагт албан томилолтоор ажиллах хугацаандаа авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлан таниулах, уулзалт ярилцлага хийх, санал хүсэлтийг сонсох, гомдол мэдээлэл хүлээн авах зэрэг голчлон иргэдэд чиглэсэн соён гэгээрүүлэх арга хэмжээг 21 аймагт зохион байгуулав.

“Иргэн төвтэй соён гэгээрүүлэх өдөрлөг”, “Олон нийтийн хяналт ба шударга ёс” сэдэвт уулзалт, “Төрийн албан хаагч, эрх бүхий албан тушаалтанд зориулсан сургалт семинар” гэсэн 3 төрлийн арга хэмжээг хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

## “АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР-ТАНАЙ АЙМАГТ” СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ӨДӨРЛӨГ

Зарим аймагт иргэдэд зориулсан төрийн үйлчилгээний нээлттэй өдөрлөг, хууль зүйн зөвлөгөө өгөх, уралдаан тэмцээн зохион байгуулах, дүгнэх зэрэг үйл ажиллагааг “Иргэн төвтэй соён гэгээрүүлэх өдөрлөг”-тэй хамтатган зохион байгуулсан нь иргэдэд нэг цэгээс олон төрлийн мэдээлэл, зөвлөгөө авах, гомдол мэдээлэл өгөх, яриа таниулгад оролцох, санал бодлоо илэрхийлэх, зарим үйлчилгээг газар дээрээс нь авах боломж олгосон арга хэмжээ боллоо гэж иргэд онцолж байв.

“Иргэн төвтэй соён гэгээрүүлэх өдөрлөг”-ийн үеэр Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн видео шторкыг үзүүлж, авлига, албан тушаалтны хүнд суртлын талаар гомдол, мэдээлэл хүлээн авах цахим хаяг, “110” дугаарын утсыг танилцуулан сурталчилснаас гадна, авлига, ашиг сонирхлын гэмт хэрэг, зөрчлийн талаарх ерөнхий ойлголт, хор хөнөөл, үр дагавар, мөн албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлэг, түүнд тавих иргэдийн хяналтын талаар мэдээлэл өгсөн юм.



Уг өдөрлөгийн арга хэмжээний үеэр ажлын хэсгээс иргэдэд хууль зүйн зөвлөгөө өгч, төрийн үйлчилгээний талаар ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлага хийж иргэдийн өмнө тулгарч буй асуудал, бэрхшээлийг сонсож, санал гомдлыг хүлээн авсан.



Орон нутагт ажиллах явцад 16 төрлийн

**48275**

ширхэг гарын авлага, тараах материалыг иргэд, төрийн байгууллагад түгээсэн байна.



## “ОЛОН НИЙТИЙН ХЯНАЛТ БА ШУДАРГА ЁС” СЭДЭВТ УУЛЗАЛТ

Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа, мөрдөн шалгах болон хяналт шалгалтын үйл ажиллагааны талаар иргэдэд мэдээлэл өгч, тэдний санал хүсэлтийг сонсов.

Уулзалтаар иргэдэд Авлигатай тэмцэх газрын зорилго, хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Авлигатай тэмцэх газраас эрхлэн гүйцэтгэдэг “Шударга байдлын үнэлгээ”, “Хүүхдийн шадарга байдлын үнэлгээ” зэрэг судалгааны үр дүн, авлигын нөхцөл байдлын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл өгсөн.

Уулзалт, өдөрлөгийн үеэр 100 орчим иргэн Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагаа, тэдний амьдралд тохиолдож буй асуудал, бэрхшээл, шийдвэрлэх арга зам болон хамтран ажиллах талаар санал бодлоо илэрхийлж, авлигын эсрэг тэмцэх үйл ажиллагаанд амжилт хүсч байлаа.



Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын хоёрдугаар багийн иргэн Д.Гансүх: Авлигатай тэмцэх газраас ирж иргэдээ сонсож, үйл ажиллагааныхаа талаар товчхон бөгөөд ойлгомжтой мэдээлэл өгч буйд талархаж, өнөөдрийн уулзалтаас иргэдийн хяналт, оролцоо чухал гэдгийг ойлголоо.



Дорноговь аймгийн Сайншанд сумын иргэн н.Буян-Амгалан: Авлигатай тэмцэх газраас иргэдтэй уулзаж байгаад би талархаж байна. Залуучуудыг соён гэгээрүүлэх ажлыг маш их хийх ёстой гэж би хувьдаа боддог. Мэдээж танай хүч хүрэлцэхгүй, ойлгомжтой. Эрх зүйн талаасаа ямар боломж байдгийг мэдэхгүй юм. Соён гэгээрүүлэх чиглэлээр олон нийтийн, албан, албаны бус байгууллагыг байгуулж болохгүй юу? Тэтгэвэрт гарсан ахмадууд гэртээ зүгээр шахуу л сууцгааж байна. Оюуны потенциалтай, ажлын маш их арга туршлагатай энэ хүмүүсийг зохион байгуулалтад оруулдаг ч юм уу, сайн дурын үндсэн дээр ч юм уу олон нийтийн байгууллага байгуулаад, тэгээд тэр залуусдаа сургадаг баймаар байна.



Ховд аймгийн иргэн н.Пэлжээ: АТГ харьцангуй сайн ажиллаж байгаа гэж ойлгодог. Гол нь авлигын том хэргүүдийг шүүх дээр яаж шийдвэрлэдэг нь ард иргэд бидэнд ойлгомжгүй байна. Миний бодлоор шүүх дээр олон хэрэг байхгүй болдог юм шиг байна. Тэгэхээр АТГ-ыг улам илүү өргөжүүлэх, хүч чадалтай болгох ёстой хэмээн саналаа хэлэв.



“Иргэн төвтэй соён гэгээрүүлэх өдөрлөг” болон “Олон нийтийн хяналт ба шударга ёс” сэдэвт уулзалтад **21** аймгийн **3496** иргэн оролцсон байна.

## ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ ХҮЛЭЭН АВЧ, БОЛОМЖТОЙ ТОХИОЛДОЛД ГАЗАР ДЭЭР НЬ ШИЙДВЭРЛЭН, ЗӨВЛӨГӨӨ, МЭДЭЭЛЭЛ ӨГӨВ

Ажлын хэсэг аймаг бүрт иргэдтэй уулзаж, ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага зохион байгуулан иргэдийн санаа бодол, гомдол, мэдээллийг хүлээн авав.

Иргэдийн гомдол, мэдээллийг газар дээр нь шийдвэрлэхэд анхааран ажиллалаа. Тухайлбал, Ховд аймгийн иргэд, олон нийттэй уулзалт, ярилцлага хийж, соён гэгээрүүлэх өдөрлөг зохион байгуулах үеэр иргэдээс олон тооны санал, гомдол, мэдээлэл өгсөн бөгөөд тэдгээрийн нэг нь дулааны шугам солихтой холбоотой гомдол байв.

Өндөр настан А “орон сууцны дулааны шугамыг солихдоо шинийг тавилгүй, хуучныг нь буцаан булж, оршин суугчдыг хууран мэхэлж байна, шугамыг дулаалан хучаагүй, хавтан тавихгүй байгааг аймгийн холбогдох албан тушаалтнууд хянахгүй байна” гэсэн гомдол хэлэв. Авлигатай

тэмцэх газрын ажлын хэсгээс Цамбагарав багийн нутаг дэвсгэрт тавигдаж байгаа дулааны 1,5 км магистрал шугамын ажилтай газар дээр нь танилцаж, Ховд аймгийн Мэргэжлийн хяналтын газарт иргэдийн эрх ашгийг зөрчсөн байж болзошгүй гомдлыг уламжилж, илэрсэн зөрчлийг газар дээр нь арилгуулан, цаашид мэргэжлийн байгууллагаас зохих хяналт тавьж ажиллахыг анхааруулав.




## НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БОЛОН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ТУШААЛТНУУДАД ТУСГАЙЛСАН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАВ

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллагын албан хаагчид, эрх бүхий албан тушаалтнуудыг чадавхижуулах зорилгоор зохион байгуулсан сургалт, семинарт 21 аймгийн **5238** албан хаагч оролцов.





## ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭЙ ТАНИЛЦАВ



Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, авлигын эсрэг хууль тогтоомж, АТГ-аас хүргүүлсэн ЗӨВЛӨМЖ-ийн хэрэгжилттэй газар дээр нь танилцах, арга зүйн зөвлөгөө өгөх АТГ-ын ажлын баг 2017 онд 21 аймагт 3 удаа, давхардсан тоогоор 144 суманд ажиллаж, үр дүнг орон нутгийн удирдлагад газар дээр нь танилцуулж байв. Тухайлбал, 2018 онд цөөн тооны хүчийг оновчтой зохион байгуулан 21 аймаг, 50 суманд, 2019 онд 21 аймгийн төвийн 21 сумдад ажилласан нь хамрагдсан байгууллага, орон нутгийн тоог 2013-2014 онтой харьцуулахад 4 дахин нэмэгдүүлсэн байна. Хэдийгээр төрийн үйлчилгээний хүнд суртлыг багасгах, нээлттэй, ил тод байдлыг хангах, хариуцлагыг дээшлүүлэх, шударга ёсны үнэлэмжийг сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үрдүн гарч байгаа боловч шалгалтын явцад ажлын багаас төрийн байгууллагууд авлига, ашиг сонирхлын зөрчилд өртөх эрсдэлийг бууруулах, дотоод хяналт, санхүүгийн сахилга батыг сайжруулах талаар дорвитой арга хэмжээ аваагүй, төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны нээлттэй байдлыг боломжит түвшинд хангаагүй, мэдээлэгчийг хамгаалах тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр анхаарч ажиллаагүй байна гэсэн дүгнэлтэд хүрсэн болно. Иймд, авлигын түвшинг бууруулах, авлигын эрсдэл үүсгэж буй хүчин зүйл, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, зөрчлийг давтан гаргахгүй байх зорилгоор Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээний байгууллагын удирдах албан тушаалтнууд болон нийслэл, аймаг, орон нутгийн удирдлагад, албан хаагчдад илэрсэн нөхцөл байдлын талаар танилцуулж, Засгийн газарт Зөвлөмж хүргүүлээ. Засгийн газрын гишүүдэд салбар бүрийн авлигын нөхцөл байдлын талаар тусгайлсан зөвлөмж хүргүүлэн, илэрсэн зарим зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх, эрсдэлээс хамгаалах чиглэлээр хамтран ажиллаж байна.



## ОРОН НУТАГТ ИЛЭРЧ БҮЙ НИЙТЛЭГ ЗӨРЧЛҮҮД:

### Хэм хэмжээний акт тогтоох эрхгүй этгээд дүрэм, журам батлан мөрдүүлж байна

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-т “Хуульд заасан хязгаар, шаардлагад нийцүүлэн орон нутгийн зарим татвар, төлбөр, хураамжийн хувь хэмжээг тогтоох” эрхийг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд олгосон байхад дээрх заалтыг зөрчин иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид өөрт олгогдоогүй эрхийг хэрэгжүүлж, шийдвэр гаргаж байна.


-Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсэгт “Захиргааны хэм хэмжээний актыг хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллага батална” гэж заасныг зөрчсөн, мөн хуулийн 65 дугаар зүйлийн 65.1-т заасны дагуу хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлж, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх” гэснийг мөрдөхгүй байна.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т заасан “Энэ хуулийн ... 27.1.1, 27.1.4-27.1.6 дахь заалт, 27.2-27.4 дэх хэсэг, ... -т заасан тэмдэгтийн хураамжийн хэмжээг энэ хуульд заасан хязгаарт багтаан Засгийн газар тогтооно.” гэж заасан байтал уг хэмжээг Засгийн газар бус Эрүүл мэндийн сайд баталсан (“Тэмдэгтийн хураамжийн төлбөрийн хэмжээ, зардлын жишиг”) -ыг эргэж нягтлах, хуульд нийцүүлэхтэй холбоотой зөвлөмжийг АТГ-аас Засгийн газар, Эрүүл мэндийн сайдад хүргүүлсэн боловч холбогдох арга хэмжээг авалгүй, орон нутагт мөрдсөөр байна.

### Нөөц хөрөнгийн зориулалтын дагуу зарцуулахгүй байна

Засаг даргын нөөц хөрөнгө баяр наадам, хүлээн авалт, дайлага, цайлага, шагнал, урамшуулалд зарцуулсан хэвээр байна. Нийт батлагдсан хөрөнгийн 30-аас доошгүй хувийг Засаг даргын нөөцөд байнга бэлэн байлгахтай холбоотой журмын хэрэгжилт хангалтгүй байгааг анхааруулж, зөвлөмж хүргүүлэв.

2019 оны 10 дугаар сарын байдлаар





## Худалдан авах ажиллагаатай холбоотой нийтлэг зөрчил

Төрийн байгууллагууд, төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээд, худалдан авалтын үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллаагүй, авлига, ашиг сонирхлын эрсдэлтэй, анхаарвал зохих олон асуудал гарсаар байна. Үүнд:

- хөрөнгө оруулалтын ажлыг зураг, төсөвгүйгээр баталсан;
- тендер сонгон шалгаруулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14-16 дугаар зүйлд заасан ерөнхий шаардлагыг хангаагүй компаниудтай гэрээ байгуулсан;
- худалдан авах ажиллагааг зохион байгуулалгүй гэрээ байгуулж, тендерийн баримт бичгийг нөхөн бүрдүүлсэн;
- хэрэгжиж дуусаагүй, гэрээ дүгнээгүй ажил, арга хэмжээнд санхүүжилт олгосон;
- төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны чиглэлээр зохих сургалтад хамрагдаж, АЗ сертификат аваагүй этгээдийг тендерийн үнэлгээний хороонд ажиллуулсан;
- хууль зөрчин шууд худалдан авалт хийсэн;
- тендерт хамгийн бага үнээр шалгарсан аж ахуйн нэгж гэрээний хугацаанд нэмэлт гэрээ байгуулан төсвийн хөрөнгө завшсан г.м.

### Орон нутгийн хөгжлийн сангийн журмын хэрэгжилт хангалтгүй

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийх ажлыг төлөвлөх, батлахад иргэдийн оролцоог хангах талаар анхаарч ажиллах шаардлагатай. Хэдийгээр багийн иргэдээр хэлэлцүүлсэн гэх боловч холбогдох материалыг архивын нэгж болгодоггүй, техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөвгүй ажлыг баталдаг зэрэг зөрчил, дутагдал арилахгүй байна.


Аймаг, нийслэлийн ЗДТГ-аас <https://tusuv-oronnutag.mof.gov.mn/> цахим хуудсанд ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 9.9-т заасан мэдээллийг бүрэн байршуулахгүй байгаад дүгнэлт хийж, 2020 оны I улиралд багтаан 2013 оноос хойшхи мэдээллийг нөхөж, бүрэн байршуулах, цаашид мэдээллийг тогтмол шинэчилж байх, тус сангаас хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, тэдгээрийн үр ашиг, алдаа дутагдлын талаарх хэлэлцүүлгийг цахим болон бусад хэлбэрээр өрнүүлж, олон нийтэд мэдээлэх ажлыг хэвшүүлэх ажлыг зохион байгуулах шаардлагатай.



*Авлигатай тэмцэх газрын  
Хяналт шалгалтын албаны  
дарга, ахлах комиссар  
Л.Сүх-Очир*

*Өдрийн сонинд өгсөн  
ярилцлагаас 2019.12.14*

...Ах, эгч, дүүдээ давуу байдал олгосон шийдвэр гаргадаг. Ийм байдлаас болж төрийн албан хаагчид авлига, ашиг сонирхлын зөрчилд холбогдоод байгаа юм. Тухайлбал, “Төв авто зам засвар арчлалт” ТӨХК-ийн захирал өөрийнхөө эгчийн хүүхдийг өөрийн компанид авахын тулд нэг жилийн турш компанийн зардлаар ямар ч сонгон шалгаруулалтгүйгээр сургуульд сургасан тохиолдол байна. Төгсөөд хүрээд ирэнгүүт нь компанидаа ажилд оруулсан. Гэтэл уг ажлын байранд ажилд орох 10 хүүхдийн боломжийг хаасан. АТГ-аас холбогдох тушаал, шийдвэрийг нь хүчингүй болгож, арга хэмжээ тооцуулсан. Түүнээс гадна, Хэнтий аймгийн “Хан Хэнтий” цогцолбор сургуулийн захирал Т нь нөхрийнхөө төрсөн дүүгийн эхнэртэй гэрээ байгуулаад ажилд авсан байгаа юм. Үүн дээр энэ албан тушаалтан мэдэгдэл, тайлбар гаргаад ажиллах ёстой байсан. “Би ах, дүү, хамаатан садныхаа асуудал шийдвэрлэх гэж байна. Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсээд байна. Би үүнийг шийдэх үү, шийдэхгүй юу” гэдгээ сумынхаа Засаг даргадаа мэдэгдээд, шийдвэрлүүлэх ёстой. Гэтэл үүнийгээ хэрэгжүүлээгүй. Бас нэг тохиолдол бол Завхан аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга С өөрийн нөхрийн компанитай гэрээ байгуулаад ажилласан зөрчил байна. Дансанд нь мөнгө шилжүүлчихсэн. Бас мэдэгдэл, тайлбар гаргах болон бусад хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлээгүй. Энэ асуудлаар албан тушаалаасаа чөлөөлөгдсөн. Жижиг гэлтгүй хууль хэрэгжүүлэхгүй бол дараа нь өөрөө ийм байдалд хүрнэ гэдгийг албан тушаалтнууд мэдэж, ойлгох ёстой...




## ХАСХОМ-ИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЛААР

Авлигатай тэмцэх газар хуулиар хүлээсэн үндсэн чиг үүрэг, бүрэн эрхийн хүрээнд Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг (ХАСХОМ)-ийг хянан шалгаж, зөрчлийн шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгуулах, зөрчил гаргагчид хуульд заасан хариуцлага тооцуулж, үр дүнг тооцон ажилладаг.

Төлөвлөгөөт хяналт шалгалтад бүх шатны шүүхийн ерөнхий шүүгч, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн удирдах болон гүйцэтгэх албан тушаалтнуудыг хамруулав.

Шалгасан ХАСХОМ 2017-2019 он



## ХУУЛЬ БУС, НУУГДМАЛ ОРЛОГЫГ ИЛРҮҮЛЭХЭЭР ТАТВАРЫН БАЙГУУЛЛАГАТАЙ ХАМТРАН АЖИЛЛАЖ БАЙНА

Албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлт, судалгаа, дүн шинжилгээний хүрээнд мэдүүлэг гаргагчдын ХАСХОМ-ийн орлого хэсэгт мэдүүлсэн орлогын үзүүлэлтээс орлого нь их хэмжээгээр өссөн, их хэмжээний орлого олсон мэдүүлэг гаргагчдын судалгааг гаргаж, улмаар мэдүүлэг гаргагчдын мэдүүлсэн өөрийн болон гэр бүлийн гишүүдийн орлого нь үнэн бодит эсэх, хувь эзэмшдэг хуулийн этгээд, аж ахуйн нэгжүүд нь үйл ажиллагаа явуулснаар олсон орлого, ногдол хувийг компанийн дүрэм болон гэрээнд заасны

дагуу авсан эсэх, хөрөнгө, орлогын мэдүүлэгт мэдүүлсэн орлого нь татварын байгууллагад гаргаж өгсөн тайлан, мэдээтэй нийцэж байгаа эсэх, түүнчлэн татвараас зайлсхийсэн үндэслэл байгаа эсэхэд хяналт тавьж, цаашид иргэдийн татварын тайлан гаргалтын түвшинг нэмэгдүүлэх, татвараа үнэн зөв мэдүүлэх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, цаашид хууль бус орлогыг илрүүлэх, албан тушалатан хөрөнгө, орлого бодитой мэдүүлэх, татвараас зайлсхийсэн зөрчилд хариуцлага тооцуулах чиглэлээр 2019 онд Татварын ерөнхий



газартай хамтран ажилласан. Энэ ажлын хүрээнд Аж ахуйн нэгжийн албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль болон Татварын ерөнхий хуулийг зөрчсөн нийт 1.133.194.100 /Нэг тэрбум нэг зуун гучин гурван сая, нэг зуун ерөн дөрвөн мянга, нэг зуун/ төгрөгийн зөрчлийг илрүүлж, 3 иргэн, 4 аж ахуйн нэгж, байгууллагад 71.043.400 төгрөгийн торгууль ногдуулсан, 1 албан тушаалтныг нийтийн албанаас халах, 2 албан тушаалтанд сануулах сахилгын шийтгэл ногдуулаад байна.

### ХАСХОМ-ийн хяналтаар хариуцлага тооцуулсан байдал /оноор/



### Шүүгч нарын ёс зүй, үүрэг хариуцлагыг дээшлүүлэх талаар холбогдох байгууллагуудад албан бичиг хүргүүлэв

ХАСХОМ-ийн хяналт шалгалтаар 2019 онд нийт 381 албан тушаалтны мэдүүлгийг хянан шалгаснаас 164 нь шүүгч байна. Сүүлийн 2 жилийн хугацаанд нийт шүүгчдийн 88 хувийг төлөвлөгөөт хяналт шалгалтад хамруулж, хөрөнгө, орлогын мэдүүлгийг нь нарийвчлан шалгав. Хяналт шалгалтын явцад зарим шүүгчдийн зүгээс дээрх хууль, тогтоомжид заасан үүрэгтээ хайнга хандах, өөрийн болон гэр бүлийн гишүүдийн орлого, хөрөнгийг зөрчилтэй мэдүүлэх, санаатайгаар хөрөнгө, орлогоо мэдүүлэхгүй орхигдуулах, эсхүл олоогүй орлого, байхгүй хөрөнгийг мэдүүлэх, мэдүүлэг гаргахдаа хуульд заасан хугацаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хожимдуулах зэрэг зөрчил гаргаж байна.


Авлигатай тэмцэх газраас хуульд заасан бүрэн эрхийн дагуу зөрчил гаргасан нэр бүхий шүүгч нарт хариуцлага тооцуулах, хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн

18.4.15-д “мэдүүлэг гаргагчийн хөрөнгө, орлогын мэдүүлэгт хяналт тавих, шалгах, хугацаа хожимдуулсан буюу санаатай худал мэдүүлсэн этгээдэд холбогдох хуульд заасан арга хэмжээг авахуулахаар эрх бүхий байгууллагад шилжүүлэх”, Шүүхийн захиргааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2-т “шүүгчийг томилох, шилжүүлэх, сэлгэн ажиллуулах, албан тушаалаас нь чөлөөлөх, огцруулах тухай саналыг Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэх” гэж тус тус заасныг үндэслэн Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт хандан “шүүгчийн ёс зүй, үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх, Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр холбогдох арга хэмжээ авч, хууль зөрчсөн албан тушаалтнуудад зохих хариуцлагыг хүлээлгэх асуудалд анхаарал хандуулж, дэмжлэг үзүүлэх талаар албан бичиг хүргүүлээд байна.

## Үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн

2019 онд 403 албан тушаалтны ХАСХОМ-ийг хянан шалгаж, 30 албан тушаалтныг үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн байж болзошгүй нөхцөл байдлыг илрүүлэн, нарийвчлан шалгаж байна.

Үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн байж болзошгүй



## АЛБАН ТУШААЛТНЫ ДАВХАР АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛД ХЯНАЛТ ТАВИВ

Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, албан тушаалтны хариуцлага, ёс зүйг дээшлүүлэх чиглэлээр нийтийн албан тушаалтны давхар ажил эрхлэлтийн байдлыг хянаж, хууль бусаар орлого олсон эсэх, хоёр буюу түүнээс дээш байгууллагад нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байдлыг нягтлан шалгалаа.

Шалгалтаар Гадаад харилцааны яам, Зам, тээврийн хөгжлийн яамны нэр бүхий албан тушаалтнууд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан хязгаарлалт болон Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.17-д “үндсэн ажлаас гадуур хуулиар зөвшөөрснөөс бусад ажил, үүрэг эрхлэхгүй байх” гэж заасныг зөрчсөн, хуулийн этгээд, аж ахуй нэгж, байгууллагад давхар ажил

эрхэлж, цалин, урамшуулал авсан, ажил, хөдөлмөр эрхлээгүй байхад ажил олгогчийн зүгээс нийгмийн даатгалын шимтгэл төлсөн, өндөр насны тэтгэврийг өндөр хэмжээгээр үндэслэлгүйгээр тогтоолгох үүднээс аж ахуйн нэгж, байгууллагаар худал мэдээлэл гаргуулсан зэрэг нь Нийгмийн даатгалын тухай хуулийг зөрчсөн байж болзошгүй нэр бүхий албан тушаалтан болон зарим хуулийн этгээдийг шалгуулахаар харьяа дүүргүүдийн Нийгмийн даатгалын хэлтэст холбогдох мэдээллийг хүргүүлж, хяналт тавин ажилласан.


Албан тушаалтан Б нь үндсэн ажлаас гадна хувийн компаниас 9.4 сая төгрөгийн цалин хөлс авч, нийгмийн даатгалын шимтгэл давхар төлүүлсэн, Албан тушаалтан М нь аж ахуйн нэгж болон төрийн өмчит үйлдвэрийн газраас нийт 11.2 сая төгрөгийн цалин, урамшуулал авч, нийгмийн даатгалын





шимтгэлийг давхар төлүүлсэн. Өөрийн хүсэлтээр төрийн албанаас чөлөөлөгдөж, хөдөлмөрийн гэрээ нь дуусгавар болсон албан тушаалтан Б-д 2014 оны 5 дугаар сараас эхлэн 2019 оны 6 дугаар сарыг хүртэлх хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр төлж байжээ.


Авлигатай тэмцэх газар нийтийн албан тушаалтны давхар ажил эрхлэлтийг хянах, шалгах ажлаа үргэлжлүүлж байна.

### ХАСХОМ-ийн хяналт шалгалтын ажлын үр дүнг сайжруулах зорилгоор

 Албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг шалгах эрх зүйн орчин / хууль болон журам/, мэдүүлгийн маягтыг боловсронгуй болгох,

 Төрийн байгууллагуудын нэгдсэн мэдээллийн санг ашиглах боломжийг нэмэгдүүлэх,

 Хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргагчийг хянан шалгах зорилгоор арилжааны банкны мэдээлэл болон бусад хувь хүн, хуулийн этгээдийн нууцад хамаарах мэдээллийг авах эрх зүйн орчныг бүрдүүлэх

 Хяналт шалгалтын үйл ажиллагааг автоматжуулах, техник, технологийг сайжруулах, цахим мэдээллийн баазыг ашиглан хянан шалгах үйл ажиллагаанд хүний оролцоог багасгах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.


## АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХОЛБООТОЙ ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, МЭДЭЭЛЛИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ

Авлигатай тэмцэх газар нь 2019 онд албан тушаалтны авлига, ашиг сонирхлын зөрчлийг шалгуулахаар хандсан **692**, /**өмнөх оны үлдэгдэл 50/ нийт 742** өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авч **694** өргөдөл, гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэв.


### Илэрч буй нийтлэг зөрчлүүд:

Зөрчлийн агуулга	2017 оны гомдол	2018 оны гомдол	2019 оны гомдол
Албаны эрх мэдлээ урвуулсан, хэтрүүлсэн	16,2%	15,1%	15.90%
Хууль бус шийдвэр гаргаж бусдад давуу байдал олгосон	16,2%	14,3%	15.60%
Ашиг сонирхлын зөрчил болон сонирхлын зөрчилтэй шийдвэр гаргасан	26,2%	14,4%	34.60%
Хууль бус томилгоо хийсэн	28,5%	23,8%	14.80%
Бусад	12,9%	21,1%	19.10%

Өргөдөл, гомдол мэдээллийн агуулга /хувиар/



Өргөдөл, гомдол, мэдээлэл шийдвэрлэсэн байдал





## Өргөдөл, гомдлын хяналт шалгалтаар илэрсэн зөрчилд хариуцлага тооцуулсан байдал

Хариуцлагын хэлбэр	2018 он	2019 он
Сануулсан	8	8
Цалинг бууруулсан	23	22
Албан тушаал бууруулсан	–	4
Ажлаас халсан	7	3
Нийт	38	37


## ХАСУМ-ИЙГ ЦАХИМААР АВЧ, ХЯНАЖ ЭХЭЛЛЭЭ

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг /ХАСУМ/-ийг бүртгэх, хянах үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлж эхэллээ. 2019 оны байдлаар Сангийн яам, Эрчим хүчний яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Цагдаагийн ерөнхий газар, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, Харилцаа, холбооны зохицуулах хороо, Гаалийн ерөнхий газар, Улсын Ерөнхий прокурорын газар, Үндэсний аудитын газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, “Улаанбаатар төмөр зам” ХНН, Увс, Завхан, Өвөрхангай, Төв, Баян-Өлгий, Баянхонгор зэрэг яам, агентлаг, аймаг орон нутгийн төрийн захиргааны болон төрийн өмчит аж ахуйн нэгжүүд цахим системд бүрэн холбогдоод байна.

Цаашид бүх байгууллага, салбар нэгжүүдийн ХАСУМ-ийн бүртгэл, хяналтыг цахимжуулж, гарсан дүгнэлтийг олон нийтэд ил тод, нээлттэй хүргэхээр ажиллаж байна.

2019 онд нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн 8682 этгээдийн ХАСУМ-ийг хянав.

### ХАСУМ хянасан байдал





## АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ЭТГЭЭДИЙГ НИЙТИЙН АЛБАНД ТОМИЛОХГҮЙ БАЙХ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ

2017 онд 39, 2018 онд 25, 2019 онд 28 этгээдийг тухайн албан тушаалд томилоход ашиг сонирхлын зөрчил үүсэх тухай хариуг хүргүүлж, нийтийн албанд ашиг сонирхлын зөрчилтэй этгээдийг томилуулахаас урьдчилан сэргийлж, зөрчилтэй этгээдийг нийтийн албанд томилуулахгүй байх бодлогыг хэрэгжүүлж байна.

Тухайлбал:

- “Багануурын дулааны станц” ТӨХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр томилогдохоор нэр дэвшсэн Л.Гэндэнсүрэн
- “Багануур-Зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр томилогдохоор нэр дэвшсэн Ц.Санчин
- “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр томилогдохоор нэр дэвшсэн М.Ганбаатар
- “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр томилогдохоор нэр дэвшсэн Ж.Доржпүрэв
- “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр томилогдохоор нэр дэвшсэн Д.Үлэмж
- Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн Тээврийн нэгдсэн удирдлага, сургалт, судалгааны хэлтсийн даргаар томилогдохоор нэр дэвшсэн Д.Төгсжаргал
- Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдохоор нэр дэвшсэн А.Цэцэнбилэг
- Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлгийн ТУЗ-ийн гишүүнээр томилогдохоор нэр дэвшсэн Ц.Гончиг
- Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлгийн ТУЗ-ийн гишүүнээр томилогдохоор нэр дэвшсэн М.Батсайхан
- Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлгийн ТУЗ-ийн гишүүнээр томилогдохоор нэр дэвшсэн Т.Гэрэлчулуун
- Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлгийн ТУЗ-ийн гишүүнээр томилогдохоор нэр дэвшсэн П.Аюушжав
- Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлгийн ТУЗ-ийн гишүүнээр томилогдохоор нэр дэвшсэн Ч.Болдбаатар
- Хэнтий аймгийн Шүүхийн шинжилгээний албаны даргаар томилогдохоор нэр дэвшсэн Х.Түвшин-Эрдэнэ
- Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн харьяа Хэнтий аймгийн Шүүхийн шинжилгээний албаны даргаар томилогдохоор нэр дэвшсэн Д.Адилбаяр
- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргын үүрэг гүйцэтгэгчээр томилогдохоор нэр дэвшсэн Ө.Сумьяабаатар
- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргын үүрэг гүйцэтгэгчээр томилогдохоор нэр дэвшсэн О.Хуягтцогт
- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Үйлдвэрлэлийн хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгчээр томилогдохоор нэр дэвшсэн Д.Бямбасүрэн
- Баян-Өлгий аймгийн Бугат сумын Засаг даргаар томилогдохоор нэр дэвшсэн К.Хавдилмалик
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Малын удмын сангийн үндэсний төвийн захирлаар томилогдохоор нэр дэвшсэн П.Ганхуяг
- Баян-Өлгий аймгийн Цагдаагийн газрын дэд дарга бөгөөд тасгийн даргаар томилогдохоор нэр дэвшсэн А.Ержан
- Нийслэлийн цагдаагийн газрын Хүнд гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтсийн тасгийн даргаар томилогдохоор нэр дэвшсэн Ч.Ойдов
- Хөдөө аж ахуйн их сургуулийн Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирлаар томилогдохоор нэр дэвшсэн М.Найданхүү
- Төв аймгийн Заамар сумын Засаг даргаар томилогдохоор нэр дэвшсэн Б.Самбуу
- “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн Хангамж үйлчилгээний албаны ахлах мэргэжилтнээр томилогдохоор нэр дэвшсэн Ц.Батсүрэн
- “Дулааны 2 дугаар цахилгаан станц” ТӨХК-ийн Санхүү бүртгэл, эдийн засгийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогчоор томилогдохоор нэр дэвшсэн Л.Оюун-Эрдэнэ
- “Дулааны 2 дугаар цахилгаан станц” ТӨХК-ийн Ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдохоор нэр дэвшсэн Г.Нямдолгор
- Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн Шатахуун, төсөл, хөтөлбөрийн зээлийн асуудал хариуцсан мэргэжилтнээр томилогдохоор нэр дэвшсэн Г.Батжаргал
- Улаанбаатар хот дахь гаалийн газарт Гаалийн эрсдэлийн удирдлага, статистик, мэдээллийн технологийн албаны даргаар томилогдохоор нэр дэвшсэн Б.Чулуундарь гэх мэт




## МЭДҮҮЛГИЙН ДҮН БҮРДҮҮЛЭЛТ

Нийтийн албан тушаалтны 2019 оны ХАСХОМ-ийг шинэчлэн бүртгэх ажлыг улсын хэмжээнд удирдан зохион байгуулав. ХАСХОМ-ийг шинэчлэн мэдүүлэх хуулийн хугацаанд улсын хэмжээнд нийт 41382 мэдүүлэг гаргагч мэдүүлгээ бүртгүүлэхээс хуулийн хугацаанд 41381 мэдүүлэг гаргагч мэдүүлж, 1 албан тушаалтан мэдүүлгээ хуулийн хугацаанд гаргаагүй, гүйцэтгэл 99.99 хувьтай гарав.

Төрийн болон нутгийн захиргааны нийт 36794 албан тушаалтны 2018 оны ХОМ-ийн хураангуйг <http://www.xасxом.iaас.mn> цахим хуудсанд нээлттэй байршуулж, олон нийт хяналт тавих боломжийг бүрдүүлэв.

### ХОМ-ийг ил тод, нээлттэй байршуулав



2019 онд Авлигатай тэмцэх газрын даргын баталсан “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн талаар иргэдэд мэдээлэл өгөх журам”-ын дагуу зарим хөрөнгийн мэдээллийг дэлгэрэнгүй, олон нийтэд ойлгомжтой нээлттэй болгов. Тухайлбал, орон сууц, барилга байгууламжийг 14 төрлийн үзүүлэлтээр, хадгаламжийг “гадаад”, “дотоод” гэж ангилж өгсөн нь иргэдэд ойлгомжтой болж, хяналт тавих боломжийг нэмэгдүүллээ.



### НИЙТИЙН АЛБАН ТУШААЛТНЫ ХОМ-Т ИРГЭД ХЯНАЛТ ТАВИХ АРГАЧЛААД СУРГАВ

Нээлттэй болгосон мэдээлэлд үндэслэн иргэд дүн шинжилгээ хийх, хянах бүрэн боломжтой юм. Ийм хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх иргэд тодорхой мэдээлэл, мэдлэгтэй, арга зүй, туршлагыг эзэмшсэн

байх шаардлагатай. Тиймээс Нийтийн албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлэгтэй танилцаж, хяналт тавих, энэ төрлийн гомдол, мэдээллийг хэрхэн гаргах талаарх видео шторк хийж, иргэдийг чадавхжуулав.




# МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГАА

## ГЭМТ ХЭРГИЙН ШИНЖТЭЙ ГОМДОЛ, МЭДЭЭЛЛИЙН ТОО

2019 онд гэмт хэргийн шинжтэй **894** гомдол, мэдээлэл шалгасан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад **4.2** хувиар өссөн байна.

### Шалгаж шийдвэрлэсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл



2019 онд гомдол, мэдээлэлд холбогдсон этгээдийг албан тушаалаар нь ангилбал:

- төрийн улс төрийн-141
- төрийн захиргааны-204
- төрийн тусгай-360
- төрийн үйлчилгээний-77
- төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн-71
- хувийн хэвшил, аж ахуйн нэгж, болон төрийн бус байгууллагын-41 албан тушаалтан холбогдон шалгагдсан байна.

### Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн шийдвэрлэлт





## МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН ХЭРГИЙН ТОО

2019 онд 1559 үйлдэлтэй, 481 холбогдогчтой, 1300 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан байна.

### Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан

	ХЭРГИЙН ТОО	ХОЛБОГДОГЧИЙН ТОО
2016	235	459
2017	427	639
2018	1138	1224
2019	1300	481

### 2019 онд мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийг төрлөөр нь ангилбал:

- Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэрэг-**688** буюу **44.1** хувь,
- Хахууль авах **172** буюу **11.0** хувь,
- Хахууль өгөх **174** буюу **11.2** хувь,
- Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах **24** буюу **1.5** хувь,
- Үндэслэлгүйгээр хөрөнгөжих **40** буюу **2.6** хувь,
- Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах **10** буюу **0.7** хувь,
- Мөнгө угаах **23** буюу **1.5** хувь,
- Хөрөнгө завших **58** буюу **3.7** хувь,
- Эрүү шүүлт тулгах **60** буюу **3.9** хувь
- Бусад хэрэг **310** буюу **19.9** хувийг тус тус эзэлж байна.

### Мөрдөн шалгах хамтарсан ажлын хэсэг байгуулав

Хууль сахиулах чиг үүрэг бүхий Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газартай хамтарсан тушаалаар 30 эрүүгийн хэрэгт ажлын хэсэг байгуулагдан мөрдөн шалгах ажиллагаа явуулж, ажлын хэсгүүдийг өдөр тутмын мэргэжлийн удирдлагаар хангаж ажилласнаар 24 хэргийг шийдвэрлэж одоо 6 хэргийн үлдэгдэлтэй ажиллаж байна


## Авлигын гэмт хэрэгт холбогдон шалгагдсан этгээд албан тушаалын байдлаар

	2017	2018	2019
Төрийн тусгай албан тушаалтан	168	434	101
Иргэн, хувийн хэвшлийн ААН-ийн албан тушаалтан	109	193	143
Улс төрийн албан тушаалтан	58	166	48
Төрийн өмчит хуулийн этгээдийн албан тушаалтан	168	82	38
Төрийн үйлчилгээний албан тушаалтан	38	145	48
Төрийн захиргааны албан тушаалтан	113	204	103


## МӨРДӨН ШАЛГАСАН ХЭРГИЙН ШИЙДВЭРЛЭЛТ

2019 онд Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийн шийдвэрлэлт 62.6 хувьтай шүүхээр 68 хэрэг эцэслэн шийдвэрлэгдсэн байна.

### Мөрдөн шалгасан хэргийн шийдвэрлэлт



### Шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн тоо




2018 онд шүүхээр **84** эрүүгийн хэрэг шийдвэрлэгдэж байсан бол 2019 онд нийт **68** хэргийг шүүхээр эцэслэн шийдвэрлүүлжээ.



## Мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлсэн хөрөнгийн хэмжээ

2019 онд гэмт хэргийн улмаас **12,123,202,011,893** төгрөгийн хохирол учирснаас мөрдөн шалгах ажиллагааны явцад **11,343,770,066** төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж үл хөдлөх, хөдлөх, байр, орон сууц, автомашин, тоног төхөөрөмж зэрэг **9,736,776,389,079** төгрөгөөр үнэлэгдэх эд хөрөнгө болон бэлэн мөнгийг битүүмжлэн хамгааллаа.

### Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, нөхөн төлүүлэлт



Авлигатай тэмцэх газрын  
Олон нийттэй харилцах  
асуудал хариуцсан ахлах  
ажилтан, ахлах комиссар  
Т.БАЯРХҮҮ

Өдрийн сонинд өгсөн  
ярилцлагаас 2019.12.24

“...Ер нь нийгэмд ч гэсэн улсын төсвөөс давсан хэмжээний хохирол гэсэн ойлголт яваад байгаа. Үүнээс хамгийн их буюу 9.5 их наяд төгрөг Эрдэнэтийн 49 хувьтай холбоотой асуудал дээр яригдаж байгаа. Үүн дээр анхаарах зүйл бол 11.9 их наяд төгрөг алга болчихсон юм шиг ойлгоод байгаа юм. Мөрдөн шалгах ажиллагааны явцад хохирол нөхөн төлүүлж байгаа. Дээрээс нь битүүмжлэн хамгаалж байна.

Манайд жишээ нь мөрдөн байцаалтын явцад дансан дахь бэлэн мөнгө, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө гээд одоогоор 136 тэрбум төгрөгийн хөрөнгийг битүүмжлэн хамгаалсан. 7 тэрбум гаруй төгрөгийн хөрөнгийг нэмж битүүмжлэн хамгаалах асуудал яригдаж байна.

Эрдэнэтийн 49 хувийг төр өөрөө мэдэлдээ авчихсан байгаа. Тэгэхээр 9.5 их наяд төгрөгийн хохирол бол битүүмжлэн хамгаалагдсан гэдэг ойлголтод хамаарна. Бусад хэргүүдийн хувьд хохирлыг нөхөн төлүүлнэ...”

## ДҮГНЭЛТ, САНАЛ

### Нэг. Эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр:

1. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд “Шүгэл үлээгч /мэдээлэгч/-ийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг бий болгох”-оор заасан.

Бусад орны хууль тогтоомжоос үзэхэд төрийн байгууллагын болон эрх бүхий этгээд, өндөр албан тушаалтны зүй бус үйлдлийн эсрэг хүчтэй дуугарч, асуудалд нийгмийн анхаарлыг чиглүүлж байгаа хүнийг “шүгэл үлээгч” гэсэн нэр томъёоны дор тайлбарлан хэрэглэж байна. 1987-2018 оны хооронд нийт 27 орон шүгэл үлээгчийг хамгаалах талаар тусгайлсан хууль баталсан нь шүгэл үлээхийн ач холбогдол, улмаар авлигаас урьдчилан сэргийлэх чухал арга хэрэгсэл гэдгийг хүлээн зөвшөөрөх хандлага нэмэгдэж байгааг харуулж байна.

Монгол Улс авлигатай тэмцэх тогтолцоогоо улам бүр бэхжүүлэхэд авлигын талаар шүгэл үлээгч(илчлэгч)-ийг хамгаалах, урамшуулах эрх зүйн орчин үгүйлэгдэж байна. Манай орны хувьд иргэдээс гэмт хэргийн талаар мэдээлэх, мэдээллийг төлбөртэй авах талаар Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон холбогдох бусад хуульд заасан боловч мэдээлэгчийг хамгаалах, мэдээлэл өгөх боломж нөхцөлөөр хангах эрх зүйн тогтолцоо бүрдээгүй, зохицуулалт хангалтгүй байна.

Авлигын чиглэлээр зохион байгуулсан судалгаануудын дүн, шинжээчдийн үнэлгээ нь авлигыг мэдээлэхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах механизм бүрдүүлэх шаардлагатайг илэрхийлсээр байна. Тухайлбал, Авлигын эсрэг конвенцийн хэрэгжилтийг үнэлэх механизмын дагуу манай улсад үнэлгээ хийсэн олон улсын шинжээчид “мэдээлэгчийг хамгаалах хууль тогтоомж бий болгох зайлшгүй шаардлагатай байна” гэж дүгнэсэн.

Авлигатай тэмцэх газрын захиалгаар Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хууль зүйн судалгааны төвөөс хийсэн Шүгэл үлээгчийн эрхийг хамгаалах хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааны тайланд “...асуудлын мөн чанар, цар хүрээ болон нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн холбогдох харилцааг өргөжүүлэх, чанар, үр өгөөжийг дээшлүүлэхийн тулд одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийн хүрээнд Нийтийн ашиг сонирхлын төлөө илчлэгч, шүгэл үлээгч, /мэдээлэгч/, гэрчийг төрөөс урамшуулах, хамгаалах хуулийг боловсруулах шаардлага зүй ёсоор тулгарч байна.” хэмээн тэмдэглэжээ.

Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг хамгаалах тухай хуулийн төсөл батлагдсанаар Авлигын эсрэг конвенцийн 33 дугаар зүйлд “Оролцогч улс бүр энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэргийн талаарх аливаа баримт нотолгоог сайн санааны үүднээс үндэслэлтэйгээр эрх бүхий байгууллагад мэдээлж буй аливаа этгээдийг аливаа шударга бус хандлагаас хамгаалахаар заах талаарх зохих арга хэмжээг өөрийн дотоодын эрх зүйн тогтолцоонд нэвтрүүлэн оруулах асуудлыг авч үзнэ” гэж заасныг хэрэгжүүлэх бодит алхам болох юм.

Авлигатай тэмцэх газраас Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч/илчлэгч/-ийг хамгаалах тухай хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулга, даган гарах хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хурлын даргад хүргүүлсэн тул төслийг энэ хаврын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэх тал дээр онцгойлон анхаарал хандуулахыг хүсч байна.

2. Авлигатай тэмцэх газраас Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан Авлигын гэмт хэргийг буюу үндсэн гэмт хэргийг шалгаж тогтоохын зэрэгцээ мөнгө угаах,



үндэслэлгүй хөрөнгөжих зэрэг гэмт хэргийн бүрэлдэхүүн байгаа эсэхийг хянан шалгах ажиллагааг явуулдаг.

Авлига, албан тушаалын гэмт хэрэг нь бусад төрлийн гэмт хэргүүдээс үйлдлийн арга барил, үйлдэгдсэн нөхцөл байдал, субъектын хувьд өөрийн онцлогтой, ээдрээ түвэгтэй, өргөн цар хүрээнд шалгалт хийдэг тул мөрдөн шалгахад нэлээд цаг хугацаа шаарддаг бөгөөд мөнгө угаах, үндэслэлгүй хөрөнгөжих гэмт хэргийн хувьд одоогийн үйлчилж буй хуулиар тогтоосон хөөн хэлэлцэх хугацаа нэг жил буюу 12 сар байгаа нь практикт дээр гэмт хэргийг эцэслэн шалгаж, шийдвэрлэхэд сөргөөр нөлөөлж байна. Иймд эдгээр гэмт хэргийн хувьд хүлээлгэх хариуцлагыг хүндрүүлэх талаар холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай.

3. Эрүүгийн хуулийн 18.6 дахь зүйлд Мөнгө угаах гэмт хэргийг *“Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласан, түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн, эсхүл түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуусан, далдалсан бол зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ”* гэж тодорхойлсон.

Энэ нь үндсэн гэмт хэрэг нь заавал авлигын гэмт хэрэг байхыг шаардахгүй бөгөөд Эрүүгийн хуульд заасан аливаа гэмт хэргийн замаар олсон орлогыг эзэмшсэн, ашигласан түүний хууль бус эх үүсвэрийг нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн, нуусан, далдалсан зэрэг идэвхтэй үйлдэл байхаар хуульчилсан нь харагдаж байна. Иймд мөнгө угаах гэмт хэргийг бүхий л төрлийн гэмт хэрэгт хамаатуулан

хянан шалгаж, шийдвэрлэх талаар хууль сахиулах байгууллагууд, прокурор, шүүхийн хувьд нэгдсэн нэг ойлголттой болж, практикт хэрэгжүүлж хэвших шаардлага байна.

4. Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 1 ба 2 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн этгээдэд нэг ижил, адил хариуцлага хүлээлгэхээр заасныг өөрчлөх шаардлагатай байна. Энэ нь улсад бодит хохирол учруулсан этгээд хохирол учруулаагүй этгээдтэй ижил ял шийтгэгдэхээр байгаа нь шударга ёсны зарчимд нийцэхгүй байна. Иймд Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан (материаллаг бүрэлдэхүүнтэй) гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг чангатгах.

5. Нийтийн албан тушаалтан өөрийн хөрөнгө, орлого их хэмжээгээр нэмэгдсэн нь хууль ёсны болохыг үндэслэлтэй тайлбарлаж чадаагүй бол үндэслэлгүй хөрөнгөжих гэж үзэхээр 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс үйлчилж эхэлсэн Эрүүгийн хуульд тусгасан. 2002 оны Эрүүгийн хуульд нийтийн албан тушаалтан хууль ёсны орлогоосоо гадна их хэмжээгээр эд хөрөнгө, орлого олсон нь тогтоогдсон бол хууль бусаар хөрөнгөжсөн гэж үзэхээр тусгасан байсан тул одоогийн зохицуулалтаар 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс өмнөх хугацаанд хамаарах хөрөнгө, орлого нь их хэмжээгээр нэмэгдсэнийг албан тушаалтан үндэслэлтэй тайлбарлах асуудал өөрөө яригдахгүй. Одоо мөрдөж буй Эрүүгийн хуулийн заалтыг нийтийн албан тушаалтныг өөрийнхөө гэм бурууг нотлохыг үүрэгжүүлсэн буюу Монгол Улсын Үндсэн хуулийн суурь зарчимд харшлах зохицуулалт болсон гэж үзэх үндэслэлтэй байгаа юм.

Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийг албан тушаалтан хээл хахууль авах, эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах зэрэг үндсэн гэмт хэрэгт заавал давхар зүйлчлэн мөрдөн шалгадаг. Практикт дээр үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийг дангаар шийдвэрлэсэн тохиолдол гараагүй,



хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэж байсан нь ийм төрлийн гэмт хэргийг дахин үйлдэхэд нөлөөлдөг байж болзошгүй байна. Иймд, дээр дурдсан асуудлыг шийдвэрлэхийн тулд Үндсэн хуулийн суурь зарчимд харшлахгүй байдлаар холбогдох хуульд зохих өөрчлөлтийг оруулах шаардлагатай байна.

6. Банкны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.3-т заасны дагуу зөвхөн эрүүгийн хэрэг мөрдөн шалгах ажиллагааны явцад иргэн, албан тушаалтны банкны данс, гүйлгээтэй холбоотой аливаа мэдээллийг прокурорын зөвшөөрлөөр гаргуулан авах боломжтой бөгөөд нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг хянан шалгах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд албан тушаалтан, түүний хамаарал бүхий этгээдүүдийн банкны данс, гүйлгээтэй холбоотой мэдээллийг гаргуулан авах боломжийг хуульчлан тогтоогоогүй нь албан тушаалтны үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэрэг, нуугдмал хөрөнгийг илрүүлэх ажиллагаанд томоохон бэрхшээл учруулж байгаа ба тухайн албан тушаалтны зөвхөн өөрийн гарган өгч буй мэдээллээр хязгаарлагдах, хяналт шалгалтын үйл ажиллагаанд шаардлагатай хөндлөнгийн нотолгоог бүрэн цуглуулах боломжгүй, хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүрэн гүйцэд шалгах, нуугдмал хөрөнгийг илрүүлэх үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу нийтийн албан тушаалтан оффшор бүсэд хуулийн этгээд байгуулах, данс эзэмших, мөнгөн хөрөнгө байршуулахтай холбоотой хориглолт, хязгаарлалтын хэрэгжилтэд хяналт тавих, зөрчлийг илрүүлэх чиг үүрэгтэй холбогдуулан, албан тушаалтны банкны дансны орлого, зарлагын гүйлгээг хянан шалгах зорилгоор холбогдох мэдээлүүдийг

шалган тогтоох зайлшгүй нөхцөл байдал бий болж байна. Иймд Банкны тухай хуульд холбогдох нэмэлтийг нэн даруй оруулах шаардлагатай байна.

7. Сүүлийн жилүүдэд авлига, ашиг сонирхлын зөрчилд өртөмтгий байгууллага, салбарыг ХАСХОМ-ийн төлөвлөгөөт хяналт шалгалтын үйл ажиллагаанд хамруулах ажлыг зохион байгуулж, үндэслэлгүйгээр хөрөнгөжих, нуугдмал эд хөрөнгийг илрүүлэх, хууль бус орлогын эх үүсвэрийг тодорхойлох, зөрчлийг таслан зогсоох, зөрчил гаргагчдад хариуцлага тооцуулах үйл ажиллагааг эрчимжүүлэн ажиллахаас гадна цахим системийг ашиглан орлого, хөрөнгө нь хэт өссөн болон давтамжтайгаар өсч байгаа мэдүүлэг гаргагчдын хөрөнгийн байдалд харьцуулалт, судалгаа, дүн шинжилгээ хийн, хянан үзэж байна. Албан тушаалтны ХАСХОМ-ийг шалгахдаа зөвхөн тухайн албан тушаалтны өөрийн болон гэр бүлийн гишүүний өмчлөлд бүртгэлтэй эд хөрөнгийн байдлыг шалгахад хязгаарлалгүйгээр тэдгээрийн хамаарал бүхий этгээдийн хөрөнгө, орлогын эх үүсвэрийг нягтлах замаар нуугдмал эд хөрөнгийг илрүүлэх, мөн ХАСХОМ-т мэдүүлсэн орлогууд нь татварын байгууллагад гаргасан тайлан, мэдээтэй нийцэж байгаа эсэх, татвараас зайлсхийсэн үндэслэл байгаа эсэхэд хяналт тавьж нийслэл, дүүргийн Татварын хэлтэстэй хамтран ажиллаж байгаа нь үр дүнтэй байна.

Төрийн албаны тухай хуулийн дагуу Засгийн газрын тогтоолоор төрийн захиргааны ба төрийн үйлчилгээний зарим албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 5 дугаар тогтоолоор баталсан “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах зарим албан тушаалын жагсаалт”-ыг шинэчлэн боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах зайлшгүй хэрэгцээ шаардлага гарч байна.



Түүнээс гадна Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр” болон Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.15.14-т “Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягтыг боловсронгуй болгож, мэдүүлгийг цахим хэлбэрээр хүлээн авах тогтолцоонд бүрэн шилжүүлэх” гэж заасныг үндэслэн ХАСХОМ гаргах албан тушаалтнуудын хамрах хүрээг эрхлэх асуудлын чиг үүрэг, албан тушаалынх нь онцлог, шийдвэр гаргах эрх мэдэл, авлига, ашиг сонирхлын зөрчилд өртөх эрсдэл зэргийг харгалзан ХАСХОМ-ийн маягтыг боловсронгуй болгох ажлыг гүйцэтгэж байна.

8. Сүүлийн жилүүдэд Засгийн газар шинээр байгуулагдах, сайд нар өөрчлөгдөх бүрт тухайн яам, агентлагийн бүтэц зохион байгуулалт өөрчлөгдөж нийтийн болон төрийн жинхэнэ албан тушаалтныг томилох, чөлөөлөхтэй холбоотой хувь хүний болоод улс төр, бизнесийн тодорхой хэсгийн ашиг сонирхол бүхий хууль бус нөлөөлөл нэмэгдэх хандлагатай байх төдийгүй тус газарт иргэдээс ирүүлсэн гомдол, мэдээллийн 20 гаруй хувийг ашиг сонирхлын зөрчилтэй, хууль бус томилгооны талаарх асуудал эзэлж байна.

Түүнчлэн холбогдох мэдээлэл, судалгаанаас харахад тухайн яамдын сайд, удирдлага солигдох бүрт төрийн жинхэнэ албан тушаалтан тэр дундаа шийдвэр гаргах түвшний удирдах албан тушаалтнуудыг өөрчлөн томилдог, тухайн ажлын байранд сонгон шалгаруулалт зарлахгүйгээр түр орлон гүйцэтгэгч томилж байгаа нь төрийн алба мэргэшсэн, тогтвортой байх, төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах зарчмууд алдагдаж байна гэж үзэхээр байна

Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн ХАСУМ-ийг хянах үйл ажиллагааны явцад дараах нийтлэг зөрчил илэрч байна. Үүнд:

- ХАСУМ-ийг хянуулалгүйгээр тухайн албан тушаалд томилох;
- Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт өгөөгүй, эсхүл тэнцээгүй, ажлын байрны шаардлага, хуульд заасан шалгуур хангахгүй иргэдийг “түр орлон гүйцэтгэгч”, “гэрээт ажилтан” нэрээр төрийн албанд томилон ажиллуулах /АТГ 2019 онд ажлын байрны шаардлага, хуульд заасан шалгуур хангахгүй 130 этгээдийн талаар тухайн байгууллага, томилох эрх бүхий албан тушаалтанд анхааруулсан/;
- Албан тушаалын буюу ажлын байрны тодорхойлолтыг тухайн томилогдох этгээд, хувь хүнд зориулан субъектив байдлаар боловсруулах;
- Хоёр байгууллага, албан тушаалтны хооронд зөвшилцөж томилогддог албан тушаалтнуудын талаар зохих шатны удирдлагууд нь нэгдмэл байр сууринд хүрэлгүйгээр ХАСУМ хянуулж, томилох /аймаг, нийслэлийн Засаг дарга нь төрийн төв байгууллагын удирдлагатай зөвшилцөж томилдог албан тушаалтны тухайд/;
- Түүнчлэн ХАСУМ хянуулахаар ирүүлж буй материалын бүрдэл хангалтгүй, хуулийн үйлчлэлд хамаарахгүй ангилал, зэрэглэлийн албан тушаалд ХАСУМ хянуулахаар болон томилох эрхгүй албан тушаалтнаас ирүүлэх, нэг албан тушаал дээр томилохоор судалж буй хэд хэдэн хүнийг сонгон шалгаруулалт явуулалгүйгээр ХАСУМ-ийг нь тус газарт нэгэн зэрэг ирүүлэх зэрэг нөхцөл байдал гарч байна.

Иймд нийтийн албанд томилогдохоор нэр дэвшигч нь Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан болзол, шалгуурыг хэрхэн хангаж байгаа, сонгон шалгаруулалтад орж тэнцсэн, нөөцөд авагдсан эсэх, тухайн ажлын байранд тавигдах, шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэхэд болон төрийн албанаас чөлөөлөгдсөн, халагдсан этгээд дахин өөр албан тушаалд томилогдохоор нэр

дэвшсэн байдалд Төрийн албаны зөвлөл, салбар зөвлөлтэй хамтран хяналт тавих, Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлийн системтэй ХАСУМ-ийн цахим системийг уялдуулж, хяналтын механизмыг сайжруулах шаардлага зүй ёсоор тулгарч байна.

Түүнчлэн нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн ХАСУМ-ийг Авлигатай тэмцэх газарт хянуулахгүй томилсон албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх хуулийн зохицуулалт тодорхойгүйгээс авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна.

Иймд, ХАСУМ хянуулахгүй нийтийн албанд томилсон тохиолдолд томилох шийдвэр гаргасан албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх заалтыг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлд нэмж оруулах шаардлагатай гэж үзэж байна.

9. ХАСУМ-ийн хяналтаар 2015 онд 40, 2016 онд 39, 2017 онд 39, 2018 онд 25 этгээдийг тухайн албан тушаалд томилоход илт ашиг сонирхлын зөрчил үүсэх тухай хариуг хүргүүлж, нийтийн албанд ашиг сонирхлын зөрчилтэй этгээдийг томилуулахаас урьдчилан сэргийлж, зөрчилтэй этгээдийг нийтийн албанд томилуулахгүй байх практик тогтоон ажиллаж байна.

Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлахдаа Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7 дахь хэсгийг өөрчлөн найруулсан. Энэхүү өөрчлөлт нь нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн ХАСУМ-ийг Авлигатай тэмцэх газар хянаад илт ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдлыг тогтоосон талаар албан бичиг хүргүүлсэн байхад тухайн байгууллагын удирдлага нь түүнийг томилох, ашиг сонирхлын зөрчилтэй

нөхцөл байдалд албан үүрэг гүйцэтгүүлэх боломжтой болсон байна. Энэ нь дээрх хуулийн үндсэн агуулга, үзэл баримтлалыг алдагдуулж, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 4.1.1.1-д заасан “... хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хариуцлагыг дээшлүүлэх” арга хэмжээтэй уялдаагүй, зөрүүтэй, Үндэсний хөтөлбөрийн 2.1.1-д тусгагдсан “шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөлмөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх” зорилтоос ухарсан шийдвэр болсон байна.

Дээрх хуулийн 23.7-д заасныг зөрчиж, илтэд ашиг сонирхлын зөрчилтэй этгээдийг албан тушаалд томилсон, хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг худал мэдүүлсэн, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.2-т заасан хариуцлага хүлээлгэх зөрчлийг удаа дараа гаргасан бол албан тушаалыг бууруулах буюу сахилгын шийтгэл ногдуулах хариуцлага тооцуулах хуулийн зохицуулалт хэвээр байгаа нь хуулийг хэрэгжүүлэхэд ойлгомжгүй, салаа утгатай агуулгыг бий болгож байна.

10. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан зөрчлийн хувьд хөөн хэлэлцэх хугацааг хязгаарлаагүй. Гэвч шүүхийн практикт энэ төрлийн зөрчлийг Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуульд заасан сахилгын зөрчилтэй адилтган, хөөн хэлэлцэх хугацааг нэг жилээр авч үзэж байгаа нь буруу практик тогтохоос гадна авлига, ашиг сонирхлын зөрчлийн шинж чанартай уялдаагүй, зөрчил гаргасан албан тушаалтан хариуцлагаас гадуур үлдэх



эрсдэлийг бий болгон, хуулийн үндсэн зорилгыг алдагдуулж, хяналт шалгалтын ажлын үр дүнд сөргөөр нөлөөлж байна. Иймд авлига, ашиг сонирхлын зөрчлийн хөөн хэлэлцэх хугацааг нэг мөр ойлгож, хэрэглэх, холбогдох хууль тогтоомжид “зөрчил гарснаас хойш 36 сар, зөрчлийг илрүүлснээс хойш 12 сар өнгөрсөн бол нийтийн албан тушаалтанд сахилгын шийтгэл оногдуулж болохгүй” гэсэн агуулга бүхий заалт нэмж оруулах шаардлагатай.

11. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасныг зөрчсөн тохиолдолд нийтийн албан тушаалтанд шүүх хариуцлага хүлээлгэхээр хуульчилсан байх боловч тухайн хариуцлагыг хэрхэн оногдуулах журам хуульд тусгагдаагүйн улмаас хууль зөрчсөн албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх явдал хангалтгүй байна. Энэ хариуцлагыг шүүгч хүлээлгэхээр зохицуулсан байдаг ч өнөөдрийг хүртэл энэ төрлийн авлигын зөрчил шүүхээр шийдвэрлэхэд дагаж мөрдөх механизм(процесс) бүрэн бүрдээгүй байгааг анхаарах шаардлагатай байна. Мөн нийтийн албанд ажиллаж байхдаа Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль зөрчсөн иргэн ажлаас чөлөөлөгдсөн, өөр байгууллагад шилжин ажилласан тохиолдолд хариуцлага хүлээлгэх боломжгүй байгаа тул тухайн зөрчилд холбогдох хариуцлагыг шүүгч оногдуулдаг байх зохицуулалтыг хуульд нэмж тусгах хэрэгтэй байна.

12. Монгол Улсын өнөөгийн авлигын нөхцөл байдал, ялангуяа өндөр түвшний болон улс төрийн хүрээний авлигад нөлөөлж буй нэг том хүчин зүйл бол улс төрийн намын болон сонгуулийн санхүүжилт юм. Улс төрийн намын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т “Нам санхүүгийн үйл ажиллагаандаа жил бүр аудит хийлгэн баталгаажуулж, нийтэд мэдээлнэ” гэж заасан боловч хуулийг

хэрэгжүүлэх, хариуцлагын механизм байхгүйн улмаас хэрэгжихгүй байна. Авлигын нөхцөл байдлын талаар зохион байгуулсан төсөөллийн судалгаа болон шинжээчдийн үнэлгээгээр Монгол Улс дахь улс төрийн намын болон сонгуулийн санхүүжилт дахь авлига нь анхаарал хандуулах, онцгойлон авч үзэх шаардлагатай түвшинд хүрсэн байгааг харуулдаг. Тухайлбал, улс төрийн намын санхүүжилтийг бүрэн ил тод болгож, хандив өгсөн этгээд, тэдгээрийн хандивын хэмжээ болон намын үйл ажиллагаанд зарцуулсан зардлын талаарх мэдээллийг тусгасан санхүүгийн нэгдсэн тайлан гаргадаг болох, түүнийг ил тод болгох, зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг оновчтой бий болгох; мөн Сонгуулийн ерөнхий хорооны мэргэшсэн, хараат бус байдлыг нэмэгдүүлэх шаардлагатай байгааг Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас Монгол Улс дахь авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэхдээ зөвлөсөн байдаг. Энэ асуудлаар холбогдох хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хариуцлага, хяналтын механизмыг бүрдүүлэхэд Улсын Их Хурлаас тусгайлан анхаарал хандуулж ажиллах шаардлага зүй ёсоор тулгарч байна.

13. Улс төрийн намын болон сонгуулийн санхүүжилтийг олон нийтэд ил тод, нээлтэй болгох, хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагыг улс төр, бизнесийн бүлэглэлийн хууль бус ашиг сонирхол, нөлөөллөөс ангид байлгах зорилгыг хангах чиглэлээр хууль тогтоомжийг боловсронгуй болгох шаардлагатай.

Хэдийгээр Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 19<sup>1</sup>.3.-т “Намын дотоод зохион байгуулалт ардчилсан зарчимд нийцсэн, хөрөнгө, орлогын эх үүсвэр, зарцуулалт нь нийтэд ил тод байна. Намын зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, санхүүжилт, төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөлийг хуулиар тогтооно” гэсэн заалт нэмэгдсэн, Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль шинэчлэн батлагдсан боловч улс төрийн намын

санхүүгийн үйл ажиллагаа, нэн ялангуяа сонгуулийн бус үеийн санхүүжилт, түүний ил тод байдлыг зохицуулсан хууль тогтоомж шинэчлэгдээгүй байна. Тухайлбал, Улс төрийн намын тухай хуулийн дөрөвдүгээр бүлэгт Улс төрийн намын санхүүжилтийг хуульчлан “Нам санхүүгийн үйл ажиллагаандаа жил бүр аудит хийлгэн баталгаажуулж, нийтэд мэдээлнэ” гэж заасан. Энэ бүлэгт 2005 оны 2 дугаар сарын 17-ны өдрөөс хойш нэмэлт, өөрчлөлт ороогүй, хэрэгжилт нь хангалтгүй, зохицуулалт нь хэт ерөнхий, аудит, хяналт шалгалт хийх тогтолцоо тодорхойгүй, олон улсын стандартаас хол зөрүүтэй хэвээр байгааг олон улсын болон дотоодын судалгаа, тайланд дурдсан байна. Түүнчлэн Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдлыг хангах талаар эрх зүйн орчинг боловсронгуй болгох зөвлөмж (Монгол Улс дахь авлигын эсрэг шинэтгэл, Итсанбулын авлигын эсрэг арга хэмжээний төлөвлөгөөний 4 дүгээр шатны мониторингийн тайлан, зөвлөмжийн 29-т)-ийг Монгол Улсад өгсөн болно.

14. Улсын Их Хурлаас Өршөөл үзүүлэх тухай хуулийг 2000 онд, Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойг тохиолдуулан Өршөөл үзүүлэх тухай хуулийг 2006 онд, Татварын өршөөл үзүүлэх тухай хуулийг 2008 онд, Өршөөл үзүүлэх тухай хуулийг 2009 онд, Анхны ардчилсан сонгууль болж байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан өршөөл үзүүлэх тухай хуулийг 2015 онд тус тус баталсан байдаг. Эдгээр өршөөл үзүүлэх хуульд авлига, албан тушаалын гэмт хэргийг хамруулсан нь авлигыг өөгшүүлсэн, гэмт этгээдүүдэд ял завших боломж олгосон, авлигатай тэмцэх чиглэлээр хэрэгжүүлсэн нөр их хөдөлмөрийг үнэгүйдүүлсэн үйлдэл болсны зэрэгцээ олон улсын байгууллага, судлаачдын зүгээс “Монгол Улс авлига, албан тушаалын гэмт хэргийг өршөөлд хамруулж байгаа явдал нь олон улсын хүлээн зөвшөөрсөн түгээмэл зарчмыг

гажуудуулсан, нийгмийн шударга ёсыг үгүйсгэсэн алхам болох”-ыг онцлон тэмдэглэдэг. Цаашид авлигын гэмт хэрэгт өршөөл үзүүлэхгүй байх талаар зарчмын шинжтэй өөрчлөлтийг холбогдох хууль тогтоомжид тусгах шаардлагатай байна.

14. Төрийн албаны эрхэм зорилго нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж, үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэхэд оршдог. Энэхүү зорилгыг гүйцэлдүүлэхэд төрийн өндөр албан тушаалтнууд, тэр дундаа Улсын Их Хурлын гишүүдийн ёс суртахуун, шударга, хариуцлагатай байдал чухал. Харамсалтай нь сүүлийн жилүүдэд ард түмний элч болсон Улсын Их Хурлын гишүүдийн холбогдсон хэрэг, зөрчил цөөнгүй гарч байгаа нь төрийн албаны нэр хүнд, дархлаанд сөргөөр нөлөөлж байна гэж дүгнэж болохоор байна. Монгол Улсын Их хурлын гишүүдийн үг, үйлдэл, үйл ажиллагаа бүр нь нийт ард түмний байнгын хараа хяналтад байж, шударга ёс, хууль ёс бодитоор хэрэгжиж байгаа эсэхийн нэг шалгуур болж байдаг. Улсын Их Хурлын гишүүн тангараг өргөсөн эхний өдрөөсөө эхлэн энэхүү үүрэг хариуцлага, манлайлыг сайтар ухамсарлан мэдэрч байвал зохилтой билээ. Иймээс Монгол Улсын Их Хурлын гишүүний тангарагийн үг болон тангараг өргөх дэгд зарим холбогдох өөрчлөлт оруулах саналтай байна. Үүнд:

- Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т тодорхойлогдсон Улсын Их Хурлын гишүүний тангаргийг “Монгол Улсын Их Хурлын гишүүн би ард түмнийхээ элчийн хувьд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн, төрийн хуулийг дээдлэн сахиж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, гишүүний үүргээ чин шударгаар биелүүлэхээ тангараглая. Миний бие энэ тангаргаасаа няцвал хуулийн хариуцлага хүлээнэ хэмээн төрийн сүлдэнд тангараг өргөнө.” гэж өөрчлөн найруулах.



- Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3-т “Сонгуулийн ерөнхий хорооны дарга илтгэл тавьсны дараа насаар хамгийн ахмад гишүүн гишүүний тангараг уншиж бусад гишүүд нь давтан хэлж тангараг өргөх, насаар хамгийн ахмад гишүүн гишүүний тангараг унших боломжгүй бол насаар ахмад дараагийн гишүүн гишүүний тангаргийг уншиж бусад гишүүд нь давтан хэлж тангараг өргөх” гэснийг “Сонгуулийн ерөнхий хорооны дарга илтгэл тавьсны дараа гишүүн нэг бүр насны эрэмбээр, Монгол Улсын Үндсэн хууль дээр гараа тавьж, тангарагийн үгийг цээжээр уншиж тангараг өргөнө” гэж өөрчлөн найруулах.

### **Хоёр. Авлигатай тэмцэх газрын бүтэц, зохион байгуулалтыг сайжруулах чиглэлээр:**

1. Авлигын эсрэг амжилттай тэмцэл явуулахад авлигатай тэмцэх байгууллагууд хангалттай хэмжээний хүний нөөцтэй байхыг “Авлигатай тэмцэх байгууллагын Жакартагийн зарчим”-д тусгасан байдаг. Авлигатай тэмцэх газрын чиг үүрэгт хамаарах ажлын ачаалал жилээс жилд өсч байгаатай холбогдуулан авлигын гэмт хэрэг, авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой өргөдөл, гомдол хянан шалгах бүтцийг эргэж харах шаардлага зүй ёсоор тулгарч байна.

Авлигатай тэмцэх газарт ирүүлж буй өргөдөл, гомдлын 60 орчим хувийг орон нутаг дахь байгууллага, албан тушаалтантай холбоотой өргөдөл, гомдол эзэлдэг, тухайлбал тус газарт 2019 онд хүлээн авсан нийт 2100 өргөдөл, гомдол, мэдээллийн 50.8 хувь нь орон нутгаас ирсэн байна. Манай байгууллага орон нутагт бүтцийн нэгжгүй тул төвөөс албан хаагч томилолтоор очиж ажилладаг. Төсөв, санхүүгийн боломж, төвд хариуцан шалгаж байгаа гомдол, мэдээлэл, эрүүгийн хэргээсээ шалтгаалан ажлын хэсэг газар дээр нь

урт хугацаагаар ажиллах боломжгүй байдалд хүрэх, цөөн хоногт мөрдөн шалгах ажиллагааг хийдгээс асуудал бүрэн гүйцэд шалгагдахгүй байх, орон нутгаас бичгийн нотлох баримтуудыг гаргуулан авах, орон нутгийн хууль, хяналтын байгууллага, мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулан авахад хугацаа алдах, гэмт хэрэг, зөрчлийг бүрэн илрүүлэн, шалтгаан, нөхцөлийг тогтоож, буруутай албан тушаалтанд хуульд заасан хариуцлага тооцох, ял завшуулахгүй байх зэрэгт эрсдэл үүсч байна.

Түүнчлэн авлигын гэмт хэргийг шалгаж, шийдвэрлэхэд хяналт тавих прокурор, аливаа зөвшөөрөл олгох, хянан шийдвэрлэх шүүх нь орон нутгийн харьяалалтай байдаг нь авлига, ашиг сонирхлын шинжтэй гомдол мэдээлэл, эрүүгийн хэргийг түргэн шуурхай шалгаж шийдвэрлэхэд хүндрэл бэрхшээл, иргэд, олон нийтэд чирэгдэл, хүнд суртал үүсэх сөрөг үр дагавар гарч болзошгүй байна.

Иймд, дээрх нөхцөл байдлыг харгалзан Авлигатай тэмцэх газрын бүтцийн нэгжийг бүсчилсэн хэлбэрээр байгуулан ажиллуулах зайлшгүй шаардлагатай байна.

2. Авлигын эсрэг хуулийн 27 дугаар зүйлд зааснаар авлигатай тэмцэхэд олон нийтийг идэвхтэй оролцуулах, тэдний санал бодлыг хүргэх, авлигын нөхцөл байдал, авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар зөвлөмж өгөх зорилго бүхий орон тооны бус Олон нийтийн зөвлөл Авлигатай тэмцэх газрын дэргэд ажиллаж байна. Энэхүү Олон нийтийн зөвлөлийн гишүүнийг Монгол Улсын Ерөнхийлөгч 4 жилийн хугацаагаар томилж байгаа бөгөөд ийнхүү томилох гишүүнийг хэрхэн сонгон шалгаруулах талаар зохицуулалтгүй байсаар байна. Зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах зохицуулалтгүй байх нь уг зөвлөлийн үйл ажиллагаа үндсэн зорилгоосоо хазайх, улс төрийн нөлөөнд автах эрсдэлтэйг судлаачид илэрхийлдэг.

Түүнчлэн Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас

Монгол Улсад өгсөн зөвлөмжийн гуравдугаарт “ОНЗ-ийн гишүүдийг нээлттэй, объектив байдлаар сонгон шалгаруулах байдлыг хангах, тус зөвлөлийн үйл ажиллагаанд нээлттэй, хариуцлагатай байдлыг бэхжүүлэх”-ийг дурдсан байна.

Олон нийтийн зөвлөлийн гишүүдийг ил тод, нээлттэй сонгон шалгаруулах, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг бүрэн хамруулах, зөвлөлийн үйл ажиллагааны нээлттэй байдлыг хангах талаар холбогдох хууль тогтоомжид нэмэлт оруулж, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.

### **Гурав. Авлигын хэргээр дагнан мэргэшсэн шүүгчийг ажиллуулах чиглэлээр:**

Авлигатай тэмцэх газраас зохион байгуулдаг Шударга байдлын үнэлгээний судалгаа, Улс төр, шүүх, хууль сахиулах байгууллагуудын хүрээн дэх авлигын төсөөллийн судалгаа болон бусад байгууллагуудын зохион байгуулсан удаа дараагийн судалгаагаар шүүх нь авлига хамгийн их тархсан институцуудын нэг гэж тодорхойлогддог. Сүүлийн үед иргэд, олон нийт авлигын хэргийн шийдвэрлэлтэд шүүмжлэлтэй хандаж байна. Тухайлбал, хахууль авсан төрийн албан хаагчид харилцан адилгүй шийтгэл ногдуулсан шүүхийн шийдвэрийг харьцуулан тавьж, шударга бус явдал гэж иргэд үзэж байна. Үүний зэрэгцээ прокурор, шүүгчийг авлига, албан тушаалын гэмт хэрэгт хяналт тавих, хянан шийдвэрлэх чиглэлээр дагнан мэргэшүүлэх шаардлага зүй ёсоор тулгарч байна. Өнөөгийн Монгол Улс дахь шүүх тогтолцооны талаар Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын шинжээчид үнэлгээ өгөхдөө шүүх тогтолцоог бэхжүүлэхийн тулд шүүгчийн сонгон шалгаруулалтыг ил тод болгох, шүүгчийг чадахуйн зарчимд тулгуурлан томилох, шүүгчийг сонгон шалгаруулах шалгалтад тэнцсэн ч, тухайн нэр дэвшигчийг шүүгчээр томилуулахаар

нэр дэвшүүлээгүй Шүүхийн ерөнхий зөвлөлийн шийдвэрийн эсрэг давж заалдах тодорхой процедурыг хуульд тусгах, шүүхийн хараат бус байдлыг нэмэгдүүлэх, хэрэг хуваарилах механизмыг хүний оролцоогүй болгох зэрэг асуудлыг зөвлөсөн байдагт анхаарал хандуулах, улмаар авлигатай тэмцэх бодлогын хүрээнд Монгол Улс дахь шүүх тогтолцоог тусгайлан авч үзэх, авлигын эсрэг тэмцэл явуулж буй зарим улс орнуудын жишгийн дагуу авлигын гэмт хэргийг хянан үздэг дагнасан шүүх байгуулах асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.

Бусад улс оронд дагнасан шүүх байхаас гадна хөдөлмөрийн шүүх, гэр бүлийн шүүх, патентын шүүх, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн шүүх, авлигын шүүх зэрэг бие даасан төрөлжсөн шүүхүүдэд шүүгчид дагнан мэргэшин ажилладаг туршлага байна. Олон улсын туршлагаас харахад Филиппин, Пакистан, Индонези, Непал, Кени, Бангладеш, Бурунди, Хорват, Уганда Улсад авлигын хэргийн шүүн таслах ажиллагаа явуулах тусгай шүүх ажиллаж байна. 2009 онд Словак, 2010 онд Афганистан, Палестин, 2011 онд Камерун, Малайз, 2012 онд Болгар, Сенегал, 2013 онд Ботсвана, 2015 онд Мексик, 2016 онд Танзани, Тайланд Улсад авлигын эсрэг тусгай шүүхийг байгуулжээ. Авлигын хэргээр дагнан мэргэшсэн шүүгчийг ажиллуулбал шийдвэр, захирамж, тогтоолын чанар сайжирч, хуулийг зөв хэрэглэх, хууль хэрэглээний алдаа багасахад нөлөөлж, нийгмийн зүгээс шүүгчдэд өгөх сөрөг дүгнэлтийг өөрчлөх, шүүх шударга ажиллаж байгаа гэдэгт иргэдийн итгэл нэмэгдэх, гэмт хэргийн шүүн таслах үйл ажиллагаа, оногдуулах ялын бодлогод чанарын ахиц гаргахад нөлөөлнө гэж үзэж байна.

### **Дөрвөн. Эрх зүйн харилцан тусалцаа, олон улсын хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр:**

Авлига, албан тушаалын болон мөнгө угаах гэмт хэргийг мөрдөн шалгах, гэмт этгээдийг шилжүүлэх, гэмт хэргийн



замаар олсон хууль бус хөрөнгө илрүүлэх ажиллагааны үр дүн нь дан ганц дотоодын хууль тогтоомж болон хууль сахиулах байгууллагын чадавхаас хамаарахгүй байна. Авлига, албан тушаалын болон мөнгө угаах гэмт хэргийг үр дүнтэй мөрдөн шалгахад бусад улс орнуудын хууль сахиулах байгууллагатай нягт хамтран ажиллах зайлшгүй шаардлагатай байна. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсаны дагуу Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийг эрх зүйн харилцан туслалцааны үндэслэл болгон хэрэгжүүлэх талаар системтэй арга хэмжээ авах, эрүүгийн хэргийн талаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээг бусад улс орнуудтай байгуулах, авлига, мөнгө угаах, терроризм, хүн худалдаалах, хар тамхи, мансууруулах бодис наймаалах зэрэг гэмт хэргийн талаар мэдээлэл солилцох, мөрдөн шалгах ажиллагаа явуулах чиглэлээр хоёр болон олон талт гэрээ байгуулж, нэгдэн орох талаар удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авах, ялангуяа гэмт хэрэг үйлдэж олсон гадаад улсад байгаа хөрөнгө, орлогыг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад битүүмжлэх, хураан авах, хөрөнгө буцаах ажиллагааг явуулах зорилгоор эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх, гэрээ байгуулах туршлага судлах, энэ чиглэлээр эрх зүй, зохион байгуулалтын арга хэмжээ авах шаардлага зүй ёсоор тулгарч байна.

Монгол Улсын нэгдэн орсон НҮБ-ын аливаа конвенцийн хүрээнд олж авсан мэдээ, мэдээлэл, баримтыг нотлох баримтаар үнэлэх практикийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэвшүүлэх арга замыг бий болгох, эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагаанд оролцогч төрийн байгууллага /Хууль зүй, дотоод хэргийн яам, Гадаад харилцааны яам, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын газар, хууль сахиулах байгууллага/-уудын харилцан хамтын ажиллагаа, үйл ажиллагааны уялдааг хангах, эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэхтэй холбогдсон гэрээ, эх сурвалж, хүсэлтэй

холбогдсон тоо баримтуудын талаарх мэдээллийн нэгдсэн бааз, хууль сахиулах байгууллага хоорондын цахим санг бий болгож, үйл ажиллагаанд ашиглах, мэдээ, мэдээллийг тодорхой хугацаанд давтамжтайгаар шуурхай солилцох ажиллагаа болон гэрээний дагуу хүргүүлсэн мөрдөгчийн хүсэлтийн гүйцэтгэл, эргэх холбоонд тавих төрийн байгууллагуудын хяналтын тогтолцоог бий болгох, холбогдох бусад үйл ажиллагааг нэг мөр, тодорхой болгон журамлах нөхцөл бий болсны зэрэгцээ эрх зүйн туслалцааны хүсэлтийг хууль, олон улсын гэрээ, хэлэлцээрт заасан шаардлагын түвшинд боловсруулах, хүсэлтэд тусгагдвал зохих мэдээ, мэдээллийг олж авах арга зам, холбогдох бусад ажиллагааны талаар хуульчдын үргэлжилсэн сургалтын хүрээнд кредитийн сургалтад оруулах, ном, гарын авлагыг боловсруулах, хүртээмжтэй болгох цогц арга хэмжээ авах хэрэгтэй байна.

### **Тав. Авлигын шалтгаан, нөхцөлийг арилгах чиглэлээр:**

1. Улсын Их Хурлын болон орон нутгийн сонгууль зохион байгуулахтай холбогдуулан орон нутгийн өмч, хөрөнгө, төсөв, мөнгө, хүн хүчийг улс төрийн үйл ажиллагаа, сонгуулийн сурталчилгаанд ашиглахгүй байхад онцгойлон анхаарч, аливаа ашиг сонирхлын зөрчил гаргах, авлигын асуудал үүсгэхээс урьдчилан сэргийлэх, хяналт тавьж ажиллах шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Улсын Их Хурлын сонгууль бүрийн дараагаар төрийн албан хаагчдын багагүй хувьд өөрчлөлт ордогийг холбогдох статистик харуулдаг. Түүнчлэн шинэ коронавирусийн тархалттай холбоотойгоор эдийн засагт хүндрэл учирч байгааг холбогдох байгууллагууд илэрхийлж байна. Эдийн засагт хүндрэл учирч байгаа нь хувийн хэвшлээс төрийн албанд орж ажиллах сонирхлыг нэмэгдүүлж болзошгүй ба эдийн засгийн нөхцөл байдал хүндэрч, иргэд, өрхийн худалдан авах чадвар буурах нь төрийн албан хаагчдын амьжиргааны нөхцөл доройтох, бодит орлого буурах үр



дагаварт хүргэхээр байна. Ингэснээр төрийн албан хаагч авлига, хээл хахуулийн гэмт хэрэг, зөрчилд өртөх эрсдлийг бий болгож болзошгүй юм.

Эдгээр нөхцөл байдалтай холбоотойгоор 2020 оны сүүлийн хагас жилд төрийн албаны мэргэшсэн, тогтвортой байдлыг хадгалах, төрийн албан хаагчдын цалин, орлогыг бууруулахгүй байх, инфляц, хүн амын худалдан авах чадвартай уялдуулан цалинг нэмэх асуудлыг зайлшгүй анхаарч үзэх шаардлагатай байна.

2. Төрийн байгууллагууд, төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тендер, худалдан авалтын үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллаагүй, авлига, ашиг сонирхлын эрсдэл арилаагүй, зөвлөмж, шаардлага хүргүүлсээр байхад доор дурдсан зөрчил, дутагдал гарсаар байна:

- хөрөнгө оруулалтын ажлуудыг зураг, төсөвгүйгээр баталсан;
- төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14-16 дугаар зүйлд заасан ерөнхий шаардлагыг хангаагүй хуулийн этгээдтэй гэрээ байгуулсан;
- худалдан авах ажиллагааг зохион байгуулалгүйгээр гэрээ байгуулж, тендерийн баримт бичгийг нөхөн бүрдүүлсэн;
- хэрэгжиж дуусаагүй, гэрээ дүгнээгүй ажил, арга хэмжээнд санхүүжилт олгосон;
- хууль зөрчин шууд худалдан авалт хийсэн;
- тендерт хамгийн бага үнээр шалгарсан аж ахуйн нэгж гэрээний хугацаанд анхны үнийн дүнг нэмэгдүүлж нэмэлт гэрээ байгуулан төсвийн хөрөнгө завшсан;
- төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны чиглэлээр зохих сургалтад хамрагдаагүй, АЗ сертификатгүй этгээдийг тендерийн үнэлгээний хороонд ажиллуулсан г.м.

Иймд, Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах журмын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах, төлөвлөлт болон гүйцэтгэлийг үр ашигтай, ил тод, олон нийтэд нээлттэй болгож, гүйцэтгэл, явцад хөндлөнгийн хяналт тавих нөхцөл, боломжийг сайжруулах, дээрх зөрчлийг таслан зогсоох, цахим тендерийн үйл ажиллагааг боловсронгуй болгох шаардлагатай.

3. Ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн бүртгэлийг 2019 оны 12 дугаар 11-ний өдрийн байдлаар судлан үзэхэд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт 436, Татварын байгууллагад 547 хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээлэл бүртгэгдсэн. Эцсийн өмчлөгчийн мэдээлэлд орсон өөрчлөлтөө 46 хуулийн этгээд хуулийн этгээдийн бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн бол татварын байгууллагад зөвхөн 2 хуулийн этгээд бүртгүүлсэн зэрэг зөрүүтэй бүртгэлүүд хийгдэж байгаа нь төрийн байгууллага хоорондын уялдаа холбоо хангалтгүй байгааг илтгэж байна. Мөн тусгай зөвшөөрөлтэй 2088 компанийн 63 хувь нь эцсийн өмчлөгчийн талаарх мэдээллийг бүртгүүлээгүй ба 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлүүлсэн бүртгэлийн үйл ажиллагаа 2018 оны 6 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл үргэлжлээд зогсонги байдалд орсон бөгөөд энэхүү үйл ажиллагааг хариуцан зохион байгуулж буй Улсын бүртгэлийн газар, Татварын ерөнхий газар, Ашигт малтмал, газрын тосны газрын хамтын ажиллагааг уялдуулах, мэдээллийн зөрүү үүсэхээс сэргийлэх, мэдээллийг хянан баталгаажуулах тогтолцоог бүрдүүлэхийн зэрэгцээ ашигт малтмалын тусгай зөвшөөрөл хүсэх өргөдөлд хавсаргадаг Хуулийн этгээдийн тодорхойлолт буюу Маягт К-04, Маягт К-02 дахь мэдээлэл нь хуулийн этгээдийн “эцсийн өмчлөгч”-ийг бүрэн тодорхойлж чадахгүй байна. Ашигт малтмал, газрын тос, байгалийн хий, цацраг идэвхт ашигт малтмалын



хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл шинээр олгох, хугацаа сунгах тухай шийдвэр гаргахад эцсийн өмчлөгчийн мэдээллийг заавал авах мөн эцсийн өмчлөгчийн ил тод мэдээлэх талаар зохицуулалт бий болгох нь зүйтэй.

4. Байгууллага, албан тушаалтан хуулиар тусгайлан эрх олгоогүй байхад эрх хэмжээгээ хэтрүүлэн дүрэм, журам батлан мөрдүүлэх, төлбөр хураамж тогтоох асуудал түгээмэл байгаа нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хүнд суртал, чирэгдэл учруулах шалтгаан болж байна. Тухайлбал, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-т “Хуульд заасан хязгаар, шаардлагад нийцүүлэн орон нутгийн зарим татвар, төлбөр, хураамжийн хувь хэмжээг тогтоох” эрхийг зөвхөн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд олгосон байхад дээрх заалтыг зөрчин, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид өөрт олгогдоогүй эрхийг хэрэгжүүлж, шийдвэр гарган мөрдүүлж байгаад онцгойлон анхаарах шаардлагатай. Захиргааны ерөнхий хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-т заасан “Хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллага өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хүчин төгөлдөр үйлчилж байгаа захиргааны хэм хэмжээний актад жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хэрэгжилтийн явц, үр дүнгийн тайланг цаашид авах арга хэмжээний талаарх саналын хамт хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ” гэж заасныг хэрэгжүүлж, захиргааны хэм хэмжээний актад мониторинг, үнэлгээ хийж, нэгдсэн тайлан мэдээ гарган, олон нийтэд мэдээлэх ажлыг хэвшүүлж, зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулах шаардлага байна.

5. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль хэрэгжиж буй 26 жилийн хугацаанд 5 удаагийн хуулиар хэд хэдэн нэмэлт, өөрчлөлт орсон байдаг. Цаг үе, нийгмээ дагаж төр, иргэний харилцаа ч мөн адил

хувьсан өөрчлөгдөж байгаа тул хуулийн зохицуулалт өнөөдрийн хэрэгцээ шаардлагыг хангаж байна уу гэдгийг судлан үзэх шаардлагатай. Төрийн байгууллагууд хууль тогтоомжоор тогтоосон өөрийн эрхлэх асуудлын хүрээгээ хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, сурталчлах ажлыг тасралтгүй хийх нь хангалтгүй байгаагаас хамааран иргэд тухайн нэг асуудлаар хаана, хэнд хандахаа мэдэхгүй байх тохиолдол гардаг нь иргэдийн бухимдлыг төрүүлдэг, иргэдээс төрийн эрх бүхий дээд шатны байгууллагад хандсан асуудлыг хянаж үзэж шийдвэрлэхгүйгээр доод шатны байгууллагад шууд шилжүүлэх явдал хэвшмэл болсон нь иргэдийн төрд итгэх итгэлийг бууруулах хүчин зүйл болж байна.

6. Албан тушаалтны буруутай үйл ажиллагааны улмаас төрд учирсан хууль бус хохирлыг нөхөн төлүүлэх талаар хууль тогтоомжийн зохицуулалтыг үр дүнтэй хэрэгжүүлэх механизмыг бий болгох, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Улсын ерөнхий прокурорын газар, Төрийн албаны зөвлөл, Үндэсний аудитын газар зэрэг төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх, уялдаа холбоог хангах, мэдээлэл солилцох, сан бүрдүүлэх, дүн шинжилгээ хийх чиглэлээр асуудал хариуцсан холбогдох байгууллагууд үр дүнтэй хамтран ажиллах;

7. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийх ажлыг төлөвлөх, батлахад иргэдийн оролцоог хангах талаар анхаарч ажиллах шаардлагатай. Хэдийгээр багийн иргэдээр хэлэлцүүлсэн гэх боловч холбогдох материалыг архивын нэгж болгодоггүй, техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөвгүй ажлыг баталдаг. Иймд, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлыг урт, дунд болон богино хугацааны хөгжлийн хөтөлбөр, зорилттой нийцүүлэн төлөвлөх, “Орон нутгийн

хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын хэрэгжилтийг нэг мөр хангуулах, хяналт мониторингийн ажлыг улсын хэмжээнд зохион байгуулж, үр ашгийг үнэлж, дүгнэх, ил тод байдлыг хангуулах, олон нийтэд мэдээлэх дэвшилтэт арга хэлбэрийг нэвтрүүлэх, хариуцсан ажилтнуудыг чадавхжуулах, сайн туршлагыг солилцох ажлыг зохион байгуулах шаардлагатай.

8. Сум хөгжүүлэх сангаас олгосон зээл, түүний талаарх мэдээллийг нийтэд ил тод болгон сонирхогч этгээд танилцах боломж, нөхцөлийг бүрдүүлэх талаар үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлдэггүй, зээлийн эргэн төлөлт, зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэхэд хяналт тавьдаггүй, зээл олгохдоо барьцаа хөрөнгө авдаггүй, зээлийг буцаан төлөх төлбөрийн чадваргүй иргэнд зээл олгосон зэрэг зөрчлүүд арилахгүй байна. Засгийн газрын 2019 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдаанаар Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд хийсэн улсын үзлэгийг 2019 оны 4 дүгээр сарын 25-ны өдрөөс 5 дугаар сарын 25-ны өдрүүдэд зохион байгуулж, дүнг 2019 оны 7 дугаар сарын 1-ний дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар шийдвэрлэсэн. Улсын үзлэгийг заасан хугацаанд явуулсан боловч үр дүнг тайлагнах ажил хийгдээгүй тул үүргийн биелэлтийг хангах, цаашид уг сангийн үр өгөөжийг дээшлүүлэх, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох, өр төлбөрийг барагдуулах, мэдээллийн сангийн ил тод, нээлттэй байдлыг хангах, иргэд, олон нийтийн зүгээс хяналт тавих боломжийг олгох чиглэлээр дорвитой

арга хэмжээ авах шаардлагатай байна.

9. Засаг даргын нөөц хөрөнгийн захиран зарцуулалтад тавих хяналтыг чангатгах, хэт үрэлгэн, зориулалт бусаар зарцуулж байгааг таслан зогсоохтой холбогдуулан Авлигатай тэмцэх газраас ИТХ-ын дарга, Засаг дарга, Сангийн сайдад хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, баталсан хөрөнгийг баяр ёслол, тэмцээн уралдаан, шагнал, урамшуулал, туршлага солилцох аялал, гадаад, дотоодын зочид, төлөөлөгчдийн хоол, буудал, унаа, бэлэг зэрэгт зарцуулах нь түгээмэл байна. Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын зарим зүйл, хэсэг, заалт албан тушаалтанд төсвийн хөрөнгийг үр дүнгүй зарцуулах боломжийг бүрдүүлсэн ба Захиргааны ерөнхий хуульд заасан шаардлага (захиргааны хэм хэмжээний улсын нэгдсэн санд бүртгэгдээгүй)-ыг хангаагүй, хууль бус захиргааны актыг мөрдсөөр байна. Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах, урьдчилан төлөвлөж, урсгал зардлаар хийж болох үйл ажиллагаа(мал тооллого, цэрэг татлага, баяр наадам тэмдэглэх, зочид төлөөлөгч хүлээн авах, шагнал, урамшуулалд өгөх)-г санхүүжүүлдэг зөрчил дутагдлыг таслан зогсоох, хуульд заасан нөөцийг бэлэн байлгах, олон нийтэд ил тод тайлагнаж хэвшүүлэх, хяналт, хариуцлагыг чангатгах нь зүйтэй.

# ХОЁРДУГААР БҮЛЭГ

## Авлигын ерөнхий нөхцөл байдал-2019




## ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

Авлигатай тэмцэх газраас төрийн 62 байгууллагаас үйлчилгээ авсан 7400 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл, үйлчилгээ хүргэсэн 1360 албан хаагч, 795 шинжээчийн үнэлгээнд үндэслэн 2019 оны шударга байдлын үнэлгээг тооцов.

Энэ оны шударга байдлын үнэлгээгээр судалгаанд хамрагдсан 62 байгууллагын дундаж үнэлгээ 74.1<sup>1</sup> гарч, өмнөх оны түвшнээс 5.4 пунктээр өссөн байна. Ийнхүү өсөхөд төрөөс үйлчилгээ авсан иргэдийн өгсөн үнэлгээ 8.4 пунктээр, төрийн албан хаагчдын өгсөн үнэлгээ 4.0 пунктээр нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Байгууллага бүрээр авч үзвэл Соёл, урлагийн газар, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Гадаадын иргэн, харьяатын газар, Онцгой байдлын ерөнхий газар, Оюуны өмчийн газар, Завхан аймгийн ЗДТГ хамгийн өндөр буюу 83.7-81.1-ийн хооронд оноо авчээ. Харин Гаалийн ерөнхий газар, Биеийн тамир, спортын газар, Үндэсний хөгжлийн газар, Иргэний нисэхийн ерөнхий газар, Ховд аймгийн ЗДТГ хамгийн бага буюу 64.8-66.7 оноо авсан байна.


### Агентлагийн шударга байдлын үнэлгээ /оноор/




1 0-100 онооны хооронд үнэлсэн бөгөөд 100 бол эерэг утгыг илэрхийлнэ.



## Яамдын шударга байдлын үнэлгээ /оноор/



## Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын үнэлгээ, байршлаар



Судалгаанд хамрагдсан 54 байгууллагын шударга байдлын үнэлгээ өмнөх оныхоос 0.1-18.8 пунктээр нэмэгдсэн бол Үндэсний хөгжлийн газар (10.7 пункт), Гадаад харилцааны яам (3.4), Гаалийн ерөнхий газар (2.9), Иргэний нисэхийн ерөнхий газар (2.8) зэрэг 8 байгууллагын үнэлгээ буурсан байна. Тухайлбал, Үндэсний хөгжлийн газар (65.7)-ын хувьд байгууллага дахь авлигын эсрэг тогтолцоо, мэдээлэгчийг хамгаалах, авлигыг хянах дотоод хяналтын механизм, төсвийн зарцуулалтын хяналт, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл тааруухан байна. Гадаад харилцааны яам (76.7) харьцангуй өндөр оноотой ч, өмнөх оныхоос буурсан байна. Тус яамны хувьд иргэдийн үнэлгээгээр үйл ажиллагаа, хүний нөөцийн мэдээллийн ил тод байдал, албан хаагчдын хариуцлагатай байдлын үнэлгээ өмнөх оноос буурсан дүнтэй гарчээ. Гаалийн ерөнхий газар (64.8)-ын хувьд тухайн газрын албан хаагчдын үнэлгээ өссөн хэдий боловч иргэд болон шинжээчдийн үнэлгээ буурсан байна. Иргэдийн үзэж байгаагаар төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээлэл ил тод байдал, албан хаагчдын хариуцлагатай байдал, тухайн байгууллага дахь авлигын талаарх төсөөллийн үнэлгээ буурсан бол шинжээчдийн

үзэж байгаагаар тухайн байгууллага дахь авлигыг хянах механизм, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр үр дүнтэй ажиллаж байгаа эсэх болон авлигатай тэмцэх чиглэлээр удирдлагын хүсэл эрмэлзлийн үнэлгээ өмнөх оныхоос буурсан нь нөлөөлжээ. Иргэний нисэхийн ерөнхий газар (66.0)-ын хувьд шинжээчдийн үнэлгээгээр тус байгууллага дахь авлигын талаарх төсөөлөл, авлигын хянах механизм, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлийн үзүүлэлтүүд өмнөх оноос буурсан байна.


Бага оноо авсан байгууллагуудын хувьд нийтлэг байдлаар мэдээллийн ил тод, хариуцлагатай байдал хангалтгүй, авлигыг хянах дотоод хяналтын механизм, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул байна.

Цаашид төрийн байгууллагууд шударга байдлын үнэлгээгээ нэмэгдүүлэхийн тулд хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, албан хаагчдын хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх, авлигатай тэмцэх үйл ажиллагаагаа олон нийтэд сурталчлах, хариуцлага тооцох механизмыг илүү сайжруулах, ил тод мэдээлэх, авлига ашиг сонирхлын зөрчил гаргасан этгээдийг мэдээлсэн мэдээлэгчийг бүрэн хамгаалах, байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, нийт албан хаагчдын ёс зүй, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх зэрэгт анхаарал хандуулж, тодорхой үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

## АВЛИГЫН ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАЛААРХ ТӨСӨӨЛӨЛ


Шударга байдлын үнэлгээний судалгаанд оролцогчдоос Монгол Улсад авлига хэр түгээмэл байгааг тодруулахад 23.0 хувь нь ихээхэн түгээмэл гэж хариулсан нь өмнөх оноос 5.1 пунктээр, 48.4 хувь нь түгээмэл гэж хариулсан нь 2.2 пунктээр тус тус буурсан үзүүлэлттэй байна.

### Монгол Улсын авлигын өнөөгийн байдал



Мөн Монгол Улсын ирэх 2 жилийн авлигын нөхцөл байдлын талаарх төсөөллийг тодорхойлох зорилгоор судалгаанд оролцогчдоос ирэх 2 жилд Монгол Улсын авлигын түвшин хэрхэн өөрчлөгдөх талаар тодруулахад 43.5 хувь нь буурна гэж үзжээ. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 26.7 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.

### Авлигын нөхцөл байдлын талаарх ирэх 2 жилийн төсөөлөл /оноор/






## АВЛИГА ТАРХСАН ИНСТИТУЦИЙН ТАЛААРХ ТӨСӨӨЛӨЛ

Монгол Улсад авлига хамгийн их тархсан институцийн талаар тодруулахад судалгаанд оролцогчид 2019 онд шүүх, гааль, мэргэжлийн хяналтын байгууллагад авлига их тархсан гэж үзэж байна.

Монгол Улсад авлига их тархсан институцийн талаарх төсөөлөл, судалгаанд оролцогчдын дүнд эзлэх хувиар



## ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН АВЛИГЫН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Авлигатай тэмцэх газраас 2019 онд Шударга байдлын үнэлгээний судалгаанд хамрагддаггүй эмнэлэг, сургууль, төрийн өмчит компани буюу нийт 15 байгууллагын<sup>2</sup> үйл ажиллагаанд авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэж буй, үүсгэж болзошгүй шалтгаан нөхцөл, хүчин зүйлийг тодорхойлох зорилгоор эрсдэлийн үнэлгээний ажлыг зохион байгуулж, үр дүнг тухайн байгууллагын удирдлагад танилцуулан хэлэлцүүлэг зохион байгуулж, цаашид авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа явуулах чиглэлийг тодорхойлон ажиллав.

Эрсдэлийн үнэлгээнд хамрагдсан **эмнэлэгүүдийн хувьд** төсөв санхүү, хүний нөөц, худалдан авалт зэрэг үйл ажиллагаатай холбоотой авлигын эрсдэл байна. Ялангуяа, нэг талаас орон тоо, төсөв бага байгаа нь үйлчилгээний чанар, хүртээмжид сөргөөр нөлөөлж байгаа бол нөгөө талаас үйлчилгээ авч буй иргэдийн хувьд чанар, хүртээмжтэй үйлчилгээ авах хүсэл сонирхолтой байгаа нь авлигын эрсдэлийг бий болгож байна.

**Их сургуулиудын хувьд** гомдлыг шийдвэрлэх механизм, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл эрсдэл өндөртэй байна. Авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх чухал хүчин зүйлсийн нэг нь тухайн байгууллагын удирдлагын манлайлал, авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл байдаг. Удирдлагын манлайлал, хүсэл эрмэлзэлийг тодорхойлох нэг үзүүлэлт бол тухайн байгууллагад авлигын эсрэг төлөвлөж, хэрэгжүүлсэн арга

<sup>2</sup> **Эмнэлэг:** Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Нийслэлийн Өргөө амаржих газар, П.Н.Шастины нэрэмжит гуравдугаар төв эмнэлэг, Улсын хоёрдугаар төв эмнэлэг, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Гэмтэл, согог судлалын үндэсний төв,

**Сургууль:** МУИС, МУБИС, АШУУИС,

**Төрийн өмчит компани:** “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК, “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ, “Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл” ТӨААТҮГ, “МИАТ” ТӨХК, “Монгол шуудан” ТӨХК, “Хөдөө аж ахуйн бирж” ТӨХК



хэмжээ байдаг. Авлигын эсрэг төлөвлөж, хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар тухайн сургуулийн багш, оюутнууд мэдээлэл муутай байгаагаас дүгнэлт хийж болохоор байна. Цаашид удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэлийг нэмэгдүүлэх, сонгон шалгаруулалтад анхаарал хандуулах, гомдол, мэдээллийг шийдвэрлэх механизмыг боловсронгуй болгох шаардлагатай.

**Төрийн өмчит компаниудын хувьд** хүний нөөцийн үйл ажиллагаа харьцангуй өндөр эрсдэлтэй байна. Тухайлбал, ХАСУМ-ээ хянуулаагүй, эсхүл, ашиг сонирхлын зөрчилтэй албан хаагчдыг томилдог, хүний нөөцийн сонгон шалгаруулалтын мэдээллийн ил тод байдал хангалтгүй, албан тушаалд дэвших, шагнал, урамшуулал олгох үйл ажиллагаа шударга, ил тод явагддаггүй зэрэг асуудал түгээмэл байна. Мөн дотоод хяналт шалгалтын бүтэцгүй, эсхүл бүтэцтэй ч үр дүн хангалтгүй байгаа нь эдгээр байгууллагуудын хариуцлагын тогтолцоог сулруулах, цаашлаад авлигын эрсдэлийг бий болгох нөхцөлийг бүрдүүлж байна. Мөн байгууллагад хүлээн авсан гомдлыг шийдвэрлэх, шүгэл үлээгчийг хамгаалах тогтолцооны хүрээнд шүгэл үлээгчийг хамгаалах, урамшуулах тогтолцоог дотоод журмаараа шийдвэрлэсэн байдал хангалтгүй байгаа нь мөн эрсдэлийг бий болгож байна.

## УЛС ТӨР, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ТАЛААРХ ТӨСӨӨЛЛИЙН СУДАЛГАА

Авлигатай тэмцэх газраас 2008 оноос хойш жил бүр “Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгаа”-г зохион байгуулж үр дүнг танилцуулж байна. Судалгаа нь улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөлөл, хандлага, шалтгааныг тодруулах, мөн хүрээн дэх авлигад автагдсан байдал, цар хүрээ, хэлбэрийг авч үзэх, авлигад нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэхэд эх сурвалж болдог.

2017 он хүртэл улс төр болон шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийг нэг судалгаагаар судалж, нэгтгэсэн тайланг гаргаж байсан бол 2018 оноос хоёр хүрээг тусад нь авч үзэн судалгааг гүйцэтгэж байна.

2019 онд улс төрийн хүрээн дэх авлигын түвшин 4.08<sup>3</sup> пункт гарлаа. Өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад 0.15 пунктээр өсчээ. Харин шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын түвшин 3.86 пункт гарч, өмнөх оны үзүүлэлтээс 0.18 пунктээр өссөн байна.

Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээний авлигын түвшин, 2008-2019 онд



3 Үзүүлэлтийн утгыг 1-5 гэх оноогоор үнэлүүлэн тооцсон. Оноо буурах тусам эерэг утгыг илэрхийлж байгаа бол өсөх тусам сөрөг утгыг илэрхийлдэг.




Сүүлийн үед гарч байгаа авлигын үзэгдэл дэх гол өөрчлөлт бол дээр, доор, дунд бүх түвшинд хавтгайрсан, эрээ цээргүй, айж ичих зүйлгүй, ил цагаандаа гарснаар илэрч байна. Жирийн иргэн хүнд авлигыг үл тэвчих үзэл бүдгэрч, харин дөжирсөн, эвлэрсэн, хүлээн зөвшөөрсөн, авлигын субъект болж өөрчлөгдөх нь түгээмэл байна гэж үзжээ.

## “ДЭЭД БОЛОВСРОЛЫН САЛБАР, ОРЧИН ДАХЬ ЁС ЗҮЙН АСУУДАЛ” СУДАЛГАА

Тус газраас “Дээд боловсролын салбар, орчин дахь ёс зүйн асуудал” сэдэвт судалгааг төрийн бус байгууллагын оролцоотойгоор зохион байгуулаад байна. Уг судалгааны зорилго нь багш, эмч, эрх зүйч зэрэг иргэдэд нийтлэг үйлчилгээ үзүүлдэг, ёс зүйн өндөр хэм хэмжээг өдөр тутам чанд сахин мөрдөх шаардлагатай мэргэжилтэн бэлтгэдэг төрийн өмчийн их сургуулиудаар төлөөлүүлэн дээд боловсролын салбарын ёс зүйн нөхцөл байдлыг тодруулахыг зорьсон болно. Судалгаанд Дотоод хэргийн их сургууль, Боловсролын их сургууль, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн багш, албан хаагч, оюутнуудыг хамруулав.


Судалгааны үр дүнгээр их сургуулийн багш нарын дунд ёс зүйтэй байхыг чухалчлах байдал харьцангуй өндөр байна.

### Ёс зүйтэй байх нь таны хувьд хэр зэрэг чухал вэ?



Оюутнуудын хувьд ёс зүйн үлгэр дуурайл авах хүмүүсийн эхэнд багш байгаа хэдий ч, багшаас суралцах ёстой гэсэн хандлага курс ахих тусам буурч байна. Мөн курс ахих тусам их сургуулийн орчинд ёс зүйгүй байдал газар авсан гэж үзэх хандлага нэмэгдэж буй нь анхаарал татаж байна.

### Ёс зүйн талаар хэнээс/юунаас суралцах ёстой талаар оюутны хариулт (курсээр)




Судалгааны тайланд дээд боловсролын орчинд мөрдөгдөж буй ёс зүйн дүрмийн хэрэгжилт, тэдгээрийн үр дүнг судлах, оюутнуудыг ёс суртахуунтай, шударга иргэн болон төлөвшихөд чиглэсэн үйл ажиллагааг бодлогын түвшинд боловсруулан, системтэй хэрэгжүүлэх, оролцогч талуудын дунд нэгдмэл ойлголт, мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх шаардлагатай гэжээ.

## ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН СУДАЛГАА

Хүүхдийн шударга байдлын судалгааг Авлигатай тэмцэх газраас жил бүр зохион байгуулж байна. Уг судалгаа нь Монгол Улсын ирээдүй болсон хүүхдүүдийн шударга байдал, ёс зүй, ёс суртахуун, төлөвшилтийн түвшинг үнэлэх, цаашид хүүхдүүдийг шударга иргэн болгон төлөвшүүлэхийн тулд авч хэрэгжүүлбэл зохих урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын чиглэлийг тогтоох зорилготой.

Хүүхдийн шударга байдлын түвшин 2019 оны судалгаагаар 3.91<sup>4</sup> гэсэн дүнтэй гарсан нь өмнөх судалгааны түвшинд гарсан байна.

Хүүхдийн шударга байдлын түвшин, оноор



Судалгааны дүнгээс харахад хүүхдийн шударга байдлын түвшин нас ахин, анги дэвших тутам буурч байгаагаас гадна эрэгтэй хүүхдийн шударга байдлын түвшин эмэгтэй хүүхдийнхээс зөрүүтэй байна. Мөн нийслэлийн хүүхдүүдийн шударга байдлын түвшин орон нутгийн хүүхдийнхээс доогуур байдаг хандлага мөн энэ удаагийн судалгаанд илрэв. Хүүхдийг шударга байх талаар ярилцах, шударга хандсаных нь төлөө магтаж сайшаах, шударга бус зүйл хийвэл зэмлэх, шударга ёсны талаар зааж сургах, анхаарал, халамжтай байх явдал хүүхдийн төлөвшилд эерэгээр нөлөөлдөг нь судалгааны үр дүнгээс харагдаж байна. Эдгээр хандлага сүүлийн хэдэн жил хадгалагдаж байгаа нь анхаарал татаж байна. Иймд, хүүхдүүдэд ёс зүй, ёс суртахууны зөв төлөвшил олгоход боловсролын байгууллагаас гадна гэр бүл, хэвлэл мэдээллийн байгууллагын оролцоо чухал байна.

4 Хүүхдийн шударга байдлын түвшин болон дэд үзүүлэлтийг 1-5 хүртэлх оноогоор үнэлсэн бөгөөд уг үзүүлэлтийн утга 1-д ойртох тусам шударга бус, 5-д ойртох тусам шударга гэж ойлгоно.




## ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН АВЛИГЫН ТАЛААРХ ОЙЛГОЛТ ХАНДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГАА

Авлигатай тэмцэх газраас 2019 онд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн авлигын талаарх ойлголт хандлагыг тодорхойлох судалгаа”-г төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулав. Судалгаанд Улаанбаатар хотод амьдарч байгаа 18-аас дээш настай хөдөлгөөний бэрхшээлтэй 116, харааны бэрхшээлтэй 71, сонсголын болон хэл ярианы бэрхшээлтэй 77, бусад бэрхшээлтэй 34 иргэн, мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй эцэг эх, асран хамгаалагч 57 иргэнийг буюу нийт 355 иргэнийг хамруулан зохион байгууллаа.


Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд авлига хамгийн түгээмэл тохиолддог салбар нь тоон болон чанарын судалгааны үр дүнгүүдээр нэгдүгээрт, эрүүл мэндийн салбар, хоёрдугаарт, боловсролын салбар, гуравдугаарт, нийгмийн халамж, үйлчилгээний салбар, дөрөвдүгээрт, цагдаа, шүүхийн салбар гэж үзжээ.

Авлигад хамгийн өртөмтгий салбар, дунд эзлэх хувиар




Сүүлийн 12 сарын хугацаанд хахууль өгсөн эсэхэд судалгаанд оролцогчдын 67.3% нь үгүй гэж хариулжээ. Харин 21.8% нь хахууль өгсөн гэж хариулсан байна. Хээл хахууль өгсөн гэж хариулсан оролцогчдын 62.9% нь нэг удаа, 21.4% нь хоёроос гурван удаа, 15.7% нь гурваас дээш удаа өгсөн гэж хариулсан байна.

Сүүлийн 12 сарын хугацаанд хээл хахууль өгсөн эсэх



Судалгаанд оролцогчдоос сүүлийн 12 сарын хугацаанд хахууль өгсөн гэж хариулсан иргэд эмч нарт 51.4%, багш нарт 12.9% нь хээл хахууль өгсөн гэж хариулсан байдлаас харахад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд хамгийн их харилцаагч буюу харилцаа хэрэгцээ тулгардаг албан хаагчид нь эрүүл мэнд, боловсролын салбарын ажилтнууд болох нь харагдаж байна.

## Хэнд хээл хахууль өгсөн бэ?



Сүүлийн 12 сарын хугацаанд хээл хахууль өгсөн эсэх гэсэн асуултад “Тийм” гэж хариулсан оролцогчдоос хээл хахууль өгсөн шалтгааныг тодруулбал, 40% нь “дүрэм, журам, шат дамжлагыг тойрохын тулд” хэмээн хариулжээ.

## Хээл хахууль өгсөн шалтгаан



Нийгмийн эмзэг бүлэг болох хөгжлийн бэрхшээлтэй иргэд төрийн үйлчилгээг авахдаа шударга бус байдалтай нүүр тулсаар байгаа нь судалгааны мэдээллээс харагдаж байна. Тэд шударга бус байдалтай тулгарсан ч тэмцэх чадвар бусад иргэдтэй харьцуулахад хязгаарлагдмал юм. Иймд, төрийн үйлчилгээний хүртээмж, нээлтэй, ил тод байдлыг нэмэгдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тулгардаг бэрхшээлүүдийн талаар нийгэмд зөв ойлголт түгээх, улмаар тэдэнтэй харилцах хандлагад эерэг байдлыг хэвшүүлэхэд анхаарах шаардлагатай гэж судлаачид үзжээ.

## АВЛИГЫН ТӨСӨӨЛЛИЙН ИНДЕКС



Берлинд төвтэй Транспэрэнси Интернэшнл олон улсын төрийн бус байгууллагаас дэлхийн 180 орны төрийн албан дахь авлигын талаар шинжээч, бизнес эрхлэгчдийн төсөөлөлд үндэслэн Авлигын төсөөллийн индексийн 2019 оны дүнг гаргасан байна.

Энэхүү индекс нь нэгдмэл аргачлал бүхий бие даасан судалгаа биш бөгөөд харин АНУ, ХБНГУ, Их Британи, Швейцар, ХонКонгод байрлан үйл ажиллагаа явуулдаг 13 байгууллагын судалгаа, үнэлгээнээс авлига болон түүнд холбогдох хэсгийн үзүүлэлтийг сонгон авч, тодорхой аргачлалаар индексийг тооцон, улс орнуудыг эрэмбэлдэг аж.

Индексийн дүнгээр Монгол Улс 2019 онд 35 оноо авч, 180 орноос 106-р байрт оржээ. Манай улсын индексийг тооцоход нийт 9 эх сурвалжийг ашигласан байна. Үүнээс АНУ-



ын “Пи Ар Эс” группээс гаргадаг Эрсдэлийн үнэлгээний холбогдох хэсэг 3 оноогоор нэмэгдсэн бол Швейцарын “Ай Эм Ди” Бизнесийн сургуулийн Дэлхийн өрсөлдөх чадварын эмхэтгэлийн Үзэл бодлын судалгаа, Ардчиллын олон талт байдлын төсөл, Дэлхийн эдийн засгийн форумын Үзэл бодлын судалгаа, Германд төвтэй Бертелсманы сангийн Шилжилтийн индекс, Дэлхийн банкны Улс орны бодлого, институцийн үнэлгээний холбогдох хэсгийн үнэлгээ тус бүр 2-8 оноогоор буурсан дүнтэй байна.

### Монгол Улсын Авлигын төсөөллийн индекс, үнэлгээнд ашигласан эх сурвалж, оноор

Д/д	Байгууллага-судалгаа	2016	2017	2018	2019	19/20
1.	“Пи Ар Эс” групп – Эрсдэлийн үнэлгээ 2019	32	32	32	35	3↑
2.	“Дэлхийн эрх зүйн төсөл” – Хууль дээдлэх ёсны индекс 2019	38	36	36	36	→
3.	“Экономист группийн мэдээллийн нэгж” – Эрсдэлийн үнэлгээ 2019	37	37	37	37	→
4.	“Глобал инсайт” – Улс орны эрсдэлийн түвшин 2018	47	35	47	47	→
5.	“Ай Эм Ди” – Үзэл бодлын судалгаа 2019	35	33	30	28	2↓
6.	“Ардчиллын олон талт байдлын төсөл” – /V-Dem/ 2019	34	35	33	31	2↓
7.	“Дэлхийн эдийн засгийн форум” – Үзэл бодлын судалгаа 2019	38	30	31	28	3↓
8.	“Бертелсман” сан – Шилжилтийн индекс 2020	36	41	41	37	4↓
9.	“Дэлхийн банк” – Улс орны бодлого, институцийн үнэлгээ 2018	47	43	43	35	8↓
<b>Дундаж оноо</b>		<b>38</b>	<b>36</b>	<b>37</b>	<b>35</b>	<b>2↓</b>

Харин Дэлхийн эрх зүйн төслийн Хууль дээдлэх ёсны индекс, Экономист группийн мэдээллийн нэгжийн Улс орнуудын эрсдэлийн үнэлгээ, «Глобал инсайт» байгууллагын Улс орнуудын эрсдэлийн түвшний үнэлгээний оноо өмнөх оныхоос өөрчлөгдөөгүй байна.


Эх сурвалж: Транспэрэнси Интернэшнл, <https://www.transparency.org>

## АВЛИГЫН ХЯНАЛТЫН ҮЗҮҮЛЭЛТ

Дэлхийн банкны Дэлхийн Засаглалын үзүүлэлт (WGI)<sup>5</sup> төслөөс 200 гаруй улс орны засаглалын түвшинг 1996 оноос хойш хэмжиж байна. Ийнхүү хэмжихдээ 30 гаруй судалгааны институци, төрийн бус байгууллага, олон улсын байгууллагын судалгааны мэдээлэлд үндэслэн нэгдсэн зургаан шалгуур үзүүлэлтээр засаглалыг үнэлж байна.

Засаглалын зургаан шалгуур үзүүлэлтийн нэг болох Авлигын хяналтын үзүүлэлтээр Монгол Улс 2018 онд **-0.43**<sup>6</sup> үнэлгээтэй байгаа нь өмнөх оныхоос 0.02 пунктээр өссөн эерэг үзүүлэлт болж байна.

Авлигын хяналт, Монгол Улс 1996-2018



Эх сурвалж: Дэлхийн банкны Засаглалын үзүүлэлт, <http://info.worldbank.org/governance/wgi/>

<sup>5</sup> The Worldwide Governance Indicators (WGI) project

<sup>6</sup> Засаглалыг -2.5 (сул)-аас +2.5 (хүчтэй)-ын хооронд хэмжиж байна.

## “TRACE” ХЭЭЛ ХАХУУЛИЙН ЭРСДЭЛИЙН МАТРИЦЫН ҮНЭЛГЭЭ

“Trace” олон улсын байгууллагаас 2019 оны Хээл хахуулийн эрсдэлийн матрицын дүнг танилцуулав. Уг матриц нь 200 улс орон дахь бизнесийн хээл хахуулийн эрсдэлийг хэмждэг.

Энэ оны дүнгээр Монгол Улс 55<sup>8</sup> оноо авч, дэлхийн 200 улс орон 109 дүгээр байрт орсон байна. Өмнө оны дүнтэй харьцуулахад эрсдэлийн оноо 3-аар нэмэгдэж, байр 11-ээр ухарсан үзүүлэлттэй байна<sup>9</sup>.

Монгол Улсын хувьд эрсдэлийн оноо тооцоход ашигласан дөрвөн хүрээний 1 дэх хүрээ буюу “Бизнесийн хүрээ төртэй харилцах харилцаа” гэсэн бүлэг үзүүлэлтэд харьцангуй эрсдэл өндөртэй гарсан байна.

### Хээл хахуулийн эрсдэлийн матрицын үнэлгээ, Монгол Улс, 2014-2019 он

Он	Монгол Улсын байр/нийт улс	Монгол Улсын оноо	Үүнээс:			
			Хүрээ 1: Бизнесийн хүрээ төртэй харилцах харилцаа	Хүрээ 2: Хээл хахуулийн эсрэг хяналт, хууль сахиулах байдал	Хүрээ 3: Төрийн алба, төрийн үйлчилгээний ил тод байдал	Хүрээ 4: Хяналт тавих иргэний нийгмийн чадавх
2014	156/197	72	80	29	48	45
2016	137/199	68	76	29	45	44
2017	122/200	52	61	37	57	36
2018	98/200	52	65	42	56	33
2019	109/200	55	72	42	54	35

Эх сурвалж: “Trace” олон улсын байгууллага, [www.TRACEinternational.org/trace-matrix](http://www.TRACEinternational.org/trace-matrix)

7 [www.TRACEinternational.org/trace-matrix](http://www.TRACEinternational.org/trace-matrix)

8 0-100 оноо өгдөг, 0 оноо бол эрсдэл багатай, 100 оноо бол эрсдэл өндөртэй гэж үзнэ.

9 Тус байгууллагаас уг үзүүлэлтийн дүнг оноор харьцуулахыг зөвлөмж болгодоггүй. Учир нь аргачлал өөрчлөгддөг, мөн уг үзүүлэлт нь зөвхөн тухайн үеийн нөхцөл байдлыг харуулдаг гэжээ.

# ГУРАВДУГААР БҮЛЭГ

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр,  
Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга  
хэмжээний төлөвлөгөөний  
хэрэгжилт (I үе шат)





## АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР, ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ (I ҮЕ ШАТ)

**Нэг. Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх зорилтыг хангах чиглэлээр**

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 1 дүгээр зорилтын хүрээнд нийт 10 үйл ажиллагаа, 26 арга хэмжээ тусгагдсан. Зорилтын хүрээнд төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг тоймлон танилцуулбал:

4.1.1.1-1.Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох /АТГ, ТАЗ, 2017-2022/

Авлигатай тэмцэх газраас нийтийн албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн этгээд тухайн албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх, үүсч болзошгүй, ашиг сонирхлын зөрчил бүхий нөхцөл байдал тогтоогдсон эсэх талаарх дүгнэлтийг нэр дэвшигч тус бүрээр сар бүрийн 25-ны өдөр зохион байгуулдаг хэвлэлийн хурал, мэдээллийн хуудсаар олон нийтэд хүргэж хэвшсэн бөгөөд 2017 онд 11143, 2018 онд 10461, 2019 онд 8682 Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлтийг мэдээлсэн байна. ХАСУМ-ийг хянасан дүгнэлтийг цахимаар ил тод, нээлттэй болгохоор ажиллаж байна. Төрийн байгууллагуудаас Барилга, хот байгуулалтын яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Дундговь аймаг, Эрчим хүчний зохицуулах хороо, Сүхбаатар, Дархан-Уул, Орхон, Хэнтий, Сэлэнгэ аймаг, Иргэний нисэхийн ерөнхий газар, Цаг уур,

орчны шинжилгээний газар, Стандарт, хэмжил зүйн газар, Оюуны Өмчийн газар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь байгууллагынхаа цахим хуудсаар Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, ХАСУМ-ийг хянасан дүгнэлтийг олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлэх ажлыг хэвшүүлжээ.

Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-т “Төрийн албаны сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий байгууллага албан тушаалтан олон нийтэд мэдээлэх, шалгалтын үйл явцыг иргэд, олон нийт хөндлөгөөс ажиглах боломжийг олгох зорилгоор шалгалт авч буй танхимын гадна лед дэлгэц байршуулан, тухайн шалгалтын үйл явцыг иргэд, олон нийтэд ил тод мэдээлж байна. Тухайлбал, 2019 онд төрийн албаны ерөнхий шалгалтыг авах үеэр шалгалт авч байгаа танхимын гаднах 10 дэлгэцээр шалгалтын үйл явцыг мэдээллээ. Төрийн албаны зөвлөл төрийн жинхэнэ албаны удирдах ба гүйцэтгэх албан тушаалын сонгон шалгаруулалтын 85 сул орон тоог Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар мэдээлж, 37 удаа сонгон шалгаруулалт явуулж, 36 сул орон тоог нөхсөн бөгөөд шалгалт авах тухай бүрд шалгалтын явцыг иргэд, олон нийтэд лед дэлгэцээр харуулж байсан болно.

Төрийн албаны зөвлөл холбогдох дүгнэлтийг цахим хуудас дахь “Төрийн албаны зөвлөлийн хуралдааны тойм” хэсгээр дамжуулан ил тод болгож байгаа боловч Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлтийг олон нийтэд ойлгомжтой байдлаар мэдээлэх ажлыг цогц байдлаар зохион байгуулах ажилд ахиц гараагүй байна. (Биелэлт 70 хувь)

4.1.1.1-2. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг гаргах, хянах үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх / АТГ, 2017-2019/

Авлигатай тэмцэх газраас УИХ-ын Хууль зүйн Байнгын хорооны 2017 оны 01 дүгээр сарын



03-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хянах, хадгалах журам батлах тухай” 2012 оны 05 дугаар тогтоолд нэмэлт оруулж, 7 дугаар хавсралтын “Б” хэсэгт “нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн ХАСУМ-ийг цахим хэлбэрээр мэдүүлсэн тухай” БАТАЛГААНЫ МАЯГТ-ыг батлуулан ашиглаж байна. ХАСУМ-ийг гаргах, хянах үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг 2017 онд эхлүүлэн системийн хөгжүүлэлтийг 2018 онд дуусгаж, 2019 оноос туршилтын журмаар Улсын бүртгэлийн ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар, Сэлэнгэ аймгийн ЗДТГ-тай цахим системээр холбогдон хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлж эхэлсэн. 2019 оны байдлаар Сангийн яам, Эрчим хүчний яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Цагдаагийн ерөнхий газар, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, Харилцаа холбооны зохицуулах хороо, Гаалийн ерөнхий газар, Улсын Ерөнхий прокурорын газар, Үндэсний аудитын газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Улаанбаатар төмөр зам ХНН, Увс, Завхан, Өвөрхангай, Төв, Баян-Өлгий, Баянхонгор зэрэг нийт 41 яам, агентлаг, аймаг, орон нутгийн төрийн захиргааны болон төрийн өмчит компаниуд цахим системд холбогдож ХАСУМ-ийг бүртгэх, хянах үйл ажиллагааг цахимаар хянах боломжтой болсон байна. 2020 онд бүх байгууллага, салбар нэгжүүдийн ХАСУМ-ийн бүртгэл, хяналтыг бүрэн цахимжуулж, гарсан дүгнэлтийг мэдээллийн сангаас электрон хэлбэрээр үзэх, олон нийтэд ил тод, нээлттэй болгох боломж нөхцөлийг бүрдүүлэхээр ажиллаж байна. (Биелэлт 70 хувь)

4.1.1.1-3. ХАСУМ-д хавсаргаж ирүүлэх баримт бичгийн жагсаалтад Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлтийг оруулах /АТГ, ТАЗ, 2017-2019/

Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга(цаашид “Төрийн албаны тухай хууль” гэх)-ын 33 дугаар зүйлийн 33.12-т Төрийн албаны зөвлөл Төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалт (тухайн албан тушаалын) өгөх болзол, журам, Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх журмуудыг батлахаар заасны дагуу Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 17 дугаар тогтоолоор холбогдох журмуудыг батлан

мөрдүүлж байна. Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7.6-д “Нэр дэвшигчийг томилохоос өмнө Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23.5-д заасан мэдүүлгийг авсан байна.” гэж тусган хэрэгжүүлж, хяналт тавин ажиллаж байна.(Биелэлт 100 хувь)

4.1.1.1-4. Төрийн албаны зөвлөл болон салбар зөвлөлийн дүгнэлт, ХАСУМ хянуулалгүйгээр томилгоо хийсэн албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгох /АТГ, ТАЗ, 2017-2019/

Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөр хэрэгжсэнтэй холбогдуулан Авлигатай тэмцэх газраас багийн зохион байгуулалтаар ажиллан 2017-2019 онд яам, агентлаг, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, нийслэл, дүүрэг, 21 аймаг, зарим сумдад ажиллаж хуулийн хэрэгжилт болон төрийн албан дахь хүний нөөцийн томилгоонд хяналт тавин ажилласан нь үр дүнгээ өгсөн. Тухайлбал, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн ХАСУМ-ийг тухайн албан тушаалд томилсны дараа хянуулахаар ирүүлсэн тоо 2017 онд 844 байсан бол 2018 онд 211, 2019 онд орон нутгийн төрийн байгууллагуудад 40 болж буурсан үзүүлэлттэй гарсан.

Авлигатай тэмцэх газрын ажлын баг дээрх нэгжид ажиллах явцдаа албан тушаалын томилгоотой холбоотой асуудлыг нарийвчлан судалж, нөхцөл байдлыг тогтоон Төрийн албаны зөвлөл болон салбар зөвлөлийн дүгнэлт, ХАСУМ-ийг хянуулалгүйгээр томилгоо хийсэн албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгох чиглэлээр санал, дүгнэлт боловсруулан Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар байгуулагдсан Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг шинэчлэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсэгт хүргүүлсэн.

Үндэсний хөтөлбөрт тусгагдсаны дагуу ХАСУМ хянуулалгүйгээр томилгоо хийсэн албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгох зорилтыг хэрэгжүүлж байхад Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг

батлахдаа Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд стратегитэй уялдахгүй агуулга бүхий нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Өөрөөр хэлбэл, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7 дахь хэсгийг өөрчлөн, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн ХАСУМ-ийг Авлигатай тэмцэх газар хянаад илт ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдлыг тогтоож, хариу хүргүүлсэн байхад тухайн байгууллагын удирдлага нь нэр дэвшүүлсэн этгээдийг дур мэдэн томилох, ашиг сонирхлын зөрчилтэй нөхцөл байдалд албан үүрэг гүйцэтгүүлэх эрсдлийг бий болгож байна. Энэхүү нэмэлт, өөрчлөлтийн үр дагаврын талаар УИХ-ын Хууль зүйн байнгын хороонд саналаа хүргүүлсэн боловч шийдвэрлээгүй байна.

Гэсэн хэдий ч дээрх хуулийн 23 дугаар зүйлийн 23.7-д заасныг зөрчиж илтэд ашиг сонирхлын зөрчилтэй этгээдийг албан тушаалд томилсон, хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг худал мэдүүлсэн бол хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.2-т заасан хариуцлага хүлээлгэх, энэхүү зөрчлийг удаа дараа гаргасан бол албан тушаалыг нь бууруулах буюу сахилгын шийтгэл ногдуулах хуулийн зохицуулалт хэвээр үйлчилж байгаа нь хуулийг шударга ёсны дагуу ашиг сонирхлын зөрчлөөс ангид хэрэгжүүлэх боломж байгааг илтгэж байна.

Төрийн албаны зөвлөлөөс 2018 оныг “Хуулийн хэрэгжилт, хариуцлага, үр дүнгийн жил” болгон зарлан төв, орон нутгийн төрийн байгууллагын удирдах ажилтны томилгоонд хяналт шалгалт хийж, зөрчлийг арилгуулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, үр дүнг хуралдаанаараа хэлэлцээд зөрчлийг арилгуулах талаар томилох эрх бүхий албан тушаалтанд хугацаатай үүрэг өгснөөр хууль зөрчиж томилсон, мөн сонгон шалгаруулалтад тэнцээгүй удирдах албан тушаалтныг чөлөөлж, түр орлон гүйцэтгэгчдийг хуульд нийцүүлэн томилсон шийдвэр гаргажээ. Мөн байгууллагууд хууль бус томилгоотой байсан албан тушаалтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалт явуулах захиалгаа Төрийн албаны зөвлөлд ирүүлж байна. Төрийн албаны тухай хуулийн 30 дугаар зүйлээр хууль бус шийдвэрийг Төрийн албаны

зөвлөл хүчингүй болгож төрд учирсан хохирлыг төрийн нэрийн өмнөөс шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг олгосон.

Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6-д заасны дагуу Төрийн албан тушаалд тавих тусгай шаардлагад Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг (ХАСХОМ) гаргадаг албан тушаалд сонгогдсон буюу томилогдсон этгээд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4-т заасан арга хэмжээг авахаар хуульчилсан.

Төрийн албаны зөвлөлийн тогтоолоор нэр дэвшүүлсэн нэр бүхий иргэдийг мөн хуулиудад заасан шаардлагыг баримтлан төрийн жинхэнэ албаны шалгалтаар хамгийн өндөр оноо авсан иргэнийг тухайн албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлэн, томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн албан бичигт Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан шаардлагыг хангасан эсэх тухай баримт бичгийг Авлигатай тэмцэх газар томилох эрх бүхий байгууллагаас албан ёсоор авахуулж, нэр дэвшигчийг томилсон шийдвэрийн хамт Төрийн албаны зөвлөлд ирүүлж байгаа болно. Цаашид нөөцөд байгаа иргэн авлига, албан тушаалын гэмт хэрэгт холбогдсон эсэх, нэр дэвшигчийн их, дээд сургуульд төгссөн дипломын хүчинтэй эсэх, эрүүл мэндийн магадлан итгэмжлэгдсэн эмнэлгийн дүгнэлт, улс төрийн намын гишүүн бол Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1-д заасны дагуу намын гишүүнчлэлээсээ түтгэлзсэн тухай баримт бичиг зэргийг албан ёсоор гаргуулан нэр дэвшигчийг томилсон шийдвэрийн хамт Төрийн албаны зөвлөлд ирүүлж байхаар журамласан болно. (Биелэлт 100 хувь)

4.1.1.1-5. Төрийн захиргааны төв байгууллагын хүний нөөцийн жагсаалт, төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн албан хаагчийн нөөцийн бүртгэлийг ил тод, нээлттэй болгох /ТАЗ, 2017-2019/



Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлд төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөхтэй холбоотой зохицуулалтыг тусгасан ба хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасны дагуу Засгийн газрын 2019 оны 74 дүгээр тогтоолоор “Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх, мэдээлэл авах журам”-ыг баталсан. Уг журамд төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлийн мэдээллийн сантай байх, уг сан нь төрийн албан тушаал эрхэлж байгаа төрийн албан хаагчийн мэдээлэл, төрийн албан тушаал эрхэлж байсан иргэний мэдээлэл, төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний удирдах ажилтны нөөцөд байгаа иргэний мэдээлэл, төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлд хамаарах албан тушаал эрхэлж байсан, удирдах албан тушаалтны нөөцөд бүртгэгдсэн төрийн албан хаагч, иргэний тухай мэдээллээс бүрдэхээр тусгажээ. Мөн тоо бүртгэлийн мэдээллийн санг бүрдүүлэхдээ төрийн албаны “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системийг ашиглахаар тусгасан байна.

Төрийн албаны хүний нөөцийн нэгдсэн системийг боловсронгуй болгох ажлыг хийж байна. Уг системд төрийн тусгай албан хаагч буюу цэрэг, цагдаа, прокурор, шүүх, тагнуулын байгууллагуудын албан хаагчдын мэдээллийг нэгтгэхээр холбогдох хууль тогтоомжийг судалж байна. Төрийн албаны зөвлөлийн хүний нөөцийн системд бүртгэгдсэн албан хаагчдын мэдээлэлд үндэслэн төрийн албан хаагчийн цалин бодогдохоос гадна төрийн албан хаагчдын нарийвчилсан статистик мэдээ гарч, төрийн жинхэнэ албан тушаалд шатлан дэвшүүлэх буюу мерит зарчмыг хэрэгжүүлэх бодитой нөхцөл бүрдэх давхар ач холбогдолтой юм.

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 359 дүгээр тогтоолоор 2019 онд зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны ерөнхий шалгалтад тэнцэж, төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэгдсэн 1116 иргэн байгаа ба тэдгээр иргэдийн мэдээллийг цахим хуудсанд нээлттэй байршуулсан байна. (Биелэлт 70 хувь)

4.1.1.2-1. Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн төрийн албанд томилох, дэвшүүлэх тогтолцоог бүрдүүлэх /ЗГХЭГ, ТАЗ, 2017-2022/

Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлд төрийн жинхэнэ албан тушаалд тавих нийтлэг шаардлага, мөн хуулийн 23 дугаар зүйлд төрийн албан тушаалд тавих тусгай шаардлагыг тус тус хуульчилсан. Тухайлбал, төрийн төрийн захиргааны албан тушаалын тэргүүн, эрхэлсэн, ахлах түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалд томилогдох иргэний хувьд төрийн албанд ажилласан жил, тухайн ангилалд ажилласан жилийг зааж, мэргэшүүлэх багц цагийн сургалтад хамрагдаж, төгссөн байхаар тусгасан нь туршлага, ур чадварыг үндэслэн шатлан дэвшүүлэх нөхцөлийг бүрдүүлж, мөн хуулийн 26 дугаар зүйлд төрийн захиргааны албан тушаалд томилох үндсэн шалгуурыг тодорхойлон хуульчилсан. Төрийн албан тушаалд тавих нийтлэг болон тусгай шаардлагыг хангасан төрийн албан хаагчийг үйл ажиллагааны ажлын үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээ, ёс зүй, мэдлэг, мэргэжил, туршлага, ур чадварыг харгалзан хугацаанаас өмнө шатлан дэвшүүлж байх, тухайн байгууллагын чиг үүрэгт хууль тогтоомжоор өөрчлөлт орсноос бусад тохиолдолд төрийн албан тушаалд тавих тусгай шаардлага болон албан тушаалтын тодорхойлолтод өөрчлөлт оруулахыг тус тус хориглосон зохицуулалтыг хийсэн болно.

Энэ хүрээнд Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 2 дугаар тогтоолоор “Төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалд тавигдах тусгай шаардлага”, мөн оны 3 дугаар тогтоолоор “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”, мөн оны 16 дугаар тогтоолоор “Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журам”-ыг тус тус батлан хэрэгжүүлж байна. (Биелэлт 100 хувь)

4.1.1.2-2. Мерит зарчмыг хэрэгжүүлэх зорилгоор эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох /ЗГХЭГ, ТАЗ, 2017-2019/

Төрийн албаны тухай хуульд иргэнийг төрийн албанд сонгон шалгаруулж томилох, чөлөөлөх,

ажлын гүйцэтгэлийг нь үнэлэх, дэвшүүлэх, шагнаж урамшуулах асуудлыг шийдвэрлэхдээ хувь хүний мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага, ажлын үр дүнд тулгуурлах талаар тусгасан ба төрийн жинхэнэ албан тушаалд иргэнийг томилохдоо гагцхүү чадахуйн зарчмыг баримтлахаар тусгасан.

Тус хуульд нийцүүлэн Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 2 дугаар тогтоолоор “Төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалд тавигдах тусгай шаардлага”, мөн оны 3 дугаар тогтоолоор “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”, мөн оны 5 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”, мөн оны 14 дүгээр тогтоолоор “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол журам”, мөн оны 15 дугаар тогтоолоор “Төрийн албаны ерөнхий шалгалт өгөх болзол, журам”, мөн оны 16 дугаар тогтоолоор “Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журам”, мөн оны 17 дугаар тогтоолоор “Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх журам”, мөн оны 25 дугаар тогтоолоор “Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах журам”-ыг тус тус батлан мөрдүүлж байна. Мөн Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор “Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”, Засгийн газрын 2019 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 74 дүгээр тогтоолоор “Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх, мэдээлэл авах журам” зэргийг батлав.

Дээрх дүрэм, журмуудыг батлан мөрдүүлснээр төрийн албаны томилгоо мерит буюу чадахуйн зарчмыг хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалт бүрдсэн болно. (Биелэлт 100 хувь)

#### 4.1.1.2-3. Төрийн албаны сонгон шалгаруулалтыг олон улсын стандартад нийцүүлэх /ТАЗ, 2017-2019/

Төрийн албаны зөвлөл, салбар зөвлөлүүд төрийн жинхэнэ албанд анх орох иргэний сонгон шалгаруулах шалгалтын сорилын буюу тестийн шалгалтыг цахим хэлбэрээр авч хэвшүүлсэн бөгөөд төрийн албаны тусгай буюу албан тушаалын шалгалтыг онлайн, цахим хэлбэрт шилжүүлэх зорилт тавин бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Энэ хүрээнд Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлүүдийг

шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, хүний нөөцийг чадавхижуулах шаардлагатай байгаа болно.

2019 онд төрийн жинхэнэ албаны ерөнхий шалгалтын бүртгэлийг анх удаа онлайнээр зохион байгуулж, шалгалтыг цахимаар авсан нь ахиц дэвшил гарсан, шинэлэг ажил болжээ. (Биелэлт 70 хувь)

#### 4.1.1.2-4. Шалгалтын тестийн агуулгыг сайжруулах /ТАЗ, 2017-2019/

Төрийн албаны сонгон шалгаруулалтыг боловсронгуй болгохтой холбогдуулан хийж буй зарчмын нэг өөрчлөлт нь төрийн албаны шалгалтын агуулгад хийж буй шинэтгэл юм.

Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.6-д зааснаар төрийн жинхэнэ албаны шалгалтын агуулгыг удирдан зохион байгуулах, дүн шинжилгээ хийх, асуудал шийдвэрлэх, манлайлах, монгол хэлний ярианы болон бичгийн, багаар ажиллах (бусад) зэрэг чадварыг шалгахаар зохицуулсан.

Өмнө нь төрийн албаны шалгалтын агуулгад хууль, эрх зүйн мэдлэг зонхилсон, монгол хэл, мэдээллийн технологийн мэдлэг багтдаг байсан бол 2019 оноос Монгол Улсын түүх, нийгэм, эдийн засаг, соёлын мэдлэгийн зэрэгцээ Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.6-д заасан дээр дурдсан чадвартай холбогдох сорил, даалгавар нэмэгдэж, агуулгын хүрээ өргөжсөн.

Шалгалтын агуулгыг шинэчлэх ажлын хүрээнд Төрийн албаны зөвлөл, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран хэрэгжүүлж буй “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төслийн санхүүжилтээр “Асуудал шийдвэрлэх чадварыг тогтоох”, “Дүн шинжилгээ хийх чадварыг тогтоох”, “Багаар ажиллах чадварыг тогтоох”, “Удирдан зохион байгуулах чадварыг тогтоох”, “Манлайлах чадварыг тогтоох” шалгалтын сан боловсруулах ажлыг зохион байгуулав. Шалгалтын сан боловсруулахтай холбоотой асуудлаар мэргэшсэн эрдэмтэн, судлаачдын багаас зөвлөх үйлчилгээ авч ажилласан ба чадвар тус бүрээр авах шалгалтын 500, нийт 2500 тест, асуулт, бодлогын даалгавар, эссэний сэдэв бүхий сорил, даалгаврыг боловсруулсан. Мөн 2019 онд өмнө нь хэвлэгдэн гарч байсан гарын авлагаас хүчингүй



болсон, нэмэлт, өөрчлөлт орсон хуулиудын сорилыг хасч, Төрийн албаны тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль, хүний эрхтэй холбоотой хууль тогтоомж, Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, “Монгол Улсын Ерөнхийлөгчийн мөрийн хөтөлбөрийг зорилт”-ыг багтаасан нийт 1552 сорилыг шинээр боловсруулж, “Төрийн албаны мэргэшлийн шалгалт, сонгон шалгаруулалтад бэлтгэх гарын авлага”-ыг баяжуулан хэвлэж, нийтийн хэрэглээнд гаргав. (Биелэлт 100 хувь)

4.1.1.2-5. Төрийн захиргааны албан хаагчийн сэлгэн ажиллуулах журмыг шинэчлэн батлуулах /ЗГХЭГ, ТАЗ, 2017-2019/

Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5-д төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журмыг төрийн албаны төв байгууллага, Засгийн газар хамтран батлахаар хуульчилсан бөгөөд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн 34/31 дүгээр хамтарсан тушаалаар “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-ыг батлан мөрдүүлж байна. (Биелэлт 100 хувь)

4.1.1.2-6. Төрийн албан хаагчийн ажлын байрны тодорхойлолтод тавигдах нийтлэг шаардлагыг батлах, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох /ЗГХЭГ, ТАЗ, 2017-2019/

Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-т “Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалд тавигдах тусгай шаардлага болон албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журмыг төрийн албаны төв байгууллага батална.” гэж заасны дагуу Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 3 дугаар тогтоолоор “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”, “Албан тушаалын тодорхойлолтын маягт”, “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах мэдээлэл цуглуулах асуулгын хуудас”, “Хяналтын хуудас”-ыг тус тус баталсан. Төрийн захиргааны албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтыг дээрх журамд

нийцүүлэн боловсруулж, төрийн албаны төв байгууллагын зөвшөөрлийг үндэслэн тухайн албан хаагчийг томилох эрх бүхий этгээд албан тушаал бүрээр батлах, тухайн байгууллагын чиг үүрэгт хууль тогтоомжоор өөрчлөлт орсноос бусад тохиолдол албан тушаалын тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулахгүй байхаар хуульчилсан. (Биелэлт 100 хувь)

4.1.1.3-1. Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэх, дүгнэх, хариуцлага тооцох асуудлыг судлан, гүйцэтгэлийн үнэлгээний холбогдох зохицуулалтыг бий болгох /ЗГХЭГ, ТАЗ, 2017-2019/

Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.2-т “Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үр дүн, мэргэшлийн түвшинг эрх бүхий байгууллагаас тогтоосон хугацаанд зохих журмын дагуу үнэлж, дүгнэх талаар тусгасан ба “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх, тэдгээртэй холбогдуулан төрийн албан хаагчийг албан тушаал дэвшүүлэх, цалин хөлсийг өөрчлөх, урамшуулал олгох, хариуцлага хүлээлгэх журам”-ыг Засгийн газар батлахаар хуульчилсны дагуу Засгийн газрын 2019 оны 37 дугаар тогтоолоор “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”, мөн оны 38 дугаар тогтоолоор “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2019 оны 47 дугаар тушаалаар стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлалыг тус тус батлан хэрэгжүүлж, уг асуудлаар бүх шатны төрийн байгууллагад чиглэл өгч, арга зүйн зөвлөгөөгөөр хангаж байна. (Биелэлт 100 хувь)

4.1.1.4-1. Төрийн жинхэнэ албан хаагчийг төрийн өндөр албан тушаалтан, улс төрийн нөлөөллөөс ангид томилох, чөлөөлөх талаарх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох /ЗГХЭГ, ТАЗ, 2017-2019/

Төрийн албаны тухай хуульд улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч улс төрийн

нам, эвслийн үйл ажиллагаанаас ангид байх, төрийн жинхэнэ албан тушаалд иргэнийг томилохдоо гагцхүү чадахуйн зарчмыг үндсэн шалгуур болгож, түүнийг хамгийн сайн хангасан хүнийг томилох, төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд шатлан дэвших /мерит/ зарчмын дагуу төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас, эсхүл удирдах албан тушаалтны нөөцөд байгаа иргэдээс томилохоор тус тус зохицуулсан. Мэдлэг, ур чадвар, туршлагад суурилсан, улс төрөөс хараат бус төрийн албыг бэхжүүлэхтэй холбогдсон зарчмын нэг бол Төрийн албаны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2-т “Энэ хуульд заасан журмын дагуу төрийн албан хаагчийн сонгон шалгаруулж томилоход Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, гишүүн, Ерөнхий сайд, төсвийн ерөнхийлөн захирагч, улс төрийн албаны тушаалтан, улс төрийн нам, эвслийн удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан, бусад этгээдийн зүгээс аливаа хэлбэрээр нөлөөлөх, дарамт, шахалт үзүүлэхийг хориглоно.” гэж заасан явдал юм. Энэ тохиолдол буюу хуулийн 32 дугаар зүйлийн 32.6-д заасныг зөрчсөн тохиолдолд улс төрийн албан тушаалтныг огцруулах үндэслэл болохоор хуульчилсан.

Мөн төрийн захиргааны албан тушаалд тавих тусгай шаардлагыг хуульчилж, томилох эрх бүхий албан тушаалтан төрийн албан тушаалын тодорхойлолтыг төрийн албаны төв байгууллагын зөвшөөрлийг үндэслэн баталж, хэн нэгэн хүнд тохируулан дураар өөрчлөх боломжгүй болсон нь төрийн албан хаагчийг томилох, чөлөөлөх ажлыг хүний хүчин зүйлийн нөлөөлөөс ангид явуулах нөхцөлийг бүрдүүлсэн болно. (Биелэлт 100 хувь)

#### 4.1.1.5-1. Авлигын эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлээс хамгаалах арга хэмжээ авах /АТГ, 2017-2022/

Авлигатай тэмцэх газар авлигын шалтгаан, нөхцөлийг судлан тогтоох, арилгах, таслан зогсоох, эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлээс хамгаалах үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулж байна. Авлигын эрсдэлийн үнэлгээний аргачлалыг Авлигатай тэмцэх газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн а/185 дугаар тушаалаар батлуулсан бөгөөд 2019 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн А/40 тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулан

мөрдөж байна(Авлигын эрсдэлийн үнэлгээний аргачлалын холбоос: [https://iaac.mn/files/d8faf0f3-92d8-470f-bb01-c1b0b25490be/atg\\_argachlal\\_2019.pdf](https://iaac.mn/files/d8faf0f3-92d8-470f-bb01-c1b0b25490be/atg_argachlal_2019.pdf)). Аргачлалын дагуу 2018 онд 6 төрийн бус байгууллагаар 24 яам, агентлагт, 2019 онд 5 төрийн бус байгууллагаар 15 байгууллагад авлигын эрсдэлийн үнэлгээг хийлгүүлэн, үр дүн, үнэлгээний тайланг яам, агентлагт танилцуулах ажлыг зохион байгуулав. Үнэлгээнд хамрагдсан байгууллагуудын бүтэц, төсөв санхүү, шийдвэр гаргах явц, ил тод байдал, мэдээллийн хүртээмж, ёс зүйн шударга байдлын түвшин, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тодорхой эрсдэл байна гэж дүгнэсэн.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, авлигын эсрэг хууль тогтоомж, АТГ-аас хүргүүлсэн ЗӨВЛӨМЖ-ийн хэрэгжилттэй газар дээр нь танилцах, арга зүйн зөвлөгөө өгөх, зөвлөн туслах, шалган зааварлах зорилгоор АТГ-ын ажлын баг 2017 онд 21 аймагт 3 удаа, давхардсан тоогоор 144 суманд ажиллаж, үр дүнг орон нутгийн удирдлагад газар дээр нь танилцуулсан. Тухайлбал, 2018 онд цөөн тооны хүчийг оновчтой зохион байгуулан 21 аймаг, 50 суманд, 2019 онд 21 аймгийн төвийн 21 сумдад ажилласан нь хамрагдсан байгууллага, орон нутгийн тоог 2013-2014 онтой харьцуулахад 4 дахин нэмэгдүүлсэн байна. Хэдийгээр төрийн үйлчилгээний хүнд суртлыг багасгах, нээлттэй, ил тод байдлыг хангах, хариуцлагыг дээшлүүлэх, шударга ёсны үнэлэмжийг сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүн гарч байгаа боловч шалгалтын явцад ажлын багаас төрийн байгууллагууд авлига, ашиг сонирхлын зөрчилд өртөх эрсдэлийг бууруулах, дотоод хяналт, санхүүгийн сахилга батыг сайжруулах талаар дорвитой арга хэмжээ аваагүй, төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны нээлттэй байдлыг боломжит түвшинд хангаагүй, мэдээлэгчийг хамгаалах тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр анхаарч ажиллаагүй байна дүгнэлтэд хүрсэн болно. Иймд авлигын түвшинг бууруулах, авлигын эрсдэл үүсгэж буй хүчин зүйл, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, зөрчлийг давтан гаргахгүй байх зорилгоор Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээний байгууллагын удирдах албан тушаалтнууд болон нийслэл, аймаг, орон нутгийн удирдлагад, албан хаагчдад илэрсэн



нөхцөл байдлын талаар танилцуулж, Засгийн газарт “Зөвлөмж” хүргүүлсэн. Мөн Засгийн газрын гишүүдэд салбар бүрийн авлигын нөхцөл байдал талаар тусгайлсан зөвлөмж хүргүүлэн, илэрсэн зарим зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх, эрсдэлээс хамгаалах чиглэлээр хамтран ажиллаж байна.

2018 оны 2, 3 дугаар улиралд яам, агентлагт ажиллах явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах чиглэлээр Засгийн газрын гишүүд, сайд нарт 2018 онд 159, 21 аймагт 10-15 асуудал бүхий, “Боловсролын салбар дахь авлига, түүнээс урьдчилан сэргийлэх арга зам” сэдэвт хэлэлцүүлгийг 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулж, хэлэлцүүлгээс 13 асуудал бүхий, 2019 онд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид 5 асуудал бүхий, авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцаад Эрүүл мэндийн яам, Зам тээвэр, хөгжлийн яам, Эрүүл мэндийн яам, Гадаад харилцааны яаманд тус тус 3-5 асуудал бүхий, 2020 онд зөвлөмжийн хэрэгжилтийн мөрөөр ажиллаад Засгийн газарт 10 асуудал бүхий, 21 аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нарт 7 асуудал бүхий ЗӨВЛӨМЖ-ийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих, биелэлтийг шаардах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээг авч ажилласан бөгөөд жилийн эцсийн байдлаар дүгнэн үзэхэд гүйцэтгэл 81 хувьтай байв.

Авлига гарч болох нөхцөл боломж бүрдүүлсэн, хуулиар тусгай эрх олгоогүй байхад батлан мөрдүүлсэн, хууль тогтоомжид нийцээгүй, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актад тавих шаардлагыг хангаагүй гэж үзсэн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны А/129 дүгээр тушаалаар баталсан “Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам”, Эрчим хүчний сайдын 2012 оны 64 дүгээр тушаал, Эрчим хөгжлийн төвийн захирлын Б/36 дугаар тушаалаар баталсан “Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны үйлчилгээний үнэ тооцох журам”, Газрын тосны газрын даргын 2011 оны 211 дүгээр тушаалаар баталсан “Төлөөлөгчийн үйл ажиллагааг дэмжих хөрөнгийг зарцуулах журам”, Гаалийн ерөнхий газрын Мэргэжлийн зөвлөлийн хуралдааны 2009 оны 28/01 дүгээр тэмдэглэл, Татварын ерөнхий газрын даргын 2017 оны А/18 дугаар тушаал зэрэг 50 гаруй дүрэм, журмыг хянан үзэж бүхэлд нь буюу хэсэгчлэн хүчингүй болгох арга хэмжээг авлаа.

Түүнчлэн орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, аймгийн Засаг даргын захирамж, Засаг даргын Тамгын газрын даргын тушаалаар батлан мөрдүүлсэн хууль тогтоомжид нийцээгүй, хуулиар эрх олгоогүй байхад дүрэм, журам тогтоон мөрдүүлсэн, үндэслэлгүй төлбөр хураамж тогтоосон нийт 91 журмыг хянан үзэж өөрчлөх, хүчингүй болгоход чиглэсэн арга хэмжээг авлаа. Тухайлбал, энэ ажлын хүрээнд Баянхонгор аймгийн 5, Говь-Алтай аймгийн 3, Завхан аймгийн 2, Өвөрхангай аймгийн 11, Өмнөговь аймгийн 3, Дундговь аймгийн 7, Увс аймгийн 5, Баян-Өлгий аймгийн 13, Хэнтий аймгийн 6, Дорнод аймгийн 9, Сүхбаатар аймгийн 4, Булган аймгийн 7, Орхон аймгийн 5, Дархан-Уул аймгийн 8, Ховд аймгийн 10 шийдвэрийг тус тус хянан үзсэн байна.

Гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар 2017 онд 22, 2018 онд 8, 2019 онд 42 байгууллагад хүргүүлсэн АТГ-ын мөрдөгчийн мэдэгдлийн мөрөөр газар дээр нь ажиллахад мэдэгдлийн хариуг хуулийн хугацаанд ирүүлээгүй, гэмт хэрэг гарсан шалтгаан, нөхцөлийг арилгах, давтан гарахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр бодитой арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй хэлбэрийн төдий байгаа зэрэг нийтлэг дутагдал илэрсэн бөгөөд төрийн байгууллагууд Авлигын эсрэг хуулийн 6.1.12-т заасан “бүрэн эрхийнхээ хүрээнд авлигын шалтгаан, нөхцөлийг илрүүлэн тогтоох, тэдгээрийг арилгах, авлигын үйлдлийг таслан зогсоох, үр дагаврыг нь арилгах арга хэмжээ авах” нийтлэг үүргийн хэрэгжилт хангалтгүй байв.

Авлига, ашиг сонирхлын зөрчилд өртөх эрсдэл өндөр, энэ төрлийн зөрчил, гэмт хэрэгт албан хаагчид нь түлхүү холбогдож буй салбарт буюу Мэргэжлийн хяналтын газар, Авто тээврийн үндэсний төв, Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн байгууллагуудад ажиллав. Тухайлбал, нийслэлд 2018-2019 оны хичээлийн жилийн сургуулийн өмнөх буюу төрийн өмчийн цэцэрлэгүүдийн элсэлтийг Нийслэлийн боловсролын газар 100 хувь цахимаар зохион байгуулах болсонтой холбогдуулан Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.12 дахь хэсэгт заасны дагуу цахим бүртгэл болон элсэлт, элсэлттэй холбоотой бусад үйл ажиллагаанд авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэхгүй байх нөхцөлийг бүрдүүлэхэд



анхаарч, урьдчилан сэргийлэх шат дараалсан арга хэмжээ авч ажиллах талаар тусгайлсан ЗӨВЛӨМЖ боловсруулан хүргүүлж, 2018 оны 9 дүгээр сард Нийслэлийн төвийн дүүргүүдийн сургуулиуд 45, 1, 84, 23, 24, 2019 онд 1,2, 5, 6, 9, 12, 13, 17 38,14, 33, 84, 18, 52, 75 сургуулиудын нэгдүгээр ангийн элсэлтийн, 20 цэцэрлэгийн бүртгэлийн явц байдалтай газар дээр нь танилцаж, хөндөгдсөн асуудлаар олон нийтэд мэдээлэв. Авлигатай тэмцэх газраас гаргадаг Шударга байдлын үнэлгээ болон төрийн бус судалгааны байгууллагуудын судалгааны дүнгээр авлигын өндөр эрсдэлтэй гэж тооцогдож буй уул уурхай, боловсрол, эрүүл мэнд, гаалийн салбаруудад авлигын шалтгаан нөхцөлийг тогтоох, гарч болох эрсдлээс урьдчилан сэргийлэх тусгайлсан арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. (Биелэлт 100 хувь)

4.1.1.6-1. Төрийн албан хаагчдын ёс зүйн дүрмийг судлах, дүн шинжилгээ хийх, төрийн албаны ёс зүйн үлгэрчилсэн дүрмийг батлуулах /ТАЗ, 2017-2019/

Төрийн албаны тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2-т заасны дагуу Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор “Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг баталж, байгууллагын дотоод журмыг энэ тогтоолоор баталсан дүрэмд нийцүүлэн баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг төсвийн шууд захирагч нарт даалгасан. Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмд 2019 оны 122 дугаар тогтоолоор зарим нэмэлт, өөрчлөлт оруулсан. (Биелэлт 100 хувь)

4.1.1.6-2. Үлгэрчилсэн дүрмийн хүрээнд төрийн албан хаагчдын ёс зүйн дүрмийг салбар бүрээр батлуулах /ТАЗ, ЗГХЭГ, УИХТГ 2018-2022/

Төрийн албаны тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1-д “Энэ хуулийн 10.1.1, 10.1.3-т заасан албан тушаал эрхэлж байгаа төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг хууль тогтоомжоор тогтооно.”, мөн зүйлийн 40.2-т “Энэ хуулийн 10.1.2, 10.1.4-т заасан албан тушаал эрхэлж байгаа төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.” Гэж тус тус заасан. Засгийн газрын 2019 оны 33 дугаар

тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн 1.2-т “төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагын эрх бүхий албан тушаалтан хууль тогтоомжид заасан тохиолдолд тухайн салбар, байгууллагын чиг үүргийн онцлогийг харгалзан албан хаагчийн мэргэжлийн болон ёс зүйн дүрмийг батлан мөрдүүлж болно” гэж тусгасан. Өөрөөр хэлбэл, Төрийн албан тухай хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээр төрийн албан хаагчдын ёс зүйн үлгэрчилсэн дүрэм бус төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын ёс зүйн дүрэм мөрдөгдөж эхэлсэн ба төрийн бусад байгууллага өөрийн онцлогт тохируулан ёс зүйн дүрэм батлах нь нээлттэй байгаа болно. Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолд байгууллагын дотоод журмыг энэ тогтоолоор баталсан дүрэмд нийцүүлэн баталж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг төсвийн шууд захирагч нарт даалгасан.

Татварын ерөнхий хууль, Төрийн аудитын тухай, Боловсролын тухай зэрэг хуулиудад албан хаагчдын мэргэжлийн болон салбарын ёс зүйн дүрмийг баталж мөрдүүлэх талаар тусгасан ба эдгээр албан хаагчдын ёс зүйн дүрмүүд бүгд Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг батлахаас өмнө батлагдсан байна. Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.9-т зааснаар төрийн байгууллага тухайн салбарын албан хаагчийн ёс зүйн дүрмийг батлан гаргахын өмнө Авлигатай тэмцэх газраас санал авах үүргийг хүлээдэг. Энэ хүрээнд УИХ-аас ирүүлсэн Төрийн албаны ёс зүй, сахилга хариуцлагын тухай хуулийн төсөл болон Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрэм, Эрүүл мэндийн яамнаас ирүүлсэн Эмнэлгийн ажилтны ёс зүйн дүрэм, Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас ирүүлсэн Мэргэжлийн хяналтын газрын төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм, ХХААХҮЯ-ны Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас ирүүлсэн тус сангийн албан хаагчдын ёс зүйн дүрэм, нийслэлийн Газрын албанаас ирүүлсэн албан хаагчийн ёс зүйн дотоод дүрмийн төслүүдэд тус тус санал өгөв. Түүнчлэн 2019 онд Хил хамгаалах байгууллагын албан хаагчийн ёс зүйн дүрмийг баталсан байна.



Төрийн улс төрийн албан тушаалтны хувьд зөвхөн УИХ-ын 2009 оны 34 дүгээр тогтоолоор баталсан “Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрэм”-ийг мөрдөж байгаа бол бусад төрийн улс төрийн албан тушаалтан болох Засгийн газрын гишүүд, зөвлөх, туслах, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч, Засаг дарга, УИХ дахь нам, эвслийн бүлгийн ажлын албаны албан тушаалтнуудын хувьд үйлчлэх ёс зүйн дүрэм батлагдаагүй байна.

Төрийн тусгай албан тушаалтны хувьд ёс зүйн хэм хэмжээг хууль тогтоомжоор тогтоохоор хуульчилсан ба өнөөдрийг хүртэлх хугацаанд хуулиар буюу Улсын Их Хурлын тогтоолоор баталсан төрийн тусгай албан хаагчийн ёс зүйн дүрэм байхгүй, төрийн тусгай чиг үүргийг гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаандаа баримталдаг салбарын хуулиудад нь ёс зүрмийг батлахыг тодорхой субъектэд эрх олгох байдлаар зохицуулсан байна. (Биелэлт 70 хувь)

4.1.1.6-3. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгах, тайлагнах, хэлэлцэх арга хэмжээ авах /ТАЗ, 2017-2022/

2018 онд Нийслэлийн Засаг даргын Тамгын газар АНУ-ын Азийн сантай хамтран нийслэлийн хэмжээн дэх төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн талаар гаргасан гомдол, мэдээлэл, зөрчлийн агуулга, түүнийг шийдвэрлэж буй байдалд дүн шинжилгээ хийж, санал, зөвлөмж боловсруулан хэрэгжүүлж байна.

Төрийн албаны тухай хуулийн 74 дүгээр зүйлд зааснаар Төрийн албаны зөвлөлөөс УИХ-д хүргүүлэх тайланд “төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний хэрэгжилт, зөрчлийн талаархи дүгнэлт, цаашид авах арга хэмжээний санал”-ыг тусгахаар хуульчилсан.

Улсын Их Хурлын 2019 оны 17 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн “Гурав”-ын 3.1.2-т заасан хяналт шалгалт, шинжилгээ, үнэлгээ хийх хүрээнд буюу 3.1.2.г-д зааснаар “төрийн албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэх үйл ажиллагаанд хяналт тавих”, 3.1.5-д заасан мэргэшил, арга зүйн зөвлөгөө өгөх хүрээнд буюу 3.1.5.в-д зааснаар “ёс зүйн хэм хэмжээг сахиулахтай холбогдсон зөвлөгөө өгөх, арга

зүйн удирдлагаар хангах” чиг үүргийг Төрийн албаны зөвлөл хэрэгжүүлдэг.

Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-д төрийн байгууллага дахь Ёс зүйн зөвлөлөөс ёс зүйн зөрчлийн тайлан мэдээ ирүүлэхтэй холбоотой зохицуулалт байхгүй байна.

Төрийн албаны зөвлөлөөс Ёс зүйн зөвлөлийн ажиллах нийтлэг журмын төслийг боловсруулахаар ажиллаж байна. (Биелэлт 30 хувь)

4.1.1.7-1. Албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үйл ажиллагааг шинэ арга хэлбэрт шилжүүлэх, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх /АТГ, ТАЗ, 2017-2019/

Авлигатай тэмцэх газар (АТГ)-аас албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас факс, www.iaac.mn цахим хуудас дахь гомдол, мэдээллийн тусгай маягт бүхий гомдол илгээх холбоос, утсаар болон байгууллагын байранд биечлэн ирж гомдол, мэдээлэл, тоо бүртгэлийн ажилтанд өгөх боломжийг бүрдүүлсэн. АТГ нь 2007 оноос 1969, 2014 оноос 1800-1969 дугаарын утсыг ажиллуулж байсан бөгөөд байсан бол 2019 оноос дээрх мэдээллийг 110 тусгай дугаарын утсаар хүлээн авах боллоо. АТГ гомдол, мэдээлэл хүлээн авах цээжлэхэд амар, тогтооход хялбар, ярианы төлбөргүй “110” тусгай дугаарын утсыг ажилд оруулснаар иргэд авлига, ашиг сонирхлын зөрчил, авлигын гэмт хэрэг, хүнд сурталтай үйлчилгээ, албан тушаалтны ёс зүй, зүй бус шаардлагын талаарх мэдээллийг түргэн шуурхай хүргэх боломжтой боллоо. Энэхүү системийн тусламжтайгаар мэдээллийн сан үүсгэж, түүн дээр суурилан авлигын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх сургалтыг үе шаттайгаар, илүү үр дүнтэй, давхардал, хийдэлгүй зохион байгуулах нөхцөл бүрдэж байна. Утасны дуудлагыг хүлээн авах ажилтны тоог нэмэгдүүлж, дуудлагын бичлэгийг хадгалах, хүлээн авсан гомдол, мэдээллийг бүртгэх, шийдвэрлэлтийг хянах програм хангамжийг боловсруулж,

нэвтрүүлсэн. Гомдол мэдээлэл хүлээн авах “110” дугаарын утсыг олон нийтэд таниулах зорилгоор видео контент, шторк, зурагт хуудас гаргах зэрэг хэлбэрээр сурталчилгаа явуулж, зурагт хуудас, баннерийг гудамж, талбай дахь самбар, дэлгэц болон цахим хуудсуудад байршуулав. Мөн “Скайтел”, “Мобиком”, “Жи Мобайл”, “Юнител” зэрэг үүрэн телефоны оператор компанийн маркетингийн албатай хамтран холбогдох сурталчилгааг хэрэглэгчдэд үнэ төлбөргүй хүргэх ажлыг зохион байгуулав. Ингэснээр гомдол, мэдээлэл хүлээн авах утасны програмд 2017 оны сүүлийн хагас жилд нийт 125, 2018 онд 249 дуудлага ирж байсан бол 2019 онд 110 тусгай дугаарын утсаар зөвхөн 2019 оны 10 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 4464 удаагийн дуудлага бүртгэгдсэн байна. Тус газраас бусад орны сайн туршлагыг судалж, авлигын талаар гомдол, мэдээллийг хүлээн авах, авлигын эсрэг хууль тогтоомжийн талаар мэдээлэл, зөвлөгөө, сурталчилгааг иргэдэд ойртуулах зорилгоор Иргэний хяналтын төвүүдийг нээн ажиллуулсан бөгөөд 2019 оны 4 дүгээр улирлаас эхлэн төвүүдийн үйл ажиллагааг АТГ-ын дэргэдэх Олон нийтийн зөвлөл зохион байгуулж байна.

АТГ-ын гомдол, мэдээллийн програмыг шинэчлэх ажлыг зохион байгуулж програмын болон гэрээний маягтуудыг Үндэсний статистикийн хорооны хурлаар батлуулан туршиж дууссан. Энэхүү програм ашиглалтад орсноор иргэд, аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн гомдол, мэдээллийн шалгах хугацаа, явц байдал, шийдвэрлэлтэд нэгжийн дарга тухай бүр хяналт тавих, байгууллагын дотоод хяналтыг давхар хэрэгжүүлэх боломж бүрдсэн болно.

АТГ-ын даргын 2012 оны 74 дүгээр тушаалаар баталсан “Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд хүргэх арга хэмжээний журам”-ыг АТГ-ын даргын 2018 оны А/123 дугаар тушаалаар батлуулан хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Уг журам нь Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 2018 оны 4036 дугаарт бүртгэгдэн 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөгдөж байна. Энэхүү журмын хэрэгжилтийн талаарх мэдээллийг байгууллагын цахим хуудсанд “Сахилгын шийтгэл” цэсийг

шинээр нээн байршуулж, иргэд олон нийтийг мэдээллээр хангах нөхцөлийг бүрдүүлэв. “Сахилгын шийтгэл” цэсэнд 7 хоногийн хугацаанд 12316 иргэн хандсанаас үзэхэд мэдээлэл иргэдийн анхаарлыг татсан төдийгүй, мэдээлэлд иргэд хяналт тавих сонирхолтой байгааг илтгэж байна. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар 14 албан тушаалтанд хариуцлага тооцуулсан байх ба үүнээс “Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам”-ын хүрээнд 4 албан тушаалтны мэдээллийг журамд заасан хугацаанд, 8 албан тушаалтны сахилгын шийтгэл ногдуулсан талаарх мэдээллийг журамд заасан хугацаа өнгөрөөж тус тус нийтэд мэдээлсэн байна.

Харин төрийн бусад байгууллагаас дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр тухайн байгууллагын албан тушаалтны ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээлэл хүлээн авах тусгай дугаарын утас ажиллуулах, дотоод хяналтын албан тушаалтнуудад чадавхжуулах сургалт зохион байгуулах, харьяа нэгж, байгууллагадаа дотоод хяналтыг сайжруулах чиглэлээр зөвлөмж, үүрэг, албан даалгавар хүргүүлэх, дотоод хяналт, шалгалт хийх, цахим хуудсандаа тусгай цэс нээж ажиллуулах зэрэг ажлыг тогтмол зохион байгуулж байна. Тухайлбал, Монгол Улсын Засгийн газар, Төрийн албаны зөвлөл хамтран “Төрийн албаны удирдах ажилтны улсын зөвлөгөөн”-ийг зохион байгуулж, “Төрийн албан хаагчийн сахилга, хариуцлага” нэртэй салбар хуралдаанаар төрийн албан хаагчийн хариуцлага, ёс зүй, ёс зүйн олон улсын стандарт зэрэг сэдвүүдээр хэлэлцүүлэг өрнүүлж, гарсан санал, санаачилгыг холбогдох дүрэм, журмуудыг батлахдаа тусгасан. Нийслэлийн ЗДТГ-аас нийслэлийн нутгийн захиргааны болон харьяа байгууллагуудын хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан 92 ажилтанд сургалт зохион байгуулж, ажлын чиглэл, зөвлөмж чиглэл өгсөнөөс гадна, Олон Улсын Хөгжлийн Ассоциаци/Дэлхийн банк/-тай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд олон улсад ашиглаж буй төсөл хөтөлбөрийн үнэлгээний аргачлалыг судлан, нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдэд хөндлөнгийн үнэлгээ



хийх журмыг боловсруулан батлуулж мөрдөж байна. (Биелэлт 100 хувь)

4.1.1.8-1. Хууль бус шийдвэрийг хүчингүй болгох, гарсан сөрөг үр дагаврыг арилгах, учруулсан хохирлыг төлүүлэх талаарх эрх зүйн зохицуулалтыг бий болгох /ХЗДХЯ. ШЕЗ, УЕПГ, 2018-2019/

Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлд сөрөг нөлөөлөл бүхий болон хууль бус захиргааны акт гэж эрх зүйн зөрчилтэй актыг хэрхэн ойлгох, 47 дугаар зүйлийн 1-д захиргааны акт хууль бус болох тохиолдол, 48 дугаар зүйлд сөрөг нөлөөлөл бүхий болон хууль бус захиргааны актыг хүчингүй болгох, 55 дугаар зүйлд захиргааны гэрээ хууль бус болох тохиолдол, 98 дугаар зүйлд захиргааны актыг хууль бус болохыг хүлээн зөвшөөрөх, бүхэлд нь буюу хэсэгчлэн хүчингүй болгох, өөрчлөх, мөн хуулийн аравдугаар бүлэг(100-104 дүгээр зүйл)-т хууль бус үйлдэл, эс үйлдэхүйгээс өөрт учирсан хохирол арилгахыг шаардах эрх, хохирол барагдуулах этгээд, хохиролтой холбоотой маргаан шийдвэрлэх, хохирол барагдуулах, нөхөн олговор, түүний хэмжээг тогтоох, арван нэгдүгээр бүлэг (105-107 дугаар зүйл)-т хууль зөрчсөн албан тушаалтанд хүлээлгэх хариуцлага ногдуулахтай холбоотой зохицуулалтыг тусгасан.

Төрийн албаны тухай хуулийн 75 дугаар зүйлд төрийн жинхэнэ албан хаагч болон төрийн албанд нэр дэвшигчийн эрх зөрчигдсөн тухай маргааныг хянан шийдвэрлэхтэй холбоотой асуудлыг зохицуулж, төрийн албаны хүний нөөцийн удирдлага, мэргэшлийн шалгалттай холбогдон гаргасан шийдвэр хууль зүйн үндэслэлгүй болох нь тогтоогдсон бол төрийн албаны төв байгууллага өөрчлөх буюу хүчингүй болгохоор заасан. Мөн хуулийн 76 дугаар зүйлийн 76.4-т “Төрийн албаны төв байгууллагын болон шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй, биелүүлсэн боловч албан хаагчийг хууль бусаар дахин ажлаас халсан албан тушаалтны шийдвэрийг энэ хуулийн 76.7-д зааснаас бусад тохиолдолд төрийн албаны төв байгууллага хүчингүй болгож, буруутай албан тушаалтныг үүрэгт ажлаас нь чөлөөлөх мэдэгдлийг эрх бүхий этгээдэд хүргүүлнэ.”, 76 дугаар зүйлийн 76.5-т “Энэ хуулийн 76.4-д заасан эрх бүхий этгээд нь мэдэгдлийг заавал биелүүлж, авсан арга хэмжээний талаар

7 хоногийн дотор хариу мэдэгдэнэ.” гэж зохицуулсан.

Мөн Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1-д “Төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ”, 50.2-т “Төрийн албаны төв байгууллага шүүхийн шийдвэрийн биелэлтийн талаар бүртгэл хөтөлж, төрд учруулсан хохирлын нөхөн төлөлтөд хяналт тавьж, нөхөн төлөгдөөгүй тохиолдолд төрийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргана” гэсэн зохицуулалтыг тус тус тусгасан байна.

Прокурорын тухай хууль болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд тусгагдсан “Прокурор төр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр ....төрийн нэрийн өмнөөс оролцоно.” гэсэн заалтын дагуу төрийг төлөөлж прокуророор оролцсон тохиолдолд ИХШХШТХ-ийн 25 дугаар зүйлд заасны дагуу оролцуулж хэвшсэн. Улсын хэмжээнд 2019 оны эхний 8 сарын байдлаар прокурор төр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж дараах байдлаар прокурор иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон байдаг.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.1 дүгээр зүйлд заасны дагуу иргэд мөрдөгч, эрх бүхий албан тушаалтан, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас өөрт учирсан эдийн болон эдийн бус гэм хорын хохирлоо төрөөс (Засгийн газар) нэхэмжилж байна.

Дээрх үндэслэлээр 31 иргэнээс нийт 2,8 тэрбум төгрөгийн хохирол нэхэмжилсэн хэрэг шүүхээр хянагдаж байна.

Захиргааны хэргийн шүүх нь 2018 онд нийт 1638 хэрэг шийдвэрлэснээс 335 нь төрийн албаны маргаан байна. Үүний дотор 37.6% хувь 126 хэрэг нь төрийн байгууллагын ажил олгогчийн буруутай шийдвэрийн улмаас ажлаас үндэслэлгүйгээр халагдсантай холбоотой хэрэг эзэлж байна. 126 хэргийн 78.5 хувьд нь нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь болон зарим хэсгийг нь хангаж шийдвэрлэсэн байгаагаас үзэхэд төрийн байгууллагын ажил олгогчийн буруутай шийдвэр зонхилж байгаа

нь харагдаж байна. Ажлаас үндэслэлгүй халагдсан маргаан 31.1 хувиар, ажлаас буруу шилжүүлсэн маргаан 41.5 хувиар тус тус буурсан бол цалин хөлсний маргаан 12.7 хувиар өссөн байна.

Ажлаас үндэслэлгүйгээр халагдсаны улмаас олгогдох ажилгүй байсан хугацааны цалинг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 93 дугаар зүйлд заасны дагуу төрийн байгууллагын төлбөр төлөх зориулалт бүхий мөнгөн хөрөнгөөс гаргуулах, хүрэлцэхгүй тохиолдолд төсөвт тусгуулан шийдвэрлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхээр хуульчилсан. Уг ажлын хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцаас 2016-2019 онд Төрийн жинхэнэ албан хаагчдад доорх нөхөн төлбөрийг олгосон. Үүнд:

- 2016 онд 1 гүйцэтгэх баримт бичгийн 4.0 сая төгрөгийг;
- 2017 онд 103 гүйцэтгэх баримт бичгийн 659.5 сая төгрөгийг;
- 2018 онд 91 гүйцэтгэх баримт бичгийн 544.3 сая төгрөгийг;
- 2019 онд 43 гүйцэтгэх баримт бичгийн 285.6 сая төгрөгийг, нийт 238 төлбөр авагчид 1,493.4 сая төгрөгийг олгосон байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын төсөвт тусгагдсан мөнгөн хөрөнгөөс 2018-2019 онд олгосон ажилгүй байсан хугацааны цалин болох 553.0 сая төгрөгийг гэм буруутай төрийн эрх бүхий албан тушаалтнаар нөхөн төлүүлэх, Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангуулахаар Шийдвэр гүйцэтгэх албаны 2019 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 4/341 тоот албан бичгээр холбогдох баримт бичгийг Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн.

Авлигатай тэмцэх газар, Үндэсний аудитын газар хамтран Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Авлигатай тэмцэх газар, Үндэсний аудитын газар, Төрийн албаны зөвлөл, Шүүхийн Ерөнхий зөвлөл, Улсын ерөнхий прокурорын газар, “Онч шийдэл” ТББ, аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх дотоод аудитын нэгжийн албан хаагчид, холбогдох яам агентлагийн асуудал хариуцсан нэгжийн удирдлагуудыг оролцуулан “Төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх арга зам” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулж, асуудлыг тоо баримт, мэдээлэлд тулгуурлан ярилцаж, учирч буй хүндрэл бэрхшээл, түүнийг шийдвэрлэх

арга зам, төрийн байгууллагын хамтын ажиллагаа зэрэг сэдвийг хэлэлцэж зөвлөмж гаргасан. (Биелэлт 100 хувь)

4.1.1.8-2. Хууль бус шийдвэр гаргаж, улсад хохирол учруулсныг шүүх тогтоосон тохиолдолд албан тушаалтныг нийтийн албанд дахин томилохгүй байх эрх зүйн орчинг бүрдүүлэх /ЗГХЭГ, ХЗДХЯ. ТАЗ, АТГ, ШЕЗ, УЕПГ, УАГ, 2018-2019/

Захиргааны ерөнхий хуулийн 105 дугаар зүйлийн 105.1-д захиргааны байгууллагын захиргааны шийдвэр гаргах ажиллагаа болон захиргааны акт энэ хуулийн дагуу эрх зүйн зөрчилтөйд тооцогдож эрх зүйн үр дагаваргүй болсон бол тухайн гэм буруутай албан тушаалтны санаатай болон санамсаргүй үйлдсэн зөрчилд нь тохирох шийтгэлийг оногдуулахаар тусгасан. Мөн хуулийн 105 дугаар зүйлийн 105.2-т зааснаар тухайн албан тушаалтныг томилсон болон дээд шатны байгууллагын албан тушаалтан энэ хуулийн 105.1-д заасан зөрчил гаргасан, эсхүл захиргааны шийдвэрийг сайн дураараа эс биелүүлсэн албан тушаалтанд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол “нийтийн албанд нэгээс арав хүртэл жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах.” зэрэг шийтгэл оногдуулахаар заасан.

Мөн эрх зүйн зөрчил гаргасан албан тушаалтанд дээрх хуулийн 105 дугаар зүйлийн 105.2-т заасан шийтгэл оногдуулаагүй, эсхүл тохирсон шийтгэлийг ногдуулаагүй тохиолдолд эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн этгээд захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг хуульчилсан ба “нийтийн албанд нэгээс арав хүртэл жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах.” шийтгэл ногдуулсан тохиолдолд энэ хуулиас бусад хуулиас тогтоосон нөхцөл журам хэрэглэгдэхгүй болно.

Төрийн албаны тухай хуульд төрийн албаны хүний нөөцийн удирдлага, мэргэшлийн шалгалттай холбогдон гаргасан шийдвэр хууль зүйн үндэслэлгүй болох нь тогтоогдсон бол төрийн албаны төв байгууллага өөрчлөх буюу хүчингүй болгох, хууль бус шийдвэрийг Засгийн газар гаргасан бол уг шийдвэрийг төрийн албаны төв байгууллагын мэдэгдлийг үндэслэн Засгийн газар өөрөө ажлын 14 хоногийн дотор хүчингүй болгох, Төрийн албаны төв байгууллагын болон шүүхийн



шийдвэрийг биелүүлээгүй, биелүүлсэн боловч албан хаагчийг хууль бусаар дахин ажлаас халсан албан тушаалтны шийдвэрийг энэ хуулийн хуульд зааснаас бусад тохиолдолд төрийн албаны төв байгууллага хүчингүй болгож, буруутай албан тушаалтныг үүрэгт ажлаас нь чөлөөлөх мэдэгдлийг эрх бүхий этгээдэд хүргүүлэх, тухайн мэдэгдлийг зөрчсөн эрх бүхий этгээдийг “төрийн албанд гурван жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр төрийн албанаас халах” эрх зүйн зохицуулалтыг тусгасан. Тухайлбал, албан хаагчийг үндэслэлгүйгээр ажлаас чөлөөлсөний улмаас ажилгүй байсан хугацааны цалин, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг улсаас нөхөн төлүүлдэг байдал арилах юм.

Төрийн албаны тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.4-т “Төрийн албаны төв байгууллагын болон шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй, биелүүлсэн боловч албан хаагчийг хууль бусаар дахин ажлаас халсан албан тушаалтны шийдвэрийг энэ хуулийн 76.7-д зааснаас бусад тохиолдолд төрийн албаны төв байгууллага хүчингүй болгож, буруутай албан тушаалтныг үүрэгт ажлаас нь чөлөөлөх мэдэгдлийг эрх бүхий этгээдэд хүргүүлнэ.”, мөн зүйлийн 76.5-т “Энэ хуулийн 76.4-д заасан эрх бүхий этгээд нь мэдэгдлийг заавал биелүүлж, авсан арга хэмжээний талаар 7 хоногийн дотор хариу мэдэгдэнэ.” гэж тус тус заасан.

Эрүүгийн хуулийн 5.7 дугаар зүйлийн 1-д “Гэмт хэрэг үйлдсэн хүний нийтийн албанд ажиллах, мэргэжлийн үйл ажиллагаа явуулах, эсхүл бусад тодорхой эрхийг нэг жилээс найман жил хүртэл хугацаагаар хориглохыг эрх хасах ял гэнэ.” гэж тусган, шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан оногдуулсан үндсэн ял дээр нэмж эрх хасах ялыг оногдуулж болно, мөн энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд эрх хасах ялыг заавал оногдуулахаар хуульчилсан. Хуульд зааснаар шүүх эрх хасах ялыг хорих ял дээр нэмж оногдуулсан бол уг ялыг эдэлж дууссаны дараа, эсхүл торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах ял дээр нэмж оногдуулсан бол ял оногдуулсан үеэс, эсхүл хорих ял оногдуулахгүйгээр үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авсан бол албадлагын арга хэмжээ авсан үеэс хугацааг тоолж байна. (Биелэлт 100 хувь)

4.1.1.9-1.Төрийн байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн системүүдтэй нийтийн түлхүүрийн дэд бүтцийг холбох /ЗГХЭГ, ХХМТГ, 2017-2022/

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас дижитал шилжилтийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тодорхой зорилтуудыг хэрэгжүүлж ажилласан бөгөөд энэ хүрээнд “Төрийн байгууллага хооронд албан бичиг солилцох суурь систем ([www.docx.gov.mn](http://www.docx.gov.mn))”-ийг хөгжүүлж “Үндэсний дата төв” УТҮГ-т хүлээлгэн өглөө. Энэхүү систем нь төрийн байгууллагууд ямар систем ашиглаж байгаагаас үл хамааран албан бичгийг цахимаар солилцох, цахим албан бичгийн нэгдсэн мэдээллийн сан үүсэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх өргөн боломжийг олгож байна.

Төрийн байгууллага хооронд албан бичиг цахимаар солилцох энэхүү боломж нь тодорхой нэг системийг ашиглаж байгаа байгууллага хооронд л хийгддэг байсан нь албан бичиг солилцохын тулд зөвхөн нэг систем ашиглах, өөр сонголт хийх боломжийг хязгаарлах сөрөг талтай байсан. Тус системийг хөгжүүлж, “Үндэсний дата төв” УТҮГ-т хүлээлгэн өгснөөр “ХҮР” үйлчилгээний тоог нэгээр нэмэгдүүлж, төрийн байгууллагын албан хэрэг хөтлөлтийн системүүдийг нэг үйлчилгээгээр холбох боломж бүрдсэн болно.

Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг тоон хэлбэрт хөтлөн бүртгэлжүүлэх, баримт боловсруулах, хянах, батлах (тоон гарын үсгээр батлах), байгууллага хооронд солилцох, баталгаажсан баримтыг цахим болон тоон хэлбэрээр архивлах боломжтой албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд тоон гарын үсэг нэвтрүүлсэн онлайн <https://edoc.ulaanbaatar.mn> системийг нийслэлийн харьяа 918 байгууллагын 12,898 албан хаагчид ашиглаж байна.

Захиргааны байгууллагуудын албан хэрэг хөтлөлт болон солилцооны үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Барилга, хот байгуулалтын яам, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар болон Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хэрэг хөтлөлт, солилцооны үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх туршилтын ажлыг

эхлүүлсэн. Мөн туршилтаар нэвтрүүлэх байгууллагуудад зориулсан тоон гарын үсгийг ашиглах талаарх сургалтын материал, гарын авлагыг боловсруулав.

“Төрийн байгууллага хооронд албан бичиг солилцох суурь систем”-ийн хүрээнд албан бичиг солилцооны нэгдсэн сүлжээ, а/ төрийн байгууллага хооронд солилцсон албан бичгийн нэгдсэн сан, б/ төрийн байгууллагын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, в/ албан бичиг солилцооны түүх, хандалтын мэдээллийн нэгдсэн сан үүсч, төрийн байгууллага хооронд солилцсон албан бичгийн тухай статистик мэдээлэл гаргах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, дүн шинжилгээ хийх, цаашид албан бичиг солилцооны цахим архив үүсэх боломж бүрдэнэ. (Биелэлт 70 хувь)

#### 4.1.1.9-2. Мэдээлэл солилцох нэгдсэн сүлжээ, сан байгуулах /ЗГХЭГ, ХХМТГ, 2018-2022/

Төрийн байгууллага болон аж ахуйн нэгжүүдийг төрийн мэдээлэл солилцооны системд холбох, төрийн үйлчилгээний нэгдсэн портал болон төрийн үйлчилгээний платформор дамжин хүрэн “ХУР” төрийн мэдээлэл солилцооны систем (2018 оны 1 сараас ашиглалтад орсон)-ийг хөгжүүлж байна. Систем ашиглалтад орсноос хойш нийт төрийн 47, хувийн 118 байгууллага холбогдсон ба 170 төрлийн лавлагааг 2019 онд 58 сая удаа дуудаж ашигласан байна. Мөн төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системд 97 байгууллагын веб сервис холбогдож 19246680 удаагийн хүсэлтээр мэдээлэл солилцсон байна. Улсын хэмжээнд төрийн үйлчилгээний цахим машинаар 28 нэр төрлийн үйлчилгээг 1.426491 иргэдэд үзүүлсэн байна.

Танилт, баталгаажуулалтын “ДАН” системээр 18 байгууллага холбогдож 31852 хэрэглэгч бүртгүүлж ашиглаж эхлээд байна.

“ХУР” системийн дэд бүтцийг өргөтгөх төслийг боловсруулан Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй “Ухаалаг засаг” төслийн Удирдах хороо болон төслийн ерөнхий зохицуулагчид танилцуулж зөвшөөрөл авлаа. Үндэсний дата төвийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, тоног төхөөрөмж нийлүүлэгчийн сонгох шалгаруулалтыг зохион байгуулж, төслийн гүйцэтгэгчээр шалгарсан “Вертексмон” ХХК-тай Засгийн газрын Хэрэг

эрхлэх газраас 2019.07.03-ны өдөр гэрээ байгуулан ажиллаж, мэдээллийн технологийн тоног төхөөрөмжийг бүрэн хүлээн авсан бөгөөд нөөц өрөөний засварын ажлыг хийж байна. (Биелэлт 70 хувь)

#### 4.1.1.10-1. Төрийн албаны бүх чиглэлээр богино хугацааны болон давтан сургалт явуулах нийтийн албаны сургалтын институт байгуулах /ЗГХЭГ, АТГ, ТАЗ, УА, 2017-2019/

Төрийн албаны тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.3-т Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэргэд төрийн албан хаагчийг сургах, давтан сургах, төрийн албаны хүний нөөцийн менежментийн талаар судалгаа, шинжилгээ хийх, энэ талаар бодлого боловсруулагчид мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх үндсэн үүрэг бүхий Засгийн газрын харьяа төрийн албаны сургалтын байгууллага ажиллахаар заасан. Үүний дагуу Засгийн газрын 2018 оны “Удирдлагын академийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 366 дугаар тогтоолыг батлан, Удирдлагын академид 2019 оноос өмнө төрийн захиргаа, төрийн удирдлага болон бизнесийн удирдлагын чиглэлээр элсэн хувийн зардлаар суралцаж байгаа суралцагчдын сургалтын хөтөлбөрийг үргэлжлүүлэн дуусгавар болгох арга хэмжээ авч, Засгийн газрын захиалгат сургалт, судалгаа, зөвлөх үйлчилгээний зардлыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцад жил бүр тусган санхүүжүүлж байхаар шийдвэрлэсэн. Мөн тогтоолоор Удирдлагын академийн дүрмийг шинэчлэн баталсан ба тус байгууллага нь төрийн албан хаагчдын мэргэшүүлж бэлтгэх, давтан сургах, мэргэшлийг нь дээшлүүлэх, төрийн албаны хүний нөөцийн менежментийн асуудлаар судалгаа, шинжилгээ хийх, төрийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх чиглэлээр төр, захиргааны байгууллагуудад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх чиг үүрэг бүхий Засгийн газрын харьяа төрийн албаны сургалтын байгууллага юм.

Удирдлагын академи нь:

- төрийн албан тушаалын ангилал, зэрэглэлийн шаардлага, ажлын чиг үүрэгт нийцсэн дипломын дараахь мэргэшүүлэх сургалт;
- төрийн албанд шинээр томилогдсон иргэнийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалт;



- ахлах түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалд томилогдох төрийн албан хаагчийг мэргэшүүлэх багц сургалт;
- эрхэлсэн түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалд томилогдох төрийн албан хаагчийг мэргэшүүлэх багц сургалт;
- тэргүүн түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалд томилогдох төрийн албан хаагчийг мэргэшүүлэх багц сургалт;
- төрийн албанд анх орох иргэнийг төрийн захиргаа, төрийн удирдлагаар мэргэшүүлэх сургалт.
- цаг үеийн эрэлт, шаардлага, тухайн албан тушаалын онцлог, хариуцсан ажил, гүйцэтгэх чиг үүрэгт нийцүүлэн төрийн албан хаагчдыг давтан сургах, мэргэшлийг нь дээшлүүлэх зорилтот сургалт;
- удирдах ажилтан бэлтгэх, захиргааны шинжлэх ухааныг хөгжүүлэх шаардлагад нийцүүлэн төрийн захиргаа болон төрийн удирдлагын магистр, докторын сургалт сургалтыг тус тус явуулна.

Засгийн газрын захиалгаар гүйцэтгэх сургалтын агуулга, хөтөлбөрийг Төрийн албаны төв байгууллага, Засгийн газар хамтран батална. (Биелэлт 100 хувь)

#### 4.1.1.10-2. Сургалтын модуль, давтан сургалтын хөтөлбөр боловсруулах /АТГ, ТАЗ, УА, 2017-2019

Төрийн албаны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д заасныг үндэслэн төрийн албан хаагчийн мэргэшүүлэх багц сургалтын хэрэгцээг тодорхойлж, төрийн албан хаагчдад албан тушаалын ангилал, зэрэглэл, ажлын байрны шаардлагад нийцсэн мэдлэг, чадвар олгох мэргэшүүлэх багц сургалтын агуулга, хөтөлбөрийг Нэгдсэн үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөр (НҮБХХ)-өөс хэрэгжүүлж буй “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төслийн хүрээнд боловсруулан Мэргэшүүлэх багц сургалтын агуулга, хөтөлбөр”-ийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 37/33 дугаар хамтарсан тушаалаар, Төрийн албан хаагчдад албан тушаалын ангилал, зэрэглэл, ажлын байрны шаардлагад нийцсэн мэдлэг, чадвар олгох мэргэшүүлэх “Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын агуулга, хөтөлбөрийг Засгийн газрын 2019

оны 299 дүгээр тогтоолын хавсралтаар тус тус баталсан.

Үүнд төрийн албан тушаалын ахлах, эрхэлсэн, тэргүүн түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалд томилогдох иргэнийг мэргэшүүлэх багц сургалтын болон төрийн албанд шинээр томилогдсон буюу туслах, дэс түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалд ажиллаж байгаа иргэнийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтын хөтөлбөр багтаж байна. Энэхүү хөтөлбөрийн дагуу Засгийн газрын хэрэг эрхлэх газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн “Монгол Улсад мэргэжлийн иргэн төвтэй төрийн албыг хөгжүүлэх нь” төсөл, Удирдлагын академи хамтран үе шаттай сургалт зохион байгуулав.

Тэргүүн түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалтнуудад зориулсан мэргэшүүлэх багц сургалтад Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Төрийн албаны зөвлөл, УИХ-дажлаатайлагнадаг байгууллагын болон Удирдлагын академийн удирдах ажилтнууд, яамдын төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга зэрэг нийт 131 удирдах албан тушаалтан, эрхэлсэн түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалтнуудад зориулсан мэргэшүүлэх багц сургалтад УИХ-д ажлаа тайлагнадаг байгууллага, яам, агентлагийн хэлтсийн дарга, аймаг, нийслэлийн ИТХ-н нарийн бичгийн дарга, ЗДТГ-ын дарга зэрэг нийт 575 удирдах албан тушаалтан, ахлах түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалтнуудад зориулсан мэргэшүүлэх сургалтад 455 албан хаагч, нийт 1161 албан хаагчийг хамруулаа.

Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх багц сургалт буюу тэргүүн, эрхэлсэн, ахлах албан тушаалын мэргэшүүлэх багц сургалтад 2019 онд нийт 1198 албан хаагчдыг хамруулсан 13 удаагийн багц сургалтын хөтөлбөрт “Ёс зүйт манлайлал, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь”, “Ёс зүйн менежмент, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх”, “Авлига, ашиг сонирхлын зөрчил, төрийн албан хаагчийн ёс зүй” хичээлийг тус тус зохион байгуулсан болно.

АТГ-аас 2019 онд нийт 40 сэдвээр, Удирдлагын Академи, Монгол Улсын Их сургууль, Монголын Улсын Боловсролын Их Сургуулиудтай хамтран нийт 20 сэдвээр тус тус сургалтын модуль боловсруулан нийтийн



албан тушаалтанд зориулсан авлигын эсрэг сургалтыг зохион байгуулсан байна.

Энэ хүрээнд ЗГХЭГ, яам, агентлаг, чөлөөт бүс, нийслэлийн ИТХ-ын ажлын алба, нийслэлийн ЗДТГ-ын дарга нарт зориулсан “Манлайллын симпозиум: Өөрчлөлт хийх чадварыг хөгжүүлэх нь” сэдэвт сургалтад 142, Төрийн байгууллагын хүний нөөцийн ажилтан нарт зориулсан “Төрийн албан хаагчдын сургалтын бодлого, тогтолцоо” сэдэвт сургалтад 61, нийт 203 албан хаагч богино хугацааны сургалтад хамрагдсан. Эдгээр сургалтыг Удирдлагын академийн Төрийн албаны сургуультай хамтран зохион байгуулав.

АТГ авлигын эсрэг сургалтын хөтөлбөр, агуулгыг шинэчлэх чиглэлээр мэргэжлийн байгууллагууд болон иргэний нийгмийн байгууллагуудтай сургалтын модуль, хөтөлбөр, гарын авлагыг шинэчлэн боловсруулах ажлыг зохион байгуулав. Тухайлбал, Удирдлагын академитай хамтран нийтийн албан тушаалтанд зориулсан авлигын эсрэг сургалтын 6 модуль, гарын авлагыг боловсруулж, туршилт сургалтыг зохион байгуулан уг модулиар төрийн албан хаагчдад сургалт зохион байгуулах ажлыг хэвшүүлээд байна.

НҮБХХ-ийн “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төслийн дэмжлэгтэйгээр “Төрийн албан хаагчийн албан хаагчийн ёс зүй” сургалтын модуль, гарын авлагыг МУИС-ийн баг, “Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сургалтын модуль, гарын авлагыг МУБИС-ийн баг тус тус боловсруулсан. Түүнчлэн “Шинэ хөгжлийн түлхүүр” ТББ-аас иргэдэд зориулсан авлигын эсрэг сургалтын модуль, “Жаргалант хангай” ТББ ерөнхий боловсролын сурагч, хүүхэд залууст зориулсан шударга ёсны хичээлийн сургалтын модуль, “Глоб интернешнл төв” ТББ сэтгүүлчид зориулсан сургалтын модуль, хөтөлбөрийг боловсруулж сургалтыг үе шаттай зохион байгуулсан.

681 төрийн байгууллагаас Төрийн албаны зөвлөлд ирүүлсэн хүсэлтийн дагуу төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон зорилтот арга зүйн сургалт зохион байгуулж 6500 төрийн албан хаагчийг хамруулав. (Биелэлт 100 хувь)

#### 4.1.1.10-3. Авлигын эсрэг сургалт, давтан сургалтыг зохион байгуулах /ЗГХЭГ, АТГ, ТАЗ, УА, 2017-2022/

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 37/33 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Мэргэшүүлэх багц сургалтын агуулга, хөтөлбөр”, Засгийн газрын 2019 оны 299 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын агуулга, хөтөлбөр”-т “Төрийн албан хаагчийн ёс зүй, хариуцлага, албан ажлын зохион байгуулалт, харилцааны соёл”, “Авлига, ашиг сонирхлын зөрчил, төрийн албан хаагчийн ёс зүй” болон “Харилцааны соёл, ур чадвар” зэрэг чиглэлээр төрийн албан хаагчдад сургалт явуулахаар тусган хэрэгжүүлж байна.

Удирдлагын академийн Мэргэжил дээшлүүлэх институт улсын төсвийн санхүүжилтээр гүйцэтгэх сургалт, судалгааны ажлын төлөвлөгөөний дагуу танхимын 14, зайн 4, ажлын байран дахь 5, нийт 23 удаагийн сургалтад нийт 1287 төрийн албан хаагч хамруулсан байна. Танхимын сургалтаар 6 чиглэлийн 14 удаагийн сургалтад 572 төрийн албан хаагч, “Албан хэрэг хөтөлөлт”, “Төрийн албан хаагчийн ёс зүй”, “Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцаа, эрх зүйн зохицуулалт”, “Төрийн албан хаагчийн манлайлал” сэдвээр зохион байгуулсан зайн сургалтад нийслэл, 21 аймаг болон яам, агентлагийн 298 төрийн албан хаагч, 12 аймагт нийт 417 төрийн албан хаагч ажлын байран дахь сургалтад хамрагдсан. Үүнд: Дорноговь, Говьсүмбэр, Төв аймагт “Бодлогын хэрэгжилтийг үнэлэх арга зүй” сэдвээр Дархануул, Сэлэнгэ аймагт “Иргэнд чиглэсэн төрийн үйлчилгээ”, Хөвсгөл, Булган, Орхон аймагт “Төрийн байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ”, Архангай, Өвөрхангай, Дундговь, Өмнөговь аймагт “Төрийн байгууллагын стратеги төлөвлөлт хийх арга зүй” зэрэг сэдвээр сургалтыг зохион байгуулсан.

Удирдлагын академийн Мэргэжил дээшлүүлэх институт улсын төсвийн санхүүжилтээр гүйцэтгэх сургалтууд, төрийн байгууллагатай хамтарсан болон захиалгат сургалтуудад “Төрийн албаны ёс зүй”, “Төсвийн ил тод байдал” гэх мэт авлигаас урьдчилан сэргийлэхтэй холбоотой сэдвээр тогтмол сургалт зохион байгуулж байна. Тухайлбал,



төрийн албаны ёс зүй, манлайлал, харилцааны ур чадварын танхимын болон зайн, ажлын байран дахь сургалт, байгууллагуудын захиалгат богино сургалтад төрийн болон орон нутгийн нийт 1515 албан хаагчид хамрагдсан байна. Мөн 2018-2019 оны хичээлийн жилд байгууллагын захиалгат сургалтаар төрийн албан хаагчийн ёс зүй, манлайлал, удирдах ажилтны ёс зүй, төрийн үйлчилгээний соёл, захиргааны шийдвэр гаргах ажиллагаан дахь нийтлэг алдаа, түүнээс урьдчилан сэргийлэх арга зам, төсөв санхүүгийн хяналт, худалдан авах ажиллагаан дахь нийтлэг зөрчил, түүнээс сэргийлэх арга зам зэрэг сэдвийн хүрээнд 510 хүн хамрагдсан. Түүнчлэн, Авлигын эсрэг сургалт, сурталчилгааны үйл ажиллагааг төрийн зарим байгууллагууд онцлог байдлаар зохион байгуулсан байна. Тухайлбал, нийслэлийн ЗДТГ Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүжилтээр Азийн сантай хамтран хэрэгжүүлж буй “Хотын засаглалыг сайжруулах” төслийн хүрээнд “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын төрийн албан хаагчдын сургалтын хүрээг тодорхойлох, сургалтын хөтөлбөрийн агуулга” боловсруулан Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн Хурлаар хэлэлцүүлсэн. Мөн хөтөлбөрт тусгагдсан модуль сургалтуудыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх “Сургалтын төв”-ийг түшиглэн зохион байгуулав. Нийслэлийн төвийн 6 дүүрэг, хэрэгжүүлэгч 14 агентлагийн хүний нөөц хариуцсан ажилтнуудад зориулсан “Хувь хүнийг хөгжүүлэх нь” сэдэвт олон улсын сертификаттай сургалт; Герман-Монголын хамтарсан Афа академитэй хамтран “Төрийн албан хаагчийн хувь хүний хөгжил ба ёс зүй” сэдэвт сургалт; Ёс зүйн хорооны дарга, гишүүдэд зориулсан сургалтыг; “Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн зохицуулалт, төрийн албаны соёл, стандарт, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, авах арга хэмжээ” сэдэвт сургалт; Дүүргийн хороодод шинээр томилогдсон хорооны Засаг дарга, нийгмийн ажилтан, хорооны зохион байгуулагч нарт зориулсан суурь сургалт, төрийн жинхэнэ албан тушаалд нэр дэвшигчдэд зориулсан сургалт; Төрийн жинхэнэ албан тушаалд анх удаа орж байгаа албан тушаалтнуудад ажлын байранд тавигдах үндсэн шаардлага, төрийн захиргааны албан

хаагчийн ёс зүйн дүрмийг танилцуулах сургалтыг тус тус зохион байгуулав.

Авлигатай тэмцэх газрын Олон нийтийн төвд зохион байгуулсан авлигын эсрэг сургалтад 2017 онд 11345, 2018 онд 14783, 2019 онд 25007 нийт 51135 этгээдийг хамруулжээ. Тэдгээрээс 2018 онд 8497, 2019 онд 4947 буюу нийт 13444 албан хаагчийг Авлигатай тэмцэх газрын Олон нийтийн төвд сургасан бол 2019 онд тухайн байгууллага дээр болон аймаг орон нутагт зохион байгуулсан сургалтад 5238 албан хаагч, 3580 оюутан, сурагч, 7627 иргэд, 354 төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн төлөөлөл тус тус хамрагдсан байна. Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан “Авлигын эсрэг сургалтад оролцогчдыг салбар, байгууллагаар нь авч үзвэл Ерөнхийлөгчийн Тамгын газар түүний харьяа байгууллагаас 32, Улсын Их Хурал түүний харьяа байгууллагаас 572, шүүхийн 3 байгууллагаас 121, прокурорын 11 байгууллагаас 254, Засгийн газар болон Ерөнхий сайд, Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний 17 байгууллагаас 582, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний 3 байгууллагаас 31, Батлан хамгаалах сайдын эрхлэх асуудлын хүрээний 4 байгууллагаас 429, гадаад харилцааны яамнаас 67, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээний 4 байгууллагаас 128, Зам тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 5 байгууллагаас 216, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 2 байгууллагаас 16, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний 5 байгууллагаас 132, Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 11 байгууллагаас 1971, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 7 байгууллагаас 108, Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 3 байгууллагаас 724, Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 2 байгууллагаас 185, Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагаас 51, нийслэлийн төр захиргааны 30 байгууллагаас 345 болон орон нутагт 7 аймгийн авлигын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрх бүхий 1576 албан тушаалтан хамрагджээ.

Авлигын эсрэг сургалтын оролцооны байдлаас дүгнэхэд төрийн байгууллагуудын удирдлагын зүгээс уг сургалтад албан хаагчийг авлигад

өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалтын нэгдсэн төлөвлөлт, бодлогогүйн улмаас мэдээлэл авсан сэдвээр 1 албан хаагчийг удаа дараа оролцуулах, сургалтын ирц, гүйцэтгэл хангалтгүй байх, оролцогчдын давхардал, хийдэл гарах асуудлууд гарч байв. Авлигын эсрэг сургалтыг Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн зорилготой уялдуулан хэрэгжүүлэх, төрийн албанд анх удаа томилогдсон албан хаагчийг энэхүү сургалтад заавал сургадаг байх, давтан сургалтад оролцогчдын эрэлт хэрэгцээг тодорхойлох ажлыг хэрэгжүүлэх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч, төрийн байгууллагуудад саналаа хүргүүлэв.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх хүрээнд Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар болон АТГ газраас 21 аймгийн удирдлагуудад хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг хангахад орон нутгийн зүгээс анхаарах асуудлын талаар аймгийн удирдах ажилтнуудад мэдээлэл хийж, арга зүйн зөвлөгөөгөөр хангасан. Уг зөвлөгөөнд аймгийн ИТХ, Засаг дарга, ЗДТГ, түүний дэргэдэх агентлагуудын удирдах ажилтнууд, мөн сумдын ИТХ болон ЗДТГ-ын удирдах албан тушаалтнууд 120 гаруй хүн оролцсон болно.

- Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагуудын захиргааны удирдлагын болон төлөвлөлт зохион байгуулалтын газар, хэлтэс, тасгийн дарга нарын сургалт, зөвлөгөөнд (60 орчим хүн хамрагдсан) “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний явц байдал, цаашид анхаарах асуудал” сэдвээр сургалт хийж, ХШДШХ, УССГХ-ээс холбогдох ажилтныг оролцуулан ажлыг зохион байгуулав.
- ЦЕГ-ийн орон нутгийн салбар ЭБАТ-уудын цугларалтад АТҮХ-ийн хэрэгжилт, цаашид анхаарах асуудал сэдвээр сургалт хийж, 50 орчим салбар ЭБАТ-ыг арга зүйн удирдлагаар хангав.

Авлигатай тэмцэх газраас “Авлигын эсрэг сургалт”-ын хүрээнд иргэд, оюутан залуус, хувийн хэвшил зэрэг нийгмийн зорилтот бүлэг рүү чиглэсэн чадавхжуулах “Үзэл санааны удирдагчдаар оюутнуудад лекц уншуулах”, “Хууль сахиулах байгууллагын

ажилтан, албан хаагчид эрэн сурвалжлах сэтгүүл зүй, сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах нь”, “Сайн туршлага: Иргэдийн бүлэг”, “Төрийн үйлчилгээ ба иргэний хяналт” сэдэвт сургалтуудыг тус тус зохион байгуулж нийт 68 байгууллагын 6381 иргэдийг хамруулаад байна. АТГ-ын ОНТ-д зохион байгуулсан нийтийн албан тушаалтнуудад зориулсан сургалтад оролцогчдыг бүртгэл цахимын бүртгэлийн системийг ашиглалтад оруулж, бүртгэж хэвшүүлээ. Ийнхүү цахим бүртгэлжүүлэлт хийснээр дараагийн давтан сургалтын агуулга, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, оролцоог нэмэгдүүлэхэд ач холбогдолтой юм.

Сангийн яам “Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг сурталчлах нэг сарын аян”-ыг өрнүүлж, “Монгол төрийн албан хаагчийн ёс зүй, үнэт өв”, “Албаны соёл, ажил хэрэгч байдал”, “Төрийн албаны үнэт зүйл, байгууллагын соёл”, “Хүний нөөцийн хөгжил, хөдөлмөрийн ёс суртахуун”, “Харилцааны чадвар” сургалт зохион байгуулан, яамны албан хаагчдын 75 хувийг хамруулсан; Улсын бүртгэлийн ерөнхий газар 69 удаагийн сургалт зохион байгуулж 3525 /давхардсан тоогоор/ гаруй албан хаагчийг, Засгийн газрын болон байгууллагын зардлаар, бусад төрийн байгууллагын зохион байгуулж буй сургалтад 193 гаруй албан хаагчийг хамруулсан. Төрийн болон төрийн бус байгууллагын захиалгаар, иргэдэд зориулсан эрх зүйн сургалт зохион байгуулах зорилтын хүрээнд 15 удаагийн сургалт зохион байгуулж 481912 иргэнд байгууллагын үйл ажиллагааг сурталчлах сургалт зохион байгуулсан.

АТГ-ын Олон нийтийн төвд нийтийн албан тушаалтнууд, зорилтот бүлэгт зориулсан авлигын эсрэг сургалтаас гадна иргэдэд мэдээлэл хүргэх, гомдол мэдээлэл хүлээн авах, гарын авлага, материал түгээх, дотоодын болон гадаадын хурал, зөвлөгөөн хэлэлцүүлгүүдийг зохион байгуулж байна. (Биелэлт 100 хувь)

4.1.1.10-4 Бүс нутгийн хэмжээнд авлигын эсрэг сургалт, семинарыг зохион байгуулах / АТГ, ЗГХЭГ, 2020-2022/

Арга хэмжээ хэрэгжиж эхлээгүй.



**Хоёр. Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр:**

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 2 дахь зорилтын хүрээнд нийт 7 үйл ажиллагаа, 18 арга хэмжээ тусгагдсан. Үүнээс 1 дүгээр үе шатанд 17 арга хэмжээг хэрэгжүүлэв. Зорилтын хэрэгжилтийг тоймлон танилцуулбал:

4.1.2.1-1. Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхэд учрах хүндрэл бэрхшээл, шийдвэрлэх арга замыг судалж, цахим хэлбэрт шилжүүлэх төрийн үйлчилгээний жагсаалтыг шинэчлэн батлуулах /ЗГХЭГ, ХХМТГ, Бүх шатны төрийн байгууллагууд. 2017-2018/

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар нь Засгийн газрын 2015 оны 254 дүгээр тогтоолоор баталсан төрийн үйлчилгээний цахим систем /eZasag.mn/-д холбох төрийн 167 үйлчилгээний жагсаалтын дагуу 2017 онд 18 үйлчилгээг цахимжуулж, төрийн үйлчилгээг цахим машин ашиглан иргэдэд хүргэхэд мөрдөх “Төрийн үйлчилгээний цахим машины ашиглалт үйлчилгээний журам”-ыг шинэчлэн батлуулсан. Төрийн үйлчилгээний нэгдсэн системийн www.eZasag.mn цахим хуудсыг ашиглан Цагдаагийн ерөнхий газрын Лицензийн төвийн жолооны үнэмлэх солиулах үйлчилгээ, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 6 төрлийн үйлчилгээний холболтыг турших, Автотээврийн үндэсний төв, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн 3 төрлийн үйлчилгээг ТҮЦ машины үйлчилгээнд нэвтрүүлэх бэлтгэл ажлыг гүйцэтгэсэн.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлагдсаны дараа 2018 онд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2018 оны 30 дугаар тушаалаар “Төрийн үйл ажиллагаанд мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлэн, төрийн үйлчилгээг иргэн төвтэй болгож, төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж хэрэглээнд нэвтрүүлэх” үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан санал, дүгнэлт боловсруулж Засгийн газрын 2018 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн 259 дүгээр тогтоолоор “Төрийн цахим мэдээлэл солилцох системд холбох төрийн үйлчилгээний жагсаалт”-ыг 1 дүгээр

хавсралт, “Төрийн цахим мэдээлэл солилцох системийг ашиглан цахим хэлбэрээр үзүүлэх төрийн үйлчилгээний жагсаалт”-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус шинэчлэн баталж, 2015 оны 254 дүгээр тогтоолыг хүчингүй болгов. “Төрийн цахим мэдээлэл солилцох системд холбох төрийн үйлчилгээний жагсаалт”-д 176 үйлчилгээг төрийн цахим мэдээлэл солилцох системд холбохоор холбогдох яам, үйлчилгээний нэрээр нь баталсан бол “Төрийн цахим мэдээлэл солилцох системийг ашиглан цахим хэлбэрээр төрийн үйлчилгээний жагсаалт”-д 38 байгууллагын 320 үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхээр нэрээр нь тусгасан байна. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд тоног төхөөрөмж авч, хөгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

“Төрийн мэдээлэл солилцооны ХҮР систем”-ийг хөгжүүлэн 2018 оны 1 дүгээр сараас ашиглалтад оруулж системд нийт төрийн 47, хувийн 118 байгууллага холбогдсон. 2019 онд 170 төрлийн лавлагааг 58 сая удаа дуудаж ашигласан байна. Мөн “Төрийн мэдээлэл солилцооны ХҮР систем”-д 97 байгууллагын веб сервис холбогдож 19.246.680 мэдээлэл солилцох хүсэлтийг солилцон ажилласан байна. Улсын хэмжээнд төрийн үйлчилгээний цахим машинаар 28 нэр төрлийн үйлчилгээг 1.426.491 иргэнд үзүүлсэн байна. “Танилт, баталгаажуулалтын ДАН” системээр 18 байгууллага холбогдож 31.852 хэрэглэгч бүртгүүлж ашиглаж байна.

Гаалийн ерөнхий газар нь хуулиар тогтоосон чиг үүргийн дагуу иргэдэд хүргэх үйлчилгээний чанар, шуурхай байдал, хүртээмжийн бодит байдлын талаар хэрэглэгчийн үнэлгээг “Эс Ай Си Эй” ХХК-ийн судалгааны багаар 2018 оны 11-12 дугаар сард гүйцэтгүүлсэн бөгөөд судалгаанд оролцогчдын 48.3 хувь нь хувийн хэвшлийн, 31.9 хувь нь энгийн иргэн, 15.9 хувь нь хувиараа бизнес эрхлэгч, 3.9 хувь нь төрийн болон төрийн өмчийн байгууллагад хамаарч байв. Хэрэглэгчид гаалийн байгууллагад 3.68 буюу “дунд” гэсэн үнэлгээг өгчээ. Өөрөөр хэлбэл, хэрэглэгч сэтгэл ханамжтай байгаа хэдий ч хэрэглэгчтэй холбоотой зарим үзүүлэлтүүдийг сайжруулах шаардлагатай байгааг энэхүү индексийн утга харуулж байна. Хууль зүй дотоод хэргийн яам болон харьяа агентлаг, байгууллагаас иргэн, хуулийн этгээдэд үзүүлж байгаа 27 үйлчилгээний

судалгааг гарган Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газарт хүргүүлээд байна.

Татварын ерөнхий газар 2017 оны Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн хүрээнд албан татварын чөлөөлөлт, хөнгөлөлт, буцаан олголтын үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр буюу татварын орлогын чөлөөлөлт, хөнгөлөлтөд хамрагдахад татвар төлөгчийн бүрдүүлэх материалыг “ХУР” системийг ашиглан цахимаар 2018 оноос эхлэн татварын албанд хүлээн авах шинэ хэрэглээг нэвтрүүлэхээр Үндэсний Дата Төвтэй гэрээ байгуулж, хамтарсан төлөвлөгөө гарган ажилласнаар Орон сууцны орлогын чөлөөлөлт болон сургалтын төлбөрийн хөнгөлөлт эдлэхэд бүрдүүлэхтэй холбогдуулан “ХУР” системээс татвар төлөгчийн гарын хурууны хээг уншуулах төхөөрөмжийн тусламжтайгаар иргэний үнэмлэхийн лавлагаа, үл хөдлөх эд хөрөнгийн лавлагаа, төрсний бүртгэлийн лавлагаа, нийгмийн даатгалын шимтгэлийн лавлагааг авдаг боллоо. “ХУР” системийг ашиглан үйлчилгээг хөнгөвчилснөөр орон сууцны чөлөөлөлтөд хамрагдах татвар төлөгч 12 төрлийн материал бүрдүүлдэг байсан бол 5 ширхэг, сургалтын төлбөрийн хөнгөлөлтөд хамрагдах татвар төлөгч 9 материал бүрдүүлдэг байсан бол 3 ширхэг материал бүрдүүлдэг болсон.

“ХУР” системийг ашиглан 18000 гаруй иргэдээс хөнгөлөлт, чөлөөлөлтийн материал хүлээн авсан байна.

Сангийн яам Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн системийн В7 хувилбар /цахим технологид суурилсан/ -ыг нэвтрүүлэв. Төсвийн орлогыг түргэн шуурхай, тогтмол төвлөрүүлэх зорилгоор “Татварын цахим төлбөрийн систем” төслийг Татварын ерөнхий газарт хэрэгжүүлж, системээс үүсэх давтагдашгүй нэхэмжлэхийн дугаараар иргэд, аж ахуйн нэгж, байгууллага татвараа төлөх бэлтгэл ажлыг хийв. Арилжааны 11 банкны 2887 дансаар дамждаг байсан орлого 6 банкны 6 дансанд төлөгдөх ба татварын төрлөөр уг систем ангилан Төрийн сан дахь улсын болон орон нутгийн төсвийн орлогын /аймаг сум нийслэл дүүрэг/ 5137 дансанд өдөр тутам төвлөрүүлнэ.

Сангийн яам нь нийслэлийн ЗДТГ, УБ хотын банктай ТЭГ үлдэгдэлтэй дансны гурвалсан гэрээ

байгуулан Замын хөдөлгөөний удирдах төвд байрлуулсан пос машинаар дамжуулан замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн иргэдэд ногдуулсан торгуулийн орлогыг цахим хэлбэрээр хүлээн авч байна. Төрийн албан хаагчийн цалин хөлсний мэдээллийг төсвийн төлөвлөлтөд ашиглах замаар төсвийн орон тооны хяналт тогтоох, урсгал зардлын хуваарилалтын үр ашиг, төсвийн сахилга батыг сайжруулах зорилгоор “Цалин хөлсний тооцооны төвлөрсөн систем”-ийг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангасан байна.

“Олон нийтийн мэдээллийн эрх чөлөөг хангах, боловсронгуй болгох” гэсэн зорилтот хөтөлбөрийн хүрээнд 2008 оноос хойш [www.il.tod.mn](http://www.il.tod.mn) цахим хуудсыг нээн ажиллуулж байна. Тус цахим хуудсанд 2008-2018 оны хооронд нийт 400 гаруй Монгол Улсын төсөвтэй холбогдолтой цаг үеийн мэдээ, мэдээлэл, гарын авлага, хууль тогтоомж, дүрэм, журмыг тогтмол тавьж, төсвийн үйл явц, төсвийн төсөл, батлагдсан төсвүүд, түүнд холбогдох баримт бичгийг олон нийтэд нээлттэй, түргэн шуурхай хүргэхээр холбогдох мэдээллийг байршуулсан.

Орон нутгийн хөгжлийн сангийн хэрэгжилтийн мэдээллийг [www.tusuv-oronnutag.mn](http://www.tusuv-oronnutag.mn) цахим хуудсаар дамжуулан иргэд олон нийтэд мэдээлдэг бөгөөд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээний талаар дэлгэрэнгүй мэдээлэл авах боломжтой болсон.

Монгол Улсын хөгжлийн банкнаас төслийн санхүүжилт, зээлийн хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх үйл ажиллагааг хялбаршуулж Зээл санхүүжилтийн хүсэлт хүлээн авах, шийдвэрлэх цахим систем (LOS system)-ийг ашиглалтад оруулав.

“ҮЦТХТ” ХХК-иас [mcsd.mn](http://mcsd.mn) цахим хаягаар иргэд олон нийтэд хөрөнгийн зах зээлийн мэдээ, мэдээллийг түргэн шуурхай хүргэхэд анхаарч ажиллаж байна. Мөн уг цахим хуудсанд холбогдох бусад төрийн байгууллагын цахим хуудсанд нэвтрэх болон Засгийн газрын 2011 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 98 дугаар тогтоолын дагуу Монгол Улсын иргэдэд “Эрдэнэс тавантолгой” ХК-ийн хувьцааг эзэмшүүлсэнтэй холбоотойгоор хувь хүн өөрийн регистрийн дугаараар “Эрдэнэс тавантолгой” ХК-ийн хувьцааг шалгах боломжийг нэвтрүүлэн ажиллаж байна. (Биелэлт 100 хувь)



#### 4.1.2.1-2. Төрийн үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх /ЗГХЭГ, ХХМТГ, 2018-2022/

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газраас Төрийн үйлчилгээний нэгдсэн системийн [www.ezasag.mn](http://www.ezasag.mn) цахим хуудсыг ашиглан иргэдэд үзүүлж буй нийгмийн халамжийн үйлчилгээг хэвийн ажиллагаатай болгохоор Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, “Интерактив” ХХК, “Интерактив Би Ай” ХХК хамтран холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.

Санхүүгийн зохицуулах хороо Үндэсний дата төвтэй хамтран “ХҮР” системд Санхүүгийн зохицуулах хорооны “Зөвшөөрлийн цахим систем”-ийг 2020 оны хагас жилийн дотор бүрэн холбохоор ажиллаж байна.

Сангийн яам Хөрөнгийн үнэлгээний болон Аудит, Татварын мэргэшсэн зөвлөхийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийг цахим хэлбэрээр үзүүлэх үйлчилгээний хүрээнд тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээд болон иргэдийн нэгдсэн мэдээллийн санг үүсгэх ажлыг эхлүүлсэн байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс «Монгол Улсын шүүхийн цахим сан», «Эрэн сурвалжлах албадан ирүүлэх» бүртгэл тайлангийн систем, «Санал хүсэлт»-ийн систем, «Иргэний хэргийн хөдөлгөөний удирдлагын төв»-ийн систем, «Захиргааны хэргийн хөдөлгөөний удирдлагын төв»-ийн систем гэсэн 5 цахим үйлчилгээний системийг нэвтрүүлэв. Тухайлбал, Шүүхийн үүдэнд байрлах киоско төхөөрөмжөөр иргэдэд шүүхийн мэдээллийг хүргэх, иргэдээс шүүхтэй холбоотой санал хүсэлт болон судалгаа авах зорилготой “Санал хүсэлт” системийг ашиглаж байна. Түүнчлэн 2018 онд Улсын бүртгэлийн ерөнхий газартай хамтран шүүхэд шаардлагатай иргэн, хуулийн этгээдийн талаар лавлагаа, мэдээллийг цахимаар авах бололцоог бүрдүүлэхээр ажиллав.

“Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2016 оны 141 дүгээр тогтоолоор Төрийн үйлчилгээний Дүнжингарав, Мишээл, Драгон болон Оргил төвийг байгуулан ажиллаж байна. Тус төвүүдэд төрийн 28 байгууллагын 225 албан хаагч 325 нэр төрлийн төрийн үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд нэг

дороос үзүүлж байна. Жил тутам үйлчилгээний хандалт эрс нэмэгдэж байгаа бөгөөд хандалтыг оноор авч үзвэл, 2016 онд 1,000,049, 2017 онд 1,520,954, 2018 онд 1,917,929, 2019 онд 1,970,999 үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд тус тус үзүүлжээ. Үйлчилгээний хандалт жил тутам нэмэгдэж байгаа нь төрийн үйлчилгээг авах иргэдийн эрэлт, хэрэгцээнд тулгуурлан үйлчилгээний нэгдсэн төвүүдийг шинээр байгуулсан, үйлчилгээний нэгдсэн төвөөс үзүүлж буй төрийн үйлчилгээний нэр төрлийг иргэн, хуулийн этгээдийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн нэмэгдүүлсэн, түүнчлэн иргэд төрийн үйлчилгээний нэгдсэн төвөөр үйлчлүүлж хэвшсэнтэй шууд холбоотой байна. Энэ ажил нь төрийн үйлчилгээний хүнд суртал, шийдвэрлэлтийн хугацаа багасаж, иргэдийн санхүү болон цаг хугацааг хэмнэх давуу талтай болсон. “Нэг цонхны үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2013 оны 153 дугаар тогтоолын дагуу нийслэл, орон нутагт нэг цонхны үйлчилгээний нийт 45 төв (213 цонх бүхий) үйлчилгээ үзүүлж байгаагаас 150 цонх нь төрийн үйлчилгээг иргэдэд хүргэж байна. Төрийн үйлчилгээ үзүүлж байгаа нэг цонх жилд дунджаар 3150 удаа, өдөрт 13 удаа үйлчилгээ үзүүлдэг ба төрийн байгууллагуудын үйлчилгээнээс шалтгаалан цонхны ачаалал харилцан адилгүй байдаг. Эдгээр төвүүдэд байгууллага тус бүрээс төлөөлөл сууж ажилладаг, үйлчилгээний ачаалал харилцан адилгүй, үйлчилгээ авах хүсэлтийг шийдвэрлэх явц иргэнд тодорхойгүй байдгаас хүлээлт үүсэх, дахин лавлаж ачаалал үүсгэх зэрэг асуудал тулгарч байна.

Төрийн мэдээлэл солилцооны “ХҮР” систем талаар танилцуулахад 2019 онд төрийн 28 байгууллагын 85 үйлчилгээг цахим хэлбэр бүрэн шилжүүлсэн байна. Иргэд төрийн үйлчилгээ авахдаа олон цонх дамжиж байгаа шатлалыг арилгах, давхардсан бүтэц үүсгэхгүй байх зорилгоор төрийн дижитал шилжилтийг хийж нэг цонхны үйлчилгээ болон төрийн үйлчилгээний нэгдсэн төвийг өөрчлөн зохион байгуулах, сумдад төрийн зарим үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэх үйлчилгээний нэгдсэн төв шинээр байгуулах, тэдгээрийг операторын горимд шилжүүлэх (олон цонх дамжих шатлалыг арилгаж, тухайн нэг цонхноос бүх үйлчилгээг авах бололцоог бүрдүүлэх), үйлчилгээний хүсэлтийг хүлээн авч, шийдвэр гаргах эрх

бүхий албан хаагчид цахим хэлбэрээр дамжуулах, шийдвэрлэлтийн явцыг иргэнд мэдээлэх, үйлчилгээний чанар, хүртээмж, шийдвэрлэлтийн явцын талаар нэгдсэн хяналт хийх боломж бүхий “Үйлчилгээний нэгдсэн төв”-ийн мэдээллийн системийг хөгжүүлж төрийн мэдээлэл солилцооны “ХҮР” системд холбохоор Засгийн газрын тогтоолын төсөл, холбогдох материалыг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 149 дүгээр тогтоол батлуулсан.

“Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 149 дүгээр тогтоол батлагдсантай холбогдуулан Монгол Улсын бүх суманд цахим үйлчилгээний нэгдсэн төв байгуулах ажлын хүрээнд Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Үйлчилгээний нэгдсэн төвийн мэдээллийн систем” ХХМТГ/201912003 төслийн Багц-1-1 “Цахим үйлчилгээний систем хөгжүүлэх”, Багц-1-2 “Төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем хөгжүүлэх” төслүүдийн сонгон шалгаруулалтыг амжилттай зохион байгуулан ажиллаж байна. Төслийн хэрэгжилтийн хүрээнд “Төрийн Үйлчилгээний нэгдсэн төв”-өөр дамжуулан төрийн байгууллагуудын өмнөөс оператор хэлбэрээр үйлчилгээг үзүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн ба 2019 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр зохион байгуулсан “Дижитал хөгжилд хамтдаа форум”-ын үеэр төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний цахим систем буюу www.mgov.mn порталыг нээж, 25 байгууллагын 181 нэр төрлийн үйлчилгээг дижитал хэлбэрээр үзүүлэхэд бэлэн болсон. Энэхүү систем нь ХҮР, ДАН, Орон зайн өгөгдлийг дундын мэдээллийн сан, Үндэсний төлбөрийн систем, бусад төлбөрийн систем, ebarimt төлбөрийн баримтын систем, esign тоон гарын үсэгтэй холбогдсон. Төв аймгийн Засаг Даргын Тамгын Газартай хамтран тус аймгийн “Үйлчилгээний нэгдсэн төв”-ийг жишиг болгон хөгжүүлэх нөхцөл бололцоог судалсан байна.

Иргэд, аж ахуйн нэгжүүдэд төрийн үйлчилгээг хүргэдэг төрийн захиргааны байгууллагуудад хэрэглэгдэж буй програм хангамжуудыг тэдгээрийн ашигладаг техник, програм хангамж, платформын ялгаатай байдлаас үл хамааран хоорондоо холбогдон, өгөгдөл

мэдээлэл солилцох боломж бүхий “Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем” /www.erp.gov.mn/-г бий болгон хөгжүүлэх замаар төрийн захиргааны байгууллагуудын үйлчилгээг цахимжуулах, мэдээллийн урсгалын зохион байгуулалтыг сайжруулах, нэгдсэн удирдлагатай болгох, төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, ил тод байдлаар хүргэх боломжийг бүрдүүлэн ажилласан байна. (Биелэлт 70 хувь)

4.1.2.1-3. Төрийн байгууллагуудын цахим засгийн тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжүүлэх нэгдсэн удирдлагаар хангах бүтцийг бий болгох /ЗГХЭГ, ХХМТГ, 2020 он/

Арга хэмжээ 2020 онд хэрэгжиж эхэлнэ.

4.1.2.2-1. Зөвшөөрөл, лицензийн тоог эрс цөөлөх, олон шат дамжлагыг багасгах зорилгоор Зөвшөөрлийн тухай хуулийн төслийг боловсруулах /ЗГХЭГ, 2017-2018/

Зөвшөөрлийн тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт 2019 оны 3 дугаар сарын 29-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 19 чиглэлээр 103 ерөнхий төрөл, энэхүү төрөл нь 210 гаруй дэд төрөлд хуваагдан тусгай зөвшөөрөл олгохоор байгаа боловч салбарын бусад хууль тогтоомж, эрх зүйн дэд актаар тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл /олон удаа болон нэг удаагийн шинжтэй/-ийг шинээр бий болгох, ерөнхий төрлийг задалж олгох байдал түгээмэл болсон гэж үзсэн байна.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заагаагүй зөвшөөрлийн чиглэл, төрлөөр зөвшөөрөл олгох харилцаа явагдаж байгаа бөгөөд Монгол Улсын хэмжээнд 2020 оны байдлаар 54 байгууллага 914 төрлийн зөвшөөрөл олгож байна гэсэн судалгаа хийсэн байна. Энэ нь бизнес эрхэлж, үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд дарамт болдог. Үүнтэй холбоотойгоор Аж ахуйн үйл ажиллагааны тухай хуулийг шинэчлэн найруулах хуулийг төслийг боловсруулж хуулийн нэрийг “Зөвшөөрлийн тухай гэж” өөрчлөн санал төсөл өргөн барьсан байна.

Хуулийн төсөл батлагдсанаар хуулиар хориглоогүй, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшлаагүй аливаа үйл ажиллагаа эрхлэх Иргэний хуулийн суурь



үзэл баримтлалыг баталгаажуулж, Монгол Улсын нутаг дэвсгэрт эрхлэхийг хориглосон үйл ажиллагаа болон зөвшөөрлөөр эрхлэх үйл ажиллагаа чиглэл, төрөл, эдгээр харилцаатай холбоотой суурь харилцаа тодорхой болно хэмээн төсөл санаачлагчид үзсэн байна.

Өөрөөр хэлбэл, лицензийн тоог цөөлж, лиценз авдаг олон шат, дамжлагыг багасгах, бизнест ээлтэй эрх зүйн орчинг бүрдүүлэх, үндэсний аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхол, хүн амын эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд хохирол учруулж болзошгүй, орчиндоо аюултай аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх, хязгаарлагдмал нөөц бүхий нийтийн өмч, эрхийг эзэмших, ашиглахад төрөөс зөвшөөрөл олгох, зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, цуцлах, зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд хяналт тавихтай холбоотой харилцаа боловсронгуй болгон гэж үзсэн байна. (Биелэлт 100 хувь)

4.1.2.2-2.Зарим төрлийн зөвшөөрөл олгох, хяналт тавих чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх /ЗГХЭГ, 2018-2022/

Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэн гүйцэтгүүлэх зохицуулалтын дагуу Сангийн сайдын тушаалаар олгодог мэргэшсэн нягтлан бодогчийн эрхийг Мэргэшсэн нягтлан бодогчийн институт ТББ-д, Татварын мэргэшсэн зөвлөхийн үйлчилгээг Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгт, нягтлан бодох бүртгэлийн програм хангамжийн үйлчилгээг Монголын нягтлан бодох бүртгэлийн хүрээлэнд, Засгийн газрын худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх АЗ гэрчилгээ олгох сургалт хийх эрхийг төрийн бус байгууллагуудад тус тус шилжүүлэн ажиллаж байна. Хөрөнгийн үнэлгээний, аудит, татварын мэргэшсэн зөвлөхийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох талаарх сонгон шалгаруулалт, мэргэжлийн байгууллагын санал дүгнэлтийг үндэслэн шийдвэрлэх ажлыг зохион байгуулж Засгийн газрын 2016 оны 165 дугаар тогтоолын дагуу Нягтлан бодох бүртгэлийн болон татварын мэргэшсэн зөвлөхийн үйлчилгээний төрийн зарим чиг үүргийг гүйцэтгэж байгаа Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэг, Монголын нягтлан бодох бүртгэлийн хүрээлэн, аудитын төрийн зарим чиг үүргийг гүйцэтгэж байгаа

Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт, Монголын мэргэшсэн үнэлгээчдийн институттэй гэрээ байгуулан, жил бүр ажлын төлөвлөгөөг баталж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Төрийн захиргааны төв байгууллагуудаас дараах ажил, үйлчилгээг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлж байна. Үүнд:

1. Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/25 дугаар тушаалаар “Эрүүл мэндийн салбарын зарим ажил, үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх журам” батлагдсан бөгөөд төрийн бус байгууллагад тавих нийтлэг шаардлага, шалгуур үзүүлэлтийн төслийг шинэчлэн боловсруулж байна

Төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх үйл ажиллагаанд дараах үйл ажиллагаа хамаарна. Үүнд:

- Эрүүл мэндийн тухай хууль, тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгах;
- Эрүүл зан зан үйл төлөвшүүлэх, эрүүл мэндийн боловсрол олгох мэдээлэл, сургалт, сурталчилгаа;
- Эрүүл мэндийн байгууллагад магадлан итгэмжлэл олгох үйл ажиллагаанд оролцох;
- Эмийг бүртгэх, баталгаажуулах, эмийн чанар, аюулгүй байдлын талаар нийтэд мэдээлэх үйл ажиллагаанд оролцож, санал өгөх;
- Эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага, үйл ажиллагааны стандартын хэрэгжилт, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах, иргэний гомдол, саналын мөрөөр хяналт тавих, үнэлэх үйл ажиллагаанд оролцож санал өгөх.

2. Барилга, хот байгуулалтын яамнаас салбарын хэмжээнд олгогддог тусгай зөвшөөрөл олгох ажлыг төрийн бус байгууллагуудаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх шийдвэр гарч, уг ажил 2 дахь жилдээ амжилттай хэрэгжиж байна. Барилгын салбарт өнөөдрийн байдлаар 4 төрлийн тусгай зөвшөөрөл олгогдож байгаа бөгөөд эдгээрт:

- Барилга байгууламжийн ажил гүйцэтгэх,
- Барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах,
- Барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх,



- Өргөх байгууламж түүний эд ангийн үйлдвэрлэл, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл багтаж байна.
- Барилга, хот байгуулалтын яамнаас “Барилгын материалын үйлдвэрлэгчдийн холбоо” ТББ-г барилгын материал үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийн асуудлыг гэрээгээр гүйцэтгүүлэх эрхийг олгосон бол бусад гурван төрлийн тусгай зөвшөөрлийг “Монголын барилгын үндэсний ассоциаци” ТББ тэргүүтэй найман байгууллагын түншлэлд олгосон.

3. Зам, тээврийн хөгжлийн яамнаас салбарын хэмжээнд Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн хүрээнд хийгдэх ачаа, зорчигч тээвэрлэлтийн зөвшөөрлийн бичгийг солилцох, тээвэрчдэд олгох, тооцоо хийх, хяналт тавих, Автотээврийн салбарын мэргэшсэн болон зөвлөх инженерийн сургалтыг зохион байгуулж, гэрчилгээ олгох ажлыг “Монголын автотээвэрчдийн нэгдсэн холбоо” ТББ-аар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж байна.

Тээврийн хэрэгслийг гаалийн хилээр түр хугацаагаар нэвтрүүлэх таслах хуудас бүхий дагалдах дэвтэр (CPD карней)-ийг олгох, Монгол Улсын нутаг дэвсгэрт уг дэвтэрт тэмдэглэсэн асуудалтай холбогдон үүсэх хариуцлагыг хүлээх, баталгаа гаргах чиг үүргийг Монголын автомашин, мотоциклын спортын холбоогоор гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж байна.

“Авто зам, замын байгууламжийн техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах, барих, арчлах, засварлах, техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажлын тусгай зөвшөөрөл олгох журам”-ын 2.1, 2.2, 2.4, 2.6 болон 2.7 дахь заалтуудад заасан аж ахуйн нэгж, байгууллагуудаас тусгай зөвшөөрөл хүссэн хүсэлтийг хүлээн авах авах, хүсэлтийг ажлын хэсгээр хэлэлцүүлж дүгнэлт гаргах зэрэг эрх үүргийг “Монголын авто замчдын холбоо ТББ”-д шилжүүлсэн бөгөөд тус ТББ-аас ирүүлсэн дүгнэлтийг үндэслэн Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаалаар тусгай зөвшөөрлийг олгож байна. (Биелэлт 30 хувь)

4.1.2.2-3. Төрийн бус байгууллагад шилжүүлсэн төрийн үйлчилгээний үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх; /ЗГХЭГ, ТББ, 2020-2021/

Авлигатай тэмцэх газраас Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд төрийн бус байгууллагад шилжүүлсэн төрийн үйлчилгээний үр дүн, үр нөлөөнд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг “Жи Би Эм социал ресэрч консалтинг” ХХК-иар гүйцэтгүүлж, 2019 онд хүлээн авсан. Төрийн бус байгууллагад шилжүүлсэн төрийн үйлчилгээний үр дүн, үр нөлөөнд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын тайланг төрийн болон төрийн бус байгууллагын хүрээнд хэлэлцүүлж, олон нийтэд танилцуулан үр дүн, түүний мөрөөр авах арга хэмжээний саналыг Засгийн газарт хүргүүлэхээр ажиллаж байна. (Биелэлт 30 хувь)

4.1.2.3-1. Олон улсын стандарт хангасан бараа, бүтээгдэхүүнийг дотоодын стандартаар шалгадаг зохицуулалтыг өөрчлөх, шаардлагагүй стандартыг хүчингүй болгох /СХЗГ, 2018-2020/

Улсын Их Хурлаас Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийг батлан 2018 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс даган мөрдөж байна. Энэ хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 ба 14.7 дахь заалтад Олон улс бүс нутгийн байгууллагаас хүлээн зөвшөөрөгдсөн хүчин төгөлдөр аюулгүйн тэмдэг баталгаатай бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх, экспортод гаргах, импортоор оруулахад хяналт тохирлын үнэлгээнд давтан хамруулахгүй байхаар тусгасан.

Улсын Их Хурлаас Хэмжил зүйн тухай хуулийг 2019 оны 5 дугаар сарын 09-ний өдөр баталсан бөгөөд уг хуулийн 9 дүгээр зүйлийн 9.7-д Хууль эрхийн хэмжил зүйн Олон улсын байгууллага /OIML/, зохих гэрээ хэлэлцээр байгуулсан гадаад орны хэмжил зүйн төв байгууллагаас загварыг баталж, гэрчилгээ олгосон тохиолдолд хэмжих хэрэгслийн загварын туршилтыг давтан хийхгүйгээр хүлээн зөвшөөрөхөөр тусган мөрдөж байна.

“Хүйсийн тэгш эрхийн төв” ТББ-тай 2019 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид тусламж, үйлчилгээ үзүүлдэг Нэг цэгийн үйлчилгээний төвийн аюулгүй байдал болон хууль зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээний стандартын төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээ (дугаар 148) байгуулан, стандартын төслийг



боловсруулан, 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдөр урьдчилсан хэлэлцүүлэг зохион байгуулж, холбогдох байгууллагуудаас санал авч, нэгтгэсэн байна. (Биелэлт 70 хувь)

4.1.2.3-2. Стандартын тоог цөөрүүлэх, шаардлагагүй стандартыг хүчингүй болгох; СХЗГ, ХЗДХЯ 2018-2020/

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 12.1, 5.1, 5.2-д “Иргэн аж ахуйн нэгж, байгууллага стандартчиллын баримт бичгийг сонгон хэрэглэнэ” гэж тусган, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн аюулгүй байдлыг хангах, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах техникийн зохицуулалтыг нийтээр заавал дагаж мөрдөж бусад стандартыг сонгон хэрэглэх зохицуулалтыг тусгасан байна. Монгол Улсын хэмжээнд нийт 6421 стандартыг мөрдөж байна Стандартын тоог цөөрүүлэх, шаардлагагүй стандартыг хүчингүй болгох зорилтын хүрээнд 2019 онд 72 стандартыг хүчингүй болгож, 4 стандартад нэмэлт өөрчлөлт оруулан, 34 стандартыг шинэчилсэн байна.. (Биелэлт 70 хувь)

4.1.2.4-1. Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх талаар хууль тогтоомжийг боловсронгуй болгох /ЗГХЭГ, МХЕГ, ТЕГ 2018-2019/

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг гүнзгийрүүлэн төлөвшүүлэх замаар авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгож “Мэргэжлийн хяналт шалгалтын ерөнхий шаардлага” стандартад эрсдэлд суурилсан хяналт шалгалтын хяналтын хэлбэрүүдийг нарийвчлан тогтоож, тандалт судалгаа, хяналт шинжилгээ, урьдчилан сэргийлэх хяналт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээг шалгалттай хослуулан хэрэгжүүлэх замаар аюул, эрсдэлийг удирдах хяналтын тогтолцоог хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэн шинэчлэн боловсруулж МХЕГ-ын даргын 2019 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн А/67 дугаар тушаалаар баталлаа.

Тус журам, заавраар улсын байцаагч зөвхөн зөрчил илрүүлээд торгох, хаах биш илэрсэн зөрчил, шаардлага хангаагүй асуудлаар судалдаг, зөвлөгөө өгдөг байх зохицуулалтыг

бий болгосон. Ингэснээр бизнес эрхлэгчид мэргэжлийн хяналтын байгууллагад хүсэлт гаргаж зөвлөгөө авах эрмэлзэлтэй боллоо.

Хяналт шалгалтын объектыг эрсдэлийн ангилалд хамааруулах 40 шалгуур, үзүүлэлтийг шинэчлэн боловсруулах ажлыг зохион байгуулж, Засгийн газрын тогтоолоор батлуулахаар 2019 оны 08 дугаар сарын 01/2612 албан бичгээр Шадар сайдын ажлын албанд хүргүүлсэн.

МХЕГ-ын даргын зөвлөлийн хурлын шийдвэрт үндэслэн хяналт шалгалтын объектод 2019 оны эрсдэлийн үнэлгээг хийж, эрсдэлийн ангилалд хамаарах объектын жагсаалтыг Шадар сайдын 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 113 дугаар тушаалаар баталсан.

Эрсдэл их үнэлэгдсэн объектын тоог 2018 оныхтой харьцуулж үзэхэд хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлж буй сөрөг нөлөөлөл их үнэлэгдсэн объектын тоо 187-оор буурч, эрсдэл үүсэх магадлал багатай объектын тоо 2085-аар нэмэгдсэн дүнтэй гарчээ.

Мэргэжлийн хяналтын байгууллагаас эрсдэл өндөртэй үнэлэгдсэн 14193 объектыг 2020 онд төлөвлөгөөт шалгалтад, зөвлөн туслах үйлчилгээнд 6392 объектыг хамруулахаар төлөвлөж МХЕГ-ын даргын 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/159 дугаар тушаалаар баталсан. Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын төлөвлөгөөг олон нийтэд 12 дугаар сарын 1-ний өдөр хуулийн хугацаанд [khyanal.gov.mn](http://khyanal.gov.mn), [shienkhyanal.gov.mn](http://shienkhyanal.gov.mn) цахим системээр, [inspection.gov.mn](http://inspection.gov.mn) цахим хуудсаар зарлалаа.

Мэргэжлийн хяналтын байгууллагын 2019 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийг тооцоход нийт зөвлөн туслах үйлчилгээнд хамрагдах объектын 96.8 хувь, хяналт шалгалтад хамрагдах объектын 98.8 хувийг тус тус хамруулсан байна. Эдгээр төлөвлөсөн объектуудад хяналтын чиглэлээр давхардсан тоогоор нийт 6990 зөвлөн туслах үйлчилгээ, 14720 шалгалт хийхээр төлөвлөснөөс, зөвлөн туслах үйлчилгээний гүйцэтгэл 97.2 хувь, төлөвлөгөөт шалгалтын гүйцэтгэл 98.6 хувьтай биелсэн байна. 2019 онд төлөвлөсөн их дунд эрсдэлтэй үнэлэгдсэн объектуудад хяналт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж, нийт 233 хяналтын хуудаснаас тухайн онд 227 хяналтын хуудсаар үнэлэхэд 16.9 хувь нь их, 41.3 хувь нь дунд, 41.8 хувь нь бага эрсдэлтэй үнэлэгдэж,

нийт 21249 объектоос 8304 объектын эрсдэл буурч, 8332 объектод хууль сахин мөрдөлт өссөн үзүүлэлттэй байна. Мөн хяналтын хуудсаар үнэлэгдсэн объектуудын эрсдэл үүсэх магадлалын хувь 2018 онд 36.4 хувьтай байсан бол 2019 оны 35.хувь болж 0.5 пунктээр буурч, харин салбарын хууль сахин мөрдөлтийн түвшин 2018 онд 63.26 хувь байсан бол 2019 оны жилийн эцсийн байдлаар 63.30 хувь болж 0.4 пунктээр өссөн эерэг үзүүлэлттэй байна. Хяналт шалгалтын явцад хяналтын хуудсаар 291'034 зөрчил илрүүлснээс 98'722 зөрчлийг гүйцэтгэлийн хяналтаар арилгасан байна.

Улсын байцаагчдын 2019 оны хяналт шалгалтад хэрэглэх шинээр 17, шинэчилж 100 хяналтын хуудсыг боловсруулж, МХЕГ-ын даргын 2019 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн А/25 дугаар тушаалаар батлуулан, хяналт шалгалтад ашиглалаа.

Мөн “нэг удаагийн нийлэг хальсан уутыг хориглох тухай” Засгийн газрын 189 дүгээр тогтоол гарсантай холбогдуулан Сав, баглаа, боодол импортлох үеийн хяналтын хуудсанд нэмэлт, өөрчлөлт оруулж МХЕГ-ын даргын 2019 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А/43 тушаалаар батлуулан, хилийн хяналт шалгалтад ашигласан.

Хилийн эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг боловсронгуй болгох зорилгоор Дэлхийн банк групп Олон улсын санхүүгийн корпорацийн санхүүжилтээр ГЕГ-тай хамтран Баян-Өлгий аймгийн Цагааннуур, Замын-Үүд, Алтанбулаг, Сүхбаатар, Буянт-Ухаа боомт болон АБТЭМА, Монголтранс гүний терминалын 10 дугаар сарын 3740 ачилт дээр олон улсын аргачлалын дагуу “TRS” судалгаа хийж, гадаад худалдаанд зарцуулж буй цаг хугацааг тодорхойлоо.

Судалгааг хэрэгжүүлэхийн тулд 8 боомт, гүний терминалын бизнес процессын зураглалыг гаргаж, 16 төрлийн цаг хугацааг тодорхойлох асуумжийг боловсруулж, улсын байцаагч, судлаачдыг бэлтгэх олон улсын зөвлөлтэй сургалтыг зохион байгуулж, мэдээллийг Олон улсын Гаалийн байгууллагын цахим системд бүртгэж, боловсруулалт хийлээ.

Хяналт, бүрдүүлэлт хийгдэж буй бүхий л шатанд зарцуулсан цаг хугацааны бодит мэдээлэлд үндэслэн хил дээрх хяналтын байгууллагуудын ачаалал, оролцогч байгууллагуудтай холбоотой саад тотгорыг багасган, бүс нутаг, олон

улсын түвшинтэй харьцуулж үнэлэн, үр нөлөөг хэмжих суурь үзүүлэлтийг тогтоож, хяналт шалгалтын үр ашгийг нэмэгдүүлснээр Дэлхийн худалдааны байгууллагын “Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр”-т заасан үүргээ хэрэгжүүлэх нөхцөл бүрдэх юм.

Аж ахуйн нэгж, байгууллагуудад эрсдэлд суурилсан хяналт шалгалтын мэдээллийг ил тод, цахимаар хүргэж аюул эрсдэлийг удирдах зорилгоор “Шилэн хяналтын цахим систем” <http://shilenkhyanal.gov.mn>-д тоон гарын үсгээр нэвтэрч Мэргэжлийн хяналтын байгууллагаас аж ахуйн нэгж, байгууллагад хийх хяналт шалгалтын төлөвлөгөө, илэрсэн зөрчил, авсан арга хэмжээ, лабораторийн шинжилгээний дүн, эрсдэлийн үнэлгэний мэдээллийг авах боломжтой болгож хөгжүүлээ.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг нэвтрүүлээд 10 жил, Шилэн хяналтын цахим системийг нэвтрүүлээд 5 жил болсон тул цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийж, эрсдэлийн төлөв байдлыг Шадар сайдын 2014 оны 87 дугаар тушаалаар баталсан “Мэргэжлийн хяналтын байгууллагын эрсдэлийн удирдлагын стратеги”-т заасны дагуу олон нийтэд /100 оролцогчтой/ танилцууллаа.

“Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 86-д Дотоод аудитын тухай анхдагч хуулийн төслийг Засгийн газраас санаачлан боловсруулахаар заасны дагуу Сангийн сайдын 2017 оны 236, 309 тоот тушаалаар байгуулсан ажлын хэсэг хуулийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр эцсийн найруулгыг хийж байна.

Санхүүгийн зохицуулах хороо, Даатгалын байгууллагууд өөрийн чанарын эрсдэлийн үнэлгээг хийх аргачлалыг (Own risk solvency assessment-ORSA) нэвтрүүлэх бэлтгэл ажил, эрсдэлд суурилсан хөрөнгө буюу тоон үзүүлэлтийн үнэлгээг (Risk Based Capital-RBC)-г нэвтрүүлэх талаар судалгаа хийж, тусгай зөвшөөрөлтэй зохицуулалттай 22443 этгээд, даатгалын 18 компаниудын хөрөнгийн хүрэлцээт байдал, төлбөрийн чадварыг оновчтой тогтоох, нөөцийн санг тооцох аргачлалыг боловсруулан 2018, 2019 онд үнэлгээ хийсэн.



Даатгалын компанид учирч болох эрсдэлийг урьдчилан таамаглаж тогтоох, үүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор даатгалын зохицуулалтын байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих хяналтыг боловсронгуй болгоход эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог бий болгохоор Дэлхийн банкны болон Люксембургийн төслийн зөвлөхүүдтэй хамтран ажиллаж, холбогдох саналуудыг тусгасан “Даатгагчийн үйл ажиллагаанд зайнаас хяналт тавих журам”, “Даатгалын компанийн үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан хяналт шалгалт хэрэгжүүлэх журам”-уудын төслийг боловсруулаад байна. Хадгаламж зээлийн хоршоодын эрсдэлийг үнэлсэнээр, өндөр түвшиний эрсдэлтэй хоршоодод хугацаатай үүрэг даалгавар болон холбогдох зөвлөмжийг хүргүүлсэн бөгөөд мөн маш өндөр эрсдэлийн түвшинтэй буюу өөрийн хөрөнгөгүй болсон хоршоодод тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох нөхцөл бүрдсэн болохыг мэдэгдэх, газар дээрх хяналт шалгалтын төлөвлөгөөнд оруулах гэх мэт холбогдох арга хэмжээнүүдийг авч ажилласан байна.

ОУВС-ын аргачлалын дагуу Мөнгө угаах, терроризмийг санхүүжүүлэх эрсдэлийн индикаторуудыг тодорхойлж, асуулга, судалгааны төсвийг боловсруулан, нийт зохицуулалттай этгээдүүдийг хамруулсан судалгааг өрнүүлээд байна. Судалгааны үр дүнг нэгтгэн боловсруулсан. Тус судалгааны аргачлалыг журмын хавсралтаар баталсан ба судалгааны үр дүнд үндэслэн өндөр эрсдэлтэй байгууллагуудад газар дээрх хяналт шалгалт хийхээр төлөвлөгдөж байна. Хэрэглээний зээлийн хувьд зээлдэгчийн өр, орлогын харьцааг 70 хувиар, зээлийн хугацааг 30 сараас хэтрүүлэхгүй байх шийдвэрийг арилжааны банкуудын хувьд хэрэгжүүлсэнээр зээл шилжих эрсдэл байгаа эсэхийг судлах, уг шийдвэрийг банк бус санхүүгийн байгууллагуудын хувьд хэрэгжүүлэх боломж байгаа эсэхийг Монголбанкны Мөнгөний бодлогын газартай хамтран судалгаа хийсэн.

Мөн БНСУ-ын “Knowledge sharing program” буюу мэдээлэл солилцох хөтөлбөрийн хүрээнд эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хөгжүүлэх чиглэлээр холбогдох судалгаа хийсэн.

Банк бус санхүүгийн байгууллагуудын болон хадгаламж зээлийн хоршоодын санхүүгийн үзүүлэлт дээр тулгуурлан эрсдэлийн

зэрэглэлийг тогтоох аргачлалыг боловсруулсан. Тус аргачлалыг боловсронгуй болгох хүрээнд их сургуулийн багш, судлаач нартай хамтран ажиллаж, зөвлөгөө аван санал солилцохоор төлөвлөж байна.

Хадгаламж зээлийн хоршооны салбарт эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг нэвтрүүлэх чиглэлээр Зайны хяналтын журам, эрсдэлийн үнэлгээ хийх гарын авлагын төслийг боловсруулж байна. Эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан өндөр эрсдэл бүхий ХЗХ-дод авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан биелэлтийг гаргасан. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд нэгдсэн хяналт шалгалтын эрх зүйн орчны талаар зүйл заалтууд оруулаад байна.

Банкнаас бусад хадгаламж татдаг санхүүгийн байгууллагуудад эрсдэлд суурилсан хяналт шалгалтын аргачлал боловсруулахтай холбоотой Монгол Улсын хадгаламж татдаг байгууллагуудын өнөөгийн нөхцөл байдал, хяналт, зохицуулалтын орчны талаар судалгааг гүйцэтгэсэн.

Хяналт шалгалтын аргачлалыг эрсдэлд суурилсан хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд Хадгаламж зээлийн хоршооны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтэд тулгуурлан эрсдэлд нөлөөлөх 11 санхүүгийн голлох үзүүлэлтүүдийг тогтоож, нийт 290 ХЗХ-дын сүүлийн 8 улирлын тайлан мэдээ нь дээр үндэслэн эрсдэлийн шинжилгээ хийсэн бөгөөд улмаар Хадгаламж зээлийн хоршоо тус бүрийн эрсдэлийн хандлага болон эрсдэлийн шалтгааныг тодорхойлж, эрсдэлийг нь 5 түвшинд ангилан, үнэлэлт дүгнэлт өгч холбогдох санал, зөвлөмжийг боловсруулсан. ХЗХ-дын эрсдэлийг үнэлсэнээр өндөр түвшний эрсдэлтэй хоршоодод хугацаатай үүрэг даалгавар болон холбогдох зөвлөмжийг хүргүүлсэн бөгөөд маш өндөр эрсдэлийн түвшинтэй буюу өөрийн хөрөнгөгүй болсон ХЗХ-дод тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох нөхцөл бүрдсэн болохыг мэдэгдэх, газар дээрх хяналт шалгалтын төлөвлөгөөнд оруулах гэх мэт холбогдох арга хэмжээнүүдийг авч ажиллав.

“Санхүүгийн зохицуулах хорооны дотоод аудитын гарын авлага”-ыг боловсруулсан.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг

хангуулах зорилгоор 2018 оны 4-7 саруудад Улаанбаатар хот, орон нутагт нэгдсэн шалгалт хийж, тус шалгалтад Хорооны зохицуулалт бүхий мэдээлэх үүрэгтэй этгээдүүдийг 100 хувь хамруулав. (Биелэлт 100 хувь)

4.1.2.4-2. Аж ахуйн нэгжийн дотоод хяналтын стандартыг шинээр боловсруулж нэвтрүүлэх /ЗГХЭГ, МХЕГ, СХЗГ, ТӨБЗГ 2018-2020/

Стандарт, хэмжил зүйн газраас аж ахуйн нэгжийн дотоод хяналтын стандартыг шинээр боловсруулж нэвтрүүлэх (2018-2020) ажлын хүрээнд Менежментийн стандартчиллын техникийн хорооны ажлын төлөвлөгөөнд ISO 19011 стандартыг шинэчлэх төслийг боловсруулан, гадаад улс орнуудын ижил төстэй стандарт, техникийн баримт бичгийг судлах, шүүлт хийх ажлыг хийж гүйцэтгэсэн. Стандарт боловсруулахад хяналтын байгууллагын оролцоо, дэмжлэг, стандартын хэрэгжилтийг хангуулахад анхаарах асуудлуудаар Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, 21 аймгийн Мэргэжлийн хяналтын хэлтсийн хүнсний болон үйлчилгээний, хэмжилзүйн, байгаль орчны 510 улсын байцаагчдыг хамруулж, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн төрийн хяналтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг мэдээллийг олгосон байна.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар нь дотоод хяналтыг төлөвшүүлэх чиглэлээр тодорхой алхмуудыг хэрэгжүүлж ажиллалаа. Үүнд:

Байгууллагын дунд хугацааны төлөвлөгөөний 3.2-ийн 10 дугаар зорилго, Эрсдэлийн удирдлагын стратегийн 2.1.2 заалтын хүрээнд хэрэглэгч, бизнес эрхлэгчид хуулийг сайн дураар сахин биелүүлэх соёлыг хэвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор “Дотоод хяналтын соёлыг нэвтрүүлэх”-д хамтран ажиллах 30 байгууллагыг 21 аймаг, нийслэлийн бизнес эрхлэгчдээс сонгож, хамтран ажиллах санамж бичиг байгуулаа. Улсын хэмжээнд 30 түшиц байгууллага бэлтгэж, эдгээр байгууллагууд бусад байгууллагуудыг манлайлж ажиллах юм.

2019 онд Дундговь, Дорнод, Дархан-Уул, Говьсүмбэр, нийслэлийн аж ахуйн нэгж, байгууллагын дотоод хяналт хариуцсан 525 ажилтнуудад 11 удаагийн сургалтыг МХЕГ-

ын даргын баталсан хөтөлбөр, удирдамжийн дагуу зохион байгуулж, дотоод хяналт шалгалт хийх арга зүй эзэмшихэд нь дэмжлэг үзүүллээ. (Биелэлт 30 хувь)

4.1.2.4-3. Хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, хяналт шалгалтын чиглэлийг цөөрүүлэх /ЗГХЭГ, МХЕГ 2018-2022/

Мэргэжлийн хяналтын газраас шалгалтын объектуудад эрсдэлийн үнэлгээ хийсэн. Нийт объектуудыг эрсдэлийн түвшингээр ангилан хяналт шалгалтыг хамгийн их эрсдэл ихтэй объектуудад шалгалтын ажил хийж шалгалтын тоог цөөрүүлэхээр ажиллаж байна. “Мэргэжлийн хяналтын байгууллагаас 2019 онд төлөвлөгөөт хяналт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх ажлын төлөвлөлт хийх аргачлал”-ыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2018 оны А/172 дугаар тушаалаар батлуулав. Мэргэжлийн хяналтын байгууллагаас 2019 онд эрсдэлийн үнэлгээнд хамрагдсан 140519 объектоос их, дунд үнэлэгдсэн хяналтын чиглэлээр давхардсан тоогоор 10100 объектыг төлөвлөгөөт шалгалт, 5613 объектыг зөвлөн туслах үйлчилгээнд хамруулахаар төлөвлөгөө гарган ажилласан. Мөн 2019 онд бусад хяналтын 5 хэлбэрээр 178 ажил хэрэгжүүлэхээр төлөвлөж олон нийтэд зарласан.

Мэргэжлийн хяналтын байгууллага зөвхөн шалгалтын хэлбэрийг ашиглаж, улсын байцаагч торгох, хаах албадлагын аргыг хэрэглэдэг байсан. Иймд шалгалтаас гадна “Зөвлөн туслах үйлчилгээ”, “Салбарын сургалт”, “Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт”, “Баталгаажуулах үйл ажиллагаа”, “Тандалт судалгаа”, “Хяналт шинжилгээ” гэсэн 6 хяналтын хэлбэрийг хэрэгжүүлэх замаар хяналт шалгалтыг хэрэгжүүлэх чиглэлээр журам, заавруудыг боловсруулан мөрдөж байна. Тус журам, заавраар улсын байцаагч зөвхөн зөрчил илрүүлээд торгох, хаах биш илэрсэн зөрчил, шаардлага хангаагүй асуудлаар судалдаг, зөвлөгөө өгдөг байх зохицуулалтыг бий болгосон. Ингэснээр бизнес эрхлэгчид мэргэжлийн хяналтын байгууллагад хүсэлт гаргаж зөвлөгөө авах эрмэлзэлтэй боллоо.

Урьдчилан сэргийлэх хяналтыг хэрэгжүүлэх хүрээнд мэргэжлийн хяналт шалгалтаас гадна аж ахуйн нэгж, байгууллагын дотоод



хяналт, хэрэглэгчийн хяналт хамтын хяналтын хэлбэрийг нэвтрүүлж эхлэв. Аюул эрсдэл, хордлого, халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлэх үүргийг зөвхөн улсын байцаагчийн үүрэг, хариуцлага гэж ойлгож, бизнес эрхлэгчид улсын байцаагчийг аргалахад л болно гэсэн хандлагыг бий болгож байсан. Энэ нь бизнес эрхлэгчид хяналтын байгууллага, улсын байцаагчийг хяналт шалгалтаар ирэх үед л бэлтгэлээ хангаж бусад үед хяналтгүй байсантай холбоотой. Иймд Мэргэжлийн хяналтын байгууллагын эрсдэлийн удирдлагын стратегитай болсон. Энэ стратегитай болсноор зөвхөн улсын байцаагч бизнес эрхлэгч дээр очиж эрсдэл, аюулыг бууруулах биш аж ахуйн нэгж байгууллагын дотоод хяналт, хэрэглэгчийн хяналтыг нэмэгдүүлэх зохицуулалтыг бий болгосон. Хэрэглэгч, үйлчлүүлэгч өдөр тутам бараа, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээ худалдан авахдаа байнгын хяналт тавьж, шаардлага хангасан эсэхийг хянах 15 “Хэрэглэгчийн хяналтын хуудас”-ыг бий болгосон. Ингэснээр хэрэглэгч, үйлчлүүлэгчид аюулгүй бөгөөд чанартай эсэхийг хянах мэдлэг, чадвартай болж, тодорхой эрсдэлийг хуваалцаж, бизнес дээр улсын байцаагчийн адил хяналт тавьдаг болно. Ингэснээр улсын байцаагч төдийгүй хэрэглэгч бүрийн хяналт дор аюулгүй байдлаа хангаж ашиг орлоготой ажиллахад нөлөөлж байна. Хэрэглэгч нь худалдан авч буй бараа, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээнээс үүсч болох аливаа эрсдэлийг тооцон сонголтоо зөв хийж чадаж байгаа эсэхэд тандалт судалгаа хийх 2018 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 01/269 удирдамжийг МХЕГ-ын даргаар батлуулан Өвөрхангай аймаг, Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт судалгааны ажил хийсэн. Тус судалгааны ажлын үр дүнд хэрэглэгч аюулгүй, чанартай бараа, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээг худалдан авахад анхаарах асуудлын жагсаалтыг гаргаж, олон нийтэд мэдээлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

Санхүүгийн зохицуулах хороо нь 2018 онд 1089, 2019 онд 1022 зохицуулалттай этгээдэд хяналт шалгалт хийж, хуулийн этгээдийг урьдчилан сэргийлэх зорилгоор газар дээр нь хяналт шалгалтыг хийсэн байна.

2019 онд Мэргэжлийн хяналтын байгууллагын “Улсын байцаагчийн жилийн ажлын хөдөлмөрийн жишиг норматив”-ыг боловсруулан МХЕГ-ын даргын 2019 оны 08

сарын 12-ны өдрийн А/113 дугаар тушаалаар баталсан. Энэхүү тушаалаар нэг хяналтын чиглэлийн улсын байцаагчийн жилийн ажлын жишиг нормативыг тогтоож, МХЕГ-ын улсын байцаагч шалгалтыг жилийн ажлын хүн өдрийн 30 хувь, бусад хүн өдрүүдэд эрсдэлээс урьдчилан сэргийлэх хяналт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээ, тандалт судалгаа, хяналт шинжилгээ, сургалтууд зохион байгуулах болон бодлого боловсруулах ажил үйлчилгээнд зарцуулахаар тогтоосон байна.

Мэргэжлийн хяналтын байгууллагаас 2020 онд аюул, эрсдэлийг тодорхойлох “тандалт судалгаа”, аюулыг хянаж бууруулах зорилгоор “хяналт шинжилгээ”, хууль бус үйл ажиллагаа, зөрчлийг таслан зогсоох зорилгоор “урьдчилан сэргийлэх шалгалт”, нийтлэг илэрсэн зөрчлийг арилгах зөвлөгөө зөвлөмж өгөх зорилгоор “салбарын сургалт”, үйл ажиллагаа эхлэхээс өмнө урьдчилсан хяналт хийж дүгнэлт гаргах, баталгаажуулах үйл ажиллагаа гэсэн 5 хэлбэрээр 10 зорилтын хүрээнд 158 ажил хэрэгжүүлэхээр төлөвлөж МХЕГ-ын даргын 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/159 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан байна. Төлөвлөгөөт шалгалтад хамруулахаар төлөвлөсөн объектын тоо 2019 онтой харьцуулахад 527 объектоор буурсан байна.

Тандалт судалгаа, хяналт шинжилгээний ажлыг үр дүнтэй, шинжлэх ухааны үндэслэлтэй явуулахын тулд “Тандалт судалгаа, хяналт шинжилгээ хийх аргачлал”-ыг 2019 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр А/123 дугаар тушаалаар шинэчлэн батлуулж мөрдсөн байна.

Стандарт, хэмжил зүйн газраас алт, үнэт металлын сорьцын төрийн хяналт шалгалтыг Стандарт, хэмжил зүйн газрын Үнэт металлын сорьцын хяналтын газраас гүйцэтгэдэг бөгөөд тайлант хугацаанд 131000 үнэт эдлэлд сорьцын хяналтын баталгаажуулалтыг хийж, 270 орчим худалдааны цэг, 12 аймгийн 30 суманд 100 алт олборлогч аж ахуйн нэгж, 70 орчим нөхөрлөл (5000 орчим бичил уурхайчид)-ийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх зорилготой хяналт шалгалтыг явуулсан байна. (Биелэлт 30 хувь)

4.1.2.5-1. Төрийн үйлчилгээний шударга, ил тод, нээлттэй байдлын талаарх судалгаа хийж, үр дүнг үйл ажиллагаандаа ашиглах / АТГ, 2017-2022/

Авлигатай тэмцэх газар нь Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-т заасны дагуу “авлигын хэлбэр, цар хүрээ, шалтгааныг 2 жилд нэгээс доошгүй удаа судлан авлигын индексийг гаргаж олон нийтэд мэдээлэх”; мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.7-д заасны дагуу “төрийн үйлчилгээ авсан иргэд, байгууллагын судалгаанд тулгуурлан төрийн байгууллагын шударга байдлын түвшинд 2 жил тутамд үнэлгээ гаргаж, олон нийтэд мэдээлэх” чиг үүргийг хэрэгжүүлдэг. Төрийн байгууллагыг авлигаас ангид байлгах, урьдчилан сэргийлэх, авлига үүсэх шалтгаан нөхцөлийг арилгах чиглэлд хэрэгжүүлж буй үйл ажиллагааны нэг хэлбэр нь шударга байдлын үнэлгээний судалгаа юм. Төрийн байгууллагын шударга байдлын судалгааг 2016, 2018, 2019 онд зохион байгуулсан бөгөөд үр дүнг авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд ашиглаж байна.

Шударга байдлын үнэлгээгээр төрийн байгууллагаас үйлчилгээ авсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөллийг хамруулдаг бөгөөд шударга байдлын үнэлгээний дэд үзүүлэлт болох ил тод, хариуцлагатай байдлын индексийн оноо 2016 онд 57.5, 2018 онд 56.5, 2019 онд 61.6 гарсан нь 2018 оны дүнгээс 5.1 пунктээр, 2016 оныхоос 4.1 пунктээр тус тус нэмэгдсэн эерэг үзүүлэлттэй байна.

Шударга байдлын үнэлгээний үр дүнг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 9.9-д “Авлигатай тэмцэх газраас гаргасан шударга байдлын түвшингийн үнэлгээ нь захиргааны байгууллагын үнэлгээний нэг үзүүлэлт болно.” гэж заасны дагуутөрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд ашиглах шалгуур үзүүлэлт болгон ашиглаж байна.

АТГ-ын ажлын баг бүх яам, агентлаг, аймаг, нийслэл, дүүрэг, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн

оролцоотой аж ахуйн нэгжид ажиллах явцад төрийн үйлчилгээний ил тод, нээлттэй байдлыг хангах талаар фокус ярилцлага хийж, холбогдох судалгааг зохион байгуулсан.

Сангийн яам нь мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор Шилэн дансны тухай хууль болон “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын хэрэгжилтийг хянахад shilendans.gov.mn хуудсанд 2018, 2019 онд 4 газар 22 мэдээлэл байршуулжээ. (Биелэлт 100 хувь)

4.1.2.6-1. Монгол Улсын иргэн бүрт цахим гарын үсэг олгох /ХХМТГ, 2017-2022/

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2014 оны 09 дүгээр сарын 30-ний өдрийн 45 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Цахим гарын үсгийн нийтийн түлхүүрийн дэд бүтцийн журмуудад заасны дагуу тоон гарын үсгийн гэрчилгээ олгох хувийн түлхүүрийг олгосон.

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2017 оны А/36 дугаар тушаалаар байгуулсан “Нийтийн түлхүүрийн дэд бүтцийг ашиглах бодлогын чиглэл, холбогдох журмын хэрэгжилтэд санал, дүгнэлт гаргах” ажлын хэсгээс төрийн байгууллагуудад тоон гарын үсэг олгох үйл ажиллагааг гэрээгээр гүйцэтгүүлэхээр дүгнэлт гаргасны дагуу төрийн байгууллагуудад Төрийн гэрчилгээжүүлэх байгууллагатай бүртгэлийн нэгжийн гэрээ байгуулан тоон гарын үсэг олгох нөхцөлийг бүрдүүлсэн.

Төрийн байгууллагуудын үйл ажиллагаа, цахим албан хэрэг хөтлөлтөд тоон гарын үсэг ашиглахтай холбогдуулан тоон гарын үсгийн тэмдэглэгээний хэлбэржилтийг боловсруулж, Нийслэлийн мэдээллийн технологийн газар, “Монпасс СА” ХХК, Нийслэлийн архивын газарт тус тус хүргүүлж, хэрэглээнд нэвтрүүлэв. Засгийн газрын 2016 оны 151 дүгээр тогтоол, Төрөөс баримтлах бодлогын чиглэлийн дагуу “Үндэсний дата төв” ҮТҮГ-ийг төрийн албан хаагчдад тоон гарын үсгийн гэрчилгээ олгогч байгууллагаар ажиллуулж, 2018 онд төрийн 765 албан хаагчдад тоон гарын үсэг олгож, нийслэлийн хэмжээнд 545 албан хаагч тоон гарын үсгийг ашиглаж, 2019 онд төрийн 43 байгууллагын 940 ажилтанд тоон гарын үсэг



олгож, нийслэлийн 8 байгууллагын 85 ажилтанд тоон гарын үсэг олгосон байна. Тухайлбал; Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар, Нийслэлийн Хот Төлөвлөлт хөгжлийн газар, Нийслэлийн Татварын Газар, Нийслэлийн Газрын Алба, Нийслэлийн Нийгмийн Халамжийн Газар, Нийслэлийн Хөдөлмөр Эрхлэлтийн Газар, Нийслэлийн Хөрөнгө Оруулалтын Газар, Нийслэлийн Орон Сууцны Корпораши ХК зэрэгт олгосон.

Мөн Харилцаа холбоо, мэдээллийн технологийн байгууллага бүр дээр тоон гарын үсгийн талаар ойлголт өгөх, хэрэглээг нэвтрүүлэх чиглэлээр танилцуулга сургалтыг тогтмол явуулж байна. Тоон гарын үсэг ашигладаг төрийн захиргааны албан хаагчдын тоо 60 хувиар өссөн.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар нь 40 удирдах ажилтанд тоон гарын үсгийн төхөөрөмж авч, удирдамжийг тоон гарын үсгээр баталгаажуулах, тайлангийн модулийг сайжруулах ажлыг хийж байна. 2018 оны 3 дугаар сард Мэргэжлийн хяналтын системийн нийт ажилтнуудад Интерактив ХХК-тай хамтран онлайн сургалтыг зохион байгуулж, цахим системийн хяналт шалгалтын сайжруулсан модулийг ашиглалтад оруулснаас гадна шалгалтын удирдамжийг тоон гарын үсгээр баталгаажуулдаг болсон.

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан иргэний үнэмлэхэд тоон гарын үсгийг бичих ажлын хүрээнд Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газарт иргэний цахим үнэмлэхэд 2048 битийн тоон гарын үсгийн гэрчилгээ суулгах туршилтын ажлыг зохион байгуулж, тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон “Үндэсний дата төв” ҮТҮГ-тай хамтран тоон гарын үсгийн гэрчилгээний дундын санг бий болгосон ба гэрчилгээ олгогч байгууллагууд гэрчилгээний мэдээлээ тухай бүр оруулсны дүнд 2019 оны байдлаар тус санд 18596 ширхэг тоон гарын үсгийн гэрчилгээний мэдээлэл байна.

Тоон гарын үсэг ашиглах нэгдсэн хэрэглэгчийн програм хангамж /Esign client/ -ийг хөгжүүлж, гэрчилгээ олгогч байгууллагуудын ашиглаж байгаа е-Токен төхөөрөмжүүдийн драйверуудыг нэгтгэж, ашиглаж эхлээд байгаа бөгөөд төхөөрөмжийн үнэ 30-50 хувиар буураад байна.

Төрийн албан хаагчдын тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэхээр төлөвлөн ажиллаж байгаа ба одоогийн байдлаар 1960 албан хаагч тоон гарын үсэг ашиглаж байгааг ирэх онд 3300 болгох зорилттой ажиллаж байна. (Биелэлт 70 хувь)

4.1.2.6-2. Төрийн байгууллагуудын албан ёсны цахим хуудсаар иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах журмыг боловсруулж мөрдүүлэх /ХХМТГ, ЗГХЭГ, ХЗДХЯ, 2018 он/

Ухаалаг засаг төслийн санхүүжилтээр иргэдэд үйлчлэх лавлах төвийн үйл ажиллагааг дэмжих техникийн зөвлөх үйлчилгээ төсөл болон иргэдийн санал хүсэлт хүлээн авах лавлах төвийн системийг шинэчлэн хөгжүүлэх, нэвтрүүлэх төсөл, мөн иргэдийн санал хүсэлтийн мэдээлэлд бизнес анализ хийх дотоодын зөвлөх болон бизнес аналитикийн систем нэвтрүүлэх төслүүдийг хэрэгжүүлэх, холбогдох сургалтыг зохион байгуулахаар төлөвлөн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар ажиллаж байна. Зөвлөх үйлчилгээний төслийн үр дүнг харгалзан төрийн байгууллагуудын албан ёсны цахим хуудсаар иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах журмын төслийг боловсруулж байна. (Биелэлт 30 хувь)

4.1.2.6-3. Авлигатай тэмцэх газрын гомдол мэдээлэл хүлээн авах үйл ажиллагааг шинэ хэлбэрт шилжүүлэх /АТГ, ЗГХЭГ 2018 он/

АТГ-аас өргөдөл, гомдол, мэдээллийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас факс, [www.iaas.mn](http://www.iaas.mn) цахим хуудас дахь гомдол, мэдээллийн тусгай маягт бүхий гомдол илгээх холбоос, 18001969 тусгай дугаарын утсаар болон байгууллагын байранд биеэр ирж гомдол, мэдээлэл, тоо бүртгэлийн ажилтанд биечлэн өгөх хэлбэрээ хүлээн авч байсан.

2019 онд өргөдөл, гомдол, хүлээн авах тусгай 110 дугаарын утсыг 2019 оны 10 дугаар сараас эхлэн ажиллуулж эхэлсэн. Энэ дугаар нь ярианы төлбөр үнэ төлбөргүй, иргэд тус 3 оронтой дугаарыг цээжлэхэд амар хялбар гэдгээрээ онцлог юм. 110 дугаарын утсыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр, нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн “Дүнжингарав” дахь салбар болон “Бөмбөгөр” худалдааны төвөөр үйлчлүүлж буй иргэдэд сурталчлан,



үүрэн телефоны оператор Мобиком ХХК, Жимобайл ХХК, Юнител, Скайтел ХХК-иудын харилцагч нар мессеж хэлбэрээр хүргэх ажлыг зохион байгуулав. Улаанбаатар хотын 6 дүүргийн 40 байршилд байрлах сурталчилгааны байгууламж, Гадаад хэргийн яам, Дүнжингарав, Мишээл экспо, Богдын музейн дэргэдэх самбаруудад 110 дугаарын утасны сурталчилгааг үнэ төлбөргүй байршуулж ажиллав.

Гомдол, мэдээлэл хүлээн авах 110 утасны дугаар бүхий номын хавчуурга 1000 ширхэг, нэрийн хуудасны хэмжээтэй сурталчилгааны материалыг 5000 ширхэг, авлигын эсрэг афоризм бүхий 14 төрлийн зурагт хуудсыг тус бүр 150 ширхэгийг хэвлүүлэв. 51 төрийн байгууллага байгууллагаар дамжуулан 110 тусгай утсыг сурталчилсан шторк (9 минут бичлэг бүхий 1 DVD), сурталчилгааны зурагт хуудас (9 төрлийн 10 зурагт хуудас, нийт 4641 ширхэг)-ыг хүргүүлэн өөрийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн электрон самбарт шинээр байршуулан сурталчлах, зурагт хуудсыг иргэд, олон нийтэд хүргэх, түгээх ажлыг зохион байгуулав.

Авлигыг мэдээлэх 110 тусгай дугаарын утсыг цахим орчинд сурталчлах, мөн тус газраас зохион байгуулж буй аян, арга хэмжээг сошиал медиа сувгаар түгээх ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулав. (Биелэлт 100 хувь)

#### 4.1.2.7-1. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийлгүүлэх /ЗГХЭГ, 2017-2022/

Төрийн албаны тухай хуульд Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр нөлөөнд олон нийтийн хяналт тавих чиг үүргийг Олон нийтийн хяналтын зөвлөл гүйцэтгэнэ. Олон нийтийн хяналтын зөвлөлийг сонгон шалгаруулах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх, зөвлөлийн ажиллах дүрмийг төрийн албаны төв байгууллага батлахаар тусгасан болно.

Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ийн 9.6-д “Захиргааны байгууллага нь хэрэглэгчийн үнэлгээг Хэрэг

эрхлэх газрын баталсан ерөнхий удирдамжийн дагуу хөндлөнгийн үнэлгээ хийлгэнэ” гэж заасны дагуу Хэрэг эрхлэх газрын 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 302 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар “Хэрэглэгчийн үнэлгээний ерөнхий удирдамж”-ийг баталсан.

“Хэрэглэгчийн үнэлгээний ерөнхий удирдамж”-ийн иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа авах санал асуулгын хуудасны ерөнхий загвар нь салбар чиг үүргийн үнэлгээний 63 үзүүлэлт, үйлчилгээний чанар хүртээмжийн үнэлгээний 19 үзүүлэлт, 16 асуудлаас бүрдсэн.

Дээрх удирдамжийн дагуу 265 сум, дүүргийг төлөөлүүлэн 30068 насанд хүрсэн иргэнээс судалгаа авах ажлыг төрийн захиргааны холбогдох байгууллагууд хийсэн. Судалгааны дүнгээр ерөнхий сэтгэл ханамж 58.7 хувьтай, салбарын дундаж үнэлгээ 55.3 хувьтай, чанар хүртээмжийн дундаж үнэлгээ 67.8 хувьтай гарсан байна.

Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийлгүүлэх чиглэлээр Батлан хамгаалах яам нь 2018 онд “Орон нутгийн хамгаалалтад тулгуурласан батлан хамгаалах тогтолцооны хууль, эрх зүйн үндсийг бүрдүүлж, мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хүчнийг бэхжүүлэх удирдлага, зохион байгуулалтын үр дүнтэй арга хэмжээ авна” гэсэн зорилгыг дэвшүүлэн 6 зорилтын хүрээнд 199 арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан байна

Сонгуулийн ерөнхий хороо сонгуулийн зохион байгуулалтын үйл ажиллагаатай холбоотойгоор Төрийн хэргийг удирдахад иргэдийг оролцуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулах дүрмийн зорилт бүхий төрийн бус байгууллагуудаас сонгуульд оролцогч бусад байгууллага, албан тушаалтан сонгуулийн тухай хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж байгаад хяналт шинжилгээ /мониторинг/ хийх, сонгуулийн үйл ажиллагаанд ажиглалт хийх, сонгогчдын боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх, сонгогчдод эрхээ эдлэхэд нь аргачилсан туслалцаа үзүүлэх, сонгуулийн хуулийн дагуу, шударгаар явуулахад дэмжлэг үзүүлэх, сургалт зохион байгуулах үйл ажиллагааг зохицуулах зорилго бүхий “Төрийн бус байгууллагаас сонгуулийн тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт шинжилгээ, ажиглалт хийх, сургалт зохион байгуулах тухай журам”-ыг тус Хорооны 2016 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 16



дугаар тогтоолоор баталсан. Энэхүү журамд заасны дагуу сонгуулийн үйл ажиллагаанд ажиглалт, мониторинг хийхээр “Нээлттэй нийгэм форум”, “Глоб интернэйшнл төв”, “Филантропи хөгжлийн төлөө төв”, “Мидас”, “Өөрчлөлтийн төлөө залуу эмэгтэйчүүд”, Бодлогод залуусын хяналт” зэрэг 6 ТББ нэгдсэн “Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт сүлжээ”-нд тус Хорооны 2016 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 53 дугаар тогтоолоор сонгуулийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх зөвшөөрөл олгож, хамтран ажиллав. Мөн “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бизнес инкубатор төв”, “Нийгмийн дэвшил эмэгтэйчүүдийн хөдөлгөөний төв” ТББ-ын Ус аймаг дахь салбар сонгуулийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, мониторинг хийх, сонгогчдод аргачилсан туслалцаа үзүүлэхээр зөвшөөрөл олгосон байна.

Сонгуулийн тухай хуулийн 5.5-д “Төрийн хэргийг удирдахад иргэдийг оролцуулах дүрмийн үүрэг, зорилт бүхий төрийн бус байгууллага сонгуулийн төв байгууллагаас тогтоосон журмын дагуу сонгуулийн байгууллага, сонгуульд оролцогч бусад байгууллага, албан тушаалтан сонгуулийн хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж байгаад хяналт шинжилгээ /мониторинг/ хийх, ажиглалт хийх, сонгогчийн боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх, сонгогчид эрхээ эдлэхэд нь аргачилсан туслалцаа үзүүлэх зэргээр сонгуулийг хуулийн дагуу, шударгаар явуулахад дэмжлэг үзүүлэх, сургалт зохион байгуулах эрхтэй.” гэж зааснаар Сонгуулийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд иргэний нийгмийн байгууллагын мэргэжлийн төлөөлөл шууд оролцож хяналт тавих боломжийг бүрдүүлсэн.

Иргэдийн сэтгэл ханамжийг тандан судалж, төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагаас хэрэгжүүлж байгаа бодлого, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн болон иргэдэд хүргэдэг төрийн үйлчилгээний чанартай, хүртээмжтэй, хүнд сурталгүй, түргэн шуурхай байгаа эсэх талаар иргэдийн санаа бодлыг тандан судалж судалгааны дүгнэлт, зөвлөмжийг төрийн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, бодлого шийдвэрийг боловсруулах, үнэлэх явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, төрийн байгууллагын үйл ажиллагааг хараат бусаар үнэлэх юм. Засгийн газраас 2019 оны 12 дугаар сард “Төрийн

бодлого, үйлчилгээний талаарх иргэдийн сэтгэл ханамжийн судалгаа”-г улс орон даяар зохион байгуулж дууслаа.

Судалгаанд Улаанбаатар хотоос гадна 21 аймгийн 291 сум, 545 багийг хамруулсан бөгөөд нийт судалгаанд оролцогчдын гуравны нэг хувийг хөдөө, орон нутгийн багт амьдардаг иргэд эзэлж байна. Төрийн үйлчилгээний салбар, чиг үүргийг нийт 13 салбарт хуваан иргэдээр үнэлүүлсэн. Салбарууд дунджаар 3.1 гэсэн үнэлгээтэй байгаа бол 7 салбар дунджаас дээгүүр үнэлэгдэж бусад нь дунджаас доогуур үр дүнг харуулж байна. Төрийн үйлчилгээний хүртээмжтэй холбоотой бүлэг асуултаас мэдээ, мэдээллийн хүртээмжтэй байдалтай холбоотой асуултууд илүү өндөр үнэлгээтэй байна. Харин үйлчилгээний ачааллын хэвийн байдлыг хамгийн тааруу үнэлжээ. (Биелэлт 70 хувь)

4.1.2.7-2. Төрийн албан хаагчдын үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлэх /ЗГХЭГ, ХХМТГ, төрийн үйлчилгээний байгууллага, 2018-2019 он/

Засгийн газрын 2019 оны 38 дугаар тогтоолоор “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэжлийн түвшинг үнэлэх журам” баталсан. Уг журам нь төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө (цаашид “төлөвлөгөө” гэх) боловсруулах, баталгаажуулах, төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах, албан хаагчийн гүйцэтгэлийн үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах бөгөөд төрийн албан хаагчийн зан үйлийн үнэлгээ, ажлын цаг ашиглалтын байдал, албан үүргээ гүйцэтгэхдээ гаргасан идэвх чармайлт, шуурхай үүрэг даалгаврын биелэлтийг нэгжийн дарга, багаар ажиллах чадвар үйлчилгээ үзүүлэх хандлагыг албан хаагчийн ажлын байрны тодорхойлолтын онцлогоос хамааруулан тухайн албан хаагчийн харьяалах нэгжийн хамт олон дүгнэхээр зохицуулж өгсөнөөрөө ач холбогдолтой юм. Албан хаагчийн үйлчилгээ үзүүлэх хандлагыг үйлчлүүлэгчээр үнэлүүлж, албан хаагчийн хандлага, зан үйлийг нэгжийн хамт олноор үнэлүүлэх ажлыг байгууллагын үнэлгээний баг зохион байгуулах бөгөөд үнэлгээг албан хаагчдаас нууцаар авч, санал тоолох ажиллагааг илээр явуулахаар тусган хэрэгжүүлж эхэллээ.

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар “Ухаалаг засаг” төслийн санхүүжилтээр иргэдэд үйлчлэх лавлах төвийн үйл ажиллагааг дэмжих техникийн зөвлөх үйлчилгээ төсөл болон иргэдийн санал хүсэлт хүлээн авах лавлах төвийн системийг шинэчлэн хөгжүүлэх, нэвтрүүлэх төсөл, мөн иргэдийн санал хүсэлтийн мэдээлэлд бизнес анализ хийх дотоодын зөвлөх болон бизнес аналитикийн систем нэвтрүүлэх төслүүдийг хэрэгжүүлэх, холбогдох сургалтыг зохион байгуулахаар төлөвлөн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар бэлтгэл ажлыг ханган ажилласан байна. Төрийн албан хаагчдын үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлээгүй байна. (Биелэлт 30 хувь)

4.1.2.7-3. Төрийн албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох зорилгоор төрийн байгууллага бүрт ажил дүгнэх үзүүлэлт бий болгож мөрдүүлэх /ЗГХЭГ, ТАЗ, төрийн үйлчилгээний байгууллага, 2018 он/

ЗГХЭГ болон Төрийн албаны зөвлөл хамтран Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагаа, мэргэшлийн түвшин /31 үзүүлэлтээр/ болон төрийн байгууллагын ажлыг үнэлэх /70 үзүүлэлтээр/ ажлыг улсын хэмжээнд 2018 оны 11 дүгээр сарын 05-ны өдрөөс 12 дугаар сарын 05-ны өдрийн хооронд явуулсан. Энэ үнэлгээний хүрээнд төрийн албан хаагчийн сүүлийн 2 жилийн үр дүнгийн гэрээг дүгнэсэн байдалтай газар дээр танилцаж, албан хаагчдаас ярилцлага авах ажлыг зохион байгуулсан.

Засгийн газрын 2019 оны 38 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн мэргэшлийн түвшинг үнэлэх журам” болон Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын даргын 2019 оны 47 дугаар тушаалаар журмыг хэрэгжүүлэхэд шаардлагатай загвар, аргачлалыг баталсан бөгөөд нэгжийн дарга албан хаагчийг улирал тутам, нэгжийн даргыг төсвийн шууд захирагч хагас, бүтэн жилээр гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэхээр зохицуулж өгөв. Мөн төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын төлөвлөлт, гүйцэтгэлийг сайжруулж цаг тухайд нь үнэлснээр үнэлгээ илүү бодитой, албан

хаагчдыг цаг тухайд нь урамшуулах, хариуцлага тооцох боломжтой эрх зүйн орчин бүрдэв. Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг нэгжийн даргаас гадна байгууллага бүрт үнэлгээний баг албан хаагчдын гүйцэтгэлийн үнэлгээг байгууллагын бүхий л түвшинд жигд, бодитой, шударга хийгдэж байгаа эсэхийг тогтоох зорилгоор ажилтнуудын үнэлгээг давхар хянаж эцсийн үнэлгээ өгөх зохицуулалтыг хийлсэн байна.

Сангийн яам Төрийн албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох зорилгоор яамны цахим хяналт-шинжилгээ үнэлгээний “Лидер мониторинг” (LM) програмыг ашиглалтад оруулсан. Цахим хяналт-шинжилгээ, үнэлгээний “Лидер мониторинг” програм нь

- Бодлогын баримт бичгүүдэд туссан Сангийн сайдын хариуцан хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ
- Дээд байгууллагын тогтоол шийдвэрээр өгөгдсөн үүрэг даалгавар
- Үндэсний аудитын газар, ТАЗ болон бусад эрх бүхий байгууллагаас өгсөн зөвлөмж
- Сангийн яамны дотоод аудитын хорооноос өгсөн зөвлөмж гэх мэт байнгын хяналт тавьж, хэрэгжилтийг тайлагнах шаардлагатай баримт бичиг, заавар, зөвлөмжийг нэгтгэн мэдээллийн сан үүсгэснээр ажилтнууд холбогдох мэдээллийг цаг алдалгүй тайлагнах, нэг ажлыг олон дахин тайлагнаж тэр бүрт газар хэлтсүүд хоорондоо бичиг бичих зэрэг ажлын давхардлыг арилган үйл ажиллагааг хөнгөвчилж байна. Тус яамны дотоод бүтцийн нэгжүүдийн долоо хоног, сар, жилийн төлөвлөгөө, тайланг тус програмаар нэгтгэн, ажилтан нэг бүрийн ажлын байрны тодорхойлолтыг оруулж өгснөөр “Үр дүнгийн гэрээ”-г програмыг ашиглан боловсруулж, дүгнүүлдэг болсноор илүү шударга, үнэн зөв дүгнэгдэх, нөгөө талаас гэрээ байгуулах, дүгнэх ажлыг хөнгөвчлөн цаг хугацаа хэмнэсэн, ажлын давхардал зохих хэмжээнд арилсан байна. (Биелэлт 70 хувь)



**Гурав. Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр:**

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 3 дахь зорилтын хүрээнд нийт 10 үйл ажиллагаа, 35 арга хэмжээ тусгагдсан бөгөөд үүнээс 2017 онд 27 арга хэмжээг, 2018 онд 8 арга хэмжээг хэрэгжүүлж эхлэхээр төлөвлөсөн ба 2018 онд 2 арга хэмжээ, 2019 онд 13 арга хэмжээг хэрэгжүүлж дуусахаар төлөвлөсөн байна. Зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг тоймлон танилцуулбал:

4.1.3.1-1. Улсын болон орон нутгийн төсөв, санхүүгийн удирдлагын одоогийн тогтолцоонд дүн шинжилгээ хийж, оновчтой бүтцийг бий болгох /СЯ, 2017-2022/

1. Сангийн яамнаас 21 аймгийн 330 суманд орон нутгийн хөгжлийн сан /ОНХС/-ийн жилийн гүйцэтгэлийн үнэлгээг 4 дэх жилдээ хийж болзол хангасан сумдад 2018 оны ОНХС-ийн санхүүжилтийн 25 хувьтай тэнцэх хэмжээний “урамшуулал” олгон ажиллаж байна. Жилийн гүйцэтгэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлтэд иргэдийн оролцоог хэрхэн хангаж буй талаарх 5 үзүүлэлт, төсвийн төлөвлөлтийн 10 үзүүлэлт, олон нийтэд мэдээлэх, ил тод байдлыг хангаж буй 5 үзүүлэлт, гүйцэтгэлтэй холбоотой 8 үзүүлэлт, хяналт-шинжилгээ, үнэлгээтэй холбоотой 7 үзүүлэлтийг тусган, үзүүлэлт тус бүрээр үнэлгээ хийдэг. Сумдын жилийн гүйцэтгэлийн үнэлгээний дундаж оноо жил ирэх тусам өсч байна. ЖГҮ-нд үндэслэн 21 аймгийн ОНХС-нд 15.2 тэрбум төгрөгийн дэмжлэг, урамшууллыг хуваарилсан байна.
2. 21 аймаг, 330 сум, нийслэл, 9 дүүргийн 2019 оны иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлагдсан тогтоолыг хүлээн авч, орон нутгийн нэгдсэн төсвийг гарган, 2019 төсвийн хуваарийн өөрчлөлт бүрт зарлагын нэгдсэн дүнд хяналт тавьж ажилласан. Үүний үр дүнд аймаг, нийслэл, сум, дүүрэг нь төсвийн сахилга батыг чандлан сахиж, төсвийн тодотгол хийгээгүй болно.
3. Улсын болон орон нутгийн төсвийн

орлогын сар, улирлын гүйцэтгэлд тухай бүр шинжилгээ хийж, төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэхэд анхаарч ажилласан. 2019 оны урьдчилсан гүйцэтгэлээр улсын төсөвт 8,705.3 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 9,077.4 тэрбум төгрөг, орон нутгийн төсөвт 2,899.5 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 2,942.8 тэрбум төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.

4. Орон нутгийн төсвийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх зорилгоор 2019 онд улсын төсөвт төвлөрч байгаа ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогын 50 хувь буюу 5.4 тэрбум төгрөг, газрын тосны тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогын 30 хувь буюу 639.1 сая төгрөгийг орон нутагт нэмж хуваарилсан.
5. Эмнэлгийн бие даасан байдлыг хангаж, тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулахаар Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Улсын гуравдугаар төв эмнэлэг, Арьсны өвчин судлалын үндэсний төвийг хагас бие даасан хэлбэрээр үйл ажиллагаа явуулахаар 2020 оны төсвийг тооцож батлуулсан. Мөн Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2019 оны А/561/256 тоот тушаалаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний өртгийн тооцоололд үндэслэсэн төлбөрийн хэмжээ, санхүүжүүлэх болон хяналт тавих журмыг батлуулсан. Ингэснээр Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд заасан эмнэлэг хагас бие даасан хэлбэрээр үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлж байна. Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, сум, өрхийн эмнэлгийн нэг иргэнд ноогдох тарифын зөрүүтэй байдлыг арилгах зэрэг бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэхээр 2020 оны төсвийг тооцож батлуулсан. Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/562/257 тоот тушаалаар анхан шатны эрүүл мэндийн байгууллагын төсвийг тооцох, санхүүжүүлэх журмыг баталсан.

Төсвийн хэмнэлтийн горим хэрэгжсэн 2015-2017 онд урсгал зардлыг танаж бууруулсан, түүнчлэн 2019 онд хүчин төгөлдөр мөрдөж байсан норм, норматив орчин үеийн техник, технологи албан хэрэглээний шаардлагыг хангахгүй болсон зэрэг нь орон нутгийн

засаг захиргааны байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад хүрэлцэхгүй болж улмаар бодит бус төлөвлөлт, хуваарилалт нь төсвийг зориулалтын бусаар зарцуулах, төсвийн сахилга батыг алдагдуулах, өр үүсэх шалтгаан болсон. Иймд орон нутгийн засаг захиргааны байгууллагын үйл ажиллагааны онцлогт нийцүүлж зардлыг төрөлжүүлэн ангилах, үйл ажиллагааны зардлыг ажлын онцлог, ялгаатай байдал, хэрэгцээ, давтамж зэрэг хүчин зүйлсийг зардал чиглүүлэгч болгож тооцох, хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, их засвар болон шинээр хөрөнгө бий болгох зардлыг бууруулах зорилгоор барилга байгууламж, автомашины урсгал засварыг хөрөнгийн онцлог, ашиглалтын насжилт, үлдэгдэл өртөгтэй нь уялдуулсан аргачлалаар тооцох, 2019 оны төсвийн жилээс эхлэн орон нутгийн төсвийн суурь зарлагад тооцогддог нийгмийн халамжийн зардлын зарим хэсгийг улсын төсөвт шилжүүлсэнтэй холбоотойгоор аргачлалын нийгмийн халамжийн зардал тооцох хэсэг болон орон нутгийн төсвийн суурь зардалд тооцогдох нийгмийн халамжийн үйлчилгээний жагсаалтыг шинэчлэх зэрэг өөрчлөлтийг тусган Засгийн газрын 2019 оны 445 дугаар тогтоолоор “Орон нутгийн төсвийн суурь зарлага тооцох аргачлал”-ыг шинэчлэн батлуулсан. (Биелэлт 70 хувь)

4.1.3.1-2. Төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, зарцуулалтын байдалд дүн шинжилгээ хийж, хариуцлагыг дээшлүүлэх / ТӨБЗГ, 2017-2019/

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2018 онд төрийн өмчит 923 хуулийн этгээдтэй байгуулсан “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний 2016 оны биелэлтийг 5 шалгуур үзүүлэлтээр дүгнэж, илэрсэн зөрчлийг арилгах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, гэрээний биелэлтийн дүн, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар ТӨБЗГ-ын 2017 оны “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” 687 дугаар тогтоол гаргаж, төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад хүргүүлсэн.

“Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний 2016 оны биелэлтийг дүгнүүлээгүй 52 хуулийн этгээдийн холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох асуудлаар холбогдох

төсвийн ерөнхийлөн захирагчид албан шаардлага хүргүүлсэн.

2019 онд төрийн өмчит нийт 1198 хуулийн этгээдтэй байгуулсан “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний 2018 оны хэрэгжилтийг дүгнэхэд 967 хуулийн этгээд хангалттай, 5 хуулийн этгээд хангалтгүй үнэлэгдсэн. “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний 2018 оны хэрэгжилтийн нэгдсэн дүн, гэрээ дүгнэхэд гарсан зөрчил дутагдлыг арилгах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тайлан, дүгнэлт боловсруулж, ТӨБЗГ-ын 26 дугаар хуралдаанд танилцуулсан.

Төрийн өмчийн илүүдэлтэй байр талбайг бусдад түрээслүүлж, төрийн өмчийн түрээсийн нийт орлогын 30 хувийг улсын төсөвт төвлөрүүлэх ажлын хүрээнд 2017 оны 276 дугаар тогтоолоор “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулах, дүгнэх журам”, “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний загвар”-ыг тус тус шинэчлэн баталж, 2017 онд улсын хэмжээнд нийт төрийн өмчит 67 хуулийн этгээдийн 402 түрээсийн гэрээг хянан баталгаажуулж, тухайн онд түрээсийн орлогоос улсын төсөвт нийт 2090.0 сая төгрөг төвлөрүүлсэн.

2019 онд төрийн өмчит 9 хуулийн этгээд, түүний салбар нэгжийн нийт 32 хуулийн этгээдийн өөрийн өмчийн байр талбайн ашиглалтын байдалд мониторинг хийсэн бөгөөд мониторингийн дүнгээр, нийт 52 байр талбайг бусдад түрээслүүлсэн боловч хууль тогтоомж, журмын дагуу түрээсийн гэрээ байгуулаагүй, ТӨБЗГ-т мэдэгдээгүйгээс улсын төсөвт төвлөрүүлбэл зохих түрээсийн орлогыг төвлөрүүлээгүй зөрчлийг илрүүлсэн. Мөн мониторингийн хүрээнд иргэн, хуулийн этгээдэд түрээслүүлж буй Улсын нэгдүгээр төв эмнэлэг (45 байр талбай), “Чингис хаан” олон улсын нисэх буудал (103 байр талбай), “МИАТ” ТӨХК (5 байр талбай), “Дулааны цахилгаан станц-3” ТӨХК (1 байр талбай), Багшийн хөгжлийн ордон (2 байр талбай), Засгийн газрын автобааз (5 байр талбай), Дотоодын Их сургууль (5 байр талбай) нийт 7 хуулийн этгээдийн 166 байр талбайг хэмжиж зөрүүг тооцон, гэрээг шинэчлэн баталгаажуулав.

Төрийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, ашиглалт, зарцуулалтад хийсэн хяналт, мониторингийн дүнд төрийн өөрийн өмчийг бусдад түрээслүүлдээ холбогдох хууль



тогтоомж, дүрэм журмын дагуу түрээслэгчийн сонгон шалгаруулалт хийж, түрээсийн жишиг үнийг баримтлах, төрийн өмчийн үр ашгийг дээшлүүлэх талаар зөвлөмж өгч, төрийн өмчит хуулийн этгээдийн хариуцлагыг дээшлүүлэх арга хэмжээ авсан.

Мөн төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, бүртгэлийг сайжруулах зорилгоор Сангийн сайдын 2018 оны 207 тоот тушаалаар “Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ, бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн дансанд тусгах аргачлал”, “Барилга байгууламжийн үнэлгээг нутаг дэвсгэрийн бүсчлэлээр тооцох итгэлцүүр”, “Инженерийн байгууламжийн нэгж хүчин чадлын үнэлгээ”, “Нийтийн эзэмшлийн байгууламжийн нэгж хүчин чадлын үнэлгээ”, “Хөрөнгийн үнэлгээнд баримтлах үл хөдлөх ба хөдлөх хөрөнгийн ашиглалтын норматив хугацаа”, “Барилга байгууламжийн хийц хэсгийн элементээрх задаргаа”, “Гадаад улс орон дахь дипломат төлөөлөгчийн газруудын 1 м.кв газрын нэгжийн жишиг үнэ”, “Дахин үнэлгээний хураангуй тайлан”, “Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нягтлан шалгалтын тайлан”-г батлан мөрдүүлж байна.

Төрийн өмчийн илүүдэлтэй байр талбайг бусдад түрээслүүлж, төрийн өмчийн ашиглалтыг сайжруулах зорилгоор ТӨБЗГ-ын 2018 оны 293 дугаар тогтоолоор “Төрийн өөрийн өмчийн түрээсийн гэрээний үлгэрчилсэн загвар”, 2018 оны 59 дүгээр тогтоолоор “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн жишиг үнэ батлах тухай” тогтоол, 2018 оны 86 дугаар тогтоолоор “Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам”, 2019 оны 400 дугаар тогтоолоор “Төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих журам”-ыг тус тус шинэчлэн баталсан.

Шинэчлэн батлагдсан дүрэм, журмын хүрээнд ТӨБЗГ-ын бүртгэлийн мэргэжилтнүүд нийслэл, 21 аймагт ажиллаж, төрийн өмчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, хууль тогтоомж, дүрэм, журмын хүрээнд эд хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах үүргийн дагуу төрийн өмчийн эзэмшилт, ашиглалт, захиран зарцуулатын хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр хяналт шалгалт хийсэн.

Сангийн яамнаас Засгийн газрын 2019 оны 3 дугаар сарын 6-ны өдрийн 91 дүгээр тогтоолын

4 дүгээр заалтын дагуу “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Монголросцветмет” ТӨҮГ-уудын 2016-2019 оны эхний 3 сарын үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийж холбогдох арга хэмжээ авах санал, дүгнэлтийг Засгийн газрын хуралдаанд танилцуулж, шалгалтаар “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд нийт 2.2 их наяд төгрөгийн зөрчил илэрснээс 296.6 тэрбум төгрөгийн зөрчлийг хуулийн байгууллагаар шалгуулахаар хандан, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, улсын төсөвт төлүүлэх 36.0 тэрбум төгрөгийн төлбөрийн акт тогтоосноос 2.8 тэрбум төгрөгийн актын төлбөрийг барагдуулсан байна.

“Монголросцветмет” ТӨҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар нийт 51.7 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс 543.8 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлж, улсын төсөвт төлүүлэх 10.7 тэрбум төгрөгийн төлбөрийн акт тогтоосноос 46.7 сая төгрөгийг барагдуулсан бөгөөд 10.7 тэрбум төгрөгийн актын төлбөрийг Маргаан таслах зөвлөлөөр хэлэлцүүлэхээр хүлээж байна.

Засгийн газрын 2019 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн хуралдааны 23 дугаар хуралдааны тэмдэглэлээр холбогдох асуудлыг хууль, хяналтын байгууллагаар шалгуулахаар шилжүүлэхийг даалгасны дагуу холбогдох материалуудыг Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 6 дугаар сарын 04-ний өдрийн 13-2/3635 дугаартай “Хуулийн байгууллагад шилжүүлэх тухай” албан бичгээр хүргүүлсэн.(Биелэлт 70 хувь)

4.1.3.1-3. “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”, түүний хавсралт болон дэд цэсүүдэд тавигдсан мэдээлэл, түүний агуулга олон нийтэд ойлгомжтой байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх /СЯ, ХХМТГ, 2017-2020/

Төрийн аудитын байгууллага нь Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд жил бүр Нийцлийн аудит хийх чиг үүргийнхээ хүрээнд 2018 оны 10 дугаар сард ХХААХЯ-ны Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд явцын аудит, 2019 онд Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2019 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн А/03 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас 2019 онд гүйцэтгэх аудитын

төлөвлөгөө"-нд тусгагдсаны дагуу "Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт" сэдэвт аудитыг хийж гүйцэтгэсэн. Монгол Улсын ерөнхий аудиторовын 2019 оны А/76 дугаар тушаалаар аудитын тайланг баталгаажуулан, УИХ-ын Төсвийн байнгын хороонд хүргүүлсэн. Уг ажлын хүрээнд шилэн дансны мэдээлэл иргэдэд ойлгомжтой байгаа эсэхэд дүн шинжилгээ хийж, цаашид боловсронгуй болгох талаар Сангийн яаманд зөвлөмж хүргүүлсэн.

Сангийн яамнаас Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын 9 дүгээр зүйлийн 9.10 дахь заалтын дагуу тус яамнаас "Төсвийн ерөнхийлөн захирагч нарын шилэн дансны хөтлөлтийн байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээг 2015 оноос хойш жил бүр хийж, ЗГХЭГ-т тайлагнаж байна. ТЕЗ нарын шилэн дансны хөтлөлтийн 2019 оны байдалд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээнд нийт 53 ТЕЗ хамрагдсан бөгөөд ТЕЗ нарын шилэн дансны хөтлөлт дунджаар 97.7 хувийн биелэлттэй буюу "хангалттай сайн" хэрэгжүүлж ажилласан дүнтэй байна.

Шилэн дансны тухай хуульд заасны дагуу төрийн байгууллагууд нийт 40 төрлийн мэдээллийг бүтэн жил, хагас жил, улирал, сар, 7 хоног тутам мэдээлэх үүргийг хүлээдэг. Үүнд:

1. Төсвийн ерөнхийлөн захирагч - 18 төрлийн мэдээлэл;
2. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага - 10 төрлийн мэдээлэл;
3. Төсвийн байгууллага, төслийн нэгж - 19 төрлийн мэдээлэл;
4. Төрийн өмчийн үйлдвэрийн газар - 18 төрлийн мэдээлэл;
5. Хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани - 7 төрлийн мэдээлэл;
6. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага - 1 төрлийн мэдээлэл.

Шилэн дансны тухай хуулийн эрх зүйн орчин, шилэн дансны системийн ашиглалтын өнөөгийн нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид шилэн дансны эрх зүйн орчин болон шилэн дансны нэгдсэн цахим хуудас, түүнд тавигдаж буй мэдээллүүдийг илүү хялбар, ойлгомжтой болгох зорилгоор ТНБД-ын тушаалаар ажлын

хэсэг байгуулан, шилэн дансанд мэдээлэл оруулдаг байгууллага, хэрэглэгч, хяналт шалгалт хийдэг эрх бүхий субъектүүдээс түүвэрлэн 650 хүнээс судалгаа авах ажлыг эхлүүлсэн. Судалгааны үр дүнд үндэслэн холбогдох журам, шилэн дансны портал сайт, түүнд тавьж буй мэдээллийг боловсронгуй болсон.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн одоогийн нөхцөл байдлыг үнэлэх, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талуудтай хэлэлцүүлэг өрнүүлэх зэргээр Шилэн дансны тухай хуультай холбоотой тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлох, дүн шинжилгээ хийх зөвлөхийг (Ц.Ганчимэг, SGM/CS/23-005, 2019.12.12-2020.12.11) сонгон шалгаруулж, одоо хэрэгжиж байгаа хууль, түүнд орсон нэмэлт өөрчлөлтүүдийг судлах, шилэн дансны цахим хуудасны хэрэглэгчдийн дунд хийсэн судалгаанд үндэслэн Шилэн дансны эрх зүй, нэгдсэн системийн өнөөгийн нөхцөл байдлыг үнэлж, сайжруулах зорилго бүхий судалгааны аргазүй, түүврийг тодорхойлж асуулга судалгаа, фокус бүлгийн ярилцлагын удирдамж зэргийг боловсруулан судалгааны ажлыг эхлүүлсэн. (Биелэлт 70 хувь)

4.1.3.1-4. Гадаадын зээл тусламж, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт болон төсөл, хөтөлбөр, арга хэмжээ бүрийн явц, гүйцэтгэлийг цахимаар хянах орчныг бүрдүүлж, нээлттэй, ил тод болгох, мэдээллийг сайжруулах /СЯ, 2017-2022/

Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам"-ыг шинэчилж, Сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 282 дугаар тушаалаар "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ыг батлуулсан.

2019 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг сайжруулах, олон нийтэд нээлттэй, ил тод болгох чиглэлээр шинэчлэлийн ажлуудыг хэрэгжүүлсэн. Тухайлбал, төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн үйл ажиллагааг онлайн болгож, <https://publicinvestment.gov.mn/> веб хуудас болон гар утасны "төсвийн хөрөнгө оруулалт" аппликэйшныг ашиглалтад оруулсан. Ингэснээр санхүүжилтийн үйл



ажиллагааг түргэн шуурхай хэрэгжүүлэх, иргэд, олон нийтийг мэдээллээр ил тод, нээлттэй хангах, төрийн үйлчилгээнд хувийн хэвшил, олон нийт хяналт тавих боломжийг бүрдүүлж, гүйцэтгэгч аж ахуйн нэгж гэрээт ажлын санхүүжилтийг ямар үе шатанд явж байгааг нээлттэй харах, хянах, иргэд тухайн орон нутагт хийгдэж буй хөрөнгө оруулалтын талаар мэдээлэл авах боломжтой болсон. Уг системийг нэвтрүүлснээр санхүүжилтийн үйл ажиллагааг онлайн байдлаар түргэн шуурхай бэлтгэх, төсөл бүрээр нарийн мэдээлэл авах, орон нутаг болон салбарт хэрэгжиж буй төсөл, арга хэмжээтэй танилцах, хөрөнгө оруулалттай холбоотой хууль эрх зүй, тоон мэдээлэл болон цаг үеийн мэдээллийг авах боломж бүрдсэн төдийгүй төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж байгаа ажлын санхүүжилт шуурхай болж, гүйцэтгэгч компани хаанаас ч, хэзээ ч гар утас, интернет ашиглан ямар ч гүйцэтгэлийг хаана, хэн дээр байгааг шууд харах боломж бүрдэж төсвийн ил тод байдлыг сайжруулахад тодорхой хувь нэмэр оруулсан.

Монгол Улсын 2020 оны төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг анх удаа аргачлалын дагуу цахим системээр 2774 төсөл хүлээн авч, үнэлэн, холбогдох материал тус бүрийг цахим системд оруулж төсвийн төслийг боловсруулсан.

Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд 2018 оны 10 дугаар сарын 17-ны өдөр байгуулсан “Төсвийн санхүүгийн удирдлагын ил тод, үр ашигтай байдал төсөл”-ийн Зээлийн хэлэлцээр болон Сангийн сайдын 2019 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 25 дугаар тушаалыг үндэслэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудыг сонгон шалгаруулж гэрээ байгуулан ажиллуулсан. Төслийн хүрээнд хөрөнгө оруулалтын <https://publicinvestment.gov.mn/> систем дээр үндэслэн худалдан авах ажиллагаа, гадаадын зээл тусламж, төрийн өмчийн бүртгэл зэрэг системүүдийг нэгтгэн нэгдмэл дата программ хангамж, мэдээллийн нэгдсэн системийг бий болгох юм. Энэхүү системийг ажиллуулахад шаардлагатай тоног төхөөрөмжийг аймаг, нийслэл, яам газруудад олгох бөгөөд худалдан авах тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлтийг боловсруулж батлуулсан. Мөн тухайн төслийн хүрээнд Мэдээллийн нэгдсэн төвийн барилгыг

барих бөгөөд газрын зөвшөөрөл болон галын дүгнэлтийг гаргуулж, барилгын зураг төсвийг боловсруулах гүйцэтгэгчийн анхан шатны сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан.

2019 онд төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн талаарх мэдээллийг [www.il.tod.mn](http://www.il.tod.mn) болон <https://publicinvestment.gov.mn/> сайтад байршуулж олон нийтэд тухай бүр мэдээлж ажилласан.

Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжиж буй төсөл, хөтөлбөр, арга хэмжээний мэдээллийг хяналт-шалгалт, үнэлгээний цахим систем /odamis.mof.gov.mn/-д тухай бүр байршуулж, үйл ажиллагааны явц, санхүүжилтийг олон нийтэд нээлттэй мэдээлдэг. Тус системийн хэрэглээ, мэдээллийн ил тод, аюулгүй байдлыг хангах, өгөгдлийн төрлийг нэмэгдүүлж, өргөтгөн сайжруулах зорилгоор 2019 онд Дэлхийн банкны Төсөв санхүүгийн тогтвортой байдлыг хангах төслийн хүрээнд үндсэн модулиудыг нэмэгдүүлэх, санхүүжилтийн хүсэлтийг хүлээн авч, шийдвэрийн явцыг харуулах, гааль, нэмүү өртгийн албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг бүртгэх, инфографик, тайланг олон нийтэд шууд харуулах боломжит хэлбэрээр хөгжүүлж байна. Системийн эхний хувилбарыг туршиж байгаа бөгөөд 2020 оны эхний хагас жилд бүрэн нэвтрүүлэхээр 70 хувийн явцтай ажиллаж байна. Системд санхүүжилтийн цахим үйлчилгээг оруулснаар үйл ажиллагааг түргэн шуурхай хэрэгжүүлэх, иргэд, олон нийтийг мэдээллээр ил тод, нээлттэй хангах, төрийн үйлчилгээнд хувийн хэвшил, олон нийт хяналт тавих, гүйцэтгэгч аж ахуйн нэгж гэрээт ажлын санхүүжилтийг ямар үе шатанд явж байгааг нээлттэй харах, хянах, иргэд тухайн орон нутагт хийгдэж буй хөрөнгө оруулалтын талаар мэдээлэл авах боломж бүрдэж байна. (Биелэлт 70 хувь)

4.1.3.1-5. Олон улсын төсвийн түншлэлээс хийгддэг “Нээлттэй төсвийн индекс”-ийн үнэлгээг ахиулах, зөвлөмжийг хэрэгжүүлэх /СЯ, УАГ 2018-2022/

Нээлттэй төсвийн индексийн 2015 оны тайлангаар Монгол Улс 51 оноо авч байсан бол 2017 оны тайлангаар 46 оноо авч үзүүлэлт нь сайжирсан байна.



Зөвлөмжид дурдсан бие даасан төсвийн институци байгуулах асуудлыг Монгол Улсын Их Хурлын 2017 оны 69 дүгээр тогтоолоор шийдвэрлэж, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл байгуулагдсан ба гишүүдийг 2018 онд томилсон байна. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, төвийн бодлогын чиглэлээр судалгаа, шинжилгээ хийж дүгнэлт, зөвлөмж гаргах зорилготойгоор үйл ажиллагаагаа явуулж байна. Түүнчлэн Засгийн газраас 2020 онд эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих “Шахим, ил тод, үр ашигтай” төсвийн бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7-д заасны дагуу Үндэсний аудитын газар жилийн төсвийн төслийн талаарх дүгнэлтийг Улсын Их Хуралд жил бүрийн 10 дугаар сарын 15-ны дотор хүргүүлдэг нь зөвлөмжид заасан арга хэмжээ юм. Үндэсний аудитын газар 2019 онд төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2018 оны санхүүгийн тайлангийн аудитад 32 төсөв захирагчийг хамруулан, үүнээс 29 төсөв захирагчид дүгнэлт өгч, 3 байгууллагад итгэл үзүүлсэн. Аудит хийгдсэн байгууллагаас “Зөрчилгүй” 26, “Хязгаарлалттай” 3 дүгнэлт авсан. Нийт Төсвийн ерөнхийлөн захирагч нарт тайланг гардуулж, илэрсэн зөрчил, цаашид анхаарах асуудлын талаар танилцуулсан.

“Нээлттэй төсвийн индекс”-ийн үнэлгээ 2017 оноос хойш гараагүй. Сангийн яамны санаачилгаар төсвийн ил тод байдлыг нэмэгдүүлэх, иргэдийн төсвийн тухай мэдлэг мэдээллийг тэлэхийг зорилгоо болгон 2018 оноос эхлэн иргэн бүрт ойлгомжтой байдлаар “Иргэдийн төсөв” товхимол болон төсвийн гүйцэтгэлийн мэдээг цахим хэлбэрээр бэлтгэн [www.mof.gov.mn](http://www.mof.gov.mn) цахим сайтад байршуулж байна. Иргэд тус товхимолтой танилцсанаар улс орны эдийн засгийн чадавх хэрхэн сайжрах, төсвийн орлогын бүрдэл, зарцуулалтын талаарх мэдээлэлтэй болох юм. (Биелэлт 30 хувь)

4.1.3.1-6. Хувь хүн, хуулийн этгээдээс төсвийн байгууллагад өгсөн хандив, тусламж гэх мэт төсвийн бус орлого, түүний зарцуулалтыг мэдээлэх тогтолцоог бүрдүүлэх /СЯ 2018-2022/

Хувь хүн, хуулийн этгээдээс улсын төсөвт 2017 онд 153.0 сая төгрөгийн мөнгөн хандив

Төрийн сангийн дансанд төвлөрсөн бөгөөд ямар нэг зарцуулалт хийгдээгүй тул 2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 153.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Харин урьдчилсан гүйцэтгэлээр улсын төсвийн байгууллагууд 2018 онд олон улсын болон дотоодын байгууллага, хувь хүнээс авсан хандив, тусламжийн санхүүжилтээс 21.201,3 сая төгрөг, Онцгой байдлын ерөнхий газар 726,4 сая төгрөгийн зарцуулалтын эрх нээлгэх хүсэлт ирүүлсний дагуу эрхийг нээж, төлбөр тооцоо хийх боломжийг бүрдүүлсэн байна.

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйл буюу “Нэмэлт төсөв” зүйлийн 47.1.1-д Төсвийн захирагч нь төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжийг холбогдох төсөл, арга хэмжээнд зарцуулж болохоор зааснаар улсын төсвийн урьдчилсан гүйцэтгэлээр нэмэлт төсвийн дансаар дамжуулан улсын хэмжээнд 138,3 тэрбум төгрөгийг төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжийн санхүүжилтээр хүлээн авч, зарцуулсан байна. Үүнээс Сангийн сайдын багцын хэмжээнд 983.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн байгууллагууд хандив, тусламжийн санхүүжилтийн зарцуулалтын мэдээллийг [shilendans.gov.mn](http://shilendans.gov.mn) сайтад байршуулж ажиллах үүрэгтэй.

Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан «Төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн заавар, журам»-аар хандив, тусламжийн орлогыг шилэн дансанд мэдээлж, бүртгэх асуудлыг зохицуулсан. (Биелэлт 30 хувь)

4.1.3.2-1. Улсын болон орон нутгийн төсөвт хөндлөнгийн байгууллага, эрдэмтэн, судлаачаар санхүүгийн шинжилгээ хийлгэх боломжийг судлах, холбогдох арга хэмжээг авах /СЯ, 2017-2019/

Олон улсын Валютын сангийн Төсвийн газраас концессийн институцийн болон хууль эрх зүйн орчинд шинжилгээ хийх, концессийн төслүүдийн төсөвт үзүүлэх нөлөөлөл, эрсдэлийг үнэлэх, удирдах, тайлагнах, мониторинг хийх чиглэлээр техник тусалцааны ажлын хэсэг Сангийн яаман дээр 2019 оны 6-7-р сард ажиллаж, нөхцөл байдлын шинжилгээ хийн,



тайлан, зөвлөмж боловсруулсан. ОУВС-ийн Төсвийн газраас боловсруулсан концессийн төслүүдийн санхүү, төсвийн эрсдэлийг үнэлэх загвараар 2 хоногийн сургалтыг зохион байгуулсан.

Европын Холбооны санхүүжилтээр Дэлхийн банкны хэрэгжүүлж буй “Засаглалыг бэхжүүлэх” төслийн хүрээнд олон улсын зөвлөх 2019 оны 4 дүгээр сард ажиллаж, “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох аргачлал”-д зөвлөгөө өгч, улсын төсвийн хөрөнгө оруулалтын замын зураглал боловсруулах ажлыг гүйцэтгэсэн. Дээрх ажлыг үргэлжлүүлэх зорилгоор төр, хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулах чиглэлээр гадаад болон дотоодын зөвлөх ажиллуулахаар 2020 оны төлөвлөгөөнд тусгав.

Монгол Улсын 2019, 2020 оны нэгдсэн төсвийн төслийг УИХ, Төсвийн байнгын хороогоор хэлэлцэхтэй холбогдуулан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс 2019 оны төсвийн төсөлд 2018 оны 10 дугаар сарын 24-ний өдөр 14 санал, зөвлөмж, 2020 оны нэгдсэн төсвийн төсөлд 2019 оны 10 дугаар сарын 20-ны өдөр 13 санал, зөвлөмжийг Улсын Их Хуралд хүргүүлсэн. Тус зөвлөлийн санал, зөвлөмжийг 2019, 2020 оны төсвийн тухай хуулийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэх үед авч үзсэн болно.

“Шинжлэх ухаан, технологийн сан”-ийн санхүүжилтээр Монгол Улсын Их Сургуулийн төслийн баг Татварын бодлого, багц хуулийн шинэчлэл, эдийн засагт үзүүлэх нөлөөллийн судалгааг 2018-2019 онд хийж гүйцэтгэсэн.

Сангийн яам Швейцарийн хөгжлийн агентлагтай хамтран хэрэгжүүлж байгаа “Төвлөрлийг сааруулах бодлогын дэмжлэг” төслийн хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын төсөвт шинжилгээ хийлгэн, тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. (Биелэлт 70 хувь)

4.1.3.2-2. Эрсдэлтэй гэж үзсэн төсөвт байгууллагын төсвийн зарцуулалтад санхүүгийн хөндлөнгийн хяналт хийх /СЯ, 2017-2022/

Сангийн яам нь Төсвийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.6-д “Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлд хяналт тавих”, 12.1.16-д “Төсвийн дотоод аудит, хяналт шалгалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”

чиг үүргийнхээ хүрээнд Төсвийн ерөнхийлөн захирагч болон түүний эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийж байна.

2008 оноос санхүүгийн хяналт шалгалтад хамрагдсан төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил болон шалгалтын дүнг үндэслэн эрсдэлтэй байгууллагын судалгаа гаргасан.

Байгууллагын хяналт шалгалтад хамрагдсан хугацааны алслалт болон өмнөх шалгалтаар илэрсэн зөрчлийн хэмжээ, түүний барагдуулалт зэргийг харгалзан үзэж, санхүүгийн хяналт шалгалтад хамрагдах байгууллагыг сонгон, тухайн жилийн төлөвлөгөөнд тусгаж хяналт шалгалтыг хийж байна.

Сангийн яамнаас 2017 онд Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газраас 14 байгууллагад хяналт, шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах чиглэлээр нийт 66.4 тэрбум төгрөгийн 44 хугацаатай албан шаардлагыг улсын байцаагчид хүргүүлсэн бол 2018 онд Сангийн яамны Дотоод аудитын хорооны хурлаар Иргэний нисэхийн ерөнхий газрын 2012-2016 он, 2017 оны эхний 9 сарын санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд, Хадгаламжийн даатгалын корпорацийн 2016 он, 2017 оны эхний хагас жилийн санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд, “Дипломат байгууллагын үйлчилгээ эрхлэх газар” ТӨҮГ-ын 2016 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд, “Зээлийн батлан даалтын сан”-ийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийсэн.-

2019 онд эрсдэлтэй гэж тодорхойлогдсон төсөвт болон төрийн өмчийн оролцоотой 19 байгууллагад төлөвлөгөөт хяналт шалгалт хийж, шалгалтын дүнг Сайдын дэргэдэх Дотоод аудитын хорооны хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, тухайн байгууллагуудад зөвлөмж хүргүүлэн биелэлтэд хяналт тавьж ажиллалаа. Шалгалтын дүнгээр нийт 353.8 тэрбум төгрөгийн зөрчил илэрсэнд улсын байцаагчийн акт тогтоож, албан шаардлага өгч биелэлтийг хангуулан ажиллаж байна.

Дотоод аудитын хорооны хурлаар хэлэлцүүлж шийдвэрлэсэн шалгалтын материалыг Сангийн яамны цахим хуудсанд тавьж олон нийтэд хүргэж байна. (Биелэлт 70 хувь)

4.1.3.2-3. Дотоод аудитын тогтолцоог боловсронгуй болгох, давхардлыг арилгах /СЯ, 2017-2019/

Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 86-д “Дотоод аудитын тухай анхдагч хуулийн төсөл”-ийг Засгийн газраас санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр заасан. Сангийн сайдын 2017 оны 236, 309 тоот тушаалаар байгуулсан ажлын хэсэг хуулийн төслийг боловсруулан УИХ-аар хэлэлцүүлэхэд бэлэн болгосон.

Төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, дотоод аудит, хяналт шалгалтын чиг үүргийн давхардлыг арилгах үүднээс яамд, нийслэл, дүүрэг, аймгуудын жилийн төлөвлөгөөг нэгтгэн бодлого, удирдамжаар ханган системийн хэмжээнд 3 байгууллагад дотоод аудит, хяналт шалгалт хийж ажилласан. Сангийн сайдын баталсан нэгдсэн удирдамжийн дагуу Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газруудад орон нутаг дахь санхүүгийн хяналт, аудитын албадтай хамтран хийж давхардлыг бууруулан ажилласан.

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын дэргэдэх дотоод аудитын нэгжүүдийн удирдлагын хурал, зөвлөгөөнд аудитын төлөвлөгөөг боловсруулахдаа бусад ТЕЗ-ын дэргэдэх нэгжүүдтэй төлөвлөгөөг уялдуулах, нэг байгууллагад нэг цаг хугацаанд хяналт шалгалт хийж шалгалтад хамрагдаж буй байгууллагад хүндрэл учруулахгүй байх, ажлын уялдаа холбоог хангахыг зөвлөн ажиллаж байна. Тухайн зөвлөмжийн дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас 2020 онд хэрэгжүүлэх дотоод, аудит, хяналт шалгалтын ажлаа орон нутгийн Санхүүгийн хяналт, аудитын албатай хамтарсан байдлаар зохион байгуулахаар төлөвлөөд байна.

Сангийн яамнаас 2019 онд Нийгмийн даатгал, нийгмийн халамжийн сангуудад системийн хэмжээний шалгалтыг орон нутгийн санхүүгийн хяналт, аудитын албадтай хамтран хийсэн бол 2020 онд Цагдаагийн байгууллагад системийн хэмжээнд хийх шалгалтыг тухайн албадтай хамтран хийхээр төлөвлөөд байна. (Биелэлт 30 хувь)

4.1.3.2-4. Төсвийн хяналтын сонсголын журмыг боловсруулан батлуулах /СЯ 2018-2019/

Сангийн яамнаас Төсвийн хяналтын сонсголын журмыг боловсруулаагүй байна. (Биелэлт 0 хувь)

4.1.3.2-5. Санхүү, төсвийн холбогдолтой хууль тогтоомж зөрчсөн этгээд, аудитын болон санхүүгийн хяналт шалгалтын дүгнэлтийг үнэн зөв гаргаагүй албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох /СЯ, УАГ 2018-2019/

Сангийн яамнаас санхүү, төсвийн холбогдолтой хууль тогтоомж зөрчсөн этгээд, аудитын болон санхүүгийн хяналт шалгалтын дүгнэлтийг үнэн зөв гаргаагүй албан тушаалтанд Аудитын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.7.3-т “санхүүгийн тайланг хуурамчаар баталгаажуулсан нь нотлогдсон” бол хариуцлага хүлээлгэхээр заасны дагуу санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлэх, Зөрчлийн тухай хуулийн 11.1-д заасан хариуцлага ногдуулах арга хэмжээг авч байна.

Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу Аудитын тухай хуулийн “аудитын байгууллагад ажилладаг мэргэшсэн нягтлан бодогч өөр байгууллагад давхар ажил эрхлэх, болон бусад аудитын хуулийн этгээдэд гэрээгээр ажиллахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчиж үндсэн орон тоонд ажиллахын зэрэгцээ өөр хуулийн этгээдэд давхар ажил эрхэлсэн 10 нягтлан бодогчид шийтгэл оногдуулж улсын төсөвт нийт 10,0 сая төгрөг төвлөрүүлсэн.

Дотоод аудитын хорооны хурлаар хэлэлцүүлж шийдвэрлэсэн шалгалтын материалыг Сангийн яамны цахим хуудсанд тавьж олон нийтэд хүргэж байна.



Үндэсний аудитын газраас Төрийн аудитын тухай хуулийн 28.1.2 дугаар заалтыг хэрэгжүүлээгүй буюу ашиглан болон залилангийн шинжтэй үйл ажиллагаа явуулсан албан тушаалтныг Авлигатай тэмцэх газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төсвийн ерөнхийлөн захирагч нарт мэдээлж, холбогдох арга хэмжээ авсан.

Монгол Улсын Хөгжлийн банкны 2012-2017 оны үйл ажиллагаа, зээл олголт, эргэн төлөлтийн байдал, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитаар нийт 15 дүгнэлт, 6 зөвлөмж, Нийслэлийн СХД-ийн нэгдсэн эмнэлгийн барилга төслийн хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитаар 6 зөвлөмж, Эрдэнэс Таван толгой ХК-ийн санхүүгийн үйл ажиллагаа, ногдол ашиг хуваарилалт сэдэвт аудитаар 10 зөвлөмж, “Засгийн газрын өрийн удирдлагын 2016-2018 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилт, үр дүн”-д хийсэн аудитаар холбогдох байгууллагуудад 7 зөвлөмжийг тус тус хүргүүлж, санхүүгийн аудитаар 33 албан тушаалтанд хариуцлага тооцох тухай албан шаардлага хүргүүлсэн. (Биелэлт 30 хувь)

4.1.3.3-1. Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, зарцуулалтын мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд “ЗГ-ын тусгай сангийн мэдээлэл” гэсэн цэсээр олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулах / СЯ, 2017-2019/

Засгийн газрын тусгай сан, бусад төсвийн хөрөнгөөр санхүүждэг сан, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдийн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, эрсдэлийг бууруулах, хяналт, үр нөлөөг дээшлүүлэх саналыг боловсруулж, Засгийн газрын 2019 оны 87 дугаар тогтоолоор батлуулсан. Тогтоолоор төсвийн хөрөнгөөс зээл, тусламж авсан, батлан даалт гаргуулсан, санхүүгийн дэмжлэг авсан хувь хүний овог нэр, хуулийн этгээдийн нэр, регистрийн дугаар, шалгарсан төслийн нэр, үйл ажиллагааны чиглэл, төсөл хэрэгжиж байгаа байршил, сонгон шалгаруулсан шийдвэр, зээлийн төлөв, зээлийн үлдэгдлийг Шилэн дансны тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн дагуу байгууллагын шилэн данс, цахим хуудсаар дамжуулан тогтмол мэдээлэх зэрэг нийт 14

арга хэмжээг авахыг Засгийн газрын холбогдох гишүүдэд даалгасан.

Тусгай сангуудын үйл ажиллагааг цэгцэлж, оновчтой зохион байгуулан, санхүүжилт, зарцуулалтыг ил тод, хяналттай болгох, олон нийтийн оролцоог хангах замаар тусгай сангуудын эдийн засаг, нийгэмд үзүүлэх үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан Улсын Их Хурлаар батлуулсан. Тус хуулийн “Тусгай сангийн тайлагнал, ил тод байдал, хяналт” бүлэгт тусгай сангийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэл, санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний мэдээллийг холбогдох шийдвэрийн хамт тухайн шийдвэр гарсан сард нь нэгтгэн олон нийтэд нээлттэй тайлагнаж, Шилэн дансны тухай хуульд заасан журмын дагуу байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн цахим хуудсаар дамжуулан хуульд заасан хугацаанд тогтмол мэдээлж байхаар тусгасан.

Тусгай сангийн хөрөнгийн зарцуулалттай холбоотой шийдвэр гаргаж, гарын үсэг зурсан эрх бүхий албан тушаалтан Шилэн дансны тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу тусгай сангийн хөрөнгийн зарцуулалттай холбоотой мэдээллийг [shilendans.gov.mn](http://shilendans.gov.mn) сайтад байршуулж байгаа тул иргэд олон нийтийн зүгээс хяналт тавих боломж бүрдсэн.

Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, зарцуулалтын мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлж байна.

Батлан хамгаалах яам Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн хөрөнгийг захиран зарцуулах шийдвэрийн ил тод байдлыг хангах чиглэлээр яамны цахим хуудсанд шилэн данс гэсэн дэд цэсийг шилэн дансны цахим хуудастай холбон нээж, сангийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг цогц байдлаар авах боломжийг бүрдүүлсэн.

Хууль зүй, дотоод хэргийн яам шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд Засгийн газрын тусгай сан цэсний 3 дугаарт “ЗТГХХТНТ олгох сан” (Зарим төрлийн гэмт хэргийн хохирогчид төрөөс нөхөн төлбөр олгох сан) нэртэй “Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл” гэсэн ангиллаар сар

бүр санхүүжилт, зарцуулалтыг олон нийтэд мэдээлж байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам Боловсролын зээлийн сан, Шинжлэх ухаан технологийн сан, Спортыг дэмжих сан, Соёл, урлагийг дэмжих сан, Кино урлагийг дэмжих сан /шинээр байгуулагдсан/-ын тусгай сангийн хөрөнгийг захиран зарцуулах шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах, иргэд олон нийтийн зүгээс хяналт тавих боломжийг нээн, цахим санд тогтмол байршуулж байна.

Санхүүгийн зохицуулах хорооны шилэн дансны мэдээлэлд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл, тайлбарын талаарх мэдээлэл, хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний талаарх мэдээлэл оруулж, олон нийтэд мэдээлж байна.

Шилэн дансны Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2019 оны хөтөлөлтийн хяналт-шинжилгээ, үнэлгээнд Сангийн сайдын багцад тусгай сангуудын шилэн дансны хөтөлөлтийн үнэлгээ хамрагдсан бөгөөд тусгай сангуудын байршуулах сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл зэрэг мэдээллийг цахим хуудаст бүрэн байршуулж, өсвийн ерөнхийлөн захирагчын нэгдсэн дүнгээр 99.3 хувьтай үнэлэгдсэн байна. (Биелэлт 70 хувь)

4.1.3.3-2. Тусгай сангийн хөрөнгийг захиран зарцуулах шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах, иргэд олон нийтийн зүгээс хяналт тавих боломжийг нээх /СЯ, тусгай санг захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан, 2017-2020 он/

Сангийн яам 2018 онд Тариалан эрхлэлтийг дэмжих сан, Мал хамгаалах сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Зарим төрлийн гэмт хэргийн нөхөн төлбөрийн сан, Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих санд шалгалт хийж Дотоод аудитын хорооны хурлаар хэлэлцүүлэн дүнг Сангийн яамны цахим хуудсанд тавьж, олон нийтэд мэдээлсэн. Тус яам төсөв, санхүүгийн удирдлага, төлөвлөлт, зохицуулалтыг боловсронгуй болгох санал боловсруулан, эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх” бүрэн эрхийнхээ хүрээнд

төсвийн хөрөнгөөр санхүүждэг, санхүүгийн дэмжлэг, зээл олгодог сан, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор “Засгийн газрын тусгай сангуудын талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан, Засгийн газрын 2019 оны 87 дугаар тогтоолоор батлуулсан. Тогтоолд тусгай сангийн хөрөнгийг захиран зарцуулах шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах, иргэд олон нийтийн зүгээс хяналт тавих боломжийг нээх чиглэлээр дараах заалтуудыг тусган батлуулсан. Тухайбал, төсвийн хөрөнгөөс зээл, тусламж авсан, батлан даалт гаргуулсан, санхүүгийн дэмжлэг авсан хувь хүний овог нэр, хуулийн этгээдийн нэр, регистрийн дугаар, шалгарсан төслийн нэр, үйл ажиллагааны чиглэл, төсөл хэрэгжиж байгаа байршил, сонгон шалгаруулсан шийдвэр, зээлийн төлөв, зээлийн үлдэгдэл, шинээр олгох зээлийн эх үүсвэрийн хэмжээ, сонгон шалгаруулалтын журам, тавигдах шаардлага, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтыг цахим хуудсаараа дамжуулан мэдээлэх, мэдээллийг тогтмол шинэчлэх; төсөл сонгон шалгаруулах, зээл олгох, эргэн төлүүлэх үйл ажиллагааг цахимжуулах, мэдээллийн нэгдсэн систем нэвтрүүлэх арга хэмжээ авах зэргийг дурдаж болно.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг Улсын Их Хурлаас баталсан бөгөөд уг хуулийн 24, 25 дугаар зүйлд тусгай сангийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэл, санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний мэдээллийг холбогдох шийдвэрийн хамт тухайн шийдвэр гарсан сард нь нэгтгэн олон нийтэд нээлттэй тайлагнаж, Шилэн дансны тухай хуульд заасан журмын дагуу байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн цахим хуудсаар дамжуулан хуульд заасан хугацаанд тогтмол мэдээлэх, тусгай сангаас зээл, буцалтгүй тусламж, санхүүгийн дэмжлэг авахаар хүсэлт ирүүлсэн иргэд, хуулийн этгээдийн бизнес төлөвлөгөөгөө танилцуулах, түүнийг сонгон шалгаруулах, үнэлэх үйл явцыг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нээлттэй, ил тод зохион байгуулах, төсөл, арга хэмжээг сонгон шалгаруулах хороо, төслийн удирдах хороо



болон хяналтын хорооны бүрэлдэхүүнд төрийн бус байгууллага, мэргэжлийн байгууллагын төлөөллийг оролцуулах ба тусгай сангийн хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагаанд хяналт тавихад олон нийтийн оролцоог хангах зэрэг заалтыг тусгаж ил тод, нээлттэй байдлыг хангах, иргэд олон нийтийн зүгээс хяналт тавих боломжийг бүрдүүлсэн.(Биелэлт 30 хувь)

4.1.3.3-3. Тусгай сангийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийж, дүнг олон нийтэд ил тод мэдээлэх /СЯ, 2017-2022/

Сангийн яамнаас 2017 онд Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сан, 2018 онд Тариалан эрхлэлтийг дэмжих сан, Мал хамгаалах сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Зарим төрлийн гэмт хэргийн нөхөн төлбөрийн санд шалгалт хийж, Дотоод аудитын хорооны хурлаар хэлэлцүүлэн дүнг Сангийн яамны цахим хуудсанд тавьж олон нийтэд мэдээлсэн. Засгийн газрын зарим тусгай санд шалгалт явуулж, дүнг Засгийн газрын 2018 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанд танилцуулсан.

2018, 2019 онд Засгийн газрын нийт 20 тусгай санд санхүүгийн хяналт шалгалт хийсэн. Үүнээс 3 тусгай санд хийсэн санхүүгийн хяналт, шалгалтын тайланг Засгийн газрын хуралдаанд, 15 тусгай санд хийсэн санхүүгийн хяналт шалгалтын тайланг Сангийн сайдын дэргэдэх Аудитын хорооны хурлаар хэлэлцүүлсэн.

“Засгийн газрын тусгай сан”-д хийсэн хяналт, шалгалтын ажлын үр дүнд төсөв, санхүүгийн үйл ажиллагаа дахь алдаа, зөрчлүүдийг илрүүлж, цаашид анхаарах асуудал, авах арга хэмжээний зөвлөмжийг өгч, акт, албан шаардлагыг хангуулахад анхаарч ажилласан нь төсвийг эрүүлжүүлэх, төсвийн сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэхэд чухал хувь нэмэр оруулсан.

Засгийн газрын хуралдаанд иргэн, хуулийн этгээдэд зээл олгодог, төсөл хөтөлбөр хэрэгжүүлдэг болон бусад тусгай сангуудад хийсэн шалгалтын дүнг хэлэлцүүлэхийн зэрэгцээ тусгай сангуудын үйл ажиллагааг үр дүнтэй болгох талаар цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний бодлого, санал боловсруулан оруулснаар “Засгийн газрын тусгай сангийн талаар авах арга хэмжээний тухай” 2019 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 87 дугаар тогтоол гарч, түүний мөрөөр тодорхой ажлуудыг хийж хэрэгжүүлж байна.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар Засгийн газрын 29 тусгай сангаас 20 тусгай сан үйл ажиллагаагаа явуулахаар хуульчлагдсан бөгөөд чиг үүрэг нэгтэй, нэг салбарын 3 санг нэгтгэж, 7 санг татан буулгаж зохион байгуулалт хийн, 3 сангийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр тусгайлсан үүрэг, даалгавар өгсөнд хяналт тавьж байна.

“Засгийн газрын тусгай сан”-гийн хяналт, шалгалтын дүнгээр 2019 онд нийт 397.6 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс 371.1 тэрбум төгрөгийн албан шаардлага, 26.5 тэрбум төгрөгийн төлбөрийн акт тогтоож биелэлтэд хяналт тавьж байна. Дээрх шалгалтын тайланг хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлж, дэлгэрэнгүй тайланг яамны [www.mof.gov.mn](http://www.mof.gov.mn) вэб сайтад <https://mof.gov.mn/article/entry/tailan-delgerengui> холбоосоор байршуулж, нийтэд ил тод мэдээлсэн. (Биелэлт 70 хувь)

4.1.3.4-1. Орон нутгийн төсвийн төслийн талаар хэлэлцүүлэг өрнүүлэх, төсвийн төсөлд олон нийтийн саналыг авч тусгах /СЯ, 2017-2022/

Орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2018 онд хийх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний саналыг иргэдээр нээлттэй болон цахим хэлбэрээр хэлэлцүүлж, иргэдээс гарсан саналыг төсвийн төсөлд тусгасан. Тухайлбал, Говь-Алтай аймгийн 19 сумын 900, Дорноговь аймгийн 3030, Дундговь аймгийн 2835, Хэнтий аймгийн 3790 иргэн, Хөвсгөл аймгийн 23 сум, 1 тосгоны иргэдээс тус тус санал авсан.

Сангийн яам, Дэлхийн банк, Швейцарийн хөгжлийн агентлагтай хамтран хэрэгжүүлж буй “Тогтвортой амьжиргаа-3” төслийн хүрээнд “Орон нутгийн төсвийн удирдлагын чадавхийг бэхжүүлэх” сэдэвт бүсчилсэн сургалт-семинарыг 2 удаа, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын А/187 дугаар тушаалын дагуу 21 аймаг, нийслэл, 6 дүүрэгт орон нутгийн хөгжлийн сан хариуцсан мэргэжилтнүүдийг оролцуулсан сургалт, хэлэлцүүлгийг 1 удаа зохион байгуулсан.

Сангийн яамны нээлттэй өдөрлөгийн үеэр улсын төсвөөс болон хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа болон хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний талаар танилцуулга бэлтгэн олон нийтэд мэдээлж, холбогдох асуултад хариулт өгөн, иргэдээс

ирсэн төсвийн төсөлд тусгах саналыг хүлээн авч шийдвэрлэх боломжтой эсэхийг судлан үзсэн.

Монгол Улсын 2020 оны төсвийн хуулийн төсөл, Нийгмийн даатгалын сангийн 2020 оны төсвийн хуулийн төсөл, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны төсвийн хуулийн төсөл, мөн дагалдах хуулийн төслүүдийн хамт [www.iltod.gov.mn](http://www.iltod.gov.mn) байршуулсан болно.

2019 онд Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох үйл ажиллагааны журам болон аргачлалууд”-ыг хэрхэн ашиглах, цахим системийг хэрэглээнд нэвтрүүлэх сургалтыг улсын хэмжээнд төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт хариуцсан 460 гаруй албан хаагчдад, бүсчилсэн сургалтыг Дархан-Уул, Төв, Өвөрхангай, Хэнтий, Ховд аймагт зохион байгуулсан. Монгол Улсын 2020 оны төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 2774 төслийг анх удаа аргачлалын дагуу цахим системээр хүлээн авч, төслүүдэд үнэлгээ өгч, холбогдох материал тус бүрийг цахим системд оруулж төсвийн төслийг боловсруулсан.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системийн «Санхүүжилт» хэсгийг ашиглах гарын авлага боловсруулж яам, агентлаг, аймаг, нийслэлийн хөрөнгө оруулалт хариуцсан ажилтнуудад хүргүүлсэн. (Биелэлт 30 хувь)

4.1.3.4-2. Орон нутгийн төсвийн төсөлд санал авах хэлэлцүүлгийн талаар Засгийн газрын [www.iltod.mn](http://www.iltod.mn), [www.shilendans.com](http://www.shilendans.com) цахим хуудас болон бусад мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэх /СЯ, 2018-2022/

Сангийн яамнаас Төсвийн тухай хуулийн 5.1.4 болон 6.5.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн орон нутгийн төсөвт иргэд, олон нийтийн оролцоог хангах, төсвийн ил тод байдлыг сайжруулах ажлын хүрээнд <http://iltod.gov.mn> сайтад дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, тухайн жилийн улсын төсөв, аймаг нийслэлийн жилийн төсөв, нийгмийн даатгалын сангийн төсөв, эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв, батлагдсан төсвийн сар, улирлын хуваарь болон бусад холбогдох мэдээллүүдийг, <https://shilendans.gov.mn/>

сайтад жил бүрийн өргөн барьсан болон батлагдсан төсвийг тухай бүрд нь нийтлэн олон нийтэд ил тод байдлаар тогтмол мэдээлж хэвшсэн.

“Улсын төсвийн хөрөнгө оруулалт, Хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ажлын хүрээнд байгуулагдсан төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагаа, хэрэгжилтэд баримтлах журам”-ын төслийг [www.iltod.mn](http://www.iltod.mn) цахим хуудсанд байршуулж санал авсан.

Концессоор эрчим хүчний салбарт 2 төсөл, зам тээврийн салбарт 6 төсөл, эрүүл мэндийн салбарт 1 төсөл хэрэгжүүлэхээр аж ахуйн нэгжтэй концессын гэрээ байгуулсан тухай мэдээллийг маягтын дагуу бэлтгэн [www.shilendans.com](http://www.shilendans.com) цахим хуудсанд байрлуулсан. 2020 оны төсвийн төслийн товхимлыг 300 ширхэг, Иргэдийн төсөв товхимлыг 200 ширхэг тус тус хэвлүүлж тараасан.

Дэлхийн банк, Сангийн яамны 2019 оны 6 дугаар сард хамтран зохион байгуулсан хэвлэлийн бага хурлаар төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн үйл ажиллагааны талаар олон нийтэд зориулсан гар утасны аппликэйшн, вэб хуудасны талаар танилцуулсан. Монгол Улсын Засгийн газар хийсэн ажлаа танилцуулж, иргэдэд төрийн зарим үйлчилгээг нэг цэгээс үзүүлэх ажлын хүрээнд 2019 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулагдсан “Нээлттэй өдөрлөг”-ийн үеэр хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын томоохон төслүүдийг танилцуулж, иргэдэд мэдээ, мэдээлэл өгч, 11-11 төвийн үйлчилгээг ард иргэдэд хүргэсэн. (Биелэлт 30 хувь)

4.1.3.5-1. Зээл авахад иргэн, аж ахуйн нэгжид учирч байгаа хүндрэл, зээлийн нөхцөлд дүн шинжилгээ хийж, зээлийн нөхцөлийг хөнгөвчлөх арга хэмжээг авах/Монголбанк, 2017-2020/

Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын 2017 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн А-193/228 дугаар хамтарсан тушаалаар “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ыг шинэчлэн баталсан бөгөөд хугацаа хэтэрсэн өдрөөс хойш иргэний хувьд 15 хүртэлх хоног, аж ахуйн нэгжийн хувьд 30 хүртэлх хоногт багтаан эргэн төлөх боломжтой гэж банк үзвэл



уг зээлийг хэвийн ангилалд бүртгэж болохоор журамласан. Ингэснээр түр зуурын санхүүгийн хүндрэлд орсон зээлдэгчийн зээлийн түүхийг хамгаалах боломжтой болсон.

Эдийн засгийн мөчлөг дагасан чанаргүй зээлийн сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор Актив удирдлагын тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн барьсан. Манай орны банк, санхүүгийн салбарт хуримтлагдсан чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдэж, цаашид өсөх хандлагатай болсон нь банкнаас олгох зээлийн хэмжээг бууруулах, санхүүгийн зуучлалыг зогсонги байдал оруулах, эдийн засгийн идэвхжилтийг сулруулан, бодит секторын өсөлтийг хязгаарлах, ажилгүйдлийг нэмэгдүүлэх, эдийн засгийн сэргэлтийг удаашруулах, халамжийн зардлыг өсгөх, татварын орлогыг бууруулах, өрийн тэнцвэрт байдалд хүрэх зорилтыг хэрэгжүүлэхэд саад учруулахаар байна. Банк, санхүүгийн салбарт хуримтлагдсан чанаргүй активыг бууруулах, тус салбарын тогтвортой байдлыг хангах зорилгоор Актив удирдлагын мэргэшсэн институци байгуулах эрх зүйн орчин бүрдүүлэх ажлыг 2015 оноос эхлүүлсэн байна.

Тэтгэвэр барьцаалсан зээлийн нөхцөлийг сайжруулах зорилгоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Монголбанк, арилжааны банк хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг байгуулан, тэтгэвэр барьцаалсан зээлийн дээд хугацааг арилжааны бүх банкинд адил байхаар тогтоох, тэтгэврийн тодорхой хувьд зээл олгох асуудлыг шийдвэрлэж мөрдүүлэх, тэтгэвэр барьцаалсан зээл олгох зориулалтаар арилжааны банкинд байршуулсан нийгмийн даатгалын сангийн эх үүсвэрт заавал байлгах нөөцийг тогтоохгүй байхаар тус тус шийдвэрлэсэн.

Банкны хэрэглээний зээлд өр орлогын харьцааг 60 хувьд, тэтгэврийн зээлийнхийг 70 хувьд, хугацааг 30 сараар тогтоох бодлогыг хэрэгжүүлж эхэлснээр иргэдийн зээлийн дарамт буурч эхэлсэн ч тэтгэврийн зээлтэй иргэдээс 2019 оны туршид хүсэлт их ирсэн. Үүний зэрэгцээ зээлийн мэдээллийн сан, ипотекийн зээл гэх мэт чиглэлээр нийт 265 өргөдөл ирсний дагуу судалгаа, шинжилгээг хийж, хариуг нь хүргүүлсэн. Мөн Монголбанкны мэдээлэл өгөх утсаар болон биеэр өдөр бүр дунджаар 30-40 иргэний асуултад хариулж, мэдээлэл өгөв.

Мөн “Зээлийн хүүг бууруулах стратеги”-ийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. (Биелэлт 30 хувь)

4.1.3.5-2. Банк зээл олгохдоо авдаг шимтгэлийг бодитой тогтоох /Монголбанк, 2017-2019/

Монголбанкнаас зээлийн хүү, шимтгэлийг бодитой тогтоосон эсэх, иргэдээс банкуудын тогтоосон зээл, шимтгэлтэй холбоотой гомдлыг хүлээн авч шийдвэрлэдэг. Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т “Зээлийн хүүгийн хэмжээг бодох аргачлалыг Монголбанк батална” гэж заасны дагуу Монголбанкны Ерөнхийлөгчийн 2013 оны А-236 дугаар тушаалаар “Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлын журам”-ыг батлан мөрдүүлж байсан. Энэхүү журмыг Монголбанкны ерөнхийлөгчийн 2018 оны А/203 дугаар тушаалаар шинэчлэн баталсан.

Банкны салбараас санхүүгийн үйлчилгээ авах иргэд, аж ахуйн нэгжид бодит мэдээлэл өгөх зорилгоор банкуудын хадгаламж, зээлийн үйлчилгээний зарласан хүү, шимтгэл, бодит өртгийн талаарх мэдээллийг сар бүр Монголбанкны <https://www.mongolbank.mn/liststatistic.aspx?id=6> цахим хуудсанд байршуулж байна.

Санхүүгийн зохицуулах хороо нь Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлэх, үйлчилгээний өртөг болон зээлийн хүүг бууруулах, чадавхийг бэхжүүлэх зорилгоор Хорооны 2016 оны 72 дугаар тогтоолын хэрэгжилтийг /хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг тогтоосон/ хангуулж, ББСБ-уудын үйл ажиллагаа, хувь нийлүүлсэн хөрөнгө, үйлчилгээний өгөөмж, хүртээмжийн талаар судалгаа хийн, 2016 оны 271 дүгээр тогтоолоор хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг шинэчлэн тогтоож, 2017 оны 91 дүгээр тогтоолоор үе шаттай нэмэгдүүлэх шийдвэр гаргасан.

Банкны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт “Банк иргэн, хуулийн этгээдэд өөрийн болзол, нөхцөлийн дагуу зээл олгож болох бөгөөд зээлийн хүүг өөрөө тогтооно” гэж заасан байдаг бөгөөд Монголбанкнаас



зээлийн хүү, шимтгэлийг бодитой тогтоосон эсэхэд хяналт тавьж, иргэдээс банкуудын тогтоосон зээл, шимтгэлтэй холбоотой гомдлыг хүлээн авч тухай бүр холбогдох хариуг хүргүүлэн ажилласан.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2015 оны А-200 дугаар тушаалаар батлагдсан “Банкны санхүүгийн тайлан, бусад мэдээллийг олон нийтэд мэдээлэх загвар”-ын дагуу банкны жилийн тайланд харилцагчийн өмнө хүлээсэн үүрэг, харилцагчийн эрх ашгийг хамгаалах талаар баримтлах бодлогын хэрэгжилт, банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний ерөнхий нөхцөл, хүү шимтгэл, хураамжийн талаар банкны цахим хуудсанд мэдээлдэг. Мөн Банкны тухай хуулийн 38 дугаар зүйлд заасан мэдээллийг банкны цахим хуудсанд тухай бүр, үнэн зөв тайлагнасан эсэхэд хяналт тавин ажиллаж байна.

Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлын журамд өөрчлөлт орсноор иргэд олон нийтэд нийт 20 орчим сургалт, уулзалт хийж 1800 орчим хүнд хүрч ажиллав.

Монголбанкны ерөнхийлөгч, Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Хадгаламжийн даатгалын корпорацийн гүйцэтгэх захирлын хамтарсан тушаалаар баталсан “Зээлийн хүүг бууруулах стратеги”-ийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Зээлийн зах зээлд гарч буй шинэ технологи түүний төрлүүдийн талаарх судалгааг боловсруулсан. Сүүлийн жилүүдэд зээлдэгч, зээлдүүлэгчийг шууд холбосон P2P платформ зээлийн зах зээлд нэвтэрч эхлээд байгаа ба олон улсад 5 өөр төрлийн P2P загвар ашиглагдаж байна. Эдгээрээс манай улсын ББСБ-ууд баталгаат зээлийн загвар бүхий P2P платформыг нэвтрүүлж эхлээд байна. Мөн ББСБ-ууд зээлийн үйл ажиллагаагаа цахимжуулан, гар утсанд суурилсан зээлийн үйлчилгээ эрхэлж эхлээд байна. 2019 оны 3 дугаар улирлын байдлаар Монгол Улсын хэмжээнд 8 ББСБ технологид суурилсан зээлийн үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэж байгаа бөгөөд салбарын нийт зээлдэгчдийн 62.5 хувь нь технологид суурилсан зээлийн үйлчилгээг хүртэж байна. Мөн олон улсад нийтлэг ашиглагдаж буй “Сэндбоксын зохицуулалтын орчин”-ны журмын төслийг боловсруулсан бөгөөд технологийн компаниудын үйл

ажиллагаа, тоон мэдээлэл хамгаалалтад ашиглагдаж буй зохицуулалт, стандартуудыг судалсан. Финтекийн хөгжлөөр тэргүүлэгч улс орнууд сэндбоксын зохицуулалтыг нэвтрүүлэн ажиллаж байгаа ба манай улсын зах зээл болон зохицуулалтын үйл ажиллагааны онцлогт тохируулан Сингапур, Малайз, Их Британи улсын сэндбоксын үйл ажиллагаатай төстэй хувилбар бүхий бодлогын баримт бичгийг боловсруулан танилцуулсан.

“Чанаргүй активын зах зээлийн эрх зүйн орчныг шинэчлэхтэй холбогдуулан “Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журам”-ыг 2019 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 46 дугаар тогтоолоор баталсан. (Биелэлт 70 хувь)

4.1.3.5-3. Банкны зээлийн бодлого, түүний журмыг боловсронгуй болгох, зээл авагч, зээлдүүлэгчийн тэгш байдлыг хангасан эрх зүйн орчинг бүрдүүлэх/Монголбанк, 2017-2020/

Монголбанкнаас 2018 онд зохион байгуулсан “Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах аян”-ы хүрээнд Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Монголын банкны холбоо, Бичил санхүүгийн хөгжлийн сан, Хадгаламжийн даатгалын корпораци, Монголын ипотекийн корпораци, Азийн хөгжлийн банкт хамтран дараах гол ажлуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Үүнд:

- Санхүүгийн салбарт хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хууль батлуулах,
- Санхүүгийн оновчтой шийдвэр гаргахад нь туслах, эрх тэгш харилцах чадамжийг бэхжүүлж, оролцогч этгээдүүдийн эрх ашгийг хамгаалах,
- Санхүүгийн тэнцвэргүй байдлаас сэргийлэх зохицуулагч этгээдүүдийн эрх, үүргийн тодорхой болгох, энэ чиглэлд хяналт шалгалт хийдэг тусгай бүтэц бүрдүүлэх,
- Шимтгэл, хураамж болон санхүүгийн үйлчилгээний нэмэлт төлбөрийн талаарх ойлголтыг нийгэмд хүргэх,
- Орон сууцны ипотекийн зээл хүсэгчдэд чиглэсэн зөв, тодорхой ойлголтыг хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр дамжуулан олон нийтэд тогтмол хүргэх,
- Зээлийн мэдээллийн сангийн ойлголт, мэдээлэл нийлүүлэгч талууд болон хэрэглэгч



өөрийн мэдээллийг хэрхэн авч ашиглах, хяналт тавих талаар олон нийтэд хүргэх зэрэг арга хэмжээг авах.

Төв банк/Монголбанк/-ны тухай хуульд 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр уг хуулийн 5 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт “банкны харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах” гэсэн шинэ зохицуулалт орсны дагуу Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн А-15 дугаар тушаалаар “Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай” хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан ба Санхүүгийн зохицуулах хороо, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газартай хамтран хуулийн төслийг боловсруулж, хууль санаачлагч УИХ-ын гишүүнд уламжилсан ба хуулийн төслийг 2019 оны 12 дугаар сарын 02-ны өдөр УИХ-ын даргад өргөн мэдүүлсэн. Хуулийн төслийн эхний хэлэлцүүлгийг хийж, УИХ-ын ЭЗБХ болон УИХ-ын чуулганаар тус тус хэлэлцэн дэмжсэн бөгөөд төслийг УИХ-ын ЭЗБХ эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэж байгаа болно.

Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо «Монгол Улсын санхүүгийн салбар дахь хэрэглэгчийн эрхийг хамгаалахад үзүүлэх техник туслалцаа»-ны хүрээнд 2019 оны 3 дугаар сарын 18-ны өдөр «Харилцан ойлголцлын санамж бичиг»-ийг байгуулсан. Уг санамж бичгийн дагуу Азийн хөгжлийн банкнаас Монгол Улсад санхүүгийн салбар дахь хэрэглэгчийн эрхийг хамгаалах эрх зүйн орчин бүрдүүлэхэд туслалцаа үзүүлэхээр 2 жилийн хугацаатай төслийг 2020 оноос эхлэн хэрэгжүүлнэ.

Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу “Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн журам”-ын төсөлд олон нийтээс санал авч, Монголбанкны Зээлийн мэдээллийн албанаас олон нийтэд мэдээлэл өгч ажиллав.

Банкны зээл олгох стандартыг олон улсын жишигт нийцүүлж, зээлийн эрсдэлийг үнэн бодитой үнэлэн зээлийг олгож, олгосон зээлийг хянах харилцааг зохицуулсан журмын төслийг боловсруулан Монголын банкны холбоо, банкууд, ОУВС-гаас санал аван тусгасан. Журмын төсөлд ОУВС-гаас 2 дахь удаагаа санал авч байна. (Биелэлт 70 хувь)

#### 4.1.3.5-4. Банкны зах зээлд өрсөлдөөний нөхцөлийг бүрдүүлэн, хуулийн хэрэгжилтийг хангуулах /Монголбанк, 2017-2019/

Монголбанкнаас банкуудын үйл ажиллагаанд зайны хяналт болон газар дээрх хяналт шалгалтыг тогтмол хийж байна. Банкны тухай хуульд арилжааны банкууд охин компанитай байхыг хязгаарлаж, банкууд санхүүгийн болон санхүүгийн бус салбарт тэгш бус өрсөлдөөн бий болох эрсдэлийг бууруулах чиглэлээр нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулсан.

Гадаадын банк, санхүүгийн зах зээлд нэвтэрснээр эдийн засаг, санхүүгийн системд үзүүлэх нөлөөлөл болон бусад улс орнуудын туршлагын талаарх судалгааг хийж гүйцэтгэсэн.

Мөн Монголбанкны Ерөнхийлөгчийн 2017 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн А-295 дугаар тушаалаар байгуулагдсан “ОУВС-ын Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах шаардлагын хүрээнд банкны тогтолцоог тогтворжуулах, өөрийн хөрөнгийн дэмжлэг үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах хуулийн төслийг боловсруулах” үүрэг бүхий ажлын хэсэг ажиллаж, хуулийн төслийг хамтран боловсруулж, 2018 оны 6 дугаар сарын 22-ны өдөр Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хууль батлагдсан. Тус хуульд банкууд хувьцаа болон үнэт цаас гаргахыг хуульчилж, өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх тэргүүн ээлжинд хэрэгжүүлэх аргаар тусгасан. Энэ нь арилжааны банкуудын хөрөнгийн зах зээлээр дамжуулан санхүүжилтийн эх үүсвэрээ өөрийн нөөц бололцоо, нэр хүнд, чадавхаас хамааруулан бие даан босгох, нэмэгдүүлэх боломжийг олгосон хууль болсон.

Банкны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.1-т “дангаараа буюу бусадтай хамтран санхүүгийн зах зээл дээр ноёрхох, өөр хоорондоо, эсхүл гуравдагч этгээдэд шударга бусаар давуу байдал бий болгоход чиглэсэн үйл ажиллагаа явуулах, ийм үйл ажиллагаанд оролцох”-ыг хориглоно гэж заасан байна. Энэ заалтын дагуу Монголбанкнаас банкуудын үйл ажиллагаанд зайны хяналт болон газар дээрх хяналт шалгалтыг тогтмол хийж байна.

Банкны тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр арилжааны банкууд охин

компанитай байхыг хязгаарлаж банкууд санхүүгийн болон санхүүгийн бус салбарт тэгш бус өрсөлдөөн бий болох эрсдэлийг буурууллаа.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн А-32 дугаар тушаалаар “Чанаргүй активыг бууруулах удирдлага, тогтолцоо, тайлагнах үлгэрчилсэн журам”-г батлан мөрдүүлж байна. Энэхүү журмыг хэрэгжүүлснээр барьцаа хөрөнгийг үүргийн гүйцэтгэлээр хангуулах эрх зүйн орчныг сайжруулж, чанаргүй активын хэмжээг бууруулсны дүнд банк суларсан эх үүсвэрээр зээл олгох, мөн чанаргүй активаас үүссэн алдагдал багассанаар банкны зээлийн хүү буурах үр нөлөөтэй. Энэ хүрээнд уг журмын 13.3 дахь заалтын дагуу банкууд олон нийтэд чанаргүй активын мэдээллийг өөрсдийн цахим хуудсаар дамжуулан тайлагнах, жилийн тайланд тусгах талаар зөвлөмж өгөв. Мөн банкуудаас Чанаргүй активыг бууруулах стратеги төлөвлөгөөний хүрээнд 2019 онд хэрхэн ажилласан талаарх дотоод үнэлгээний тайланг авч, дүгнэлт хийв. Уг журмын хэрэгжилтийн хүрээнд банкуудын ТУЗ-өөр батлагдсан “Чанаргүй зээлийг бууруулах стратеги”-ийг 2019 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр хүлээн авч, хэрэгжилтийг хянав.

Хяналт шалгалтын чиг үүргийн хүрээнд 2019 онд нийт 9 банкинд ээлжит газар дээрх иж бүрэн шалгалт болон бүх банкуудад хэсэгчилсэн шалгалтыг хийж, банкуудын үйл ажиллагаа, эрсдэл даах чадварт нь хяналт тавьж байна. Энэ арга хэмжээний хүрээнд Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг банкууд хэрхэн хангаж байгааг газар дээр шалган тогтоохоос гадна банкууд банкнаас бусад үйл ажиллагаа эрхэлж байгаа эсэхэд хяналт тавьж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж байна. Мөн Монголбанк, СЗХ-той хамтран санхүүгийн нэгдлийн үйл ажиллагаанд газар дээрх хамтарсан шалгалт хийсэн. (Биелэлт 70 хувь)

4.1.3.5-5. Хөрөнгийн эх үүсвэрийг үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх замаар бий болгоход чиглэсэн арга хэмжээг авах / Монголбанк, 2017-2022/

Засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 299 дүгээр тогтоолоор “Монгол

Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг баталсан. Энэхүү хөтөлбөрийг 2018 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд банкны салбарын өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэн эрсдэл даах чадварыг сайжруулах хүрээнд системийн нөлөө бүхий банкуудыг хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлэх бодлого баримтлахаар тусгасан. Энэ зорилтын хүрээнд системийн нөлөө бүхий банкуудыг хувьцаат компанийн хэлбэрт оруулж, хувьцааг хөрөнгийн бирж дээр арилжаалдаг болох эрх зүйн орчныг бүрдүүлэхээр ажиллаж байна. Иймд Төрөөс мөнгөний бодлогын талаар 2020 онд баримтлах үндсэн чиглэлд тусгасан “Санхүүгийн салбарын тогтвортой байдлын хүрээнд 2.2. Банкны салбарын хувь эзэмшлийн төвлөрлийг бууруулах арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлнэ” гэсэн ажлын хүрээнд банкны хувьцаа эзэмшихэд тавигдах шаардлага, нэг хувьцаа эзэмшигчид тавигдах хязгаарлалт болон банк нээлттэй хувьцаат компани болох боломжийн талаарх олон улсын туршлагыг судлан, системийн нөлөө бүхий банкуудыг хувьцаат компанийн хэлбэрт оруулах хүрээнд Банкны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулав.

Дээрх үндэсний хөтөлбөрт санхүүгийн зах зээлд хөрөнгийн зах зээлийн эзлэх хувийг 12 хувьд хүргэн нэмэгдүүлж, даатгалын зах зээлийн эзлэх хувийг өсгөхөөр тусгасан Энэ хүрээнд хөрөнгийн эх үүсвэрийг үнэт цаасны зах зээлд оруулах болон аж ахуйн нэгж, байгууллагуудыг хөрөнгийн зээлээс хямд эх үүсвэрээр хөрөнгө татах боломжийг нэмэгдүүлэхийн тулд дотоодын хөрөнгийн биржид бүртгэлтэй үндэсний компаниудыг гадаад улсын хөрөнгийн биржид бүртгүүлж, хөрөнгө оруулалт татах мөн гадаад улсад бүртгэлтэй компаниудыг Монгол Улсын хөрөнгийн биржид бүртгүүлэн, хувьцаа арилжих боломжийг нээх хууль эрх зүйн орчин бий болгох ажлыг хэрэгжүүлсэн.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд “Монгол Улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй компани нийт гаргасан үнэт цаас болон түүнд суурилсан хадгаламжийн бичгийн тодорхой хувийг гадаад улсын хөрөнгийн биржид давхар бүртгүүлэн арилжиж болно” гэж заасан. Мөн дээрх заасан компани гадаад улсад үнэт цаас гаргахдаа Хороонд бүртгүүлэх бөгөөд бүртгэлийн



журмыг Хороо тогтооно гэж заасан. Энэ дагуу “Гадаад улсад арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд Монгол Улсад үнэт цаас гаргах, Монгол Улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд гадаад улсад гаргах үнэт цаасыг бүртгэх” журмыг Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 19 дүгээр тогтоолоор баталсан. Иймд гадаадын хөрөнгийн бирж дээр үндэсний компаниуд үнэт цаас гаргах, хөрөнгө оруулалт татах хууль эрх зүйн орчин бүрдсэн.

Хөрөнгийн зах зээлд шинээр оролцох сонирхолтой компаниудад зах зээлийн онцлогийг тайлбарлан таниулах, тэдэнтэй зах зээл дээр амжилттай IPO гаргасан компаниуд өөрсдийн туршлага, мэдлэгээсээ хуваалцаж, амжилт, сорилтоо дэнслэх боломж олгох зорилгоор 2018 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр “Шинээр IPO гаргасан компаниудын нээлттэй зөвлөлдөх үйлзлэлт”-ыг зохион байгуулсан.

Монголбанкнаас Засгийн газрын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч захын арилжааг зохион байгуулахыг дэмжин, хамтран ажиллаж байна. Засгийн газрын үнэт цаасны анхдагч захын арилжаа 2017 оны 11 дүгээр сараас хойш зохион байгуулагдаагүй бөгөөд Монголбанкнаас үнэт цаасыг дахин арилжаалж эхлэх, зах зээлд төгрөгийн өгөөжийн муруйг бүрдүүлж, санхүүгийн зах зээлийн хөгжлийг дэмжих тухай холбогдох байгууллагуудад хүсэлтийг тавьсаар байгаа юм. Тухайлбал, Монголбанкнаас Эдийн засгийн бодлогын зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд Засгийн газрын үнэт цаасны арилжааг идэвхжүүлэх, хамтран ажиллах тухай тусгах саналыг дэвшүүлсэн. Түүнчлэн Монголбанкнаас “Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч, хоёрдогч зах зээлийн үнэ, өгөөж, хүү тооцох болон арилжааны хуваарилалт хийх, Засгийн газрын дотоод үнэт цаасыг хоёрдогч зах зээлээс буцаан худалдан авах аргачлал”-ын төсөлд саналыг хүргүүлсэн юм.

Монголбанкны Олон нийтийн боловсрол, мэдээллийн төв Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоотой хамтран 2019 онд “Үнэт цаасны анхан шатны мэдлэг олгох сургалт”-ыг 4 сар дараалан явуулж, нийт 600 хүнд хүрсэн бол хувь хүний санхүү, өрхийн төсөв, эрсдэл, банк санхүүгийн болон хөрөнгийн зах зээлийн

чиглэлээр 20 аймагт нийт 689 сургагч багш, МСҮТ-ийн 98 багш, 21 арга зүйч бэлтгэн, орон нутгийн иргэдэд бодитоор хүрч чадах дэд бүтцийг бүрдүүлээ. (Биелэлт 70 хувь)

4.1.3.6-1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн дотоод аудитын хяналтын хараат бус байдлыг хангаж, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох /СЯ, 2017-2019/

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн хяналт, аудитын албадыг Сангийн яамнаас салбарын нэгдсэн бодлогоор ханган, дотоод аудитор чиг үүргээ хараат бусаар, аливаа нөлөөлөлд автахгүйгээр гүйцэтгэхэд бүх талаар дэмжлэг үзүүлсэн. Сангийн сайдын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг Дотоод аудитын тухай анхдагч хуулийн төслийг 2017 онд хийгдсэн дотоод аудитын тогтолцооны шинжилгээ, эрх зүйн орчны судалгаанд үндэслэн боловсруулж, 2019 онд тухайн хуулийн төслийн эцсийн найруулгыг бэлэн болголоо. Дотоод Аудиторуудын Олон Улсын Институтээс 2017 оны 1 дүгээр сард дотоод аудитын баримт бичиг, стандартад өөрчлөлт орсонтой холбоотойгоор 2013 онд гаргаж байсан гарын авлагыг шинэчлэн боловсруулж Сангийн сайдын 2019 оны 268 дугаар тушаалаар батлуулан мөрдүүлж байна. (Биелэлт 70 хувь)

4.1.3.6-2. Төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд хийх дотоод аудитын одоогийн тогтолцоонд шинжилгээ хийх, эрх зүйн орчинг судлах, холбогдох арга хэмжээг авах /СЯ, 2017-2022/

Дотоод аудитын тогтолцооны шинжилгээ, эрх зүйн орчны судалгаанд үндэслэн Дотоод аудитын тухай хуулийн төслийг эцэслэн боловсруулснаас гадна дотоод аудитын тайлан, дүгнэлтэд хяналт тавих чиглэлээр чанарын баталгаажуулалтын тогтолцоо нэвтрүүлэх ажлыг гүйцэтгэж байна. 2017 онд дотоод аудитын чанарын баталгаажуулалтын гарын авлага боловсруулж гаргасан бөгөөд Хөвсгөл аймаг, нийслэл, Гадаад харилцааны яам зэрэг байгууллагуудын дотоод аудитын нэгжид туршилтаар чанарын хяналт хийж, зөвлөмж чиглэл өгсөн.

Мөн эрсдэлд суурилсан дотоод аудитын тогтолцоо нэвтрүүлэх хүрээнд ажлын хэсэг байгуулагдан, журам, бодлогын баримт бичгийг шинэчлэх чиглэлээр ажиллаж байна. Дотоод аудитын ажлын үе шатыг цахимжуулах,

нэгдсэн хяналтын тогтолцоог нэвтрүүлэх чиглэлээр програм хангамж хийхээр бэлтгэл ажлыг хангаж байна. Дотоод аудитын ОУ-ын институт зэрэг гадаад дотоодын мэргэжлийн байгууллагуудтай хамтран Дотоод аудитын сургалтын тогтолцоог шинэчлэх судалгааны ажил хийж байна.

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.2-т заасны дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын албадыг үйл ажиллагааны стандарт, арга зүйн удирдлагаар хангах үүднээс 2019 онд Сангийн сайдын 268, 274 дүгээр тушаалаар “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”, “Чанарын үнэлгээний аргачлал” болон “Дотоод аудитын чанарын үнэлгээ хийх журам”-ыг тус тус батлуулан, хэвлэхэд бэлтгэв. “Дотоод аудитын чанарын үнэлгээ хийх журам”-д Сангийн яамнаас чанарын үнэлгээг Төсвийн ерөнхийлөн захирагч нарын дотоод аудитын албанд 2 жил тутамд 1 удаа, харин тухайн Дотоод аудиторын алба нь өөрийн үнэлгээг жилд 1 удаа тус тус хийхээр заасан нь дотоод аудитын тогтолцоог сайжруулах, ажлын үр дүнг дээшлүүлэхэд хөгжүүлэхэд ихээхэн ач холбогдолтой зохицуулалт болсон. (Биелэлт 70 хувь)

4.1.3.7-1. Аудитын байгууллагын акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх /СЯ, УАГ 2017-2019/

2019 онд төсөвт болон төрийн өмчийн оролцоотой 19 байгууллагад төлөвлөгөөт, 5 байгууллагад төлөвлөгөөт бус, нийт 24 байгууллагад хяналт шалгалт хийж, 353.340.8 сая төгрөгийн 21 албан шаардлага, 525.5 сая төгрөгийн 5 акт тогтоож, нийт 353,866.3 сая төгрөгийн зөрчил илрүүлж, Сангийн сайдын дотоод аудитын хурлаар хэлэлцүүлэн 19 тогтоолоор 124 зөвлөмж хүргүүлсэн. Акт, албан шаардлага, зөвлөмжийг цахим хяналт-шинжилгээ, үнэлгээний “Лидер мониторинг” (LM) программд оруулан улирал тутам биелэлтийг тухайн байгууллагуудаас гаргуулан хэрэгжилтийг хангуулж байна.

Төрийн аудитын байгууллага нь 2017, 2018, 2019 онуудад хуулийн байгууллагад шилжүүлсэн асуудал, акт, албан шаардлагыг бүртгэж, биелэлтийг холбогдох газруудаас авч нэгтгэн дүгнэв. Энэ ажлын хүрээнд Төрийн аудитын байгууллагаас /Үндэсний

аудитын газар болон орон нутаг дахь Төрийн аудитын газар/ 2017, 2018, 2019 онуудад эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гэмт хэргийн шинжтэй мэдээллийг шилжүүлсэн талаарх судалгаа; Үндэсний аудитын газраас 2017, 2018 онуудад тавьсан акт, албан шаардлагын бүртгэл, биелэлт, Төрийн аудитын байгууллагаас /Үндэсний аудитын газар болон орон нутаг дахь Төрийн аудитын газар/ 2017, 2018 онуудад шүүхийн журмаар цуцлагдсан акт, албан шаардлагын талаарх судалгаа зэргийг гаргаж дүн шинжилгээ хийж байна.

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, Улсын төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн, Засгийн газрын өрийн удирдлагын 2016-2018 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилт болон бусад тайланд хийсэн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Сангийн сайдын 2019 оны 175 дугаар тушаалаар батлуулсан. Сангийн сайдад өгсөн зөвлөмж, албан шаардлагын биелэлтийн явцад 2020 оны 1 дүгээр улирлын байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээнд нийт 47 зөвлөмж, 4 албан шаардлага хамрагдсан бөгөөд зөвлөмжийн хэрэгжилт 94.6 хувь, албан шаардлагын биелэлт 77.5 хувьтай байна.

Мөн Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдсэн, дуусаагүй орхигдсон барилгуудад хийсэн аудитын тайлан, Сангийн яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлан, Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хийсэн аудитын тайлан, Орон нутгийн хөгжлийн сангийн 2018 оны хөрөнгийн зарцуулалтад хийсэн аудитын тайлангаар тус тус өгсөн зөвлөмжүүдийн биелэлт бүрэн хангагдсан болно. Төрийн аудитын байгууллага нь 2019 оны гүйцэтгэх аудитын төлөвлөгөөний дагуу хийсэн аудитаар өгсөн акт, албан шаардлага, дүгнэлт зөвлөмжийг аудитын сэдэв бүрээр <https://www.audit.mn/report/7> сайтад байршуулсан.

Төрийн аудитын байгууллагаас өгсөн зөвлөмж, албан шаардлага, төлбөрийн актын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх ажлыг хөндлөнгийн байгууллагаар гүйцэтгүүлж байна. (Биелэлт 70 хувь)



4.1.3.7-2. Иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирлыг барагдуулсны улмаас захиргааны байгууллагад учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлэх тогтолцоог бүрдүүлэх /СЯ, 2017-2019/

Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.2-т “Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна” гэж заасны дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчдын дэргэдэх дотоод аудитын нэгжүүд хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газарт 2019 онд албан тушаалтны буруутай шийдвэрээс болж төр хохирсон талаар гомдол шалгагдаагүй болно.

Төрийн аудитын байгууллага Үндэсний стандартыг батлан гаргасантай холбогдуулан Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга, дагаж мөрдөх түүнтэй нийцсэн эрх зүйн орчин бий болгох хэрэгцээ шаардлага гарсан. Хэрэгцээ шаардлагад тулгуурлан судалгааны институт, төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулан, ажлын даалгаварт заасан үр дүнг хүлээн авч эрх зүйн тогтолцоог сайжруулахаар төлөвлөж байна.

Үндэсний аудитын газар, Авлигатай тэмцэх газартай хамтран “Төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх арга зам” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулсан бөгөөд иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирлыг барагдуулсны улмаас захиргааны байгууллагад учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлэх тогтолцоог бүрдүүлэхээр ажиллаж байна.

Хууль хэрэгжүүлэх ажлын хүрээнд Төрийн аудитын байгууллагаас 2019 онд “Төрийн албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсны улмаас төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх” ажлыг зохион байгуулан судалгаа хийсэн. Төрийн албаны шинэтгэлийн үйл явцад гарсан зарчмын өөрчлөлтүүдийн нэг бол төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон

бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх зохицуулалтыг хэрэгжүүлэхээр Төрийн албаны зөвлөлтэй хамтран ажиллаж байна. (Биелэлт 30 хувь)

4.1.3.7-3. Аудитын дүгнэлтийн мөрөөр хийсэн ажлын үр дүнг хянах, үнэлэх нэгдсэн журмыг батлан мөрдүүлэх /СЯ, 2018-2020/

Сангийн яамнаас бусад байгууллагуудтай хамтран Дотоод аудитын тухай анхдагч хуулийн төслийг боловсруулж эцсийн хувилбарыг бэлэн болгосон.

“Дотоод аудитын дүрэм”-ийн 8.5-д “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төсвийн ерөнхийлөн захирагчийн болон бусад төсвийн захирагч нарын дотоод аудитын үйл ажиллагаанд дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартын дагуу чанарын хяналтын үнэлгээг 2 жилд 1 удаа хийнэ” гэж заасны дагуу Нийслэлийн дотоод аудитын алба, Гадаад харилцааны яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, Хөвсгөл аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны дотоод аудиторчуудын аудитын дүгнэлт, ажлын материалд чанарын баталгаажуулалтын гарын авлагын дагуу баталгаажилт хийж хөндлөнгийн үнэлэлт дүгнэлт өгсөн. Гарын авлагыг дээрх 3 байгууллагын үйл ажиллагаанд хяналт хийж туршиж, 2019 онд гарын авлагыг шинэчлэн боловсруулж батлуулав.

2019 оноос Сангийн сайдын 268, 274 дүгээр тушаалаар “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”, “Чанарын үнэлгээний аргачлал” болон “Дотоод аудитын чанарын үнэлгээ хийх журам”-ыг тус тус батлан мөрдүүлж байна. Арга хэмжээний мөрөөр хийсэн ажлын үр дүнг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасан аргачлалын дагуу үнэлгээ хийж байна. (Биелэлт 70 хувь)

4.1.3.8-1. Аудитын байгууллагын ажиллах тэгш нөхцөлийг хангах /СЗХ, СЯ, 2017-2022/

Аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 6 дугаар зүйлийн 6.1.2, 19 дүгээр зүйлийн 19.3.6, 19.3.7 дэх заалтаар тус тус эрх зүйн орчинг бий болгосон бөгөөд Аудитын тухай хуулийн

19 дүгээр зүйлийн 19.3-19.6, 19.4 дэх заалтад заасан нөхцөл шаардлагын дагуу аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий бүх аудитын компаниудад адил түвшний нөхцөл шаардлага тавигдаж байна. Хэрэв гадаад улсын аудитын хуулийн этгээдийг ажиллуулах бол Аудитын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.6, 19.3.7 дэх заалтад заасан нэмэлт шаардлага тавьж ажиллах тэгш нөхцөлийг хангуулж байна.

Даатгалын байгууллагад аудитын үйлчилгээ явуулах эрхтэй компаниудын мэдээллийг СЗХ-ны <http://frc.gov.mn/daatgal#> цэсний “Аудитын компани” хэсэгт байршуулж ажиллаж байна. Даатгалын байгууллагад аудит хийх эрхийг 2019 онд шинээр 1 хуулийн этгээдэд олгосон байна. Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй аудитын компаниудын холбогдох мэдээллийг тухай бүр шинэчлэн Хорооны цахим хуудасны тусгай зөвшөөрөл эзэмшигчид хэсэгт байршуулж байна. Тус мэдээлэлд компанийн оноосон нэр, тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл, хаяг байршил, удирдлагын мэдээлэл, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар багтдаг ба олон нийтэд нээлттэй байна. (Биелэлт 30 хувь)

4.1.3.8-2. Тусгай зөвшөөрөл бүхий аудитын байгууллагаас хийсэн аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмж болон тусгай зөвшөөрөл бүхий аудитын байгууллагад төрийн захиргааны байгууллагаас хийсэн хяналт шалгалтын дүнг олон нийтэд нээлттэй болгоход чиглэсэн арга хэмжээ авах /СЯ, 2017-2018/

Сангийн сайдын 2019 оны 119 дүгээр тоот тушаалаар Аудитын тусгай зөвшөөрөл бүхий аудитын байгууллагад Сангийн сайдын 2019 оны 60 дугаар тушаалаар баталсан “Аудитын хуулийн этгээдэд хийх чанарын хяналтын журам”-ыг дагуу хяналт шалгалт хийсэн. Хяналт шалгалтын нэгдсэн дүнгийн шийдвэрийг Сангийн яамны “Ил тод” цахим хуудаст байршуулан олон нийтэд мэдээлж ажилласан. Мөн Аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалтыг Сангийн яамны “Ил тод” цахим хуудсанд 2019 оны байдлаар нийт 5 удаа байршуулан олон нийтэд мэдээлж ажилласан байна.

Тусгай зөвшөөрөл бүхий аудитын байгууллагаас хийсэн аудитын тайлан, дүгнэлт,

зөвлөмжийг мэдээлэх тухайд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.7-д “Аж ахуйн нэгж, байгууллага нь зөвхөн аудит хийлгэсэн жилийн санхүүгийн тайлан болон түүний хураангуйг аудиторын дүгнэлтийн хамт өөрийн цахим хуудсанд байршуулж ил тод болгож болно.” гэж заасны дагуу аж ахуйн нэгж байгууллага өөрөө мэдээлэх боломжтой. (Биелэлт 100 хувь)

4.1.3.9-1. Төрийн аудитын байгууллагын зөвлөмжийг үр дүнтэй хэрэгжүүлэх эрх зүйн орчинг бий болгох /ХЗДХЯ, 2018-2020/

Төрийн аудитын байгууллага нь аудитын зөвлөмжийг үр дүнтэй хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдүүлэн, аудитын үйл ажиллагаа, аудитын явц, аудитын гүйцэтгэл, баталгаажуулалтыг журамласан 1 дүрэм, 18 журмыг бий болгосон/<https://www.audit.mn/detail/5e1d24e0c4296/>.

Эдгээр эрх зүйн актыг сайжруулах, шинэчлэх зорилгоор 2019 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын аудитын үйл ажиллагаатай холбогдох дүрэм, журам, зааврын үр дагаварт үнэлгээ хийж хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгах, түүний хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудал, эерэг, сөрөг нөлөөлөл, давхардал хийдлийг илрүүлэх, цаашид төрийн аудитын байгууллагын аудитын үйл ажиллагаанд холбогдох дүрэм, журам, заавруудыг зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлох /дүрэм, журам, зааврын төсөл боловсруулах/-оор төрийн бус байгууллагатай гэрээ байгуулан ажиллаж байна. (Биелэлт 70 хувь)

4.1.3.9-2. Төрийн аудитын байгууллагын хараат бус байдлыг хангах, аудитын байгууллагын тогтолцоог боловсронгуй болгох /ҮАГ, 2017-2018/

Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтад “Төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт,



үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.” хэмээн төрийн аудитын байгууллагын үндсэн чиг үүрэг, зарчмыг баталгаажуулсан.

“Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” УИХ-ын 2020 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 02 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарийн 1.2.5-д “төрийн санхүү, төсвийн хяналт /аудит/-ыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтоох;”, 1.2.6-д “төрийн нийтийн өмчийг зохистой ашиглах, зарцуулахад тавих хяналтыг боловсронгуй болгох.” гэсэн үзэл баримтлалын чиглэл болгон тусгасан.

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2019 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн А/77 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсэг Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл (<http://audit.mn/detail/5df1d02e77165>)-ийг боловсруулж, иргэд, олон нийтээс санал авахаар [www.audit.mn](http://www.audit.mn) цахим хуудсанд байршуулсан.

Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 39.1.“Энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-т заасан аудитыг гүйцэтгэхэд төрийн аудитын байгууллагын албан хаагч бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд саад учруулсан, аливаа дарамт, шахалт үзүүлсэн, хууль бус нөлөөллийн талаар нөлөөллийн мэдүүлэг хөтөлнө.”, 39.2. “Нөлөөллийн мэдүүлэг хөтөлөх журмыг Монгол Улсын Ерөнхий аудитор батална.” гэсэн заалтыг тусгасан болно.

Төрийн аудитын байгууллагын эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр “Төрийн аудитын байгууллагаас албан шаардлага хүргүүлэх, төлбөрийн акт тогтооход баримтлах журам”-ыг шинэчлэн боловсруулж, төсөлд иргэд олон нийтээс санал авахаар байршуулсан. (<http://audit.mn/detail/5d969a1bb1578>) (Биелэлт 70 хувь)

4.1.3.9-3. Удаа дараагийн аудитаар нягтлан бодох бүртгэлийн хөтөлөлт, дотоод хяналт хангалттай үнэлгээ авсан байгууллагын санхүүгийн тайланд жил бүр аудит хийдэггүй байх нөхцөл, шалгуурыг боловсронгуй болгох /ҮАГ, СЯ, 2017-2020/

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2015 оны 240 дүгээр тушаалаар баталсан “Санхүүгийн тайлангийн аудитад итгэл үзүүлэхэд баримтлах журам”-ын дагуу “...нягтлан бодох бүртгэлийн хөтөлөлт, дотоод хяналт сайтай нь тогтоогдож 3 жил дараалан санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилгүй санал дүгнэлт авсан...” заалтын дагуу байгууллагуудад итгэл үзүүлэн санхүүгийн тайланд нь аудит хийхгүй өнжөөж батламж олгож байна. Уг журам ҮАГ-ын цахим хуудсанд байршсан.

2019 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Монгол Улсын Ерөнхий аудиторовын тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын аудитын үйл ажиллагаатай холбогдох дүрэм, журам, зааврын үр дагаварт үнэлгээ хийж хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгах, түүний хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудал, эерэг, сөрөг нөлөөлөл, давхардал хийдлийг илрүүлэх, цаашид Төрийн аудитын байгууллагын аудитын үйл ажиллагаанд холбогдох дүрэм, журам, заавруудыг зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлох зорилготой ажлын даалгаврыг зөвлөх багаар гүйцэтгүүлж байна. (Биелэлт 30 хувь)

4.1.3.9-4. Төрийн аудитын байгууллага зарим чиг үүргээ аудитын бусад байгууллагаар гүйцэтгүүлэхдээ тэгш оролцоог хангах, олон нийтийн хяналтыг сайжруулах./2018-2020 он/

Төрийн аудитын байгууллага зарим чиг үүргээ аудитын бусад байгууллагаар гүйцэтгүүлэхдээ тэгш оролцоог хангах, олон нийтийн хяналтыг сайжруулах үүднээс “Санхүүгийн тайланд аудит хийх хараат бус аудитын хуулийн этгээдийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журам”-ыг Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2017 оны А/191 дүгээр тушаалаар батлан, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.



Уг журмыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлсэн.

Үндэсний аудитын газар, Авлигатай тэмцэх газартай хамтран “Санхүүгийн тайланд аудит хийх хараат бус аудитын хуулийн этгээдийг сонгон шалгаруулах журам”-ыг сайжруулах, олон нийтийн санал, шүүмжийг сонгох, журмыг хэрэглэхэд хүндрэлтэй болон ололтой тал, Хувийн аудитын компани, иргэд олон нийтийн саналыг сонсох зорилгоор “Аудитын байгууллагын зарим чиг үүргийг аудитын бусад байгууллагаар гүйцэтгүүлэх хэрэгцээ шаардлага” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулсан. (Биелэлт 70 хувь)

4.1.3.10-1. Төрийн аудитын хуульд заасны дагуу Төрийн аудитын байгууллагаас хийсэн аудитын тайланг олон нийтэд мэдээлэх/ҮАГ, 2017-2022/

Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу Төрийн аудитын байгууллагаас хийсэн аудитын тайланг Монгол Улсын Ерөнхий аудитор баталгаажуулан тухай бүр байгууллагын албан ёсны цахим хуудас болох audit.mn сайтад ил тод байршуулж ажилласан. Аудитын тайлантай холбоотой нийт 117 мэдээ, мэдээлэл 2019 онд ил тод байршуулсан.

Зууны мэдээ, Өдрийн сонинд тогтмол “Төрийн аудит” булан ажиллуулж баталгаажсан аудитын тайлантай холбоотой мэдээллүүдийг олон нийтэд ойлгомжтой байдлаар буюу хураангуй мэдээ, нийтлэл, инфографик байдлаар хүргэсэн.

Үндэсний аудитын газар 2019 онд “Нээлттэй нийгэм форум”-тай байгуулсан санамж бичгийн хүрээнд “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдсэн, дуусаагүй орхигдсон барилгуудын гүйцэтгэлийн аудитын тайлан-2018” болон “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтэд хийсэн аудитын дүгнэлт”-ийг инфографик болгон байгууллагын цахим хуудаст байршуулж, мөн 300 хувь хэвлэж олон нийтэд хүргэсэн.

Аудитын тайланг инфографик, видео шторк, богино хэмжээний хөдөлгөөнт болон дүрст контент хэлбэрт хувирган сонирхолтой хэлбэрт шилжүүлснээр иргэдийн аудитын үйл ажиллагаа, дүгнэлт тайлангийн талаарх ойлголт сайжирч хэвлэл мэдээллийн байгууллагууд олон

нийтэд мэдээллийг ойлгомжтой, товч байдлаар хүргэж байна. Төрийн аудитын байгууллагаас 2019 онд олон нийтийг мэдээллээр хангах ажлын хүрээнд нарийвчилсан төлөвлөгөө гарган аудитын үйл ажиллагаа /аудитын нээлт, үйл явц, тайлан, акт албан шаардлагын биелэлт/-тай холбоотой мэдээллийг тухай бүр байгууллагын албан ёсны цахим хуудсанд байршуулж олон нийтэд ил тод мэдээлж ажилласан.

2019 онд аудитын үйл ажиллагаатай холбоотой 36 мэдээ, мэдээлэл ил тод байршуулсан. (Биелэлт 100 хувь)

4.1.3.10-2. Аудит хийхдээ эрсдэлтэй сэдэв, чиглэлийн талаар олон нийтээс санал, судалгаа авах үйл ажиллагааг цахим технологи ашиглан нэвтрүүлэх/ҮАГ, 2017-2019/

Төрийн аудитын байгууллага нь аудитын сэдэв сонголт, чиглэлийн талаар олон нийтээс санал судалгаа авч тусгах, эрсдэлтэй сэдэв сонгох үйл ажиллагааг зохион байгуулж байна. Тухайлбал, аудитын иргэний танхимыг Нийслэл, Говь-Алтай, Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын дэргэд ажиллуулж байна.

Аудитын сэдвийн сонголтод олон нийтийн саналыг цахимаар авах нөхцөлийг бий болгох урьдчилсан судалгааг цахим систем нэвтрүүлсэн гадаад /АНУ, Гүрж улс, Мексик г.м/ улсын туршлагыг судалж “Дижитал аудит 2025” төслийн багт уг асуудлаар судалгаа хийх зөвлөхийг авч ажиллуулан ҮАГ-т хэрэгжиж байгаа Дэлхийн банкны Засаглалыг бэхжүүлэх төслийн зөвлөхтэй судалгааны ажлаа уялдуулан ажиллаж, систем хөгжүүлэх төлөвлөгөөг гарган ажиллаж байна.

Аудитын тайлан, аудитын мөрөөр хэрэгжүүлэх ажлыг иргэд, олон нийтэд түгээх, сэдвийн сонголтод иргэдийн саналыг авах системийг хөгжүүлэх гүйцэтгэгчид тавих шаардлагыг Дэлхийн банкны Засаглалыг бэхжүүлэх төслийн зөвлөхтэй хамтран боловсруулж, төслийн удирдлагад хүргүүлээд байна. Мөн Аудитын тайлан, аудитын мөрөөр хэрэгжүүлэх ажлыг иргэд, олон нийтэд түгээх, сэдвийн сонголтод иргэдийн саналыг авах системийн гар утсанд зориулсан хувилбарыг давхар хөгжүүлэхээр төлөвлөсөн. (Биелэлт 30 хувь)



4.1.3.10-3. Төрийн аудитын байгууллагаас гаргасан акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг төрийн байгууллагууд шилэн данс болон цахим хуудсаар олон нийтэд мэдээлдэг болох /СЯ, 2017-2019/

Төрийн аудитын байгууллагын хараат бүс байдал, тогтолцоог сайжруулах ажлын хүрээнд байгууллагын хэмжээнд мөрдөгдөж байгаа дүрэм журмын шинэчлэлтийг хийх ажлын хэсгийг Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаалаар томилсон бөгөөд уг ажлын хэсэг “Төрийн аудитын байгууллагаас гаргасан акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг төрийн байгууллагууд шилэн данс болон цахим хуудсаар олон нийтэд мэдээлдэг байх” холбогдох журмаар зохицуулалт хийхээр ажиллаж байна.

Сангийн яам Төсвийн тухай хуульд заасны дагуу аппаратын санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг жил бүрийн 2 дугаар сарын 25, Сангийн сайдын багцын санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг 5 дугаар сарын 5-ны дотор тус Үндэсний аудитын газраас авсны дараа тухай бүр Шилэн дансанд байршуулдаг.

Үндэсний аудитын газраас аудитад хамрагдсан бүх байгууллагын зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтийг эмхэтгэл болгон хэвлүүлж, акт, албан шаардлага, зөвлөмж, түүний биелэлтийг хагас, бүтэн жилийн байдлаар audit.mn сайтад байршуулсан.

Сангийн яам нь үндсэн хэрэгжүүлэгч байгууллагын хувьд хөтөлбөрийн энэ заалтын хүрээнд нийт төрийн байгууллагууд төрийн аудитын байгууллагаас гаргасан акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг шилэн данс болон цахим хуудсаараа мэдээлж буй байдалд Үндэсний аудитын газартай хамтран хяналт тавьж, хэрэгжилтэд нэгдсэн дүгнэлт хийж, үнэлгээ өгөх шаардлагатай байна.

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.дах заалт энэ хуулийн 3.1.1-д төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлэхээр заасны дагуу ТЕЗ нарын дэргэдэх дотоод аудитын алба нэгжүүд шилэн дансны хуулийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж байна.

Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын 9 дүгээр зүйлийн 9.10 дахь заалтын дагуу тус яамнаас ТЕЗ нарын шилэн дансны хөтөлөлтийн байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээг 2015 оноос хойш жил бүр хийж, ЗГХЭГ-т хүргүүлэн тайлагнаж байна. ТЕЗ нарын шилэн дансны хөтөлөлтийн 2019 оны байдалд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээнд нийт 53 ТЕЗ хамрагдсан бөгөөд ТЕЗ нарын шилэн дансны хөтөлөлт дунджаар 97.7 хувийн биелэлттэй буюу шилэн дансны хуулийг ТЕЗ нар “хангалттай сайн” хэрэгжүүлж ажилласан дүнтэй байна.

Шилэн дансанд Төрийн аудитын байгууллагаас гаргасан акт, зөвлөмж, албан шаардлагатай холбоотой дараах мэдээллийг оруулж буй бөгөөд 2019 оны хэрэгжилтийн үнэлгээг дор харуулав.

Мэдээллийн төрөл	2019
Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт	72.5
Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн	93.6
Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан	88.2

Зарим байгууллагын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт гараагүй, шилэн дансны цахим хуудаст байршуулах хуулийн хугацаа болоогүй байгаа тул хэрэгжилтийг үнэлэх боломжгүй байна.

Төрийн аудитын байгууллагаас гаргасан Сангийн яамны аппаратын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг хуулийн хугацаанд шилэн дансны цахим хуудсанд байршуулсан болно. Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас 2019 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөний дагуу Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газар “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт” сэдэвт аудитыг хийж гүйцэтгэсэн. МУ-ын Ерөнхий аудитын 2019 А/76 дугаар тушаалаар аудитын тайланг баталгаажуулан УИХ-ын Төсвийн байнгын хороонд хүргүүлэн, шилэн дансны мэдээлэл

иргэдэд ойлгомжтой байгаа эсэхэд дүн шинжилгээ хийж, цаашид боловсронгуй болгох талаар Сангийн яаманд зөвлөмж өгсөн. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аудит хийснээр төсөв санхүүгийн оновчтой, ил тод байх тогтолцоо сайжрах хандлагатай байна. (Биелэлт 70 хувь)

**Дөрөв. Худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үр ашигтай, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр:**

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 4 дэх зорилтын хүрээнд нийт 5 үйл ажиллагаа, 15 арга хэмжээ тусгагдсан бөгөөд үүнээс 2019 онд 12 арга хэмжээг хэрэгжүүлж дуусган, 3 арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Зорилтын хэрэгжилтийг тоймлон танилцуулбал:

**4.1.4.1-1. Цахим худалдан авах ажиллагааны нэгдсэн системийг боловсронгуй болгох үйл ажиллагааг дуусгах**

Засгийн газраас төрийн болон орон нутгийн төсвийг үр ашигтай захиран зарцуулах, худалдан авах ажиллагааг хурдан шуурхай, олон нийтэд хүртээмжтэй, ил тод, нээлттэй зохион байгуулах, түүнд олон нийтийн хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх зорилгоор “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем” буюу [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)-ийг 2017 онд бүрэн ашиглалтад оруулсан байна.

2018 оны байдлаар 1433 захиалагчийн худалдан авах ажиллагааны 21417 төлөвлөгөө бүртгэгдэж байсан бол 2019 онд нийт 2035 захиалагчийн худалдан авах ажиллагааны 27010 (өссөн дүнгээр) төлөвлөгөөний талаарх мэдээлэл бүртгэгдэж, 598 захиалагч, 5593 төлөвлөгөөгөөр нэмэгдсэн байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг 2019 оны 3 дугаар сарын 22-ны өдөр УИХ-аас батлан, 2019 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж эхэлсэн. Тус хуулиар худалдан авах ажиллагааны цахим систем, цахим худалдан авах ажиллагаа

болон цахим дэлгүүрийн эрх зүйн орчныг бүрдүүлэхтэй холбоотой хуулийн заалтыг шинээр тусган батлуулсан.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар шинээр дараах 6 журмыг Засгийн газрын тогтоолоор болон Сангийн сайдын тушаалаар батлан мөрдөж байна:

1. “Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн дүрэм” (Засгийн газрын 2019 оны 274 дүгээр тогтоол);
2. “Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг хөтлөх журам” (Засгийн газрын 2019 оны 274 дүгээр тогтоол);
3. “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам” (Сангийн сайдын 2019 оны 255 дугаар тушаалаар);
4. “Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх, гэрчилгээ олгох журам” (Сангийн сайдын 2019 оны 37 дугаар тушаал);
5. “Тендерт оролцогчоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журам” (Сангийн сайдын 2019 оны 131 дүгээр тушаал);
6. “Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох журам” (Сангийн сайдын 2019 оны 132 дугаар тушаал).

Төрийн худалдан авах ажиллагааны цахим системийн шаардлагатай хөгжүүлэлтийн ажлыг хийж, боловсронгуй болгож байгаагийн зэрэгцээ нэгдсэн системийн дэд системүүдийг үе шаттай нэвтрүүлэн ашиглаж байна. 2019 онд системийг боловсронгуй болгох, хууль журамтай холбоотой өөрчлөлтүүдийг хийж, үйл ажиллагаанд нэвтрүүлсэн. Үүнд:

- Тендерт оролцогч тал гомдол гаргахдаа цахим хэлбэрээр гаргах, түүнийг захиалагч болон Сангийн яам, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар цахим хэлбэрээр хүлээн авч хариуг хүргүүлэх боломжийг бүрдүүлсэн;
- Тендерийн материалыг тухайн тендерт оролцогчдод цахим системээр дамжуулан хүсэлт гаргаж тендерийн материалтай танилцах боломжийг бүрдүүлсэн;
- Цахим системд тендерт эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтыг байршуулсан;



- Тодруулгыг цахим хэлбэрээр хүлээн авах нөхцөлийг нэмж бүрдүүлсэн;
- Түншлэлийг цахим хэлбэрээр гаргах нөхцөл бүрдсэн. (Биелэлт 100 хувь)


**4.1.4.1-2. Худалдан авах үйл ажиллагааны тендерийн үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх**

Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)-д 2018 онд 1433 захиалагчийн худалдан авах ажиллагааны 21417 төлөвлөгөө бүртгэгдэж байсан бол 2019 онд нийт 2035 захиалагч байгууллагын хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөлтийн талаарх 27010 (өссөн дүнгээр) мэдээлэл бүртгэгдэн олон нийтэд мэдээлэгдсэн нь 598 захиалагч болон 5593 төлөвлөгөөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь захиалагч байгууллагууд худалдан авах ажиллагааны мэдээллийн нээлттэй байдлыг хангаж, өрсөлдөх боломжийг бий болгох, худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулах, цахим системийн ашиглалтад дэвшил гарч байгааг харуулж байна.

Тус системээр дамжин 2018 онд 10202, 2019 онд 17371 тендер шалгаруулалтын үр дүн олон нийтэд мэдээлэгдсэн бөгөөд харьцуулбал 41.0 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Үүнээс: нээлтийн 2528, тендер шалгаруулалтын 14458 үр дүнг мэдээлсэн бол хянан үзсэн 342, бусад үр дүнгийн 43 төлөв гарсан дүнтэй байна.

Төрийн худалдан авах ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх хүрээнд төсвийн урсгал зардлаар санхүүжүүлдэг байнгын хэрэгцээт бараа, бүтээгдүүнийг төрийн худалдан авах ажиллагааны цахим системийн дэд системээр дамжуулан Ерөнхий гэрээ байгуулах журмаар 2 жил зохион байгуулав. 2019 онд Засгийн газрын 2018 оны 388 дугаар тогтоолоор батлагдсан “Зарим ерөнхий нэршлийн эмийг ерөнхий гэрээгээр худалдан авах” төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулах хүрээнд 31 нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх 15 нийлүүлэгч аж ахуйн нэгжтэй 47 ерөнхий гэрээ байгуулж, Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) -ийн дэд систем

**2019 онд зохион байгуулагдсан худалдан авах ажиллагаа**



**(Төсвийн ерөнхийлөн захирагчаар)**

Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) -д нийт 17722 төсөл, арга хэмжээний тендерийн урилга зарлагдснаас 17384 нь “Цахим тендер шалгаруулалт”-ын урилга буюу нийт урилгын 98.0 хувийг эзэлж, өмнөх оны(88.5 хувь)-хоос 9.5 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Энэ нь цахим системийн хэрэглээ нэмэгдэн, худалдан авах ажиллагааны ил тод байдалд ахиц гарсныг харуулж байна.

болох “Цахим дэлгүүр”-ээр ерөнхий гэрээний худалдан авалтыг гүйцэтгэсэн. Мөн Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын “Элэгний В, С вирусийн илрүүлэг, шинжилгээнд шаардагдах түргэвчилсэн оношлуурыг худалдан авах ерөнхий гэрээ байгуулах” төсөл, арга хэмжээний нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийг зохион байгуулж, 2019 оны 03 сарын 22-ны өдөр шалгарсан 3 аж ахуйн нэгжтэй ерөнхий гэрээ байгуулан

2 дахь шатны сонгон шалгаруулалтыг “Цахим дэлгүүр”-ийн системээр гүйцэтгэсэн. 2019 онд зохион байгуулсан ерөнхий гэрээний худалдан авах ажиллагааны үр дүнд “Цахим дэлгүүр”-ээр нийт 2223 удаагийн захиалга хийгдэн 31 нэр төрлийн 8.9 тэрбум төгрөгийн эм, хэрэгсэл худалдан борлуулагдаж, улсын төсвийн урсгал зардалд 464.9 сая төгрөгийн хэмнэлт гарсан байна.

Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)-ний бараа, ажил, үйлчилгээний ангиллын системд нийт 27085 бараа, ажил, үйлчилгээ бүртгэлтэй байгаа нь өмнөх жилийн мөн үеэс 3234-өөр (23851 байсан) буюу 13.6 хувиар нэмэгдсэн байна. Мөн худалдан авах ажиллагаанд шалгарсан оролцогчтой гэрээ байгуулсан мэдээллийг тус цахим системд нийтэлж, олон нийтэд ил тод мэдээлэх ажилд ахиц гарч, 2019 онд 5077 гэрээний мэдээллийг ил тод болгосон нь өнгөрсөн оныхоос 3.4 дахин нэмэгдсэн үзүүлэлт юм. (Биелэлт 100 хувь)

4.1.4.2-1. Тендер шалгаруулалтын талаар гарсан гомдлыг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх хянан шийдвэрлэх чиглэлээр журам боловсруулах

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1.7-д заасныг 2019.03.22-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсны дагуу Сангийн сайдын 2019 оны 6 дугаар сарын 4-ний өдрийн 131 дүгээр тушаалаар «Тендер оролцогчдоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журам»-ыг батлан мөрдөн эхэлсэн. <https://www.legalinfo.mn/law/details/14468?lawid=14468> (Биелэлт 100 хувь)


4.1.4.2-2. Иргэд тендерийн үйл ажиллагаа, явц байдлын талаар санал, бодлоо илэрхийлэх, харилцах, гомдол гаргах асуудлыг “Цахим худалдан авах ажиллагааны нэгдсэн систем”-д тусгах

Иргэд, олон нийт тухайн тендертэй холбоотой тодруулгыг цахим хэлбэрээр гарган зохион байгуулагчид ирүүлэх, захиалагч тал цахим тодруулгыг хүлээн аваад тодруулгын хариуг нийт сонирхогч, оролцогчдод нээлттэйгээр системд байршуулан мэдээлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна. Нийлүүлэгч тал гомдол гаргахдаа цахим хэлбэрээр гаргах, түүнийг

захиалагч болон Сангийн яам, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар цахим хэлбэрээр хүлээн авч, хариуг хүргүүлэх боломжийг мөн бүрдүүлсэн. 2019 онд Сангийн яамнаас тендер оролцогчийн гомдлыг албан бичгээр (уламжлалт хэлбэрээр) хүлээн авсан бөгөөд тухайн гомдолтой холбоотой тендер оролцогчийн ирүүлсэн тендерийн материалыг цахим системээс татан авч, хянан шийдвэрлэж байна.

Сангийн сайдын 2019 оны 132 дугаар тушаалаар батлагдсан “Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендер оролцогчдод ил болгох журам”-ыг хэрэгжүүлэх хүрээнд тендерийн материалтай тухайн тендер оролцогч цахим системээр дамжуулан танилцах боломжийг цахим системд бүрдүүлсэн.

Иргэд, олон нийт, тендер оролцогч, захиалагч байгууллагын төлөөлөлд худалдан авах ажиллагаатай холбоотой шуурхай үйлчилгээ үзүүлэх, зөвлөгөө өгөх чиглэлээр холбоо барих утас, албаны и-мэйл хаягаар ирсэн санал хүсэлтэд шуурхай хариулахаас гадна төрийн худалдан авах ажиллагааны цахим систем [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)-д LiveHelpDesk-ийг ашиглалтад оруулж хэрэглээнд нэвтрүүлэв. Ингэснээр ажлын бус цагаар үйлчлүүлэх, цахим худалдан авах ажиллагаатай холбоотой зөвлөгөөг цаг алдалгүй шуурхай авах, иргэд, олон нийт, тендер оролцогч, захиалагч байгууллагын үлдээсэн цахим зурвас, захидал, асуултад цахим шуудангаар хариу хүргүүлэх боломжийг бүрдүүлэн зөвлөгөө, мэдээллийг өгч байна. Мөн худалдан авах ажиллагааны цахим системд нийтлэгдсэн тендерийн урилгыг олон нийтийн сүлжээний нийтлэг хэрэгсэл болох твиттер хуудсанд дамжуулан нийтлэх боломжийг бий болгон иргэд, олон нийтэд шуурхай мэдээлэл түгээх арга хэлбэрийг нэмэгдүүлсэн. (Биелэлт 100 хувь)



#### 4.1.4.2-3. Тендер шалгаруулалтын талаар гарсан гомдол мэдээллийг хянан шийдвэрлэсэн байдалд дүн шинжилгээ хийх /СЯ, ТӨБЗГ, 2017-2019/:

Сангийн яам Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1-д заасны дагуу тендерт оролцогчоос ирүүлсэн гомдлын шийдвэрлэлтийг цахим хуудсаараа дамжуулан сар бүр мэдээлж байна.

Сангийн яаманд 2017 онд тендер шалгаруулалттай холбоотой нийт 813 гомдол ирүүлснийг тендерт оролцогчдоор дамжуулан 453 хууль бус шийдвэрийг хуульд нийцүүлэх арга хэмжээ авч ажилласан байна.

Сангийн яам гомдлын шийдвэрлэлтэд дүн шинжилгээ хийж Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2017 оны худалдан авах ажиллагааны нэгдсэн тайланд дурдаж Засгийн газрын 2018 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн хуралдааны 16 дугаар тэмдэглэлээр Төсвийн ерөнхийлөн захирагч нарт үнэлгээний хороонд тавих захиалагчийн хяналтыг сайжруулж ажиллахыг даалгасан.

2018 онд тендер шалгаруулалттай холбоотой нийт 1446 гомдол холбогдох байгууллагуудад гаргасан бөгөөд үүнээс 198 гомдол буюу 13.7 хувь нь тендерийн нээлт хийхээс өмнөх

шатанд, 1187 буюу 82.1 хувь нь захиалагчийн шийдвэрт, 61 буюу 4.2 хувь нь гэрээнд гарын үсэг зурагдсны дараа, эсхүл Сангийн яамны шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй үндэслэлээр шүүхэд тус тус хандсан байна.

Тендер шалгаруулалттай холбоотой гомдлын тоо жилээс жилд өссөн дүнтэй байгаа нь нэг талаас тендерт оролцогчид хуулийн хэрэгжилтэд хяналт тавих байдал нэмэгдсэн сайн талтай ч нөгөө талаас төсөл, арга хэмжээний хэрэгжих хугацаа уртсах сул талтай байна.

Сангийн яам давхардаагүй тоогоор 962 тендер шалгаруулалтын үнэлгээтэй холбогдуулан 683 иргэн, аж ахуйн нэгжээс ирүүлсэн 1187 гомдлыг хүлээн авч, холбогдох материалд үндэслэн хянан үзэж, хариу хүргүүлсэн байна. Үүнээс 376 гомдлыг захиалагчийн шийдвэр хуульд нийцсэн буюу гомдол үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн байна. Тендерт оролцогчдын гомдлын 32 хувь үндэслэлгүй байсан болно.

Сангийн яам тендер шалгаруулалтын үнэлгээг хуульд нийцүүлэн дахин хийх 639 шийдвэр, үүнээс тендер шалгаруулалтыг хүчингүй болгох 176 шийдвэрийг захиалагч байгууллагад хүргүүлж, захиалагч буруу шийдвэр гаргасан байсныг тендерт оролцогчдын хяналтаар дамжуулан зохих шатанд нь залруулсан байна.

Гэрээ байгуулахын өмнөх шатанд захиалагчийн шийдвэрт тендерт оролцогчдоос гаргасан гомдлын тоо нэмэгдсэн боловч захиалагчийн хуульд нийцээгүй шийдвэрийн тоо буурахгүй байна. Түүнчлэн тендерт оролцогчоос захиалагчийн шийдвэрт гаргасан гомдол, маргааны ихэнх буюу 53 хувь нь үндэслэлтэй байна.

Гомдлын судалгаанаас авч үзвэл Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар болон харьяа төрийн өмчит компаниудаас зохион байгуулсан тендер шалгаруулалтад холбогдуулан нийт 229 гомдол ирүүлснээс 126 шийдвэр, Боловсрол, соёл, шинжлэх, ухааны яам, харьяа байгууллагатай холбогдуулан 173 гомдол ирүүлснээс 83 шийдвэр, Эрүүл мэндийн яам, харьяа байгууллагатай холбогдуулан 121 гомдол ирүүлснээс 62 шийдвэр, Нийслэлийн байгууллагуудаас зарласан тендер шалгаруулалттай холбогдуулан 120 гомдол ирүүлснээс 63 шийдвэрийг хуульд нийцүүлэн засаж, үнэлгээг дахин хийх, тендер шалгаруулалтыг дахин зохион байгуулах

шийдвэрийг Сангийн яамнаас хүргүүлсэн байна.

2019 онд нийт 1,352 гомдол холбогдох байгууллагуудад гарсан байх бөгөөд үүнээс 219 гомдол буюу 16 хувь нь тендерийн нээлт хийхээс өмнөх шатанд, 1,060 буюу 78 хувь нь захиалагчийн шийдвэрт, 74 буюу 6 хувь нь гэрээнд гарын үсэг зурагдсаны дараа эсвэл Сангийн яамны шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй үндэслэлээр шүүхэд тус тус хандсан байна.

2019 онд нийт гомдлын тоо буурсан боловч тендерт оролцогчоос захиалагчийн шийдвэрт гаргасан гомдол, маргаан 2018 онд 53 хувь, 2019 онд 54 хувь нь үндэслэлтэй гэж шийдвэрлэгдсэн буюу захиалагчийн хуульд нийцээгүй шийдвэр буурахгүй байна.

Гомдол шийдвэрлэлтийн бусад төрөлд Сангийн яам гомдлыг хүлээн авах боломжгүй, гомдол гаргах хугацаанд тус яаманд хандаагүй, захиалагч байгууллага гэрээ байгуулсан, эсхүл гомдлоо эргүүлэн татсан шийдвэрийг багтаасан байна.



Хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр захиалагчийн шийдвэрт буюу Сангийн яаманд тендерт оролцогч тендерийн баталгаага барьцаалан үндэслэл бүхий гомдол гаргах шинэ зохицуулалт 2019 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон. Хуулийн үйлчлэл эхэлснээс хойш зарлагдсан тендер шалгаруулалтад гаргасан үндэслэлгүй гомдлын хэмжээ 2019 оны сүүлийн хагас жилд 92 буюу 16.2 хувь болж буурсан. Төрийн сангийн 100900000753 тоот “Тендерийн баталгааны орлого” дансанд 81,458,648 төгрөг бүхий тендерийн баталгааг улсын орлого болгон төвлөрүүлсэн байна. Сангийн яам тендер шалгаруулалтын үнэлгээг хуульд нийцүүлэн дахин хийх 482 шийдвэр, үүнээс тендер шалгаруулалтыг хүчингүй болгох 90 шийдвэрийг захиалагч байгууллагад хүргүүлж, захиалагч буруу шийдвэр гаргасан байсныг тендерт оролцогчдын хяналтаар дамжуулан зохих шатанд нь залруулсан байна.

Сангийн яам давхардаагүй тоогоор 822 тендер шалгаруулалтын үнэлгээтэй холбогдуулан 602 иргэн, аж ахуйн нэгжээс ирүүлсэн 1,060 гомдлыг хүлээн авч, холбогдох материалд үндэслэн хянан үзэж, хариу хүргүүлсэн байна. Үүнээс 376 гомдол буюу 32 хувь нь үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн байна.

Гомдлын судалгаанаас авч үзвэл Нийслэлийн Засаг даргын харьяа байгууллагуудаас зохион байгуулсан тендер шалгаруулалтад холбогдуулан нийт 175 гомдол ирүүлснээс 109 шийдвэр, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар болон төрийн өмчит үйлдвэрийн газартай холбогдуулан 174 гомдол ирүүлснээс 95 шийдвэр, Эрүүл мэндийн яам, харьяа байгууллагатай холбогдуулан 102 гомдол ирүүлснээс 56 шийдвэр, Эрчим хүчний яам, харьяа байгууллагатай холбогдуулан 92 гомдол ирүүлснээс 54 шийдвэр, Өмнөговь аймгийн Засаг даргын харьяа байгууллагуудтай холбогдуулан 40 гомдол ирүүлснээс 25 шийдвэрийг хуульд нийцүүлэн үнэлгээг дахин хийх, тендер шалгаруулалтыг дахин зохион байгуулах шийдвэрийг Сангийн яамнаас хүргүүлэн ажилласан байна.

2018 онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хувьд Тендерт оролцогч 68 компаниас давхардсан тоогоор 93 (нийт оролцогчдын 10.5 хувь) гомдлыг холбогдох байгууллагад гаргасан. Нийт гомдлын 54 буюу 58.06 хувь нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэр үндэслэлтэй гэж хянагдсан, 33 нь буюу 35.4 хувь нь дахин үнэлэх буюу өөрчлөлт оруулах, 4 буюу 4.3 хувь нь хүчингүй болсон, 2 буюу 2.24 хувь нь



шийдэгдээгүй, хянагдаж байна. Сангийн яаманд хянагдаж дахин үнэлэхээр шийдвэрлэгдсэн 28 (83.8 хувь) гомдолд тодруулга авч өмнөх шийдвэрийг хэвээр үлдээсэн 20, шийдвэрийг өөрчилсөн 8 байгаа бол 5 (16.2 хувь) гомдолд хамаарах тендерийг дахин үнэлэхээр шийдвэрлэгдсэн. Нийт хянан шийдвэрлэгдсэн гомдлын 58.1 хувь нь захиалагчийн гаргасан шийдвэр үндэслэлтэй гэж хянагдсан байгаа бөгөөд гомдол шийдвэрлэгдэх хуулийн хугацаанд тухайн тендер шалгаруулалтын үр дүнд шалгарсан гүйцэтгэгч, нийлүүлэгчтэй гэрээ байгуулах ажил хүлээгдэж, хугацаа алдах байдал үүссэн.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт 2019 онд зохион байгуулсан худалдан авах ажиллагаанд давхардсан тоогоор 768 аж ахуйн нэгж оролцож, 40 хуулийн этгээдээс гомдол гаргасан.

1. Сангийн яаманд 30 гомдол гарсныг хянан шийдвэрлэсэн байдал:
  - Захиалагчийн шийдвэр үндэслэлтэй – 7 (23.3 хувь);
  - Захиалагчийн шийдвэр үндэслэлгүй тул дахин үнэлэх - 18 (60 хувь);
  - Гомдол гаргагч гомдлоо татсан – 5 (16.7 хувь) гомдол байна.
2. Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт 10 гомдол гарсныг хянан шийдвэрлэсэн байдал:
  - Өрсөлдөөнийг хязгаарлаагүй - 7 (70 хувь);
  - Өрсөлдөөнийг хязгаарласан- 3 (30 хувь) байна.
3. Шүүхэд гомдол гараагүй.

Нийт хянан шийдвэрлэгдсэн гомдлын 47.5 хувь нь захиалагчийн гаргасан шийдвэр үндэслэлтэй гэж хянагдсан байгаа бөгөөд гомдол шийдвэрлэгдэх хуулийн хугацаанд тухайн тендер шалгаруулалтын үр дүнд шалгарсан гүйцэтгэгч, нийлүүлэгчтэй гэрээ байгуулах ажил хүлээгдэж, хугацаа алдах байдал үүссэн үр дагавар гарсан байна. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт зохион байгуулагдсан худалдан авах ажиллагаатай холбоотой гарсан гомдол, түүний шийдвэрлэлтийн мэдээллийг байгууллагын үйл ажиллагааны тайлан мэдээнд тусган холбогдох байгууллага, олон нийтэд мэдээлж байна. (Биелэлт 100 хувь)

4.1.4.3-1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн үйлчлэх хүрээг зохистой тогтоох, түүнд хяналт тавих, өөр хоорондоо зөрүүтэй авлига гарах нөхцөл бүрдүүлэх хуулийн заалтыг хянан үзэж, эрх зүйн орчинг боловсронгуй болгох /СЯ, 2017-2020/

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг УИХ-аас 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдөр батлан, 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж эхэлсэнтэй холбоотойгоор Засгийн газрын худалдан авах ажиллагааны чиг үүргийг бие даасан агентлаг хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдсэн.

“Тендерт оролцогчоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журам”, “Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох журам”, “Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн дүрэм”, “Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг хөтлөх журам”, “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”, “Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх, гэрчилгээ олгох журам” зэрэг журмыг баталсан. Тухайлбал, Сангийн сайдын 2019 оны 6 дугаар сарын 4-ний өдрийн 132 дугаар тушаалаар «Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох журам»-ыг баталснаар тендерт оролцогчдод тендер шалгаруулалтын материалыг ил болгож захиалагч тендер шалгаруулалтыг хуулийн дагуу зохион байгуулсан эсэхэд хяналт тавих боломж бүрдсэн.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт өөрчлөлт орж, журам, заавар батлагдсанаар тендерт оролцогчдод тендер шалгаруулалтын материалыг ил болгож захиалагч тендер шалгаруулалтыг хуулийн дагуу зохион байгуулсан эсэхэд хяналт тавих, худалдан авах ажиллагаанд оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэл буюу хар жагсаалтыг хөтөлж, чанаргүй, гэрээний үүргээ биелүүлдэггүй компанийг дахин тендерт оролцуулахгүй байх, чанар, стандартын шаардлага



хангасан дотоодын бараа, бүтээгдэхүүнд давуу эрх олгох, дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой барааны тендер шалгаруулалтад гадаадын бараа нийлүүлэгчийг оролцуулахгүй байх, урьдчилан худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэх, ил тод байдлыг нэмэгдүүлэх нөхцөл бүрдсэн. (Биелэлт 100 хувь)

4.1.4.3-2. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж, дүрэм, журамд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа олон нийтийн хэлэлцүүлгийн үр дүнг тусгах /СЯ, 2017-2020/

2017 онд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл, Ерөнхий гэрээ байгуулах журмын төсөл, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын төслийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын <http://pcsp.gov.mn> цахим хуудас болон төрийн худалдан авах ажиллагааны <https://tender.gov.mn> системд тус тус байршуулж, олон нийтээс санал авч, төсөлд тусгасан. Хуулийн төслийн хэлэлцүүлгийг аймгуудын Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан ажилтнууд, яамдын холбогдох албан тушаалтнууд, төрийн бус байгууллагын төлөөлөл 80 гаруй хүнийг оролцуулан 2017 оны 8 дугаар сард Улаанбаатар хотод зохион байгуулсан. 2018 онд Сангийн яам Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийг улсын хэмжээнд зохион байгуулж 21 аймгийн орон нутгийн өмчийн газар холбогдох 30 гаруй мэргэжилтэн, 830 иргэн, 180 аж ахуйн нэгжийн саналыг авч, төсөлд тусгасан. Түүнчлэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг бүх шатны төсөвт байгууллагын төлөөлөлд танилцуулж, санал авч хэлэлцүүлсэн. 2018 онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас “Цахим тендер зохион байгуулах журам”, “Тендерийн жишиг баримт бичиг”-т холбогдох өөрчлөлт оруулах санал боловсруулахдаа олон нийтийн саналыг авч тусган, Сангийн яаманд хүргүүлсэн.

Хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу боловсруулсан дараахь бодлогын баримт бичигт олон нийтээс санал авч шинээр батлуулсан. Үүнд:

1. Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн дүрэм, Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг хөтлөх журам - Засгийн газрын 2019 оны 274 дүгээр тогтоол;
2. Тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журам - Сангийн сайдын 2019 оны 131 дүгээр тушаал;
3. Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох журам - Сангийн сайдын 2019 оны 132 дугаар тушаал;
4. Урьдчилсан худалдан авах ажиллагааны журам - Сангийн сайдын 2019 оны 208 дугаар тушаал;
5. Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 13 тендерийн жишиг баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулав. Сангийн сайдын 2019 оны 122, 123, 124, 125, 126, 127, 128 болон 129 дүгээр тушаал.

Хууль тогтоомжийн тухай хууль, Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу дээрх дүрэм, журмын төсөлд бүх төсвийн ерөнхийлөн захирагчаас санал авч, мөн Сангийн яамны цахим хуудас ([www.mof.gov.mn](http://www.mof.gov.mn)), Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим хуудас ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn))-д байршуулж санал авч, төсөлд тусган батлуулсан.

Дээр дурдсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6-д “гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтэд чанар болон гүйцэтгэлийн хяналт тавьж, явцын мэдээллийг хагас жил тутам худалдан авах ажиллагааны цахим системд оруулах;” гэж захиалагчийн эрх, үүрэг заасан хэсгийг өөрчлөн найруулсан. Энэ нь цахим худалдан авах ажиллагаа-ны нэгдсэн системд мэдээллээ бүрэн оруулах, тогтмол ажиллагааг хангах, хэрэгжүүлээгүй тохиолдолд хариуцлага хүлээлгэх тогтолцоог бүрдүүлж байна. (Биелэлт 100 хувь)

4.1.4.3-3. “Цахим худалдан авах ажиллагаа”-ны нэгдсэн системд мэдээллээ бүрэн оруулах, тогтмол ажиллагааг хангах, хэрэгжүүлээгүй тохиолдолд хариуцлага хүлээлгэх тогтолцоог бүрдүүлэх /СЯ, 2017-2020/

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2 дахь хэсэгт



нэмэлт, өөрчлөлт оруулан дээрх хуулийг зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэх харилцааг Зөрчлийн хуулиар зохицуулахаар тусгасан боловч Зөрчлийн хуульд холбогдох заалт ороогүй тул хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх боломжгүй байдлыг үүсгэсэн. Өөрөөр хэлбэл, Зөрчлийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1.7-т заасан засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим системд урилга, үр дүн, мэдээллээ бүрэн оруулаагүй албан тушаалтанд хариуцлага тооцох заалт хүчингүй болсон байсан.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас дээрх заалтад дурдагдсан “Цахим тендер зохион байгуулах журам”-ын төсөлд тусгахаар холбогдох судалгаа хийж, хариуцлагын тогтолцоог сайжруулах асуудлыг Сангийн яаманд хүргүүлсэн.

Одоогоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсэгт “Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” гэж заасны дагуу «Цахим худалдан авах ажиллагаа»-ны нэгдсэн системд мэдээллээ бүрэн оруулах, тогтмол ажиллагааг хангах, хэрэгжүүлээгүй төрийн албан хаагчид Төрийн албаны тухай хуулиар хариуцлага ногдуулах болно. Зарчмын хувьд төрийн албан хаагчид хариуцлага хүлээлгэх тогтолцоог хуулиар улам бүрдэг болгосон байгаа. Өнөөдрийн байдлаар дээрх заалтын дагуу төрийн албан хаагчид хариуцлага хүлээлгэсэн тохиолдол гараагүй хуулийг хэрэгжүүлэх механизм бүрдээгүйг харуулж байна. (Биелэлт 30 хувь)

4.1.4.3-4. Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийг бүртгэлд хамруулан тухайн аж ахуйн нэгжийн талаарх мэдээллийг захиалагч байгууллагаас холбогдох байгууллагад хүргэх тогтолцоог бүрдүүлэх /СЯ, 2017-2019/

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1.14-т заасны дагуу төрийн худалдан авах ажиллагааны цахим

систем <https://tender.gov.mn>-ээр дамжуулан тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг олон нийтэд шуурхай, бүрэн мэдээлэх тогтолцоог бүрдүүлсэн байна. Сангийн яам өөрийн цахим хуудсандаа тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн мэдээллийг байршуулж байна. Уг жагсаалтад орсон аж ахуйн нэгж нь тухайн хугацаанд цахим системээр дамжуулан аливаа тендер шалгаруулалтад оролцох боломжгүй байхаар цахим системийн хөгжүүлэлтийг хийсэн.

Засгийн газрын 2019 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 274 дүгээр тогтоолоор “Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн дүрэм” болон “Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг хөтлөх журам”-ыг баталсан.

Журам батлагдсан даруй 2019 онд төсвийн ерөнхийлөн захирагч нараас хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4, 14.1.6, 14.1.7 дахь заалтад заасан нөхцөл үүссэн эсэх талаарх мэдээллийг холбогдох нотлох баримтын хамт авч хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, нэр бүхий 20 компанийг тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд бүртгэж цахим системд олон нийтэд нээлттэй мэдээлсэн.

“Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг хөтлөх журам”-д Тендерт оролцогч сүүлийн 3 жилийн хугацаанд худалдан авах ажиллагаанд оролцоходоо гэрээний үүргээ ноцтой зөрчсөн, биелүүлээгүй талаарх шүүхийн мэдээллийг улсын байцаагчид хүргүүлэх этгээдийг тодорхой заагаагүй байгаа нь хуулийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна. (Биелэлт 70 хувь)

4.1.4.4-1. Шууд гэрээ байгуулах аргачлал, шалгуурыг боловсронгуй болгох /СЯ, 2017-2019/

2019 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн УИХ-аас баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр 52 дугаар зүйлийн 52.1.3-т “Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага худалдан авах ажиллагаатай холбоотой журам, заавар, аргачлал, жишиг баримт бичгийн төсөл, цахим тендер шалгаруулах журам, тендер шалгаруулалтын материалыг

тухайн тендерт оролцогчдоод ил болгох журам, цахим худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг зарлан мэдээлэх журам, худалдан авах ажиллагаанд мэдээллийн технологи, цахим хэрэгслийг нэвтрүүлэх нөхцөл, журам батлах эрхтэй” гэж заасан байна. Сангийн яамнаас шууд байгуулах журам, заавар, аргачлалын төслийг боловсруулан 2020 онд батлуулахаар ажиллаж байна. (Биелэлт 10 хувь)

4.1.4.4-2. Концессын гэрээ байгуулах аргачлал, шалгуурыг тодорхой болгосон журам боловсруулах /ҮХГ, 2017-2018/

Үндэсний хөгжлийн газраас Концессын тухай хуулийн шинэчилсэн найруулга, түүний дагалдах журмуудыг боловсруулах зөвлөх үйлчилгээний тендерийг 2019 онд 2 удаа зарласан боловч шаардлага хангасан санал ирээгүй тул тендер хүчингүй болсон. Үндэсний хөгжлийн газрын 2020 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд Концессын тухай хуулийн шинэчилсэн найруулга болон дагалдах журмуудын төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээ авах талаар тусгагдсан бөгөөд төлөвлөгөөний дагуу үнэлгээний хороо байгуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. (Биелэлт 0 хувь)

4.1.4.4-3. Концесс олгох уралдаант шалгаруулалт болон санал үнэлэх журмыг шударга, өрсөлдөөнтэй, үр дүнтэй, ил тод болгох талаарх зохицуулалтыг шинэчлэн боловсруулах /ҮХГ, 2017-2019/

Үндэсний хөгжлийн газар 2017 онд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг байгуулан, 2018 оны 9 дүгээр сарын 3-ны өдрийн тушаалаар ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулсан.

Мөн Азийн хөгжлийн банктай хамтран гадаадын болон дотоодын зөвлөх сонгон ажиллуулж, хуулийн төсөл, үзэл баримтлалын эхний хувилбарыг боловсруулсан. Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн үр дагаварт мэргэжлийн байгууллагаар судалгаа хийлгэх зайлшгүй шаардлагатай байсан бөгөөд 2018 оны төсөвт тус судалгааг хийлгэх зардал тусгагдаагүй байснаас ажлын гүйцэтгэл удааширч Концессын тухай хуулийн

шинэчилсэн найруулга, түүний дагалдах журмуудыг боловсруулах зөвлөх үйлчилгээний тендерийг 2019 онд 2 удаа зарласан боловч шаардлага хангасан санал ирээгүй тул тендер хүчингүй болсон.

Үндэсний хөгжлийн газрын 2020 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд Концессын тухай хуулийн шинэчилсэн найруулга болон дагалдах журмуудын төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээ авах талаар тусгагдсан. (Биелэлт 0 хувь)

4.1.4.5-1. Гэрээний үүргээ биелүүлээгүй этгээдийн талаар олон нийтэд шуурхай, бүрэн мэдээлэх тогтолцоог бүрдүүлэх /СЯ, 2017-2019/

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1.3 дахь заалтыг 2019 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн УИХ-аар баталсан нэмэлт, өөрчлөлтөөр “Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн дүрэм болон тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг хөтлөх журмыг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, Засгийн газар батална.” гэж өөрчлөн найруулсан.

Үүний дагуу Засгийн газрын 2019 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 274 дүгээр тогтоолоор “Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн дүрэм” болон “Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг хөтлөх журам”-ыг тус тус баталсан. Энэхүү журмын 3.1-д эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамруулсан шийдвэрийг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн этгээдэд албан бичгээр мэдэгдэхээр, 3.2-т төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын худалдан авах ажиллагааны бодлого хариуцсан нэгж нь эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг тухай бүр шинэчилж, худалдан авах ажиллагааны цахим систем / [www.tender.gov.mn/](http://www.tender.gov.mn/)-д олон нийтэд нээлттэй байршуулахаар заасан. 2019 онд гэрээний үүргээ биелүүлээгүй 20 этгээдийн мэдээллийг холбогдох шийдвэрийн хамт Худалдан авах ажиллагааны цахим систем болон Сангийн яамны цахим хуудсаар дамжуулан олон нийтэд нээлттэй мэдээлэв. <https://mof.gov.mn/article/tender/blacklist> (Биелэлт 100 хувь)



4.1.4.5-2. Гэрээний үүргээ биелүүлээгүй иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг хязгаарлах албадлагын арга хэмжээ авах эрхийг төрийн байгууллагад олгох, хариуцлагыг чангатгах эрх зүйн зохицуулалтыг бий болгох асуудлыг судлан шийдвэрлүүлэх /СЯ, 2017-2019/

Зөрчлийн тухай хууль 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.5-т заасан гэрээний үүргээ биелүүлээгүй иргэн, хуулийн этгээдийг тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд бүртгэх заалт хүчингүй болж, хууль зөрчсөн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлагыг хүлээлгэхээр болсон. Гэтэл Зөрчлийн тухай хуульд уг асуудал тусгагдаагүйгээс үүдэн хариуцлага хүлээлгэх механизмыг бүрдүүлэхэд хүндрэл учирч байв.

Иймд Засгийн газрын 2019 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 274 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар “Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг хөтлөх журам”-ыг батлуулсан. Энэхүү журмын 2.5-д “Иргэн, хуулийн этгээдийг эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамруулах хугацаа нь энэ тухай төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэр гарсан өдрөөс хойш 3 жил байна” гэж, 2.6-д “Захиалагч хуулийн 14.5-д заасны дагуу эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд бүртгэгдсэн тендерт оролцогчийн ирүүлсэн тендерээс татгалзана” гэж тус тус тусган баталсан. (Биелэлт 100 хувь)

4.1.4.5-3. Тендерт оролцох эрхийг хязгаарласан этгээдийн бүртгэлийг хөтлөх, мэдээлэх үүргээ хэрэгжүүлээгүй албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагыг чангатгах /СЯ, 2017-2019/

“Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг хөтлөх журам”-ын дагуу Сангийн яам тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг хөтлөх, хяналт тавих, нийтэд мэдээлэх үүргээ хэрэгжүүлж байна.

Тендерт оролцох эрхийг хязгаарласан этгээдийн бүртгэлийг хөтлөх, мэдээлэх үүргээ

хэрэгжүүлээгүй албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагыг чангатгах болон ямар албан тушаалтанд хариуцлага тооцуулах механизм бүрдээгүй байна. Захиалагч гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтэд чанар болон гүйцэтгэлийн хяналт тавьж, явцын мэдээллийг хагас жил тутам худалдан авах ажиллагааны цахим системд оруулах үүрэг хүлээж, энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ гэж заасан, Зөрчлийн хуулийн заалтыг тодорхой болгох шаардлагатай байна. (Биелэлт 30 хувь)

**Тав. Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын шударга, ил тод хараат бус байдлыг бэхжүүлэх, авлигын эсрэг хамтын ажиллагааг сайжруулах зорилтыг хангах чиглэлээр**

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 5 дугаар зорилтын хүрээнд нийт 17 үйл ажиллагаа, 34 арга хэмжээ тусгагдсан. Зорилтын хүрээнд төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг тоймлон танилцуулбал:

4.1.5.1-1. Шүүгч, прокурорын сонгон шалгаруулалт, сэлгэн болон шилжүүлэн ажиллуулсан, дэвшүүлсэн, шагнаж урамшуулсан, чөлөөлсөн, хариуцлага тооцсон байдалд судалгаа хийж, дүнг олон нийтэд мэдээлэх /ШЕЗ, УЕПГ, 2017-2018/

2017-2019 онд Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын баталсан 23 тушаалаар шүүгч, Ерөнхий шүүгчийн 221 сул орон тоонд сонгон шалгаруулалт зарлаж, нийт 814 нэр дэвшигчийг бүртгэснээс 651 хүн шалгалтад оролцсон байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар 2017-2019 онд нийт 114 хүнийг шүүгч, Ерөнхий шүүгч, Танхимын тэргүүний албан тушаалд томилсон байна. Үүнээс анхан шатны шүүхийн шүүгч 33, давж заалдах шатны шүүхийн шүүгч 13, анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч 57, давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч 7, Улсын Дээд шүүхийн шүүгч, танхимын тэргүүн 4 хүн тус тус томилогджээ.

**Хүснэгт 1. Шүүгчийн хөдөлгөөний судалгаа /2017-2019 он/**

Он	Шинээр болон дэвшин томилогдсон нийт шүүгчийн тоо	Анхан шатны шүүхэд шинээр томилогдсон шүүгчийн тоо	Анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгчээр томилогдсон тоо	Давж заалдах шатны шүүхийн шүүгчээр томилогдсон тоо	Давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгчээр томилогдсон тоо	Улсын Дээд шүүхийн шүүгч, Танхимын тэргүүнээр томилогдсон тоо
1	2	3	4	5	6	7
2017	28	10	5	8	3	2
2018	14	2	6	3	2	1
2019	72	21	46	2	2	1
Нийт	114	33	57	13	7	4

2016-2019 онд давхардсан тоогоор анхан болон давж заалдах шатны шүүхийн 226 шүүгчээс шилжин ажиллах хүсэлт ирүүлсэн ба Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар 34 шүүгчийг адил шатны өөр шүүхэд шилжүүлэн томилсон байна.

Шүүгчийн сонгон шалгаруулалтын ил тод, нээлттэй байдлыг хангах хүрээнд Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын сонгон шалгаруулалт зарласан тушаал, сонгон шалгаруулалтын үр дүнгийн талаар ШЕЗ-ийн болон шүүхийн Тамгын газруудын цахим хуудсанд байршуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд нээлттэй мэдээлсэн. Шалгалтын үйл явцтай иргэд танилцах, ажиглах боломжийг олгох зорилгоор шалгалтын танхимын гадна дэлгэц байршуулж, шалгалтыг зохион байгуулсан.

2017-2019 онд “Монгол Улсын гавьяат хуульч” цолоор 3, “Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн” цолоор 1, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор 20, Алтан гадас одонгоор 45, Хөдөлмөрийн хүндэт медалиар 39, “Шүүхийн

тэргүүний ажилтан” цол, тэмдгээр 19, Шүүхийн ерөнхий зөвлөлийн “Хүндэт тэмдэг”-ээр 56, “Хууль зүйн албаны тэргүүний ажилтан” цол, тэмдгээр 23, Хууль зүйн яамны “Хүндэт жуух”-аар 47 шүүгч, ажилтан, нийт 253 шүүгч, ажилтан төрийн дээд цол, одон, медаль, шүүхийн шагналаар шагнагдсан байна.

Шүүхийн ёс зүйн хороо иргэн, албан тушаалтан, хуулийн этгээдээс 2017-2019 онд 884 шүүгчид холбогдох 606 гомдол хүлээн авчээ. Шүүхийн ёс зүйн хорооны гомдол хянан хэлэлцэх хуралдаанаар 837 шүүгчид холбогдох 540 гомдлыг хянан шийдвэрлэснээс 111 шүүгчид сахилгын хэрэг үүсгэн, 447 гомдолд холбогдох 698 шүүгчид сахилгын хэрэг үүсгэхээс татгалзаж шийдвэрлэсэн байна.

Нийт гишүүдийн хуралдаанаар 318 шүүгчид холбогдох 210 сахилгын хэрэг, гомдлыг хэлэлцсэнээс 48 шүүгчид сахилгын шийтгэл ногдуулж шийдвэрлэжээ. Үүнээс 29 шүүгчид сануулах, 13 шүүгчид цалин бууруулах, 6 шүүгчид огцруулах сахилгын шийтгэл тус тус ногдуулжээ.

**Хүснэгт 2. Шүүгчийн ёс зүйн хороонд гомдол хүлээн авсан судалгаа /2017-2019 он/**

Он	Хүлээн авсан гомдлын тоо						Шийдвэрлэсэн гомдлын тоо							
	ШЕЗХ-нд хүлээн авсан гомдол		Өмнөх оны үлдэгдэл гомдол		Нийт гомдол		ШЕЗХ-ны гомдол хянан хэлэлцэх хуралдаанаар шийдвэрлэсэн гомдлын тоо		Сахилгын хэрэг үүсгэсэн гомдлын тоо		Сахилгын хэрэг үүсгэхээс татгалзсан тоо		Нийт гишүүдийн хуралдаанаар хэлэлцсэн сахилгын хэрэг гомдлын тоо	
	Шүүгч	Гомдол	Шүүгч	Гомдол	Шүүгч	Гомдол	Шүүгч	Гомдол	Шүүгч	Гомдол	Шүүгч	Гомдол	Шүүгч	Гомдол
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15
2017	305	197	73	45	378	242	280	180	30	30	250	153	93	62
2018	284	201	58	40	342	241	280	180	52	45	200	135	109	72
2019	295	208	63	42	358	250	277	180	29	21	248	159	116	76
Нийт	884	606	194	127	1078	733	837	540	111	96	698	447	318	210



### Хүснэгт 3. Шүүгчийн ёс зүйн хорооноос шүүгчид сахилгын шийтгэл ногдуулсан тоо /2017-2019 он/

Он	Сахилгын шийтгэл ногдуулсан тоо	Үүнээс		
		Сануулах сахилгын шийтгэл хүлээсэн шүүгчийн тоо	Цалин буруулах сахилгын шийтгэл хүлээсэн шүүгчийн тоо	Шүүгчийн албан тушаалаас огцруулах сахилгын шийтгэл хүлээсэн шүүгчийн тоо
1	2	3	4	5
2017	14	9	3	2
2018	29	17	8	4
2019	5	3	2	0
Нийт	48	29	13	6

Шүүгчийн ёс зүйн гомдлын шийдвэрлэлт, сахилгын шийтгэл хүлээлгэсэн байдал, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр хийсэн судалгааны дүнг танилцуулах зорилгоор «Шүүгчийн ёс зүй ба сахилга» сэдэвт Олон улсын бага хурлыг гадаад, дотоодын 100 гаруй эрдэмтэн, судлаач, шүүгч, хуульчдыг хамруулан 2017 оны 10 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулж, бага хурлын илтгэл, зөвлөмж, судалгааны тайланг эмхэтгэн 2018 онд бүх шатны шүүхийн шүүгчдэд хүргүүлж, шүүх, шүүхийн захиргааны байгууллагыг мэдээллээр хангаж ажилласан. Шүүхийн ёс зүйн хороо, Монголын хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хороо, Азийн сан хамтран “Хуульчийн ёс зүй ба хариуцлага” сэдэвт хэлэлцүүлгийг 2018 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр зохион байгуулсан.

2019 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр “Шүүгчийн Ёс зүй, сахилга, хариуцлага” сэдвээр зохион байгуулсан хэлэлцүүлэгт анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгч, хуульч, өмгөөлөгч, эрдэмтэн судлаач, ТББ-ын төлөөлөл, ШЁЗХ-ны гишүүн, тус хорооны гишүүнээр ажиллаж байсан гишүүд, МУИС-ийн багш, судлаач, иргэний нийгмийн байгууллага, Нээлттэй нийгэм форум, Азийн сан, Шүүхийн захиргааны байгууллага, Ерөнхийлөгчийн Тамгын газрын төлөөлөл нийт 53 хүн хамрагджээ.

Шүүхийн Ёс зүйн хорооноос шүүгчид сахилгын шийтгэл ногдуулсан шийдвэр, түүнийг Захиргааны хэргийн давж заалдах шатны болон хяналтын шатны шүүх шийдвэрлэсэн шийдвэрийг эмхэтгэн Азийн сангийн дэмжлэгтэйгээр 2017, 2019 онд тус бүр 600 хувийг хэвлүүлж шүүгч, судлаачдын хүртээл болгосон. Энэхүү бүтээлийг шүүх судлал,

шүүгчийн ёс зүйн сургалт, судалгааны ажлын эх сурвалж болгон ашигласаар байна.

Шүүхийн ёс зүйн хорооноос “Шүүгчийн ёс зүй, хариуцлага” сэдвээр хэвлэлийн бага хурлыг 2018 оны 02 дугаар сарын 26, 2018 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр зохион байгуулж, сүүлийн 5 жилд хүлээн авсан гомдол, түүний шийдвэрлэлтийн явцыг 60 орчим хэвлэл мэдээллийн агентлагийн 120 гаруй сэтгүүлчдэд мэдээлэл өгч ажилласны зэрэгцээ шүүгчийн ёс зүйн гомдол шийдвэрлэлт, сахилгын хариуцлага хүлээлгэсэн байдал зэрэг сэдвээр радио, телевизээр олон нийтэд хүргэсэн болно.

Прокурорын байгууллагад одоогийн байдлаар Улсын Ерөнхий прокурорын 2011 оны 46 дугаар тушаалаар батлагдсан “Прокурорыг сэлгэн ажиллуулах, дэвшүүлэн томилоход мөрдөх журам”, 2015 оны А/20 дугаар тушаалаар батлагдсан “Дээд шатны прокуророор ажиллах прокурорын мэдлэг, чадварыг үнэлж, дүгнэх журам”-ыг тус тус мөрдөн ажиллаж байна.

“Прокурорыг сонгон шалгаруулах журам”, “Прокурорыг албан тушаалд дэвшүүлэх, бууруулан томилох, сэлгүүлэн ажиллуулах журам”, “Дээд шатны прокуророор ажиллах санал, хүсэлт гаргасан прокурорын мэдлэг, ур чадварыг үнэлж, дүгнэх журам”-ийг Прокурорын тухай хууль, Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэн боловсруулж, батлуулахад бэлэн болсон байна.

2017 онд прокурорын байгууллагын хэмжээнд 18 прокурор, 23 туслах ажилтныг шинээр, 297 прокурор, ажилтныг шилжүүлэн болон сэлгэн ажиллуулсан ба 14 прокурор, 14 туслах ажилтныг ажлаас чөлөөлжээ. 2018 онд 41 прокурор, 55 туслах ажилтныг шинээр, 161

прокурор, 19 туслах ажилтныг шилжүүлэн болон сэлгэн ажиллуулж, 23 прокурор, ажилтныг дэвшүүлэн томилсон байна.

2019 онд 34 прокурор, 22 ажилтныг шинээр, 145 прокурор, 83 туслах ажилтныг шилжүүлэн болон сэлгэн ажиллуулжээ. 20 туслах ажилтныг прокуророор дэвшүүлэн томилсон ба 27 прокурор, 27 туслах ажилтныг ажлаас чөлөөлсөн байна.

Прокурорын байгууллагын туслах ажилтны сонгон шалгаруулалтын илт тод, нээлттэй байдлыг ханган ажиллаж, прокурорын туслах ажилтанд тавигдах шаардлага, сонгон шалгаруулалт явуулах журам, сонгон шалгаруулалт явуулах тухай зар, сонгон шалгаруулалтын хүрээнд авах шалгалтын төрөл, хэлбэр, түүнийг дүгнэхтэй холбоотой болон сонгон шалгаруулалтад оролцогчдоод тавигдах шаардлагатай бусад мэдээллийн талаар prokuror.mn цахим хуудас, Монголын хуульчдын холбооны цахим хуудас болон өдөр тутмын 2 хэвлэлд тус тус байршуулан олон нийтэд мэдээлжээ.

2018 онд 129 иргэнээс шалгалт авч шалгалтад тэнцсэн 14 иргэнийг, 2019 онд 110 иргэнээс шалгалт авч тэнцсэн 12 иргэнийг тус тус Улсын ерөнхий прокурорын тушаалаар нөөцөд авсан байна.

2017-2019 онд төрийн дээд одон, медалиар 92, салбарын шагналаар 132, байгууллагын шагналаар 541, бусад шагналаар 266, нийт 1031 прокурор, ажилтан шагнагджээ.

2017 онд 97, 2018 онд 173, 2019 онд 105 прокурорт сахилгын арга хэмжээ авсан байна.

Прокурорын ёс зүйн зөвлөл 2017 онд 29, 2018 онд 38, 2019 онд 41, нийт 108 өргөдөл, гомдол хүлээн авч шалган, 14 прокурорт сахилгын шийтгэл ногдуулж шийдвэрлэсэн.

Улсын Ерөнхий прокурорын газрын Дотоод хяналт шалгалтын хэлтсээс улсын хэмжээнд сахилгын арга хэмжээ авагдсан прокурор, ажилтны тушаалыг сар бүр авч нэгтгэн, мэдээллийн сан үүсгэсэн ба Мониторингийн хэлтэстэй хамтран сахилгын арга хэмжээ авагдсан шалтгаан, нөхцөлийг судлан, 2018 оны удирдах ажилтны “Сахилга хариуцлагын зөвлөгөөн” зохион байгуулж сахилгын арга хэмжээ авагдсан үндэслэл, цаашид анхаарах асуудлын талаар хэлэлцүүлэх зэрэг ажлыг зохион байгуулж ажилласан.

Прокурорын байгууллагын цахим бүртгэлийн системд сэлгэн болон шилжүүлэн ажиллуулсан, дэвшүүлсэн, чөлөөлсөн, шагнагдсан, сахилгын арга хэмжээ авагдсан прокурор, ажилтны талаарх мэдээллийг тухай бүр бүртгэж хэвшсэн бөгөөд энэхүү тоо баримт, судалгааг цахим бүртгэлийн системээс үзэх боломжтой.

Прокурорын томилолтын шилжилт хөдөлгөөн (сэлгэн болон шилжүүлсэн, шинээр томилсон, халсан, чөлөөлсөн, шагнал, урамшуулал, хариуцлага тооцсон)-тэй холбоотой ажлын дүн, мэдээг байгууллагын үйл ажиллагааны хагас, бүтэн жилийн ажлын тайланд тусгаж байгаа бөгөөд холбогдох мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулан, “Прокурорын байгууллага тухайн онд” эмхэтгэлд хэвлүүлж, иргэд олон нийтэд хүргэв. (Биелэлт 70 хувь)

4.1.5.1-2. Шүүгч, прокурорыг сонгон шалгаруулах журам, шалгуурыг шинэчлэн боловсруулах, шүүгчийн хараат бус байдал, хариуцлагыг дээшлүүлэх /ШЕЗ, УЕПГ, 2017-2018/

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд “Шүүхийн ерөнхий зөвлөл “Шүүгчийг сонгон шалгаруулах журам”-ыг тогтмол боловсронгуй болгох үүрэг хүлээнэ” гэж заасны дагуу “Шүүгчийг сонгон шалгаруулах журам”-ыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар шинэчлэн баталсан. 2013 оноос хойш 2 жил тутам “Шүүгчийг сонгон шалгаруулах журам” өнөөг хүртэл нийт 4 удаа шинэчлэгдсэн бөгөөд шалгалтын арга хэлбэр, төрөл, нэр дэвшигчдэд тавих шалгуур үзүүлэлт, үнэлэх аргачлал, үнэлгээний босго зэргийг тогтмол сайжруулсан байна:

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны 165 дугаар зарлиг;
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны 18 дугаар зарлиг;
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 103 дугаар зарлиг;
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 13 дугаар зарлигаар тус тус шинэчлэн баталсан байна.

Шүүгчийг сонгон шалгаруулах журмыг шинэчлэн батлуулахаар холбогдох төслийг боловсруулсан болно.

Шүүгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах ажлыг хэрэгжүүлэх, зөрчигдсэн



тохиолдолд авах арга хэмжээний санал боловсруулах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахаар “Шүүгчийн хараат бус байдалд халдсан тухай гомдлыг шийдвэрлэх журам”-ыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2018 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 22 дугаар тогтоолоор баталсан байна. Уг журмын хүрээнд шүүгчээс ирүүлсэн гомдлыг бүртгэх, нягтлан шалгах, тайлбар, залруулга гаргах, шүүгчтэй өөртэй нь зөвшилцсөнөөр шүүхэд төлөөлөх, сэтгэл зүйн үйлчилгээнд холбон зуучлах зэрэг ажиллагааг хийх бөгөөд шүүгчийн хараат бус байдал зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг явуулна. Монгол Улсын Шүүхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төслийг боловсруулж байна.

Прокурорын байгууллага дээд шатны прокуророор ажиллах санал, хүсэлт гаргасан прокурорын мэдлэг, ур чадварыг үнэлж, дүгнэх журмыг шинэчлэн баталснаар прокурорын байгууллагын удирдах албан тушаалын ажилтнуудын эрх зүйн онолын болон ажил хэргийн мэдлэг, удирдах ур чадвар, хувь хүний сахилга, ёс зүйг зохих шалгуур үзүүлэлтээр дүгнэж томилох асуудлыг шийдвэрлэхээр болж байгаа нь тэдгээр ажилтнуудыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж, хараат бусаар ажил үүргээ гүйцэтгэх боломжийг бүрдүүлсэн зохицуулалт болсон. Цаашид прокуророор томилогдох албан тушаалтан, захиргааны болон прокурорын чиг үүргийг хэрэгжүүлэхэд туслах ажилтныг сонгон шалгаруулахад мөрдөх журам, шалгуурыг боловсронгуй болгох ажлыг тасралтгүй зохион байгуулж ажиллахаар төлөвлөж байна. Прокурорын туслах ажилтнаар томилогдох хүсэлт гаргасан ажилтнуудыг сонгон шалгаруулах журмыг Улсын Ерөнхий прокурорын тушаалаар батлан мөрдүүлж байна.

Монгол Улсын Ерөнхий прокурорын 2011 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 46 дугаар тушаалаар баталсан “Прокурорыг сэлгэн ажиллуулах, дэвшүүлэн томилоход мөрдөх журам”, 2015 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн А/20 дугаар тушаалаар баталсан “Дээд шатны прокуророор ажиллах прокурорын мэдлэг чадварыг үнэлж, дүгнэх журам”-ыг мөрдөж байна. Прокурорын тухай хуулийг 2017 онд шинэчлэн баталсан ба хуулийн

45 дугаар зүйлийн 45.2-т “Прокурорын мэргэжлийн ёс зүй, мэргэшсэн байдал, ур чадвар, дадлага туршлагыг харгалзан албан тушаалд сонгон шалгаруулах, дэвшүүлэх, эсхүл бууруулан томилох, сэлгүүлэн ажиллуулах журмыг Улсын Ерөнхий прокурор батална.” гэж заасны дагуу журмын төслийг шинэчлэн боловсруулж, тус прокурорын газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд болон харьяа прокурорын газруудаас санал авч, батлуулахад бэлэн болгосон байна. (Биелэлт 70 хувь)

4.1.5.1-3. Шүүгчид нэр дэвшигчийг Монгол Улсын Ерөнхийлөгч шүүгчээр томилохоос татгалзах үндэслэлийг хуулиар тодорхой болгох /ХЗДХЯ, ШЕЗ, 2018-2019/

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор баталсан Шүүхийн захиргааны байгууллагын стратеги төлөвлөгөөний 3.4.2.1-т “Шүүгчийг томилох, томилохоос татгалзах, огцруулах, чөлөөлөх, шилжүүлэх, сэлгэх, бүрэн эрхийг түдгэлзүүлэх үндэслэл, журмын талаарх хуулийн зохицуулалтыг оновчтой болгох замаар шүүгчийн томилгооны хараат бус байдлыг бэхжүүлэх” арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлттэй холбоотойгоор Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/229 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг Монгол Улсын шүүхийн тухай хууль, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, Шүүхийн захиргааны тухай хууль, Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулийг нэгтгэн Монгол Улсын шүүхийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн төслийг боловсруулсан. Энэхүү төслийн 37 дугаар зүйлийн 37.2-т “Шүүхийн ерөнхий зөвлөлөөс санал болгосон нэр дэвшигч нь шүүгчид тавигдах болзол, хангаагүй гэж Ерөнхийлөгч үзвэл энэ тухай Шүүхийн ерөнхий зөвлөлд албан ёсоор мэдэгдэнэ”, 37.3-т “Шүүхийн ерөнхий зөвлөл Ерөнхийлөгчийн үндэслэлийн дагуу дахин нягталж, томилохоос татгалзсан шалтгаан тогтоогдоогүй тохиолдолд тухайн нэр дэвшигчийг дахин санал болгох, нотлогдсон тохиолдолд Монгол Улсын Үндсэн хууль, энэ хуульд заасан журмаар өөр нэр дэвшигчийг санал болгоно” гэж шүүгчийг томилохоос татгалзсантай холбоотой зохицуулалтыг



тусгажээ. Төслийг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрөл авахаар Сангийн яаманд хүргүүлсэн байна. (Биелэлт 30 хувь)

4.1.5.1-4. Шүүгчид нөлөөлөх үйлдэл хийсэн, нөлөөлсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг чангатгах, нөлөөллийн мэдүүлгийн үр нөлөөг дээшлүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох /ХЗДХЯ, ШЕЗ, 2018-2021/

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлд шүүгч, шүүх бүрэлдэхүүн нөлөөллийн мэдүүлэг хөтлөн Шүүхийн ерөнхий зөвлөлд ирүүлэх, Ерөнхий зөвлөл нөлөөллийн мэдүүлэгт тэмдэглэн баталгаажуулсан үйлдлийг хэрхэн шийдвэрлэхтэй холбоотой харилцааг хуульчилсан.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2015 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн 23 дугаар тогтоолоор “Нөлөөллийн мэдүүлгийг шийдвэрлэх журам”-ыг батлан мөрдөж байна.

2016 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөж эхэлсэн Захиргааны ерөнхий хуульд захиргааны байгууллагын үйл ажиллагаа, түүний дотор захиргааны хэм хэмжээний акт батлан гаргах ажиллагаа, тавигдах шаардлагыг шинээр зохицуулсантай холбоотойгоор Нөлөөллийн мэдүүлгийг шийдвэрлэх журмын зарим заалтыг шүүхээс хүчингүйд тооцсон. Тухайлбал, иргэн А.Н-ын нэхэмжлэлтэй, Шүүхийн ерөнхий зөвлөлд холбогдох Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 0001 дүгээр шийдвэрээр Нөлөөллийн мэдүүлгийг шийдвэрлэх журмын 2.2, иргэн А.Э, Ш.Э нарын нэхэмжлэлтэй Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 0008 дугаар шийдвэрээр журмын 3.7 дахь заалтыг тус тус хүчингүйд тооцож шийдвэрлэсэн байна.

2018-2019 онд “Нөлөөллийн мэдүүлгийг шийдвэрлэх журам”, “Нөлөөллийн мэдүүлгийн загвар”, “Нөлөөллийн мэдүүлгийн талаар танилцуулсан загвар”-ын төслийг тус тус шинэчлэн боловсруулж. Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2020 оны эхний хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлэн болгоод байна.

2019 онд 6 нөлөөллийн мэдүүлэг шүүгч болон шүүх бүрэлдэхүүнээс хөтөлж, Шүүхийн ерөнхий зөвлөлд ирүүлжээ. Дээрх 6

нөлөөллийн мэдүүлгээс 1 мэдүүлэгт Шүүхийн ерөнхий зөвлөл хариу хүргүүлсэн, 5 мэдүүлэг ажиллагаанд байна.(Биелэлт 30 хувь)

4.1.5.1-5. Шүүгч, прокурорын ёс зүйн дүрэм, Шүүхийн ёс зүйн хороо, Прокурорын байгууллагын Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааны журмыг шинэчлэн батлах, Ёс зүйн хорооны шийдвэр шүүхийн хяналтад байгааг өөрчлөх /ШЕЗ, УЕПГ, 2017-2020/

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 69 дүгээр захирамжаар Шүүгчийн ёс зүй, хариуцлагын тогтолцоог сайжруулах чиглэлээр ажлын хэсгийг байгуулан Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тус тус боловсруулан 2019 оны 03 дугаар сарын 07-ны өдөр Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлж, төсөлд Засгийн газар, иргэд, олон нийтийн саналыг авч байх явцад Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт орсноор хуулийн төслийг дахин боловсруулах шаардлага бий болсон.

2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт “Хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах болон сахилгын бусад шийтгэл ногдуулах чиг үүрэг бүхий Шүүхийн сахилгын хороо ажиллах бөгөөд түүний бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавих шаардлага, томилох журмыг хуулиар тогтооно” гэж заасан нь дээрх хуулийн төслүүдийн үзэл баримтлал, зарчим, судалгааны үр дүн хуульд тусгалаа олсон.

Монгол Улсын Шүүхийн тухай хууль / шинэчилсэн найруулга/-ийн төслийн 12 дугаар бүлэгт “Шүүгчид хариуцлага хүлээлгэх тухай, 15 дугаар бүлэгт “Шүүхийн сахилгын хороо байгуулах болон гомдол хянан шийдвэрлэх журмыг тодорхой зохицуулахаар боловсруулж, олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлэн, Сангийн яамнаас санал авч байгаа болно.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 10 дугаар



зарлигаар “Прокурорын ёс зүйн дүрэм”, “Прокурорын ёс зүйн зөвлөлийн ажиллах журам”-ыг, 12 дугаар зарлигаар “Прокурорын сахилгын дүрэм”-ийг тус тус шинэчлэн батлуулан мөрдөж байна.

Улсын ерөнхий прокурорын 2018 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн А/16 тоот тушаалаар прокурорын ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн томилж дүрэмд заасан үндэслэлийн дагуу прокурорт сахилгын шийтгэл оногдуулж хариуцлага тооцон ажиллаж байна. (Биелэлт 70 хувь)

4.1.5.1-6. Шүүх хуралдаанд нууцтай холбоотой асуудал хэлэлцэх хэсгийг хаалттайгаар бусад хэсгийг нээлттэй явуулахаар эрх зүйн орчинг бүрдүүлэх /ШЕЗ, ХЗДХЯ, 2018-2019/

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 34.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2-т шүүх хуралдаан хаалттай явах үндэслэлийг хуульчилж өгсөн байна. Дараах тохиолдолд шүүх хуралдааныг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг хаалттай явуулахаар байна. Үүнд:

- төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой хэргийг хянан шийдвэрлэх;
- өсвөр насны шүүгдэгчид холбогдох хэргийг хянан шийдвэрлэхэд түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч хүсэлт гаргасан бол;
- арван найман насанд хүрээгүй хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах шаардлагатай гэж үзвэл түүнд холбогдох хэргийг хянан шийдвэрлэх;
- хамгаалалтад байгаа гэрчийн мэдүүлгийг уншиж сонсох, эрэн сурвалжлах нууц ажиллагаа, мөрдөн шалгах нууц ажиллагааны явцад олж авсан нотлох баримтыг шинжлэн судлах,
- Хэргийн нотлох баримт, үйл явдал төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарах бол хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтээр, эсхүл шүүхийн санаачилгаар шүүх хуралдааныг хаалттай явуулна.

Дээрх дурдсан үндэслэлээс бусад тохиолдолд шүүх нээлттэй шүүх хуралдаанаар хэргийг

хэлэлцэж хянан шийдвэрлэхээр байна. (Биелэлт 100 хувь)

4.1.5.2-1. Ерөнхий шүүгчийг томилох шалгуур, журмыг шинэчлэн эрх зүйн орчныг боловсронгуй болгох /ХЗДХЯ, 2017-2018/

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлд Ерөнхий шүүгчид тавих шаардлагыг хуульчилсан бөгөөд бүх шатны шүүхийн Ерөнхий шүүгч нь тухайн шатны шүүхийн шүүгчид тавигдах ерөнхий шаардлагаас гадна 3-10 жил тухайн шатны шүүхэд ажилласан байх, удирдан зохион байгуулах авьяас, манлайлах ур чадвартай байх шаардлагыг нэмж хангасан байхыг шаардаж байна.

Монгол Улсын Шүүхийн тухай хууль / шинэчилсэн найруулга/-ийн төсөлд Ерөнхий шүүгчийг томилох шалгуур, журамтай холбоотой өөрчлөлт тусгагдсан байна.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.2-т зааснаар анхан давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч нь тухай шатны шүүхэд 3-аас доошгүй жил ажилласан байх шаардлага тавигдаж байгаа бол Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд 5-аас доошгүй жил ажилласан байх шаардлага хангасан байхаар тусгасан байна.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т зааснаар энэ хуульд заасан шаардлагыг хангасан гэж үзсэн шүүгч тухайн шүүхийн Ерөнхий шүүгчид нэрээ дэвшүүлэн сонгон шалгаруулалтад оролцож, Монгол Улсын Ерөнхийлөгч томилохоор байгаа бол Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 37 дугаар зүйлийн 37.5-д “Улсын дээд шүүхээс бусад шүүхийн Ерөнхий шүүгчийг тухайн шүүхийн шүүгчдийн Зөвлөгөөнөөс гурван жилийн хугацаагаар сонгох бөгөөд түүнийг тухайн шүүхэд нь нэг удаа улируулан сонгож болно” гэж тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөр Ерөнхий шүүгчийг сонгох асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхээр тусгасан байна.

“Шүүгчийг сонгон шалгаруулах журам”-ын төслийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар батлуулахаар ажиллаж байна. Уг журмын төсөлд анхан болон давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн сонгон шалгаруулалтад орж буй нэр дэвшигчээс тусгай

шалгалт авахаар заасан байна. (Биелэлт 70 хувь)

4.1.5.3-1. Прокурор, шүүгчийг мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийг шинэчлэн, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хянан шийдвэрлэх асуудлыг оруулах /ШЕЗ, УЕПГ, 2017-2019/

2017 онд батлан хэрэгжүүлсэн Шүүгчийн ёс зүйн хөтөлбөрийн агуулгад “Шүүгчийн нийтийн албанд баримтлах ёс зүй”, “Шүүгчийн ашиг сонирхлын зөрчил”, “Ашиг сонирхлын зөрчил”, “Шүүгчийн ашиг сонирхлын зөрчил үүсэх шалтгаан ба хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзах үндэслэл, журам”, “Ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх арга зам” зэрэг сэдвүүдийг багтааж, сургалтыг анхан болон давж заалдах шатны шүүхийн бүх шүүгчдийг хамруулан зохион байгуулсан.

2018 оны Шүүгчийн ёс зүйн сургалтуудын хөтөлбөрийн агуулгад авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хянан шийдвэрлэх асуудлыг тусгасан. 2018 онд Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2018 оны 141 дүгээр тушаалаар нийт шүүхийн Тамгын газрууд, Авлигын эсрэг сургалтын сургагч-шүүгч багш нартай хамтран “Авлигын эсрэг” сургалтыг нийт шүүхийн Тамгын газруудад зохион байгуулж, нийт 510 шүүгчдийг тус сургалтад хамруулсан.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2018 оны 84 дүгээр тогтоолоор “Шүүхийн сургалтын үндсэн хөтөлбөр”-ийг шинэчлэн баталсан бөгөөд тус хөтөлбөрөөр шүүгч “Үндсэн хууль ба Хүний эрх”, “Шүүгчийн ёс зүйн” сургалтад зайлшгүй жил бүр хамрагдах бөгөөд шүүгчийн ёс зүйн сургалтын агуулгад авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх агуулгыг тусгасан. Шүүгчийн ёс зүйн сургалтын сэдвүүдэд ашиг сонирхлын зөрчлөөс шүүгч ангид байх, олон нийтэд буруу ойлголт төрүүлэхгүй байх агуулгыг тусгасан байна.

2019 онд шүүгчийн ёс зүйн сургалтыг зохион байгуулж анхан болон давж заалдах шатны шүүхийн нийт 483 шүүгчийг хамруулсан.

Улсын Ерөнхий прокурорын 2017 оны А/46 тушаалаар “Прокурорын сургалтын хөтөлбөр”-ийг шинэчлэн боловсруулж, “Авлига, ашиг

сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх” талаар 2-4 цагийн сургалт буюу нийтдээ 12 цагийн сургалтыг явуулахаар тусган зохион байгуулж, “Авлигын гэмт хэргийг шалгахад анхаарах асуудал” сэдвээр сургалтын гарын авлага, модулийг боловсруулсан байна.

2017-2018 онд прокурорын болон туслах ажилтны анхан шатны болон үргэлжилсэн сургалтыг 3 удаа зохион байгуулж, нийт 70 прокурор, ажилтныг 12 цагийн сургалтад хамруулсан байна.

2018 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Авлигаас татгалзах, авлигын гэрч, хохирогчийг хамгаалах жил болгон зарлах тухай” зарлигийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Гэмт хэргийн мэдээлэгч, гэрч, хохирогчийг хамгаалах ажиллагаанд анхаарах аргачлал”-ыг боловсруулж, харьяа нэгжийн прокурорын газруудад хүргүүлсэн.

2019 онд Улсын Ерөнхий прокурорын тушаалаар “Прокурорын сургалтын хөтөлбөр”-т өөрчлөлт оруулж, “Авлига, албан тушаалын гэмт хэрэг” сэдэвт 4 цагийн сургалтын хөтөлбөр, модулийг тусгаж сургалтыг зохион байгуулсан.

Улсын Ерөнхий Прокурорын Газрын Сургалтын төвөөс 2019 онд “Авлига, албан тушаалын гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх ажиллагаанд анхаарах асуудлууд” сэдвээр сургалтын гарын авлагыг боловсруулж, 500 ширхэгийг хэвлүүлэн нийт прокуроруудад хүргүүлэн сургалтад ашиглаж байна.. Улсын Ерөнхий прокурорын орлогчоор ахлуулсан баг “Авлига, албан тушаалын гэмт хэргийг мөрдөн шалгахад анхаарах асуудал” сэдэвт сургалтын модуль, хөтөлбөр боловсруулж, сургалт явуулах болон сургагч багш бэлтгэсэн. Прокурор, ажилтнуудад ХАСХОМ болон ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар цахим сургалтыг жил бүр зохион байгуулж байна (Биелэлт 100 хувь)

4.1.5.3-2. Шинээр томилогдсон шүүгч, прокурорт сургалтын хөтөлбөрийн дагуу авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэргийг хянан шийдвэрлэх сэдвээр сургалтыг зохион байгуулах /ШЕЗ, УЕПГ, 2017-2022/

Шинээр томилогдсон шүүгчдийн “Шүүгчийн анхан шатны сургалт”-ыг 2017 оны 06 дугаар сард зохион байгуулсан бөгөөд авлига, ашиг



сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Шүүгчийн ашиг сонирхлын зөрчил”, “Шүүгчийн албан үүргээс бусад хувийн амьдралд баримтлах зарчим”, “Шүүгчийн ёс зүйн зөрчилд тооцогдох тохиолдол” зэрэг сэдвүүдийг хөтөлбөрт оруулсан байна.

2018 онд “Шүүгчийн сонгон шалгаруулалтын журам” шинэчлэн батлагдаж, шүүгчийн сонгон шалгаруулалтад тэнцсэн 62 нэр дэвшигчдийг 2018 онд, 2019 онд шүүгчээр томилогдохоор нэр дэвшиж буй 60 хуульчийг Шүүгч бэлтгэх сургалтад хамруулж, ёс зүй, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх онол, практикийн мэдлэг олгосон.

Нийслэл болон дүүргийн эрүү, иргэн, захиргааны хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн 36 шүүгч, 128 захиргааны ажилтнуудыг хамруулан “Ашиг сонирхлын зөрчил, анхаарах асуудал”, “Албан тушаалтны ХАСХОМ, анхаарах асуудал” сэдэвт сургалтыг, Гүйцэтгэх нарийн бичгийн даргын 2019 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/109 тоот тушаалаар Шүүхийн тамгын газрын “Эрх бүхий албан тушаалтан /ЭБАТ/-уудын үйл ажиллагаа, анхаарах асуудал” сэдэвт сургалтыг 2019 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр хөдөө, орон нутгийн 30 эрх бүхий албан тушаалтан, онлайн, нийслэл, дүүргүүдийн 12 эрх бүхий албан тушаалтныг хамруулан тус тус зохион байгуулсан.

Улсын Ерөнхий Прокурорын Газрын Сургалтын төвөөс шинээр томилогдсон прокуроруудад сургалтыг жил бүр зохион байгуулж байна. Сургалтын хөтөлбөрт “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын эсрэг гэмт хэргийг хянан шийдвэрлэх нь” сэдвийг тусган сургалтыг тогтмол явуулж хэвшсэн. Улсын ерөнхий прокурорын газраас 2017 онд шинээр томилогдсон 26 прокурорт “Авлигын гэмт хэргийг шалгах, шийдвэрлэхэд анхаарах асуудал” сэдвээр 8 цагийн сургалт, 2018 онд 2 жил хүртэлх хугацаанд ажиллаж байгаа 27 прокурорыг анхан шатны 45 цагийн сургалтад, 2019 онд 25 прокурорыг 42 цагийн сургалтад тус тус хамруулж, сертификат олгосон бөгөөд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэргийг хянан шийдвэрлэх сэдвээр тус бүр 4 цагийн сургалт хийв. Дээрх сургалтын үр дүнд шинээр томилогдсон прокуроруудын мэргэжлийн үр чадвар сайжирч байна. Сургалтын

хүрээнд шүүхээс энэ төрлийн гэмт хэргийг шийдвэрлэсэн тогтоол, магадлалыг авч, сан бүрдүүлэн сургалтад тогтмол ашиглаж байна. (Биелэлт 100 хувь)

4.1.5.4-1.Авлига, албан тушаалын гэмт хэргийн шийдвэрлэлт, шалтгаан нөхцөлд дүн шинжилгээ хийх, үр дүнг урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг сайжруулах болон хууль тогтоомжийг боловсронгуй болгоход ашиглах /АТГ, 2017-2021/

Авлигатай тэмцэх газар, Улсын Ерөнхий прокурорын газар, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр “Авлигатай тэмцэх тогтолцоог бэхжүүлэх нь” төслийг 2019-2021 онд хэрэгжүүлэх бөгөөд төслийн албан ёсны нээлтийн арга хэмжээг 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулав. Төслийн хүрээнд авлигын гэмт хэрэг шийдвэрлэлтийн урсгалд дэлгэрэнгүй дүн шинжилгээ хийх судалгааны аргачлалын төслийг боловсруулж төсөл хэрэгжүүлэгч 3 байгууллага баталгаажуулсан. Судалгааны аргачлалын хавсралтаар батлагдсан статистик мэдээлэл цуглуулах хүснэгтийн дагуу холбогдох байгууллагуудаас тоон судалгааг авч нэгтгэн дүн шинжилгээ хийн ажиллаж байна. Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийн статистик мэдээллийг гаргаж, 100 орчим мөрдөгч, прокурор, шүүгчдийн дунд судалгаа, ярилцлага явуулж, 130 орчим анхан шатны шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийгээд байна. Уг төслийн хүрээнд Авлигын гэмт хэргийг мөрдөн шалгах, түүнд хяналт тавих, шүүхээр шийдвэрлэх үйл явц, түүний үр дүнд дүн шинжилгээ хийж байна. Энэ төслөөр хуулийн байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх, хэрэг хянан шийдвэрлэх үйл явцыг боловсронгуй болгох санал, хууль, тогтоомжийн өөрчлөлтийн төслийг боловсруулах юм.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд гэмт хэрэг гарсан шалтгаан, нөхцөлийг арилгах талаар мөрдөгчийн мэдэгдлийг 2017 онд 40 аж ахуйн нэгж, байгууллагад, 2018 онд 29, 2019 онд 41 аж ахуйн нэгж, байгууллагад хүргүүлэн хариу хүлээн авч, зарим байгууллагад хүргүүлсэн мэдэгдэл дурдсан нөхцөл байдал бодитой арилсан эсэхийг газар дээр нь шалгаж ажилласан.

2011-2015 онд авлига, албан тушаалын гэмт хэргийг шийдвэрлэсэн 162 шийдвэрийг шүүхийн

шийдвэрийн цахим сангаас түүвэрлэн авч дүн шинжилгээ хийж тайланг боловсруулсан. Нийт 347 шүүгдэгчид холбогдох 162 шийдвэрийн 112 нь анхан шатны, 31 нь давж заалдах шатны, 18 нь хяналтын шатны шийдвэр байна. Нийт 347 шүүгдэгчийн 47 хувь буюу 162 шүүгдэгчид ял оноосон байна. Тухайлбал, хээл хахууль өгөх гэмт хэрэг үйлдсэн 78 ялтанд 1-3 жилийн хорих ял, хээл хахууль авах гэмт хэрэг үйлдсэн 43 ялтанд 1-6 жилийн хорих ял, албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах гэмт хэрэг үйлдсэн 32 ялтанд 1-7 жилийн хорих ял ногдуулсан байх бөгөөд 101 ялтны ялыг тэнсэн харгалзаж, 47 ялтны ялыг биечлэн эдлүүлэхээр шийдвэрлэжээ.

Авлига, албан тушаалын гэмт хэргийн 2012-2019 оны шүүхийн шийдвэрүүдийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн цахим сайтаас татан авч хөрвүүлэн сан бүрдүүлж, хэргийн шийдвэрлэлтэд дүн шинжилгээ хийж байгаагийн зэрэгцээ эмхэтгэл болгон хэвлүүлэхэд бэлэн болгов. (Биелэлт 70 хувь)

4.1.5.4-2. Санхүүгийн хариуцлагыг дээшлүүлж, авлигын эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор санхүүгийн аливаа гүйлгээг хүлээн авагчийн жинхэнэ нэрээр нь гүйцэтгэх /Real name financial Transaction act/ эрх зүйн орчинг бий болгох /СЗХ, 2017-2018/

Санхүүгийн аливаа гүйлгээг хэлцэл хийгч талын нэрээр хийх зохицуулалтыг хуульчлан бий болгодог “Real Name Financial Transaction Act”-ыг олон улсад батлан мөрддөг. Энэ нь аливаа гүйлгээг тухайн хэлцлийн дагуу тухайн мөнгө, хөрөнгө, эрхийг хүлээн авах жинхэнэ этгээдийн нэрээр тухайн гүйлгээ хийгдсэн байхыг хуульчлах тухай ойлголт юм. Энэ нь оролцогчдын санхүүгийн хариуцлагыг дээшлүүлэх, авлигын мөнгийг бусдын нэрээр авах, мөнгө угаах, залилан мэхлэх, санхүүгийн луйвар хийх зэрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хууль бус үйлдлийн илрүүлэлтийг сайжруулах ач холбогдолтой тул эрх зүйн орчинг бий болгох зорилгоор “Санхүүгийн аливаа гүйлгээг жинхэнэ нэрээр нь гүйцэтгэх тухай” хуулийн төслийг Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яам хамтран боловсруулахаар “Монгол улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д тусгагдсан.

Санхүүгийн зохицуулах хорооноос 2016, 2017 онд гадаадын орнуудаас Монгол Улсад, Монгол улсаас гадаадын орнуудад хийсэн гуйвуулгын дүн, тоог валютын төрөл тус бүрээр банк бус санхүүгийн байгууллагуудаас авч нэгтгэсэн.

Санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл /MON9152/-ийн хүрээнд олон улсын болон үндэсний зөвлөхийн гаргасан аргачлалын дагуу зайнаас эрсдэлийн тооцооллыг гүйцэтгэсэн. Газар дээрх хяналт шалгалт хийгдэж буй даатгалын компаниудад «Ердийн даатгалын компанийн үйл ажиллагаанд зайнаас хяналт тавих журам»-ын эрсдэлд суурилсан хяналтын асуулгын болон үнэлгээний хуудасны дагуу эрсдэлийн үнэлгээ хийсэн.

Засгийн газрын 2017 оны 327 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Ази, номхон далайн бүсийн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-ний 4.2-т заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны ажлын албаны даргын 2018 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 251 дүгээр тушаалаар мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх асуудал хариуцсан нэгж байгуулагдан ажиллаж байна. Одоогийн төлбөр төлж байгаа үйл явц, түүнд мөрдөгдөж байгаа хууль эрх зүйн тогтолцоо дээрх шаардлагын дагуу хүлээн авагчийн иргэний үнэмлэх дээрх нэр, аж ахуй нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ дээрх нэрээр шилжиж байна.

Санхүүгийн зохицуулах хороо нь даатгалын, банк бус санхүүгийн, хадгаламж, зээлийн хоршооны, үнэт цаасны болон үл хөдлөх хөрөнгө зуучлалын зах зээлийн мэргэжлийн холбоодтой хамтран “Санхүүгийн салбарын комплаенс 2018” форумыг 2018 оны 12 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулж ажилласан. Санхүүгийн салбарын аж ахуйн нэгжүүд комплаенсыг нэвтрүүлээгүй, аль эсвэл холбогдох ажилтан томилоогүйгээс шалтгаалан байгууллагын төдийгүй зах зээлийн нэр хүндийг унагах сөрөг үр дагаврыг авчирдаг.

Санхүүгийн зохицуулах хорооны албан ёсны цахим хуудсаар мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх зэрэг санхүүгийн гэмт хэрэг үйлдсэн, үйлдэж болзошгүй этгээдүүдийн жагсаалтыг мэдээлдэг болж, санхүүгийн зах зээлд оролцогч, иргэд, хуулийн этгээдүүдийг



болзошгүй эрсдэлээс хамгаалах боломжийг бүрдүүлэв. Системүүдийг нэгдсэн нэг ERP систем болгоход шаардагдах хүчин зүйлсийн судалгааны тайланг хийж дуусгасны зэрэгцээ судалгааны үр дүнд олон улсын стандартад нийцсэн нийт 14 дэд системээс бүрдсэн, өөр хоорондоо мэдээлэл солилцох боломж бүхий эрсдэлд суурилсан хяналт шалгалтын нэгдсэн системийн загварыг гаргасан.

Олон улсын хөрөнгө оруулалтын банктай байгуулсан техникийн туслалцааны харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд тус банкны санхүүжилтээр Бүгд Найрамдах Словак Улсын “Эрнст энд Янг” компанитай хамтран салбарын хэмжээнд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлээс сэргийлж, холбогдох дүрэм журмуудыг боловсронгуй болгох, шинэчлэх төслийн ажлыг гүйцэтгэв.

2018 онд Санхүүгийн зохицуулах хорооны даргын баталсан удирдамжийн дагуу Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан мэдээлэх үүрэгтэй этгээдийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж буй 186 хадгаламж зээлийн хоршоо, 460 банк бус санхүүгийн байгууллага, 51 үнэт цаасны компани, 16 хөрөнгө оруулалтын менежментийн компани, 71 Даатгалын байгууллагуудад санхүүгийн аливаа гүйлгээг хүлээн авагчийн жинхэнэ нэрээр нь гүйцэтгэх талаар мэдээлж ажилласан.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд 2018 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр нэмэлт, өөрчлөлт орсон бөгөөд санхүүгийн хариуцлагыг дээшлүүлэх, авлигын мөнгийг бусдын нэрээр авах, мөнгө угаах, залилан мэхлэх, санхүүгийн луйвар хийх зэрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хууль бус үйлдлийн илрүүлэлтийг сайжруулах зохицуулалтыг тусгасан.

Банкнаас бусад санхүүгийн салбарын оролцогчдын санхүүгийн хариуцлагыг дээшлүүлэх, авлигын мөнгийг бусдын нэрээр авах, мөнгө угаах, залилан мэхлэх, санхүүгийн луйвар хийх зэрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хууль бус үйлдлийн илрүүлэлтийг сайжруулах чиглэлээр “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх

үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам”-ын төслийг боловсруулан Хорооноос батлан мөрдүүлж байна. хуралдаанаар хэлэлцүүлж батлуулсан.

2019 оны 5, 9, 10 дугаар сард хадгаламж, зээлийн хоршоодын хяналтын зөвлөлийг хамруулан “Эрсдэлийн удирдлага” сэдэвт сургалт зохион байгуулж, санхүүгийн гүйлгээг жинхэнэ нэрээр нь гүйцэтгэж байх талаар нийт 4 удаагийн сургалтаар 126 оролцогчид зааварчилгаа өгсөн.

Блокчейн технологи болон түүнд суурилсан цахим валютуудын зах зээлийн судалгаа, мөн тэдгээрт хийгдсэн олон улсын эрх зүйн зохицуулалтын талаарх судалгааг хийж, санхүүгийн аливаа гүйлгээг харилцагчийн жинхэнэ нэрээр хийж гүйцэтгэх тухай харьцуулсан судалгааны үр дүнг харуулсан.

Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай үйл ажиллагааны багц дүрмийн төслийг Хорооны 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 04 тоот тогтоолоор баталж, ХЗДХЯ-ны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 4184 дугаарт бүртгүүлсэн. Тус багц дүрмийн 1 дүгээр хавсралт болох “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-д үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа явуулах аливаа хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан болон ажиллагсад нь тохиромжтой этгээдийн шаардлагыг зайлшгүй хангасан байх талаар тусгасан.

Мөн Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр Мөнгө угаахтай тэмцэх олон улсын санхүүгийн хориг хэрэгжүүлэгч байгууллага (ФАТФ)-ын зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх, шууд хэрэгжилтийг хангаж ажиллахтай холбоотойгоор «Эм Эм Си Жи» ХХК-аар хийж гүйцэтгүүлж буй «Санхүүгийн зохицуулах хорооны хяналт тавих мэдээлэх үүрэгтэй этгээдүүдийн 5 салбарын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээний тайлан», «Үнэт цаасны зах зээлд оролцогчид байгууллага тус бүрийн эрсдэлийн үнэлгээний тайлан»-тай холбоотойгоор санал солилцох, мэдээлэл өгөх чиглэлээр уулзалтууд хийсэн бөгөөд тайлангийн төсөлд оруулах нэмэлт, өөрчлөлтүүд болон тайлбар, тодруулгууд гаргуулах чиглэлээр саналууд өгч ажилласан.

2019 оны 10 дугаар сарын 10-ны өдөр Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсон бөгөөд түүний дагуу үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа, үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх иргэн, хуулийн этгээдүүдийг СЗХ-ны зохицуулалтын хүрээнд хамааруулж, хяналтад оруулсан. (Биелэлт 30 хувь)

4.1.5.5-1. Авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийн талаар мэдээлэл авах үйл ажиллагааны арга хэлбэрийг сайжруулах, иргэд, байгууллагаас өргөдөл, гомдол, мэдээлэл утсаар өгөх боломжийг бүрдүүлэх /АТГ, 2017-2022/

Авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг иргэн, хуулийн этгээдээс хүлээн авах сувгийг өргөжүүлэх, цахим сүлжээг ашиглах чиглэлээр сайжруулалт хийсэн. Энэ хүрээнд Авлигатай тэмцэх газарт авлигын талаар гомдол мэдээлэл хүлээн авах тусгай дугаар (18001969-ыг 110)-ыг шинэчилж, аль үүрэн болон бусад дугаараас төлбөргүй, шууд холбогдох нөхцөл боломжийг бүрдүүлсэн. Мөн гомдол мэдээлэл хүлээн авах 70112458 дугаарын факс, www.iaac.mn цахим хуудас дахь гомдол, мэдээллийн тусгай маягт бүхий хэсгийг ажиллуулж, байгаагаас гадна биечлэн ирж гомдол, мэдээлэл хүлээлгэн өгөх боломжийг бүрдүүлсэн.

Түүнчлэн Авлигатай тэмцэх газар хүлээн авсан гомдол, мэдээллийн бүртгэл, шийдвэрлэх үйл ажиллагааг шуурхай, тавих хяналтыг сайжруулах зорилгоор өргөдөл, гомдлын програм хангамжийг шинэчилж, хөгжлүүлэлтийг хийсэн, мөн гомдол, мэдээллийн нууцлал, хяналтыг сайжруулах хүрээнд зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан байна.

Авлигын талаар гомдолд мэдээлэл хүлээн авах байнгын ажиллагаатай тусгай дугаарыг сурталчилсан аудио болон видео контент, зурагт хуудас, сурталчилгааны материалыг цувралаар бэлтгэн, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээгээр үе шаттайгаар тогтмол сурталчлах ажлыг зохион байгуулж байна. Байгууллагын хэмжээнд 2017 онд иргэд, байгууллагаас 1324 өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авснаас гэмт хэргийн шинжтэй 658 гомдол мэдээлэл, 2018

онд 1887 өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авснаас гэмт хэргийн шинжтэй 858 гомдол, мэдээлэл, 2019 онд гэмт хэргийн шинжтэй 894 гомдол, мэдээллийг хүлээн авч хуулийн дагуу шалгаж шийдвэрлэсэн дүнтэй байна. 110 тусгай дугаарын утсаар 2019 оны 10 дугаар сарын 28-ны өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 4464 удаагийн дуудлага ирүүлснийг бүртгэн хяналт тавьж ажиллав.

Авлигын талаар гомдол, мэдээлэл өгч байгаа иргэний урамшуулах тогтолцоог бүрдүүлэх хүрээнд Мэдээлэгч (Шүгэл үлээгч)-ийг хамгаалах хуулийн төслийг боловсруулж, холбогдох судалгааг хийж гүйцэтгэсэн. (Биелэлт 70 хувь)

4.1.5.5-2. Мэдээлэл өгсөн иргэнийг урамшуулах тогтолцоог бүрдүүлэх /АТГ, 2017-2021/

Авлигатай тэмцэх газраас Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг хамгаалах тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хурлын даргад хүргүүлэв. Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгчийг хамгаалах тухай хуулийн төсөлтэй хамт дагалдан гарах хуулиуд болох Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай зэрэг хуулийн төслийг боловсруулан УИХ-д хүргүүлээ. Хуулийн төсөлд шүгэл үлээгч /илчлэгч/-ийн нийгэмд гүйцэтгэх үүргийг нийтэд зөв ойлгуулах, хүлээн зөвшөөрөх нөхцөл бүрдүүлэх, дэмжих, хамгаалах асуудлыг шийдвэрлэх үндэслэл, журмыг тогтоон зохицуулсан. Үүнтэй холбогдуулан хуулийн төсөлд нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээсэнтэй холбогдуулан бий болсон орлого, буруутай этгээдээр төлүүлсэн хохирол, урьдчилан сэргийлсэн нөхцөл байдал, хууль зүйн үр дагаврыг харгалзан мөнгөн шагнал, урамшууллын мөнгийг хэрхэн тооцож олгох, эдгээрийн хоорондын ялгаа, баримтлах мөнгөний хэмжээг тодорхой тусгасан. Авлигатай тэмцэх газраас Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хууль зүйн судалгааны төвд захиалан хуулийн төслийн зардлын тооцоо зэрэг үнэлгээг хийлгүүлсэн болно. (Биелэлт 70 хувь)



#### 4.1.5.6-1. Шүгэл үлээгч /мэдээлэгч/-ийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг бий болгох /ХЗДХЯ, 2018-2019/

Авлигатай тэмцэх газраас Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг хамгаалах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хурлын даргад хүргүүлэв. Энэ хүрээнд “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааны тайлан”, “Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч (илчлэгч)-ийг хамгаалах тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ”, “Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч (илчлэгч)-ийг хамгаалах тухай хуулийн төслийн зардлын тооцоо” зэрэг үнэлгээ, судалгааны ажлыг гүйцэтгүүлэн УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргад хүргүүлэв. Дээрх төслүүдтэй хамт дагалдан гарах хуулиуд болох Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай зэрэг хуулийн төслийг боловсруулан УИХ-д хүргүүлэв. Хуулийн төсөлд нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг дэмжих чиглэлээр Авлигатай тэмцэх газар болон бусад байгууллагын хүлээх үүрэг, хэрэгжүүлэх ажиллагааг тодорхойлж, нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээж иргэний эр зориг гарган хариуцлага үүрч, эрх мэдэлтэн, албан тушаалтан, төрийн байгууллагын үйл ажиллагаанд гарч буй зүй бус үйлдэлд нийгмийн анхаарлыг чиглүүлж шударга ёсыг тогтоохын төлөө хувийн эрх ашгаас нийтийн эрх ашгийг өндөрт тавьж байгаа шүгэл үлээгч /илчлэгч/-ийн нийгэмд гүйцэтгэх үүргийг нийтэд зөв ойлгуулах, хүлээн зөвшөөрөх нөхцөл бүрдүүлэх, дэмжих, хамгаалах асуудлыг шийдвэрлэх үндэслэл, журмыг тогтоон зохицуулсан. Хуулийн төслийг боловсруулахдаа бусад орны Шүгэл үлээгчийг хамгаалах тухай хуулиудыг судлахын зэрэгцээ НҮБ-ын Авлигын эсрэг конвенцийн заалт, холбогдох олон улсын байгууллагаас ирүүлсэн зөвлөмжид нийцүүлэх чиглэл баримталсан болно. (Биелэлт 70 хувь)

#### 4.1.5.6-2. Хууль сахиулах байгууллагын ажилтан, албан хаагчдад эрэн сурвалжлах сэтгүүл зүй, сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах талаар сургалт хийх, тэдний мэдлэг ойлголтыг дээшлүүлэх /МСНЭ, Хэвлэл мэдээллийн зөвлөл, 2017-2019/

Хууль зүй, дотоод хэргийн яам нь Цагдаагийн ерөнхий газартай хамтран хууль эрх зүйн чиглэлээр дагнан бичдэг сэтгүүлчдийн дунд “Эрх зүйн сургалт, өдөрлөг”-ийг 2018 онд зохион байгуулсан. Мөн эрэн сурвалжлах сэтгүүлчдийн клуб байгуулж, клубээс мэдээлэгчийг хамгаалах талаар уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, гарсан саналыг Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсэгт хүргүүлэв. Эрүүгийн багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын хэсгээс хуулийн төсөлд ирүүлсэн саналуудыг тусган гарсан саналыг үндэслэн хуулийн төсөлд нэмэлт боловсруулалт хийж байна.

Авлигатай тэмцэх газраас Хэвлэл мэдээллийн зөвлөлтэй хамтран хууль сахиулах байгууллагын ажилтан, албан хаагчдад “Эрэн сурвалжлах сэтгүүл зүй, сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах нь” сэдэвт нэг өдрийн сургалтыг 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгууллаа. Сургалтаар Монгол улс дахь хэвлэн нийтлэх эрх чөлөөний хэрэгжилт, сэтгүүлчийн аюулгүй байдлын өнөөгийн түвшний тухай судалгаанд тулгуурласан мэдээллийг танилцуулж эрэн сурвалжлах сэтгүүл зүйн үндсэн ойлголт, ёс зүй, олон улсын чиг хандлага, хуурамч мэдээллийг таних арга, алхмууд, хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын үр дүнгийн талаар мэдээлэл өгсөн. Сургалтад Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Цагдаагийн ерөнхий газрын 57 гаруй албан хаагч хамрагдав.

Авлигатай тэмцэх газар, Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс сэтгүүлчдийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлсөн, шахалт үзүүлсэн, заналхийлсэн тоо баримтыг бүрдүүлэхээр нийслэл болон орон нутгийн 300 сэтгүүлчийн дунд санал асуулгын судалгааг явуулав. Судалгааны үр дүн 2019 оны 5 дугаар сард олон нийтэд танилцуулсан болно. (Биелэлт 70 хувь)



4.1.5.6-3. Сэтгүүлчийн аюулгүй байдлын талаар судалгаа, хяналт мониторинг хийх/МСНЭ, Хэвлэл мэдээллийн зөвлөл, 2017-2020/

Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс 2018 онд сэтгүүлчдийн аюулгүй байдлын талаарх цогц судалгааг эхлүүлсэн бөгөөд энэ хүрээнд Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд хэвлэмэл сонин, цахим сайтуудад нийтлэгдсэн сэтгүүлчийн аюулгүй байдалтай холбоотой асуудал, мэдэгдэл, нийтлэлд мониторинг хийж, агуулгын судалгааг эхлүүлэв. Энэхүү мониторингийн дүнг бусад санал асуулгын судалгаа, фокус бүлгийн ярилцлагын судалгааны үр дүнтэй нэгтгэн тайлан хэвлүүлж, сэтгүүлчид болон хууль сахиулах байгууллагын ажилтан, албан хаагчдад түгээнэ.

АТГ, Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс сэтгүүлчдийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлсөн, шахалт үзүүлсэн, заналхийлсэн тоо баримтыг бүрдүүлэхээр нийслэл болон орон нутгийн 300 сэтгүүлчийн дунд санал асуулгын судалгааг явуулав. Судалгааны үр дүн 2019 оны 5 дугаар сард олон нийтэд танилцуулсан болно. (Биелэлт 30 хувь)

4.1.5.7-1. Авлигатай тэмцэх газрын албан хаагчдын мэргэжлийн үр чадварыг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулах/АТГ, 2017-2022/

2017 онд Монголбанктай хамтран “Банк, мөнгөний бодлогын ойлголт, санхүүгийн хяналт шалгалт” сэдэвт “тусгай хөтөлбөрт” 16 цагийн сургалт, Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн зарчим, үзэл баримтлал сэдэвт сургалт, Монголын хуульчдын холбоотой хамтран зохион байгуулсан шинэчлэгдсэн хуулиудын талаар 16 цагийн сургалт, Худалдан авах ажиллагааны эрх олгох 3 хоногийн сургалт, АТГ-аас НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба, Дэлхийн банкны хамтарсан “Хулгайлагдсан хөрөнгийг буцаан олгох санаачилга” (StAR)-тай хамтран “Хөрөнгө, орлогын мэдүүлгийн хяналтын тогтолцоог бэхжүүлэх нь” сэдэвт хоёр өдрийн сургалт, Авлигатай тэмцэх газар, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага хамтран зохион байгуулсан “Олон улсын

болон үндэсний хэмжээнд авлига, мөнгө угаах явдалтай тэмцэх нь” сургалтыг тус тус зохион байгуулсан.

Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагаас зохион байгуулсан Австри Улсад болсон “Сингапур улсын авлигатай тэмцэх сайн туршлага”, БНХАУ-ын Хонг Конг мужид зохион байгуулагдсан “Эдийн засгийн гэмт хэргийг мөрдөн шалгах нь”, Гүрж улсад зохион байгуулагдсан “Авлигын эсрэг сургалт”-д тус тус албан хаагчдыг хамруулав. 2017 онд дугаар сард “Авлигын эсрэг хамтын ажиллагааг Монгол Улсад идэвхжүүлэх нь”, “Олон улсын болон үндэсний хэмжээнд авлига, мөнгө угаах явдалтай тэмцэх нь” сэдэвт сургалтад албан хаагчдыг оролцуулсан.

2018 оны 06 дугаар сарын 14-15-ны өдрүүдэд “Оффшор бүс нутгийг ашиглан мөнгө угаах, түүнтэй тэмцэх олон улсын туршлага” сэдэвт сургалтыг зохион байгуулав. Санхүүгийн гэмт хэргийн чиглэлээр мэргэшсэн зөвлөх мэргэжилтэн Игорис Кризещковскийн удирдан явуулсан сургалтад АТГ, УЕПГ, ТЕГ, ЦЕГ, Монголбанк зэрэг байгууллагуудын төлөөлөл оролцон оффшорын асуудал болон мөнгө угаах гэмт хэргийн талаар мэдээлэл авч туршлага сонсов.

2018 онд Үндэсний тагнуулын академитай хамтарсан Гүйцэтгэх ажлын анхан шатны мэдлэг олгох 14 хоногийн сургалт, Худалдан авах ажиллагааны эрх олгох сургалт, Студийн зураглаачийн сургалт, Зэвсэгт хүчний жанжин штабын англи хэлний сургалт, Монголын хуульчдын холбоотой хамтран зохион байгуулсан 2 кредит цагийн Хуульчийн үргэлжилсэн сургалтад албан хаагчийг тус тус суралцуулсан. Албан хаагчдын гадаад хэлний мэдлэгийн түвшинг дээшлүүлэхээр “Burton English Mongolia” ХХК-тай гэрээ байгуулж, 106 албан хаагчийг англи хэлний цахим сургалтад, АНУ-д Англи хэлний сургалтад 3 албан хаагчийг хамруулав.

Санхүүгийн зохицуулах хороотой хамтран Санхүүгийн зах зээл, үнэт цаас, даатгал, бичил санхүүгийн зах зээл сэдвээр 16 цагийн сургалт, “Төрийн болон албаны нууцын тухай хууль, үзэл баримтлал, хэрэглээ” сэдэвт сургалт, “Байгууллагын сайн засаглал, нийгмийн хариуцлага, тогтвортой хөгжлийн үзэл баримтлал” сэдэвт сургалт, Монгол банктай



хамтран “Валютын ханш ба Монгол банкны мөнгөний бодлого”, МУИС-ийн Бизнесийн сургуультай хамтран “Баг бүрдүүлэлт, манлайлал” сэдэвт 8 цагийн сургалтыг тус тус зохион байгуулж, нийт албан хаагчдыг хамруулав. Тайваны хууль зүйн яамны шүүгч, прокурорын академийн багш нараас УЕПГ-т зохион байгуулсан Зохион байгуулалттай гэмт бүлэглэлээс үйлдэж байгаа гэмт хэрэг, хөрөнгө хураах ажиллагаа” сэдэвт сургалтад 2 албан хаагчийг хамруулав. (Биелэлт 70 хувь)

#### 4.1.5.7-2. Авлигын эсрэг хууль тогтоомжийг боловсронгуй болгох/АТГ, 2017-2019/

УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2017 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хянах, хадгалах журам батлах тухай” 2012 оны 05 дугаар тогтоолд нэмэлт оруулж, “хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг цахим хэлбэрээр мэдүүлсэн тухай”, “нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг цахим хэлбэрээр мэдүүлсэн тухай” баталгааны маягтыг тус тус батлуулан мөрдөж байна.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 10<sup>1</sup> дүгээр зүйлийн 10<sup>1.3</sup>-т заасныг үндэслэн оффшор бүсэд хамаарах нийт 49 нутаг дэвсгэрийн жагсаалтыг Засгийн газрын 2017 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн 244 дүгээр тогтоол, 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 326 дугаар тогтоолоор тус тус баталсан.

Дээрх хуулийн 10<sup>1</sup> дүгээр зүйлийн 10<sup>1.4</sup>-т заасны дагуу мэдүүлэг гаргагч нь өөрийн болон хамаарал бүхий этгээдийн нэр дээр оффшор бүсэд банкны данс нээлгэсэн, мөнгөн хөрөнгө байршуулсан, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчилсөн, хувь нийлүүлэх замаар хуулийн этгээд үүсгэн байгуулсан тохиолдолд 3 сарын дотор нээлгэсэн банкны дансаа хаалгах, банкинд байршуулсан мөнгөн хөрөнгөө татах, хөдлөх, үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийг худалдах, шилжүүлэх, татах, хувь нийлүүлэх замаар хуулийн этгээд үүсгэн байгуулсан бол үйл ажиллагаагаа зогсоох, эзэмших, ашиглах,

захиран зарцуулах эрхээ худалдах, шилжүүлэх, дуусгавар болгох арга хэмжээг авч, хөрөнгө, орлогын мэдүүлэгт орсон нэмэлт өөрчлөлтийн талаар 30 хоногийн дотор АТГ-т мэдүүлэх үүрэгтэй.

Мөн хуулийн 10<sup>1</sup> дүгээр зүйлийн 10<sup>1.5</sup>-д зааснаар мэдүүлэг гаргагч, түүний хамаарал бүхий этгээд нь оффшор бүсэд хамаарах гадаад улс, түүний нутаг дэвсгэрт суралцах, хөдөлмөр эрхлэх, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах, хуулиар хүлээсэн албаны чиг үүргээ хэрэгжүүлэх хугацаанд тухайн улсын банканд данс нээлгэх, мөнгөн хөрөнгө байршуулах, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөх, хувь нийлүүлэх замаар хуулийн этгээд үүсгэн байгуулах тохиолдолд дээрх оффшорт холбогдох хориглолт нь хамаарахгүй бөгөөд харин албаны чиг үүргээ хэрэгжүүлэхээс бусад тохиолдолд гадаад улс, түүний нутаг дэвсгэрт суралцах, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах зорилгоор тухайн улсын банкинд данс нээлгэсэн, мөнгөн хөрөнгө байршуулсан, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчилсөн бол АТГ-т бичгээр мэдэгдэж бүртгүүлэх үүрэгтэй.

Төрийн албаны тухай (шинэчилсэн найруулга) хуулийг баталж, иргэнийг төрийн албанд сонгон шалгаруулж томилох, чөлөөлөх, ажлын гүйцэтгэлийг нь үнэлэх, дэвшүүлэх, шагнаж урамшуулах асуудлыг шийдвэрлэхдээ хувь хүний мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага, ажлын үр дүнд тулгуурлах талаар тусгасан ба төрийн жинхэнэ албан тушаалд иргэнийг томилохдоо гагцхүү чадахуйн зарчмыг баримтлахаар тусгасан. Түүнчлэн хуулийн 50 дугаар зүйлд төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, хяналт тавих, 75 дугаар зүйлд төрийн жинхэнэ албан хаагч болон төрийн албанд нэр дэвшигчийн эрх зөрчигдсөн тухай маргааныг хянан шийдвэрлэх, 76 дугаар зүйлд хууль бус шийдвэрийг хүчингүй болгох зэрэг албан тушаалтныг хариуцлагажуулахад чиглэсэн олон зохицуулалтууд тусгагдсан ба төрийн албаны шинэтгэлийн хүрээнд албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуур, шатлан дэвшүүлэх журам, Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм, Төрийн албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам, Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн

төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журмыг батлан мөрдүүлжээ

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль (шинэчилсэн найруулга)-ыг 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдөр баталсан ба уг хууль 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжих юм. Тус хуульд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд баримтлах зарчмын нэг нь “төрийн байгууллага, албан тушаалтан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд хуульд заасны дагуу оролцох үүрэгтэй бөгөөд төрийн захиргааны болон хууль сахиулах байгууллага үйл ажиллагаандаа гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг тэргүүлэх чиглэл болгох”-оор тусгасан. Мөн төрийн байгууллагын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийн хөндлөнгийн хяналтын тогтолцоог бий болгохоор тусгасан нь тодорхой төрлийн гэмт хэргийн нэг болох авлигын гэмт хэрэгтэй тэмцэхэд чухал ач холбогдолтой юм. Хуульд зааснаар Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журмыг Засгийн газраас батлах юм.

Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг АТГ хүлээн авч, нэр дэвшигчид үнэмлэх олгосон өдрөөс эхлэн өөрийн байгууллагын цахим хуудаст байршуулах, төрийн аудитын дээд байгууллагаас сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг батлахдаа түүнийг тогтоосон үндэслэл, аргачлалыг урьдчилан баталж, нийтэд мэдээлэх, бэлэн мөнгөөр хандив өгөх, авахыг хориглох, мөнгөн бус хандивын үнэлгээг зах зээлийн дундаж ханшийг үндэслэн хандивын гэрээгээр харилцан тогтоох бөгөөд уг үнэлгээ нь иргэн болон хуулийн этгээдээс өгөх хандивын дээд хэмжээнээс хэтрэхгүй байх, хандив өгч байгаа иргэн, хуулийн этгээд нь нэр, регистрийн дугаараа банкны гүйлгээний баримтад тусгаж, Төрийн аудитын дээд байгууллагаас баталсан хандивлагчийн мэдүүлгийн баримтыг мэдүүлэх бөгөөд энэ шаардлагыг хангаагүй хандивыг хандив хүлээн авагч буцаан шилжүүлэх, хуулийн этгээд мөнгөн хандив өгсөн бол уг хандивыг санхүү, татварын тайланд тусгах зэрэг сонгуулийн зардлын хяналт, хариуцлагыг сайжруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн,

сонгуулийн тухай хуулиудад өмнө нь байгаагүй, шинэлэг зохицуулалтууд тусгагдсан болно.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиуд батлагдсантай холбоотойгоор Авлигын эсрэг хуульд холбогдох өөрчлөлтүүд орсон болно. Тухайлбал, Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Монгол Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг 2 дугаар улиралд багтаан цахим мэдээллийн сүлжээнд байрлуулах, тэдгээрийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газар бүртгэж, хадгалах эрх зүйн зохицуулалттай болсон.

Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонрхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр судалгаа хийж, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн саналыг хууль санаачлагчдад уламжлаад байна. Төсөлд “үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн” гэх одоогийн хуульд байгаа тайлбарыг өөрчлөн тайлбарлах, хөөн хэлэлцэн хугацааг өөрчлөн тогтоох, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгахтай холбоотой журмыг батлах эрх олгох, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, хууль зөрчсөн албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагыг оновчтой болгох, зэрэг зохицуулалтыг боловсронгуй болгохоор тусгалаа.

Авлигатай тэмцэх газраас Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг хамгаалах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг боловсруулан хууль санаачлагчид хүргүүлээ. Хуулийн төсөлд нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг дэмжих чиглэлээр Авлигатай тэмцэх газар болон бусад байгууллагын хүлээх үүрэг, хэрэгжүүлэх ажиллагааг тодорхойлж, нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээж иргэний эр зориг гарган хариуцлага үүрч, эрх мэдэлтэн, албан тушаалтан, төрийн байгууллагын үйл ажиллагаанд гарч буй зүй бус үйлдэлд нийгмийн анхаарлыг чиглүүлж шударга ёсыг тогтоохын төлөө хувийн эрх ашгаас нийтийн эрх ашгийг өндөрт тавьж байгаа шүгэл үлээгч/илчлэгч/-ийн нийгэмд гүйцэтгэх үүргийг нийтэд зөв ойлгуулах, хүлээн зөвшөөрөх нөхцөл бүрдүүлэх, дэмжих, хамгаалах асуудлыг



шийдвэрлэх үндэслэл, журмыг тусгасан болно. Уг хуулийн төсөлтэй хамт дагалдан гарах Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тус тус боловсруулсан болно.

Сонгуулийн үйл ажиллагааг нэгдсэн нэг хуулиар зохицуулах үзэл баримтлал өөрчлөгдөж, сонгуулийн төрлөөр нь тус тусад зохицуулахаар шийдвэрлэсэн. Энэ хүрээнд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр тус тус батлагдсан. Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төсөл боловсруулах шатанд байна. (Биелэлт 70 хувь)

4.1.5.7-3. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн мэдээллийн санг бий болгож, хөгжүүлэх /АТГ, 2017-2022/

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн мэдээллийн санг бий болгох, хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг цахим хэлбэрээр хүлээн авах, тайлагналтыг явцын дунд хянах, хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр “Ухаалаг Засаглал” ТББ-тай хамтран ажлаж байна. Одоогийн байдлаар цахим системд мэдээллийн санг үүсгэн, Авлигатай тэмцэх газар болон хэрэгжүүлэгч байгууллагын хэмжээнд туршилтын журмаар ажиллуулж байгаа бөгөөд туршилт дуусмагц хэрэглээнд бүрэн нэвтрүүлж хэрэгжүүлэгч байгууллага нэг бүрийг холбон үйл ажиллагааг жигдрүүлнэ. khutulbur.iaac.mn дээр байршуулан эрх бүхий албан тушаалтнуудын мэдээллийг бүрэн оруулсан бөгөөд АТҮХ-ийн хэрэгжилтийн тайлан цахим хэлбэрээр өгөхөд бэлэн болсон. (Биелэлт 70 хувь)

4.1.5.8-1. Гэмт хэргийг илрүүлэхэд ашиглаж байгаа шинжлэх ухаан, технологийн дэвшилтэт аргыг ашиглах талаар сургалт явуулах /АТГ, 2017-2022/

Гэмт хэргийг илрүүлэхэд ашиглаж байгаа шинжлэх ухаан, технологийн дэвшилтэт аргыг ашиглах талаар Олон улсын “StAR” санаачилгын Санхүүгийн гэмт хэрэг, мөрдөн шалгах ажиллагааны дунд шатны сургалтад

2019 оны 04 дүгээр сард 4 өдрийн сургалтад 5 мөрдөгчийг, Хонконгийн Авлигатай тэмцэх хороотой хамтын ажиллагааны хүрээнд олон улсын авлигын гэмт хэрэг мөрдөн шалгах 10 хоногийн модуль сургалтад 4 мөрдөгчийг, АНУ-ын Холбооны мөрдөх товчооноос зохион байгуулсан сургалтад 2 мөрдөгчийг, «Авлигын хэргийн ашиг хүртэгч эзнийг олж тогтоох нь” сэдэвт олон улсын сургалтад 6 албан хаагчийг тус тус хамруулсан. (Биелэлт 70 хувь)

4.1.5.9-1. Авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийн шийдвэрийг мэдээлэх нэгдсэн санг бий болгох /АТГ, ХЗДХЯ 2018-2019/

Шүүх, хууль сахиулах байгууллагуудын нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлж, гэмт хэргийн тоо мэдээнээс холбогдох статистик мэдээллийг боловсруулах ажлыг 2018 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс эхлүүлсэн. Нэгдсэн мэдээллийн сан дээр үндэслэсэн олон нийтэд зориулсан “e-justice.mn” портал, веб сайтыг 2018 оны 6 сарын 15-ны өдөр албан ёсоор нээж, туршилтын журмаар ажиллуулж байна. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/134 дүгээр тушаалын дагуу Шүүх, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудын мэдээллийн нэгдсэн сангийн үйл ажиллагааг Прокурорын байгууллага хариуцан ажиллаж байна. Мэдээллийн нэгдсэн санд иргэний портал үүсгэх, олон нийтэд нээлттэй байлгах талаар хамтран ажиллах байгууллагуудтай хэлэлцэж байна.

Мөрдөн шалгах ажиллагаа болон прокурор, шүүхийн байгууллагуудын дунд “гэмт хэргийн цахим сан”-тай болсон бөгөөд энэхүү цахим мэдээллийн нэгдсэн санг боловсронгуй болгох ажил тогтмол хийгдэж байна.

Улсын Ерөнхий Прокурорын Газраас авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийн шийдвэрлэлтийн байдлыг улирал бүр судлан, холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна. Авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийн шийдвэрлэлтийн талаарх мэдээлэл нэгдсэн санд бүрэн бүртгэгдэж, бүртгэсэн мэдээллийг хайлтаар шүүж үзэх боломжтой болсон.

Шүүх, хууль сахиулах байгууллагуудын нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлж, гэмт хэргийн тоо мэдээнээс холбогдох статистик мэдээллийг боловсруулах ажлыг 2018 онд эхлүүлсэн. Нэгдсэн мэдээллийн сан дээр үндэслэсэн

олон нийтэд зориулсан “e-justice.mn” портал, веб сайтыг 2018 оны 6 сарын 15-ны өдөр албан ёсоор нээж, туршилтын журмаар ажиллуулж байна. АТГ өргөдөл, гомдол болон хэрэг бүртгэлд, мөрдөн байцаалтын хэргийн бүртгэлийг системийг шинэчлэн боловсруулж, нэвтрүүлэн алба хаагчдад сургалт зохион байгуулав. (Биелэлт 70 хувь)

4.1.5.9-2. Мэдээллийн санд олон нийттэй харилцах цэс үүсгэж, хамрах хүрээ, үр нөлөөг нэмэгдүүлэх /АТГ, 2017-2020/

АТГ ирсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн шийдвэрлэлт, мөрдөн байцаалт явуулсан эрүүгийн хэргийн тоон үзүүлэлтийг тус газрын цахим хуудсаар олон нийтэд тогтмол мэдээлж байна. Хэрэг бүртгэх, Мөрдөн байцаах албанд шалгагдаж байгаа авлига, мансууруулах бодистой холбоотой хэргүүдийн шалгалтын явц, шийдвэрлэлтийн мэдээг улирал бүрээр харьяа прокурорын газруудаас авч судлах, шалгах, мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллах талаар Улсын Ерөнхий прокурорын газрын үйл ажиллагааны 2018 оны төлөвлөгөөнд тусгаж, авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийн нэгдсэн мэдээллийн сантай болох ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулсан.

Прокурорын байгууллагын хариуцан ажиллаж байгаа шүүх, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудын мэдээллийн нэгдсэн санд иргэний портал үүсгэх, олон нийтэд нээлттэй байлгах боломжийн талаар хамтран ажиллах байгууллагуудтай яриа хэлэлцээр хийсэн бөгөөд энэ ажил 2019 оны 12 дугаар сард судалгааны ажил бүрэн хийгдэж дууссан. (Биелэлт 30 хувь)

4.1.5.10-1. Авлига, албан тушаалын гэмт хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг олон нийтэд хүргэх арга хэлбэрийг сайжруулах /ШЕЗ, 2017-2022/

Монгол Улсын шүүхийн цахим сан буюу www.shuukh.mn сайтад төрийн болон албаны, байгууллага, хувь хүний нууцад хамаарахаас бусад анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхийн шийдвэр, магадлал, тогтоолыг бүрэн эхээр байршуулан, иргэд, олон нийтэд мэдээлдэг. Уг цахим хуудаст одоогоор эрүү, иргэн, захиргааны 243586 хэргийн 333469 шийдвэр хадгалагдаж байна. 2013-2019 оны

байдлаар Монгол Улсын шүүхийн цахим санд ойролцоогоор 31.920.000 удаагийн хандалт хийсэн байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн Гүйцэтгэх нарийн бичгийн даргын 2017 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн А/44 дугаар тушаалаар “Шүүхийн шийдвэрийг цахим санд байршуулах журам”-ыг баталж, журмаар иргэн, хуулийн этгээд интернэтийн сүлжээ ашиглан цахим сангаас шүүхийн шийдвэрийн мэдээлэл болон тогтоох хэсгийг үзэх, бүрэн эхээр нь татаж авах харилцааг зохицуулсан байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс “Шүүн таслах ажлын дүн мэдээ”-г хагас, бүтэн жилээр нэгтгэн боловсруулж, жилд 2 удаа олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд нээлттэй мэдээлж байна.

“Авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийг шийдвэрлэсэн мэдээллийн нэгдсэн сан” бүрдүүлэх хүрээнд Шүүхийн ерөнхий зөвлөл авлига, албан тушаалын гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэсэн тоон мэдээллийг цаг тухайд нь хүргэж хамтран ажиллах боломжтой.

Авлигын гэмт хэрэг, зөрчлийг олж илрүүлсэн, мөрдөн шалгасан, хянан шийдвэрлэсэн байдалд дүн шинжилгээ хийж, мэдээллийн сан үүсгэн, дотоод сургалтад ашиглаж байна. Авлига, хээл хахуулийн гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэсэн мэдээг улирал бүр бүх шүүхүүдээс хүлээн авч нэгтгэн мэдээллийн санд нэгтгэж байна. Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга мөрдөгдөж эхэлсэнтэй холбоотойгоор тус мэдээний маягтын үзүүлэлтийг шинэ хуулийн агуулга, үзэл баримтлалд нийцүүлэн шинэчлэн боловсруулж үйл ажиллагаандаа хэрэглэж байгаа нь авлигын хэргийн статистикийг улам нарийн гаргах нөхцөлийг бүрдүүлсэн. Бусад байгууллага, судлаачдын сургалт, судалгаанд ашиглах хүсэлтээр хувь хүн, байгууллагын нууцыг хадгалах зарчмын баримтлан авлигатай холбоотой шүүн таслах ажиллагааны мэдээг сонирхсон этгээдэд өгч байна. (Биелэлт 30 хувь)

4.1.5.10-2. Авлига, албан тушаалын гэмт хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу олон нийтэд мэдээлэх ажиллагаанд дүн шинжилгээ хийх /ШЕЗ, УЕПГ, 2017-2019/



Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2015 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 77 дугаар тогтоолоор батлагдсан “Хэвлэл мэдээллийн хэрэгслээр шүүх хуралдааныг мэдээлэх журам”, байгууллагуудын цахим хуудас / [www.shuukh.mn](http://www.shuukh.mn), [www.judcouncil.mn](http://www.judcouncil.mn)/-аар шүүхийн шийдвэрийг олон нийтэд мэдээлж байна. Авлига, албан тушаалын гэмт хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт Шүүхийн ерөнхий зөвлөлөөс томилогдсон, Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх чиг үүрэг бүхий зөвлөл 2018 онд авлига, албан тушаалын гэмт хэргийг шийдвэрлэсэн прокурорын шийдвэр, үйл ажиллагааг олон нийтэд мэдээлсэн байдал дүн шинжилгээ хийсэн.

талаар зөвхөн тус газар мэдээ, мэдээлэл хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгсөн байна

Улсын Ерөнхий прокурорын 2017 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн А/107 дугаартай тушаалаар “Прокурорын байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд мэдээлэх журам”-ийг баталж, олны анхаарал татсан, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэгдсэн хэргийн шийдвэрлэлтийн талаарх мэдээ, мэдээллийг хуулиар зөвшөөрөгдсөн хэмжээ, хүрээнд олон нийтэд мэдээлэх боломжийг бүрдүүлсэн.

Улсын Ерөнхий прокурорын 2019 оны 04

**2019 оны байдлаар авлигын хэргийг шийдвэрлэсэн байдлыг хүснэгтээс харж болно.**

**Хянан шийдвэрлэсэн авлигын гэмт хэргийн 48.9 хувийг хажууль авах гэмт хэрэг эзэлж байна**



Авлигын гэмт хэрэг, зөрчлийг олж илрүүлсэн, мөрдөн шалгасан, хянан шийдвэрлэсэн байдал дүн шинжилгээ хийж, мэдээллийн сан үүсгэн, дотоод сургалтад ашиглаж байна.

Улсын Ерөнхий Прокурорын Газрын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсээс авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийн шийдвэрлэлтийн байдлыг улирал бүр судлан, холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн Хэвлэл мэдээллийн хэлтсээс 2017-2019 онд авлига, албан тушаалын гэмт хэргийн шийдвэрлэсэн нийт 90 гаруй хэргээс олны анхаарал татсан, сэтгүүлчдээс хүсэлт тавьсны дагуу тодруулга, ярилцлага, шүүх хуралдааныг сурвалжилсан давхардсан тоогоор 180 гаруй удаа, нийслэл болон орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд хэргийн шийдвэрлэлт, үйл явц, гэмт

хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 552 мэдээ, мэдээлэл өгсөн байна. Үүнээс сонин, сэтгүүлд 105, телевизээр 180, радиогоор 25, веб сайтаар 230, бусад мэдээллийн хэрэгслээр 12 мэдээ, мэдээлэл /давхардсан тоогоор/ нийтлэгджээ.

2018 онд аймаг, нийслэл, тээвэр, дүүрэг, сум дундын прокурорын газрууд хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл болон шалгаж буй эрүүгийн хэргийн явц байдал, шийдвэрлэлт, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, прокурорын байгууллагын үйл ажиллагааг сурталчлах чиглэлээр 752 мэдээ, мэдээлэл өгсөн байна. Нийслэлийн прокурорын газар 22 удаа хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд мэдээ өгч, ялангуяа авлига, албан тушаалын гэмт хэрэгт хяналт тавьдаг тус прокурорын газрын ажлын онцлогтой холбоотойгоор энэ төрлийн хэргийн

дүгээр сарын 25-ны өдрийн А/28 дугаар тушаалаар Улсын ерөнхий прокурорын газрын бүтцэд өөрчлөлт орж “Олон нийттэй харилцах алба”-ыг шинээр байгуулан ажиллаж байна. Олон нийттэй харилцах албанаас олны анхаарал татсан, хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр нийтэд мэдээлэгдсэн хэргийн шалгалтын явц байдал, цаг үеийн шинжтэй үйл явдал, тодорхой гэмт хэрэг, зөрчлийн шийдвэрлэлтийн талаар хэвлэлийн хурал зохион байгуулах, мэдээлэл өгөх ажлыг Нийслэлийн прокурорын газартай хамтран нийт 5 удаа зохион байгуулсан.

Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдээс ирүүлсэн мэдээлэл авах тухай саналыг үндэслэн цаг үеийн асуудлаар тодруулга мэдээллийг тогтмол өгч ажиллаж байгаа бөгөөд давхардсан тоогоор нийт 50 гаруй удаа тодруулга, залруулга өгч, 11 ярилцлага,

нийтлэлийг prokuror.mn сайт болон бусад өдөр тутмын сонин, сайтуудад нийтлүүлсэн. Мөн Монголын үндэсний олон нийтийн телевизээр сар бүр “Прокурорын мэдээлэл” 20 минутын нэвтрүүлгийн 12 удаагийн дугаарыг бэлтгэн цацав. prokuror.mn сайтад нийт 711 мэдээ, мэдээллийг байршуулж олон нийтэд хүргэсэн. 2019 онд Прокурорын байгууллага гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон прокурорын хяналтын ажлын талаар сонин, сэтгүүлд 90, радио, телевизэд 233, веб сайтад 602 мэдээ, мэдээлэл, ярилцлага өгч нийтлүүлжээ

Хэвлэл мэдээллийн байгууллагын 20 сэтгүүлчийг хамруулан «Прокурор-Сэтгүүлч 2019» сургалтыг Улсын Ерөнхий прокурорын газарт анх удаа зохион байгуулсан. (Биелэлт 30 хувь)

### Шүүхийн ерөнхий зөвлөл 2019 онд

Асуулгын дугаар	Асуулт	2017 /хуучин хууль/		2017 /шинэ хууль/		2018 /хуучин хууль/		2018 /шинэ хууль/		2019 он	
		хэрэг	хүн	хэрэг	хүн	хэрэг	хүн	хэрэг	хүн	хэрэг	хүн
4	Шүүхийн цагаатгах тогтоолын тоон мэдээ	40	97	40	63	6	17	55	94	56	105
15	Авлигын гэмт хэрэгт гэм буруутай нь тогтоогдсон шүүгчдийн тоо	0	0	0	0	0	0	0	0	0	0
21	Мөнгө угаах гэмт хэрэг шийдвэрлэсэн тоо	-	-	1	1	-	-	4	14 <sup>1</sup>	1	36


4.1.5.11-1. Авлигын гэмт хэрэг, зөрчлийг олж илрүүлсэн, мөрдөн шалгасан, хянан шийдвэрлэсэн байдалд дүн шинжилгээ хийж, мэдээллийн санг үүсгэн, сургалтад ашиглах /АТГ, ШЕЗ, УЕПГ, 2017-2022/

Авлигын гэмт хэргийг шүүхэд шийдвэрлэсэн байдал: Монгол Улсын хэмжээнд 2017-2019

онд Эрүүгийн хууль /2002 он/-ийн Хорин наймдугаар бүлэг Албан тушаалын гэмт хэрэг, Эрүүгийн хууль /2015 он/-ийн шинэчилсэн найруулгын Хорин хоёр дугаар бүлэг-Авлигын гэмт хэрэгт 606 хүнд холбогдох 204 хэргийг хүлээн авснаас 93 гэмт хэрэгт холбогдсон 200 хүнд ял шийтгэл оногдуулж, эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн байна.



**График 1. Хянан шийдвэрлэлтийг өмнөх онуудтай харьцуулсан байда**



2018 онд гэмт хэрэг 55.6 хувиар өссөн ч ял шийтгүүлэгчид 20.8 хувиар буурсан дүнтэй гарсан бол 2019 онд гэмт хэрэг 67.8 хувиар, ял шийтгүүлэгчид 2.5 дахин тус тус өссөн байна.

**Хүснэгт 2. Ял шийтгүүлэгчид зарим бүлгээр**

№	Утга				Өсөлт, бууралт	Хувь
		2017 он	2018 он	2019 он		
1	2	3	4	5	6	7
1	Урьд ял шийтгүүлсэн	2	0	3	3	-
2	Бүлэглэж үйлдсэн	7	2	2	-5	-
3	Эмэгтэй	15	0	24	-15	-

Оногдуулсан ял, хариуцлагын төрөл: Авлигын гэмт хэрэгт оногдуулсан ял шийтгэлийн төрлөөр нь нарийвчлан авч үзвэл 2017 онд 92.5 хувьд нь хорих ял оногдуулж шийдвэрлэж байсан бол 2018 онд 7.1 хувьд, 2019 онд 14.2 хувьд нь хорих ял оногдуулж шийдвэрлэжээ. 2019 онд ял шийтгүүлэгчдийн 66.7 хувьд нь торгох ял оногдуулж шийдвэрлэсэн байна.


**Хүснэгт 1.2 Оногдуулсан ял, хариуцлагын төрөл**

№	Ялын төрөл	Өсөлт, бууралт				
		2017 он	2018 он	2019 он	Тоо	Хувь
1	2	3	4	5	6	7
1	Торгох	4	27	70	43	2.6 дахин
3	Баривчлах	0	0		0	
5	Нийтэд тустай ажил хийлгэх	0			0	
7	Хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх	0	10	20	10	2.0 дахин
8	Эрүүгийн хариуцлагаас чөлөөлсөн	0	1		-1	
4	Хорих	49	3	15	12	5.0 дахин

Ял шийтгүүлэгчдийн насны бүлэг: Ял шийтгүүлэгчдийг 2017-2019 оны бүтэн жилийн байдлаар насны бүлгээр авч үзвэл 18-29 насны ял шийтгүүлэгчдийн тоо 7.1 хувийг, 30-34 насны ял шийтгүүлэгчдийн тоо 17.1 хувийг, 35-аас дээш насны ял шийтгүүлэгчдийн тоо 75.9 хувийг тус тус эзэлж байна.



**График 3. Ял шийтгүүлэгчдийн насны бүлэг**



Авлигатай тэмцэх газраас авлигын хэрэгт мөрдөн байцаалт явуулсан 2017 онд 58, 2018 онд 118, 2019 онд 167 хэрэгт прокурор хяналт тавин 216 хэргийг шүүхэд шилжүүлсэн байна. Авлига, албан тушаалын гэмт хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт Шүүхийн ерөнхий зөвлөлөөс томилогдсон, шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх чиг үүрэг бүхий зөвлөл дүн шинжилгээ хийн ажиллаж байна.

Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн нь авлигын гэмт хэрэг хянан шийдвэрлэсэн хэргийн статистикийн тоон мэдээллийг нэгтгэхээс гадна шүүх тус бүрээс авлига, хээл хахуулийн гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэсэн дэлгэрэнгүй мэдээллийг нэгтгэн, холбогдох дүн шинжилгээг хийж, төрийн байгууллага, иргэдийг мэдээллээр ханган ажилладаг. Эдгээр дэлгэрэнгүй тайлангууд нь мэдээллийн сан байдлаар архивт үлддэг.

Шүүхээс авлига, хээл хахуулийн хэргийг хянан шийдвэрлэсэн талаарх тоон болон бусад мэдээллийг шүүгчийн сургалтад ашиглаж байна. Тухайлбал, 2019 онд зохион байгуулсан эрүүгийн хэргийн шүүхийн шүүгчид зориулсан хууль хэрэглээний сургалтад “Албан тушаалын гэмт хэргүүдийн шинж, шалган тогтоох онцлог, анхаарах зарим асуудал” сэдвийг оруулан, сургалтын агуулгад дээрх тоон болон бусад мэдээлэл дүн шинжилгээ хийж уялдуулан тусгасан.-

Улсын Ерөнхий прокурорын газрын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтэс нь авлига, албан тушаалын гэмт хэргийн шийдвэрлэлтийн мэдээг улирал бүр улсын хэмжээнд нэгтгэн дүгнэж, зарим хэргүүдийг татаж хянан, авлига, албан

тушаалын хэрэгт хяналт тавьж байгаа байдлыг жил бүр судалж байгаа ба харьяа прокурорын газрууд шүүхийн шийдвэрлэсэн байдалд дүн шинжилгээ хийж сан үүсгэн сургалтууддаа ашиглаж байна.

Улсын ерөнхий прокурорын газраас авлигын гэмт, хэрэг зөрчлийг олж илрүүлсэн, мөрдөн шалгасан, хянан шийдвэрлэсэн байдалд Гэмт хэрэг зөрчлийн бүртгэл дүн шинжилгээний төвөөс хийсэн дүн шинжилгээ, мэдээллийн санг ашиглан сургалтын хэрэглэгдэхүүний сан бүрдүүлэх ажлыг хийж байна. Уг ажлын хүрээнд УЕПГ-ын дэргэдэх Сургалт судалгааны төв нь “е-прокурор” прокурорын цахим сургалтын программ хангамжийг Гэмт хэрэг, зөрчлийн бүртгэл, дүн шинжилгээний төвтэй хамтран боловсруулж, серверт холбогдох сургалтын материал, Төвийн судлаач багш, хяналтын прокуроруудын тус сэдвийн талаар бичсэн эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл, илтгэлийг байрлуулах ажлыг гүйцэтгэсэн болно.

2019 онд авлига, албан тушаалын гэмт хэргийн хэрэг бүртгэлтийг хаасан шийдвэрийн хууль зүйн үндэслэлийг 2017-2019 оны 1 дүгээр улирлын байдлаар шалгаж, авлига, албан тушаалын 322 хэргийг хянаад, илэрсэн зөрчлийг арилгах, цаашид энэ төрлийн гэмт хэргийг хянаж шийдвэрлэхэд анхаарах асуудлын талаар мэдээлэл бичиж, харьяа прокурорын газруудад хүргүүлсэн.



Асуулгын дугаар	Асуулт	2017		2018		2019	
		хэрэг	хүн	хэрэг	хүн	Хэрэг	Хүн
21	Авлигын гэмт хэрэг шийдвэрлэсэн тоо	34	102	35	74	47	85
22	Авлигын гэмт хэргийг цагаатгасан тоон мэдээ	-	16	-	9	3	8

Авлигын гэмт хэргийг цагаатгасан тоон мэдээнд хуульд заасны дагуу цагаатгасан болон гэмт хэрэг нотлогдохгүй байх, гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй зэрэг үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгосон мөн Өршөөлийн хуулийн дагуу ялыг өршөөн хэлтрүүлсэн зэрэг байдлаар ял шийтгэл оногдуулаагүй хүний тоог нийтэд нь хамааруулсан болно.

Асуулгын дугаар	Асуулт	2017 он				2018 он				2019			
		ЭБАТ-ын 6 шийдвэрийг хянаснаас				ЭБАТ-ын 32 шийдвэрийг хянаснаас				ЭБАТ 2 шийдвэрийг хянасанаас			
		Хэвээр	Өөрчлөлт оруулсан	Хүчингүй болгосон	Шийтгэлээс чөлөөлсөн	Хэвээр	Өөрчлөлт оруулсан	Хүчингүй болгосон	Шийтгэлээс чөлөөлсөн	Хэвээр	Өөрчлөлт оруулсан	Хүчингүй болгосон	Шийтгэлээс чөлөөлсөн
20	Зөрчлийн тухай хуулийн 6.21-р зүйл буюу гүтгэх зөрчлийг шийдвэрлэсэн статистик	4	-	-	2	19	-	13	-	19	7	18	-

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу 6.21 дүгээр зүйлд заасан “Гүтгэх” зөрчлийг Эрх бүхий албан тушаалтан шалган шийдвэрлэх ба тухайн албан тушаалтны оногдуулсан шийдвэрийг үндэслэлгүй гэж ирүүлсэн гомдол, хүсэлтийн дагуу тухайн шийдвэр үндэслэлтэй эсэхийг шүүх хянан шийдвэрлэдэг. Сүүлийн 2 жилийн дунджаас харахад эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан шийдвэрийг үндэслэлгүй гэж үзэн шүүхээс хүчингүй болгосон хувь хэмжээ 40.1 хувьтай байна. (Биелэлт 30 хувь)

4.1.5.11-2. Олон улсын байгууллага, гадаад орноос багш, мэргэжилтэн урьж сургалт зохион байгуулах /АТГ, 2017-2019/

2017 онд зохион байгуулсан Азийн хөгжлийн банкны Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх сургалтад АТГ, Улсын Ерөнхий прокурорын газар, Цагдаагийн ерөнхий газар, Монголбанкны албан хаагчид хамрагдсан. АТГ, Дэлхийн банк болон НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны хамтарсан “Хулгайлагдсан хөрөнгийг

буцаан олгох Старсанаачилга” (“StAR”) -тай хамтран хэрэгжүүлж буй шинэ төслийн хүрээнд хөрөнгө, орлогын мэдүүлгийн хяналт шалгалтын тогтолцоог бэхжүүлэхэд чиглэсэн 2 өдрийн сургалтыг 2017 оны 4-р сард зохион байгуулж, 60 орчим албан хаагч хамрагдсан. “StAR” санаачилгын ахлах мэргэжилтэн, Румын Улсын Шударга ёсны газрын хянан шалгагч нар сургалтыг хамтран зохион байгуулж, Румын Улсын Шударга ёсны газрын үйл ажиллагаанаас танилцуулж, кэйс дээр ажиллуулан, Монгол Улс дахь хөрөнгө, орлогын мэдүүлгийн тогтолцоонд тулгарч буй саад бэрхшээл, түүнийг шийдвэрлэх арга замын талаар харилцан ярилцсан үр дүнтэй сургалт болсон.

2017 онд Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагатай хамтран “Авлигын эсрэг төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх нь” сэдвээр сургалт; “Олон улсын болон үндэсний хэмжээнд авлига, мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх нь” сургалт; 2018 оны 6 дугаар сард зохион байгуулсан “Оффшор бүс нутгийг ашиглан мөнгө угаах, түүнтэй тэмцэх олон улсын туршлага”

сэдэвт сургалтыг тус зохион байгуулж, хууль сахиулах байгууллагуудын албан хаагчдыг оролцуулав. Дээрх сургалтад Интерполын Авлигын эсрэг сүлжээний болон Их Британийн Онц залилангийн гэмт хэрэгтэй тэмцэх албаны ахлах мөрдөгч зэрэг мэргэжилтнүүд урилгаар оролцож, өөрсдийн орны авлигатай тэмцэх туршлагаас хуваалцсан. Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдсан “Оффшор бүсэд байршсан мөнгөн хөрөнгийг эргүүлэн татах боломжууд” сургалт хэлэлцүүлэг, “StAR” санаачилгаас зохион байгуулсан “Эрх зүйн туслалцаа үзүүлэх-хамтран ажиллах” чиглэлээр хийсэн 2 өдрийн хэлэлцүүлэг, 1 өдрийн сургалт, Тайваны хууль зүйн яамны шүүгч, прокурорын академийн багш нараас УЕПГ-т зохион байгуулсан Зохион байгуулалттай гэмт бүлэглэлээс үйлдэж байгаа гэмт хэрэг, хөрөнгө хураах ажиллагаа” сэдэвт сургалт, 2018 онд зохион байгуулсан “Хууль сахиулах ажилтнуудын хэлэлцүүлэг”, Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны анхан шатны сургалт”, холбогдох байгууллагуудын албан хаагчдыг хамруулж, бусад улс оронд энэ чиглэлээр явуулж буй мөрдөн шалгах ажиллагааны арга, тактикийн талаар суралцаж, харилцан мэдээлэл солилцов. 2019 онд “StAR” санаачилгаас зохион байгуулсан санхүүгийн гэмт хэрэг, мөрдөн шалгах ажиллагааны дунд шатны сургалтад 5 мөрдөгчийг, Хонконгийн Авлигатай тэмцэх хорооноос зохион байгуулсан олон улсын авлигын гэмт хэрэг мөрдөн шалгах 10 хоногийн сургалтад 4 мөрдөгчийг, АНУ-ын Холбооны мөрдөх товчооноос явуулсан сургалтад 2 мөрдөгчийг, «Авлигын хэргийн ашиг хүртэгч эзнийг олж тогтоох нь” сэдэвт олон улсын сургалтад 6 албан хаагчийг тус тус хамруулсан. (Биелэлт 70 хувь)

4.1.5.12-1. Сургуулиудын давтан сургалтын хөтөлбөрт авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийг шийдвэрлэх талаар тусгуулах /АТГ, ХЗДХЯ, 2017-2018/

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн А/131 дүгээр тушаалаар Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний болон онцгой байдлын байгууллагын тасгийн дарга буюу түүнтэй адилтгах албан тушаалтны нөөцөд авагдсан албан хаагчдад “Албан тушаалын дамжаа”-г хичээллүүлж байна. Энэхүү “Албан тушаалын дамжаа”-ны хөтөлбөрт

“Авлигатай тэмцэхэд төрийн албан хаагчийн үүрэг, хариуцлага” сэдэвт 4 цагийн сургалтыг оруулахаар хөтөлбөрийг шинэчлэн батлуулсан. “Албан тушаалын дамжаа”, Удирдах ажилтны давтан сургалтын хөтөлбөрт авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийг шийдвэрлэх талаар сургалтыг оруулж хэвшсэн.

Дотоод хэргийн их сургуулийн бакалаврын сургалтад “Авлига, албан тушаалын гэмт хэрэг”, “Албан тушаалын гэмт хэргийн криминологи шинж”, “Албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх арга зүй”, “Албан тушаалын гэмт хэргийн нотолгооны онол, арга зүй” гэсэн бүлэг сэдвүүдийг сургалтын хөтөлбөрт тусган мөрдөж байна.

Их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын сайдын 2014 оны “Нийтлэг шаардлага батлах тухай” А/174 дүгээр тушаалаар батлагдсан ерөнхий суурь “Нийгмийн ухаан” хичээлийн чиглэлд “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сэдвийг тусгах” арга хэмжээг Монголын Их, дээд сургуулийн консерсиумын гишүүн сургуулиудын хэмжээнд тодорхой үе шаттайгаар хэрэгжүүлэхээр холбогдох төлөвлөгөөний дагуу ажиллаж байна.

Энэ хүрээнд их, дээд сургуулиудын 2017-2019 онуудын сургалтын хөтөлбөр, хичээлийн агуулгад “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх” сэдэв тусгагдсан эсэхэд судалгаа, дүн шинжилгээ хийхэд их, дээд сургуулиуд /10 их, дээд сургууль/ тус бүрт харилцан адилгүй өөр өөрөөр тусгаж оюутан, суралцагчдыг хамруулсан байна. Тухайлбал, зарим их, дээд сургуулиудын “Эрүүгийн эрх зүй” хичээлийн агуулгад хээл хахууль ба авлигын тухай ерөнхий ойлголт, гэмт хэргийн төрөл, хүлээлгэх ял шийтгэл, авлигын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлийн талаарх хичээл заавал судлах сэдэвт хамаарч тусгагдсан байна.

Харин их, дээд сургуулиудын ерөнхий эрдмийн болон мэргэжлийн сургалтын “Ёс суртахууны үндсэн ойлголт”, “Хүний хөгжил-харилцааны ёс зүй”, “Эрх зүй, социологи”, “Мэргэжлийн ёс зүй” “Бизнесийн удирдлага, менежмент” гэсэн хичээлийн агуулгад шударга бус, бусдыг хуурах, худал хэлэх, биеийн амрыг харах, ажил албан тушаалаа ашиг хонжоо олох



хэрэгсэл болгох, авлига, хээл хахууль авах, өгөх, бага хийж их авахыг эрмэлзэх, бусдын амжилтыг үгүйсгэх дутагдлаа өмөөрөх гэх мэт агуулгатайгаар тусгаж хэрэгжүүлсэн байна.

Тусарга хэмжээний дагуу Их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөр, хичээлийн агуулгуудад хийгдсэн дүн, шинжилгээ, судалгааны үр дүнг үндэслэн эрх зүйч бэлтгэдэг их, дээд сургуулиуд, бусад мэргэжлээр боловсрол эзэмшүүлдэг бүх их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөр, хичээлийн агуулгад “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сэдвийг тусгах” арга хэмжээг үргэлжлүүлэн авч хэрэгжүүлнэ. (Биелэлт 30 хувь)

4.1.5.13. Хөрөнгө, орлогын болон хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, гаргах үүрэг бүхий албан тушаалтны хүрээг оновчтой тогтоож, мөрдөх

Төрийн албаны тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан Засгийн газрын 2019 оны 25 дугаар тогтоолоор төрийн үйлчилгээний зарим албан тушаалын ангилал, зэрэглэл өөрчлөгдсөн, Монгол Улсын Их Хурлын 2019 оны 19 дүгээр тогтоолоор төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийг шинэчлэн баталсан, мөн Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 275 дугаар тогтоолоор “Төрийн захиргааны албан тушаал”-ын ангилал, зэрэглэл, 276 дугаар тогтоолоор “Төрийн үйлчилгээ”-ний албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан Авлигын эсрэг хууль, УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 5, 20 дугаар тогтоол буюу ХАСХОМ гаргах албан тушаалтны хамрах хүрээнд хэрхэн өөрчлөлт орсон талаарх судалгааг хийсэн. Төрийн болон Нутгийн захиргааны нийт 109 байгууллагаас мэдүүлэг гаргагчдын хамрах хүрээнд өөрчлөлт оруулах эсэх, хэрэв оруулах бол үндэслэл шалтгааны талаарх санал хүсэлт, судалгааг авч нэгтгэн боловсруулсан.

Дээрх судалгааны дүн, бусад эрх зүйн баримт бичгийг үндэслэн Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 20 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах үндэслэл, хэрэгцээ шаардлага, “Мэдүүлэг гаргах зарим албан тушаалтны жагсаалт”-аар “ТЗ-1”-“ТЗ-5” ангилал болон Төрийн үйлчилгээний удирдах албан тушаалтны ангилал зэрэглэлд хэрхэн

өөрчлөлт орох хэрэгцээ шаардлагын талаарх танилцуулга, мэдээллийг нэгтгэж Авлигын эсрэг хууль тогтоомжид оруулах өөрчлөлтийг санал дүгнэлтийн хамт нэгтгэн боловсруулсан төдийгүй ХАСХОМ гаргасан мэдүүлэг гаргагчдын тоон үзүүлэлт нэмэгдэх хандлагатай байх тул төрийн үйлчилгээний болон төрийн тусгай албаны төсөв хөрөнгө захиран зарцуулах, ажилтныг томилох, чөлөөлөх, гэрээ байгуулах, хяналт шалгалт явуулах, тусгай зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, зөвшөөрөл олгох зэрэг чиг үүргийг хэрэгжүүлдэггүй зарим албан тушаалтныг ХАСХОМ гаргахгүй албан тушаалтны жагсаалтаас хасах талаарх судалгаа, тоон үзүүлэлтийг нэгтгэн боловсруулсан. (Биелэлт 70 хувь)

4.1.5.14. Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягтыг боловсронгуй болгож, мэдүүлгийг цахим хэлбэрээр хүлээн авах тогтолцоонд бүрэн шилжих.

Азийн сан, Авлигатай тэмцэх газрын дэргэдэх олон нийтийн зөвлөлтэй хамтран 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр “Албан тушаалтны хөрөнгө орлогод иргэдийн хяналтыг нэмэгдүүлэх, Хөрөнгө орлогын мэдүүлгийн маягтыг боловсронгуй болгох нь” сэдэвт нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт ЗГХЭГ, УИХ-ын Хууль зүйн байнгын хороо болон нийт 30 гаруй төрийн байгууллага түүнчлэн нийтийн эрх ашгийн төлөө үйл ажиллагаа явуулж буй иргэний нийгэм, ТББ-ын төлөөллийн нийт 100 гаруй албан тушаалтан, иргэд оролцлоо.

ХАСХОМ-ийг маягтыг боловсронгуй болгох чиглэлээр мэдүүлэг гаргагчаас гадна тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн орлого, зарлага, хэрэглээ зэрэг тэдгээрийн эрх ашгийг хөндсөн өөрчлөлт оруулах, орлогоос гадна зарлагын асуудал, үүнээс үүдэн гарах эдийн засгийн үр дагавар, татвар, аудит болон бусад санхүү, бүртгэл хяналтын байгууллагуудын уялдаа холбоо, одоогийн хууль, эрх зүйн зохицуулалт, мэдээлэл технологи, аюулгүй байдал зэрэг бүхий л хүрээнд эрсдэл үүсэх, үр дүнд хүрэх зэрэг асуудлыг цогцоор нь судлан тогтоохоор Авлигатай тэмцэх газрын даргын тушаалаар ажлын хэсэг ажиллаж байна.

ХАСХОМ гаргах явц бүрэн цахимжсан. ХАСХОМ-ийн маягтыг боловсронгуй болгож

зарлагын асуудлыг тусгах чиглэлээр Татварын ерөнхий газартай хамтран ажиллаж, мөн төрийн байгууллагуудын санал авах ажлыг зохион байгуулж байна. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг гаргах, хянах үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх ажил 80 хувьтай явж байгаа бөгөөд мэдүүлэг гаргагчийг цахим системд бүртгэх, мэдүүлэх, мэдүүлгийг баталгаажуулах зэрэг арга зүйн зөвлөгөөг эрх бүхий албан тушаалтнууд болон мэдүүлэг гаргагч нарт өгч байна. (Биелэлт 30 хувь)

#### 4.1.5.15-1. Хууль бус нөлөөллийн хэлбэрийг оновчтой тодорхойлох/АТГ, 2017-2019/

Хууль бус нөлөөллийн хэлбэрийг тодорхойлох хүрээнд эрсдэл өндөр зарим салбаруудад холбогдох судалгаа, дүн шинжилгээг хийж хууль тогтоомжийн төсөлд тусгуулах, санал, зөвлөмж боловсруулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Тухайлбал, АТГ, Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс сэтгүүлчдийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлсөн, шахалт үзүүлсэн, занахийлсэн тоо баримт, зүй бус нөлөөллийн хэлбэрийг судлах судалгааны ажлыг нийслэл болон орон нутгийн 300 сэтгүүлчийн дунд санал асуулгын судалгааг явуулсан. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/233 тушаалаар байгуулсан Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах Ажлын хэсгээс төслийг холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудад хэлэлцүүлэхэд сэтгүүлчийн аюулгүй байдлыг хангах, нөлөөллийн мэдүүлэг гаргах зохицуулалтыг хуульд тусгах зэрэг санал, зөвлөмжийг уламжилсан.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлд шүүгч, шүүх бүрэлдэхүүн нөлөөллийн мэдүүлэг хөтлөх, баталгаажуулах харилцааг хуульчилсан бөгөөд Шүүхийн ерөнхий зөвлөлөөс уг харилцааг нарийвчлан зохицуулж буй “Нөлөөллийн мэдүүлгийг шийдвэрлэх журам” (ШЕЗ-ийн 2015 оны 23 дугаар тогтоолоор баталсан), түүний хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, шинэчлэх ажлыг 2018-2019 онд зохион байгуулж, “Нөлөөллийн мэдүүлгийг шийдвэрлэх журам”, “Нөлөөллийн мэдүүлгийн загвар”, “Нөлөөллийн мэдүүлгийн талаар танилцуулсан загвар”-

ын төслийг тус тус шинэчлэн боловсруулж, хэлэлцүүлэхэд бэлэн болгосон.

Мөн төрийн аудитын байгууллагын хараат бус байдлыг хангах хүрээнд аудиторчуудын үйл ажиллагаанд зүй бус нөлөөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор нөлөөллийн мэдүүлгийг нэвтрүүлэх асуудлыг судалж, Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 39.1. “Энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-т заасан аудитыг гүйцэтгэхэд төрийн аудитын байгууллагын албан хаагч бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд саад учруулсан, аливаа дарамт, шахалт үзүүлсэн, хууль бус нөлөөллийн талаар нөлөөллийн мэдүүлэг хөтөлнө.”, 39.2. “Нөлөөллийн мэдүүлэг хөтлөх журмыг Монгол Улсын Ерөнхий аудитор батлах”-аар тусгажээ. (Биелэлт 30 хувь)

#### 4.1.5.15-2. Хууль бус нөлөөлөл үзүүлсэн этгээдэд хариуцлага хүлээлгэх тогтолцоог боловсронгуй болгох/ЗГХЭГ, 2017-2019/

“Шударга ёс ба олон нийтийн итгэл” сэдэвт хууль сахиулах байгууллагуудын нэгдсэн зөвлөгөөнийг 2019 оны 12 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулсан бөгөөд тус зөвлөгөөнөөс гарсан саналуудыг нэгтгэн эрх бүхий байгууллагуудад зөвлөмж хүргүүлэв.

Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/-д төрийн албаны хүний нөөцийн удирдлага, мэргэшлийн шалгалттай холбогдон гаргасан шийдвэр хууль зүйн үндэслэлгүй болох нь тогтоогдсон бол төрийн албаны төв байгууллага өөрчлөх буюу хүчингүй болгох, хууль бус шийдвэрийг Засгийн газар гаргасан бол уг шийдвэрийг төрийн албаны төв байгууллагын мэдэгдлийг үндэслэн Засгийн газар өөрөө ажлын 14 хоногийн дотор хүчингүй болгох, Төрийн албаны төв байгууллагын болон шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй, биелүүлсэн боловч албан хаагчийг хууль бусаар дахин ажлаас халсан албан тушаалтны шийдвэрийг энэ хуулийн хуульд зааснаас бусад тохиолдолд төрийн албаны төв байгууллага хүчингүй болгож, буруутай албан тушаалтныг үүрэгт ажлаас нь чөлөөлөх мэдэгдлийг эрх бүхий этгээдэд хүргүүлэх, тухайн мэдэгдлийг зөрчсөн эрх бүхий этгээдийг төрийн албанд гурван жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр төрийн албанаас халах эрх зүйн зохицуулалтыг тусгасан. (Биелэлт 70 хувь)



4.1.5.16-1. Хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төсөлд авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр санал, зөвлөмж гаргах тогтолцоог бүрдүүлэх /АТГ, 2017-2019/

Хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөлд авлигаас урьдчилан сэргийлэх санал, зөвлөмж өгөх нөхцөл боломжийн хувьд нээлттэй байна. Тухайлбал, Захиргааны ерөнхий хуульд зааснаар эрх бүхий этгээд захиргааны хэм хэмжээний акт гаргахын өмнө төслийг цахим орчинд 30 хоногийн турш нээлттэй байршуулдаг ба энэ тохиолдолд төсөлтэй танилцаж санал, зөвлөмж өгөх боломжтой байна. Захиргааны ерөнхий хуулийн 61 дүгээр зүйлийн 61.4-т зааснаар захиргааны хэм хэмжээний актын төслийг бэлтгэх явцад нөлөөллийн шинжилгээг заавал хийхээр тусгасан. Мөн хуулийн 61 дүгээр зүйлийн 61.6 дахь хэсэгт заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/147 дугаар тушаалаар баталсан “Захиргааны хэм хэмжээний актын төсөл бэлтгэх явцад нөлөөллийн шинжилгээ хийх аргачлал”-ыг баталсан. Уг аргачлалын дагуу захиргааны байгууллага акт гаргах үндэслэл, шаардлага, зорилтыг тодорхойлох, акт гарсны дараа эрх, хууль ёсны ашиг сонирхол нь аливаа байдлаар хөндөгдөх бүлгийг тодорхойлох, хүний эрх, эрх чөлөө, өрсөлдөөнийг хязгаарласан, эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд саад хориг учруулсан, аливаа хүнд суртал, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт агуулж байгаа эсэх, аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх ... зэргийн судлан тогтоож, нөлөөллийн шинжилгээгээр тухайн шийдвэрийг гаргах зайлшгүй шаардлагатай нь тогтоогдсон тохиолдолд шийдвэрийг батлан гаргаж байгаа бөгөөд уг асуудал хэвшсэн болно.

Харин хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төсөлд авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр Авлигатай тэмцэх газар санал, зөвлөмж заавал гаргах талаар эрх зүйн зохицуулалт байхгүй байна. Авлигатай тэмцэх газрын даргын 2017.12.25-ны өдрийн а/183 дугаар тушаалаар “Төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан тушаал, шийдвэр, дүрэм, журмыг хянах заавар”-ыг батлан мөрдүүлсэн бөгөөд тус газраас 2019 онд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаалаар

батлах “Норматив батлах тухай”, “Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох төсөл сонгон шалгаруулах журам”-ын төсөлд тус тус санал өгсөн байна. (Биелэлт 30 хувь)

4.1.5.17-1. Хээл хахууль өгсөн хүн эрх бүхий байгууллагад сайн дураараа илчлэн ирсэн бол хариуцлагаас чөлөөлөх асуудлыг хууль тогтоомжид тусгаж нэр томъёог тодорхой болгох/АТГ, 2017-2018/

Хээл хахууль өгсөн хүн эрх бүхий байгууллагад сайн дураараа илчлэн ирсэн бол хариуцлагаас чөлөөлөх талаар Эрүүгийн хуульд нэмэлт оруулах санал боловсруулан хүргүүлснээр Эрүүгийн хуулийн 22.5 дугаар зүйлийн тайлбарт хясан боогдуулсны улмаас аргагүй байдалд орж хахууль өгч, нийтийн албан тушаалтны хуулийн дагуу албаны чиг үүргээ гүйцэтгэж үзүүлэх төрийн үйлчилгээг авсан хүн энэ тухайгаа эрх бүхий байгууллагад сайн дураараа илчлэн ирсэн бол түүний авсан төрийн үйлчилгээг хэвээр үлдээж ялаас чөлөөлөхөөр Эрүүгийн хуульд тусгагдсан.

Эрүүгийн хуулийн дээрх тайлбарт өөрчлөлт оруулах саналаа хүргүүлж, 2017 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар Эрүүгийн хуулийн 22.4 дүгээр зүйлийн тайлбар/Хясан боогдуулсны улмаас аргагүй байдалд орж хахууль өгч, нийтийн албан тушаалтны хуулийн дагуу албаны чиг үүргээ гүйцэтгэж үзүүлэх төрийн үйлчилгээг авсан хүн энэ тухайгаа эрх бүхий байгууллагад сайн дураараа илчлэн ирсэн бол түүний авсан төрийн үйлчилгээг хэвээр үлдээж ялаас чөлөөлнө/-г өөрчлөн найруулж, эрх зүйн зохицуулалтыг сайжруулсан. (Биелэлт 100 хувь)

**Зургаа. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилтыг хангах чиглэлээр:**

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 6 дугаар зорилтын хүрээнд нийт 5 үйл ажиллагаа, 21 арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Зорилтын хэрэгжилтийг тоймлон танилцуулбал:

4.1.6.1-1. Хувийн хэвшлийн байгууллагуудын авлигын эсрэг сүлжээний үйл ажиллагааг дэмжих, Авлигын эсрэг түншлэл /РАСИ/-ийн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, Авлигын эсрэг түншлэлийн гол зарчмуудыг сурталчлах үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх /МҮХАҮТ, МАОЭНХ, МБЗ 2017-2019/

Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо нь авлигын эсрэг олон нийтийн сүлжээг ашиглан мэдээлэл түгээн ажилласан. Үүний зэрэгцээ холбооны сайт болох [www.monef.mn](http://www.monef.mn) цахим хуудсандаа үйлчилгээ цонхонд “Авлига” гэсэн бие даасан цэс үүсгэн Авлигын эсрэг хууль, холбогдох дүрэм, журам, зохион байгуулагдсан арга хэмжээ, аж ахуйн нэгж байгууллагуудын авлигаас урьдчилан сэргийлэх менежментийн /Удирдлагын/ тогтолцооны загвар, ажлын байранд авлигаас урьдчилан сэргийлэх талаар баримтлах баримт бичгийн загвар /аж ахуйн нэгж байгууллагуудын түвшинд/ болон бусад багц мэдээллийг сан үүсгэн, гол зарчмуудыг гишүүд, дагагчдад сурталчилж ажилласан. (Биелэлт 30 хувь)

4.1.6.1-3. Авлигын эсрэг түншлэлийн үйл ажиллагааг гишүүн байгууллага болон төрийн байгууллагуудын нөөц боломжийг ашиглан сурталчлах /МҮХАҮТ, МБЗ 2017-2020/

Бизнес эрхлэгчид, иргэний нийгмийн санаачилгаар авлига болон түүнийг тойрон тэлсээр буй хууль бус, ёс зүйгүй соёл, харилцааг ил тод болгон хэлэлцүүлэх, бизнес эрхлэгчид, авлигыг өөгшүүлсэн зохисгүй хандлагыг өөрчлөх, шударга, нийгмийн хариуцлагатай бизнесийг таниулах, авлигын эсрэг иргэд, аж ахуйн нэгжүүдийн хяналтын тогтолцоог дэмжих зорилго бүхий “Авлигын эсрэг НЭГ ҮЙЛДЭЛ” аяныг АТГ, “Транспэрэнси интернешнл Монгол” ТББ, бизнес эрхлэгчидтэй хамтран хэрэгжүүлж, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын гишүүн байгууллагуудад авлигын эсрэг сургалт сурталчилгаа зохион байгуулж, дуу хоолойгоо нэгтгэхийг уриалсан танилцуулга, зурагт хуудсуудыг олон нийтийн сүлжээгээр нийтэд түгээн сурталчлав.

Монголын Бизнесийн Зөвлөл гишүүн байгууллагуудынхаа дунд “Авлига хээл, хахуульгүйгээр бизнес эрхлэх нь” сэдэвт арга хэмжээг зохион

байгуулж, аливаа бизнесийг хээл хахууль өгөхгүй, авахгүйгээр хуулийн хүрээнд эрхлэх, авлигын эсрэг хууль тогтоомжийг сахин биелүүлэх болон бизнес эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд хуулиар олгогдсон эрхээ хэрхэн хэрэгжүүлэх талаарх зөвлөмжийг гишүүн компаниуддаа хүргүүлсэн. Мөн Монголын Бизнесийн Зөвлөлөөс “Транспэрэнси Интернешнл Монгол” ТББ-тай хамтарч, авлигаас урьдчилан сэргийлэх мэдлэг олгох онлайн сургалтын модулийг боловсруулж цахим хуудсанд байршуулан авлига, хээл хахуулийн эсрэг сургалтын хэрэглэгдэхүүн, материалуудыг бүхий л компаниудын ажилтан, албан хаагч бүрт үнэ төлбөргүйгээр ашиглах боломжийг бүрдүүлсэн.

2018 онд Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим Азийн сантай хамтран 4 компанийн 63 хүнийг хамруулан бизнес эрхлэгчдийн авлигаас урьдчилан сэргийлэх талаар ойлголтыг нэмэгдүүлэх, авлигын эсрэг түншлэлийг сурталчлахад чиглэсэн цуврал семинар зохион байгуулсан.

2019 онд Авлигын эсрэг түншлэлийн үйл ажиллагааг гишүүн байгууллага болон төрийн байгууллагуудын нөөц боломжийг ашиглан авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх сурталчилгааны цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх, ёс зүйтэй бизнесийг дэмжих хүрээнд МҮХАҮТ, МАОЭНХ-тай хамтарсан төлөвлөгөөг хэрэгжүүлж, МҮХАҮТ-д шинээр элссэн 225 аж ахуйн нэгжүүдэд “Ёс зүйтэй бизнес” сэдвээр сургалтуудыг, МҮХАҮТ-ын дэргэдэх Гадаад худалдааны академийн үндсэн 2018, 2019 оны сургалтын хөтөлбөр, агуулга-д “Авлига, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх нь, “Авлигын эсрэг хувийн хэвшлийн оролцоо” зэрэг сэдвийг тусгаж, сургалтуудыг зохион байгуулав. Хувийн хэвшил, иргэдийн авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг төрийн болон төрийн төрийн бус байгууллагуудын оролцоонд тулгуурлан хамтран хэрэгжүүлж, сургалт, хэлэлцүүлэг, ярилцлага зэргийг зохион байгуулсан. (Биелэлт 30 хувь)



4.1.6.2-1.Хувийн хэвшлийн байгууллагуудын чадавхжуулах цогц сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах /АТГ, ШӨХТГ, МХЕГ, ГЕГ, ТЕГ, СХЗГ, ОӨУБЕГ, 2017-2019/

Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага (ЕАБХАБ), АТГ, Монголын Бизнесийн Зөвлөл (МБЗ)-тэй хамтран “Транспэрэнси Интернэшнл Монгол” төв байгууллагын дэмжлэгтэйгээр 2017 оны 5 дугаар сард хувийн хэвшлийн байгууллагуудыг чадавхжуулах, бизнес эрхлэхэд тулгарч буй хүндрэл бэрхшээлийг тодорхойлох зорилгоор төр, хувийн хэвшлийн төлөөллийг оролцуулсан “Авлигын эсрэг хамтын ажиллагааг Монгол Улсад идэвхжүүлэх нь” сэдэвт 3 өдрийн модуль сургалтыг зохион байгуулсан ба сургалтыг олон улсын болон үндэсний экспертүүд удирдан явуулж Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, хээл хахууль удирдлагын систем, олон нийтийн худалдан авах ажиллагааны ил тод байдал, гааль, гадаад худалдааны салбар дахь авлигын эрсдэл зэрэг асуудлуудыг хөндөж ярилцав. Сургалтад хамрагдсан компаниудад бизнесийн ёс зүй, шударга байдалтай холбогдох сэдвүүдийг танилцуулах, мөн хувийн хэвшил, төрийн байгууллагуудын төлөөлүүдийг нэг дор авчирч хувийн хэвшил дэх авлига, түүний гол тулгамдсан асуудлыг хэлэлцэж, хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэгдсэн болно.

Удирдлагын академитай хамтран боловсруулсан “Хувийн хэвшил дэх авлигаас урьдчилан сэргийлэх нь” сэдэвт модулийг боловсруулж туршилт сургалтыг АТГ-ын Олон нийтийн төвд зохион байгуулсан.

МҮХАҮТ-д шинээр элссэн гишүүн аж ахуйн нэгжүүдэд авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөтэй болох талаар зөвлөмжийг өгч, сургалтыг АТГ-тай хамтран зохион байгуулж эхэлсэн. Мөн МҮХАҮТ, Азийн сан “Бизнесийн орчин дахь хүнд суртал, авлигын үнэлгээ”-ний судалгааны аргачлал, үр дүнг ашиглах талаар уулзалт, хэлэлцүүлгийг хамтран зохион байгуулж, судалгааны үр дүнгийн зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар төрийн байгууллагууд, судалгааны байгууллагууд, судлаачидтай санал солилцсон.

МҮХАҮТ, Азийн сан, “Транспэрэнси интернэшнл Монгол” төв ТББ-тай хамтран хувийн хэвшлийн байгууллагын ажилтнуудад зориулсан сургалтын хөтөлбөр боловсруулж,

аж ахуйн нэгжүүдэд хамтран цуврал сургалтыг 2018-2019 онд зохион байгуулсан.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар зорилтын хүрээнд 2018 онд 10 төрийн байгууллага, 12 төрийн бус байгууллага мэргэжлийн холбоодтой хамтран ажиллах санамж бичиг, ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна. Төрөөс бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих, хяналт шалгалтын давхардал, хүнд суртлыг арилгах зорилгоор хамтран хяналт шалгалт хийх саналыг төрийн захиргааны байгууллагуудаас авч хяналт шалгалт, аттестатчиллыг хамтран хэрэгжүүлж байна. Үүний үр дүнд төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа, ажлын уялдаа холбоо сайжирч, хяналт шалгалтын давхардлыг арилгах, бизнес эрхлэгчдэд учрах хүндрэл бэрхшээлийг арилгах ажилд ахиц гарсан.

Холбогдох хууль, тогтоомжоор олгогдсон чиг үүргийн дагуу дүгнэлт гаргах, зөвшөөрөл олгох үйл ажиллагааг хэрэгжүүлж буй 557 аж ахуйн нэгж, байгууллагад 24 сэдвээр, бизнес эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдэд хууль зүй, аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх мэдлэг, мэдээлэлтэй болгох зорилгоор бусад салбарын сургалтыг 39 сэдвийн хүрээнд зохион байгуулж, 6438 аж ахуйн нэгжийн холбогдох албан тушаалтнуудыг хамруулсан.

Хувийн хэвшлийн байгууллагуудыг чадавхжуулах хүрээнд МХЕГ-аас “Ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх сүлжээнд хүнсний аюулгүй байдлыг хангах нь”; “Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шошгололт, хадгалалтад тавигдах шаардлага”; “Хөшигийн хөндийд баригдаж буй Улаанбаатар хотын шинэ нисэх онгоцны буудлын цацрагийн аюулгүй байдал, барилга байгууламж, зам талбайн ашиглалт, арчлалтын талаар сургалт зохион байгуулах”; “Хот төлөвлөлтийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй зураг төсөл зохиогч, захиалагч аж ахуйн нэгж байгууллагуудад салбарын сургалт зохион байгуулах”; “Эрүүл ахуйн зохистой дадлыг хэвшүүлэх, нэвтрүүлэх нь”; “Эмийн сангийн салбарын сургалт”; “Эрүүл мэндийн салбарын цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны соёл” сэдвээр сургалт, “Монголын геологи хайгуул-2018” чуулга уулзалтыг тус тус зохион байгуулж, зөвлөмж гарган, холбогдох газруудад хүргүүлсэн.



Мөн “Хуулиа мөрдөнө-21” сарын аяны хүрээнд 282 удаагийн сургалтыг хамтран зохион байгуулж, 2819 аж ахуйн нэгж, 36038 иргэнийг; “Зохистой хөдөлмөр-2018” сарын аяны хүрээнд 126 удаагийн сургалтад 370 ААНБ-ын 7437 ажилтан, МСҮТ-ийн сурагчид, 4 нөхөрлөлийн 20 гишүүнийг; “Эрүүл мал-Эрсдэлгүй бүтээгдэхүүн” сарын аяны хүрээнд 268 сургалт зохион байгуулж, 99071 хүнийг хамруулсан.

Мэргэжлийн хяналтын байгууллагаас 2019 онд 44 удаагийн салбарын сургалтыг зохион байгуулж, 223 аж ахуйн нэгжийн 9012 албан тушаалтнуудыг хамруулсан.

Стандарт, хэмжил зүйн газар хувийн хэвшлийн байгууллагуудыг Олон улсын стандарт, хэм хэмжээг үйл ажиллагаандаа тусгаж нэвтрүүлэх, чадавхжуулах цогц сургалтыг үе шаттайгаар зохион байгуулж лаборатори итгэмжлэл, хэмжил зүй, тохирлын үнэлгээ, чанарын олон улсын стандартын чиглэлээр 26 сэдэвчилсэн сургалтад аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын 400 орчим хүмүүсийг хамруулсан байна. Бизнес эрхлэгчдийг олон улсын сайн дадлуудтай танилцуулах, олон улс гадаад орны стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх арга зүйн сургалтуудад хувийн хэвшлийн 378 хүнийг хамруулж, Хэмжих хэрэгслийн засвар тохируулгын ажилтан 72, хэмжүүрийн улсын шалгагч 15, бүтээгдэхүүний болон тогтолцооны баталгаажуулалтын шинжээч 41 хүнийг мэргэшүүлэн сургасан. 2019 онд 53 сэдэвчилсэн сургалтыг амжилттай зохион байгуулж, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж компаниудын 2390 хүнийг сургалтад хамруулан стандарт, хэмжилзүй, тохирлын үнэлгээ, чанар хангалт, зохистой дадлын талаар олон улсын стандартын мэдээ, мэдээлэл өгч, зохих арга зүйгээр хангасан байна. Хэмжил зүйн чиглэлээр 10 сэдэвчилсэн сургалтыг явуулж хэмжих хэрэгслийн ажил үйлчилгээ явуулах тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжүүд, үйлдвэрлэлийн хэмжил зүй, цахилгаан болон дулааны түгээх дамжуулах сүлжээ зэрэг хэмжилзүйн салбарын 350 мэргэжилтнүүдийг хамруулан хэмжлийн нэгдмэл байдлыг сахиулах, мөнгөн тооцоонд ашиглаж байгаа хэмжих хэрэгслийг заавал баталгаажуулалтанд хамруулах, хэмжил зүйн ажил үйлчилгээний тусгай зөвшөөрөл, хэмжих хэрэгслийн загварын туршилт, хэмжих

хэрэгслийн шалгалт баталгаажуулалтын чиглэлээр дүрэм журам зааврыг мэдээлж, үйл ажиллагаандаа мөрдөх стандартын арга зүйгээр сургаж мэргэшүүлсэн.

Сүлжээ дэлгүүрүүд, зах худалдааны төв, харилцаа холбооны салбарын төлөөллүүдийн удирдах албан тушаалтнуудад Хэрэглэгчийн эрхийг хамгаалах улсын зөвлөгөөнөөс гарсан зөвлөмж, “Хариуцлагатай хэрэглээ-Хэрэглэгчийн эрх”-ийн жилийн ажлын зорилго, чиглэл, “Өргөдөл, гомдлын хуудас”-ын талаарх мэдээллийг танилцуулах уулзалт арга хэмжээг зохион байгууллаа. Уулзалтад нийт 37 аж ахуйн нэгж хамрагдав. “Наран трейд” ХХК-тай хамтран Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай, Зөрчлийн тухай, Зар сурталчилгааны тухай хуулиудаар сургалт, мэдээлэл хийх, өдөрлөг арга хэмжээ зохион байгуулав. “Скайтел” ХХК, Тэди төв, Улаанбаатар их дэлгүүрүүдэд “Аюулгүй, ухаалаг бараа, бүтээгдэхүүн-2019” арга хэмжээг Монголын хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгтэй хамтарч зохион байгуулсан.

Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор Улаанбаатар хот дахь гаалийн газар, Буянт-Ухаа дахь гаалийн газар, Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газруудад гаалийн байгууллагын хяналт, бүрдүүлэлтийн үйл ажиллагааны салшгүй хэсэг болох гаалийн зуучлагч байгууллагуудад сургалтыг тогтмол хийж байна. Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газарт 2019 онд нийт 7 ААН байгууллагуудын 16 бүртгэгдсэн мэргэжилтнүүдэд 7 удаагийн сургалтыг зохион байгуулж ажилласан.

Засгийн газрын 2019 оны 220 дугаар тогтоолоор “Төрийн байгууллагаас төрийн болон бусад байгууллагатай цахим хэлбэрээр мэдээлэл солилцох, сан бүрдүүлэх, ашиглах журам”, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Гадаад харилцааны сайдын 2019 оны А/16, А/07 дугаар хамтарсан тушаалаар “Олон улсын гэрээгээр байгуулагдсан Засгийн газар хоорондын байгууллага, түүний төлөөлөгчдийн газрыг улсын бүртгэлд бүртгэх журам”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны А/22 дугаар тушаалаар “Нотариатчийн мэдээлэл нийлүүлэх, мэдээлэл авах үйл ажиллагааны журам”-ыг тус тус баталснаар Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээг төрийн



болон хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллах эрх зүйн орчныг бий болгосон. Үл хөдлөх хөрөнгө зуучлалын шинэ реалторуудын 17 удаагийн сургалтад эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр мэдээлэл өгч ажиллалаа. Энэхүү сургалтад нийтдээ 550 реалторууд оролцсон байна. Нийслэл дэх Улсын бүртгэлийн газраас иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр 2019 оны байдлаар нийт 80 удаагийн сургалт зохион байгуулж, 1235387 иргэд хамрагдсан. Оюуны өмчийн газар 2019 оныг Мэдээлэл, сурталчилгааны жил болгож зарлаж, улмаар тухайн онд нийт 70 гаруй удаагийн сургалтыг зохион байгуулж оюуны өмчийн мэдлэгийг олон нийтэд түгээж ажилласан байна. Үүнд:

Оюуны өмчийн эрхийн хамгаалалтын талаарх ерөнхий ойлголтыг түгээх, олон нийтэд сурталчлах ажлын хүрээнд 14 аймагт тухайлбал, Орхон, Сэлэнгэ, Эрдэнэт, Дорнод, Сүхбаатар, Хэнтий, Өвөрхангай, Говь-Алтай, Ховд, Баянхонгор, аймгуудын иргэд, жижиг дунд бизнес эрхлэгчдэд зориулан оюуны өмчийг өөрсдийн бизнесийн үйл ажиллагаанд хэрхэн ашиглах талар “Оюуны өмчийн эрхийн хамгаалалт” сэдвээр сургалт, Патентын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, танилцуулгыг оюуны өмчийн салбарын аж ахуйн нэгж, байгууллага, мэргэжлийн холбоод, хамтын удирдлагын байгууллага, төрийн бус байгууллага болон иргэдэд 5 удаагийн хэлэлцүүлэг, уулзалт, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, хяналт шалгалтын чиглэлээр 2019 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр Оюуны өмчийн газар, “Нарантуул” олон улсын худалдааны төв хамтран “Оюуны өмчийн зөрчлөөс урьдчилан сэргийлье” сэдэвт хэлэлцүүлэг, Иргэд, аж ахуйн нэгжийн хүсэлтээр Нийслэлийн Үйлдвэрлэл, инновацийн дэргэдэх “Улаанбаатар инновацийн төв”-ийн инкубаторт бойжиж буй гарааны компаниудад оюуны өмчийн эрхийн хамгаалалтын талаар сургалт, жижиг, дунд бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг чадавхжуулах төсөлд хамрагдаж буй жижиг дунд, бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд Барааны тэмдэг газар

зүйн заалт болон бүтээгдэхүүний загварын талаар зэрэг сургалтыг зохион байгуулсан.

2019 онд Авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх хүрээнд хувийн хэвшил, аж ахуйн нэгж, иргэдэд шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулах чиглэлээр МҮХАҮТ, МАОЭНХ-оос зохион байгуулдаг сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрт “Ёс зүйтэй бизнес”, “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдвийг тусган, хувийн хэвшил, аж ахуйн нэгжийн нийт 250 гаруй ажилтанд сургалт зохион байгуулан ажилласан.

Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо нь Авлигатай тэмцэх газар, Татварын ерөнхий газар, Сангийн яам, Нийгмийн даатгалын ерөнхий газартай хамтран “Шинээр батлагдсан татварын багц хууль, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон нийгмийн даатгалын хууль тогтоомжийг аж ахуйн нэгж, байгууллагуудад мөрдүүлэн хэрэгжүүлэх арга зам” сэдэвт сургалтыг 600 гаруй аж ахуйн нэгж байгууллага, 800 гаруй удирдах ажилтанд зохион байгуулсан бөгөөд сургалтын хөтөлбөрт “Авлигатай тэмцэхэд хувийн хэвшлийн оролцоо ба авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдвийг тусган зохион байгуулсан.

Авлигатай тэмцэх газраас хувийн хэвшил, бизнес эрхлэгчдэд зориулан “Авлигаас урьдчилан сэргийлэх 9 зөвлөмж”, Шударга ёс хөгжил дэвшилд: Хувийн хэвшлийн оролцоо” зэрэг гарын авлага гаргаж, түгээв. (Биелэлт 70 хувь)

4.1.6.2-2. Төрөөс олгодог зарим зөвшөөрөл, бүртгэл, эрх олгох үйл ажиллагааг хувийн хэвшилд шилжүүлэх асуудлыг судалж, шилжүүлж болох үйлчилгээний жагсаалт гарган хэрэгжүүлэх /ҮХГ. ЗГХЭГ, СЯ, АТГ 2018-2022/

ЗГХЭГ-аас хариуцлагын жилийн хүрээнд иргэдэд давхардал чирэгдэлгүй төрийн үйлчилгээг шуурхай үзүүлэх, төсвийн хөрөнгийг ил тод, үр өгөөжтэй зарцуулах, иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх, төрийн албан хаагчид ажлын бус цагаар ажлын байр, томилолтын явцад архи, согтуурлах ундаа хэрэглэхийг хориглох, яам, агентлагууд тусгай

зөвшөөрөл олгох аливаа үйл ажиллагааг ил тод болгож цахимжуулах, төрийн албан хаагчид ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөг сар бүр дүгнэх, ажилтан бүрийн үүргийн хэрэгжилт, цаг ашиглалт, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, төрийн албан хаагчдыг гэмт хэрэгт холбогдох хууль зөрчихөөс урьдчилан сэргийлэх, төрийн захиргааны болон нутгийн удирдлагын байгууллагын ажлын үр дүнг иргэдийн сэтгэл ханамжийн үзүүлэлттэй холбож үнэлгээ хийхийг зорилт тавин ажилласан. Засгийн газрын 2016 оны 165 дугаар тогтоолын дагуу Нягтлан бодох бүртгэлийн болон татварын мэргэшсэн зөвлөхийн үйлчилгээний төрийн зарим чиг үүргийг гүйцэтгэж байгаа Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэг, Монголын нягтлан бодох бүртгэлийн хүрээлэн, аудитын төрийн зарим чиг үүргийг гүйцэтгэж байгаа Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт, Монголын мэргэшсэн үнэлгээчдийн институттэй гэрээ байгуулан, жил бүр ажлын төлөвлөгөөг баталж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Хөрөнгө оруулалтын тухай хуулийн хүрээнд Гадаадын төрийн өмчит хуулийн этгээдэд Монгол Улсад хөрөнгө оруулалт хийх зөвшөөрлийг олгох зохицуулалттай. Монгол Улсын эрх ашиг, төсөв, санхүү, үндэсний аюулгүй байдалтай холбоотой асуудлуудыг судлахад үүнийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх боломжгүй байдаг. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн дагуу Үндэсний хөгжлийн газар нь газрын дэргэдэх төр хувийн хэвшлийн оролцоог хангасан Тогтворжуулах гэрчилгээ олгох эсэх дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий Зөвлөлийн шийдвэрийг үндэслэн Тогтворжуулах гэрчилгээ олгох ажил хийгдэж байна. Тогтворжуулах гэрчилгээ олгох шийдвэр нь Төр-хувийн хэвшлийн хамтын шийдвэр. Мөн гадаадын иргэн, харьяатын газарт хүргүүлж буй гадаадын хөрөнгө оруулагчдад түр оршин суух виз олгож өгөхийг хүссэн хүсэлт нь төрөөс үзүүлж буй дэмжлэгийн хэлбэр юм.

Авлигатай тэмцэх газар, Барилга, хот байгуулалтын яам, Монголын барилгын үндэсний ассоциаттай хамтран “Мэргэжлийн холбоодод шилжүүлсэн барилгын тусгай зөвшөөрлүүд: Асуудал, шийдэл” хэлэлцүүлэг зохион байгуулж, асуудлыг тоо баримт, мэдээлэлд тулгуурлан ярилцаж, учирч буй хүндрэл бэрхшээл, түүнийг шийдвэрлэх арга

зам, төр, хувийн хэвшлийн байгууллагын хамтын ажиллагаа зэрэг сэдвээр санал солилцож, ярилцав. Мэргэжлийн холбоод нь ингэж төрийн зарим үүргийг авснаар төрийн албаны хүнд суртал, бизнес эрхлэгчдэд учирдаг байсан чирэгдэл багасч, яам нь ч бодлогоо тодорхойлох, стратеги боловсруулдаг үндсэн чиг үүрэгтээнхаарч, ачаалал нь багассан байна. Мэргэжлийн холбоодын түншлэлд 3 төрлийн зөвшөөрөл олгох эрхийг шилжүүлсэн бол барилгын материал үйлдвэрлэх зөвшөөрлийг барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоо хариуцаж байна. (Биелэлт 30 хувь)

4.1.6.3-1. Төр, хувийн хэвшлийн зөвлөлдөх уулзалтыг бизнесийн чиглэл, салбар бүрээр зохион явуулж, бизнес эрхлэхэд тулгарч буй асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх /ЗГХЭГ, ҮХГ, 2018-2022/

2017 онд зохион байгуулсан Авлигын эсрэг үндэсний чуулганы нэг салбар хуралдааныг “Хувийн хэвшил дэх авлигаас урьдчилан сэргийлэх асуудал” гэсэн сэдвийн хүрээнд явуулж эрдэмтэн, судлаач, холбогдох байгууллагын төлөөлөл, гадаад улсын зочин, төлөөлөгчдөөр тус тус илтгэл тавиулж, хэлэлцүүлэн, гарсан санал, санаачилгыг судлан хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2018 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн 39 дүгээр захирамжийн дагуу төр, хувийн хэвшлийн зөвлөлдөх уулзалт “Монголын эдийн засгийн чуулган” арга хэмжээг 3, 5 дугаар сард 2 удаа тус тус зохион байгуулж, эхний уулзалтыг “Хүчээ нэгтгэе” уриан дор “Уул уурхай ба үр өгөөж”, “Утаагүй, түгжрэлгүй Улаанбаатар”, “Тогтвортой хөдөө аж ахуй хөгжлийн тулгуур”, “Хувьчлал ба Шинэчлэл”, “Аялал жуулчлал ба агаарын тээврийн либералчлал”, “Татварын хуулийн шинэчлэл” гэсэн 6 салбарын хүрээнд зохион байгуулсан. Хоёр дахь зөвлөлдөх уулзалтаар “Монгол Улсын хөгжлийн бодлого ба хөрөнгө оруулалт”, “Монгол Улсын хөгжлийн загвар”, “Төр хувийн хэвшлийн диалог ба Хамтын ажиллагаа”, “Аж үйлдвэрийн IV дэх хувьсал”, “Бидний үнэт зүйлс, ёс зүй ба Нийгмийн зөвшилцөл”, “Улаанбаатар хотын эдийн засаг ба Хөрөнгө оруулалт”, “Эдийн засгийг бүсчилэн хөгжүүлэх, Төвлөрлийг сааруулах” зэрэг 7 салбар хуралдааныг зохион байгуулж, бизнес эрхлэхэд тулгарч буй



асуудлыг тодорхойлох хэлэлцүүлэг өрнүүлэв.

Хөрөнгө оруулалтын тухай хууль тогтоомж, бодлогын баримт бичгийг боловсруулах, батлах явцад Төрийн болон хувийн хэвшил, хөрөнгө оруулагчдын оролцоог ижил түвшинд хангах, аливаа байдлаар эрх ашиг нь хөндөгдөж байгаа хувийн хэвшил, төрийн бус байгууллагуудын дуу хоолойг нээлттэйгээр сонсож, хүлээн авч, бодлого, үйл ажиллагаандаа тусгаж явах байнгын ажиллагаатай “Төр, хувийн хэвшлийн зөвлөлдөх хороо”-г “Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөл”-ийн дэргэд ЗГХЭГ-ын даргын 2017 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 320 дугаар тушаалаар байгуулсан. Төр, хувийн хэвшлийн зөвлөлдөх хороо 2018 онд “Татварын багц хууль болон Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслүүдийн хоорондын уялдаа холбоо: Бичил, жижиг, дунд бизнесийн үйл ажиллагаанд нөлөөлөх нь”; “Монгол Улс: Төр-Хувийн хэвшлийн хэлэлцэл, Итгэлийг бий болгох, хөрөнгө оруулалтын орчин, өрсөлдөх чадварыг сайжруулах хэрэгсэл”; “Төр, хувийн хэвшлийн зөвлөлдөх уулзалт” арга хэмжээний хүрээнд “Төр, хувийн хэвшлийн зөвлөлдөх механизмыг нэвтрүүлэх нь: Итгэлцэл, зөвшилцөл, шийдэл”; “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль болон Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагаа, Хөдөө аж ахуйн биржийн шимтгэлтэй холбоотой асуудал”; “Хөрөнгө оруулалтын шинэтгэлийн зураглал, түүний үр дүн, зөвлөмж” сэдвээр тус тус хурал, зөвлөгөөн зохион байгуулж, мэдээлэл, илтгэл хэлэлцүүлж, холбогдох зөвлөмжийг гаргаж ажилласан.

2019 онд Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөлд хандан нийт 7 гомдол ирсэн бөгөөд эдгээрийн 6 нь шүүхэд хандсан байсан тул Зөвлөлөөр хэлэлцээгүй. Харин Төр, хувийн хэвшлийн зөвлөлдөх хороо нь 2019 онд нийт 2 удаа хуралдаж Зөвшөөрлийн тухай хууль болон Баялаг бүтээгчдийг дэмжих цогц хуулийн төсөл боловсруулах тухай асуудлаар зохих шийдвэрүүдийг гаргасан.

Засгийн газрын 2018 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан “Гурван тулгуурт хөгжлийн бодлого”, “Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөл”-ийн Зөвлөмжийн дагуу Монгол Улсын Ерөнхий сайдын 2018 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 186 дугаар захирамжаар Нэг цэгийн үйлчилгээний

төвийг Үндэсний хөгжлийн газрын дэргэд байгуулахаар шийдвэрлэсэн бөгөөд 2019 оны эхний улиралд багтаан нэг цэгийн үйлчилгээний төвийг нээхээр ажиллаж байна. “Нэг цэгийн үйлчилгээний төв”-ийг байгуулсанаар хөрөнгө оруулагчдад үзүүлж буй төрийн үйлчилгээг нэг дороос, хурдан шуурхай хүргэн, цаг хугацааг хэмнэж байна.

АТГ-аас авлигын эсрэг олон улсын өдрийг тохиолдуулан “Хууль дээдлэх ёс ба авлига, ашиг сонирхлын зөрчил”, “Боловсролын салбар дахь авлига, түүнээс урьдчилан сэргийлэх арга зам”, “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан: Асуудал ба шийдэл” сэдвээр иргэний нийгмийн төлөөлөл, хуульч, судлаачдыг оролцуулсан хэлэлцүүлэг, Азийн сантай хамтран “Авлигын нөхцөл байдлын судалгаа, шинжилгээ, үр дүн, цаашид хэрэгжүүлэх ажил” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг цувралаар зохион байгуулж, санал, зөвлөмжийг боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүрүүлсэн. (Биелэлт 30 хувь)

4.1.6.3-2. Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ, хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгаж байх талаар зохион байгуулалтын арга хэмжээг авах /ҮХГ, СЯ 2017-2018/

Сангийн яам 2018 онд Засгийн газрын 2016 оны 165 дугаар тогтоолын дагуу Нягтлан бодох бүртгэлийн болон татварын мэргэшсэн зөвлөхийн үйлчилгээний төрийн зарим чиг үүргийг гүйцэтгэж байгаа Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэг, Монголын нягтлан бодох бүртгэлийн хүрээлэнтэй байгуулсан гэрээний 3.2 дахь заалтаар авлигаас урьдчилан сэргийлэх, сонирхлын зөрчлөөс ангид байх заалтуудыг тусгаж ажилласан. (Биелэлт 0 хувь)

4.1.6.3-3. Олон улсын болон дотоодын бизнесийн орчин дахь авлигатай тэмцэх сайн туршлага, эрсдэлийн менежментийн стратегийг судлах, нэвтрүүлэх санаачилга өрнүүлэх /МҮХАҮТ, Гишүүн байгууллага. АТГ 2018-2019/

МҮХАҮТ-аас бизнес эрхлэхэд хүнд суртал үзүүлж байгаа албан байгууллага, үйл явцыг үнэлэн гаргадаг “Хүнд суртлын индекс” судалгааны бэлтгэл ажлын хүрээнд төрийн байгууллагуудаас олгож байгаа зөвшөөрөл,

бүртгэл, түүнтэй адилтгах актуудын талаарх мэдээллийг шинэчлэх ажлыг явуулж байна. Нийт 50 төрийн байгууллагад албан тоот явуулснаас 39 байгууллагын 575 зөвшөөрөл, бүртгэл, түүнтэй адилтгах актуудын мэдээллийг авч нэгтгээд байна.

Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо нь “Орон нутаг дахь авлигын эсрэг төрийн бус байгууллагуудын сүлжээ”-ээр дамжуулан орон нутгийн түвшинд авлига, хүнд суртлыг бууруулах зорилгоор Булган, Орхон аймагт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудын төлөөллийг хамруулсан 2 удаагийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, нийт 80 гаруй хүнийг хамруулсан.

Компанийн засаглалын үндэсний зөвлөлөөс боловсруулан баталсан хөтөлбөрийн дагуу Компанийн засаглалын 3 удаагийн сургалтыг зохион байгуулж, нийт 40 гаруй хүнийг хамруулсан. Дээрх сургалтад Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.8-д заасны дагуу Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга нь Компанийн засаглалын сургалтад сууж гэрчилгээ авсан байхаар хуульчилсан нь тухайн аж ахуйн нэгжид засаглалын болон ёс зүйн зарчмуудыг удирдлагын хэмжээнд хэрэгжүүлэхэд ач холбогдолтой болсон. Компанийн нийгмийн хариуцлага ISO26000 Олон улсын стандарт MNS ISO26000:2012 Үндэсний стандартын талаарх ойлголтыг аж ахуйн нэгж, байгууллагуудад өгөх зорилгоор 3 удаагийн сургалт зохион байгуулж 30 гаруй хүнийг хамруулсан.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас Монгол Улсын авлигын эсрэг эрх зүйн орчин, төрийн холбогдох байгууллагуудаас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, үр нөлөөг үнэлэх ажил 2018 онд хийгдэж, 2019 онд тайланг баталгаажуулж, өгсөн дүгнэлт, зөвлөмжийг Монгол Улсын Ерөнхий сайд, Авлигатай тэмцэх газрын дарга нарт ирүүлсэн бөгөөд тус байгууллагын төлөөлөл мониторингийн тайлан, зөвлөмжийг төрийн болон хэвлэл мэдээллийн байгууллага, иргэдэд 2019 оны 7 дугаар сарын 29, 30-ны өдөр танилцуулж, мэдээлсэн. (Биелэлт 30 хувь)

4.1.6.4-1. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах /ШӨХТГ, ШСАА 2017-2019/

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, үзэл баримтлалыг Монгол Улсын Шадар сайд, ХЗДХ-ийн сайдаар батлуулан, төслийг Засгийн газрын 2019 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн УИХ-д өргөн барих бэлтгэл ажлыг хангасан. (Биелэлт 70 хувь)

4.1.6.4-2. Өрсөлдөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах /ШӨХТГ, ШСАА 2017-2019/

Улсын Их хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 22-т “Өрсөлдөөний тухай хуулийг хэрэгжүүлэх явцад тулгамдаж байгаа бэрхшээлийг шийдвэрлэх, уг хуулийг зах зээлийн эдийн засгийн харилцааг зохицуулах суурь хууль болгон өөрчлөн шинэчлэх” гэж, Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.13-т “Зах зээл дэх шударга өрсөлдөөнийг дэмжиж, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хууль, эрх зүйн орчинг сайжруулна” гэж тус тус заасны дагуу Өрсөлдөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг боловсруулан МУ-ын Шадар сайд болон Хууль зүйн сайдаар батлуулж, төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу 2019 оны 12 дугаар сарын 4-ний өдөр Шадар сайд хуулийн төслийг УИХ-ийн даргад өргөн барьсан. УИХ-ын хаврын чуулганы хэлэлцэх асуудлын жагсаалтад тусгагдсан болно. (Биелэлт 70 хувь)

4.1.6.4-3. Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах /ШӨХТГ, ШСАА 2017-2019/

Зар сурталчилгааны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийн үзэл баримтлалыг боловсруулан Монгол Улсын Шадар сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдаар батлуулан, Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн төслийн үзэл баримтлалыг олон нийтээр хэлэлцүүлж, гарсан санал, зөвлөмжийн дагуу олон улсын жишиг, хөгжлийн чиг хандлагад нийцсэн зар сурталчилгааны хуультай болохоор ажиллаж байна. Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас Зар



сурталчилгааны тухай хуулийг боловсронгуй болгох талаар санал бодлоо солилцохоор Засгийн газар, яам, агентлаг, Олон улсын байгууллагууд, эрдэмтэн судлаачид, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн дунд 2019 оны 6 дугаар сарын 14-ний өдөр хэлэлцүүлэг зохион байгууллаа. (Биелэлт 30 хувь)

4.1.6.4-4. Зах зээлийн өрсөлдөөнийг дэмжих чиглэлээр хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх /ШӨХТГ 2018-2020/

“Зах зээлийн өрсөлдөөнийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийн төслийн нөхцөл байдлын дүн шинжилгээ, тус хөтөлбөрийн нөлөөллийн урьдчилсан үнэлгээ, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөв зэргийг боловсруулж, хөтөлбөрийн төсөл ба хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг 2018 оны 5 дугаар сард “Жайка” олон улсын байгууллагатай хамтран төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй эрхлэгчдийн төлөөллийг оролцуулан хэлэлцүүлэг зохион байгуулсан. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль болон Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журмын дагуу нөхцөл байдлын дүн шинжилгээнд тулгуурлан хөтөлбөрийн төсөл, шаардлагатай баримт материалуудыг боловсруулан санал авсан.

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас 2019 онд “Өрсөлдөөний хууль, бодлогын хэрэгжилт-өнгөрсөн ба ирээдүй” сэдэвт улсын анхдугаар зөвлөгөөнийг зохион байгуулан зөвлөмж гаргаж, 2020 оныг “Зах зээлийн өрсөлдөөнийг дэмжих жил” болгон зарласан. “Зах зээлийн өрсөлдөөнийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийн төслийн боловсруулж хүргүүлсэн боловч төсөв мөнгөтэй холбоотойгоор дэмжигдээгүй. “Зах зээлийн өрсөлдөөнийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийн төслийн хавсралт-9 ийг бэлтгэж, 2019 оны 1/62 тоот албан бичгээр Монгол Улсын Шадар сайд, Сангийн яаманд тус тус хүргүүлсэн. (Биелэлт 70 хувь)

4.1.6.4-5. Төрийн байгууллага, албан тушаалтнаас зах зээлийн өрсөлдөөнд нөлөөлсөн, аль нэг аж ахуйн нэгжид давуу байдал олгосон шийдвэр, үйл ажиллагаа явуулах боломжийг хязгаарласан эрх зүйн орчинг сайжруулах /ШӨХТГ 2017-2019/

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын даргын баталсан 1/12 дугаартай удирдамжийн дагуу УУХҮЯ-ны шийдвэр нь өрсөлдөөнийг хязгаарласан эсэхэд, Эрүүл мэндийн яамны шийдвэр нь өрсөлдөөнийг хязгаарласан эсэхэд, “Шингэрүүлсэн хийн аж ахуй эрхлэгчдийн холбоо” ТББ-аас ирүүлсэн гомдлын дагуу Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаас баталсан “нийслэлийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээ эрхлэх нийтлэг журам” нь өрсөлдөөнийг хязгаарласан эсэхэд, “Тээвэр хөгжлийн банк”, “Капитрон банк”, “Богд банк”, “Кредит банк”, “Ариг банк”-уудаас Монгол банкны Өөрөнхийлөгчийн 2019 оны 5 дугаар сарын А-138 тоот тушаалаар батлагдсан “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ын 5.3-т “Банкны хамгийн том 10 харилцагчийн хадгаламж харилцахын нийлбэр нь банкны нийт активын 25 хувиас хэтрэхгүй” байхаар заасан нь Өрсөлдөөний тухай хуулийг зөрчсөн эсэхэд, Мон Пасс Са, Ви Эс Эм, Нью компас ХХК, Нью Компасс ХХК-иас тус тус ирүүлсэн гомдлын дагуу Монгол банкнаас зарласан тоон гарын үсгийн үйлчилгээ үзүүлэх сонгон шалгаруулалт нь Өрсөлдөөний тухай хуулийг зөрчсөн эсэхэд тус тус шалгалтуудыг хийсэн.

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй “Өрсөлдөөний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д хуульд зааснаас бусад тохиолдолд төрийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага аж ахуйн аливаа үйл ажиллагаатай холбогдсон зөвшөөрөл, лиценз, эрх олгох, бүртгэл явуулах, төлбөр, хураамж авахыг хориглохоор заасныг Өрсөлдөөний тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөлд “хуулиар тусгайлан эрх олгоогүй захиргааны байгууллага аж ахуйн аливаа үйл ажиллагаа явуулахтай холбоотой зөвшөөрөл, лиценз, эрх олгох, бүртгэл явуулах, төлбөр, хураамж авахыг хориглохоор өөрчлөн тусгасан “Өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн гэрээ, хэлцэл байгуулсан шийдвэр гаргасан тухайгаа сайн дураараа илчилсэн аж ахуй эрхлэгчид ногдуулах шийтгэлээс хөнгөлөх чөлөөлөхөд баримтлах нарийвчилсан журам”-ын төслийг 2019 оны 3 дугаар сарын 12-ны өдөр дарга нарын зөвлөлийн хуралдаанд танилцуулсан. (Биелэлт 30 хувь)

#### 4.1.6.4-6. Өрсөлдөөний хууль тогтоомжийг сурталчлах, шударга өрсөлдөөнийг дэмжсэн сургалтыг жил бүр зохион байгуулах /ШӨХТГ 2017-2019/

Өрсөлдөөний тухай хууль тогтоомжийг сурталчлах чиглэлээр нефть импортлогчид болон шингэрүүлсэн шатдаг хийн бизнес эрхлэгч аж ахуйн нэгжүүдэд сургалт зохион байгуулсан. Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн байгууллагын Солонгос дахь бодлогын төвтэй хамтран 2017 оны 9 дүгээр сард Улаанбаатар хотноо “Дуудлага худалдаанд үгсэн тохиролцох зөрчлийг илрүүлэх нь” сэдэвт олон улсын сургалтыг амжилттай хамтран зохион байгуулав. Тус олон улсын сургалтад гадаадын 15 орны 30, Монгол Улсаас 30, нийт Өрсөлдөөний байгууллагуудын 60 төлөөлөгчид оролцов. Мөн 2017 оны 5 дугаар сард Улаанбаатар хотноо Индонезийн Бизнесийн Өрсөлдөөнийг хянан зохицуулах хороотой хамтарсан туршлага солилцох семинарыг “Жайка” олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр зохион байгуулсан. Нийслэлийн 9 дүүргийн ЗДТГ-ын албан хаагчид болон харьяа нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдад өрсөлдөөнийг хязгаарласан буюу хөрөнгө оруулагч болон аж ахуй эрхлэгчдэд үндэслэлгүй саад учруулах, хуулиас давсан шийдвэр гаргахаас урьдчилан сэргийлэх зорилгоор уулзалт хийж, өрсөлдөөний хууль тогтоомжийг сурталчлах ажлыг зохион байгуулав.

Салбаруудын тулгамдаж байгаа асуудлууд, тэдний санал хүсэлтийг сонсох зорилгоор үүрэн холбооны оператор 4 компани, даатгалын зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаа 16 компани, төмөр замын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчийн болон хувийн компаниудтай уулзалт зохион байгуулж, холбогдох санал хүсэлтийг нь хүлээн авах 3 удаагийн уулзалтыг зохион байгуулав.

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Соёл урлагийн газар, Гадаад харилцааны яам, Үндэсний хөгжлийн газар, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас зохион байгуулсан “Монгол киноны өрсөлдөх чадвар, кино бүтээлийн түгээлт ба зохицуулалт” уулзалт, хэлэлцүүлэгт оролцож, Өрсөлдөөний хуулийн талаар танилцуулга, мэдээлэл хийв.

Өрсөлдөөний соелыг төлөвшүүлэх, шударга бус өрсөлдөөнөөс урьдчилан сэргийлэх, арга зүйн удирдлагаар хангах чиглэлээр сургалтуудыг тогтмол зохион байгуулдаг. Өрсөлдөөний тухай хууль, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль, Зар сурталчилгааны тухай хууль тогтоомж, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиар нийт 25 удаагийн сургалт, уулзалт зохион байгуулж, 819 хүн хамрагдсан. Хувийн хэвшлийн 120 орчим албан хаагчдад Өрсөлдөөний хуулийн талаар ерөнхий ойлголт, Зар сурталчилгааны тухай хуулийн хэрэгжилт, анхаарах асуудлуудын талаар зөвлөгөө, мэдээлэл өгч, Зүүн бүсийн 3 аймгийн төрийн албан хаагчдад сургалт зохион байгуулсан. Төрийн байгууллага, аж ахуй эрхлэгчдэд 69 зөвлөмж хүргүүлэн, ТВ ярилцлага, нэвтрүүлэгт 22 мэдээлэл, ФМ, МҮОНР-д 7 удаа, өдөр тутмын сонинд 2, сайтад 8 удаа ярилцлага өгч, Фэйсбүүк лайв 2 удаа хийж, агентлагийн фэйсбүүк хуудсанд 70 мэдээлэл бэлтгэн оруулсан. Олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллагуудын маркетинг хариуцсан албан хаагчдад; эрүүл мэндийн зар сурталчилгаатай холбогдуулан ЭМХТ, Телевизүүдийн төлөөлүүдэд; дотоодын үйлдвэрлэгч болон сүлжээ дэлгүүрийн чиглэлийн аж ахуй эрхлэгчдэд тус тус Өрсөлдөөний тухай хууль, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль, Зар сурталчилгааны тухай хууль тогтоомжийн талаар сургалт, арга зүйн зөвлөгөө өгөх ажлыг тогтмол зохион байгуулсан. (Биелэлт 70 хувь)

#### 4.1.6.5-1. Эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хангах талаарх эрх зүйн орчинг бүрдүүлэх асуудлыг судалж, шийдвэрлүүлэх /УУХҮЯ 2017-2019/

Боловсруулах салбарын ил тод байдлыг хангахад чиглэсэн эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор энэ салбарт үйл ажиллагаа эрхэлдэг бүх аж ахуйн нэгжүүдийг бүртгэлжүүлэн нэгдсэн мэдээллийн санг үүсгэв.

“Хайлуур жоншны үйлдвэрлэл, экспортыг дэмжих зорилгот хөтөлбөр”-ийн төслийг боловсруулж, нөлөөллийн шинжилгээг хөндлөнгийн байгууллагаар гүйцэтгүүлэн, яамдаас саналавч Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. “Баяжуулах үйлдвэрт тавигдах шаардлага, үйл ажиллагаа



эрхлэх журам”-ын төсөл, “Ил уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм”, Хүнд үйлдвэрлэлийн салбарын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх материалын жагсаалт, маягтын төслийг тус тус боловсруулан, аж ахуйн нэгж, иргэдээс санал авах ажлыг зохион байгуулж байна.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан, Засгийн газраас УИХ-д өргөн мэдүүлж, Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг хангасан. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам 2019 оны 5 дугаар сараас хойш Эрдэс баялгийн ил тод байдлын салбарын ил тод байдлын тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг ажиллаж, хуулийн үр нөлөө, тандан судалгааг хийж, үзэл баримтлалыг шинэчилсэн.

“Эрдэс баялгийн гэрээний мэдээллийн сан”-г Монгол Улсын Засгийн газар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Нээлттэй нийгэм форумын дэмжлэгтэйгээр “Астериск техноложис” ХХК боловсруулсан, тус санд нийт 583 гэрээ, 162 гэрээний заалтын тайлбар, 8 хууль тогтоомж бүртгэгдсэн байна. Хэрэглэгч мэдээллийн сангаас хүссэн аймаг, орон нутаг, эрдсийн төрөл, гэрээний төрөл, компанийн нэрээр хайлт хийн мэдээлэл авах боломж бүрдсэн. (Биелэлт 30 хувь)

4.1.6.5-2. Хөрөнгө оруулалтын гэрээ, Бүтээгдэхүүн хуваах гэрээ, Орд ашиглах гэрээ, Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээнүүдийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ил тод болгох ажлыг зохион байгуулах /УУХҮЯ 2017-2019/

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Олборлох үйлдвэрлэлийн засаглалыг сайжруулах төслийн Ажлын алба болон Нээлттэй нийгэм форумын хооронд Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх хүрээнд мэдээллийн нэгдсэн сан байгуулах замаар эрдэс баялгийн салбар дахь гэрээний ил тод байдлыг хангах чиглэлээр 2017 оны 6 дугаар сарын 22-ны өдөр “Санамж бичиг” байгуулсан ба эрдэс баялгийн салбарт байгуулагдсан гэрээг [www.iltodgereee.mn](http://www.iltodgereee.mn), [www.resourcecontracts.mn](http://www.resourcecontracts.mn) цахим санд байршуулж, олон нийтэд ил тод болгох чиглэлээр хамтран ажиллав.

Нээлттэй нийгэм форумын дэмжлэгтэйгээр

[www.iltodgereee.mn](http://www.iltodgereee.mn) цахим санг иж бүрнээр 2017 онд ашиглалтад оруулж, санг тогтмол шинэчилж, баяжуулж байх Санамж бичгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Нээлттэй нийгэм форум, Олборлох үйлдвэрлэлийн засаглалыг сайжруулах төслийн Ажлын алба хамтран байгуулсан бөгөөд эхний удаад 35 гэрээний эхийг ил тод болгосны дотор Загвар гэрээ-5, Бүтээгдэхүүн хуваах гэрээ-1, Хөрөнгө оруулалтын гэрээ-1, Ус ашиглах-1, Газар ашиглах-6, Орон нутагтай хамтран ажиллах/нийгмийн хариуцлагын-21 гэрээг гэрээний зүйл заалтын 140 тайлбарын хамт оруулсан.

Энэхүү Санамж бичгийн хүрээнд УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны А/06 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдан эрдэс баялгийн салбарын 11 төрлийн гэрээг цуглуулж бүртгэх үүрэгтэй ажилласан бөгөөд 2018 оны жилийн эцсийн байдлаар 11 төрлийн 434 гэрээг холбогдох газруудаас татан авах ажил хийгдэж бүрэн дууссан бөгөөд 248 гэрээ /буюу 58 хувь/-ийг мэдээллийн цахим санд байршуулсан.

2019 онд газрын тосны хайгуул, ашиглалтын нийт 26 Бүтээгдэхүүн хуваах гэрээний эх бичвэрийг [iltodgereee.mn](http://iltodgereee.mn) сайтад байршуулсан. 2019 оны 1-р сарын 31-ний байдлаар 583 гэрээ байршуулснаас Бүтээгдэхүүн хуваах гэрээ 26, Хөрөнгө оруулалтын гэрээ 4, Тогтвортой байдлын гэрээ 11, Орон нутагтай хамтран ажиллах 157 гэрээг байршуулсан байна. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны А/13 дугаар тушаалаар Эрдэс баялгийн гэрээний мэдээллийн цахим сангийн үр нөлөө, тогтвортой ажиллагааг дэмжих хүрээнд Газрын тосны эрлийн гэрээ болон Орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаас бичил уурхай эрхлэгч нөхөрлөлтэй байгуулсан гэрээнүүдийг ил тод болгох ажлыг ажлын хэсгийн хүрээнд бэлтгэн ханган, цахим санд байршуулахад бэлэн болгоод байна. (Биелэлт 70 хувь)

4.1.6.5-3. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын стандартын хүрээнд ашиг хүртэгч (бенефициар) эздийг ил тод болгох /ЗГХЭГ, УУХҮЯ 2020-2022/

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын стандартын хүрээнд ашиг хүртэгч (бенефициар) эздийг ил тод болгох чиглэлээр 2020 оны 1 дүгээр сарын 1-нээс



өмнө хэрэгжүүлэх “Замын Зураг” төлөвлөгөөг Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын Үндэсний Зөвлөлөөр 2016 оны 12 дугаар сард батлуулан хэрэгжүүлж байна. 2017 онд эздийн ил тод байдлын үндсэн тодорхойлолтуудыг боловсруулж Ажлын хэсгээр батлуулан, Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн болно. Ашиг хүртэгч (бенефициар) эздийг ил тод болгох чиглэлээр 300 гаруй мэргэжилтнүүдийг хамруулсан нийт 9 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулсан ба хэлэлцүүлгээс гарсан санал, дүгнэлтийг үндэслэн хуулийн төсөл боловсруулах Ажлын хэсгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаман дээр байгуулан ажиллуулахаар төлөвлөж байна. Сайн дураар мэдээллээ ил болгосон компаниуд 2013 онд 215, 2014 онд 26, 2015 онд 51, 2016 онд 46, 2017 онд 184, 2018 онд 60 компани тус тус ил болгосон байна.

Эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хангах эрх зүйн орчинг бүрдүүлэх ажлын хүрээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны А/82 дугаар тушаалаар Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийн боловсруулах ажлын хэсэг байгуулагдаж, хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу холбогдох судалгааг хийж байна.

Ашиг хүртэгч жинхэнэ эздийг ил тод болгохтой холбогдуулан тусгай зөвшөөрөл эзэмшигч бүх аж ахуйн нэгжүүд УБЕГ-т шинэчилсэн бүртгэл хийлгэх тухай зар байршуулсан. Энэ ажлын явц, цаашид авах арга хэмжээний талаар УБЕГ, ТЕГ-тай уулзаж зөвлөлдөхөөр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан байна. “Эрдэс баялгийн салбарт ашиг хүртэгч эцсийн эздийг ил болгох” 2020 он хүртэлх төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. ОУИТБС-ын жил бүрийн нэгтгэлийн тайлангаар 2013 оноос хойш 200 гаруй компаниуд сайн дураар эзэмшигчийн мэдээллээ тайлагнасан.

Авлигатай тэмцэх газар, Нээлттэй нийгэм форум, Транспэрэнси Интернешнл Монгол, Хууль тогтоомж, бодлого судалгааны төв, Байгалийн баялагийн засаглалын хүрээлэн зэрэг төрийн бус байгууллагатай хамтран Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтгал, газрын тосны газар, Татварын ерөнхий газар, УБЕГ-ын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар, бусад холбогдох байгууллагын төлөөллийг оролцуулан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн

хэрэгжилт: Олборлох салбарын ил тод байдал” хэлэлцүүлгийг 2019 оны 12 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулж хөтөлбөрийн зорилт, түүний биелэлт, эцсийн өмчлөгчийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдлын талаар хэлэлцэж, хэрэгжилтийг хангах, эрчимжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх санал зөвлөмжийг нэгтгэн Засгийн газарт хүргүүлсэн зөвлөмжид тусгасан болно.

Хэдийгээр 2017 онд Ашигт малтмалын тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд нь эцсийн өмчлөгчийн мэдээллийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар болон Ашигт малтмал, газрын тосны газар, холбогдох татварын байгууллагад 2018 оны 06 сарын 01-ний дотор бүртгүүлэх, мөн өмчлөлд өөрчлөлт орсон тухай бүр ажлын 10 хоногийн дотор шинэчлэн бүртгүүлэх үүргийг хуульчилсан боловч ил тод болгох асуудлыг хуульчлаагүй байна. (Биелэлт 30 хувь)

4.1.6.5-4. Бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайн хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх хууль, журмыг чанд мөрдүүлэх /УУХҮЯ 2017-2020/

Бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайн хайгуул, ашиглалтын ажлын жилийн төлөвлөгөө, төсөвт байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын төлөвлөгөө, төсвийг тогтмол суулган баталж байгаа ба гэрээлэгчид байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх хууль, журмын дагуу байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх менежментийн төлөвлөгөө, хэрэгжилтийн тайланг БОАЖЯ-аар батлуулсан. “Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг нөхөн сэргээх ажлын үр дүнг хүлээн авах” журмыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд болон Байгаль орчин, аялал жуулчлалын сайд нарын 2018 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн А/50, А/31 тоот хамтарсан тушаалаар батлуулсан ба Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэдэх Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 2018 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 3870 дугаарт бүртгүүлсэн. Тус журмын хэрэгжилтийг хангуулан, холбогдох байгууллагуудтай хамтран хяналт тавьж ажиллах тухай албан бичгийг 2018 оны



03 дугаар сард АМГТГ-г хүргүүлсэн. Нөхөн сэргээсэн газар, эвдэгдсэн газрын хэмжээний талаар компаниуд нь Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын тайландаа мэдээ оруулж, тайлагнаж байна.

Бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайд үйл ажиллагаа явуулж буй гэрээлэгч компаниуд жил бүр “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-г БОАЖЯ-аар батлуулж, төлөвлөгөөний дагуу байгаль орчныг хамгаалах болон нөхөнсэргээх ажлыг хийж гүйцэтгэдэг. 2019 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-г Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас энэ оны 7, 8 дугаар сард баталсан. 2019 оны 9 дүгээр сарын 20-ны байдлаар Байгаль орчны ажил дараах явцтай байна. Үүнд: Тосон-Уул XIX талбайд ахуйн шингэн хаягдлыг цэвэршүүлэх байгууламжийн шинэчлэл, өрмийн шаврын санд техникийн нөхөн сэргээлт хийх, ариутгал халдваргүйжүүлэлт хийх, байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, хатуу хог хаягдлын менежментийн ажлууд хийгдэж байна. Байгаль орчны мониторинг хийх, Биологийн нөхөн сэргээлт хийх, ургамалжуулах, Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийх, Дүйцүүлэн хамгаалал, Гүний усны мониторингийн багаж суурилуулах зэрэг ажлууд гэрээлэлтийн шатанд явж байна. Тамсаг XXI талбайд Замын тэмдэг, тэмдэглэгээ тавих ажил хийгдэж дууссан. Байгаль орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр, техникийн нөхөн сэргээлт, биологийн нөхөн сэргээлтийн ажлууд хийгдэж байна. Биологийн нөхөн сэргээлт, үйлдвэрлэлийн шингэн хаягдлын санг саармагжуулах, нөхөн сэргээх, ариутгал халдваргүйжүүлэлт, хөрсний дээж авах, шинжлүүлэх ажлыг гүйцэтгэж байна. Дорнод аймгийн 11 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2019 оны 11 дүгээр сарын 22-24-ний өдрүүдэд Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайд ажиллаж, Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-ний хэрэгжилтэд үнэлгээ хийж, Тосон-Уул XIX талбай 82 хувь, Тамсаг XXI талбай 84 хувийн үнэлгээтэй дүгнэгдсэн.

1997 оны БХГ-т талбайн 2019 оны “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө /БОМТ/”-г судалж, санал, зөвлөмж гарган Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 1 дүгээр сарын 6-ны өдрийн А-05 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн

төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах” журмын дагуу засварлуулан 2019 оны 5 дугаар сарын 30-ны өдөр Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлснээр 97 дугаар талбайн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-г 2019 оны 7 дугаар сарын 22-ны өдөр баталж, хэрэгжүүлсэн. (Биелэлт 70 хувь)

4.1.6.5-5. Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийг “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга”-д хамруулах /УУХҮЯ 2017-2019/

“Олборлох ил тод байдлын санаачилга”-д нэгдэх талаар гэрээлэгч компаниудад зөвлөмж хүргүүлсэн ба 2017 онд “Петрочайна Дачин Тамсаг” ХХК, “Петро Матад” ХХК, “Сентрал Азиан Петролиум Корпорэйшн Лимитед” ХХК-иуд уг санаачилгад нэгдсэн.

Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу газрын тосны хайгуул, олборлолтын үйл ажиллагаа явуулж буй бүх аж ахуйн нэгжийг “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга”-д 2018 онд хамруулсан. Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийг “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга”-д 2019 онд 12 компани, 2018 онд 11 компани, 2018 онд 11 компани хамруулсан. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны А/13 дугаар тушаалаар Эрдэс баялгийн гэрээний мэдээллийн цахим сангийн үр нөлөө, тогтвортой ажиллагааг дэмжих хүрээнд Газрын тосны эрлийн гэрээ болон Орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас бичил уурхай эрхлэгч нөхөрлөлтэй байгуулсан гэрээнүүдийг ил тод болгох ажлыг ажлын хэсгийн хүрээнд бэлтгэл ханган, цахим санд байршуулахад бэлэн болгосон. (Биелэлт 70 хувь)

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын 2016, 2017, 2018 оны тайлангийн нэгтгэлүүдийг гаргах ажлыг зохион байгуулж, жил бүрийн тайланг олон нийтэд ил тод мэдээлсэн. Эдгээр тайлантай <http://www.eitimongolia.mn/reconciliation-report> хаягаар танилцах боломжтой. 2019 оны тайланг нэгтгэн гаргах ажлыг 2020 онд зохион байгуулна. (Биелэлт 100 хувь)

**Долоо. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих чиглэлээр**

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 7 дугаар зорилтын хүрээнд нийт 6 үйл ажиллагаа, 18 арга хэмжээ хэрэгжүүлэхээс 14 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллав. Тус зорилтын хэрэгжилтийг тоймлон танилцуулбал:

4.1.7.1-1. Шийдвэр гаргах шатанд иргэний нийгмийн оролцоо, хяналтын талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэд үнэлгээ хийх ажлыг төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулах /АТГ, яам, агентлаг, аймаг, нийслэл дэх ГХУСАЗСЗ 2017-2018/

2017 онд зохион байгуулсан Авлигын эсрэг үндэсний чуулганы “Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийт, хэвлэл мэдээллийн болон төрийн бус байгууллагын оролцоо” салбар хуралдаан дээр “Авлигын тухай шинжлэх ухааны танин мэдэхүй ба иргэний боловсрол”, “Эрх мэдэл, их мөнгийг хянах нь: Авлигатай тэмцэхэд хараат бус хэвлэл мэдээллийн гүйцэтгэх үүрэг”, “Иргэний нийгмийн байгууллагуудын санаачилгыг нэмэгдүүлэх нь”, “Эрэн сурвалжлах сэтгүүл зүй, өнөөгийн хөгжил”, “Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэдийн оролцоо, хяналтыг бий болгох нь”, “Олон нийтийн оролцоо, хяналтыг бий болгох талаарх олон улсын туршлага” зэрэг 6 сэдвийн хүрээнд эрдэмтэн, судлаач, холбогдох байгууллагын төлөөлөл, гадаад улсын зочин, төлөөлөгчид илтгэл тавьж хэлэлцүүлгийн дүнд гарсан санал, санаачилгыг судлан хэрэгжүүлж байна.

Авлигатай тэмцэх газрын даргын 2017 оны а/185 тушаалаар Авлигын эрсдэлийн үнэлгээний аргачлал (уг аргачлалыг АТГ-ын даргын 2019.05.01-ны өдрийн А/40 дугаар тушаалаар шинэчлэн баталсан)-ыг баталж, уг аргачлалын дагуу 2018 онд 6 төрийн бус байгууллагаар 24 яам, агентлаг, 2019 онд 5 төрийн бус байгууллагаар төрийн өмчийн их, дээд сургууль, улсын төв эмнэлэг, төрийн өмчит хуулийн этгээд зэрэг 15 байгууллагын үйл ажиллагаанд авлигын эрсдэлийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулсан.

Түүнчлэн яам, агентлаг, аймаг, нийслэл дэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах

салбар зөвлөлөөс шийдвэр гаргах шатанд иргэний нийгмийн оролцоог хангах чиглэлээр тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Тухайлбал, Орхон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Эрүүл мэндийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам зэрэг байгууллага хуулийн төсөл, дүрэм, журам батлах, шийдвэр гаргахдаа нийгмийн түншлэгч талуудын оролцоог бүрэн хангаж, хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт талуудаас тэнцүү тооны төлөөлөл, эрдэмтэн, судлаач, төрийн бус байгууллагуудын төлөөллүүдийг оролцуулан тэдний саналыг тусгах зорилгоор хэлэлцүүлэг зохион байгуулсны үр дүнд “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого”-д төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх, эрүүл мэндийн салбарын хууль тогтоомж, үндэсний хөтөлбөр, тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжид иргэн, олон нийтийн дэмжлэгт хяналтыг хөгжүүлэх, оролцоог хангах, нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх, нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг иргэн, байгууллага, олон нийтийн хариуцлагатай оролцоонд түшиглэн хэрэгжүүлэхээр тусгасан.

Азийн сан “Либерал эмэгтэйчүүдийн Оюуны Сан” төрийн бус байгууллагатай хамтран “Авлигагүй нийгмийн төлөөх иргэдийн оролцоо” төслийн хүрээнд 2017 онд 9 аймагт авлигын эсрэг уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж байсан бол 2018 онд 13 аймагт авлигын эсрэг хэлэлцүүлэг зохион байгуулж, 280 хүнийг хамруулсан байна. Түүнчлэн эдгээр аймгуудад төрийн байгууллагын худалдан авах ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэлийн үйл ажиллагаанд хөндлөнгийн мониторинг хийж, зөвлөмж өгч, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж ажилласан.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг өнгөрсөн хугацаанд цаасаар авдаг байсан бөгөөд ихээхэн хэмжээний хөрөнгө энэ үйл ажиллагаанд зарцуулагддаг байсан юм. Тэгвэл Швейцарын хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр “Хотын засаглалыг сайжруулах төсөл”-ийг 2015 оноос хойш Нийслэлийн 87 хороонд хэрэгжүүлж, энэ хүрээнд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийх төсөлд иргэдийн саналыг цахим хэлбэрээр буюу ухаалаг утасны “SMART UB” аппликейшнаар авах боломжийг бүрдүүлэн 2019 онд албан ёсоор ашиглалтад оруулж, тухайн



жилийн эхний улиралд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийх ажлын саналыг цахим буюу ухаалаг утасны аппликейшнаар авдаг болсон нь иргэд, олон нийтийн оролцоог хангасан үр дүнтэй ажил болсон юм. Цаашид алдаа, эрсдэлийг тооцон шалгаж, боловсронгуй болгон Smart UB аппликейшнийг нийслэлийн хэмжээнд ашиглахаар төлөвлөсөн бөгөөд ингэснээр бодит мэдээ, судалгаан дээр үндэслэн төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, төсвийн үргүй зардлыг бууруулах, иргэд, олон нийтээс санал авах зардал хэмнэх, авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх зэрэг чухал ач холбогдолтой юм.

Монгол Улсын Авлигатай тэмцэх газрын үндсэн чиг үүрэгт авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон олон нийтэд авлигын хор аюулыг ухуулан таниулах ажил хамаардаг. Энэ хүрээнд АТГ-аас авлигатай тэмцэх бодлого, зорилтыг хэрэгжүүлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх, залуучуудын хандлагыг эерэг өөрчлөлт рүү чиглүүлэх, иргэдийн оролцоо, идэвх санаачилгыг дэмжих үйл ажиллагааны цуврал болгон “Авлигын эсрэг 2019” дижитал чуулганыг 2019 оны 11 дүгээр сард зохион байгуулав. Чуулганаар шударга ирээдүйг бий болгохыг хүссэн эрч хүчтэй, асуудлын шийдлийг олох тэмүүлэлтэй иргэд, залуучууд цуглан, зөв засаглал, шуурхай үйлчилгээ, дижитал гарц, олон нийт тэр дундаа залуучуудын оролцооны талаар үзэл бодлоо илэрхийлж, туршлага солилцсон юм.

Шийдвэр гаргах шатанд иргэний нийгмийн оролцоо, хяналтын талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэд үнэлгээ хийх ажлыг төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулах ажлын хүрээнд “олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх” үйл ажиллагааг сонгон үнэлгээ хийлгэхээр ажлын даалгаврыг боловсруулж, уг ажлыг төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулах бэлтгэл ажлыг хангалаа. (Биелэлт 30 хувь)

4.1.7.1-2. Иргэдийн оролцоо, санал, санаачилгыг нэгтгэх, төрийн бодлого, шийдвэр гаргахад тусгах боломжийг бүрдүүлсэн бизнес анализийн систем хөгжүүлэх /ХХМТГ, Үндэсний дата төв УТҮГ 2020-2022/

Хугацаа болоогүй тул үнэлээгүй.

4.1.7.1-3. Нийслэлийн хэмжээнд авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд иргэн, төрийн бус байгууллагын оролцоог хангах зорилтын хүрээнд “Ил тод Улаанбаатар Академи”-тай хамтран ажиллах /АТГ, нийслэлийн ЗДТГ, ГХУСАЗСЗ 2017-2019/

Нийслэлийн Засаг даргын дэргэдэх “Ил тод Улаанбаатар Академи-Зөвлөлдөх ардчиллын танхим”, Бүгд Найрамдахчуудын Олон Улсын Хүрээлэнтэй хамтран “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдлагын чадавхийг бэхжүүлэх нь” сургалтыг нийслэлийн Засаг даргын дэргэдэх 33 агентлагийн албан хаагчдыг хамруулан зохион байгуулсан. Мөн 2018 онд нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан тушаалтнуудыг манлайлал, харилцаа, удирдах ажилтны ёс зүй, багийн хамтын ажиллагаа болон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиудын үзэл санаа, агуулга, хэрэгжүүлэхэд анхаарах асуудлаар нэгдсэн ойлголт, мэдлэгийг олгох зорилгоор сургах, мэргэшүүлэх чиглэлээр олон улсын байгууллага, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллав.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын санаачилгаар Авлигатай тэмцэх газар, “Ил тод Улаанбаатар академи” хамтран нийслэлийн төр, захиргааны байгууллагын 110 гаруй албан хаагчдад төрийн албаны үнэт зүйлийг эрхэмлэн дээдлэх, ёс зүйг дээшлүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байлгах чиглэлээр мэдлэг олгож чадавхжуулах ёс зүйн форумыг зохион байгуулсан. Форумд “Азийн сангийн судалгааны дүн, баримт дүгнэлт, “Шударга ёс ба үнэт зүйлс”, “Ёс зүйн чиг хандлага ба хариуцлага” зэрэг сэдвээр илтгэл сонсч харилцан туршлага солилцон, ёс зүйн түвэгтэй асуудал тулгарахад хэрхэн зөв гарц гаргалгааг олох чиглэлээр хэлэлцэв. (Биелэлт 30 хувь)

4.1.7.2-1. Төрийн бус байгууллагын үйл ажиллагааг ил тод, нээлттэй, тогтвортой, хууль тогтоомж боловсруулах үйл ажиллагаанд оролцох эрхийг нь баталгаажуулах зэрэг чиглэлээр Төрийн бус байгууллагын тухай хуулийг боловсронгуй болгох /ХЗДХЯ 2017-2019/

Төрийн бус байгууллагын тухай хуулийг шинэчлэн найруулах хэрэгцээ, шаардлагыг тандан судалсан судалгааг Хууль зүй, дотоод хэргийн яам, Швейцарийн хөгжлийн агентлагийн хамтран хэрэгжүүлсэн “Иргэдийн оролцоо II” төслийн дэмжлэгээр “Баасанжав Консалтинг” ХХК-иар гүйцэтгүүлсэн. Энэхүү судалгаагаар Төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх тухай болон нийтэд тустай үйл ажиллагааны тухай хуулийн төсөл боловсруулах ажлыг Төрийн бус байгууллагын тухай хуулийг шинэчлэн найруулах хүрээнд авч үзэх нь зүйтэй гэж үзсэн тул тус хуулийн төслийг боловсруулах ажлыг нэгтгэн зохион байгуулахаар шийдвэрлэсэн.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. Тус хуулийн төсөлд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Хүний эрхийн Үндэсний комисс болон яамд, холбогдох байгууллагуудаас санал авч тусгасны зэрэгцээ иргэд, олон нийт, судлаачид болон холбогдох төрийн байгууллага, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулсан нээлттэй хэлэлцүүлгийг 2018 оны 10 дугаар сард зохион байгуулан хэлэлцүүлгээс гарсан саналуудыг нэгтгэн, судалгаа хийж нэгтгэн дүгнэж, хуулийн төсөлд нэмэлт боловсруулалт хийсэн.

Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай хуулийн төсөл болон дагалдах 140 хуулийн төслийг боловсруулж ажлын хэсгийн 2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Хуулийн төсөлд Ардчиллын боловсрол төв, Нээлттэй нийгэм форумтой хамтран 2019 оны 05 сарын 28, 6 сарын 06, 11, 18, 21-ний өдөр, 10 сарын 11-ний өдөр тус тус нийтэд хэлэлцүүлж, төрийн болон төрийн бус байгууллагуудаас саналыг авч хуулийн төсөлд тусган 2019 оны 12 дугаар сарын 02-ны өдөр УИХ-аар хэлэлцүүлэхээр өргөн барьсан. (Биелэлт 70 хувь)

4.1.7.2-2. Төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааны чиглэл, үүсгэн байгуулагч, гишүүдийн мэдээлэл, хандив, орлого, зарлагыг олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлэх механизмыг бүрдүүлэх /ОӨУБЕГ, ТББ 2019-2020/

Монгол Улсын Их Хурлын 2018 оны хаврын ээлжит чуулганаар баталсан Улсын бүртгэлийн багц хуулиуд 2018 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлснээр хуулийн этгээдийн нэр, хаяг, регистрийн дугаар, төрөл, хэлбэр, үйл ажиллагааны чиглэл, улсын бүртгэлд бүртгэсэн огноо, үүсгэн байгуулагчийн нэр, тэдгээрийн тоо, хувьцаа эзэмшигчийн нэр, итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээдийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хуулийн этгээд өөрчлөн байгуулагдсан эсэх, хэлбэр, оноосон нэр өөрчлөгдсөн, татан буугдсан талаарх мэдээллийг нээлттэй болгосон. 2019 оны 9 дүгээр сараас төрийн бус байгууллагын анхны үүсгэн байгуулагч, эцсийн өмчлөгч, удирдах зөвлөлийн дарга, гишүүдийг улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэж эхэлсэн. Тайлант хугацаанд нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага 19304, гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага 2962, нийт 22266 төрийн бус байгууллага улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэлтэй байна. Төрийн бус байгууллагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу төрийн бус байгууллага үйл ажиллагааныхаа тайланг тухайн байгууллагад ирүүлэхээр заасны дагуу 2019 онд 366 төрийн бус байгууллагын тайланг Улсын бүртгэлийн ерөнхий газар хүлээн авч нэгтгэн ажилласан.

Улсын Их Хуралд хэлэлцүүлэхээр 2019 онд өргөн барьсан Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай хуулийн төсөлд ашгийн төлөө бус хуулийн нөөц, санхүүжилтийн тогтвортой байдлыг хангахад анхаарч, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх, төлбөртэй үйлчилгээ үзүүлэх, орлогыг дүрэмдээ заасан зорилгодоо зарцуулах нөхцөл, журмыг нарийвчлан тодорхойлсон. Мөн хуулийн этгээд хуульд заасны дагуу санхүүжилтээ бүрдүүлэх үүрэгтэй бөгөөд эх үүсвэр нь хувь хүн, хуулийн этгээдээс өгсөн хандив, гишүүдийн татвар, үйл ажиллагааны орлого, төрөөс үзүүлсэн дэмжлэгийн хэлбэртэй байх, төрийн чиг үүргийг гэрээлэн гүйцэтгэсэн, эсхүл олон улсын хөгжлийн байгууллагуудаас санхүүжилт авсан бол санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг олон нийтэд ил тод нийтлэх үүрэгтэй байхаар тусгасан болно. (Биелэлт 70 хувь)



4.1.7.2-3. Төрийн бус байгууллагуудын мэдээллийн идэвхтэй солилцоог бий болгох, хоорондын үйл ажиллагааг уялдуулах зорилгоор авлигын эсрэг төрийн бус байгууллагуудын сүлжээ, түншлэлийг дэмжих /АТГ 2018-2020/

Авлигатай тэмцэх газар нь Монгол Улсад залуусын оролцоо, манлайлал, ёс зүйн чиглэлээр манлайллын хөтөлбөр, сургалт, нөлөөллийн арга хэмжээ идэвхтэй зохион байгуулдаг ТББ-уудтай хамтран ажиллав. Эдгээрт “World learning” ТББ-ын Монгол дахь төлөөлөгчдийн газраас хэрэгжүүлсэн “Lead Mongolia” хөтөлбөрийн манлайлагч залуусын “Эрүүл мэндийн салбарын ил тод байдлыг дэмжих” болон “Залуусын шударга байдлыг нэмэгдүүлэх зорилгоор ажиллах” багийн гишүүдтэй хамтран ажиллаж хүүхэд, оюутан залуусын дунд авлигаас ангид байх, шударга ёс түгээн дэлгэрүүлэх “Гэрэл тусгая” богино хэмжээний видео бүтээх уралдааныг зохион байгуулах, дүгнэх нэг болон хоёрдугаар шатны шалгаруулалтад оролцож, цааш нь түгээх санал санаачилгыг дэмжин ажиллав. “Зориг сан”-аас оюутан залуусыг хамруулан хэрэгжүүлж буй манлайллын хөтөлбөрт авлигын эсрэг сэдвийг тусгаж, хамтран ажилласан ба энэ хүрээнд “Ардчиллын элч” залуусын манлайллын хөтөлбөрт хамрагдагчдад авлигын ойлголт, шалтгаан, хор уршиг сэдвээр сургалт хийж чадавхижуулахад нь дэмжлэг үзүүлэв.

“Монголын залуучуудын холбоо”, “Монголын оюутны холбоо”, “Монголын Сурагчдын Холбоо” ТББ-тай байгуулсан санамж бичгийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хамтран ажиллах тусгайлсан төлөвлөгөө хэрэгжүүлсэн.

Авлигатай тэмцэх бодлого, зорилтыг хэрэгжүүлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх, шинэ залуу үеийн хандлагыг эерэгээр өөрчлөх, иргэдийн оролцоо, идэвх санаачилгыг дэмжих зорилгоор “Авлигын эсрэг 2019” дижитал чуулганыг Авлигатай тэмцэх газраас төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгууллаа. Чуулганаар шударга ирээдүйг хүссэн эрч хүчтэй, асуудлын шийдлийг олох тэмүүлэлтэй иргэд, залуучууд цуглан зөв засаглал, шуурхай үйлчилгээ, дижитал гарц, олон нийт, тэр дундаа залуучуудын оролцооны талаар үзэл бодлоо илэрхийлснээрээ ач холбогдолтой байлаа.

Энэхүү арга хэмжээнд 13 сэдвийн хүрээнд асуудал, шийдэл, туршлагаа танилцуулсан ба илтгэгчид нь өөрийн ажиллаж буй салбартаа туршлагатай, мэдлэгтэй, амжилттай ажиллаж байгаа мэргэшсэн мэргэжилтэн байсан нь онцлог байв. Оролцогчдын бүртгэлийг дижиталаар зохион байгуулсан бөгөөд 350 гаруй залуус өөрсдийн хүсэл, сонирхлын дагуу хүрэлцэн ирж оролцсон бөгөөд нийслэлийн Мэдээлэл, технологийн газар болон иргэд, аж ахуйн нэгжүүд төрийн үйлчилгээг цахимаар авах нөхцөлийг бүрдүүлсэн тээврийн хэрэгслийн нэгдсэн цахим үйлчилгээний [www.smartcar.mn](http://www.smartcar.mn), нийслэлийн цахим үйлчилгээний [ulaanbaatar.mn](http://ulaanbaatar.mn), цэцэрлэгийн цахим бүртгэлийн [tsetserleg.ulaanbaatar.mn](http://tsetserleg.ulaanbaatar.mn), дотоод удирдлагын [www.erp.ulaanbaatar.mn](http://www.erp.ulaanbaatar.mn) зэрэг системүүдээ сурталчлан танилцуулж, газар дээр нь үйлчилгээг үзүүлэв. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан тодорхой асуудлаар судалгаа, дүн шинжилгээ, үнэлгээ хийлгэх ажлыг салбар салбарын төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлэн, үр дүнг үйл ажиллагаандаа ашиглан хамтран ажиллаж байна. (Биелэлт 30 хувь)

4.1.7.3-1. Төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бүрдүүлэх /АТГ 2017-2019/

Хууль зүй, дотоод хэргийн яам нь харьяа агентлаг, байгууллагын 2017 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний мөрөөр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Ажиглалт” нийгэмд үйлчлэх төрийн бус байгууллагаар “Хэсгийн байцаагч, төлөөлөгч, замын цагдаа, мөрдөгч, хэрэг бүртгэгчийн ажлын ачаалал, үр дүнг тодорхойлуулах” судалгаа, IRIM хараат бус судалгааны хүрээлэнгээр “Төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдал”-д хяналт шинжилгээ хийх ажлуудыг тус тус гүйцэтгүүлсэн байх ба тайланг хэлэлцэж, ТББ-аас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Авлигатай тэмцэх газраас 2018 онд хууль зүй, санхүү, барилга, байгаль орчин, аялал жуулчлал, уул уурхай, хүнс, хөдөө аж ахуй зэрэг чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодтой тулгамдаж буй асуудал, цаашид хамтран ажиллах боломж,

чиглэлийг тодорхойлох зорилгоор цуврал хэлэлцүүлгийг зохион байгуулж, төрийн байгууллагуудын үйл ажиллагаан дахь авлигын эрсдэлийг бууруулах, үйл ажиллагааны нээлттэй, ил тод болгох чиглэлээр хамтран ажиллахаар тогтсон. Эдгээрээс гадна Монголын “Залуучуудын холбоо”, “Монголын оюутны холбоо”, “Монголын сурагчдын холбоо”, “Глоб интернешнл” зэрэг төрийн бус байгууллагатай Санамж бичиг байгуулан хамтран ажиллав.

Төрийн байгууллагын авлигын эрсдэлийн үнэлгээний аргачлалын дагуу 2018 онд 6 төрийн бус байгууллагаар 24 яам, агентлаг, 2019 онд 5 төрийн бус байгууллагаар төрийн өмчийн их, дээд сургууль, улсын төв эмнэлэг, төрийн өмчит хуулийн этгээд зэрэг 15 байгууллагын үйл ажиллагаанд авлигын эрсдэлийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулсан.

Төрийн байгууллага, албан тушаалтны аливаа шийдвэр гаргах ажиллагааны ил тод байдлыг хангах, төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийн хэрэгжилт, ил тод байдалд иргэд, олон нийтийн хяналт тавих, мэдээлэл авах эрхээ эдлэхэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр авлигаас урьдчилан сэргийлэх зорилгоор Иргэний хяналтын зөвлөлийн 124 гишүүнийг 21 аймаг, яам агентлаг, нийслэл, дүүргийн хэмжээнд гэрээ байгуулан ажилуулав. Иргэний хяналтын зөвлөлийн гишүүд Авлигатай тэмцэх газраас 2018-2019 оны хичээлийн жилийн сургууль, цэцэрлэгийн элсэлттэй холбогдуулан хүргүүлсэн зөвлөмжийн биелэлттэй танилцах зорилгоор 2018 оны 9 дүгээр сард нийслэлийн 1, 23, 24, 11, 84, 79, 107, лаборатори Шинэ эрин, Шинэ эхлэл сургууль, 2, 19, 16 дугаар цэцэрлэгүүдэд ажиллаж тухай боловсролын байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа дүрэм журам, гаргасан тушаал шийдвэр, сурагчдын хувийн хэрэг, хүлээн авч шийдвэрлэсэн өргөдөл, гомдол, мэдээлэлтэй танилцаж, хяналт тавьж ажилласан.

Иргэд, олон нийтээс төрийн байгууллага, албан тушаалтны хүнд сурталтай үйлчилгээ, авлига, ашиг сонирхлын зөрчил, авлигын гэмт хэргийн талаар гомдол, мэдээлэл хүлээн авах, эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл өгөх зорилго бүхий 4 “Иргэний хяналтын төв”-ийг Дүнжингарав худалдааны төв, Мишээл Экспо, Драгон төв, 6 буудал дахь Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвүүдэд нээн 8 иргэнийг ажилуулж байна. Үг

төвий үйл ажиллагааг Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөл хариуцан, хяналт тавьж, удирдлагаар хангаж ажиллаж байна.

Авлигатай тэмцэх газраас жил бүр гаргадаг Шударга байдлын үнэлгээгээр яамдын дундаж үнэлгээ 2015 онд 72.3, 2016 онд 69.1, 2018 онд 69.0, 2019 онд 74.1 гэсэн үзүүлэлттэй гарсан бөгөөд дунджаас доогуур үнэлэгдсэн байгууллагын үйл ажиллагаанд иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангаж, тулгарч буй асуудал, бэрхшээлийг тэдний дэмжлэгтэйгээр шийдвэрлэх, тухайн салбар дахь авлига, ашиг сонирхлын зөрчлийг багасгах талаар зарим байгууллагад зөвлөмж хүргүүлсэн. Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн явцад иргэн, иргэний нийгмийн байгууллага, сонирхогч этгээдээс хяналт тавих боломжийг олгох, ил тод нээлттэй байдлыг хангаж ажиллах зөвлөмжийг 21 аймагт хүргүүлсэн. (Биелэлт 70 хувь)

4.1.7.3-2. Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, төсвөөс олгож байгаа санхүүжилтийн зарцуулалтыг ил тод, нээлттэй болгож нийтэд мэдээлэх /ЗГХЭГ, аймаг, нийслэлийн Засаг дарга 2018-2022/

Чиг үүргийн давхардал, хийдлийг арилгах, төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолын хавсралтаар “Чиг үүрэг дахин хуваарилах аргачлал”-ыг батлан, Швейцарийн хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр хэрэгжиж буй “Төвлөрлийг сааруулах бодлогын дэмжлэг” төслийн хүрээнд төрийн захиргааны төв байгууллагуудын чиг үүрэгт шинжилгээ хийх ажлыг зохион байгуулж дуусаад байна.

Барилга, хот байгуулалтын яам Барилгын салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох сургалт эрхлэх чиг үүрэг, Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүргийг, Сангийн яам мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох чиг үүргийг, Татварын мэргэшсэн зөвлөхийн үйлчилгээ, нягтлан бодох бүртгэлийн програм хангамжийн үйлчилгээ, худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх АЗ гэрчилгээ олгох сургалт хийх зэрэг чиг



үүргийг төрийн бус байгууллагуудад тус тус шилжүүлсэн. Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт хооронд байгуулсан “Төрийн байгууллагын зарим чиг, үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх гэрээ”-ний хэрэгжилтэд дотоод аудит хийж үйл ажиллагаа болон чиг үүргийн хэрэгжилтийг сайжруулах зорилгоор Сангийн яаманд 12 зөвлөмж, Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтэд 6 зөвлөмжийг тус тус өгч ажилласан.

Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/25 дугаар тушаалаар “Эрүүл мэндийн салбарын зарим ажил, үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх журам”-ыг баталсан. Уг журмын дагуу эрүүл мэндийн тухай хууль, тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, эрүүл зан зан үйл төлөвшүүлэх, эрүүл мэндийн боловсрол олгох мэдээлэл, сургалт, сурталчилгаа, магадлан итгэмжлэл олгох үйл ажиллагаанд оролцох, эмийг бүртгэх, баталгаажуулах, эмийн чанар, аюулгүй байдлын талаар нийтэд мэдээлэх үйл ажиллагаанд оролцож, санал өгөх, эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага, үйл ажиллагааны стандартын хэрэгжилт, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах, иргэний гомдол, саналын мөрөөр хяналт тавих, үнэлэх үйл ажиллагаанд оролцож санал өгөх зэрэг үйл ажиллагааг Төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэхээр журамласан байна.

Авлигатай тэмцэх газраас Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д “Засгийн газар нь төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийн холбогдох хууль, түүнд үндэслэн Засгийн газрын шийдвэр, гэрээний үндсэн дээр Засгийн газрын бус байгууллагад хариуцуулан, гүйцэтгүүлж, холбогдох зардлыг бүрэн буюу хэсэгчлэн санхүүжүүлж болно” гэж заасан ба төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлж байгаа төрийн бус байгууллагын үйлчилгээний үр дүн, үр нөлөөнд хяналт-шинжилгээ хийх ажлыг 2019 онд “JBM social research consulting” ХХК-аар гүйцэтгүүлсэн. Хяналт-шинжилгээний ажлын тайлангийн мөрөөр холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Мөн Авлигатай тэмцэх газар нь Барилга, хот байгуулалтын яамтай хамтран салбарын яам, агентлагийн асуудал хариуцсан нэгжийн удирдлагууд, барилгын салбарын

ТББ-ын төлөөлүүд, барилгын компанийн удирдлагуудыг оролцуулан “Мэргэжлийн холбоодод шилжүүлсэн барилгын тусгай зөвшөөрлүүд: Асуудал, шийдэл” сэдэвт хэлэлцүүлгийг 2019 онд зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт Авлигатай тэмцэх газар, Барилга, хот байгуулалтын яам, Барилгын хөгжлийн төв, Монголын барилгын үндэсний ассоциацийн төлөөлүүд “Барилгын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг ТББ шилжүүлсэн болон цаашид энэ чиглэлээр хэрэгжүүлэх бодлого”, “Барилгын салбарын бүртгэл мэдээллийн нэгдсэн санг тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаатай уялдуулах нь”, “Төрийн чиг үүргийг хувийн хэвшил, мэргэжлийн холбоодод шилжүүлсэн туршлага, ололт амжилт, тулгарч буй зарим бэрхшээл” зэрэг сэдвүүдээр илтгэл хэлэлцүүлж, асуудлыг тоо баримт, мэдээлэлд тулгуурлан ярилцаж, учирч буй хүндрэл бэрхшээл, түүнийг шийдвэрлэх арга зам, төр, хувийн хэвшлийн байгууллагын хамтын ажиллагаа зэрэг сэдвүүдийг хэлэлцэв. (Биелэлт 70 хувь)

4.1.7.3-3. Төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэж байгаа ТББ-ын үйл ажиллагаанд мониторинг хийж, дүнг олон нийтэд мэдээлэх, түүний мөрөөр холбогдох арга хэмжээ авах /ЗГХЭГ, ХЗДХЯ, холбогдох бусад яам, ТББ 2020-2022/

Хугацаа болоогүй тул үнэлээгүй.

4.1.7.4-1 Орон нутаг дахь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл болон яам, агентлагийн дэргэд авлигаас урьдчилан сэргийлэх олон нийтийн хяналтын дэд зөвлөлийг байгуулан ажиллуулах /АТГ, ХЗДХЯ 2017-2022/

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр болон Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дэргэд иргэдийн хяналтын зөвлөлийг байгуулан ажиллуулахаар тусгагдсаны дагуу орон нутаг дахь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл болон яам, агентлагийн дэргэд төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт тавих, мэдээлэл



авах эрхээ эдлэхэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр ажиллах чиг үүрэг бүхий авлигаас урьдчилан сэргийлэх Иргэний хяналтын зөвлөлийг 2017 онд байгуулсан. 2018 оны 12 дугаар сарын 30 байдлаар Иргэний хяналтын зөвлөлийн 124 гишүүн, 2019 оны 04 дүгээр сарын 30-ны байдлаар Иргэний хяналтын зөвлөлийн 124 гишүүнийг 21 аймаг, яам, агентлаг, нийслэл, дүүргийн хэмжээнд гэрээний дагуу ажиллуулж байсан бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн сайд, Авлигатай тэмцэх газрын даргын 2017 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн А/53, А/44 тоот тушаалаар баталсан “Аймаг, нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл болон Засгийн газрын яам, агентлагийн дэргэд авлигаас урьдчилан сэргийлэх үүрэг бүхий Олон нийтийн дэд зөвлөлийн ажиллах журам” хүчингүй болсонтой холбоотойгоор уг зөвлөлийн үйл ажиллагаа зогссон. (Биелэлт 70 хувь)

#### 4.1.7.4-2. Олон нийтийн дэд зөвлөлийн гишүүдийг сургах, чадавхжуулах /АТГ 2017-2022/

Аймаг, нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл болон яам, агентлагийн дэргэд ажиллах Авлигаас урьдчилан сэргийлэх Иргэний хяналтын зөвлөлийн гишүүдийг 2017 онд 20 сэдвийн хүрээнд нийт 13.5 цагийн “Олон нийтийн хяналт ба хамтын ажиллагаа” сэдэвт, 2018 онд худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх А3 сертификатын эрх олгох сургалт, сургагч багшаар бэлтгэх зорилгоор “Төрийн албаны ёс зүй”, “Нийтийн албанд ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах нь” сэдэвт сургалт, Удирдлагын академийн 2 модулийг турших сургалт, “Эрүүл мэндийн салбар дахь төрийн үйлчилгээ, анхаарах асуудлууд”, “Эрүүл мэндийн салбар дахь авлигын нөхцөл байдал”, “Эрүүл мэндийн салбарт ажиллах чиглэл” гэсэн үндсэн 3 сэдвээр сургалтын хөтөлбөр боловсруулж, онлайн хэлбэрээр 2 удаагийн сургалтуудад тус тус хамруулсан.

Иргэний хяналтын зөвлөлийн 152 гишүүдийг чадавхжуулах сургалтыг 2019 оны 01, 05 дугаар саруудад зохион байгуулан энэ хүрээнд “Авлига, ашиг сонирхлын зөрчлийн хяналт шалгалт, үр нөлөө”, “Нээлттэй мэдээллийг ашиглаж албан тушаалтанд хяналт тавих нь”, “Цахим худалдан авалтын үйл ажиллагаа: Хөндлөнгийн хяналт,

арга зам”, “Төсвийн төлөвлөлт ба үр ашгийг хянах арга зүйд суралцах нь”, “Төсвийн үйл явцад иргэдийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлэх арга зам, туршлага”, “Худалдан авах ажиллагаанд дахь авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх нь” зэрэг сэдвээр сургалт хийж, иргэний хяналтыг орон нутагт бэхжүүлэх чиглэлээр ажиллах иргэдэд тусгайлсан мэдлэг, мэдээлэл, арга зүйд сургасан. (Биелэлт 100 хувь)

#### 4.1.7.4-3. Олон нийтийн дэд зөвлөлийн ажиллах журмыг батлуулж, мөрдөх /АТГ 2017/

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Авлигатай тэмцэх газрын даргын 2017 оны А/53, А/44 тоот тушаалаар баталсан “Аймаг, нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл болон Засгийн газрын яам, агентлагийн дэргэд урьдчилан сэргийлэх үүрэг бүхий Олон нийтийн дэд зөвлөлийн ажиллах журам”-ыг баталсан. Энэхүү журмыг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжих болсонтой холбогдуулан хүчингүй болгосон ба уг хуульд нийцүүлэн Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журмыг боловсруулахаар болсон. (Биелэлт 100 хувь)

#### 4.1.7.5-1. Авлигын тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлийн ажиллах журмыг боловсронгуй болгох /АТГ-ын дэргэдэх ОНЗ 2018/

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн 30 дугаар зарлигаар “Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлийн ажиллах журам”-ыг шинэчлэн баталсан. Энэхүү журмын хоёрдугаар зүйлийн 2.1-д зөвлөл олон нийтийг төлөөлөх хэрэгжүүлэх асуудлаар авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцах, үнэлэх, хэлэлцүүлэг, зөвлөгөөн, нийтийн сонсгол зохион байгуулах, төрийн байгууллага болон төрийн өмчит аж ахуйн нэгжид АТГ-аас хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийн явц, үр дүнтэй танилцах, авлигатай тэмцэх чиглэлээр явуулж буй бодлого, үйл ажиллагааг олон нийтэд тайлбарлан таниулах сургалт, сурталчилгааны ажилд оролцох зэрэг нийт 23 чиг үүргийг хэрэгжүүлэхээр тусгасан ба Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 186 дугаар



зарлигаар нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Энэхүү зарлигаар Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлд “Авлига, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэхэд чиглэсэн олон улсын болон үндэсний хөтөлбөр, төсөлд хамрагдах, оролцох” нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Мөн дээрх зарлигаар “Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлийн ажиллах журам”-ын 2.1.3-т “Хэлэлцүүлэг, зөвлөгөөн болон эрх бүхий байгууллага, албан тушаалтантай хамтрасан нийтийн сонсголыг зохион байгуулах замаар авлигатай тэмцэх үйл ажиллагаанд олон нийтийг оролцуулах” гэснийг “Хэлэлцүүлэг, зөвлөгөөн болон эрх бүхий байгууллага, албан тушаалтантай хамтарсан нийтийн сонсголыг зохион байгуулах замаар авлигатай тэмцэх үйл ажиллагаанд олон нийтийг оролцуулах, энэ хүрээнд Олон нийтийн дэд зөвлөлийг ажиллуулж болно” гэж өөрчлөн найруулжээ. (Биелэлт 100 хувь)

4.1.7.5-2. Олон нийтийн зөвлөлийн чадавхийг бэхжүүлэх, ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх, гишүүдийн урамшуулмын асуудлыг шийдвэрлүүлэх /АТГ, ХЗДХЯ, АТГ-ын дэргэдэх ОНЗ 2018-2020/

Олон нийтийн зөвлөлийн байрлах өрөө тасалгаа, албан хэрэгцээний тээврийн хэрэгслийн асуудлыг шийдвэрлэж, ажиллах нөхцөл боломжийг сайжруулсан.

2019 оны 12 дугаар сарын 10-ны өдөр Бүгд найрамдах Казакстан Улсад зохион байгуулсан Авлигын эсрэг олон улсын хуралд ОНЗ-ийн дарга Г.Баасан оролцож олон улсын авлигатай тэмцэх үйл ажиллагаа, тулгамдаж байгаа асуудлууд тэдгээрийг шийдвэрлэх арга замын талаар туршлага судалсан. Олон нийтийн зөвлөлийн болон Авлигатай тэмцэх газрын төлөөлөл Хонконгийн Авлигатай тэмцэх бие даасан хорооноос зохион байгуулсан 120 орны 200 байгууллагын 500 гаруй төлөөлөгчтэй долоо дахь удаагийн симпозиумд оролцон авлигатай тэмцэх ажлын ололт амжилт, саад бэрхшээл, мөн хүний эрхийг хэрхэн хангаж ажиллах талаар ярилцаж, өөрсдийн орны сайн туршлагаасаа хуваалцсан байна.

Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлийн гишүүдээс бүрдсэн ажлын хэсэг 2019 оны 08 дугаар сарын 12-26-ны өдрүүдэд Хэнтий, Дорнод, Сүхбаатар,

Говьсүмбэр аймгуудад ажиллаж Авлигатай тэмцэх газраас 2017, 2018 онуудад хүргүүлсэн “Зөвлөмж”-ийн биелэлттэй 9 чиглэлээр газар дээр нь танилцаж, мөн Авлигатай тэмцэх газраас эрхлэн гаргасан ном, гарын авлага, хэвлэмэл хуудсыг түгээж, аймаг бүрт 100 иргэн, сумдад 40 иргэнээс түүврийн аргаар судалгаа авч дүн гарган Авлигатай тэмцэх газарт зөвлөмж хүргүүлж, биелэлтэд хяналт тавин ажилласан. Олон нийтийн зөвлөлөөс иргэд, байгууллагаас өргөдөл, гомдол мэдээлэл хүлээн авч, Авлигатай тэмцэх газарт хүргүүлэн шийдвэрлэж, мэдээлэхийн зэрэгцээ тэдгээрийн хүсэлт, саналыг сонсч уламжлан шийдвэрлэлтэд хяналт тавьсан. (Биелэлт 70 хувь)

4.1.7.5-3. Олон улсын туршлагад тулгуурлан Олон нийтийн зөвлөлийн дэргэд Авлигын эсрэг иргэд, залуучуудын клубыг байгуулах /АТГ-ын дэргэдэх ОНЗ. АТГ 2018-2022/

Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлөөс Их Британийн Засгийн газраас 2010 онд ашигласан сайн туршлага болох авлигыг мэдээлэхэд хэрэглэж буй Мэдээлж, Жигш аргад тулгуурлан “Авлигыг мэдээлж, Жигш(АМЖ)” клубыг үүсгэн байгуулсан. Авлигыг мэдээлж, жигш буюу “АМЖ клуб” нь <https://www.facebook.com/naming.shaming> сувгийг ашиглан мэдээлэл хүлээн авч, олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигын эсрэг мэдээллийг олон нийтэд хүртээмжтэйгээр түгээх, ард иргэдийн санал бодлыг нийгмийн сүлжээгээр дамжуулан хүлээн авах, авлигаас ангид байх, авлигыг мэдээлэх арга замыг түгээн ажиллаж байна.

Өнгөрсөн хугацаанд Авлигын эсрэг болон шударга ёсны төлөө уриа бүхий 45 постыг facebook хуудсанд оруулсан нь 19400 хүнд хүрсэн ба клубын брошюр танилцуулга 2500 ширхэгийг хэвлэн тарааж, авлигын эсрэг олон улсын стандарт, тэргүүн туршлагыг судлах зэрэг ажлуудыг гүйцэтгэсэн байна.

Авлигын талаарх мэдээллийг хүлээн авах 110 дугаарын утсыг сурталчлах, авлигын эсрэг талаарх мэдээллийг иргэдэд хүргэх, хүртээмжийг сайжруулах, тэгш оролцоог хангахад хувь нэмрээ оруулж байгаа бөгөөд авлигатай тэмцэх хууль эрх зүйн орчинд үнэлэлт, дүгнэлт хийхээр мэдээлэл цуглуулж байна. Тус клуб нь олон улсын чанарын удирдлагын тогтолцоо ISO/MNS 9001:2015

стандартыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилладаг бөгөөд тус стандартыг дагаж мөрдөх нь “Авлигыг мэдээлж, Жигш” клубын давуу тал байх болно. Дээрх олон улсын стандарт нь тухайн байгууллага, клубын үйл ажиллагааны чанарыг удирдах, хянах тогтолцоо ба олон улсын стандартын шаардлагад нийцсэн болохыг баталгаажуулдаг бөгөөд байгууллагын үйл ажиллагаа хэрэглэгч, үйлчлүүлэгчийн эрэлт, шаардлагад нийцсэн байлгахад нь туслах зорилготой, дэлхийн 178 орны 1064000 байгууллагад хэрэгжсэн, дэлхийн хамгийн түгээмэл удирдлагын тогтолцооны стандарт юм. Цаашид авлигын эсрэг олон улсын стандарт, тэргүүн туршлагыг судалсан үр дүнг байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх, авлигагүй нийгэм, шударга ёсыг сурталчлах веб хуудас тогтмол ажиллуулах, нийгэмд шударга ёс тогтоох олон талын ажил санаачилж иргэдийн идэвхи оролцоог нэмэгдүүлэх зорилго тавин ажиллаж байна. (Биелэлт 70 хувь)

4.1.7.6-1. Авлигын улмаас төр, иргэн, олон нийтийн эрх ашигт эдийн засгийн хохирол учруулсан этгээдийг олон нийтэд ил тод мэдээлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх /АТГ, ХЗДХЯ, ШЕЗ, ТББ 2018-2019/

Захиргааны ерөнхий хууль болон Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/-д хохирлыг буруутай албан тушаалтнаар төлүүлэх эрх зүйн зохицуулалт орчин бүрдсэн, мөн шүүхийн шийдвэрийн нээлттэй ил тод байх зарчим үйлчилж байгаа учраас асуудлаар мэдээлэх боломж бүрдсэн. (Биелэлт 30 хувь)

4.1.7.6.-2. Авлигын улмаас төр, иргэн, олон нийтийн эрх ашигт учруулсан хохирлыг тухайн этгээдийн өмчийн хэлбэрийг харгалзахгүйгээр нөхөн төлүүлэх талаар нэхэмжлэл гаргах эрхийг төрийн бус байгууллагад олгох, нэхэмжлэлийг тэмдэгтийн хураамжаас чөлөөлөх асуудлыг судалж шийдвэрлүүлэх ХЗДХЯ, АТГ, ТББ 2020-2022/

Хугацаа болоогүй тул үнэлээгүй.

4.1.7.6-3. Авлига, албан тушаалын гэмт хэргийг мөрдөн шалгахад мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагын тусалцаа авах арга хэмжээг зохион байгуулах АТГ, ЦЕГ, мэргэжлийн холбоод, ТББ 2020-2022/

Хугацаа болоогүй тул үнэлээгүй.

### Найм. Иргэний мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан хуулийн хэрэгжилтийг хангах, мэдээллийн эрх зүйн орчин, сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр

Энэхүү зорилтыг хангах чиглэлээр нийт 5 үйл ажиллагаа, 9 арга хэмжээг хэрэгжүүлэхээс 9 арга хэмжээг хэрэгжүүлж байна. 2019 онд Зорилтын хэрэгжилтийг тоймлон танилцуулбал:

4.1.8.1-1. Баримтад суурилсан сэтгүүл зүйг хөхиүлэн дэмжих, сэтгүүлчдийн цахим орчинд мэдээлэл олж авах чадавхийг нэмэгдүүлэх /АТГ, ХХМТГ, МСНЭ, Хэвлэл мэдээллийн зөвлөл. 2018/

“Глоб интернешнл төв” ТББ байгууллагатай 2018 оны 03 дугаар сарын 19-ний өдөр “Хамтын ажиллагааны санамж бичиг” байгуулан ажиллаж байна. Уг санамж бичгийн хүрээнд “Авлигатай тэмцэхэд сэтгүүлчдийн үүрэг оролцоо” сэдэвт сургалтыг хэвлэл, мэдээллийн байгууллагын ажилтнуудыг хамруулан 2 жил дараалан зохион байгуулав. Монголын хэвлэл мэдээллийн зөвлөлтэй хамтран “Цахим сэтгүүл зүй ба мэргэжлийн ёс зүй” сэдвээр 30 сэтгүүлчид 2 өдрийн сургалтыг зохион байгуулав.

Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлээс санаачлан “Үндэсний сэтгүүл зүйн шинэ дэвшилтэт хөгжлийн төлөө” үзэл баримтлалын дор сэтгүүл зүйн хэвлэн нийтлэх эрх, түүний дотор шинэ тутам хөгжиж байгаа цахим сэтгүүл зүйн өмнө тулгамдаж байгаа асуудлыг хэлэлцэх, цахим салбарын сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн ажилтнуудын мэдээлэл олж авах, түгээх эрхтэй холбоотойгоор “Цахим сэтгүүл зүйн II форум”-ыг 2018 оны 5 дугаар сард зохион байгуулж, цахим орчин дахь мэргэжлийн сэтгүүл зүйн хөгжил, тулгамдсан асуудал, онлайн контентийн олон улсын зохицуулалт, нийгмийн сүлжээн дэх зохистой хэрэглээг бий болгох нь, цахим орчин дахь зохиогчийн эрхийн асуудал зэрэг сэдвийн хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлэв.

Монгол Улсын сэтгүүлзүйн салбарт хамгийн тулгамдаж буй асуудал бол “хуурамч мэдээлэл” юм. Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл, Солонгос сэтгүүлчдийн холбоотой хамтран “Хуурамч мэдээлэл ба төөрөгдөл-Иргэдийн



мэдэх эрхийг хамгаалах нь” сэдэвт анхдугаар чуулганыг 100 гаруй сэтгүүлчдийг хамруулан 2019 оны 06 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулаа. Дэлхий даяар маш хурдацтай хөгжиж буй Fact Check тогтолцоо, хуурамч мэдээллийг олон төрөл зүйлийн дэвшилтэт технологиор таних боломжийн талаар Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл Солонгосын сэтгүүлчдийн холбоотой хамтран «Fact Check” сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан.

Дижитал хувьслын нөлөөгөөр хэвлэл мэдээллийн редакцуудад тулгарч буй асуудалд шийдэл болох “Цахим орчинд хэвлэл мэдээллийн редакцийн баримтлах бодлого” баримт бичгийг Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс санаачлан боловсруулж, редакцуудад хүргүүлж эхэлсэн. Энэхүү баримт бичигт редакцууд сошиал медиатай хэрхэн харьцах тухай, сэтгүүлчид сошиал медиад “хоёр нүүр”-тэй байж болохгүй тухай, мөн нийтлэл, нэвтрүүлгээрээ үзэн ядалт, ялгаварлан гадуурхалтыг түгээхгүй байх, цахим орчинд сэтгүүлчийг үзэн ядалтын хохирогч болохоос хэрхэн сэргийлэх тухай зэргийг тусгасан болно.

МСНЭ-ээс санаачлан АТГ, ГХЯ, ХХЗХ, Жендерийн үндэсний хороо хамтран орон нутгийн сэтгүүлчдыг чадавхжуулах зорилгоор 2019 оны 04 дүгээр 20-22-ны өдрүүдэд “Орон нутгийн хэвлэл мэдээллийн II форум”-ыг 100 гаруй сэтгүүлч, уран бүтээлчдийг хамруулан зохион байгуулаа. Форумаар “Мэдээллийн аюулгүй байдал, орчин цагийн чөлөөт хэвлэлийн асуудал, сэтгүүлчдийн ур чадвар, орон нутгийн сэтгүүлчдэд тулгамдаж буй асуудал, сэтгүүл зүйн бичвэр түүнд тавигдах шаардлага, өргөн нэвтрүүлэг ба цахим орчны зохицуулалт, сошиал орчинд ажиллах, авлигын эсрэг сэтгүүлчдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх зэрэг сэдвээр мэргэжлийн багш, судлаачид сэтгүүлчдэд сургалт оров.(Биелэлт 30 хувь)

4.1.8.1-2. Эрэн сурвалжлах сэтгүүлч, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөлөлд сургалт зохион байгуулсан байх / АТГ, МСНЭ, Хэвлэлийн хүрээлэн, 2018-2020/

“Глоб интернешнл Төв” төрийн бус байгууллага эрэн сурвалжлах сэтгүүл зүйн гарын авлага, сургалтын хөтөлбөрийг Германы “Дойчэ Вилле

академи”-иас гаргасан модуль, арга зүйд тулгуурлан боловсруулж, АТГ-тай хамтран сэтгүүлчдэд “Авлигатай тэмцэхэд сэтгүүлчдийн үүрэг, оролцоо” сэдвийн дор 2 удаагийн модуль сургалтыг зохион байгуулсан байна. Эхний сургалтад 2018 оны 3 дугаар сарын 22, 23-ны өдөр эрэн сурвалжлах сэтгүүл зүйгээр мэргэших сонирхолтой 23 сэтгүүлчийг, 12 дугаар сарын 13-14-ний өдрүүдэд 17 сэтгүүлчийг нийт 40 сэтгүүлчийг хамруулж, чадавхжуулсан байна.

ЦЕГ-тай хамтран 2018 оны 9 дүгээр сарын 21-ний өдөр хэвлэл, мэдээллийн байгууллагын эрэн сурвалжлах сэтгүүлзүйн чиглэлээр дагнан ажилладаг сэтгүүлчдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх зорилгоор телевиз, сонин, сайт, богино долгионы (фм) радиогийн нийт 31 байгууллагын 36 сэтгүүлч мөн харьяа 12 агентлаг, байгууллагын хэвлэлийн төлөөлөгч нарыг хамруулан “Эрх зүйн сургалт, өдөрлөг” зохион байгуулсан. Мөн гэмт хэргийн талаарх олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхэд хэвлэл мэдээллийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 20 сэтгүүлч, энэ төрлийн гэмт хэргийн хохирогчдод үзүүлэх хууль зүйн туслалцааг сайжруулах зорилгоор 50 өмгөөлөгчийг мэргэшүүлэх сургалтад хамруулаа.

Авлигатай тэмцэх газраас авлигын болон бусад төрлийн гэмт хэргийг эрэн сурвалжлах, хууль зүйн мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх, чадавхжуулах зорилгоор “Бие даасан боловсрол, хөгжлийн төв” ТББ-тай хамтран эрэн сурвалжлах 90 орчим сэтгүүлчдэд 2 удаагийн сургалт (2019.04.08, 2019.04.26)-ыг зохион байгуулав. Сургалтаар авлигын гэмт хэргийн шинж, нийгмийн хор аюул, авлига ба эрэн сурвалжлах сэтгүүл зүйн олон улсын туршлага, чиг хандлага, оффшор бүс нутаг болон улс дамнасан санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа, олон улсын эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ, эрэн сурвалжлах ярилцлага хийх тактик, хөрөнгө оруулалтын гэрээ, түүн дэх авлигын эрсдэл, давхар татварын гэрээ, Засгийн газрын тусгай сангийн гэрээ гэх хүрээнд мэргэжлийн багш, судлаач, шинжээч, мөрдөгч нараар сургалт, хэлэлцүүлэг хийлгэж чадавхжуулав. (Биелэлт 70 хувь)

4.1.8.2-1. Сэтгүүлчдийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлсөн, дарамт, шахалт үзүүлсэн, заналхийлсэн тохиолдолд “Нөлөөллийн мэдүүлэг” гаргах, хууль бус нөлөөлөлд хариуцлага хүлээлгэх асуудлыг судлах, санал боловсруулах /МСНЭ, Хэвлэл мэдээллийн зөвлөл, АТГ, ХЗДХЯ. 2018-2019/

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсгээс Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хороо, Цагдаагийн ерөнхий газар, Хууль зүйн үндэсний хүрээлэн, МУИС-ийн Хууль зүйн сургууль, Хэвлэл мэдээллийн зөвлөл, “МОНЦАМЭ” мэдээллийн агентлаг, “Глоб интернэшнл төв” зэрэг байгууллагын төлөөллийг оролцуулж, санал хүсэлтийг авч, хуулийн төсөлд тусгасан.

АТГ, Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс сэтгүүлчдийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлсөн, шахалт үзүүлсэн, заналхийлсэн тоо баримтыг бүрдүүлэхээр нийслэл болон орон нутгийн 300 сэтгүүлчийн дунд санал асуулгын судалгааг явуулж, үр дүнг нэгтгэн гаргав.

Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэлээс сэтгүүлчийн эрхийг хангах, аливаа хууль бус нөлөөллөөс хамгаалах чиглэлээр мэргэшсэн хуульчдыг бэлтгэх зорилгоор өмгөөллийн байгууллагатай хамтран тодорхой ажлуудыг эхлүүлж, сэтгүүлчийг мэргэжлийн үйл ажиллагаатай нь холбогдуулан эрүүгийн хариуцлагад татдаг асуудлыг өөрчлөх зорилгоор Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг байгуулж, мэргэжлийн байгууллагуудтай цуврал хэлэлцүүлэг зохион байгуулсан.

2002-2017 онд гүтгэлэг, доромжлолыг Эрүүгийн хуулиар шийдэж ирсэн бөгөөд энэ хугацаанд 48 сэтгүүлч үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрхээ хэрэгжүүлсний төлөө эрүүгийн хуулиар шүүхэд дуудагдсан байдаг. Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс санаачлан эдгээр хэргүүдийг шүүх хэрхэн шийдвэрлэсэн болон зарим хэргүүдэд хараат бус судлаачаар нарийвчилсан дүн шинжилгээ хийлгэв.

Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс шүүгч, прокурор болон сэтгүүлчдэд зориулсан 4 удаагийн сургалт, уулзалт, ярилцлагыг зохион байгуулж, Зөрчлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн “гүтгэх”(6.21) зүйл нь гомдол маргааныг

шийдвэрлэх процессын хувьд учир дутагдалтай, сэтгүүлчдийг эрх зүйн хамгаалалтгүй орчинд торгуулийн ялаар шийтгэж байгаа нь хэвлэлийн эрх чөлөөнд халдаж, эдийн засгийн цензур дарамт болж байгаа зэрэг хүндрэл бэрхшээлийн талаар хэлэлцсэн байна. Хэвлэл мэдээллийн зөвлөл, МСНЭ, “Глоб” интернэшнл Төв” ТББ, Монголын хэвлэлийн хүрээлэн, Өдөр тутмын сонинуудын холбоо, Монголын телевизүүдийн холбоо зэрэг 15 хэвлэл мэдээллийн байгууллага, мэргэжлийн холбоод хамтран УИХ-д өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд 6 дугаар зүйлийн 6.21 дэх хэсгийг хасуулах саналыг тусгуулсан. (Биелэлт 30 хувь)

4.1.8.2-2. НҮБ-ын хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан, албан хаагч, сэтгүүлчдийн аюулгүй орчинг бүрдүүлэх уриалга, ЮНЕСКО-гоос Монгол Улсын Засгийн газарт ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулж тайлагнах /ГХЯ, 2017-2020/

НҮБ-аас гаргасан уриалга, ЮНЕСКО-гоос Монголын Засгийн газарт ирүүлсэн зөвлөмжийн дагуу сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах сургалт, бусад арга хэмжээ зохион байгуулснаас гадна гадаадын хэвлэл, мэдээллийн байгууллагын ажилтан, албан хаагч, сэтгүүлчдийн аюулгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэх үүднээс сурвалжлага, нэвтрүүлэг хийх гадаадын сурвалжлагчдын бүртгэлийн нэгдсэн санг бүрдүүлж, ГХЯ дээр бүртгэн, түр сурвалжлагчийн үнэмлэх олгож байна. Гадаадын сурвалжлагч Монгол Улсын нутаг дэвсгэрт ажиллах журмыг Засгийн газрын 2019 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар шинэчлэн батлуулав.

Сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хамгаалах, тэдний эсрэг гэмт үйлдэл, ял шийтгэлгүй үлдэж буй асуудлаарх НҮБ-ын үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, хадгалах, хамгаалах, сэргээн засварлах болон бусад харилцааг зохицуулсан хууль тогтоомжийн хэрэгжилт, үйл ажиллагааны талаар харилцан мэдээлэл солилцох, хамтран ажиллахаар ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисс, Улсын Ерөнхий прокурорын Тамгын газар хооронд 2017 онд “Санамж бичиг”-т гарын үсэг зурсан.



“Глоб Интернэшнл төв” ТББ-аас жил бүрийн 11 дүгээр сарын 2-ны өдрийг “Сэтгүүлчдийн эсрэг гэмт үйлдэл ял шийтгэлгүй үлдэж буйг таслан зогсоох өдөр” болгон зарласантай холбогдуулан 2017 онд “IFEX” олон улсын сүлжээний дэмжлэгтэйгээр “Аюулгүй, Хамгаалагдсан, Айдасгүй” сэдвийн дор хагас жилийн аян өрнүүлж, сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнуудын аюулгүй байдлыг хангах чиглэлээр гурван шторк бэлтгэн олон нийтийн сүлжээгээр түгээсэн ба энэ өдөр сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангахад тулгамдаж буй асуудлууд болон зөвлөмжийн хэрэгжилтийн талаар “АХА” хэлэлцүүлгийг зохион байгуулсан байна. Мөн 2018 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр Хэвлэл мэдээллийн зөвлөл, ГИТ, Монголын хуульчдын холбоо хамтран гүйцэтгэж буй Монголын хэвлэл мэдээллийн орчин, сэтгүүлчдийн аюулгүй байдлыг тодорхойлох судалгааны явцын мэдээллийг танилцуулж, сэтгүүлчдийн аюулгүй байдлын талаар хэвлэлийн бага хурал хийсэн. Энэ хүрээнд “Глоб Интернэшнл төв” ТББ-аас 2019 оны 11 сарын 1-ний өдөр “Үнэн амьд байгаа” хэвлэлийн бага хурал зохион байгуулж, хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлч, олон нийтэд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мэдээллийн хүртээмж, хэвлэлийн эрх чөлөө, сэтгүүлчдийн аюулгүй байдлын ач холбогдлын талаар мэдээлэл өгөв.

Авлигатай тэмцэх газраас “Глоб интернэшнл төв” төрийн бус байгууллагатай хамтран 2018 онд цагдаагийн байгууллагын албан хаагч, прокуроруудад зориулан соёлын өвийг хамгаалах, авлигаас урьдчилан сэргийлэх сэдвээр сургалтын гарын авлага, хөтөлбөрийг боловсруулж, сургалтыг 2019 онд эхний хагаст зохион байгуулав. Монголын Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлтэй хамтран 2019 онд дотоодын 80 гаруй сэтгүүлчийг гадаадын улс орнуудад богино хэмжээний чадавхжуулах сургалт, семинарт хамруулав.

Глоб интернэшнл төв, Монголын хуульчдын холбоо, Хэвлэл мэдээллийн зөвлөл хамтран Монгол дахь үзэл бодолтой байх, үзэл бодлоо илэрхийлэх эрхийн хэрэгжилтэд үнэлгээ өгөх, хэвлэл мэдээллийн өнөөгийн нөхцөл байдлыг тодруулах, сэтгүүлчдийн аюулгүй байдал ямар түвшинд байгааг тодруулах зорилгоор “Сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилтийн

мониторинг” 4 төрлийн бүлэг судалгааг 2019 онд хийж гүйцэтгэж олон нийтэд танилцуулсан байна.

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мэдээллийн хүртээмж, хэвлэлийн эрх чөлөө, сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хамгаалах чиглэлээр Глоб Интернэшнл төвөөс 1. НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлд илгээсэн Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг дэх Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний тайлангийн зөвлөмж, 2. Мэдээлэлтэй байх эрхийг хязгаарлаж буй хууль тогтоомжийн дүн шинжилгээний тайлангийн зөвлөмж, 3. Европын холбоо болон Монгол улсын Засгийн газар хооронд байгуулсан худалдааны хэлэлцээр болох GSP+ механизмын үр дүнтэй хэрэгжилтийг хангах замаар хүний эрхийн нөхцөл байдлыг сайжруулах зөвлөмжийг Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын Их Хуралд хүргүүлсэн байна.

Засгийн газраас боловсруулж, УИХ-д өргөн барьсан Эрүүгийн багц хуулийн төсөлд “гүтгэх” гэмт хэргийг Эрүүгийн хуульд нэмэлтээр оруулахаар болсон нь Монгол Улсын Үндсэн хууль болон түүнд нийцүүлэн гаргасан Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, түүнийг хэрэгжүүлэхээр НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс ирүүлсэн зөвлөмж, Монгол Улсын Засгийн газрын авсан амлалттай зөрчилдөж байна гэж үзэн хэвлэл мэдээллийн салбарын төрийн бус байгууллагууд нэгдэн Эрүүгийн багц хуулийн төслийн 13.14 “гүтгэх” заалтын томъёоллыг өөрчлөх санал боловсруулж, УИХ-ын Хууль зүйн байнгын хороонд хүргүүлж, төсөлд тусгуулсан. (Биелэлт 70 хувь)

4.1.8.3-1. Хэвлэлийн эрх чөлөөний хуулийг шинэчлэн боловсруулж, эрх зүйн орчинг сайжруулах /ХЗДХЯ 2017-2019/

Хэвлэл мэдээллийн байгууллагын бие даасан, хараат бус байдлын хангах, хэвлэлийн эрх чөлөөг хамгаалах эрх зүйн орчинг боловсронгуй болгох хүрээнд салбарын болон холбогдох чиглэлийн судлаач, мэргэжилтэн, иргэдийн төлөөллийг оролцуулан “Хараат бус сэтгүүл зүй” үндэсний форумыг МНСЭ-ээс 2018 оны 5 дугаар сард зохион байгуулж, сэтгүүл зүйн хөгжил, цаашдын хандлага, сэтгүүлчийн мэргэжлийн боловсрол, ажиллах орчин, нийгмийн асуудал зэрэг салбарын

хэмжээнд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх гарч, шийдлийг авч хэлэлцсэн. Түүнчлэн сэтгүүлч, хэвлэл мэдээллийн салбарын хараат бус байдлыг хангах чиглэлээр МСНЭ-ээс хэлэлцүүлэг, сургалтуудыг цувралаар зохион байгуулж ажилласан. Тухайлбал, “Ёс зүй, мэргэжлийн хараат бус сэтгүүл зүйг төлөвшүүлэх, сэтгүүлчдийн мэргэжил боловсролыг дээшлүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх нь” болон “Сэтгүүл зүйн салбарт санхүүгийн хараат бус байдлыг бүх түвшинд нэмэгдүүлэх” зорилгоор орон нутгийн салбар зөвлөлүүдийг идэвхижүүлэх 18 удаагийн уулзалтыг аймгуудад цуврал байдлаар зохион байгуулсан.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/233 тушаалаар Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. Хуулийн төслийг боловсруулахтай холбогдуулан Эстони, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Солонгос Улсын хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагааг зохицуулж байгаа хууль тогтоомж, онцлог эрх зүйн зохицуулалт, үйл ажиллагааны зохион байгуулалт зэргийг судалж Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн төслийн анхны хувилбарыг боловсруулсан байна.

Түүнчлэн хэвлэл мэдээлэл, сэтгүүл зүйн салбарын ахмад сэтгүүлч, судлаач, мэргэжлийн холбоод, хэвлэл мэдээллийн байгууллагын удирдлага, ажилтан, сэтгүүлчдээс бүрдсэн зорилтот хэлэлцүүлгүүдийг зохион байгуулан хуулийн төслийг танилцуулж, байр суурь, санал бодлоо солилцсон байна. Тухайлбал, Авлигатай тэмцэх газар, МСНЭ хамтран “Хараат бус сэтгүүл зүй ба хууль эрх зүйн шинэчлэл”/2019.10.18/, “Хэвлэл мэдээлэл, сэтгүүл зүйн салбарын хууль эрх зүйн шинэчлэл”/2019.11.18/ сэдэвт хэлэлцүүлэг, Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс “Сэтгүүл зүйн ёс зүйн форум 2019”- зэрэг зорилтот хэлэлцүүлгийг тус тус зохион байгуулсан байна. Хуулийн төслийг 2020 онд батлуулахаар ажиллаж байна.(Биелэлт 30 хувь)

4.1.8.3-2. Хэвлэл мэдээллийн байгууллагын эзэмшигч, хөрөнгө оруулагчийг олон нийтэд мэдээлж байх үүргийг хуульчлах, уг үүргийг биелүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгох /МСНЭ, ХМЗ 2020-2022/

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчлэн найруулгын төслийн 9 дүгээр зүйлд Хэвлэл мэдээллийн байгууллагын эзэмшлийн ил тод байдлыг хангах талаар, ялангуяа хуулийн этгээдийн нэр, хувийн хувьцаа эзэмшигчийн нэр, эзэмшиж байгаа хувьцааны тоо, хэвлэл мэдээллийн байгууллагын эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл санхүүгийн тайлан ил тод, нээлттэй байхаар тусгасан байна.(Хугацаа болоогүй)

4.1.8.4-1. Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд аливаа нийтлэл, нэвтрүүлэг, зар сурталчилгаа, мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэхтэй холбоотой ажлаа ил тод мэдээлэх, гүйцэтгэгчийг нээлттэй сонгон шалгаруулах эрх зүйн орчинг бүрдүүлэх /ХЗДХЯ. МСНЭ, Хэвлэл мэдээллийн зөвлөл. 2018-2022/

Монголын Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлээс сэтгүүл зүй, хэвлэл мэдээллийн салбарт мэдээ, мэдээлэл олж авах, хэвлэн шийтлэх, түгээх үйл ажиллагааг боловсронгуй болгох, мэдээлэл, үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах арга замыг тодорхойлох зорилгоор 2018 оны 3 дугаар сард “Цахим эрин ба сэтгүүл зүй, чиг хандлага” сэдэвт сэтгүүлч, сэтгүүл зүй судлаачдын IV симпозиумыг зохион байгуулсан.

Шилэн дансны тухай хуульд заасан төсөв, гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын болон бусад мэдээллийг байгууллага өөрийн цахим хуудсаар хүргэх бөгөөд шилэн дансны бие даасан цэстэй байхаар заасны дагуу байгууллага бүр шилэн дансны нэгдсэн цахим хуудаст холбогдон бие даасан цэс байршуулж, олон нийт байршуулсан мэдээлэлтэй танилцах, хяналт тавих боломжоор ханган ажиллаж байна.(Биелэлт 0 хувь)



4.1.8.4-2. Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хэвлэл мэдээллийн байгууллагаар хийлгэсэн сурталчилгаа нийтлэл нэвтрүүлэгт зарцуулсан хөрөнгө, хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчтэй хамтран ажиллах чиглэлээр байгуулсан гэрээг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд мэдээлэх ажлыг хэвшүүлэх, эрх зүйн орчин бүрдүүлэх /ХЗДХЯ, МСНЭ 2019/

Сангийн яамнаас Монгол Улсын Их Хурлаас баталсан 2018 оны төсвийн тухай хуульд тусгагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилтийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд мэдээлж, “Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагыг сайжруулах” сэдэвт сургалтыг яам, нийслэл, аймгуудын улсын төсвийн хөрөнгө оруулалт хариуцсан 120 албан хаагчдад 2019 оны 5 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулсан байна. Түүнчлэн Барилгын хөгжлийн төвийн ажилтнуудтай хамтран яамдын хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтнүүдийг хамруулан 2018 оны 6 дугаар сард хоёр өдрийн сургалт зохион байгуулсан. (Биелэлт 0 хувь)

4.1.8.5-1. Сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүйн дүрмийг редакци, сэтгүүлчдэд мөрдүүлэх, таниулан сургах, хэвлэл мэдээллийн зөвлөлийн үйл ажиллагааг олон нийтэд таниулах ажлыг зохион байгуулах /Хэвлэл мэдээллийн зөвлөл 2017-2019/

Хэвлэл мэдээллийн ёс зүйн өөрийн зохицуулалтын байгууллага Монголын хэвлэл мэдээллийн зөвлөл нь 2015 оны 4 дүгээр сараас ёс зүйн зөрчилтэй сэтгүүл зүйн бүтээлийн эсрэг иргэдийн гомдлыг хүлээн авч эхэлсэн ба 2015-2019 онд нийт 333 гомдлыг хүлээн авч шийдвэрлэв. Тухайлбал, 2019 онд хэвлэл мэдээллийн байгууллага редакцийн мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, иргэн, байгууллага аж ахуйн нэгжээс редакцийн нийтлэл, нэвтрүүлэгт гаргасан 106 өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэсэн байна. Үүний зэрэгцээ 400 орчим иргэн, 600 гаруй сэтгүүлчтэй нүүр тулсан уулзалт, ярилцлага, сургалт хийж, хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт, ёс зүйн зарчмыг таниулан сурталчлах ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулжээ.

Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл, Орон нутгийн хэвлэл мэдээллийн холбоотой хамтран Өмнөговь, Орхон, Дорнод, Увс аймагт бүсчилсэн семинар зохион байгуулж, сэтгүүлчдээс гадна иргэдэд зориулсан сургалтууд зохион байгуулсан ба үйл ажиллагаагаа [www.mediacouncil.mn](http://www.mediacouncil.mn) сайт, Монголын хэвлэл мэдээллийн зөвлөл фэйсбүүк хуудас, улирал тутмын цахим сэтгүүлээр дамжуулан мэдээ мэдээллийг тогтмол түгээж байна.

Хэвлэл мэдээллийн редакцуудыг Ёс зүйн кодын 1.1 дэх заалт (Мэдээлэл нь үнэнд нийцсэн эсэхийг баталгаажуулж, санамсаргүй алдаа гаргахаас зайлсхийнэ)-ыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хуурамч мэдээлэлтэй тэмцэхэд бодит хувь нэмэр оруулах зорилготой “Fact Check Mongolia” хөтөлбөрийг санаачлан, төв, орон нутгийн 20 орчим хэвлэл мэдээллийн редакцийг чадавхжуулах урт хугацааны хөтөлбөрийг бодлогын хувьд анхаарч Монголын эрэн сурвалжлах сурвалжлагчдын төлөө төвийг дэмжин ажиллаж байна.

“Цахим орчинд хэвлэл мэдээллийн редакцийн баримтлах бодлого” баримт бичгийг санаачлан боловсруулж, редакцуудад хүргүүлэв.

2019 онд Эрүүл сэтгүүл зүйн аян, хуурамч мэдээлэлтэй тэмцэх хөтөлбөрийн хүрээнд 3 үйл явдал, хэвлэл мэдээллийн салбарынхан болон олон нийтэд зориулсан хэлэлцүүлэг, дугуй ширээний ярилцлага 12, хэвлэлийн бага хурал 5, кейс судалгаа, мониторингийн ажлыг 3 удаа тус тус зохион байгуулж, нийт 1000 гаруй хүнд хүрч ажиллажээ.

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг шинэчлэхтэй холбогдуулан “Сэтгүүл зүйн ёс зүйн форум 2019”-ыг зохион байгуулж, хэвлэлийн эрх чөлөөг баталгаажуулах, хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтыг хамгаалж бэхжүүлэхэд салбарын төдийгүй олон нийтийн анхаарлыг хандуулав. Тус хуулийн тавдугаар бүлэгт хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтыг эрх зүйн хувьд баталгаажуулах, төрөөс иргэнийхээ үнэн бодит мэдээлэл хүлээн авах эрхийг дэмжих талаар тусгасан болно. (Биелэлт 70 хувь)



**Ес. Улс төрийн намын болон сонгуулийн санхүүжилтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох, хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагыг улс төр, бизнесийн бүлэглэлийн хууль бус ашиг сонирхол, нөлөөллөөс ангид байлгах зорилтыг хангах чиглэлээр:**

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 9 дэх зорилтын хүрээнд нийт 8 үйл ажиллагаа, 17 арга хэмжээг тусгасан. Зорилтын хэрэгжилтийг тоймлон танилцуулбал:

4.1.9.1-1. Улс төрийн намын санхүүжилт, санхүүгийн тайланг ил тод мэдээлэх, мэдээлээгүй тохиолдолд хариуцлага хүлээлгэх чиглэлээр хууль тогтоомжид байгаа зохицуулалтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх / СЕХ, 2018-2019/

Монгол Улсын Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр батлагдсан. Тус хуулийн 57, 58 дугаар зүйлд намын сонгуулийн зардлын тайлан, тайлангийн хяналт ба нээлттэй, ил тод байдлыг хангах, энэ хүрээнд Төрийн аудитын байгууллагын эрх, үүргийг тодорхой болгон зохицуулсан байна. Тухайлбал, Нам, эвсэл нь санал авах ажиллагаа явагдсан өдрөөс хойш 45 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлэхээр тусгасан байна.

Сонгуулийн ерөнхий хорооны цахим хуудасны “УИХ сонгууль”/“зардал” цэсэнд 2008, 2012, 2016 оны Улсын Их Хурлын сонгуульд оролцсон нам, эвслийн сонгуулийн зардлын тайланг байршуулан, нээлттэй мэдээлж байна. Мөн цахим хуудсыг шинэчилж Улсын Их Хурлын сонгууль 2020 цэсэнд “сонгуулийн зардал” цэсэнд Сонгуульд оролцсон нам, эвслийн Улсын Их Хурлын сонгуулийн зардал, санхүүжилт, тайланг нээлттэй танилцах боломжийг бүрдүүлсэн.

Мөн тус зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд Сонгуулийн тухай хууль (2019.12.20-ны өдрийн хуулиар хүчингүй болсон хууль)-ийн 60 дугаар зүйлийн 60.5-д “Хуульд заасан хугацаанд сонгуулийн зардлын тайлангаа ирүүлээгүй бол тухайн нам, эвсэл, нэр дэвшигчийг дараагийн сонгуульд бүртгэхгүй.” гэж заасны дагуу УИХ-ын сонгуулийн 42 дугаар тойргийн

нөхөн сонгуульд тайлангаа ирүүлээгүй намыг бүртгэхээс татгалзах шийдвэр (Сонгуулийн Ерөнхий Хорооны 2018 оны 8 дугаар сарын 9-ний өдрийн 22 дугаар тогтоол)-ийг гаргаж хуулийн хэрэгжилтийг хангаж байсан. Гэвч уг зохицуулалт шинэ хуульд тусгагдаагүй байна.

Нөгөөтэйгүүр дээрх зохицуулалтууд нь улс төрийн намын сонгуулийн үеийн зардалын тайлангийн ил тод байдалтай холбоотой боловч 2019 онд өөрчлөгдсөн тул хэрэгжилтийг тайлант хугацаанд үнэлэх боломжгүй юм.

Улс төрийн намын санхүүгийн үйл ажиллагаа, нэн ялангуяа сонгуулийн бус үеийн санхүүжилт, түүний ил тод байдлыг зохицуулсан хууль тогтоомж шинэчлэгдээгүй. Тухайлбал, Улс төрийн намын тухай хуулийн дөрөвдүгээр бүлэгт Улс төрийн намын санхүүжилтийг хуульчлан “20.3.Нам санхүүгийн үйл ажиллагаандаа жил бүр аудит хийлгэн баталгаажуулж, нийтэд мэдээлнэ.” гэж заасан бөгөөд уг бүлэгт 2005 оны 2 дугаар сарын 17-ны өдрөөс хойш нэмэлт, өөрчлөлт ороогүйн зэрэгцээ хэрэгжилт нь хангалтгүй, мөн зохицуулалт нь хэт ерөнхий, аудит, хяналт шалгалт хийх тогтолцоо нь тодорхойгүй, олон улсын стандартаас хол зөрүүтэй хэвээр байгааг олон улсын болон дотоодын судалгаанууд дурдсан байна. (Биелэлт 30 хувь)

4.1.9.1-2. Сонгуулийн зардлын тайлангийн хяналт, ил тод байдал, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг мэдээлэх үүргээ биелүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг чангатгах чиглэлээр хууль тогтоомжийг боловсронгуй болгох /ХЗДХЯ, 2018-2020/

Монгол Улсын Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57, 58 дугаар зүйлд намын сонгуулийн зардлын тайлан, тайлангийн хяналт ба нээлттэй, ил тод байдлыг хангах талаар тусгасан. Тухайлбал,

57.3.Нам, эвсэл нь санал авах ажиллагаа явагдсан өдрөөс хойш 45 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлнэ;

58.1.Төрийн аудитын дээд байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлнэ.



58.3.Төрийн аудитын дээд байгууллага энэ хуулийн 26.3.6, 26.4.6, 38.5-д заасан мэдээллийг дүгнэлт гаргаж дууссан өдрөөс эхлэн, 58.4-т заасан мэдээллийг хүлээн авсан өдрөөс эхлэн өөрийн байгууллагын цахим хуудаст ил тавьж, нийтэд чөлөөтэй танилцах бололцоо олгоно.

58.4.Нэр дэвшигч, нам, эвсэл авсан хандив болон сонгуулийн зардлын зарцуулалтын явцын тайланг санал авах өдрөөс гурав хоногийн өмнө нийтэд ил тод мэдээлж, төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлнэ.

Дээрх үүргээ биелүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг Зөрчлийн тухай хуулийн 17 дугаар бүлэгт тодорхойлсон бөгөөд 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар нэмэлт оруулж, 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан байна. Тухайлбал,

Хуульд нам, эвсэл, нэр дэвшигч нь сонгуулийн зардлын тайлангаа хуульд заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хүргүүлэх үүргээ биелүүлээгүй бол; Сонгуулийн зардлын данс байршуулсан банк сонгуулийн санал авах ажиллагаа дууссан өдрөөс хойш 30 хоногийн дотор нам, эвсэл, нэр дэвшигчийн дансны гүйлгээний мэдээллийг төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлэх үүргээ биелүүлээгүй бол; Нэр дэвшигч, нам, эвсэл хандив болон сонгуулийн зардлын зарцуулалтын явцын тайланг санал авах өдрөөс 3 хоногийн өмнө нийтэд ил тод мэдээлж, төрийн аудитын байгууллагад хүргүүлэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг болон хуулийн этгээдийг тус тус торгохоор тусгажээ. Ийнхүү хуульд хариуцлагын арга хэмжээг торгуулийн хэлбэрээр тодорхойлж өгчээ. Өмнөх Сонгуулийн тухай хууль (2019.12.20-ны өдрийн хуулиар хүчингүй болсон, 60 дугаар зүйлийн 60.5)-д “Хуульд заасан хугацаанд сонгуулийн зардлын тайлангаа ирүүлээгүй бол тухайн нам, эвсэл, нэр дэвшигчийг дараагийн сонгуульд бүртгэхгүй” гэж заасан зохицуулалт шинэ хуульд тусгагдаагүй байна. Түүнчлэн сонгуулийнхаас бусад үеийн улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдал, хяналтын асуудал шинээр батлагдсан УИХ-ын сонгуулийн тухай хуульд хамаарахгүй байгаа нь учир дутагдалтай бөгөөд хариуцлагыг чангатгах чиглэлээр хууль тогтоомжийг боловсронгуй

болгох хөтөлбөрийн зорилтыг хангасан гэж үзэх боломжгүй байна. (Биелэлт 30 хувь)

4.1.9.2-1. Улс төрийн намуудад төрөөс үзүүлсэн санхүүгийн дэмжлэг, улсын төсвөөс олгосон санхүүжилтийн зардлыг тайлагнах, ил тод мэдээлэх эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх /ХЗДХЯ, 2017-2019/

Улс төрийн намын тухай хуулийн төсөл батлагдаагүй, боловсруулах шатанд байна. Улс төрийн намын тухай хуульд өөрчлөлт ороогүй бөгөөд Улс төрийн намуудад төрөөс үзүүлсэн санхүүгийн дэмжлэг, улсын төсвөөс олгосон санхүүжилтийн зардлыг тайлагнах, ил тод мэдээлэх эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх талаар өөрчлөгдсөн зүйл байхгүй байна.

“Хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д тус яам хариуцан боловсруулахаар тусгагдаагүй тул уг төлөвлөгөөнөөс хасуулах саналтай байгааг Хууль зүй, дотоод хэргийн яам тайландаа дурдсан байгааг анхаарч зохион байгуулалтын арга хэмжээ авах шаардлагатай байна. (Биелэлт 0 хувь)

4.1.9.2-2. Улс төрийн намын санхүүжилт, санхүүгийн тайланд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг олон нийтэд мэдээлэх /ХЗДХЯ, 2018-2022/

2017-2019 онуудад тодорхой ажил хийгдээгүй. “Хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д тус яам хариуцан боловсруулахаар тусгагдаагүй тул уг төлөвлөгөөнөөс хасуулах саналтай байгааг Хууль зүй, дотоод хэргийн яам тайландаа дурдсан байгааг анхаарч зохион байгуулалтын арга хэмжээ авах шаардлагатай байна. (Биелэлт 0 хувь)

4.1.9.3-1. Парламентад суудалгүй намуудад төрөөс олгох санхүүжилтийг хүртээмжтэй болгох асуудлыг судалж шийдвэрлэх /СЕХ, 2017-2019/

2017-2019 онуудад тодорхой ажил хийгдээгүй. Улс төрийн намын тухай хуулийн төсөл боловсруулах шатанд байгаа бөгөөд Сонгуулийн санхүүжилт, улс төрийн нам, нэр дэвшигчдийн сонгуулийн зардал, түүнд тавих хяналтыг үр дүнтэй, ил тод байлгахад чиглэгдсэн судалгаанууд болон эрдэмтэн, судлаачдын саналыг хуулийн төсөлд тусгах

талаар хэд хэдэн удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулсан. (Биелэлт 0 хувь)

4.1.9.3-2. Төрөөс улс төрийн намуудад үзүүлэх дэмжлэгийн хэлбэрийг тодорхойлох, сонгуульд оролцож байгаа нэр дэвшигч, улс төрийн намуудыг төлөвших, санхүүгийн хувьд нөлөөнд автахгүй байх чиглэлээр судалгаа, шинжилгээ хийх, оновчтой арга замыг тодорхойлох /СЕХ, 2017-2022/

Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Ардчилсан институт, хүний эрхийн албанд техникийн туслалцаа авах хүсэлтийг хүргүүлж “Улс төрийн намын бүртгэл, санхүүжилт болон хяналт, ЕАБХАБ-ын гишүүн орнуудын “Сайн туршлага”-ын талаар мэдээлэл, судалгааг; түүнчлэн “Улс төрийн намын тухай хуулийн төсөл”-д ЕАБХАБ-аас санал, зөвлөмж ирүүлснийг хүлээн авч, хуулийн төсөл боловсруулахад ашигласан.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль шинэчлэн батлагдсантай холбоотойгоор Үндэсний аудитын газар, Авлигатай тэмцэх газар болон энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд, судлаачдын төлөөллийг оролцуулан “Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль-Сонгуулийн санхүүжилт” хэлэлцүүлгийн 2019 оны 12 дугаар сард өдөр зохион байгуулж, хэлэлцүүлгээс гарсан санал, зөвлөмж болон тус Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Ардчилсан институт, хүний эрхийн албанаас ирүүлсэн судалгаа, мэдээлэл болон Улс төрийн намын тухай хуулийн төсөлд ирүүлсэн санал, зөвлөмжийг нэгтгэн Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. (Биелэлт 30 хувь)

4.1.9.4-1. Сонгуулийн тухай хуулийг боловсронгуй болгох /СЕХ, 2018-2019/

Сонгуулийн үйл ажиллагааг нэгдсэн нэг хуулиар зохицуулах үзэл баримтлал өөрчлөгдөж, сонгуулийн төрлөөр нь тус тусад зохицуулахаар шийдвэрлэсэн. Энэ хүрээнд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр тус тус батлагдсан. Харин Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төсөл боловсруулах шатандаа байна.

Улс төрийн намын сонгуулийн санхүүжилтийг ил тод нээлттэй болгох, хариуцлагыг сайжруулах чиглэлээр тодорхой саналуудыг боловсруулж Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд тусгуулсан. Үүнд:

- Нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг АТГ хүлээн авч, нэр дэвшигчид үнэмлэх олгосон өдрөөс эхлэн өөрийн байгууллагын цахим хуудаст байршуулна.
- Төрийн аудитын дээд байгууллагаас сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг батлахдаа түүнийг тогтоосон үндэслэл, аргачлалыг урьдчилан баталж, нийтэд мэдээлнэ.
- Бэлэн мөнгөөр хандив өгөх, авахыг хориглоно.
- Мөнгөн бус хандивын үнэлгээг зах зээлийн дундаж ханшийг үндэслэн хандивын гэрээгээр харилцан тогтоох бөгөөд уг үнэлгээ нь иргэн болон хуулийн этгээдээс өгөх хандивын дээд хэмжээнээс хэтрэхгүй байна.
- Хандив өгч байгаа иргэн, хуулийн этгээд нь нэр, регистрийн дугаараа банкны гүйлгээний баримтад тусгаж, Төрийн аудитын дээд байгууллагаас баталсан хандивлагчийн мэдүүлгийн баримтыг мэдүүлэх бөгөөд энэ шаардлагыг хангаагүй хандивыг хандив хүлээн авагч буцаан шилжүүлнэ.
- Хуулийн этгээд мөнгөн хандив өгсөн бол уг хандивыг санхүү, татварын тайландаа тусгана. Үүнд Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хяналт тавьж ажиллах бөгөөд зөрчсөн хуулийн этгээдийн нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арван таваас хорин тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
- Хандивлагч хандив өгөх бол хуульд заасан шаардлага хангаж буй эсэхээ хандив хүлээн авагчид нотлох үүрэгтэй.
- Нам, эвсэл нь санал авах ажиллагаа явагдсан өдрөөс хойш 45 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлнэ.
- Зардлын тайлангийн талаарх Төрийн аудитын дээд байгууллагын эрх хэмжээг нэмэгдүүлж, тодорхой болгож төсөлд тусгасан.
- Нэр дэвшигч, нам, эвсэл нь авсан хандив болон сонгуулийн зардлын зарцуулалтын явцын тайланг санал авах өдрөөс 3 хоногийн



өмнө нийтэд ил тод мэдээлж, төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлнэ.

- Төрийн аудитын дээд байгууллага хуульд заасан бүрэн эрхийн дагуу мэдээлэл, баримт шаардсан тохиолдолд холбогдох иргэн, хуулийн этгээд мэдээлэл, баримтыг гаргаж өгөх үүрэгтэй.
- Төрийн аудитын дээд байгууллага сонгуулийн мөрийн хөтөлбөр, зардлын талаарх хуульд заасан мэдээллийг хүлээн авсан өдрөөс эхлэн өөрийн байгууллагын цахим хуудаст ил тавьж, чөлөөтэй танилцах бололцоо олгоно зэрэг сонгуулийн зардлын хяналт, хариуцлагыг сайжруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн, сонгуулийн тухай хуулиудад өмнө нь байгаагүй, шинэлэг зохицуулалтууд орсон. (Биелэлт 70 хувь)

4.1.9.4-2. Улс төрийн намын тухай хуулийг боловсронгуй болгох, улс төрийн намын санхүүжилт, улс төрийн намуудын санхүүгийн үйл ажиллагаанд төрийн болон олон нийтийн зүгээс хяналт тавих зохицуулалтын эрх зүйн орчинг сайжруулах /ХЗДХЯ, 2018-2019/

Монгол Улсын Үндсэн хуулийн 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр батлагдсан нэмэлт, өөрчлөлтөөр улс төрийн намын санхүүгийн үйл ажиллагаанд төрийн болон олон нийтийн зүгээс хяналт тавих эрх зүйн орчинг сайжруулах чиглэлээр зохицуулалтыг тусгаж өгсөн. Тухайлбал, Арван ес дүгээр зүйлийн 19<sup>1</sup>.3.-т “Намын дотоод зохион байгуулалт ардчилсан зарчимд нийцсэн, хөрөнгө, орлогын эх үүсвэр, зарцуулалт нь нийтэд ил тод байна. Намын зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, санхүүжилт, төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөлийг хуулиар тогтооно” гэсэн заалт нэмэгдсэн.

Уг заалтын агуулгад нийцүүлэн органик хуулиудыг сайжруулах асуудал хүлээгдэж байгаа бөгөөд Улс төрийн намын тухай хуулийн төсөл батлагдаагүй, боловсруулах шатандаа байна. (Биелэлт 30 хувь)

4.1.9.5-1. Төрийн өндөр албан тушаалтны ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, шинэчлэн боловсруулах, УИХ-ын гишүүдийн шударга байдал, ёс зүйн дүрэм, шийдвэр гаргалтын үйл явцыг шинэчлэх, дагаж мөрдүүлэх үр дүнтэй механизмыг бий болгох /ХЗДХЯ, 2018-2022/

Төрийн албаны тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1-д “төрийн улс төрийн болон тусгай албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг хууль тогтоомжоор тогтооно” гэж, 40.2-т төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байгаа төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно” гэж тус тус заасан.

“Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлан мөрдөж байна.

“Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрэм”-ийг шинэчлэн боловсруулах талаар судалгаа хийж байгаа бөгөөд “Төрийн албаны ёс зүй, сахилга хариуцлагын тухай хууль”-ийн төслийг боловсруулж байна. (Биелэлт 30 хувь)

4.1.9.5-2. Оффшор бүсэд данс эзэмшдэг этгээдийг төрийн албанд ажиллуулахгүй байх эрх зүйн зохицуулалтыг бий болгож, хяналт тавих механизмыг бүрдүүлэх /ХЗДХЯ, АТГ, 2017-2019/

Улсын Их Хурал Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2017 оны 04 дүгээр сард, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2017 оны 05 дугаар сард тус тус баталсан. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 10<sup>1</sup> дүгээр зүйлийн 10<sup>1</sup>.3-т заасныг үндэслэн оффшор бүсэд хамаарах нийт 49 нутаг дэвсгэрийн жагсаалтыг Засгийн газрын 2017 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн 244 дүгээр тогтоол, 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 326 дугаар тогтоолоор тус тус баталсан. АТГ-ын даргын 2017 оны 129 дүгээр тушаалаар 2012 оны 91 дүгээр тушаалд нэмэлт оруулж, «мэдүүлэг гаргагч албан тушаалтан, түүний хамаарал бүхий этгээдээс “Оффшор бүсэд банкны данс эзэмших, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөх, хуулийн этгээд байгуулсан талаарх бүртгэл”-ийн маягт»-ыг баталсан. Оффшор бүсэд нээлгэсэн банкны дансаа хаалгах, банкинд байршуулсан мөнгөн хөрөнгөө татах, хөдлөх ба үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийг худалдах, шилжүүлэх, татах,

хувь нийлүүлэх замаар үүсгэн байгуулсан хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоох, эрхээ худалдах, шилжүүлэх, дуусгавар болгох зэрэг арга хэмжээг авсан талаар мэдүүлэх хуулийн хугацаа 2018 оны 04 дүгээр сарын 06-ны өдрөөр дуусгавар болсон бөгөөд уг хугацаанд хуульд заасан үүргээ биелүүлж, оффшор бүс дэх хөрөнгөө шилжүүлсэн болон уг бүсэд хамаарах нутаг дэвсгэрт эд хөрөнгө, данс эзэмшиж байгаа талаараа нийт 20 албан тушаалтан АТГ-т мэдүүлж, мэдэгдэж бүртгүүлсэн болно. Дээрх хуулийн хэрэгжилт болон хуулийн хугацаанд үүргээ биелүүлж мэдэгдсэн албан тушаалтнуудын талаарх мэдээллийг тус газрын цахим сайтад байршуулж, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн. Оффшор бүсэд хамаарах хориглолтын талаар яам, агентлаг, аймаг, нийслэл болон холбогдох албан тушаалтнуудад хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах талаар зөвлөмж хүргүүлж, өдөр тутмын хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэл өгч, хуулийг сурталчлан таниулах ажиллагааг зохион байгуулсан.

Засгийн газрын 2017 оны 326 дугаар тогтоолын хавсралтын “Оффшор бүсэд хамаарах гадаад улс, түүний нутаг дэвсгэрийн жагсаалт” гэснийг “Нийтийн албанд болон нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор гаргасан гадаад улс, нутаг дэвсгэрийн жагсаалт” гэж өөрчилж, шинэчлэн 2020 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 67 дугаар тогтоолоор баталсан. (Биелэлт 100 хувь)

4.1.9.5-3. Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн, зөрчил гаргасан төрийн өндөр албан тушаалтны эрхийг түдгэлзүүлэх, огцруулах, эгүүлэн татах эрх зүйн орчинг бүрдүүлэх /ХЗДХЯ, 2018-2022/

2017-2019 онуудад тодорхой ажил хийгдээгүй.

4.1.9.6-1. Улс төрийн намын дарга, удирдах албан тушаалтны хөрөнгө, орлогын байдалд хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх /АТГ, 2017-2018/

Улс төрийн бүх намын удирдлагуудаас хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах хуулийн зохицуулалт байхгүй тул холбогдох хууль, тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах талаар судалж байна. Энэ хүрээнд, Улс төрийн намын болон

сонгуулийн үйл ажиллагааны санхүүжилтийн ил тод байдлыг сайжруулах, хяналт хариуцлагын тогтолцоо бүрдүүлэх асуудлаар “Улс төрийн намын тухай хууль: тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам” сэдэвт хэлэлцүүлгийг “Транспэрэнси интернешнл Монгол”, “Шилэн нам” авлигын эсрэг төрийн бус байгууллагуудын түншлэл зэрэг төрийн бус байгууллагуудтай хамтран 2019.6.26-нд, Нээлттэй нийгэм форум ТББ-аас зохион байгуулсан “Улс төрийн санхүүжилтийн тогтолцоо: олон улсын туршлага” хэлэлцүүлгийг 2019.12.05-06-ны өдрүүдэд, “Шилэн нам” санаачилгатай хамтран “Улс төрийн санхүүжилтийн ил тод байдлыг хангаж, авлигын эрсдлээс сэргийлэх эрх зүйн орчин бүрдүүлэх нь” хэлэлцүүлгийг 2019.12.09-ний өдөр тус тус хамтран зохион байгуулсан. Эдгээр хэлэлцүүлгүүдээр “Улс төрийн намын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төсөлд Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгасан зорилтууд, олон улсын бусад стандарт, сайн туршлагыг хэрхэн тусгах, шийдэл арга замын талаар талаар хэлэлцүүлэг өрнүүлж, мэдээлэл солилцож, хуулийн төсөлд тусгуулах талаар ажлын хэсэгт санал хүргүүлсэн. (Биелэлт 0 хувь)

4.1.9.6-2. Улс төрийн намын дарга, удирдах албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын талаар олон нийтэд мэдээлэх /АТГ, 2018-2022/

2018-2019 онуудад тодорхой ажил хийгдээгүй. Улс төрийн намын дарга, удирдах албан тушаалтнууд одоогийн байгаа хууль тогтоомжийн хүрээд хувийн ашиг сонирхол болон хөрөнгө, орлогоо мэдүүлэх үүрэг хүлээгээгүй байна. Харин Улсын Их Хуралд суудалтай намуудын дарга, зарим удирдлагууд нь Хувийн ашиг сонирхол, хөрөнгө, орлогын мэдүүлгээ тухайн эрхэлж буй улс төрийн албан тушаалтны хувьд хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасны дагуу гаргаж байгаа бөгөөд хөрөнгө орлогын мэдүүлгийн хураангуйг тус газрын <http://www.хасхот.iaас.mn> цахим хуудсанд нээлттэй байршуулж, олон нийтийг мэдээлж байна. (Биелэлт 0 хувь)

4.1.9.7-1. Төрийн бодлого, шийдвэр гаргахад нийгмийн сонирхлын бүлэг, иргэний оролцоог хангах эрх зүйн зохицуулалтыг бий болгох /ХЗДХЯ, 2018-2020/



ХЗДХЯ-аас Төрийн бус байгууллагын тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай хуулийн төсөл, холбогдох бусад хуулийн төсөлд санал авахаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Хүний эрхийн Үндэсний комисс болон яамд, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. Хуулийн төслийн үзэл баримтлал, шинэлэг зохицуулалтыг танилцуулах, хуулийн төсөлд санал авах зорилгоор иргэд, олон нийт, судлаачид болон холбогдох төрийн байгууллага, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулсан нээлттэй хэлэлцүүлгийг 2018 оны 10 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулсан. Саналуудыг хүлээн авч, судалгаа хийн, нэгтгэн дүгнэж, хуулийн төсөлд нэмэлт боловсруулалт хийж байна.

Иргэдийн оролцооны талаарх хуулиудын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, иргэний оролцоог зохицуулж буй хууль тогтоомжийг боловсронгуй болгох зорилгоор холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хүрээнд ирүүлсэн судалгаа, саналыг судлан хуулийн төсөл боловсруулах шаардлагатай эсэх талаар санал боловсруулсан. (Биелэлт 30 хувь)

4.1.9.8-1. Улс төрийн хариуцлагыг дээшлүүлэх, ил тод байдлыг хангахад иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр олон улсын туршлагыг судлан эрх зүйн орчныг боловсронгуй болгох /ХЗДХЯ, 2018-2020/

Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай хуулийн төсөл болон төслийг дагах 140 хуулийн төслийг боловсруулж. Ардчиллын боловсрол төв, Нээлттэй нийгэм форумтой хамтран 2019 оны 05 дугаар сарын 28, 6 дугаар сарын 06, 11, 18, 21-ний өдөр, 10 дугаар сарын 11-ний өдөр тус тус олон нийтээр хэлэлцүүлсэн. Хэлэлцүүлгийн оролцогчдоос гаргасан саналыг тусган, төслийг эцэслэн боловсруулж, 10 дугаар сарын 9-ний өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн Улсын Их Хуралд өргөн барихаар тогтсон болно. (Биелэлт 70 хувь)

4.1.9.8-2. Бүх нийтэд эрх зүйн боловсрол олгох тогтолцоо бий болгох, иргэдэд эрх зүйн үйлчилгээ үзүүлэх хэлбэрийг хуульчлан тогтоох /ХЗДХЯ, 2017-2020/

Монгол Улсын Засгийн газраас 2018 оны 50 дугаар тогтоолоор “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг баталсан ба уг хөтөлбөр нь 2023 он хүртэл 2 үе шаттай хэрэгжих юм. Хоёрдугаар үе шатаар эхний шатны үйл ажиллагаанд үнэлгээ хийж, бүх нийтийн эрх зүйн боловсролыг тасралтгүй дээшлүүлэх тогтолцоог бэхжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх юм. Уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар батлан хэрэгжүүлж байна.

“Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд эрх зүйн хөтөч бэлтгэх сургалтыг 1 дүгээр сарын 23-24-ний өдрүүдэд Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран зохион байгуулж, аймгуудын ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтан 1, Засаг даргын Тамгын газрын хууль эрх зүйн хэлтсийн эрх зүйн сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн 1, насан туршийн боловсролын төвийн сургагч багш 1, нийслэлээс 4 хүн, нийт 67 хүнийг эрх зүйн хөтөчөөр бэлтгэн, сертификат олгов. (Биелэлт 70 хувь)

4.1.9.8-3. Улс төрийн хариуцлагыг дээшлүүлэх, ил тод байдлыг хангахад сайн дураараа оролцож байгаа иргэн, иргэний нийгмийн байгууллагад төрөөс дэмжлэг үзүүлэх боломжийг судалж шийдвэрлүүлэх /СЯ, ХЗДХЯ, 2018-2022/

Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай хуулийн төслийг боловсруулан, 2019 оны 10 дугаар сарын 9-ний өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хуралд өргөн барихаар шийдвэрлэсэн болно. (Биелэлт 70 хувь)

**Арав. Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр:**

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 10 дугаар зорилтын хүрээнд 10 арга хэмжээг хэрэгжүүлж байна. Зорилтын 2019 оны хэрэгжилтийг товч танилцуулбал:

4.1.10.1-1. Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх зорилгоор иргэдэд зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах /АТГ, 2017-2022/

Авлигаасурьдчилансэргийлэх,соёнгэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх, байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх зорилгоор АТГ-ын Олон нийтийн төвд авлигын эсрэг сургалтыг зохион байгуулж байна. 2017 ондавлига,ашигсонирхлыгзөрчлөөсурьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр 2017 онд 11345, 2018 онд 14783, 2019 онд 25007, нийт 51135 хүнийг сургалтад хамруулсан. Авлигын эсрэг сургалт, сурталчилгааны үйл ажиллагааны чиглэлээр Удирдлагын академи, МУИС, МУБИС, Мэргэшсэн нягтлан бодогчдын институт, Глоб интернешнл төв, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, Хөгжлийн түлхүүр, Жаргалант хангай, Иргэний боловсрол төв, Онч шийдэл, Боловсролын хамтын ажиллагааны төв, Хэвлэл мэдээллийн зөвлөл, Азийн сан, Бие даасан боловсрол хөгжлийн төв, Нээлттэй нийгэм форум, Худалдан авах үйл ажиллагааны хөтөч, Худалдан авах ажиллагааны сургалт, зөвлөгөө өгөх төв, Хүний хөгжил судалгаа сургалтын төв, Худалдан авах ажиллагааны боловсролын төв, Төсвийн удирдлагын хүрээлэн, Худалдан авах ажиллагааны хөгжлийн төв зэрэг төрийн бус байгууллагатай хамтран ажиллав.

Засгийн газрын 2018 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 50 дугаар тогтоолоор батлагдсан “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-т иргэдэд эрх зүйн болон хүний эрхийн талаарх мэдлэг, ойлголтыг түгээх, тэднийг чадавхжуулах, хүний эрхийн зөрчлийг ялгаж таних, эрх

зүйн харилцаанд бие даан оролцох чадварыг эзэмшүүлэх эрх зүйн шаталсан сургалтын тогтолцоог бүрдүүлэхээр тусгасан. ХЗДХЯ-ны дэргэдэх Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албанаас Цагдаагийн ерөнхий газартай хамтран гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, хууль сурталчлах зорилгоор олон нийтийн нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулсан.

“Шударга үнэнийг дэмжинэ” уриалга дэвшүүлж, үүнийхээ бэлгэ тэмдэг болгон энгэртээ бичгийн хавчаар зүүж авлигатай тэмцэж буйгаа илэрхийлэх санаачилга гаргасан. Бичгийн хавчаар сонгосон болно. “Нийгэмд болж бүтэхгүй байгаа муу муухай бүхнийг хавчиж гаргах ёстой” гэсэн агуулга илэрхийлж байгаа бөгөөд энэ үйл ажиллагаанд 12611 хүн оролцсон.

Авлигын эсрэг “Нэг үйлдэл” аяны хүрээнд фейсбүүк шууд ярилцлага явуулж, аяны уриалгыг 100 гаруй редакци, 200 сэтгүүлчдэд хүргүүлэн, хэвлэл мэдээллийн оролцоо нэмэгдүүлэв. Хувийн хэвшлийн 5 байгууллага бүтээлч нэг үйлдэл хийхэд дэмжлэг үзүүлж, нийгэмд нөлөө бүхий багш, хуульч, бизнес эрхлэгч, залуу мэргэжилтнүүдийг татан оролцуулав.

2018 онд Өвөрхангай аймгийн ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 96 сурагч, Зориг сангийн Ардчиллын элч манлайлын хөтөлбөрт хамрагдсан нийслэлийн ЕБС-уудын 17 сурагч, “Lead Mongolia” хөтөлбөрөөс зохион байгуулсан “Гэрэл тусгая” төслийн үеэр 150 хүүхэд залуус болон Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын 70 иргэд Авлигын ойлголт, шалтгаан, хор хөнөөл сэдвээр сургалт хийжээ.

2019 онд Авлигатай тэмцэх газар Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “Найзын яриа” сэдэвт өдөрлөгийг Монголын Хүүхдийн ордон, Сурагчдын холбоо зэрэг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран Сүхбаатарын талбайд зохион байгуулав. Өдөрлөгийн үеэр “Найзын яриа” комикс номыг танилцуулахын зэрэгцээ хүүхдүүдэд шударга ёсны ойлголт, үзэл санааг түгээн дэлгэрүүлэх, шударга амьдралын зан үйл хэвшүүлэх, үлгэр дуурайл бий болгох зорилготой “Би шударга хүүхэд”



хөтөлбөрт арга хэмжээг зохион байгуулав. Энэ хүрээнд хүүхэд багачуудын дунд шударга ёсыг гар зураг, шүлэг, дуу хөгжим, жүжиг зэрэг урлагийн төрлөөр илэрхийлэх сургамжит, хөгжөөнт, танин мэдэхүйн сургалтыг хөтлөн явуулав.

Авлигатай тэмцэх газраас авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх ажлын хүрээнд сургуулиа төгсөн амьдралд хөл тавихаар бэлтгэж буй 3000 орчим оюутан, залуучуудад үзэл санааны удирдагчдаар буюу оюутан залуусын хүндэтгэлийг хүлээсэн, үлгэрлэж чадах, бахархан дуурайх эрхэм хүмүүсийг сонгон авч, Үнэт зүйлийн боловсрол” ерөнхий сэдвийн дор лекц уншуулах арга хэмжээг зохион байгуулаа.

Олон нийтэд авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, тэдэнд авлигыг үл тэвчих ёс суртахуун төлөвшүүлэх, уг ажиллагаанд татан оролцуулах, Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааг сурталчлан таниулах, эрх зүйн зөвлөгөө мэдээлэл өгөх зорилгоор “Авлигатай тэмцэх газар-Танай хороонд” иргэн төвтэй соён гэгээрүүлэх өдөрлөгийг Сонгинохайрхан, Баянзүрх дүүргийн 2 хороонд зохион байгуулж, авлигын хор хөнөөлийг эдийн засгийн агуулгаар ойлгуулах, авлигатай тэмцэхэд иргэд ямар үүрэгтэйг ярьж таниулан, авлигын гэмт хэргийн талаар мэдээлэл хийж, иргэдийн дунд бичил хэлэлцүүлэг, асуулт, хариултын тэмцээн явуулан, ашиг сонирхлын зөрчил болон иргэд төрийн албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлэгтэй хэрхэн танилцаж, хяналт тавих боломжтой талаар зөвлөгөө, мэдээлэл өгөв.

АТГ-ын ажлын хэсэг 21 аймагт ажиллаж, авлигатай тэмцэх үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, эрх зүйн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, зөвлөгөө, мэдээлэл өгөх, гомдол хүлээн авах, санал, хүсэлтийг сонсохоор “Авлигатай тэмцэх газар- Танай аймагт” иргэн төвтэй соён гэгээрүүлэх өдөрлөг болон “Олон нийтийн хяналт ба шударга ёс” сэдэвт уулзалтыг тус тус зохион байгуулж, иргэд хяналт тавих боломж, үүрэг, оролцооны ач холбогдлын талаар яриа таниулга хийн, авлига, ашиг сонирхлын зөрчил, байгууллага, албан тушаалтны хүнд суртлын талаар гомдол, мэдээлэл хүлээн авах “110” дугаарын утсыг сурталчлах зэрэг ажлыг хийж гүйцэтгэсэн. Эдгээр үйл ажиллагаанд 21 аймгийн 3496 иргэн оролцож, 96 иргэн санал хүсэлтээ илэрхийлсэн.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллагын албан хаагчид, эрх бүхий албан тушаалтнуудыг чадавхжуулах зорилгоор зохион байгуулсан сургалт, семинарт 21 аймгийн 5238 албан хаагч оролцсон.

Авлигатай тэмцэх бодлого, зорилтыг хэрэгжүүлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх, шинэ залуу үеийн хандлагыг эерэгээр өөрчлөх, иргэдийн оролцоо, идэвх санаачилгыг дэмжих зорилгоор “Авлигын эсрэг 2019” чуулганыг Авлигатай тэмцэх газраас Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, “Транспэрэнси интернэшнл Монгол” төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулаа. Шударга ирээдүй рүү тэмүүлсэн эрч хүчтэй, асуудлын шийдлийг олох хүсэлтэй 350 гаруй иргэд, залуучууд цуглан, зөв засаглал, шуурхай үйлчилгээ, дижитал гарц, олон нийтийн хяналт, тэр дундаа залуучуудын оролцооны талаар санал туршлагаа солилцов. Түүнчлэн цаг шаарддаг, олон шат дамжлагатай, дараалал үүсгэн чирэгдүүлдэг, хүнд сурталтай төрийн үйлчилгээг дэвшилтэт шинэ технологи ашиглан хийх дижитал шилжилт, өөрчлөх боломж болон цахим шийдлийг танилцуулж, нийгмийн салбар бүрийн оролцсон төлөөлөл болсон мэргэжилтнүүд 13 сэдвийн хүрээнд илтгэл тавьж, хэлэлцүүлэг өрнүүлсэн. Авлигын эсрэг 30 орчим төрлийн 30000 гаруй сурталчилгааны материалыг төрийн байгууллага, албан тушаалтан, олон нийтэд түгээсний зэрэгцээ АТГ-ын англи, монгол хэл дээрх танилцуулга, нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран авлигын эсрэг хууль тогтоомжийн эмхэтгэл, авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчилсан тэмдэглэлийн дэвтэр, ууттай хавтас, “Монгол контент” ХХК-тай хамтран 5 төрлийн зурагт хуудас хэвлүүлж, 21 аймаг 330 сум, яам, агентлаг, дүүргийн төрийн байгууллага, олон нийтэд түгээв.

2019 онд Авлигатай тэмцэх газрын ажлын хэсэг орон нутаг, нийслэлд сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах явцад авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах ном, гарын авлага, 20 орчим төрлийн 48275 ширхэг тараах материалыг иргэд, төрийн байгууллагад хүргэж, аймаг, нийслэлийн Иргэний танхим болон Эрх зүйн тусалцаа үзүүлэх төв, нийтийн номын сангуудад түгээн авлигын эсрэг ном, гарын авлагатай танилцах, судлах нөхцөл боломжоор хангасан.



Монголын үндэсний олон нийтийн телевизийн “Баримт” нэвтрүүлэгтэй хамтран авлига, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, авлигын хор хөнөөлийг ухуулах чиглэлээр 3 удаагийн нэвтрүүлэг бэлтгэн цацав.

Монголын үндэсний олон нийтийн телевизтэй байгуулсан гэрээний дагуу “Эрх зүйн хөтөч” нэвтрүүлэгт 2018 онд “АТГ-ын мэдээлэл” буланг нэмж, 40 цуврал нэвтрүүлэг хамтран бэлтгэж цацсан бөгөөд энэ ажлыг 2019 онд өргөжүүлж Монголын олон нийтийн үндэсний телевизийн хөтөлбөрт 14 хоног тутамд 1 удаа цацагдсан “АТГ-ын цаг” нэвтрүүлгийн 20 дугаар бэлтгэж, олон нийтэд хүргэв.

Байгууллагаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар мэдээлэх нийт 14 удаагийн хэвлэлийн бага хурлыг зохион байгуулав. Хэвлэлийн бага хуралд хийх үндсэн мэдээллийг боловсруулж, дата мэдээлэл болон график дүрст мэдээллийг бэлтгэж, хэвлэлийн бага хурлын өмнө төдийгүй дараа нь мэдээлэл сурталчилгааг үргэлжлүүлж идэвхжүүлж ажилласан болно.

Шударга ёсыг эрхэмлэх, төлөвшүүлэх, авлигын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын гомдол, мэдээллийг хүлээн авах утасны дугаарыг сурталчилсан радио спот 6-г бэлтгэж, “Гэр бүлийн радио 104.5” радиогоор 60 удаагийн цацалт хийлгэх ажлыг зохион байгуулж, дүрсжүүлэх ажлыг Азийн сантай хамтран хийж олон нийтэд түгээсэн;

“Тендер”, “Байцаагч”, “Эмч” сэдэвт 3 төрлийн вирал видео бэлтгэж олон нийтийн сүлжээгээр цацсан. Түүнчлэн 13 яам, холбогдох агентлаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар болон бусад эрүүл мэндийн байгууллагууд, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн цахим хуудсанд байршуулан сурталчлах, Олон нийтийн төвд зохион байгуулагдсан төрийн албан хаагчдад зориулсан сургалтын үеэр оролцогчдод танилцуулсан. Туулайхүүгийн адал явдал зохиолын баатраар зохиомжилсон хүүхэд зориулсан “Шударга хөдөлмөр илүү амттай”, “Бүгдээрээ хэрэглэдэг юмын ганцаараа хэрэглэж болохгүй”, “Жижиг алдаанаас том гэмшил” сэдэвт 3 төрлийн 3D анимейшн бэлтгэж цацсан. 2019 онд 110 тусгай дугаарын сурталчилгааг Мобиком ХХК, Жимобайл ХХК, Юнител ХХК-ий харилцагч нарт мессеж хэлбэрээр хүргэснээс гадна гудамжны

LED болон бусад зарын самбар, телевиз, радиогоор олон нийтэд түгээсэн. Шударга ёс, ёс зүйг эрхэмлэх үзлийг төлөвшүүлэх, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх зорилгоор 4 төрлийн видео шторк хийсэн. (Биелэлт 70 хувь)

4.1.10.1-2. Авлигын эсрэг сургалт, сурталчилгааны материал боловсруулах, соён гэгээрүүлэх арга хэмжээ зохион байгуулахад иргэн, төрийн бус байгууллагыг татан оролцуулах /АТГ, 2017-2022/

АТГ авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, сургалт сурталчилгааны ажлыг олон нийтэд хүргэхэд сэтгүүлч, төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж, олон нийтийн оролцоог хангах ажлыг тогтмол зохион байгуулж байна. Авлига, ашиг сонирхлын зөрчил, авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр гарын авлага боловсруулах, сургалт хийх, мэдээлэл солилцож, дэмжлэг үзүүлэх, уулзалт, хэлэлцүүлэг хийх зэргээр хамтран ажиллаж, авлигын хор хөнөөлийг таниулах, авлигыг үл тэвчих шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх ажлын хүрээнд сурталчилгааны материал, эмхэтгэл, товхимол хэвлүүлж тараах, видео шторк, радио спот, сошиал вирал видео, нэвтрүүлэг, хэлэлцүүлэг, ярилцлага хийж хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд хүргэх ажлыг тогтмол хийж хэрэгжүүлж байна. Тухайлбал, хүүхэд, залуучууд, олон нийтэд авлигын хор хөнөөлийг таниулах, авлигыг үл тэвчих шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх зорилгын хүрээнд Монголын сурагчдын холбоо, Монголын оюутны холбоо, Монголын залуучуудын холбоо, “Глоб интернешнл төв” зэрэг ТББ-тай хамтран ажиллах санамж бичиг байгуулж, хэлэлцүүлэг, сургалт зохион байгуулах, мэдээлэл өгөх, гарын авлага боловсруулах чиглэлээр хамтран ажиллаж байна. Тодорхой салбарт ажиллаж буй төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодтой цуврал хэлэлцүүлэг зохион байгуулсан.

Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хичээлийн хөтөлбөр, гарын авлага боловсруулах, сургалт хамтран зохион байгуулах, туршилтын сургалт зохион байгуулах, соён гэгээрүүлэх ажилд иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт болон улс төрийн намын санхүүжилтийн ил



тод байдлын эрх зүйн орчныг бүрдүүлэх зэрэг чиглэлээр Нээлттэй нийгэм форум, Глоб интернешнл төв, Захиргааны шинэ санаачилга, Иргэний боловсрол төв, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим, АНУ-ын Азийн сан, Транспэрэнси интернешнл Монгол, “Онч шийдэл” зэрэг төрийн бус байгууллага, Монгол Улсын Их сургууль, Монгол Улсын Боловсролын Их сургууль, Удирдлагын академийн багш нар, судлаач, эрдэмтэдтэй хамтран ажиллав.

АТГ-ын Олон нийтийн төвд аймаг, нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл болон яам, агентлагийн дэргэдэх Иргэний хяналтын зөвлөлийн гишүүдийг хамруулсан “Олон нийтийн хяналт ба хамтын ажиллагаа” сэдэвт сургалт, авлигаас урьдчилан сэргийлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд хүүхэд, залуусын оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, тэдгээрийн идэвх санаачилгыг дэмжих зорилгоор Монголын залуучуудын холбоо, Монголын оюутны холбоо, Монголын сурагчдын холбоо болон зарим сургуулийн оюутны холбоо зэрэг төрийн бус 12 байгууллагын төлөөллийг оролцуулсан “Авлигатай тэмцэхэд залуу үеийн үүрэг оролцоо” сэдэвт уулзалт, хэлэлцүүлгийг амжилттай зохион байгуулав.

Мөн авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, олон нийтэд мэдлэг, мэдээлэл олгох зорилгоор FM радиотой хамтран АТГ-ын албан хаагчид, төрийн бус байгууллагын төлөөлөл, эрдэмтэн, судлаачдыг урьж авлигыг үл тэвчих үзэл, хандлагыг төлөвшүүлэх, авлигын илрэх хэлбэр, шалтгаан, нөлөөлдөг хүчин зүйлс, авлигатай тэмцэхэд иргэдийн оролцоо, хяналт тавих боломж, эрх зүйн орчны талаар ойлголт мэдлэг олгох зорилгоор олон талт сэдвээр ярилцлага, нэвтрүүлгийг бэлтгэн олон нийтэд хүргэсэн.

Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэх, идэвх санаачилгыг дэмжих хүрээнд 2017 онд “Монголын залуучуудын холбоо”, Монголын оюутны холбоо”, “Монголын сурагчдын холбоо” зэрэг ТББ-ай хамтран ажиллах Санамж бичиг, 2018 онд хамтран ажиллах төлөвлөгөө батлан хэрэгжүүлж, сургалтын модуль боловсруулах ажлын судалгаа хийх, зорилтот бүлэгт сургалт

явуулах, ухуулан таниулах ажлыг зохион байгуулсан. Сургалтыг хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохируулан жүжигчилсэн хэлбэрээр зохион байгуулсан бөгөөд “Туулайхүүгийн адал явдал” ном, хүүхэд өөрийнхөө үнэнч шударга байдлыг үнэлэх зориулалттай “Шударга ёсны мод”-ыг сурагчдад танилцуулж, гарын авлагыг түгээсэн. Орон нутагт “Туулайхүүгийн адал явдал” сургалтаар дамжуулан эцэг эх, багш сурган хүмүүжүүлэгч, сурагчдад зориулан “Хүн байхын учир”, “Сайн аав, ээж” сэдэвт сургалтыг зохион байгуулж, эцэг эх, багш сурган хүмүүжүүлэгчдэд Хүүхдийн шударга байдлын судалгааны дүнг танилцуулж, шударга байдлын талаар хэлэлцүүлэг өрнүүлсэн болно.

110 тусгай дугаарын сурталчилгааг “Скай-тел”, “Мобиком”, “Жи Мобайл”, “Юнител” зэрэг үүрэн телефоны оператор компанийн маркетингийн албатай хамтран хэрэглэгчдэд үнэ төлбөргүй хүргэх ажлыг зохион байгуулав.

2019 онд шударга ёс, ёс зүйг эрхэмлэх үзлийг төлөвшүүлэх, авлигыг үл тэвчих зорилгоор чөлөөт уран бүтээлчид, мэргэжлийн тамирчин, жүжигчидтэй хамтран 4 төрлийн видео контент, шторк хийж, олон нийтэд хүргэв.

Монгол Улсад залуусын оролцоо, манлайлал, ёс зүйн чиглэлээр манлайллын хөтөлбөр, сургалт, нөлөөллийн арга хэмжээ идэвхтэй зохион байгуулдаг “Зориг сан, “World learning” ТББ-уудтай хамтран оюутан болон хүүхэд залуусын дунд авлигаас ангид байх, шударга ёс түгээн дэлгэрүүлэх “Гэрэл тусгая” богино хэмжээний видео бүтээх уралдааныг зохион байгуулан, дүгнэж, түгээх санал санаачилгыг дэмжин ажиллав.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас гаргасан “Шударга байдлын боловсрол” сургалтын гарын авлагыг орчуулах, иргэдтэй харилцах гар утасны аппликэйшн хийх зэрэг ажлыг иргэн, хувийн хэвшилтэй хамтран гүйцэтгэж байна.

World Learning байгууллагын (LEAD) хөтөлбөрийн Авлигатай тэмцэх, ил тод байдлыг сайжруулах багийн “Сайн сургууль” төслийн багтай хамтран Нийслэлийн 2, орон нутгийн 1 сургууль дээр авлига, ил тод байдлын тухай ойлголт, хандлагын талаар хэлэлцүүлэг, сургалт, уралдааныг сургуулийн захиргаа, багш, сурагчид, эцэг эхийг хамруулан зохион байгуулсан.

Авлигатай тэмцэх газар, “Гэр, иргэдийн оролцоотой амьдрах орчны зураглалын төв” ТББ хамтран “Хоёр хотын цадиг: Нээлттэй мэдээлээр дамжуулан ил тод байдлыг нэмэгдүүлж, авлигыг бууруулах нь” үзэсгэлэнг Монголын Уран зургийн галлерейд зохион байгуулав.

Хүүхдийн шударга байдлын судалгааны үр дүнд тулгуурлан Азийн сан, Авлигатай тэмцэх газар, Нийслэлийн Боловсролын газар, Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг хамтран “Шударга ёсыг бэхжүүлэх нь” хөтөлбөрийг хэрэгжүүлж, нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн бүх сурагчдад шударга ёсны талаар сургалт зохион байгуулсан. Хөтөлбөрт хамрагдсан 168 багш, 12460 орчим сурагч, тэдгээрийн эцэг эхийн төлөөллийг оролцуулсан сургалтын үр дүнг тооцох, сайн туршлагыг солилцуулах уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан.

“Цахим шийдэл-Авлигын эсрэг чуулган 2019” чуулганд 350 гаруй иргэд, залуучууд оролцож, “Мандал даатгал” ХК, “ICT групп” ХХК, “Транспэрэнси интернэшнл Бангладеш” байгууллага, “Гэр, иргэдийн оролцоотой амьдрах орчны зураглалын төв” ТББ, “Цахим эрин дэх Монгол Улс” төсөл, Дэлхийн банк, “IRIM хараат бус судалгааны хүрээлэн” зэрэг хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын төлөөлүүд авлигын эсрэг санал, шийдлээ танилцуулсан.

Авлигатай тэмцэх газар НҮБХХ-ийн “Монгол Улсад мэргэшсэн, иргэн төвтэй төрийн албыг бэхжүүлэх нь” төслийн дэмжлэгтэйгээр МУИС, МУБИС-ийн эрдэмтэн багш, судлаачдын багтай хамтран “Төрийн албаны ёс зүй”, “Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сургалтын модулийг боловсруулж, туршилт сургалтыг хийж, эцэслэн, сургалтын модульд суурилан гарын авлагыг хэвлүүлж, түгээх ажлыг зохион байгуулсан.

Залуу эрдэмтэн, судлаач, багш, оюутнууд, төрийн албан хаагч, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд шинэ технологи, шинэлэг санааг нэвтрүүлэх, авлигын эсрэг санаачилгыг өрнүүлэх зорилгоор зохион байгуулсан “Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд дэвшилтэд аргыг нэвтрүүлэх нь” илтгэлийн уралдаанд хувийн хэвшил, иргэний

нийгмийн байгууллага, иргэдээс 46 бүтээл оролцсон. (Биелэлт 70 хувь)

4.1.10.1-3. Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулах чиглэлээр аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэний танхим болон Эрх зүйн тусалцаа үзүүлэх төвтэй хамтран ажиллах /АТГ, 2017-2022/

АТГ-аас авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах үйл ажиллагааг аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэний танхим болон Эрх зүйн тусалцаа үзүүлэх төвтэй хамтран зохион байгуулах чиглэлээр холбогдох судалгааг хийж гүйцэтгэсэн ба 2016, 2017 онуудад 21 аймагт албан томилолтоор ажиллах явцаа Иргэний танхим хариуцсан ажилтнуудыг Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах сургалтад хамруулснаас гадна хувийн хэвшилтэй хамтран аймаг бүрт “Авлигаас урьдчилан сэргийлэх ажилд хувийн хэвшлийн үүрэг, оролцоо” сэдэвт хэлэлцүүлэг хийв.

Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах чиглэлээр орон нутгийн иргэний танхимын оролцоотойгоор холбогдох арга хэмжээг зохион байгуулсан. Тухайлбал, Баян-Өлгий аймгийн ЗДТГ-аас “Хууль сурталчлах өдөрлөг”-ийг 2017 оны 05 дугаар сард зохион байгуулж, өдөрлөгт нийт 600 орчим хүн оролцсон. Мөн Баянхонгор аймгийн ЗДТГ-аас “Авлигагүй нийгмийн төлөө хамтдаа” аян өрнүүлэн нийтийн албан тушаалтан, иргэдэд зориулсан авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах ажлыг зохион байгуулсан ба сургууль, цэцэрлэгийн эцэг, эхчүүдийн дунд “Авлигагүй нийгмийн төлөө” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулсан байна.

АТГ нь нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Засаг даргын Тамгын газартай хамтран нийслэлийн төсвөөр авлигын нийгмийн хор хөнөөлийг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх чиглэлээр брошюр, гарын авлага, зурагт хуудас зэрэг сурталчилгааны материалыг 2018, 2019 онуудад хэвлүүлж, иргэд, олон нийтэд түгээв.

Иргэний хяналтын төвийг нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн Драгон, Дүнжингарав, Мишээл, Оргил салбаруудад нээн ажиллуулах бэлтгэл ажлыг 2018 онд



хангаж, 2019 оны 01 дүгээр сараас үйл ажиллагаа явуулж эхэлсэн.

Авлигатай тэмцэх газрын ажлын хэсэг 2019 онд 21 аймагт ажиллах явцад болон орон нутаг, нийслэлд сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах явцад авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах ном, гарын авлага зэрэг 20 орчим төрлийн 48275 ширхэг сурталчилгааны материалыг иргэд, төрийн байгууллага, аймаг, нийслэлийн Иргэний танхим, нийтийн номын сангуудад түгээсэн бөгөөд иргэд, төрийн албан хаагчид дээрх байгууллагуудаар дамжуулан авлигын эсрэг ном, гарын авлагатай танилцах, судлах нөхцөл боломжоор хангасан. (Биелэлт 30 хувь)

4.1.10.1-4. Төрийн байгууллагуудын Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнг сайжруулах /АТГ, 2017-2022/

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлагдсантай холбогдуулан уг хөтөлбөрийг хэрэгжүүлэгч үндсэн болон хамтран хэрэгжүүлэгч байгууллагын өөрсдийн хариуцсан үйл ажиллагаа, арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, гүйцэтгэлийг хангаж ажиллах, төлөвлөгөөг албан ёсны цахим хуудас дээрээ ил тод мэдээлж, үр дүнгийн тайланг Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх талаар яам, агентлаг, аймаг, нийслэлд албан бичиг хүргүүлж, төлөвлөгөөний биелэлтийг хангахад чиглэсэн мэргэжил, арга зүйн зөвлөгөөг тогтмол өгч ажиллав.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх ажлын баг 2017 онд 21 аймаг, яам, агентлаг, нийслэл, дүүргийн байгууллагуудын Авлигын эсрэг төлөвлөгөө болон үндэсний хөтөлбөрийн хэрэгжилттэй газар дээр нь танилцан зөвлөн туслах ажлыг гүйцэтгэв.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, авлигын эсрэг хууль тогтоомж, Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилттэй газар дээр нь танилцах, арга зүйн зөвлөгөө өгөх, зорилгоор АТГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу 2018 оны 4 дүгээр улиралд 21 аймаг, 50 суманд ажиллаж, үр дүнг орон нутгийн удирдлагад газар дээр танилцуулж ажилласан бол 2019 онд мөн 21

аймагт томилолтоор ажиллан авлигын эсрэг төлөвлөгөө болон үндэсний хөтөлбөрийн хэрэгжилттэй газар дээр нь танилцан, зөвлөн туслах ажлыг гүйцэтгэсэн.

Ийнхүү өнгөрсөн 3 жилийн хугацаанд Авлигатай тэмцэх газрын ажлын хэсгүүд давхардсан тоогоор 21 аймаг, 144 суманд ажилласан нь нийт сумдын 43.6 хувийг эзэлж байна. Орон нутагт ийнхүү ажиллахдаа цөөн тооны хүчийг оновчтой зохион байгуулж, урьдчилан сэргийлэх, зөвлөн туслах шалгалтад хамрагдсан байгууллага, орон нутгийн тоог 2013-2014 онтой харьцуулахад даруй 3 дахин нэмэгдүүлсэн юм.

Өнгөрсөн хугацаанд Авлигатай тэмцэх газар нь орон нутаг, яам, агентлагт ажиллах явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, хүнд суртал, чирэгдлийг таслан зогсоох, авлига үүсэх нөхцөл боломж бүрдүүлсэн дүрэм, журмыг хүчингүй болгох, авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжүүлэх чиглэлээр Монгол Улсын Засгийн газарт 2 удаа, Засгийн газрын гишүүд болон салбарын сайд нарт 1 удаа, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга нарт тус бүр 3 удаагийн Зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих, биелэлтийг шаардах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээг авч ажилласан болно. (Биелэлт 30 хувь)

4.1.10.2-1. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын агуулга, хичээлийн хөтөлбөрт шударга ёсны үзэл, хандлагыг бий болгох, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх асуудлыг тусгах /БСШУСЯ, АТГ, 2017-2022/

БСШУС-ын сайдын 2017 оны А/100 дугаар тушаалаар Авлигын эсрэг хууль, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд насан туршийн боловсрол, сургалтын чиглэлээр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэгт 2017 онд боловсролын бүх түвшний сургалтын агуулга, хөтөлбөр, сурах бичиг, багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрт нийгмийн шударга ёс, эрх тэгш байдлыг хөгжүүлэх, авлигагүй нийгмийн үнэт зүйлс, соёлыг төлөвшүүлэх үзэл санаа, агуулга туссан байдалд үнэлгээ дүгнэлт өгөх, боловсролын стандарт, сургалтын агуулга, хөтөлбөр, сурах бичигт холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах, албан болон насан туршийн

боловсролын суралцагч, иргэдэд авлигыг үл тэвчих иргэний ухамсар, ур чадварыг бий болгоход чиглэсэн нэгдмэл агуулгын хүрээг боловсруулж, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, коллеж, их дээд сургууль, иргэдийн сургалтад зориулсан багц ном, цахим болон нээлттэй жишиг сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах, сургалтыг зохион байгуулж эхлүүлэх, сургуулийн өмнөх болон ерөнхий боловсрол, их, дээд сургууль, коллежийн багш нарт авлигыг үл тэвчих иргэний ухамсар, ур чадварыг бий болгоход чиглэсэн мэргэжил дээшлүүлэх сургалтын модулийг боловсруулж, үндэсний сургагч багшийг бэлтгэх болон нийт багш нарын сургалтыг зохион байгуулахыг тус тус үүрэг болгосон боловч ерөнхий боловсролын сургуулийн сургалтын агуулга, хичээлийн хөтөлбөрт шударга ёсны үзэл, хандлагыг бий болгох, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх асуудлыг тусгах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй байна.

Харин БСШУС-ын сайдын 2017 оны А/100 дугаар тушаалын хүрээнд АТГ, БСШУСЯ, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, Нийслэлийн Боловсролын газраас “Багшийн ёс зүйн харилцаа” сургагч багш бэлтгэх сургалтын хөтөлбөрт “Авлигаас ангид байх нь” дэд бүлгийг хамтран боловсруулж сургагч багш нарт зориулсан “Багшийн ёс зүй: ёс суртахууны харилцаа” сэдэвт гарын авлагыг боловсруулж, нийслэлийн 62, орон нутгийн 760 багшийг сургагч багшаар бэлтгэсэн ба сургагч багш нар аймаг, нийслэлийн 36000 орчим багш нарт ёс зүйн сургалтыг 2017 оны 8 дугаар сард зохион байгуулсан байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын “Ажлын хэсэг байгуулах тухай” 2017 оны А/02 дугаар тушаалаар байгуулагдсан “Сургалтын агуулгын талаар баримтлах бодлого, сургалтын хөтөлбөрт тавигдах шаардлага боловсруулах, дунд, ахлах ангийн сургалтын агуулга, хөтөлбөр, үнэлгээ, арга зүйн шинэчлэл хийх, ахлах ангийн сургалтын төлөвлөгөө боловсруулах, суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшил болон багшийн ажлыг үнэлэх үнэлгээний журам шинэчлэх ажлыг гүйцэтгэх” ажлын хэсгээс боловсруулсан “Сургалтын агуулгын талаар баримтлах бодлого”-ын төсөл боловсруулсан. Тус төсөлд ерөнхий боловсролын сургуулийн 10 дугаар

ангийн суралцагчид “Нийгмийн ухаан” сонгон суралцах хичээлийн 6 дугаар бүлэгт “Шударга ёс ба авлига” бүлэг сэдвийн хүрээнд дараах агуулгыг оруулахаар судалж байна. Үүнд: а/ Тохиолдолд шударга ёсны үүднээс шинжилгээ хийн авлигад холбогдох асуудлыг тодорхойлох; б/ Авлигын нийгэм, улс төр, эдийн засаг, соёлд үзүүлэх сөрөг үр нөлөөг тодорхойлох, тайлбарлах; в/ Авлигаас зайлсхийх иргэний санаачилгын хувилбар дэвшүүлэн хамгаалах зэрэг болно.

Авлигатай тэмцэх газраас шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх чиглэлээр ерөнхий боловсролын бага, дунд ангийн сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах тендерийг 2019 онд 2 удаа зарласан боловч шаардлага хангах материал ирээгүй тул 2020 онд дахин сонгон шалгаруулалт зарлахаар болсон.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны “Хөтөлбөр батлах тухай” А/492 дугаар тушаалаар баталсан ерөнхий боловсролын сургуулийн Х ангид судлах “Нийгэм судлал” хичээлийн агуулгад 1) Шударга ёсны ойлголт, түүний шалгуур, 2) Гажуудал ба нийгмийн хяналт, 3) Соёлын олон янз байдал, харилцаан дахь шударга ёсны үнэлэмж, 4) Үл ялгаварлан гадуурхах, 5) Эдийн засгийн өсөлт ба амьдралын чанар, 6) Шударга ёс ба авлига/авилга гэж бичсэн/, 7) Улсуудын орлогын ялгаатай байдал гэсэн сэдвүүдийг тусгасан байна. (Биелэлт 30 хувь)

4.1.10.2-2. Их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сэдвийг тусгах / БСШУСЯ, АТГ, 2017-2022/

БСШУС-ын сайдын 2017 оны А/100 дугаар тушаалаар бүх түвшний сургалтын агуулга, хөтөлбөр, сурах бичиг, багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрт нийгмийн шударга ёс, эрх тэгш байдлыг хөгжүүлэх, авлигагүй нийгмийн үнэт зүйлс, соёлыг төлөвшүүлэх үзэл санаа, агуулга туссан байдалд үнэлгээ, дүгнэлт өгөх, боловсролын стандарт, сургалтын агуулга, хөтөлбөр, сурах бичигт холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах, албан болон насан туршийн боловсролын суралцагч, иргэдэд авлигыг үл тэвчих иргэний ухамсар, ур чадварыг бий болгоход чиглэсэн нэгдмэл агуулгын хүрээг боловсруулж, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль,



коллеж, их дээд сургууль, иргэдийн сургалтад зориулсан багц ном, цахим болон нээлттэй жишиг сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах зэрэг ажил гүйцэтгэх ёстой байсан боловч их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сэдвийг тусгах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй байна.

Их, дээд сургуулийн сургалтын агуулга, хичээлийн хөтөлбөрт тусгах талаар судалгаа хийгдэж байна. 2017-2018 оны хичээлийн жилд нийт их, дээд сургуулиуд оюутан, суралцагчдын дунд хар тамхи мансууруулах бодис, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомж зөрчихгүй байх талаар Цагдаагийн байгууллага, төрийн бус байгууллагуудтай хамтран сургалт, лекц, өдөрлөг зохион байгуулж, гарын авлага, брошюр хэвлэж түгээх ажил хийгдсэн. 2018-2019 оны хичээлийн жилийн бэлтгэл, өвөлжилтийн бэлтгэл, гэнэтийн аюул, үер, гал түймэр, архи дан согтуурах явдалтай тэмцэх зэрэг болон хичээлийн жилийн зорилгоо тодорхойлон хэлэлцэх ажлын хүрээнд их, дээд сургуулиудын захирлуудын дунд «Боловсролын чанар-удирдлагын манлайлал» сургалт хэлэлцүүлгийг зохион байгуулж 85 их, дээд сургуулийн удирдах ажилтнууд оролцсон.

АТГ-аас Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан “авлигын эсрэг боловсрол олгох агуулгыг бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөр, стандартад тусгах” зорилтын хүрээнд их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөр, стандартад ёс зүй, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сэдвийг тусгадаг эсэх талаар судалгаа, дүн шинжилгээ хийсэн. Азийн сан, Хууль сахиулахын их сургуультай хамтран ёс зүйн сургалтын хөтөлбөрийг шинэчлэх асуудлаар санал солицох уулзалтад оролцож, сургалтын хөтөлбөр агуулгыг шинэчлэх, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр мэдээлэл өгч, арга зүйн удирдлагаар хангасан. Сургалтын хөтөлбөрийн төсөлтэй танилцаж санал өгч, туршилт сургалтыг 2018 оны 11 дүгээр сард хийсэн ба тус хөтөлбөр батлагдснаар ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн сонсогчдод ёс зүй, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хичээлийн хөтөлбөрийн дагуу заавал хамрагдах боломж бүрдэнэ.

Их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сэдвийг тусгах ажил хийгдээгүй.

Хүний хөгжлийг хангах чиглэлээр 3 кредитийн “Хүний үндсэн эрх /шударга ёс, авлигаас урьдчилан сэргийлэх/, хувь хүний төлөвшил, хөгжлийн талаар суралцах, бүтээлч сэтгэлгээ, хувийн зохион байгуулалт, өөрийгөө хянах чадвар, багаар ажиллах чадвар, нийгэм, хүмүүнлэгийн үйл ажиллагаанд биечлэн оролцох, зохион байгуулах чадвар эзэмшүүлэх” хичээлийг оруулсан. (Биелэлт 30 хувь)

4.1.10.2-3. Оюутан, сурагч, эцэг, эхийг хамруулсан шударга ёсны сэдэвт өдөрлөг, сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулах / БСШУСЯ, ГБХЗХГ, АТГ, 2017-2022/

АТГ-аас авлигаас урьдчилан сэргийлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд хүүхэд, залуусын оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, тэдгээрийн идэвхи санаачилгыг дэмжих зорилгоор Монголын залуучуудын холбоо, Монголын оюутны холбоо, Монголын сурагчдын холбоо болон зарим сургуулийн оюутны холбоотой хамтран “Авлигатай тэмцэхэд залуу үеийн үүрэг оролцоо” сэдэвт уулзалт, хэлэлцүүлгийг амжилттай зохион байгуулсан. Мөн Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газраас “Авлигагүй нийгмийн төлөө хамтдаа” аян өрнүүлэн, нийтийн албан тушаалтан, иргэдэд зориулсан авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах ажлыг зохион байгуулсан ба сургууль, цэцэрлэгийн эцэг, эхчүүдийн дунд “Авлигагүй нийгмийн төлөө” сэдэвт хэлэлцүүлгийг тус тус зохион байгуулсан. Цаашид дээрх арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас идэвх, санаачилга гарган ажиллах шаардлагатай байна. (Биелэлт 20 хувь)

“Боловсролын салбар дахь авлига, түүнээс урьдчилан сэргийлэх арга зам” сэдэвт хэлэлцүүлгийг “Боловсролын салбарын авлигын нөхцөл байдал”, “Боловсролын салбарын ил тод байдал”, “Боловсролын салбар дахь авлигаас урьдчилан сэргийлэх нь”, “Боловсролын салбар дахь авлигаас урьдчилан сэргийлэхэд мэдээллийн технологийг ашиглах нь” гэсэн 4 сэдвийн хүрээнд амжилттай зохион байгууллаа.

“Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг” ТББ болон Азийн сан хамтран зохион байгуулсан “Хариуцлага оюутан залуус” төслийн хүрээнд “Дээд боловсрол: ёс зүй, ил тод, шударга байдал” уулзалт хэлэлцүүлэгт оролцож, мэдээлэл солилцох, “Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг” ТББ-тай хамтран шударга ёсны хичээл заасан 33 сургуулийн 110 багш, удирдлага, эцэг эхийн төлөөллийг оролцуулсан туршлага солилцох уулзалт зохион байгуулж, харилцан мэдээлэл солилцсон ба тус ТББ-аас эрхлэн гаргаж улсын хэмжээний бүх ерөнхий боловсролын сургуульд хүргэгдэг “Нээлттэй сургууль” сонины дугаарт дээрх 110 багшийн сайн туршлага, шударга ёсонд суралцах нь хичээлийг зааснаар сургуулийн орчинд гарсан өөрчлөлт, хүрсэн үр дүнгийн талаар болон Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн танилцуулга, 10 дугаар зорилтын талаарх мэдээллийг багтаасан дугаар (2018 оны 11 дүгээр)-ыг эрхлэн гаргалаа.

Улсын хэмжээнд нийт ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн сурагчдын дунд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, авлигын эсрэг хууль тогтоомж зөрчихгүй байх талаар холбогдох байгууллагатай хамтран, лекц, өдөрлөг зохион байгуулсан. “Сургалтын төлбөр-Оюутны хөгжил» сэдэвт их, дээд сургуулиудын захирал, оюутны байгууллагуудын нэгдсэн анхдугаар хуралдаан, хэлэлцүүлэг 2018 оны 09 дүгээр сарын 06-нд зохион байгуулж Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газар, БСШУСЯ болон ДББГ, их, дээд сургуулиудын захирал, оюутны холбоод, зөвлөлүүдийн тэргүүд, намын дэргэдэх оюутны байгууллагын төлөөллүүд оролцсон. Монгол Улсын дээд боловсролын салбар дахь, их, дээд сургуулиудын сургалтын төлбөртэй холбоотой сургуулийн удирдлага, оюутнууд хоорондын үл ойлголшлыг тодорхойлж, харилцан зөвшилцөж, хамтран ажиллаж, цаашид Монголын оюутны хөгжлийг сайжруулах арга замыг тодорхойлон хэлэлцэн зөвшилцсөн.

2019 онд их, дээд сургуулиудын Хууль зүйн сургуулийн дэргэдэх “Хууль зүйн клиник сургалтын төв” болон оюутны холбоо, оюутны хөгжлийг дэмжих клубүүдтэй хамтран ёс зүйг эрхэмлэх, зөв хандлага, дадал эзэмшүүлэх, авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигын эсрэг хууль тогтоомж, байгууллагын үйл ажиллагааг сурталчилж, авлигын эсрэг

залуучуудын байр суурь, нийгэмд хандах хандлагыг судлах зорилготой уулзалт, өдөрлөгийг Олон улсын Улаанбаатар их сургуулийн Хууль зүйн тэнхимтэй хамтран эрх зүйн 3 дугаар курсын 57 оюутны дунд зохион байгуулсан.

World Learning байгууллагын (LEAD) хөтөлбөрийн Авлигатай тэмцэх, ил тод байдлыг сайжруулах багийн “Сайн сургууль” төслийн багтай хамтран Нийслэлийн 2, орон нутгийн 1 сургууль дээр авлига, ил тод байдлын тухай ойлголт, хандлагын талаар хэлэлцүүлэг, сургалт, уралдааныг сургуулийн захиргаа, багш, сурагчид, эцэг эхийг хамруулан зохион байгуулсан.

Авлигатай тэмцэх газраас Авлигын эсрэг олон улсын өдрийг угтан их, дээд сургуулийн оюутнуудад зориулан “Үнэт зүйлийн боловсрол” сэдвийн дор 3000 орчим оюутанд лекц уншуулж, телевиз, цахим сүлжээгээр орон даяар шууд дамжуулсан.

“Шударга ёсыг бэхжүүлэх нь” хөтөлбөрт хамрагдсан 168 багш, 12460 орчим сурагч, тэдгээрийн эцэг эхийн төлөөллийг оролцуулсан сургалтын үр дүнг тооцох, сайн туршлагыг солилцуулах уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан.

Нийгмийн амьдралд оюутан залуусын бодит оролцоог нэмэгдүүлэх, идэвх санаачилгыг өрнүүлэх, дэмжиж хамтран ажиллах замаар шударга, бүтээлч иргэдийг төлөвшүүлэх зорилгоор «Түлхүүр» уралдааныг санаачлан их, дээд сургуулийн 3 дугаар курсын оюутнуудын дунд 2 үе шаттайгаар зохион байгуулсан. Уралдаанд 14 сургуулийн бие даасан 41, хамтарсан 6, нийт 47 баг, суралцаж байгаа мэргэжлээр нь ангилвал 19 төрлийн мэргэжлийн 188 оюутан оролцсон.

Сурагчид шударга ёсны тухай үзэл бодлоо эссэ бичлэг, зургаар дамжуулан илэрхийлэх, шударга бус байдлын эсрэг олон нийтэд тэдний дуу хоолойг хүргэх зорилгоор Ерөнхий боловсролын сургуулийн 9-12 дугаар ангийн сурагчдын дунд “Шударга ёс: Хүн болох багаасаа” сэдэвт эссэ бичлэгийн уралдаан, бага, дунд ангийн сурагчдын дунд “Миний мэдэх шударга ёс” гар зургийн уралдаан зохион байгуулсан. Эссэ бичлэгийн уралдаанд 129, гар зургийн уралдаанд 194, нийт 323 сурагч бүтээлээ ирүүлж оролцсон байна. (Биелэлт 30 хувь)



4.1.10.3-1. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх асуудлаар нийтийн албан тушаалтан, хувийн хэвшил, төрийн бус байгууллага, иргэдэд зориулсан сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах, сургалтыг шинэлэг арга хэлбэрээр үе шаттай зохион явуулах/ АТГ, 2017-2022/

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлагдснаар соён гэгээрүүлэх ажлыг илүү өргөн хүрээнд зохион байгуулах боломж бүрдсэн. Авлигын эсрэг сургалтыг төрийн байгууллагын хүсэлтээр байгууллага дээр нь очиж мэдээлэл хийх түвшинд хийж байсныг өөрчилж, сэдвийг өргөжүүлэн, практик жишээгээр баяжуулж сургалтад хамрагдагсдыг зорилтот бүлгээр нь ангилан АТГ-ын Олон нийтийн төвд сургалт зохион байгуулах стратегийн дагуу шинэлэг хэлбэрт шилжүүлсэн.

- Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтын хүрээнд Авлигатай тэмцэх газрын дэргэд Олон нийтийн төвийг 2017 онд нээн ажиллуулж, нийтийн албан тушаалтанд зориулсан авлигын эсрэг сургалтыг албан тушаалын ангилал, эрхэлж буй ажил үүргийн онцлогтой нь уялдуулан, сургалтын хөтөлбөр, агуулгыг шинэчлэн, сургалтыг улирлаар төлөвлөн, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажилласан. Энэ хүрээнд Олон нийтийн төвд зохион байгуулсан нэг өрдийн хөтөлбөрт сургалтад 2018 онд 8497, 2019 онд 4947, нийт 13444 төрийн албан хаагчийг хамруулсан.
- Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх зорилгоор Авлигатай тэмцэх газраас төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн хүсэлт, хэрэгцээ шаардлагыг харгалзан, тодорхой сэдвээр нэг удаагийн сургалтыг зохион байгуулж 2018 онд 6286 иргэн, 2019 онд 6381, нийт 12667 хүнийг хамруулсан байна.

Авлигын эсрэг сургалтын хөтөлбөр, агуулгыг шинэчлэх чиглэлээр мэргэжлийн байгууллагууд, эрдэмтэн, судлаачид болон иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран дараах арга хэмжээг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- Удирдлагын академитай хамтран нийтийн албан тушаалтанд зориулсан авлигын эсрэг сургалтын (Авлигын эсрэг эрх зүйн орчин; Төрийн байгууллагын үйл ажиллагааны

ил тод, нээлттэй байдал; Төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа; Хувийн хэвшил дэх авлигаас урьдчилан сэргийлэх нь; Авлигын эсрэг үйл ажиллагаанд удирдах ажилтны манлайлал; Төрийн байгууллага дахь авлигын эсрэг дотоод хяналтын тогтолцоо, гомдлын менежментийн хэрэгжүүлэлт, мэдээллийн технологийн гүйцэтгэх үүрэг сэдвээр) 6 модуль, хөтөлбөрийг боловсруулж, туршилт сургалтуудыг цувралаар зохион байгуулж, төрийн албан хаагч, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл зэрэг нийт 100 гаруй хүнийг сургасан.

- НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн “Монгол Улсад мэргэжлийн, иргэнтөвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төслийн дэмжлэгтэйгээр Монгол Улсын Их Сургуулийн баг “Төрийн албан хаагчийн албан хаагчийн ёс зүй” сургалтын; Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн баг “Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сургалтын модуль, гарын авлагыг тус тус боловсруулж, тус бүр 6000 хувь хэвлүүлж, түгээх ажлыг зохион байгуулсан. Тус сургалтын модуль, хөтөлбөрөөр сургалт явуулах сургагч багшийн сургалтад 132, сургагч багш нартай хамтран зохион байгуулсан туршилт сургалтад Сэлэнгэ, Орхон, Дархан-Уул аймагт 369, нийслэлд шүүгч, прокурорын байгууллагын 40; УИХ-ын харьяа байгууллага, яам, агентлагийн ажилтан 60, нийслэл, дүүргийн 200, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн нийтийн албан тушаалтан 200 хүн, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 100 албан хаагч, нийт 1101 хүн хамрагдсан байна.

Авлигын эсрэг сургалтыг зөвхөн нийтийн албан тушаалтнуудад бус оюутан, сурагч, эцэг, эх, төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэдэд зэрэг зорилтот бүлгүүдэд зориулан үе шаттайгаар зохион байгуулах, нийтийн албан тушаалтанд зориулсан сургалтын хөтөлбөр, материалыг боловсруулж, зохион байгуулж, холбогдох төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Тухайлбал, 2017 Глоб Интернэшнл төв, “Мэдэх эрхийг хөхиүлэн дэмжих” төслийн хүрээнд “Ус дээшээ урсдаг” олон ангит киног ашиглан авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар кино сургалтыг Азийн сангийн санхүүжилтээр зохион



байгуулсан бөгөөд нийслэлийн ЕБС-ийн Ирээдүй цогцолбор сургууль, 23-р сургууль, “Монгени” цогцолбор сургууль, “Хобби” сургуулийн 11, 12 дугаар ангийн сурагчид болон МУИС, Хууль сахиулахын их сургууль, Их засаг Олон улсын их сургуулийн 1, 2-р курсийн нийт 237 оюутан, сурагчид сургалтад хамрагдсан байна. Багшийн хөгжлийн ордонд тус төслийн хаалт “Тусгал” нэртэй туршлага хуваалцах уулзалтыг зохион байгуулж, үр дүнг дүгнэсэн.

Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг, Азийн сантай хамтран авлигын эсрэг ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад шударга ёсны агуулгаар хичээл заах, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах зорилгоор “Шударга ёсыг бэхжүүлэх нь” хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэв. Уг хөтөлбөрт хичээл заах сургагч багш бэлтгэх, ЕБС-ийн багш нарыг сургахад хамтран ажиллаж, авлигаас урьдчилсан сэргийлэх сэдвээр сургалтыг хийв. Уг хөтөлбөрийг Канадын Засгийн газрын дэмжлэгтэйгээр Азийн сан, Авлигатай тэмцэх газар, Нийслэлийн Боловсролын газар, Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг хамтран зохион байгуулсан бөгөөд хөтөлбөрт нийслэлийн ЕБС-ийн ахлах ангийн 140 гаруй багш, төгсөх ангийн 12460 орчим сурагч хамрагдсан.

Түүнчлэн “Шинэ хөгжлийн түлхүүр” ТББ-аас иргэдэд зориулсан авлигын эсрэг сургалтын модуль; “Жаргалант хангай” ТББ ерөнхий боловсролын сурагч, хүүхэд залууст зориулсан шударга ёсны хичээлийн сургалтын модуль; “Глоб интернешнл төв” ТББ сэтгүүлчдэд зориулсан эрэн сурвалжлах сэтгүүл зүйн болон хуулийн байгууллагын ажилтнуудад зориулсан “Авлига ба соёлын өвийг хамгаалах нь” сэдвээр зориулсан сургалтын модуль, хөтөлбөрийг боловсруулж, туршилт сургалтуудыг үе шаттайгаар зохион байгуулсан.

Авлигатай тэмцэх газраас хувийн хэвшлийн байгууллагад зориулсан сургалтын хөтөлбөрийг Азийн сан, Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтран боловсруулж, цуврал сургалтуудыг зохион байгуулсан.

Монголын бизнесийн зөвлөлөөс олон улсын туршлагыг судалж, хувийн хэвшлийн ажилтнуудад зориулсан онлайн сургалтын хөтөлбөрийг эхлүүлсэн. Түүнчлэн эдгээр

сургалтын хөтөлбөрт тулгуурлан хувийн хэвшлийнхэнд зориулсан “Шударга ёс, хөгжил дэвшил: Хувийн хэвшлийн оролцоо” гарын авлагыг боловсруулж, 3000 хувь хэвлэж, түгээсэн. Мөн гарын авлагыг Азийн сангийн санхүүжилтээр 3000 хувь хэвлэж, түгээсэн.

Улаанбаатар төмөр замын 1200 гаруй ажилтанд хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, гэмт хэрэг гарах шалтгаан, нөхцөлийг арилгах, авлига албан тушаалын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор жил бүр зохион байгуулдаг “Вагонтой сургалт”-ыг төмөр замын урд, хойд чиглэлд зохион байгуулсан.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас 2019 оныг “Иргэний ёс зүйн боловсролын жил” болгон зарлаж, Авлигатай тэмцэх газартай хамтран багш, сурган хүмүүжүүлэгчид, эрдэмтэн судлаачид, урлаг, соёлынхон, авьяастнууд, тамирчид, дасгалжуулагчидад хандан уриалга гаргаж, 2019 онд хамтран ажиллах төлөвлөгөө гарган ажилласан. Энэ ажлын хүрээнд Авлигатай тэмцэх газар, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Боловсролын газар хамтран Сонгинохайрхан, Хан-Уул дүүргийн 44 сургуулийн захирал, 77 цэцэрлэгийн эрхлэгч, нийт 121 албан тушаалтанд Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах хөтөлбөрт сургалтыг зохион байгуулсан.

Иргэдэд авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, тэдэнд авлигыг үл тэвчих ёс суртахуун төлөвшүүлэх, уг ажиллагаанд татан оролцуулах зорилготой “Иргэн төвтэй соён гэгээрүүлэх өдөрлөг” болон “Олон нийтийн хяналт ба шударга ёс”, “Найзын яриа” өдөрлөг зэрэг соён гэгээрүүлэх арга хэмжээний хөтөлбөр агуулгыг боловсруулж, төлөвлөгөө гарган зохион байгуулж иргэдийг идэвхтэй хамруулсан. Эдгээр үйл ажиллагаанд иргэд зөвхөн мэдээлэл сонсох байдлаар оролцох бус тодорхой санал санаачилга, санал хүсэлтээ илэрхийлсэн бөгөөд сургалт, сурталчилгааны ажлыг шинэлэг арга хэлбэрээр явуулах шинэ санаачилга болсон.

“Үнэт зүйлсийн боловсрол” сэдвээр үзэл санааны удирдагч 6 илтгэгчээр лекц уншуулах арга хэмжээг зохион байгуулж 3000 оюутан залуусыг хамруулсан. Мөн оюутнуудын дунд авлигын эсрэг “Түлхүүр” уралдааныг зохион байгуулж авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр оюутнуудыг суралцах, авлигын эсрэг



үйл ажиллагаанд санаачилга гарган оролцох боломжийг бүрдүүлэв.

Иргэний хяналтын зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах хүрээнд “Төрийн үйлчилгээ ба иргэний хяналт”, “Авлига, ашиг сонирхлын зөрчлийн хяналт шалгалт, үр нөлөө”, “Нээлттэй мэдээллийг ашиглаж албан тушаалтанд хяналт тавих нь”, “Цахим худалдан авалтын үйл ажиллагаа: Хөндлөнгийн хяналт, арга зам”, “Төсвийн төлөвлөлт ба үр ашгийг хянах арга зүйд суралцах нь”, “Төсвийн үйл явцад иргэдийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлэх арга зам, туршлага”, “Худалдан авах ажиллагаанд дахь авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх нь” зэрэг сэдвээр сургалт зохион байгуулж, олон улсын болон дотоодын мэргэжилтэн, судлаачдаар хичээл заалгаж, тусгайлсан мэдлэг, мэдээлэл, арга зүйд сургасан.

Авлигатай тэмцэх газар, “Гэр, иргэдийн оролцоотой амьдрах орчны зураглалын төв” ТББ хамтран “Хоёр хотын цадиг: Нээлттэй мэдээллээр дамжуулан ил тод байдлыг нэмэгдүүлж, авлигыг бууруулах нь” үзэсгэлэн Монголын Уран зургийн галлерейд зохион байгуулж, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд нээлттэй өгөгдлийг ашиглан олон нийтийн зүгээс хяналт тавих, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, хөндлөнгийн хяналтын тогтолцоог бэхжүүлэх зорилгоор “Гэр, иргэдийн оролцоотой амьдрах орчны зураглалын төв”, “Нээлттэй нийгэм форум” зэрэг төрийн бус байгууллагатай хамтран хөгжүүлсэн цахим мэдээллийн санг олон нийтэд танилцуулсан нь мэдээллийг шинэлэг хэлбэрээр иргэдэд хүргэсэн алхам болсон. Мөн сургалтын бүртгэл, хяналтын програм хангамжийг боловсруулж, хөгжүүлэлтийг хийхийн зэрэгцээ түүнд тулгуурласан онлайн болон видео сургалтын модуль, хөтөлбөрийг нэвтрүүлэхээр хөгжүүлэх ажлыг судалж эхлэл шатандаа явж байна. (Биелэлт 70 хувь)

4.1.10.4-1. Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа явуулах сургагч багшийг бэлтгэх, чадавхжуулах, мэргэжил, арга зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх /АТГ, 2017-2022/

АТГ 2017 онд БСШУСЯ, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, Нийслэлийн Боловсролын газраас “Багшийн ёс зүйн харилцаа” сургагч багш бэлтгэх сургалтын хөтөлбөрт “Авлигаас ангид байх нь” дэд

бүлгийг хамтран боловсруулж оруулсан ба сургагч багш нарт зориулсан гарын авлагыг боловсруулж, нийслэлийн 62, орон нутгийн 760 багшийг сургагч багшаар бэлтгэж, тэдгээр багш нар орон нутгийн боловсролын салбарын багш ажилтнуудад Ёс зүйн харилцаа” модулиар сургалт хийсэн байна. Удирдлагын академитай хамтран гэрээ байгуулж авлигын эсрэг сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох судалгаа хийлгэж, төрийн албан хаагчдад зориулсан 6 модуль, гарын авлага боловсруулж, сургагч багш бэлтгэх туршилт сургалтыг 40 хүнийг хамруулан зохион байгуулав.

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төслийн дэмжлэгтэйгээр Монгол Улсын Их Сургуулийн баг “Төрийн албан хаагчийн албан хаагчийн ёс зүй” сургалтын; Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн баг “Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сургалтын модуль, гарын авлагыг тус тус боловсруулсан бөгөөд тус сургалтын модуль, хөтөлбөрөөр сургалт явуулах сургагч багшийн сургалтад 21 аймгаас тус бүр 3 төрийн албан хаагч 63 хүн, нийслэлээс Иргэний хяналтын зөвлөлийн 69 гишүүн, нийт 132 хүнийг сургасан. Эдгээр сургагч багш нарыг чадавхижуулах хүрээнд Авлигатай тэмцэх газраас Сэлэнгэ, Орхон, Дархан-Уул аймагт томилолтоор ажиллаж, сургагч багш нартай хамтран дээрх модуль, хөтөлбөрөөр туршилт сургалтыг зохион байгуулж 369 төрийн албан хаагчийг хамруулж, сургагч багш нарыг чадавхижуулж, гарын авлагаар хангав.

Түүнчлэн Засгийн газрын 2018 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 50 дугаар тогтоолоор батлагдсан “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Авлигатай тэмцэх газраас 2019 онд авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт явуулах сургагч багш бэлтгэх хүрээнд Цагдаагийн ерөнхий газартай хамтран цагдаа, дотоодын цэргийн 65 алба хаагчийг сургагч багшаар бэлтгэж гэрчилгээ олгов.

Хууль сахиулах байгууллагын ажилтан, албан хаагчдад зориулан “Эрэн сурвалжлах сэтгүүл зүй, сэтгүүлчийн аюулгүй байдлыг хангах нь” сэдэвт бүтэн өдрийн сургалтыг Хэвлэл мэдээллийн зөвлөлтэй хамтран зохион

байгуулав. Сургалтад Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын ерөнхий прокурор, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газрын 57 албан хаагч хамрагдсан.

Хууль зүй дотоод хэргийн яам, “Нээлттэй нийгэм форум”-тай хамтран Эрүүгийн хууль тогтоомжийн сургагч багш бэлтгэх сургалт зохион байгуулсан байна. (Биелэлт 30 хувь)

4.1.10.5-1. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүй, ил тод байдлыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийг арилгах чиглэлээр дотоод, гадаадын сайн туршлага, оновчтой шийдлийг сурталчлах, түгээх, нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах/ АТГ, 2017-2022/

2017 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр Төрийн ордонд зохион байгуулагдсан Авлигын эсрэг үндэсний чуулган дээр “Төрийн байгууллагын ил тод, шударга, хариуцлагатай байдал-Олон улсын сайн туршлага, санаачилга”, “Авлигатай тэмцэх эрх зүйн орчин, шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын хамтын ажиллагаа-Олон улсын сайн туршлага, санаачилга”, “Хувийн хэвшил дэх авлигаас урьдчилан сэргийлэх асуудал-Олон улсын сайн туршлага, санаачилга”, “Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд Олон нийтийн оролцоо, хяналтыг бий болгох талаарх олон улсын туршлага”, “Улс төрийн намын санхүүжилт: Олон улсын туршлага ба Монгол дахь тулгамдсан асуудал” зэрэг 5 сэдвээр дотоод, гадаадын эрдэмтэн судлаач, шинжээчдээр илтгэл тавиулж хэлэлцүүлсэн болно.

АТГ-аас авлигын нөхцөл байдал, авлигатай тэмцэх үйл ажиллагаа, дотоод, гадаадын сайн туршлага, авлигын нөхцөл байдлын судалгааны үр дүн зэрэг сэдвээр танилцуулга, илтгэл, хэвлэлийн мэдээг тасралтгүй бэлтгэж байгууллагын албан ёсны цахим хуудас болон олон нийтийн сүлжээгээр түгээж хэвшсэн ба «Худалдан авах ажиллагаан дахь авлига, түүний шалтгаан нөхцөл, хор уршиг», «Шударга байдлын үнэлгээ-2016», «Монгол Улсын авлигын нөхцөл байдал», «Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн 2016 оны судалгааны дүн» зэрэг сэдвээр илтгэл бэлтгэн амжилттай хэлэлцүүлэв.

Мөн Авлигын эсрэг үндэсний чуулганд Авлигын эсрэг олон улсын академи, “StAR” санаачилга” Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага, БНХАУ-ын Ардын дээд прокурорын газрын Авлигатай тэмцэх товчоо, БНСУ-ын Авлигын эсрэг, иргэний эрхийн хорооны Хээл хахуультай тэмцэх албанаас төлөөлөл оролцон тухайн улсын авлигатай тэмцэх сайн туршлага, оновчтой шийдлийн талаар үндэсний чуулганд оролцогчдод танилцуулсан болно.

Мөн гадаадын сайн туршлага, оновчтой шийдлийг судлах зорилгоор БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (КОЙКА) болон тус улсын Прокурорын дээд газраас зохион байгуулсан “Авлигын хэргийг мөрдөн шалгах нь” сэдэвт сургалт, Шри Ланка Улсад зохион байгуулагдсан Ази, Номхон далайн орнуудын мөнгө угаахтай тэмцэх бүлгийн хурал, Франц Улсад Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас зохион байгуулсан уулзалт, Египет Улсын Шарм Эль-Шейх хотод зохион байгуулагдсан Авлигын эсрэг олон улсын академийг олон улсын байгууллага болгон өөрчлөх тухай хэлэлцээрт оролцогч талуудын 6 дугаар хурал, Азербайжан Улсад зохион байгуулагдсан Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын хууль сахиулах сүлжээний уулзалтад, БНСУ-аас Азийн хөгжлийн банк, ЭЗХАХБ-тай хамтран зохион байгуулсан хурал болон “Сингапур улсын авлигатай тэмцэх сайн туршлага” сэдэвт сургалтад АТГ-ын албан хаагчид тус тус оролцож, харилцан мэдээлэл солилцон, туршлагаа хуваалцсан байна.

Түүнчлэн Австри Улсад зохион байгуулагдсан Авлигын эсрэг Нэгдсэн үндэстний байгууллагын конвенцид оролцогч талуудын 7 дугаар хуралд оролцож, ижил төстэй чиг үүрэг гүйцэтгэдэг гадаадын байгууллагын төлөөлөгчидтэй уулзалт хийж цаашид хамтран ажиллах чиглэлээр санал солилцсон ба Монгол Улсын авлигын эсрэг хийж байгаа үйл ажиллагаа, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, бусад холбогдох асуудлаар туршлага судлах уулзалтыг тус тус зохион байгуулсан. Азербайжан Улсын Авлигын эсрэг газрын урилгаар тус улсад 2018 оны 11 дүгээр сард зочилж, Авлигын эсрэг газар, дүүргийн шүүх, прокурор, “АСАН” олон нийтийн үйлчилгээний төвийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж,



харилцан ойлголцлын санамж бичиг байгуулан, туршлага солилцсон. Хонг Конгийн Авлигатай тэмцэх бие даасан хороонд АТГ-ын төлөөлөгчид зочилж, тус хорооны Оперативын хэлтэс, Урьдчилан сэргийлэх хэлтэс, Олон нийттэй харилцах хэлтэс, дүүргийн салбар нэгжийн үйл ажиллагаатай танилцлаа. Томилолтоор ажилласны дараа Хонг Конгийн туршлагад тулгуурлан нийслэлийн төрийн үйлчилгээний нэгдсэн төвүүд (Дүнжингарав, Саппоро, Оргил, Мишээл) авлигын эсрэг Иргэний хяналтын төвүүдийг байгуулан ажиллаж байна.

2019 онд орон нутаг дахь Иргэний хяналтын зөвлөлийн гишүүдэд зориулсан “Төрийн үйлчилгээ ба иргэний хяналт” сэдэвт чадавхижуулах сургалтыг Олон нийтийн төвд зохион байгуулсан. Гурван өдөр үргэлжилсэн тус сургалтад 21 аймгаас 48 гишүүн оролцсон.

Канадын Засгийн газрын дэмжлэгтэйгээр Азийн сан, Авлигатай тэмцэх газар, Нийслэлийн Боловсролын газар, Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг хамтран зохион байгуулсан “Шударга ёсыг бэхжүүлэх нь” хөтөлбөрт хамрагдсан багш, сурагчид, тэдгээрийн эцэг эхийн төлөөллийг оролцуулсан сургалтын үр дүнг тооцох, сайн туршлагыг солилцуулах уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

Авлигын эсрэг олон улсын өдрийг тохиолдуулан залуу эрдэмтэн, судлаач, багш, оюутнууд, төрийн албан хаагч, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд шинэ технологи, шинэлэг санааг нэвтрүүлэх, авлигын эсрэг санаачилгыг өрнүүлэх зорилгоор “Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд дэвшилтэд аргыг нэвтрүүлэх нь” илтгэлийн уралдааныг зохион байгуулсан.

Төрийн байгууллагын өргөдөл гомдол хариуцсан албан тушаалтнуудыг чадавхжуулах зорилгоор “Төрийн байгууллагуудын өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авах ажилтнуудын форум” зохион байгуулж, төрийн яам агентлаг, нутгийн захиргааны 65 байгууллагын өргөдөл, гомдол хариуцсан албан хаагчийг хамруулав.

Авлигатай тэмцэх газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, “Ил тод Улаанбаатар Академи” хамтран нийслэлийн төр, захиргааны байгууллагын албан хаагчдын ёс зүйн форумыг зохион байгуулсан. Форумд нийслэлийн 12

харьяа агентлагийн 110 гаруй албан хаагчид оролцож харилцан туршлага солилцов.

Улс төрийн намын болон сонгуулийн үйл ажиллагааны санхүүжилтийн ил тод байдлыг сайжруулах, хяналт хариуцлагын тогтолцоо бүрдүүлэх асуудлаар “Улс төрийн намын тухай хууль: тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам” сэдэвт хэлэлцүүлгийг “Транспэрэнси интернешнл Монгол”, “Шилэн нам” авлигын эсрэг төрийн бус байгууллагуудын түншлэл зэрэг төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулсан.

Төрийн албаны зөвлөл, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Авлигатай тэмцэх газар, зарим яам болон бусад аймаг, нийслэл, сум дүүргийн ЗДТГ, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын 400 орчим төрийн албан хаагчдын дунд зохион байгуулсан “Монгол Улсын Төрийн албаны менежментийн хөгжил” сэдэвт форумд оролцсон Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн цахим үйлчилгээний сайн туршлагыг “Авлигын эсрэг чуулган: Цахим шийдэл” арга хэмжээний үеэр олон нийтэд танилцуулж, сурталчилсан.

“Транспэрэнси Интернэшнл - Бангладеш” олон улсын байгууллагын Иргэдийн хяналт, оролцоо хариуцсан захирал хатагтай Ferhana Ferdous Бангладеш улсад амжилттай хэрэгжиж олон улсад сайшаагдсан авлигын эсрэг иргэдийн бүлэг байгуулж ажиллуулах туршлагын талаар “Сайн туршлага: Иргэдийн бүлэг” сэдэвт туршлага судлах сургалт зохион байгуулж 89 иргэнийг хамруулав. (Биелэлт 30 хувь)

**Арван нэг. Авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон улсын байгууллагын санал, зөвлөмжийг авч хэрэгжүүлэх зорилтыг хангах чиглэлээр:**

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 11 дүгээр зорилтын хүрээнд нийт 5 үйл ажиллагаа, 13 арга хэмжээг хэрэгжүүлэв. Зорилтын хэрэгжилтийг тоймлон танилцуулбал:

**4.1.11.1-1. Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийг эрх зүйн харилцан туслалцааны үндэслэл болгон хэрэгжүүлэх /ХЗДХЯ, 2017-2022/**

Монгол Улсын нэгдэн орсон НҮБ-ын аливаа конвенцийн хүрээнд олж авсан мэдээ, мэдээлэл, баримтыг нотлох баримтаар үнэлэх практикийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэвшүүлэх арга замыг бий болгох, эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагаанд оролцогч төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа, үйл ажиллагааны уялдааг хангах, улмаар Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийг эрх зүйн харилцан туслалцааны үндэслэл болгон хэрэглэх арга хэмжээний хүрээнд Авлигатай тэмцэх газраас “Эрүүгийн хэрэг дэх эрх зүйн харилцан туслалцаа, хамтын ажиллагаа сэдэвт хэлэлцүүлэг”-ийг 2018 оны 4 дүгээр сард зохион байгуулж, холбогдох байгууллагуудын ажилтнуудыг чадавхжуулж, үйл ажиллагааг нь уялдуулах талаар асуудал дэвшүүлсэн ярилцлага өрнүүлэн, санал солилцов.

Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийг эрх зүйн харилцан туслалцааны үндэслэл болгон хэрэглэх хүрээнд ХЗДХЯ-аас Авлигатай тэмцэх газар, Улсын ерөнхий прокурорын газартай хамтран ажиллаж, авлигын хэрэгт холбоотой эрх зүйн туслалцааны хүсэлтийг нууцын зэрэглэлтэй болон энгийн байдлаар хүлээн авч, конвенцийн дагуу холбогдох улсын эрх бүхий байгууллагад хүргэдэг. Энэ хүрээнд Авлигатай тэмцэх газар сүүлийн 3 жилийн байдлаар Авлигын эсрэг НҮБ-ын конвенцид нэгдэн орсон 9 улсад 17 хүсэлтийг хүргүүлэв. Тухайлбал, 2018 оны байдлаар 4 эрх зүйн туслалцааны хүсэлтийг 7 улс (Англи, Панам, Сингапур, Хонконг, Австри, Канад, БНХАУ)-д, 2019 оны байдлаар улсын хэмжээнд гадаадын нэр бүхий (Швейцарь, Мэн Арал, ОХУ, БНХАУ, БНСУ, ХБНГУ, Канад, Засаг захиргааны онцгой бүс Хонконг, Франц, Швейцарь, АНУ, Сингапур зэрэг) улсуудад авлигын эсрэг НҮБ-

ын конвенцийг үндэслэл болгосон 26 эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт хүргүүлжээ. Үүнээс Хонконг, Сингапур, Швейцарь зэрэг улсаас эрх зүйн туслалцааны хүсэлтийн хариу ирсэн байна.

Гадаад улс орнуудтай байгуулсан эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай гэрээний хүрээнд гадаадын эрх бүхий байгууллагаас ирүүлсэн 168 эрх зүйн туслалцааны хүсэлт, даалгаварт холбогдох ажиллагааг гүйцэтгэсэн ба Монгол Улс, БНХАУ-ын Хууль зүйн яамдын Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, Ялтан шилжүүлэх тухай асуудлаар II дугаар зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулж, уулзалтын протоколд гарын үсэг зурав. (Биелэлт 70 хувь)

**4.1.11.1-2. Гадаад орнуудтай эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээ байгуулах, өмнө байгуулсан гэрээний хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх /ХЗДХЯ, УЕПГ, ГХЯ 2018-2021/**

Монгол Улс 2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Иргэний хэргээр эрх зүйн туслалцаа үзүүлэх /18/, Эрүүгийн хэргээр эрх зүйн туслалцаа үзүүлэх /19/, Гэмт этгээд шилжүүлэх /18/, Ялтан шилжүүлэх /12/ асуудлаар 21 улстай 35 гэрээг байгуулсан байна. 2018-2019 онд гадаад орнуудтай гэрээ, хэлэлцээрүүдийг нэмж байгуулах чиглэлээр дараах ажлуудыг хэрэгжүүлэв. Тухайлбал:

1. Монгол Улс болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засаг Захиргааны онцгой бүс Хонконгийн хооронд 2018 оны 03 дугаар сарын 26-ны өдөр байгуулсан “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засаг Захиргааны онцгой бүс Хонконгийн Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг 2018 оны 3 дугаар сарын 26-ны өдөр байгуулж, 2018 оны 10 дугаар сарын 26-ны өдөр Улсын Их Хурлаар соёрхон батлуулсан.
2. Ялтан шилжүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засаг Захиргааны онцгой бүс Макаогийн хооронд 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдөр гэрээнд гарын үсэг зурж, ГХЯ-ны Консулын газарт эрх зүйн туслалцааны нэгдсэн сан байгуулахаар тохиролцон ажиллаж байна.



3. “Ялтан шилжүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Казахстан Улс хоорондын гэрээ”-г 2018 оны 3 дугаар сарын 29-ний өдөр байгуулав.
4. “Гэмт этгээд шилжүүлэх тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс хоорондын гэрээ”-г 2019 оны 07 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан бөгөөд Улсын Их Хурлын чуулганаар соёрхон батлуулахаар Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 2019 оны 12 дугаар сарын 03-ны өдөр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.
6. “Ялтан шилжүүлэх тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс хоорондын гэрээ”-г 2019 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр УИХ-ын чуулганаар соёрхон батлуулав.
7. “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засаг захиргааны онцгой бүс Макао хоорондын хэлэлцээр”-ийг Улсын Их Хурлын чуулганаар соёрхон батлуулахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2019 оны 12 дугаар сарын 03-ны өдөр хүргүүлэв.
8. “Гэмт этгээд шилжүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засаг захиргааны онцгой бүс Макао хоорондын хэлэлцээр” байгуулах тухай саналыг БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Макаогийн талаас 2019 оны 06 дугаар сарын 25-ны өдөр хүлээн авч, орчуулгын ажлыг эхлүүлэн, дотоодын байгууллагаас санал авахаар хүргүүлсэн.
9. “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Беларусь Улс хоорондын гэрээ”, “Гэмт этгээд шилжүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Беларусь Улс хоорондын гэрээ”-г Улсын Их Хурлаар 2019 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр тус тус соёрхон батлуулсан.
10. “Иргэний болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Казахстан Улс хоорондын 1993 оны 10 дугаар сарын 22-ний өдрийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протокол”-ыг Засгийн газрын хуралдаан, холбогдох байнгын хороогоор хэлэлцүүлсэн бөгөөд тус протоколд 2019

оны 10 дугаар сарын 10-ны өдөр гарын үсэг зурсан.

Хоёр талт гэрээ хэлэлцээр байгуулахаас гадна олон улсын конвенцид нэгдэн орох хүрээнд Монгол Улсын “Гэмт этгээд шилжүүлэх тухай Европын Конвенц” болон “Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Европын Конвенц”-д нэгдэн орох ажлыг Хууль зүй, дотоод хэргийн яам гүйцэтгэж байна. Эдгээр конвенцид элссэнээр конвенцид заасан нөхцөлийн дагуу эрүүгийн хариуцлагад татах, шүүхийн хүчин төгөлдөр болсон таслан шийдвэрлэх тогтоолыг биелүүлэх зорилгоор хэрэгт холбогдсон этгээдийг шилжүүлэн өгөх, авах эрх зүйн үндэс бий болох юм. Монголын талаас тус конвенцид нэгдэн орохтой холбоотой саналаа Европын зөвлөлийн Нарийн бичгийн даргын газарт хүргүүлсэн.

“Эрүүгийн ял шийтгэлийг гадаад улсад эдлүүлэх тухай Америкийн улсууд хоорондын конвенц”-д нэгдэн орох ажлын хүрээнд тус конвенцийн монгол хэл дээрх орчуулгыг Гадаад харилцааны яамнаас хянан баталгаажуулсан бол тус конвенцид нэгдэн орох тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас бэлтгэн батлуулжээ. Энэхүү конвенцийг Улсын Их Хурлын чуулганаар соёрхон батлуулахаар 2019 оны 12 дугаар сарын 03-ны өдөр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас гадаад улс орнуудтай байгуулсан эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, ялтан шилжүүлэх тухай гэрээний хэрэгжилтийг сайжруулахаар Гадаад хэргийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Улсын ерөнхий прокурорын газраас төлөөлөл бүхий ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэг 2019 оны 05 дугаар сард хуралдаж ялтан шилжүүлэх үйл ажиллагаанд гарч буй хүндрэл бэрхшээлээс гадна БНХАУ-аас ялтан шилжүүлэн авах ажиллагаа удааширч байгаа, БНХАУ-аас шилжүүлэн авсан ялтанд Монгол Улсын шүүхээс дүйцүүлэн оногдуулсан ялын хэмжээ БНХАУ-ын шүүхээс оногдуулсан ялын хэмжээнээс зөрүүтэй байгаа нь БНХАУ-ын талаас ялтан шилжүүлэн өгөх ажиллагаанд нөлөөлж байгаа, эрх зүйн туслалцааны хүсэлт, ялтан шилжүүлэх ажиллагааны холбогдох баримт бичгийн орчуулгын ажил, орчуулгын зардлын асуудал, мөн эрх зүйн туслалцаа, ялтан шилжүүлэх ажлын хүрээнд холбогдох хүсэлт,

баримт бичгийн нэгдсэн бүртгэлийн талаар хэлэлцэн хурлын үр дүнг Хууль зүй, дотоод хэргийн сайдад танилцуулсан. Цаашид шинээр байгуулах гэрээнд албан тушаалаа урвуулан ашиглах, авлигын гэмт хэрэгтэй холбоотой заалтыг тусгаж ажиллахаар төлөвлөсөн.

Гадаад улсад илгээх хүсэлтийг олон улсын гэрээ, хэлэлцээрт заасан шаардлагыг бүрэн хангахуйц, оновчтой, үндэслэлтэй боловсруулах, гадаад улсаас ирүүлсэн хүсэлтийг чанартай гүйцэтгэх ажиллагаанд прокурор, мөрдөгч нарын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагааны талаарх эрх зүйн баримт бичгийг боловсронгуй болгоход анхаарч, Улсын ерөнхий прокурорын газраас «Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагааны аргачилсан заавар», “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагааны эрх зүйн хэлбэрүүдийн жагсаалт, загвар”, “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг шилжүүлэн авах тухай хүсэлтийн бүтэц, загвар”, “Монгол Улсаас эрх зүйн туслалцаа үзүүлэхэд өгөх зөвлөмж”-ийг тус тус боловсруулж, Улсын ерөнхий прокурорын 2019 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн А/16 дугаар тушаалаар баталж, прокуроруудын үйл ажиллагаанд мөрдүүлж байна.

2019 оны байдлаар Улсын ерөнхий прокурорын газраас эрх зүйн туслалцааны хүсэлт бэлтгэн боловсруулж байгаа прокурор, мөрдөгч нарт тусгайлан анхаарах асуудлуудын талаар тайлбарлах, заавар чиглэл өгөх зэргээр гадаад улсад илгээхээр төлөвлөсөн эрх зүйн туслалцааны 6 хүсэлтэд практик зөвлөмж өгсөн байна.

Улсын ерөнхий прокурор тэргүүтэй прокурорын байгууллагын төлөөлөгчид БНХАУ-ын Ардын дээд прокурорын газрын Ерөнхий прокурорын урилгаар 2019 оны 11 дүгээр сард БНХАУ-д ажлын айлчлал хийж, “Монгол Улсын ерөнхий прокурорын газар, БНХАУ-ын Ардын дээд прокурорын газар хоорондын хамтын ажиллагааны гэрээ»-г байгуулав. Энэхүү гэрээгээр хоёр орны хооронд эрх зүйн туслалцааны хүсэлтийг цахим хэлбэрээр хүргүүлэхээр тохиролцсон нь энэхүү ажиллагааг шат дамжлага багатай, түргэн шуурхай гүйцэтгэхэд нэн чухал алхам болсон. (Биелэлт 70 хувь)

#### 4.1.11.1-3. Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх чиглэлээр албан хаагчдыг мэргэшүүлэх /ХЗДХЯ, УЕПГ, 2017-2022/

Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх чиглэлээр 2018-2019 онд албан хаагчдыг мэргэшүүлэх сургалтуудыг зохион байгуулав. Тухайлбал, УЕПГ-аас олон улсын эрх зүйн туслалцааны хүсэлтийг боловсруулах сургалт, нийслэл, төвийн 6 дүүргийн прокурорын газруудын прокурор, туслах ажилтнуудад “Эрх зүйн туслалцааны хүсэлтийг боловсруулах, илгээхэд анхаарах асуудал”, “Гэмт этгээдийг шилжүүлэн авах ажиллагаа” сургалт, ХЗДХЯ-наас жил бүр Монгол Улсаас гадаад улсад томилогдон ажиллах дипломат ажилтнуудад эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх чиглэлээр тусгай сургалт, 2018 оны 5 дугаар сард олон улсын “StAR” санаачилгын дэмжлэгтэйгээр хуулийн байгууллагуудын албан хаагчдад олон улсын эрх зүйн туслалцааны хүсэлт, гадаадад хууль бусаар гарсан хөрөнгийг буцаах, мөнгө угаахтай холбоотой сургалтыг тус тус зохион байгуулсан. Авлигатай тэмцэх, мөнгө угаах чиглэлээр 2018 онд Хонг-Конг, Индонези улсад зохион байгуулагдсан “Авлигатай тэмцэх шинэ хандлага” олон улсын семинарт Авлигатай тэмцэх газар болон прокурорын байгууллагын төлөөллийг хамруулав.

Авлигатай тэмцэх газраас “Эрүүгийн хэрэг дэх эрх зүйн харилцан туслалцаа, хамтын ажиллагаа хэлэлцүүлэг”-ийг 2018 оны 4 дүгээр сард зохион байгуулж, эрх зүйн туслалцаа үзүүлэх асуудлаар туршлага солилцсон нь хамтын ажиллагааг сайжруулахад дэмжлэг болсон.

Улсын ерөнхий прокурорын газраас «Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагааны аргачилсан заавар», “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагааны эрх зүйн хэлбэрүүдийн жагсаалт, загвар”, “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг шилжүүлэн авах тухай хүсэлтийн бүтэц, загвар”, “Монгол Улсаас эрх зүйн туслалцаа үзүүлэхэд өгөх зөвлөмж”, аргачлал, зааврын талаар Улсын ерөнхий прокурорын газраас харьяа нэгж прокурорын газруудын хэмжээнд дотоод сургалт зохион байгуулсан.



Улсын ерөнхий прокурорын газар, ОХУ-ын Ерөнхий прокурорын газрын хамтын ажиллагааны хүрээнд прокуроруудыг ОХУ-ын Эрхүү хотод жил бүр мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулахаар тохиролцсны дагуу 2019 оны 10 дугаар сард ОХУ-ын Эрхүү муж дахь Прокурорын их сургуульд 5 прокурор, мөн оны 11 дүгээр сард БНХАУ-д мэргэжил дээшлүүлэх сургалтад 30 прокурор тус тус хамрагдсан байна. Дээр дурдсанаас гадна Европын холбооны санхүүжилтээр 2019 оны 2 дугаар сард 6 прокурор Бельги, Нидерланд улсын шүүх, прокурорын байгууллагын үйл ажиллагаатай танилцаж, ажлын туршлага солилцжээ. Улсын ерөнхий прокурорын газар, БНСУ-ын КОЙКА байгууллагын хооронд хамтран хэрэгжүүлж буй төслийн хүрээнд 2019 оны 04 дүгээр сард БНСУ-ын Хууль зүйн институтэд зохиогдсон “Прокурорын байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь” сургалтад 15 прокурор хамрагдсан.

Дэлхийн банкны «StAR» санаачилгын хүрээнд Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант улсын мэргэжилтнүүдийн 2019 оны 04 дүгээр сард мөнгө угаах, хулгайлагдсан хөрөнгийг буцаах чиглэлээр зохион байгуулсан сургалтад Нийслэлийн прокурорын газрын 5 прокурор хамрагдсан.

2019 оны 8, 9 дүгээр сард Тайландын Вант улсын Бангкок хотод АНУ-ын Хууль сахиулах академиас зохион байгуулсан сургалтад 4 прокурор оролцсон. 2020 онд Улсын ерөнхий прокурорын газраас АНУ-ын Элчин сайдын яамтай хамтран мөнгө угаах болон санхүүгийн гэмт хэргийг мөрдөн шалгах чиглэлээр прокурор, хууль сахиулах байгууллагын чадавхийг бэхжүүлэхэд чиглэгдсэн сургалтыг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

“Монгол Улсын ерөнхий прокурорын газар, БНХАУ-ын Ардын дээд прокурорын газар хоорондын хамтын ажиллагааны гэрээ»-гээр Монгол Улсын прокуроруудыг БНХАУ-ын Ардын дээд прокурорын газрын дэргэдэх Эрх зүйн академид жил бүр мэргэжил дээшлүүлэх, давтан сургалтад хамруулах, хил залгаа муж, аймгийн прокурорын газруудын хамтын ажиллагааг хөгжүүлэх зэрэг асуудлуудыг шийдвэрлэсэн. (Биелэлт 70 хувь)

4.1.11.1-4.Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хүсэлт, даалгавар, бусад материалыг орчуулахад шаардлагатай хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэх /ХЗДХЯ, 2017-2022/

Авлигатай тэмцэх газар сүүлийн 2017-2018 жилийн байдлаар нийт эрх зүйн туслалцаа хүссэн мөрдөгчийн даалгаврыг 24 удаа бичиж 12 улсад хүргүүлсэн. Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээтэй 3 улсад 7 мөрдөгчийн хүсэлтийг, Авлигын эсрэг НҮБ-ын конвенцид нэгдэн орсон улс орнууд болох 9 улсад 17 хүсэлтийг тус тус хүргүүлж ажилласан. Эрх зүйн туслалцаа харилцаа үзүүлэх гэрээг Монгол Улстай байгуулсан улс орнуудаас БНСУ-аас даалгаврын 1 хариу ирсэн бөгөөд бусад даалгаврыг хүлээн авсан болохоо илэрхийлж тодорхой мэдээлэл нэмж ирүүлэх шаардлагатай гэсэн шалтгаанаар ажиллагаа явуулахаас татгалзсан, Авлигын эсрэг НҮБ-ын конвенцид нэгдэн орсон улс орнуудад хандан хүргүүлсэн хүсэлтээс хариуг Канад улсаас ирүүлсэн; Швейцарь улсаас мөрдөн шалгах ажиллагааг эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ байгуулаагүй учир биелүүлэх боломжгүй тухайгаа мэдэгдсэн; Америкийн Нэгдсэн Улс, Австрали, ХБНГУ-аас мөрдөгчийн даалгаврыг хүлээн аваад ямар нэгэн хариу ирүүлээгүй.

Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлт, даалгавар бусад материалыг орчуулахад шаардлагатай байцаан шийтгэх ажиллагааны зардалд 2017 онд 50.0 сая төгрөгийг төсөвлөн ажилласан. 2018 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар гадаад, дотоодын байгууллагаас ирүүлсэн нийт 174 эрх зүйн туслалцааны хүсэлт хүлээн авч зохих ажиллагааг хийжээ.

Эрх зүйн туслалцааны хүсэлт, даалгавар, бусад материалын орчуулгын зардлын асуудлыг ГХЯ-ны “Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангийн дүрэм”-д тусгуулах саналыг ХЗДХЯ-аас гаргаж, Засгийн газрын 2018 оны 179 дүгээр тогтоолоор шийдвэрлүүлсэн.

Улсын ерөнхий прокурорын газар 2019 онд мөнгө угаах чиглэлээр гадаад сургалт, Мөнгө угаахтай тэмцэх түр хороо (FATF), Ази, Номхон далайн орнуудын мөнгө угаахтай тэмцэх бүлэг (APG)-ийн уулзалтууд, энэ чиглэлээр ажиллах ажлын хэсгийн үйл ажиллагааг эрчимжүүлэх



төсөв, санхүүгийн тооцоог гаргаж Сангийн яаманд хүргүүлсэн.

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас байгуулсан Гадаад хэргийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Улсын ерөнхий прокурорын газраас төлөөлөл бүхий гадаад улс орнуудтай байгуулсан эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, ялтан шилжүүлэх тухай гэрээний хэрэгжилтийг сайжруулах үүрэг бүхий ажлын хэсэг 2019 оны 05 дугаар сарын 07-ны өдөр хуралдаж эрх зүйн туслалцааны хүсэлт, ялтан шилжүүлэх ажиллагааны холбогдох баримт бичгийн орчуулгын ажил, орчуулгын зардлын асуудал, мөн эрх зүйн туслалцаа, ялтан шилжүүлэх ажлын хүрээнд холбогдох хүсэлт, баримт бичгийн нэгдсэн бүртгэлийн талаар хэлэлцэж, “Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх чиглэлээр хамтран ажиллах журам” боловсруулж, батлуулах талаар талууд тохиролцсон.

Гадаад хэргийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Улсын ерөнхий прокурорын газрын холбогдох албан тушаалтнууд ажил хэргийн уулзалтыг зохион байгуулж, эрх зүйн туслалцаа үзүүлэх хүсэлт, даалгавар, бусад материалыг орчуулахад шаардагдах хөрөнгийн асуудлыг тухай бүр нь шийдвэрлэж байх талаар санал солилцов. (Биелэлт 30 хувь)

4.1.11.2-1. Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн өөрийн үнэлгээний тайланг боловсруулж НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албанд хүргүүлэн, тайланг хамгаалж, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх /АТГ, ХЗДХЯ, УЕПГ, СЯ, ГХЯ, ТАЗ, Монголбанк 2017-2022/

Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн хэрэгжилтийг гаргахдаа тухайн гишүүн улс өөрийн үнэлгээний тайланг гаргаж, түүний хүрээнд томилогдсон гишүүн улсуудын шинжээчдээр эцсийн үнэлгээг гүйцэтгүүлдэг. Үнэлгээ хийх улс болон үнэлгээнд хамрагдах Конвенцийн хэсэг, бүлгийг урьдчилан төлөвлөж, хуваарилсан. Энэхүү хуваарийн дагуу НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны урилгаар Улсын ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, Хууль зүй, дотоод хэргийн яам болон Гүрж Улсын төлөөлөгчдийн шинжээчдийн баг Словени Улсын Конвенцийн хэрэгжилтийн тайланг 2018 онд хянаж, зөвлөмжүүд өгч ажилласан.

Монгол Улсын хувьд Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн хэрэгжилтийг хуваарийн дагуу тайлагнаж, үнэлгээ хийлгүүлэх зорилгоор Авлигатай тэмцэх газрын даргын 2019 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн тушаалаар Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн 2, 5 дугаар бүлгийн хэрэгжилтийг тайлагнах ажлын хэсгийг байгуулан ажиллуулж, тус Конвенцийн 2, 5 дугаар бүлгийн заалт тус бүрээр тайлан боловсруулж, 2019 оны 8 дугаар сарын 23-ны өдөр НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албанд тусгай програмаар дамжуулан илгээв.

НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны энэхүү үнэлгээний ажлын зохион байгуулалтын асуудлыг хариуцсан зөвлөхүүдтэй хамтран ажиллаж байгаа бөгөөд Монгол Улсын Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн өөрийн үнэлгээний тайланг НҮБ-аас тогтоосон журам, үнэлгээний механизмын дагуу 2020 онд үнэлнэ. (Биелэлт 30 хувь)

4.1.11.2-2. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Зүүн Европ, Төв Азийн авлигын эсрэг сүлжээний Авлигатай тэмцэх үйл ажиллагааны Станбулын төлөвлөгөөний тайланг гаргаж хүргүүлэх, тайлагнах, хамгаалах /АТГ 2017-2022/

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Авлигын эсрэг сүлжээний Станбулын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө нь Зүүн Европ, Төв Азийн бүс нутгийн улс орнуудад явуулж буй авлигын эсрэг үйл ажиллагаа, эрх зүйн орчинд үнэлгээ хийх зорилгоор 2003 онд байгуулагдсан.

Монгол Улс нь Станбулын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд 2012 онд нэгдэн орсон бөгөөд 2014 онд тус байгууллагын Үнэлгээний баг манай улсын авлигын эсрэг үйл ажиллагаа, эрх зүйн орчинд анх удаа үнэлгээ хийсэн. Үнэлгээний цар хүрээ нь авлигатай тэмцэх байгууллага, худалдан авах ажиллагаа, санхүүгийн дотоод хяналт шалгалт, дотоод аудит, шүүх, прокурорын байгууллага, хувийн хэвшил зэрэг байгууллагуудтай холбоотой үйл ажиллагаа, эрх зүйн орчноос гадна авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мэдээллийн ил тод байдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаарх асуудлуудыг хамарсан.



Авлигатай тэмцэх газраас 2017 онд Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх талаарх Монгол Улсын холбогдох тайлан мэдээллийг бэлтгэн, урьдчилсан хамгаалалт хийсэн тус байгууллагын Авлигын эсрэг сүлжээний Станбулын авлигын эсрэг төлөвлөгөөний 2016-2020 оны ажлын төлөвлөгөөний хүрээнд хийсэн ажлын талаарх явцын мэдээллийг жил бүр бэлтгэн тус байгууллагад заасан хугацаанд хүргүүлж байна.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Авлигын эсрэг сүлжээнээс Монгол Улсын авлигын эсрэг эрх зүйн орчин, төрийн холбогдох байгууллагуудаас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг үнэлэх ээлжит ажил 2018 оны 8 дугаар сард эхэлж, 2019 оны 1 дүгээр сарын 8-ны өдөр тус байгууллагын Шинжээчдийн багаас мониторингийн ажилд шаардлагатай нэмэлт мэдээллийн жагсаалтыг Авлигатай тэмцэх газарт ирүүлж, Авлигатай тэмцэх газар төрийн болон төрийн бус 13 байгууллагаас холбогдох мэдээллийг нэгтгэн авч, тус байгууллагад хариу илгээсэн болно. Тус сүлжээнээс 2019 оны 3 дугаар сарын 22-ны өдөр Парис хотод гишүүн улсуудын төлөөллийг оролцуулсан Удирдах зөвлөлийн уулзалтыг зохион байгуулж, энэхүү хуралд Монгол Улсын төлөөлж, Сангийн яам, Улсын ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, Трансперэнси Интернэшнл-Монгол ТББ-ын нийт 6 төлөөлөгч оролцон, Авлигын эсрэг сүлжээний шинжээчдийн багаас үнэлгээний тайлангийн талаар танилцуулж, талууд харилцан санал солилцсоны дараа Монгол Улсын авлигын эсрэг орчны үнэлгээний тайланг тус сүлжээнээс эцэслэн баталж, Монгол Улсын Ерөнхий сайд, Авлигатай тэмцэх газрын дарга нарт албан бичгээр ирүүлсэн. Монгол Улсын авлигын эсрэг орчинд хийсэн мониторингийн тайланг баталсны мөрөөр Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Авлигын эсрэг сүлжээний зөвлөхүүд 2019 оны 7 дугаар сарын 29, 30-ны өдөр Монгол Улсад ажиллаж, мониторингийн тайлан, зөвлөмжийг олон нийт болон төрийн байгууллагуудад танилцуулах, хэвлэлийн бага хурал хийх зэрэг арга хэмжээг зохион байгуулсан. Цаашид тус сүлжээнээс гаргасан үнэлгээний тайланг монгол хэлэнд орчуулж, тусгагдсан зөвлөмжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр Авлигатай тэмцэх газраас төлөвлөгөө гарган ажиллаж байна. (Биелэлт 70 хувь)

4.1.11.2-3. НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба, Дэлхийн банкны хамтарсан “Хулгайлагдсан хөрөнгийг буцаан олгох санаачилга” (StAR)-тай хамтран төсөл хэрэгжүүлэх /АТГ 2017-2019/

Авлигатай тэмцэх газраас 2017 оны 4 дүгээр 16-17-ны өдрүүдэд НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба, Дэлхийн банкны хамтарсан “Хулгайлагдсан хөрөнгийг буцаан олгох санаачилга” (StAR)-тай хамтран “Хөрөнгө, орлогын мэдүүлгийн хяналтын тогтолцоог бэхжүүлэх нь” сэдэвт хоёр өдрийн сургалтыг зохион байгуулсан бөгөөд тус санаачилгаас ирүүлсэн хамтын ажиллагааны шинэ төсөлд холбогдох саналыг боловсруулан хүргүүлэв.

StAR"-тай хамтран хууль сахиулах байгууллагын албан хаагчдыг чадавхжуулах чиглэлээр хамтарсан сургалтыг үе шаттайгаар зохион байгуулж байна. Энэ хүрээнд 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдрөөс 05 дугаар сарын 01-ний өдрүүдэд хууль сахиулах байгууллагуудын дунд “Хууль сахиулах ажилтнуудын хэлэлцүүлэг”-ийг зохион байгуулж, “Хөрөнгө буцаах гарын авлага”-ын төслийн талаар хэлэлцэж, байгууллагуудын саналуудын нэгтгэн тусгав.

“StAR”-тай хамтран 2018 оны 10 дүгээр сарын 08-ны өдрөөс 12-ны өдрүүдэд хууль сахиулах байгууллагуудын албан хаагчдад зориулсан “Санхүүгийн гэмт хэрэг мөрдөн шалгах анхан шатны сургалт”, мөн хууль сахиулах байгууллагуудын удирдах албан тушаалтнуудад зориулсан “Санхүүгийн гэмт хэрэг мөрдөн стратеги, менежмент семинар” зохион байгуулсан. “StAR”-тай хамтран ажиллах урт хугацааны төлөвлөгөөнд тусгуулах саналыг боловсруулж, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Авлигын эсрэг сүлжээнээс жил болгон гишүүн орнуудаас авдаг Авлигын эсрэг үйл ажиллагааны явцын тайлан болон орон нутаг дахь авлигын асуудлаар мэдээлэл бэлтгэн хүргүүлсэн.

Тус Санаачилгатай хамтран 2019 оны 4 дүгээр сарын 8-11-ний өдрүүдэд “Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа” сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Энэхүү сургалтад хөрөнгө царцаах, хураах, хөрөнгө буцаах, олон улсын хамтын ажиллагаа, санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны ахисан түвшний арга

хэрэгслүүд зэрэг сэдвээр сургагч багш нар мэдээлэл хийжээ. Тус сургалтад Улсын ерөнхий прокурорын газар, Тагнуулын ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Монголбанк болон зарим төрийн байгууллагын эрх бүхий албан хаагчид хамрагдав. Мөн Авлигатай тэмцэх газраас дээрх Санаачилгатай хамтран 2019 оны 5 дугаар сарын 15-16-ны өдрүүдэд “Хөрөнгө, орлогын мэдүүлгийн хяналт шалгалт” сэдэвт сургалтыг зохион байгууллаа. (Биелэлт 30 хувь)

4.1.11.2-4. Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагатай сургалт, семинар зохион байгуулах зэрэг чиглэлээр хамтран ажиллах /АТГ, 2017-2022/

Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагаас зохион байгуулсан Австри Улсад болсон “Сингапур улсын авлигатай тэмцэх сайн туршлага” сэдэвт сургалт, БНХАУ-ын Хонг Конг мужид зохион байгуулагдсан “Эдийн засгийн гэмт хэргийг мөрдөн шалгах нь” сэдэвт сургалт, Гүрж улсад зохион байгуулагдсан “Авлигын эсрэг сургалт”-д тус тус төлөөлөл оролцуулав. Мөн тус байгууллагатай хамтран 2017 оны 5 сарын 8-10-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо “Авлигын эсрэг хамтын ажиллагааг Монгол Улсад идэвхжүүлэх нь” сэдэвт гурван өдрийн сургалт, 2017 оны 9 дүгээр сарын 20-22-ны өдрүүдэд “Олон улсын болон үндэсний хэмжээнд авлига, мөнгө угаах явдалтай тэмцэх нь” сэдэвт гурван өдрийн сургалтыг тус тус хамтран зохион байгуулсан.

Авлигатай тэмцэх газар, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагатай хамтран 2018 оны 06 дугаар сарын 14-15-ны өдрүүдэд “Оффшор бүс нутгийг ашиглан мөнгө угаах, түүнтэй тэмцэх олон улсын туршлага” сэдэвт сургалт зохион байгуулж, хуулийн болон хууль сахиулах байгууллагуудын 35 албан хаагчдыг хамруулсан. Мөн тус байгууллагын “Авлигатай тэмцэх гарын авлага”-ыг Монгол хэлнээ орчуулж, төрийн болон төрийн бус байгууллагуудад түгээв.

2019 оны 5 дугаар сард Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагатай хамтран “Цахим мөнгөн тэмдэгтийг ашиглан гэмт хэрэг үйлдэх явдалтай тэмцэх нь” сэдэвт сургалт, 2019 оны 10 дугаар сард “Авлигын гэмт хэргийг шийдвэрлэх туршлага солилцох

нь” сэдэвт семинар зохион байгуулсан. (Биелэлт 70 хувь)

4.1.11.3-1. Гадаад улсын авлигатай тэмцэх, хууль сахиулах байгууллагатай хамтын ажиллагааг бэхжүүлэх, санамж бичиг байгуулах, харилцан туршлага судлах, солилцох ажлыг зохион байгуулах /ХЗДХЯ, ГХЯ, АТГ 2019-2020/

БНХАУ-ын Нийгмийг аюулаас хамгаалах яамтай 2011 онд байгуулсан санамж бичгийн хүрээнд 2017-2021 онд хамтран ажиллах үйл ажиллагааны хөтөлбөр, ОХУ-ын Дотоод хэргийн яамтай хамтран ажиллах тухай 2017 оны хэлэлцээрийн хүрээнд 2020 он хүртэл олон улсад гэмт хэрэгтэй тэмцэх, хамтын ажиллагааг хөгжүүлэхээр хамтран ажиллах протоколыг байгуулан ажиллаж байна. “Гэмт этгээд шилжүүлэх тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс хоорондын гэрээ”-г 2019 оны 07 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан бөгөөд Улсын Их Хурлын чуулганаар соёрхон батлуулахаар Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 2019 оны 12 дугаар сарын 03-ны өдөр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.

“Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засаг захиргааны онцгой бүс Макао хоорондын хэлэлцээр”-ийг Улсын Их Хурлын чуулганаар соёрхон батлуулахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2019 оны 12 дугаар сарын 03-ны өдөр хүргүүлэв.

Авлигатай тэмцэх газар 2016-2019 оны хооронд НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба, Авлигын эсрэг олон улсын академи, Авлигатай тэмцэх байгууллагуудын олон улсын холбоо, Хулгайлагдсан хөрөнгийг буцаан олгох “StAR” санаачилга, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага, Ази, номхон далайн орнуудын хулгайлагдсан хөрөнгө буцаах байгууллагууд хоорондын сүлжээ болон Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Авлигын эсрэг олон улсын удирдах төв, Онц залилангийн гэмт хэрэгтэй тэмцэх алба, АНУ-ын Хууль зүйн департамент, Холбооны мөрдөх товчоо, Швейцарийн Холбооны Улсын Ерөнхий прокурорын газар, Хонг Конгийн Авлигатай тэмцэх бие даасан хороо, БНСУ-



ын Авлигын эсрэг, иргэний эрхийн хороо, Азербайжан Улсын Авлигын эсрэг газар зэрэг байгууллагуудтай хамтран ажиллаж, харилцаагаа өргөжүүлэн, хөгжүүлж байна.

Монгол Улс Авлигын эсрэг олон улсын академийн гишүүнийнхээ хувьд олон улсын хэлэлцээрээр хүлээсэн үүргээ биелүүлж, гишүүн орнуудын албан хаагчид тус Академийн зуны сургалтад хөнгөлттэй нөхцөлөөр хамрагдаж байна.

“StAR” санаачилгатай хамтран санхүүгийн гэмт хэрэг мөрдөн шалгах анхан шатны сургалт, прокурорын байгууллага, хууль сахиулах байгууллагуудын ажилтнуудын дундах уулзалт, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагатай хамтран “Оффшор бүс нутгийг ашиглан мөнгө угаах явдалтай тэмцэх нь” сэдэвт сургалтыг тус тус зохион байгуулж, УЕПГ, АТГ, ТЕГ, ЦЕГ, Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албаны албан хаагчдыг оролцуулж, мэдлэг, чадварыг нь дээшлүүлсэн.

Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын байгууллагын “Авлигатай тэмцэх гарын авлага”-ыг Монгол хэлнээ орчуулж, төрийн болон төрийн бус байгууллагуудад түгээж байна.

Швейцарийн Холбооны Улсын Ерөнхий прокурорын газар, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Авлигын эсрэг олон улсын удирдах төв, Онц залилангийн гэмт хэрэгтэй тэмцэх алба, АНУ-ын Хууль зүйн департаментын Олон улсын хамтын ажиллагааны газар, Холбооны мөрдөх товчооны олон улсын ажиллагааны албаны төлөөлөлтэй уулзалт хийж, эрүүгийн хэрэг хамтран мөрдөн шалгаж, харилцан ашигтай мэдээлэл солилцож байна.

Түүнчлэн, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Онц залилангийн гэмт хэрэгтэй тэмцэх алба, Азербайжан Улсын Авлигын эсрэг газартай харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан.

2019 оны 07 дугаар сард Монгол Улсын ерөнхий прокурорын газрын албаны төлөөлөгчид ОХУ-ын Ерөнхий прокурорын газарт ажлын айлчлал хийж, “Монгол Улсын ерөнхий прокурорын газар, ОХУ-ын Ерөнхий прокурорын газрын 2020-2021 оны хамтын ажиллагааны хөтөлбөр”-ийг харилцан гарын

үсэг зурж, батлав. 2019 оны 11 дүгээр сард БНХАУ-д ажлын айлчлал хийж, “Монгол Улсын Ерөнхий Прокурорын Газар, БНХАУ-ын Ардын дээд прокурорын газар хоорондын хамтын ажиллагааны гэрээ”-г байгуулав.

“Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар болон Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Нийгмийн аюулгүй байдлын яамны харьяа Хорих байгууллагын удирдах газар хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”; “Шүүхийн шинжилгээний үйл ажиллагааны салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн, Бүгд Найрамдах Беларусь Улсын Шүүхийн шинжилгээний улсын хороо хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”-ийг тус тус байгуулсан.

ОХУ-ын Москва хотод 2019 онд зохион байгуулагдсан Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Евроазийн бүсийн байгууллагын 30 дахь удаагийн хуралд Улсын ерөнхий прокурорын газрын төлөөлөл оролцож, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх ажиллагааны хэв шинж, эдгээр гэмт хэргийг илрүүлэхэд учирч байгаа бэрхшээлийн талаар бусад улсын прокуроруудтай санал солилцож, туршлага судалсан байна. (Биелэлт 70 хувь)

4.1.11.3-2. Гэмт хэргийн улмаас гадаад улсад гарсан хөрөнгийг буцаан авахтай холбоотой асуудлыг судлан Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн үзэл баримтлалд нийцүүлэн дотоодын хууль тогтоомжийг боловсронгуй болгох /ХЗДХЯ, ГХЯ, АТГ 2018/

Иргэний болон аж ахуйн хэргээр эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Беларусь Улс хооронд байгуулах гэрээний төслийг ХЗДХЯ-аас Засгийн газрын хуралдаан, Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороогоор хэлэлцүүлж, 2018 оны 06 дугаар сарын 04-нд гэрээг байгуулав. Гэрээг соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх ажлын бэлтгэлийг ханган ажиллаж, хуулийн төслийг 2018 оны 12 дугаар сарын 04-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, 2019 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр Улсын Их Хурлаас

соёрхон батлав. “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засаг Захиргааны онцгой бүс Хонконгийн Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг Улсын Их Хурлаар 2018 оны 10 дугаар сарын 26-ны өдөр соёрхон батлуулсан.

Авлигатай тэмцэх газраас 2016-2019 оны хооронд Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийг үндэс болгон нийт 16 эрх зүйн туслалцааны хүсэлтийг гадаад орны эрх бүхий байгууллагад хүргүүлж, хоёр улсаас гүйцэтгэлийн талаар мэдээлэл хүлээн авсан. Энэ чиглэлээр Австри Улсын Вена хот дахь НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны Нэгдсэн хурал, уулзалтууд тухай бүр урилгаар оролцож, шинэ мэдээлэл авч, бусад улс орны эрх бүхий байгууллагатай харилцаа тогтоон, мэдээлэл солилцож, хамтран ажиллаж ирсэн.

Санхүүгийн гэмт хэрэг мөрдөн шалгах, гадаад улсаас эрх зүйн туслалцаа хүсэх, үзүүлэх чиглэлээр “StAR” санаачилгатай хамтран албан хаагчдыг чадавхжуулах сургалтыг зохион байгуулав.

Авлигатай тэмцэх газрын санаачилгаар ХЗДХЯ, ГХЯ, УДШ, УЕПГ, ТЕГ, ЦЕГ, МУИС-ийн Хууль зүйн сургууль, Хууль сахиулахын Их сургууль, Монголын Хуульчдын Холбооны төлөөлүүдийг оролцуулан хамтран “Эрүүгийн хэрэг дэх эрх зүйн харилцан туслалцаа-Хамтын ажиллагаа” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулж, зөвлөмж гарган эрх бүхий байгууллагуудад хүргүүлэв. Монгол Улс 19 улстай оронтой эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ байгуулсан байдаг. Улсын Их Хурлын 2018 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн чуулганаар Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Хонг Конгийн Засгийн газар хооронд байгуулсан Иргэний болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай хуулийг баталсан байна.

Гадаад улсад хөрөнгө буцаан авах чиглэлээр илгээх хүсэлтийг олон улсын гэрээ, хэлэлцээрт заасан шаардлагыг хангахуйц, оновчтой, үндэслэлтэй боловсруулах, эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагааны талаарх эрх зүйн баримт бичгийг боловсронгуй болгоход анхаарч, Улсын ерөнхий прокурорын газраас «Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа

харилцан үзүүлэх ажиллагааны аргачилсан заавар», “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагааны эрх зүйн хэлбэрүүдийн жагсаалт, загвар”, “Монгол Улсаас эрх зүйн туслалцаа үзүүлэхэд өгөх зөвлөмж”-ийг тус тус боловсруулж, Улсын ерөнхий прокурорын 2019 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн А/16 дугаар тушаалаар баталж, прокуроруудын үйл ажиллагаанд мөрдүүлж байна. (Биелэлт 30 хувь)

4.1.11.4-1. Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн этгээдийг харилцан шилжүүлэх тухай дотоодын хууль тогтоомжийн зохицуулалтыг боловсронгуй болгох /ХЗДХЯ, УЕПГ, АТГ 2018-2022/

Монгол Улс 18 улстай гэмт этгээд шилжүүлэх тухай гэрээ, хэлэлцээрийг байгуулаад байна.

Монгол Улсын “Гэмт этгээд шилжүүлэх тухай Европын Конвенц” болон “Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Европын Конвенц”-д нэгдэн орох ажлыг Хууль зүй, дотоод хэргийн яам хариуцан ажиллаж байна. Монголын талаас тус конвенцид нэгдэн орохтой холбоотой саналаа Европын зөвлөлийн Нарийн бичгийн даргын газарт хүргүүлсэн.

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас гадаад улс орнуудтай байгуулсан эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, ялтан шилжүүлэх тухай гэрээний хэрэгжилтийг сайжруулахаар Гадаад харилцааны яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Улсын ерөнхий прокурорын газраас төлөөлөл бүхий ажлын хэсэг 2019 оны 05 дугаар сард хуралдаж ялтан шилжүүлэх үйл ажиллагаанд гарч буй хүндрэл бэрхшээлээс гадна БНХАУ-аас ялтан шилжүүлэн авах ажиллагаа удааширч байгаа, БНХАУ-аас шилжүүлэн авсан ялтан Монгол Улсын шүүхээс дүйцүүлэн оногдуулсан ялын хэмжээ БНХАУ-ын шүүхээс оногдуулсан ялын хэмжээнээс зөрүүтэй байдал нь БНХАУ-ын талаас ялтан шилжүүлэн өгөх ажиллагаанд нөлөөлж байгаа, ялтан шилжүүлэх ажиллагааг гүйцэтгэхэд ШШГЕГ-аас ирүүлж буй албан бичигт мэдээлэл дутуу байх, дутуу мэдээллийг ХЗДХЯ-наас ГХЯ-нд нөхөж мэдээлэхэд хугацаа тулгамддаг, зарим ялтны ар гэртэй холбогдох холбоо барих утас, бусад суваг тодорхой бус байгаагаас төлбөр болон ялтны бусад мэдээллийг дамжуулахад хүндрэл учирдаг зэрэг асуудал, эрх зүйн туслалцааны хүсэлт, ялтан шилжүүлэх ажиллагааны холбогдох



баримт бичгийн орчуулгын ажил, орчуулгын зардлын асуудал, мөн эрх зүйн туслалцаа, ялтан шилжүүлэх ажлын хүрээнд холбогдох хүсэлт, баримт бичгийн нэгдсэн бүртгэлийн талаар хэлэлцэн хурлын үр дүнг Хууль зүй, дотоод хэргийн сайдад танилцуулсан. Цаашид шинээр байгуулах гэрээнд албан тушаалаа урвуулан ашиглах, авлигын гэмт хэрэгтэй холбоотой заалтыг тусгаж ажиллахаар төлөвлөсөн.

ХЗДХЯ, ГХЯ, УДШ, УЕПГ, ТЕГ, ЦЕГ, МУИС-ийн Хууль зүйн сургууль, Хууль сахиулахын Их сургууль, Монголын хуульчдын холбооны төлөөлүүдийг оролцуулан хамтран зохион байгуулсан “Эрүүгийн хэрэг дэх эрх зүйн харилцан туслалцаа-Хамтын ажиллагаа” сэдэвт хэлэлцүүлгээр хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудлыг хэлэлцэж, зөвлөмжийг боловсруулан эрх бүхий байгууллагуудад хүргүүлсэн.

Гадаад улстай гэмт хэрэг үйлдсэн этгээдийг харилцан шилжүүлэх талаар хамтран ажиллах чиглэлээр дотоодын хууль тогтоомж, эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагааны талаарх эрх зүйн баримт бичгийг боловсронгуй болгоход анхаарч, Улсын ерөнхий прокурорын газраас “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг шилжүүлэн авах тухай хүсэлтийн бүтэц, загвар”-ыг боловсруулж, Улсын ерөнхий прокурорын 2019 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн А/16 дугаар тушаалаар баталж, прокуроруудын үйл ажиллагаанд мөрдүүлж байна. (Биелэлт 30 хувь)

4.1.11.5-1. Олон улсын авлигын эсрэг холбоо, сүлжээ, санаачилгуудыг судалж, сайн туршлагыг нэвтрүүлэх /ГХЯ, ХЗДХЯ, АТГ, Холбогдох байгууллага 2017-2022/

Олон улсад авлигатай тэмцэх чиглэлээр өрнөж буй үйл ажиллагааг өдөр бүр судлан гадаад мэдээний тойм бэлтгэж, олон нийтэд мэдээлж хэвшсэн. Авлигатай тэмцэх газрын Олон нийтийн төвд зохион байгуулж буй Авлигын эсрэг сургалтын сэдэв бүрт гадаад улсын сайн туршлагуудыг оруулан танилцуулга мэдээлэл өгч байна.

Дэлхийн банк, Нэгдсэн үндэстний байгууллагын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага, Авлигын

эсрэг олон улсын академи, БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага Ази, Номхон далайн орнуудын мөнгө угаахтай тэмцэх бүлэг зэрэг байгууллагуудаас зохион байгуулсан хурал, сургалтад албан хаагчдыг тогтмол оролцуулан мэдээлэл, туршлага солилцох боломжийг бүрдүүлсэн. Ижил төстэй чиг үүрэг гүйцэтгэдэг гадаадын байгууллагын төлөөлөгчидтэй Авлигатай тэмцэх үндэстний хөтөлбөр түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, бусад холбогдох асуудлаар ажил хэргийн уулзалтуудыг зохион байгуулж, хамтын ажиллагааг хөгжүүлж байна.

Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын асуудлаар ил тод байдлыг хангах тухай Монгол Улс, Америкийн Нэгдсэн Улс хоорондын хэлэлцээрийн 7 дугаар зүйлд авлигатай тэмцэх асуудлаар АНУ-тай хамтран ажиллах эрх зүйн хүрээг тодорхойлж, хэлэлцээр 2017 оны 3 дугаар сарын 20-нд хүчин төгөлдөр болсон. Хэлэлцээрийн дагуу олон улсын худалдаа, хөрөнгө оруулалт дахь авлига, хээл хахуулийн эсрэг тэмцэх санал санаачилгыг урамшуулан дэмжих талаар АНУ-тай хамтран ажиллаж байна. ХБНГУ-ын энэ төрлийн байгууллагатай туршлага солилцох, сургалт зохион байгуулах ажлыг судалж байна.

Авлигатай тэмцэх газраас “Хулгайлагдсан хөрөнгийг буцаан олгох санаачилга” (StAR)-тай 2013 оноос хойш хамтран ажиллаж байгаа бөгөөд олон удаагийн, үе шат бүхий сургалтыг тус Санаачилгатай хамтран төлөвлөж, зохион байгуулсаар ирсэн. 2019 оны 4 дүгээр сарын 8-11-ний өдрүүдэд тус Санаачилгын сургагч багш нартай хамтран “Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны сургалт”-ыг зохион байгуулж, Улсын ерөнхий прокурорын газар, Тагнуулын ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Монголбанк болон зарим төрийн байгууллагын эрх бүхий албан хаагчид хамруулав. Мөн Авлигатай тэмцэх газраас дээрх Санаачилгатай хамтран 2019 оны 5 дугаар сарын 15-16-ны өдрүүдэд “Хөрөнгө, орлогын мэдүүлгийн хяналт шалгалт” сэдэвт сургалтыг зохион байгуулжээ.

2018 онд Индонези улсын Бали хотод зохион байгуулагдсан Ази, номхон далайн орнуудын хөрөнгө буцаах байгууллагууд хоорондын сүлжээ (ARIN-AP)-ний Удирдах зөвлөлийн уулзалт, Бүгд хурлаас Монгол Улс

удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдож, тус Сүлжээний Бүгд хурал болон Удирдах зөвлөлийн хурлыг Улаанбаатар хотод зохион байгуулах эрхийг авч, 2019 онд даргалагч улсаар томилогдов. Улмаар 2019 оны 9 дүгээр сарын 23-27-ны өдрүүдэд Ази, номхон далайн орнуудын хөрөнгө буцаах байгууллагууд хоорондын сүлжээний Удирдах зөвлөлийн хурал, Бүгд хурал болон Австрали Улсын Дотоод хэргийн яамтай хамтран хөрөнгө буцаан авах чиглэлээр олон улсын сургалтыг Улаанбаатар хотод зохион байгуулав. Тус арга хэмжээнүүдэд гадаадын гишүүн 24 улс, 5 олон улсын байгууллагын 70, дотоодын 7 хууль сахиулах байгууллагын 56 төлөөлөгч буюу нийт 126 оролцогч хамрагдсан.

Монгол Улс нь Станбулын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд 2012 онд нэгдэн орсон бөгөөд 2014, 2018 онд тус байгууллагын Үнэлгээний баг манай улсын авлигын эсрэг үйл ажиллагаа, эрх зүйн орчинд үнэлгээ хийж, зөвлөмж өгснийг хэрэгжүүлж байна. (Биелэлт 70 хувь)

4.1.11.5-2. Олон улсын туршлага судлах, чадавхи бэхжүүлэх, үнэлгээ мониторингийн чиглэлээр олон улсын сүлжээ, санаачилгад идэвхтэй оролцох /ГХЯ, ХЗДХЯ, АТГ, Холбогдох байгууллага 2017-2022/

Мянган хөгжлийн сангийн Хоёрдугаар компакт гэрээний Монгол Улсын авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх зорилтын хүрээнд АНУ-ын Элчин сайдын яамны урилгаар Авлигатай тэмцэх газрын ажлын хэсэг тус улсад 2018 оны 3 дугаар сард туршлага судлах сургалтад хамрагдан, авлигатай тэмцэх чиг үүргийг гүйцэтгэдэг төрийн байгууллагуудын төлөөлөгчидтэй уулзалт хийж, авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаатай нь танилцан, төрийн байгууллага, төрийн албан тушаалтны үйл ажиллагаан дахь иргэдийн хяналт, оролцооны талаарх туршлагыг судлан, байгууллагууд хоорондын цаашдын хамтын ажиллагааг бэхжүүлэн ажиллаж байна.

2018 онд Бүгд Найрамдах Киргиз Улсын “Станбулын авлигын эсрэг төлөвлөгөө”-г хэрэгжүүлсэн байдалд үнэлгээ өгөх олон улсын шинжээчдийн багт Авлигатай тэмцэх газрын албан хаагч томилогдон ажиллаж, Киргиз Улсын нөхцөл байдлыг үнэлэн тайлан бэлтгэж, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн

байгууллагад хүргүүлэв. НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албанаас томилсон Словени Улсын Конвенцийн хэрэгжилтийн тайланг үнэлэх шинжээчдийн багт Монгол Улсын төлөөлөгчид ажиллан тайланг хянаж баталгуулан, зөвлөмж хүргүүлэв.

Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө нь 2003 онд байгуулагдсан.

Монгол Улс нь Зүүн Европ, Төв Азийн бүс нутгийн улс орнуудад явуулж буй авлигын эсрэг үйл ажиллагаа, эрх зүйн орчинд үнэлгээ хийдэг Станбулын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд 2012 онд нэгдэн орж, үнэлгээ хийлгэж байна. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Авлигын эсрэг сүлжээний шинжээчдийн баг Монгол Улсын авлигын эсрэг эрх зүйн орчин, төрийн холбогдох байгууллагуудаас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг 2014, 2018 онд үнэлж, тайланг эцэслэн баталж, Монгол Улсын Ерөнхий сайд, Авлигатай тэмцэх газрын дарга нарт ирүүлсэн. Энэхүү тайланд төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал, прокурор, шүүх, хууль сахиулах байгууллагуудын хараат бус байдал, худалдан авах ажиллагааны ил тод байдал, нийтийн алба болон төрийн улс төрийн албан тушаалтны шударга байдал, улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдал, бизнесийн шударга байдал зэрэг сэдвийн хүрээнд 29 хэсэг бүхий 153 зүйл зөвлөмжийг Монгол Улсад өгсөн байна. Авлигатай тэмцэх газраас уг үнэлгээний ажлыг зохион байгуулахад анхнаас нь оролцож, тайлан гарсны дараа зөвлөмжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр ажиллаж байна.

Авлигатай тэмцэх газраас 2017 онд Мөнгөугаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх талаарх Монгол Улсын холбогдох тайлан мэдээллийг бэлтгэн, урьдчилсан хамгаалалт хийсэн тус байгууллагын Авлигын эсрэг сүлжээний Станбулын авлигын эсрэг төлөвлөгөөний 2016-2020 оны ажлын төлөвлөгөөний хүрээнд хийсэн ажлын талаарх явцын мэдээллийг жил бүр бэлтгэн тус байгууллагад заасан хугацаанд хүргүүлж байна.

2019 онд Бүгд Найрамдах Азербайжан Улсын Ерөнхий прокурорын газрын дэргэдэх Авлигын эсрэг газрын дарга тэргүүтэй төлөөлөгчдийн албан ёсны айлчлал, БНСУ-ын Авлигын эсрэг, иргэний эрхийн хорооны төлөөлөгчдийн



айлчлал, БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Хонг Конгийн Авлигатай тэмцэх бие даасан хорооны төлөөлөгчдийн айлчлалыг зохион байгуулж, харилцан туршлага солилцов.

БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Хонг Конг мужийн Авлигатай тэмцэх бие даасан хороо байгуулагдсаны 45 жилийн ойн арга хэмжээ, Бүгд Найрамдах Казакстан Улсын Авлигын эсрэг агентлагаас зохион байгуулсан арга хэмжээнд Авлигатай тэмцэх газрын албан хаагчид болон Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлийн дарга, гишүүд оролцлоо. Олон улсын байгууллагаас Монгол Улсад зохион байгуулсан сургалтад 90 албан хаагч, гадаад улс оронд зохион байгуулагдсан сургалтад 19 албан хаагчийг суралцуулж, чадавхжуулав.

2019 онд БНХАУ-ын засаг захиргааны онцгой бүс Хонг Конг мужийн Авлигатай тэмцэх бие даасан хороонд туршлага солилцох сургалт, уулзалтад 9 алба хаагчийг, 7 хоногийн эрчимжүүлсэн сургалтад 10 мөрдөгчийг, Тайваний Тайпей хотод охион байгуулагдсан Америкийн Нэгдсэн Улсын Холбооны мөрдөх товчооны академийг төгсөгчдийн холбооны бүс нутгийн давтан сургалтад 1 албан хаагчийг хамруулав.

Нидерландын Вант Улсын Гааг хотод зохион байгуулагдсан Хөрөнгө буцаах байгууллага хоорондын сүлжээнүүдийн нэгдсэн хурал, Австралын Холбооны Улсын Канберра хотод зохион байгуулагдсан Ази, Номхон далайн бүс нутгийн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн хурал, Тайландын Вант Улсын Бангкок хотод зохион байгуулагдсан Ази, Номхон далайн

бүс нутгийн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн олон улсын хамтын ажиллагааны хяналтын бүлгийн уулзалт, Ази, Номхон далайн бүс нутгийн Авлигын эсрэг санаачилгын Нарийн бичгийн дарга нарын газраас Вьетнам улсын Ханой хотноо Авлигын эсрэг бүс нутгийн хуралд албан хаагчид оролцож, Монгол Улсын авлигатай тэмцэх чиглэлээр гарч буй ололт амжилт, хүндрэл бэрхшээл зэрэг асуудлаар санал солилцож, туршлагаа хуваалцсан.

“Транспэрэнси Интернэшнл-Монгол” олон улсын байгууллагатай хамтран олон улсад сайшаагдсан авлигын эсрэг үйл ажиллагаанд иргэдийг оролцуулдаг туршлагаар “Сайн туршлага: Иргэдийн бүлэг” сэдэвт сургалтыг 2019 оны 11 дүгээр сард Улаанбаатар хотод иргэд, сургуулиудын эцэг эхийн зөвлөлийн төлөөлөл, “Глоб интернэшнл”, “Либерал эмэгтэйчүүдийн оюуны сан”, “Зориг сан”, “Хүний эрх хөгжил төв”, “Нээлттэй нийгэм форум”, “Монголын нутгийн удирдлагын нийгэмлэг” “Монголын залуучуудын холбоо” зэрэг ТББ, оюутнууд зэрэг 89 иргэнийг хамруулан зохион байгуулав. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Монгол Улсад хэрэгжүүлэх “Монгол улсын Засгийн газарт олгох техникийн туслалцаа”-ны төслийн хүрээнд Авлигатай тэмцэх газар, Шүүхийн Ерөнхий зөвлөл, Улсын Ерөнхий прокурорын газар, Азийн хөгжлийн банк хамтран 2018 оны 12 дугаар сараас 2 жилийн хугацаатай “Монгол Улс: Авлигатай тэмцэх тогтолцоог бэхжүүлэх нь” төслийг хэрэгжүүлж байна. (Биелэлт 70 хувь)

-oOo-



## ДҮГНЭЛТ, САНАА

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн 51 дүгээр тогтоолоор Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Засгийн газрын 2017 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 114 дүгээр тогтоолоор “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г тус тус баталсан билээ. Үндэсний хөтөлбөрийн үндсэн зорилго нь “Төрийн байгууллага, албан тушаалтан, хувийн хэвшил, иргэний нийгэм, улс төрийн нам, бүлгийг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, олон нийтэд шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх, ил тод, нээлттэй, хариуцлагатай нийгмийг хөгжүүлэх” явдал бөгөөд уг зорилгод хүрэхээр 11 зорилтыг дэвшүүлж, 83 үйл ажиллагааг 2016-2023 он хүртэл 2 үе шаттайгаар 6 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр тусгасан болно. Үндэсний хөтөлбөрийн нэгдэх үе шат 2019 онд дууссантай холбогдуулан хариуцсан байгууллагуудаас 2020 оны 02 дугаар сарын 01-ний дотор арга хэмжээний биелэлтийг гаргуулан авч, судалж, хяналт шинжилгээ үнэлгээ хийв.

Хөтөлбөрийн 5.1.1-д заасан хүрэх үр дүнг асуудал тус бүрээр дүгнэн танилцуулбал:

### **Нэг. Авлигатай тэмцэх эрх зүйн орчинг боловсронгуй болгох, нийтийн албанд цогц шинэтгэл хийх үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар:**

Хөтөлбөрийн нэг дэх үе шатанд Улсын Их Хурлаас авлигатай тэмцэх эрх зүйн орчинг бүрдүүлэхэд анхаарч, шаардлагатай хууль тогтоомжийг баталсан байна. Тухайлбал, Эрүүгийн болон Зөрчлийн багц хуулийн төсөл, холбогдох нэмэлт, өөрчлөлтүүдийг батлан гаргасан бөгөөд эдгээр хуулиудад авлиг

УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2017 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хянах, хадгалах журам батлах тухай” 2012 оны 05 дугаар тогтоолд нэмэлт оруулж, “хувийн ашиг

сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг цахим хэлбэрээр мэдүүлсэн тухай”, “нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг цахим хэлбэрээр мэдүүлсэн тухай” баталгааны маягтуудыг батлуулан мөрдөж байна. Мэдүүлэг гаргагч албан тушаалтнууд ХАСХОМ-ээ цаасаар хэвлэж, баталгаажуулдаг байсныг өөрчлөн, зөвхөн “Баталгааны маягт”-ыг ашигладаг болгосноор эдийн засгийн болон мэдүүлэг гаргагч, мэдүүлгийг бүртгэж хүлээн авч байгаа эрх бүхий албан тушаалтны ажлын ачаалал, цаг хугацааг хэмнэсэн чухал арга хэмжээ болсон юм.

УИХ-аас 2017 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн хуулиар Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд “Оффшор бүсэд банкны данс эзэмших, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөх, хуулийн этгээд байгуулах”-тай холбогдсон хориглолтыг нэмж тусгасан бөгөөд энэ нь нийтийн албан тушаалтнуудыг хууль бусаар орлого олох, үндэслэлгүйгээр хөрөнгөжих болон ашиг сонирхлын зөрчил болон цаашлаад албан тушаалын гэмт хэрэг болон бусад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чухал зохицуулалт болсон. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.3-т заасныг үндэслэн оффшор бүсэд хамаарах нийт 49 нутаг дэвсгэрийн жагсаалтыг Засгийн газрын 2017 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 244 дүгээр тогтоол, 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 326 дугаар тогтоолоор тус тус баталсан юм. Хууль тогтоомжийн дээрх өөрчлөлтийг мөрдөж ажиллах зөвлөмжийг Авлигатай тэмцэх газар төрийн бүх байгууллагуудад хүргэж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. Авлигатай тэмцэх газраас явуулсан мөрдөн шалгах ажиллагааны үр дүнд нийтэд зарлагдсан оффшор бүсээс Монгол Улсын иргэн 4 сая 370 мянган ам.доллароо



Монгол Улсад оруулж ирсэн нь оффшор бүсэд байршуулсан мөнгөн хөрөнгийг буцаан татсан хамгийн анхны тохиолдол юм.

УИХ-аас Төрийн албаны тухай (шинэчилсэн найруулга) хуулийг баталж, 2019 оноос эхлэн даган мөрдөж байна. Энэхүү хуульд иргэнийг төрийн албанд сонгон шалгаруулж томилох, чөлөөлөх, ажлын гүйцэтгэлийг нь үнэлэх, дэвшүүлэх, шагнаж урамшуулах асуудлыг шийдвэрлэхдээ хувь хүний мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага, ажлын үр дүнд тулгуурлах, төрийн жинхэнэ албан тушаалд иргэнийг томилохдоо гагцхүү чадахуйн зарчмыг баримтлахаар тусгасан. Хуулийн 50 дугаар зүйлд төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, хяналт тавих, 75 дугаар зүйлд төрийн жинхэнэ албан хаагч болон төрийн албанд нэр дэвшигчийн эрх зөрчигдсөн тухай маргааныг хянан шийдвэрлэх, 76 дугаар зүйлд хууль бус шийдвэрийг хүчингүй болгох зэрэг албан тушаалтныг хариуцлагажуулахад чиглэсэн олон зохицуулалтууд тусгагдсан ба төрийн албаны шинэтгэлийн хүрээнд албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуур, шатлан дэвшүүлэх журам, Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм, Төрийн албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам, Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам зэрэг 50 гаруй эрх зүйн актыг батлан мөрдүүлж байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль (шинэчилсэн найруулга)-ыг 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдөр баталж, 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Тус хуульд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд баримтлах зарчмын нэг нь “төрийн байгууллага, албан тушаалтан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд хуульд заасны дагуу оролцох үүрэгтэй бөгөөд төрийн захиргааны болон хууль сахиулах байгууллага үйл ажиллагаандаа гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг тэргүүлэх чиглэл болгох”-оор тусгасан. Мөн төрийн байгууллагын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон

нийтийн хөндлөнгийн хяналтын тогтолцоог бий болгохоор тусгасан нь тодорхой төрлийн гэмт хэргийн нэг болох авлигын гэмт хэрэгтэй тэмцэхэд чухал ач холбогдолтой зохицуулалт юм. Хуульд зааснаар Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журмыг Засгийн газраас батлах юм.

Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг АТГ хүлээн авч, нэр дэвшигчид үнэмлэх олгосон өдрөөс эхлэн өөрийн байгууллагын цахим хуудаст байршуулах, төрийн аудитын дээд байгууллагаас сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг батлахдаа түүнийг тогтоосон үндэслэл, аргачлалыг урьдчилан баталж, нийтэд мэдээлэх, бэлэн мөнгөөр хандив өгөх, авахыг хориглох, мөнгөн бус хандивын үнэлгээг зах зээлийн дундаж ханшийг үндэслэн хандивын гэрээгээр харилцан тогтоох бөгөөд уг үнэлгээ нь иргэн болон хуулийн этгээдээс өгөх хандивын дээд хэмжээнээс хэтрэхгүй байх, хандив өгч байгаа иргэн, хуулийн этгээд нь нэр, регистрийн дугаараа банкны гүйлгээний баримтад тусгаж, Төрийн аудитын дээд байгууллагаас баталсан хандивлагчийн мэдүүлгийн баримтыг мэдүүлэх бөгөөд энэ шаардлагыг хангаагүй хандивыг хандив хүлээн авагч буцаан шилжүүлэх, хуулийн этгээд мөнгөн хандив өгсөн бол уг хандивыг санхүү, татварын тайланд тусгах зэрэг сонгуулийн зардлын хяналт, хариуцлагыг сайжруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн, сонгуулийн тухай хуулиудад өмнө нь байгаагүй, шинэлэг зохицуулалтууд тусгагдсан болно.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиуд батлагдсантай холбоотойгоор Авлигын эсрэг хуульд холбогдох өөрчлөлтүүд орсон болно. Тухайлбал, Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Монгол Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг 2 дугаар улиралд багтаан цахим мэдээллийн сүлжээнд байрлуулах, тэдгээрийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газар бүртгэж, хадгалах эрх зүйн зохицуулалтыг бий болгосон.

Төрийн болон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ

худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг 2019 оны 3 дугаар сарын 22-ны өдөр УИХ-аас батлан, 2019 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж эхэлсэн. Тус хуулиар худалдан авах ажиллагааны цахим систем, цахим худалдан авах ажиллагаа болон цахим дэлгүүрийн эрх зүйн орчныг бүрдүүлэхтэй холбоотой дараах зохицуулалтын тусган батлуулсан. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар шинээр 6 журам буюу “Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн дүрэм”, “Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг хөтлөх журам”, “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”, “Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх, гэрчилгээ олгох журам”, “Тендерт оролцогчоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журам”, “Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох журам”-ыг Засгийн газрын тогтоолоор болон Сангийн сайдын тушаалаар батлан мөрдөж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орж, журам, заавар батлагдсанаар тендерт оролцогчдод тендер шалгаруулалтын материалыг ил болгож захиалгач тендер шалгаруулалтыг хуулийн дагуу зохион байгуулсан эсэхэд хяналт тавих, худалдан авах ажиллагаанд оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэл буюу хар жагсаалтыг хөтөлж, чанаргүй, гэрээний үүргээ биелүүлдэггүй компанийг дахин тендерт оролцуулахгүй байх, чанар, стандартын шаардлага хангасан дотоодын бараа, бүтээгдэхүүнд давуу эрх олгох, дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой барааны тендер шалгаруулалтад гадаадын бараа нийлүүлэгчийг оролцуулахгүй байх, урьдчилан худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэх, ил тод байдлыг нэмэгдүүлэх нөхцөл боломж бүрдсэн болно.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг мөрдөж эхэлсэнтэй холбоотойгоор Засгийн

газрын худалдан авах ажиллагааны чиг үүргийг бие даасан агентлаг хэрэгжүүлэхээр Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 438 дугаар тогтоолоор Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Төрийн худалдан авах ажиллагааны газрыг байгуулсан байна.

Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонрхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр судалгаа хийж, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн саналыг хууль санаачлагчдад уламжлаад байна. Төсөлд “үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн” гэх одоогийн хуульд байгаа тайлбарыг өөрчлөн тайлбарлах, хөөн хэлэлцэн хугацааг өөрчлөн тогтоох, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгахтай холбоотой журмыг батлах эрх олгох, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, хууль зөрчсөн албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагыг оновчтой болгох, зэрэг зохицуулалтыг боловсронгуй болгохоор тусгасан болно.

Авлигатай тэмцэх газраас Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг хамгаалах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг боловсруулан хууль санаачлагчид хүргүүлсэн. Хуулийн төсөлд нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг дэмжих чиглэлээр Авлигатай тэмцэх газар болон бусад байгууллагын хүлээх үүрэг, хэрэгжүүлэх ажиллагааг тодорхойлж, нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээж иргэний эр зориг гарган хариуцлага үүрч, эрх мэдэлтэн, албан тушаалтан, төрийн байгууллагын үйл ажиллагаанд гарч буй зүй бус үйлдэлд нийгмийн анхаарлыг чиглүүлж шударга ёсыг тогтоохын төлөө хувийн эрх ашгаас нийтийн эрх ашгийг өндөрт тавьж байгаа шүгэл үлээгч /илчлэгч/-ийн нийгэмд гүйцэтгэх үүргийг нийтэд зөв ойлгуулах, хүлээн зөвшөөрөх нөхцөл бүрдүүлэх, дэмжих, хамгаалах асуудлыг шийдвэрлэх үндэслэл, журмыг тусгасан болно. Уг хуулийн төсөлтэй хамт дагалдан гарах Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай



хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тус тус боловсруулсан болно.

Сонгуулийн үйл ажиллагааг нэгдсэн нэг хуулиар зохицуулах үзэл баримтлал өөрчлөгдөж, сонгуулийн төрлөөр нь тус тусад зохицуулахаар шийдвэрлэсний дагуу Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр тус тус батлагдаж, Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төсөл боловсруулах шатандаа байна.

### **Хоёр. Төрийн байгууллагын авлигын эрсдэлийг үнэлэх ажиллагаа хэвшүүлэх талаар:**

Авлигатай тэмцэх газар авлигын шалтгаан, нөхцөлийг судлан тогтоох, арилгах, таслан зогсоох, эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлээс хамгаалах үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулж байна. Авлигын эрсдэлийн үнэлгээний аргачлалыг Авлигатай тэмцэх газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн а/185 дугаар тушаалаар батлуулсан бөгөөд 2019 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн А/40 тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулан мөрдөж байна. Аргачлалын дагуу 2018 онд 6 төрийн бус байгууллагаар 24 яам, агентлагт, 2019 онд 5 төрийн бус байгууллагаар 15 байгууллагад авлигын эрсдэлийн үнэлгээг хийлгүүлэн, үр дүн, үнэлгээний тайланг яам, агентлаг, холбогдох этгээдэд танилцуулах ажлыг зохион байгуулав. Үнэлгээнд хамрагдсан байгууллагуудын бүтэц, төсөв санхүү, шийдвэр гаргах явц, ил тод байдал, мэдээллийн хүртээмж, ёс зүйн шударга байдлын түвшин, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тодорхой эрсдэл байна гэж дүгнэсэн.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, авлигын эсрэг хууль тогтоомж, Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн Зөвлөмжийн хэрэгжилттэй газар дээр нь танилцах, арга зүйн зөвлөгөө өгөх, зөвлөн туслах, шалган зааварлах зорилгоор Авлигатай тэмцэх газрын ажлын баг тайлант хугацаанд 21 аймагт 3 удаа, давхардсан

тоогоор 144 суманд ажиллаж, үр дүнг орон нутгийн удирдлагад газар дээр нь танилцуулсан. Тухайлбал, 2018 онд цөөн тооны хүчийг оновчтой зохион байгуулан 21 аймаг, 50 суманд, 2019 онд 21 аймгийн төвийн 21 сумдад ажилласан нь хамрагдсан байгууллага, орон нутгийн тоог 2013-2014 онтой харьцуулахад 4 дахин нэмэгдүүлсэн байна. Хэдийгээр төрийн үйлчилгээний хүнд суртлыг багасгах, нээлттэй, ил тод байдлыг хангах, хариуцлагыг дээшлүүлэх, шударга ёсны үнэлэмжийг сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүн гарч байгаа боловч шалгалтын явцад ажлын багаас төрийн байгууллагууд авлига, ашиг сонирхлын зөрчилд өртөх эрсдэлийг бууруулах, дотоод хяналт, санхүүгийн сахилга батыг сайжруулах талаар дорвитой арга хэмжээ аваагүй, төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны нээлттэй байдлыг боломжит түвшинд хангаагүй, мэдээлэгчийг хамгаалах тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр анхаарч ажиллаагүй байна дүгнэлтэд хүрсэн болно. Иймд авлигын түвшинг бууруулах, авлигын эрсдэл үүсгэж буй хүчин зүйл, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, зөрчлийг давтан гаргахгүй байх зорилгоор Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээний байгууллагын удирдах албан тушаалтнууд болон нийслэл, аймаг, орон нутгийн удирдлагад, албан хаагчдад илэрсэн нөхцөл байдлын талаар танилцуулж, авлигын эрсдэлээс сэргийлэх чиглэлээр Монгол Улсын Засгийн газарт Зөвлөмж хүргүүлсэн.

Засгийн газрын гишүүдэд салбар бүрийн авлигын нөхцөл байдлын талаар тусгайлсан зөвлөмжийг тухай бүрт нь хүргүүлэн, илэрсэн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх, эрсдэлээс хамгаалах чиглэлээр хамтран ажиллаж байна.

Авлига гарч болох нөхцөл боломж бүрдүүлсэн, хуулиар тусгай эрх олгоогүй байхад батлан мөрдүүлсэн, хууль тогтоомжид нийцээгүй, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актад тавих шаардлагыг хангаагүй гэж үзсэн 50 гаруй дүрэм, журмыг хянан үзэж бүхэлд нь буюу хэсэгчлэн хүчингүй болгох арга хэмжээг авсан байна. Түүнчлэн орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, аймгийн Засаг

даргын захирамж, Засаг даргын Тамгын газрын даргын тушаалаар батлан мөрдүүлсэн хууль тогтоомжид нийцээгүй, хуулиар эрх олгоогүй байхад дүрэм, журам тогтоон мөрдүүлсэн, үндэслэлгүй төлбөр хураамж тогтоосон нийт 91 журмыг хянан үзэж өөрчлөх, хүчингүй болгоход чиглэсэн арга хэмжээг авсан.

Гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар 2017 онд 22, 2018 онд 8, 2019 онд 41 байгууллагад Авлигатай тэмцэх газрын мөрдөгчийн мэдэгдлийг хүргүүлж, тэдгээрийн мөрөөр газар дээр нь ажиллахад мэдэгдэл дурдсан эрсдэлээс сэргийлэх, гэмт хэрэг гарсан шалтгаан, нөхцөлийг арилгах, давтан гарахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр бодитой арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй зэрэг нийтлэг дутагдал илэрсэн бөгөөд төрийн байгууллагуудын Авлигын эсрэг хуулийн 6.1.12-т заасан “бүрэн эрхийнхээ хүрээнд авлигын шалтгаан, нөхцөлийг илрүүлэн тогтоох, тэдгээрийг арилгах, авлигын үйлдлийг таслан зогсоох, үр дагаврыг нь арилгах арга хэмжээ авах” нийтлэг үүргийн хэрэгжилт хангалтгүй байв.

Авлигатай тэмцэх газраас гаргадаг Шударга байдлын үнэлгээ болон төрийн бус судалгааны байгууллагуудын судалгааны дүнгээр авлигын өндөр эрсдэлтэй гэж тооцогдож буй уул уурхай, боловсрол, эрүүл мэнд, гаалийн салбаруудад авлигын шалтгаан нөхцөлийг тогтоох, гарч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх тусгайлсан арга хэмжээг авч хэрэгжүүлсэн зэргээр авлигын эрсдэлийг үнэлэх, тогтоох, таслан зогсоох ажлыг үр дүнтэй зохион байгуулсан байна.

### **Гурав. Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг сайжруулах талаар**

Авлигатай тэмцэх газар нь төрийн үйлчилгээний хүнд суртлыг багасгах, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэх зорилгоор яам, агентлагийн түвшинд авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан явдал юм.

Засгийн газар, Азийн сантай хамтран авлигад өртөх эрсдлийн үнэлгээг гаргах, авлигаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, түүнийг

хэрэгжүүлэхэд тохиолдох хүндрэл бэрхшээл, түүнээс гарах арга замын талаар зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, төлөвлөгөөний хэрэгжилтийг шалгасан шалгалтын үр дүнг танилцуулах зорилгоор яамдын Төрийн нарийн бичгийн дарга, агентлагийн дарга нарт зориулан 2008 онд “Авлигаас урьдчилан сэргийлэх арга зам, төлөвлөлт”, 2009 онд “Авлигаас урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилт, сайжруулах арга зам”, 2010 онд “Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг үнэлэх аргачлал ба орон нутгийн оролцоо” сэдэвт сургалт, семинарыг тус тус зохион байгуулсан юм. Үүний үр дүнд 2008 онд 26 байгууллага /яам, нийтлэг үйлчилгээ үзүүлдэг агентлагууд/ төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажилласан бол 2009-2010 онд 55 байгууллага /11 яам, 42 агентлаг, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба/, 2011 онд 77 байгууллага /11 яам, 42 агентлаг, аймаг, ийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба/, 2012-2016 онуудад 120-127 /яам, агентлаг, аймаг, нийслэл, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд/ байгууллага уг төлөвлөгөөг батлан хэрэгжүүлсэн байдаг.

Төрийн байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг 2010, 2011 онд ЗГХЭГ, АТГ-ын ажилтнуудаас бүрдсэн баг хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газрын хуралдаанд танилцуулдаг байсан бол 2013-2016 онд Авлигатай тэмцэх газар “Авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх аргачлал”-ыг боловсруулан баталж, уг аргачлалын дагуу хөндлөнгийн шинжээчдээр үнэлгээ хийлгэсэн бөгөөд үнэлгээний улсын дундаж дүн 2013 онд 48.2 хувь, 2014 онд 60.0 хувь, 2015 онд 68.2 хувь, 2016 онд 61.7 хувьтай байсан байна.

Харин Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”, Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх болсонтой холбогдуулан төрийн байгууллагууд үндэсний хөтөлбөрт заасан зорилт, үйл ажиллагаа, арга хэмжээг өөрийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд



тусган хэрэгжүүлж, жил бүрийн 2 дугаар сарын 1-ний дотор Авлигатай тэмцэх газарт тайлагнаж байна.

Авлигатай тэмцэх газраас Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан ажил, арга хэмжээг хэрэгжүүлэх, төрийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах явцад байнгын туслалцаа үзүүлэх, мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ажиллахын зэрэгцээ жил бүр үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж байна. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт 2018 онд 35.3 хувьтай үнэлэгдэж байсан бол 2019 оны үнэлгээ 58,8 хувьтай гарч, 23,5-аар өссөн дүнтэй байна.

### **Дөрөв. Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлсэн байх**

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар Засгийн газрын 2015 оны 254 дүгээр тогтоолоор баталсан төрийн үйлчилгээний цахим систем (ezasag.mn)-д холбох төрийн 167 үйлчилгээний жагсаалтын дагуу 2017 оноос 855 үйлчилгээг цахимжуулж, төрийн үйлчилгээг цахим машин ашиглан иргэдэд хүргэхэд мөрдөх “Төрийн үйлчилгээний цахим машины ашиглалт үйлчилгээний журам”-ыг шинэчлэн батлуулж, www.ezasag.mn цахим хуудсыг ашиглан Цагдаагийн ерөнхий газрын Лицензийн төвийн жолооны үнэмлэх солиулах үйлчилгээ, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 6 төрлийн үйлчилгээний холболтыг турших, Автотээврийн үндэсний төв, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн 3 төрлийн үйлчилгээг ТҮЦ машины үйлчилгээнд нэвтрүүлэх ажлыг гүйцэтгэсэн.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлагдсны дараа 2018 онд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2018 оны 30 дугаар тушаалаар “Төрийн үйл ажиллагаанд мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлэн, төрийн үйлчилгээг иргэн төвтэй болгож, төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж хэрэглээнд нэвтрүүлэх” үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан санал, дүгнэлт боловсруулж, Засгийн газрын 2018 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн 259 дүгээр тогтоолоор “Төрийн цахим мэдээлэл солилцох системд холбох төрийн үйлчилгээний жагсаалт”-ыг 1 дүгээр

хавсралтаар, “Төрийн цахим мэдээлэл солилцох системийг ашиглан цахим хэлбэрээр үзүүлэх төрийн үйлчилгээний жагсаалт”-ыг 2 дугаар хавсралтаар шинэчлэн баталж, дээр дурдсан 2015 оны 254 дүгээр тогтоолыг хүчингүй болгосон. “Төрийн цахим мэдээлэл солилцох системд холбох төрийн үйлчилгээний жагсаалт”-д 176 үйлчилгээг төрийн цахим мэдээлэл солилцох системд холбохоор холбогдох яам, үйлчилгээний нэрийг заан баталсан бол “Төрийн цахим мэдээлэл солилцох системийг ашиглан цахим хэлбэрээр төрийн үйлчилгээний жагсаалт”-д 38 байгууллагын 320 үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхээр тусгасан байна.

“Төрийн мэдээлэл солилцооны ХҮР систем”-ийг хөгжүүлэн 2018 оны 1 дүгээр сараас ашиглалтад оруулж системд нийт төрийн 47, хувийн 118 байгууллага холбогдсон. 2019 онд 170 төрлийн лавлагааг 58 сая удаа дуудаж ашигласан байна. Мөн “Төрийн мэдээлэл солилцооны ХҮР систем”-д 97 байгууллагын веб сервис холбогдож 19.246.680 мэдээлэл солилцох хүсэлтийг солилцон ажилласан байна. Улсын хэмжээнд төрийн үйлчилгээний цахим машинаар 28 нэр төрлийн үйлчилгээг 1.426.491 иргэнд үзүүлсэн байна. “Танилт, баталгаажуулалтын ДАН” системээр 18 байгууллага холбогдож 31.852 хэрэглэгч бүртгүүлж ашиглаж байна.

2019 онд 28 төрийн байгууллагын 85 үйлчилгээг цахим хэлбэрт бүрэн шилжүүлсэн байна. Иргэд төрийн үйлчилгээ авахдаа олон цонх дамжиж байгаа шатлалыг арилгах, давхардсан бүтэц үүсгэхгүй байх зорилгоор төрийн дижитал шилжилтийг хийж нэг цонхны үйлчилгээ болон төрийн үйлчилгээний нэгдсэн төвийг өөрчлөн зохион байгуулах, сумдад төрийн зарим үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэх үйлчилгээний нэгдсэн төв шинээр байгуулах, тэдгээрийг операторын горимд шилжүүлэх, үйлчилгээний хүсэлтийг хүлээн авч, шийдвэр гаргах эрх бүхий албан хаагчид цахим хэлбэрээр дамжуулах, шийдвэрлэлтийн явцыг иргэнд мэдээлэх, үйлчилгээний чанар, хүртээмж, шийдвэрлэлтийн явцын талаар нэгдсэн хяналт хийх боломж бүхий “Үйлчилгээний нэгдсэн төв”-ийн мэдээллийн системийг хөгжүүлж төрийн мэдээлэл солилцооны “ХҮР” системд холбохоор Засгийн газрын тогтоолын төсөл, холбогдох

материалыг боловсруулж, хэлэлцүүлэн, “Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 149 дүгээр тогтоолыг батлуулсан.

“Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 149 дүгээр тогтоол батлагдсантай холбогдуулан Монгол Улсын бүх суманд цахим үйлчилгээний нэгдсэн төв байгуулах ажлын хүрээнд Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Үйлчилгээний нэгдсэн төвийн мэдээллийн систем” ХХМТГ/201912003 төслийн Багц-1-1 “Цахим үйлчилгээний систем хөгжүүлэх”, Багц-1-2 “Төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем хөгжүүлэх” төслүүдийн сонгон шалгаруулалтыг амжилттай зохион байгуулан ажиллаж байна. Төслийн хэрэгжилтийн хүрээнд “Төрийн Үйлчилгээний нэгдсэн төв”-өөр дамжуулан төрийн байгууллагуудын өмнөөс оператор хэлбэрээр үйлчилгээг үзүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн ба 2019 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр зохион байгуулсан “Дижитал хөгжилд хамтдаа форум”-ын үеэр төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний цахим систем буюу [www.mgov.mn](http://www.mgov.mn) порталыг нээж, 25 байгууллагын 181 нэр төрлийн үйлчилгээг дижитал хэлбэрээр үзүүлэхэд бэлэн болсон. Энэхүү систем нь ХУР, ДАН, Орон зайн өгөгдлийг дундын мэдээллийн сан, Үндэсний төлбөрийн систем, бусад төлбөрийн систем, ebarimt төлбөрийн баримтын систем, esign тоон гарын үсэгтэй холбогдсон.

Төрийн байгууллагуудын үйл ажиллагаа, цахим албан хэрэг хөтлөлтөд тоон гарын үсэг ашиглахтай холбогдуулан тоон гарын үсгийн тэмдэглэгээний хэлбэржилтийг боловсруулж, Нийслэлийн мэдээллийн технологийн газар, “Монпассы СА” ХХК, Нийслэлийн архивын газарт тус тус хүргүүлж, хэрэглээнд нэвтрүүлэв. Засгийн газрын 2016 оны 151 дүгээр тогтоол, Төрөөс баримтлах бодлогын чиглэлийн дагуу “Үндэсний дата төв” ҮТҮГ-ийг төрийн албан хаагчдад тоон гарын үсгийн гэрчилгээ олгогч байгуулагаар ажиллуулж, 2018 онд төрийн 765 албан хаагчдад тоон гарын үсэг олгож, нийслэлийн хэмжээнд 545 албан хаагч тоон гарын үсгийг ашиглаж, 2019 онд төрийн 43 байгууллагын 940 ажилтанд тоон гарын үсэг олгож, нийслэлийн 8 байгууллагын 85 ажилтанд тоон гарын үсэг олгосон байна.

Иргэн, аж ахуйн нэгжид төрийн үйлчилгээг хүргэдэг төрийн захиргааны байгууллагуудад хэрэглэгдэж буй програм хангамжуудыг тэдгээрийн ашигладаг техник, програм хангамж, платформын ялгаатай байдлаас үл хамааран хоорондоо холбогдон, өгөгдөл мэдээлэл солилцох боломж бүхий “Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем” /[www.erp.gov.mn](http://www.erp.gov.mn)-г бий болгон хөгжүүлэх замаар төрийн захиргааны байгууллагуудын үйлчилгээг цахимжуулах, мэдээллийн урсгалын зохион байгуулалтыг сайжруулах, нэгдсэн удирдлагатай болгох, төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, ил тод байдлаар хүргэх боломжийг бүрдүүлэн ажилласан байна.

Төрийн үйлчилгээг цахим хэлбэр амжилттай шилжүүлж байгаа боловч системийн аюулгүй байдлыг хангах, хууль, дүрэм журамд нийцүүлэн цахим шилжилтийг хийж, үйлчилгээ чанар хүртээмж сайжирч буйд тогтмол судалгаа, дүгнэлт хийж ажиллах нь зүйтэй байна.

Засгийн газрын 2019 оны 73 дугаар тогтоолоор Цахимзасаглалүндэснийхөтөлбөрийгбаталсан. Цахим засаглалын эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилтын хүрээнд Цахим мэдээллийн аюулгүй байдлын тухай, Өгөгдөл хамгаалах тухай хуулийн төслүүд, төрийн мэдээллийн нээлттэй өгөгдлийн санг үүсгэх, ашиглах журам, зорилтот бүлгийн иргэд ашиглах боломжийг бүрдүүлсэн цахим хуудасны стандарт зэргийг боловсруулж мөрдүүлэх юм.

### **Тав. Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын авлигын эсрэг хамтын ажиллагаа сайжруулах талаар**

Авлигатай тэмцэх газраас ХАСУМ-ийг гаргах, хянах үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг 2017 онд эхлүүлэн системийн хөгжүүлэлтийг 2018 онд дуусгаж, 2019 оноос хэрэгжүүлж эхэлсэн. 2019 оны байдлаар Цагдаагийн ерөнхий газар, Улсын Ерөнхий прокурорын газар цахим системд холбогдож ХАСУМ-ийг бүртгэх, хянах үйл ажиллагааг цахимаар хянах боломжтой болсон байна.

Шүүх, хууль сахиулах байгууллагуудын нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлж, гэмт хэргийн тоо мэдээнээс холбогдох статистик мэдээллийг боловсруулах ажлыг 2018 онд эхлүүлсэн. Нэгдсэн мэдээллийн сан дээр үндэслэсэн олон нийтэд зориулсан “e-justice.mn” портал, веб



сайтыг ажиллуулж байна. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/134 дүгээр тушаалын дагуу Шүүх, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудын мэдээллийн нэгдсэн сангийн үйл ажиллагааг Прокурорын байгууллага хариуцан ажиллаж байна. Мэдээллийн нэгдсэн санд иргэний портал үүсгэх, олон нийтэд нээлттэй байлгах талаар хамтран ажиллаж байна.

Мөрдөн шалгах ажиллагаа болон прокурор, шүүхийн байгууллагуудын дунд “гэмт хэргийн цахим сан”-тай болсон бөгөөд энэхүү цахим мэдээллийн нэгдсэн санг боловсронгуй болгох ажил тогтмол хийгдэж байна. Улсын Ерөнхий Прокурорын Газраас авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийн шийдвэрлэлтийн байдлыг улирал бүр судлан, холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна. Авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийн шийдвэрлэлтийн талаарх мэдээлэл нэгдсэн санд бүрэн бүртгэгдэж, бүртгэсэн мэдээллийг хайлтаар шүүж үзэх боломжтой болсон.

Улсын Ерөнхий Прокурорын тушаалаар хууль сахиулах байгууллагууд болон Авлигатай тэмцэх газар Хөгжлийн банк, Оффшор бүс, Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл хууль бусаар эзэмшсэн гэх албан тушаалтнууд, Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн зээлийг хууль бусаар ашигласан, Эрдэнэт Үйлдвэрийн 49 хувийг хууль бусаар эзэмшсэн, Агаарын бохирдол, Стандарт банк, Оюутолгойн гэрээ, Монгол банк, Эгийн гол усан цахилгаан станцийн төсөл, 60 тэрбумын хэрэг, АСЕМ-ийг зохион байгуулах үндэсний зөвлөлийн албан тушаалтнуудад холбогдох зэрэг нийгмийн анхаарал татсан хэргүүдэд прокурорын хамтарсан ажлын хэсэг байгуулан ажилласан. Тухайлбал, 2019 онд 30 эрүүгийн хэрэгт Авлигатай тэмцэх газар, Тагнуулын Ерөнхий Газар, Цагдаагийн Ерөнхий газрын дарга нарын хамтарсан тушаалаар ажлын хэсэг байгуулагдан ажилласан бөгөөд ажлын хэсгүүдийг өдөр тутмын мэргэжлийн удирдлагаар хангаж ажилласнаар 24 хэргийг шийдвэрлэж, 6 хэргийн үлдэгдэлтэй гэсэн дүн мэдээ гарсан байна.

УЕПГ, Нийслэлийн Прокурорын газартай хамтарсан авлигын эсрэг гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах явцад гэрч хохирогчийг хамгаалах өнөөгийн байдал,

тулгамдаж буй асуудал, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийг практикт хэрэглэхэд тулгамдаж буй асуудал, хүндрэл бэрхшээл, авлига болон хууль бусаар гадаад улс оронд байршсан нуугдмал хөрөнгө орлогыг буцаах, зарцаах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг StAR санаачилгаас “Эрх зүйн туслалцаа үзүүлэх-хамран ажиллах” чиглэлээр хэлэлцүүлэг, сургалт, уулзалт ярилцлагуудыг хамтран зохион байгуулсан. Мөн Авлигын гэмт хэрэг болон мөнгө угаах гэмт хэргийг шийдвэрлэхэд хууль хяналтын байгууллагын хамтын ажиллагаа, хуулийг нэг мөр ойлгох, практик дээр тулгарч байгаа хүндрэл бэрхшээл зэргийг судлан дүгнэлт хийж хамтарсан сургалт, хэлэлцүүлгүүдийг үе шаттайгаар зохион байгуулж ажилласан.

2017 онд шүүхээр нийт 46 эрүүгийн хэрэг шийдвэрлэж байсан бол 2018 онд нийт 84 хэргийг шүүхээр эцэслэн шийдвэрлүүлсэн. “Авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийг шийдвэрлэсэн мэдээллийн нэгдсэн сан” бүрдүүлэх хүрээнд Шүүхийн ерөнхий зөвлөл авлига, албан тушаалын гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэсэн тоон мэдээллийг цаг тухайд нь хүргэж хамтран ажиллах боломжтой. Шүүхийн ерөнхий зөвлөл Авлигын гэмт хэрэг, зөрчлийг олж илрүүлсэн, мөрдөн шалгасан, хянан шийдвэрлэсэн байдалд дүн шинжилгээ хийж, мэдээллийн сан үүсгэн, дотоод сургалтад ашиглаж байна. Авлига, хээл хахуулийн гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэсэн мэдээг улирал бүр бүх шүүхүүдээс хүлээн авч нэгтгэн мэдээллийн санд нэгтгэж байна.

### **Зургаа. Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх талаар:**

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 4.1.7-д заасан “Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих” зорилтыг хангах хүрээнд “төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бий болгох, төрийн зарим ажил үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх, санхүүжилтийг ил тод, үр ашигтай зарцуулах, түүнд хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх” арга хэмжээг Засгийн газрын



2017 оны 114 дүгээр тогтоолоор баталсан төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Засгийн газар нь төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг холбогдох хууль, түүнд үндэслэсэн Засгийн газрын шийдвэр, гэрээний үндсэн дээр Засгийн газрын бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлж, холбогдох зардлыг бүрэн буюу хэсэгчлэн санхүүжүүлж болно” гэж заасны дагуу төрийн байгууллагууд зарим чиг үүргээ тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагад шилжүүлэн ажиллах нөхцөл бүрдэж, салбарын хуульд төрийн бус байгууллагаар төрийн зарим үйлчилгээг гүйцэтгүүлэх зохицуулалт тусгагдсан.

Гаалийн тухай хуулийн 252 дугаар зүйлийн 252.4-т “Магадлан шинжилгээг мэргэжлийн хувийн өмчийн болон төрийн бус байгууллага, эсхүл бие даасан шинжээчээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болох бөгөөд энэ тохиолдолд магадлан шинжилгээний төлбөрийг мэдүүлэгч хариуцна”, Эрүүл мэндийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.3-т “Эрүүл мэндийн салбарын зарим ажил, үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх журам, төрийн бус байгууллагад тавих нийтлэг шаардлага, шалгуур үзүүлэлтийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална”, Авто замын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Авто замын салбарын төрийн бус байгууллага нь авто замын тухай хууль тогтоомж, норм, норматив, техникийн баримт бичгийг боловсронгуй болгох, төрөөс үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, салбарын мэргэжилтэй ажилтан бэлтгэх, давтан сургах, мэргэжлийн зэрэг олгох, авто замчдын эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж болно” гэж тус тус заасан байдаг байна.

Өнөөгийн байдлаар зарим төрийн бус байгууллага гэрээ, Засгийн газрын тогтоол, сайдын тушаал, хуулиар олгогдсон эрхийн хүрээнд төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлж байна. Тухайлбал, Улаан загалмай нийгэмлэг нь Улаан загалмай нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай хууль, Монголын Хуульчдын холбоо нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим Худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай хууль, Шинжлэх ухааны академи нь Шинжлэх ухааны академийн эрх

зүйн байдлын тухай хууль, спортын холбоод Биеийн тамир, спортын тухай хууль, Монголын Нотариатчдын танхим Нотариатын тухай хууль, Арбитр Арбитрын тухай хуульд заасны дагуу төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Барилга, хот байгуулалтын яам Барилгын салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох сургалт эрхлэх чиг үүрэг, Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүргийг, Сангийн яам мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж байна.

Сангийн яам 2018 онд Засгийн газрын 2016 оны 165 дугаар тогтоолын дагуу Нягтлан бодох бүртгэлийн болон татварын мэргэшсэн зөвлөхийн үйлчилгээний төрийн зарим чиг үүргийг гүйцэтгэж байгаа Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэг, Монголын нягтлан бодох бүртгэлийн хүрээлэн, аудитын төрийн зарим чиг үүргийг гүйцэтгэж байгаа Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт, Монголын мэргэшсэн үнэлгээчдийн институттэй гэрээ байгуулан, жил бүр ажлын төлөвлөгөөг баталж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт хооронд байгуулсан “Төрийн байгууллагын зарим чиг, үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх гэрээ”-ний хэрэгжилтэд дотоод аудит хийж үйл ажиллагаа болон чиг үүргийн хэрэгжилтийг сайжруулах зорилгоор Сангийн яаманд 12 зөвлөмж, Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтэд 6 зөвлөмжийг тус тус өгсөн болно.

Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/25 дугаар тушаалаар “Эрүүл мэндийн салбарын зарим ажил, үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх журам”-ыг баталсан. Уг журмын дагуу эрүүл мэндийн тухай хууль, тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, эрүүл зан зан үйл төлөвшүүлэх, эрүүл мэндийн боловсрол олгох мэдээлэл, сургалт, сурталчилгаа, магадлан итгэмжлэл олгох үйл ажиллагаанд оролцох, эмийг бүртгэх, баталгаажуулах, эмийн чанар, аюулгүй байдлын талаар нийтэд мэдээлэх үйл ажиллагаанд оролцож,



санал өгөх, эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага, үйл ажиллагааны стандартын хэрэгжилт, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах, иргэний гомдол, саналын мөрөөр хяналт тавих, үнэлэх үйл ажиллагаанд оролцож санал өгөх зэрэг үйл ажиллагааг Төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэхээр журамласан байна. Харин салбарын сайдын тушаалаар гэрээний дагуу төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлж байгаа төрийн бус байгууллагуудыг сонгон шалгаруулж байгаа үйл явц, тэдгээрийн гүйцэтгэсэн ажил, гэрээний хэрэгжилтийг хэрхэн дүгнэдэг, тухайн төрийн бус байгууллагын санхүүжилт болон улсын төсөвт төвлөрүүлсэн орлого зэрэг мэдээллүүд нээлттэй, ил тод биш байна.

Төрийн бус байгууллагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-д “Төрийн бус байгууллагын үйл ажиллагаа нь олон түмэнд ил тод байх ба түүний гишүүд болон иргэд хэн ч тухайн байгууллагын тайлантай танилцаж болно”, 23 дугаар зүйлийн 23.2-т “Төрийн бус байгууллага үйл ажиллагааныхаа тайланг энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацаанд улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргаж өгөх бөгөөд түүнд дараахь асуудлыг тусгана” гэж заасан ч хуулийн энэ заалтыг холбогдох байгууллагууд баримтлан хэрэгжүүлээгүй байна.

Төрийн бус байгууллагын тухай хуулийг шинэчлэн найруулах хэрэгцээ, шаардлагыг тандан судалсан судалгааг Хууль зүй, дотоод хэргийн яам, Швейцарийн хөгжлийн агентлагийн хамтран хэрэгжүүлсэн “Иргэдийн оролцоо II” төслийн дэмжлэгээр гүйцэтгүүлсэн. Энэхүү судалгаагаар Төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх тухай болон нийтэд тусгай үйл ажиллагааны тухай хуулийн төсөл боловсруулах ажлыг Төрийн бус байгууллагын тухай хуулийг шинэчлэн найруулах хүрээнд авч үзэх нь зүйтэй гэж үзсэн тул тус хуулийн төслийг боловсруулах ажлыг нэгтгэн зохион байгуулахаар шийдвэрлэсэн. Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар байгуулсан ажлын хэсэг Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай хуулийн төсөл болон дагалдах 140 хуулийн төслийг боловсруулж, олон нийтээр хэлэлцүүлж, холбогдох байгууллагуудаас санал авч тусган, төслийг 2019 оны 12 дугаар сарын 02-ны өдөр УИХ-д өргөн барьсан болно.

Авлигатай тэмцэх газар нь 2019 онд Барилга, хот байгуулалтын яамтай хамтран салбарын яам, агентлагийн асуудал хариуцсан нэгжийн удирдлагууд, барилгын салбарын ТББ-ын төлөөлүүд, барилгын компанийн удирдлагуудыг оролцуулан “Мэргэжлийн холбоодод шилжүүлсэн барилгын тусгай зөвшөөрлүүд: Асуудал, шийдэл” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулж, илтгэл хэлэлцүүлэн, асуудлыг тоо баримт, мэдээлэлд тулгуурлан учирч буй хүндрэл бэрхшээл, түүнийг шийдвэрлэх арга зам, төр, хувийн хэвшлийн байгууллагын хамтын ажиллагаа зэрэг сэдвүүдийг хэлэлцэв

Төрийн бус байгууллагад шилжүүлсэн төрийн үйлчилгээний тоог бодитой гарган тухай төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нарийвчлан дүн шинжилгээ хийж цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох шаардлагатай.

Авлигатай тэмцэх газраас төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлж байгаа төрийн бус байгууллагын үйлчилгээний үр дүн, үр нөлөөнд хяналт-шинжилгээ хийх ажлыг 2019 оны 12 дугаар сард судалгааны байгууллагаар гүйцэтгүүлсэн бөгөөд хяналт-шинжилгээний ажлын тайлангийн мөрөөр холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

### **Долоо. Хувийн хэвшил дэх авлигын эрсдэлийг бууруулж, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын хамтын ажиллагаа сайжруулах талаар:**

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилтыг хангах чиглэлээр холбогдох төрийн болон төрийн бус байгууллагууд тодорхой арга хэмжээнүүдийг зохион байгуулсан. Тухайлбал, *авлигын эсрэг түншлэлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, хувийн хэвшлийн чадавхийг сайжруулах, зөвлөлдөх уулзалтууд хийх, өрсөлдөөний орчныг сайжруулах, бизнесийн ил тод байдлыг хангах, төрийн чиг үүргийг хувийн хэвшилд шилжүүлэх, байгаль орчны нөхөн сэргээлтийн хууль тогтоомжийг мөрдүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна. Дэлхийн банкнаас улс орнуудын бизнесийн орчинд үнэлгээ хийдэг “Doing business” судалгаанаас харахад тус хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн 2016 онд*

Монгол Улсын бизнес эрхлэлтийн орчны дундаж үнэлгээ 65.3 оноогоор үнэлэгдэж байсан бол 2019 оны байдлаар 67.7 оноогоор дүгнэгдэж, үзүүлэлтүүд сайжирсан байна. Үүнд өмч бүртгүүлэх, төлбөрийн чадваргүй байдлыг шийдвэрлэхтэй холбоотойгоос бусад бизнес эрхлэлттэй холбоотой дэд үзүүлэлтүүд сайжирсан нь нөлөөлсөн. Гэвч Дэлхийн банкаас гаргадаг энэхүү судалгааг Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх шууд үзүүлэлт болгож болохгүй юм.

Дэлхийн эдийн засгийн форумаас гаргадаг 2016 оны Дэлхийн өрсөлдөх чадварын индексийн 1 дэх тулгуур үзүүлэлт болох Институцын чадавхийн үнэлгээгээр Монгол Улс 3.4 оноотой үнэлэгдэж, 137 орноос 108 дугаар байрт оржээ. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 1 дэх үе шат хэрэгжиж дууссан 2019 оны байдлаар Монгол Улс 49.8 оноо авч, 141 орноос 90 дүгээр байр эзэлсэн. Энэ нь 2016 оны үзүүлэлтээс 18 байраар ахисан үзүүлэлт юм.

Азийн сангаас эрхлэн явуулдаг Бизнесийн орчин дахь авлигын нөхцөл байдлын 2016 судалгаагаар “Таны бодлоор төрийн албанд авлига хэр их байгаа вэ?” гэсэн асуултад “маш их” гэж хувийн хэвшлийнхний 47.9 хувь нь хариулж байсан бол 2018 онд ингэж үздэг хүний тоо 44.2 хувь болж буурсан үзүүлэлтэй, 2016 оны судалгаагаар “Төрийн албан дахь авлига таны бизнест шууд нөлөөлдөг үү?” гэсэн асуултад “тийм” гэж хэвийн хэвшлийнхний 43.6 хувь нь хариулсан бол 2018 оны байдлаар 37.6 хувь нь ингэж үздэг гэж хариулжээ.

Дэлхийн банк, Дэлхийн эдийн засгийн форум, Азийн сангаас Монгол Улсын бизнесийн орчин, түүнд авлигын үзүүлэх нөлөөллийг судалсан тайлангуудаас үзэхэд Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 1 дэх үе шат хэрэгжсэн арга хэмжээ бизнесийн орчин дахь авлигын нөхцөл байдал бага хэмжээгээр сайжрахад нөлөөлсөн гэж үзэж болохоор байна.

Хувийн хэвшлийн чадавхийг сайжруулах, зөвлөлдөх уулзалт зохион байгуулах, өрсөлдөөнийн орчныг сайжруулах, бизнесийн ил тод байдлыг хангах, төрийн чиг үүргийг хувийн хэвшилд шилжүүлэх чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн бол авлигын эсрэг түншлэлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, байгаль орчны нөхөн сэргээлтийн хууль тогтоомжийг мөрдүүлэх

зарим арга хэмжээг хангалттай түвшинд хэрэгжүүлж чадаагүй байна.

### **Найм. Шударга ёсны үзэл санаа нийгэмд төлөвшиж, иргэн өөрт учирч байгаа хүндрэл, бэрхшээлийг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлдэг байх нийгмийн сэтгэлгээ, хандлагыг өөрчлөгдсөн байх үр дүнгийн талаар:**

Шударга ёсны үзэл санааны төлөвшилт маш олон хүчин зүйлээс хамаардаг бөгөөд 4-5 жилийн хугацаанд үр дүн нь гарах боломжгүй, урт хугацаанд үргэлжлэх үйл явц боловч тоон болон чанарын судалгааны үр дүнгээс ерөнхий хандлагыг ажиглаж болно.

Авлигатай тэмцэх газраас зохион байгуулдаг Шударга байдлын үнэлгээний дүн 2016 онд 69.7 байсан бол 2019 онд 74.1 болж, 4.4 пунктээр нэмэгдсэн байна. Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын төсөөллийн судалгааны оноо 2016 онд 3.65 байснаа 2017 онд 3.97 болж нэмэгдсэн бол Улс төрийн хүрээн дэх авлигын төсөөллийн судалгааны оноо 2018 онд 3.93, 2019 онд 4.08, Шүүх, хууль сахиулах байгууллагын хүрээн дэх авлигын төсөөллийн судалгааны оноо 2018 онд 3.68, 2019 онд 3.86 болж тус тус нэмэгдэж, иргэд улс төр, шүүх, хууль сахиулах байгууллагын шударга байдалд сэтгэл ханамжгүй байна гэсэн дүн гарсан байна. Хүүхдийн шударга байдлын судалгааг 2010 оноос эхлэн хийж байгаа бөгөөд 2016 оноос хойшх үр дүнг харвал 4-3.91 болж, бага багаар буурсаар байна.

Азийн Сан, Сант Марал сангийн хамтран зохион байгуулсан “Авлигын талаарх олон нийтийн ойлголт, мэдлэг тогтоох судалгаа-2019” судалгааны тайланд “Сүүлийн 14 жилийн хугацаанд “авлига нь манай улсад түгээмэл үзэгдэл” болсон гэдэгтэй судалгаанд оролцогчдын үргэлж 80-аас илүү хувь санал нийлнэ гэж хариулж байсан бөгөөд 2019 онд энэ тоо хамгийн дээд цэг болох 93.6 хувь хүрсэн” хэмээн тэмдэглэсэн байна. Гэхдээ энэ нь авлигын талаар иргэдийн авч байгаа, авахыг хүсч байгаа мэдээллийн төрөл, хэмжээтэй холбоотой байж болохыг мөн дурдсан байна.

Дээрх судалгааны сүүлийн 3 сард хахууль өгсөн өрхийн талаарх мэдээллээс харахад 2016 онд 6.7 хувь байсан бол 2019 онд 3.3 хувь болж, жижиг авлигын тохиолдол жил ирэх тутам ерөнхийдөө буурч байна.



Сант марал сангийн Политбарометрийн судалгааны үр дүнгээс харахад авлигатай тэмцэхэд чухал үүрэг гүйцэтгэх ёстой гурван байгууллага буюу парламент, шүүхийн тогтолцоо болон улс төрийн намуудад итгэх олон нийтийн итгэлийн түвшин доогуур байгаа бол Авлигын талаарх олон нийтийн ойлголт, мэдлэг тогтоох судалгаа-2019 судалгаанд оролцогчид улс төрчдийн авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлийг өмнөх жилүүдийн нэгэн адил доогуур үнэлсэн бөгөөд 88 хувь нь улс төрчид асуудлыг шийдвэрлэх маш бага, эсхүл огт хүсэлгүй байна гэж үзжээ.

Авлигын эрсдэлтэй байгууллагаар шүүх засаглал болон Газрын алба байнга нэрлэгдэж ирсэн дээр сүүлийн үед УИХ, улс төрийн намууд болон Засгийн газар нэмэгдэх болсон нь авлигын эсрэг үр дүнтэй бодлого боловсруулж, хэрэгжүүлэхэд тулгарч буй хамгийн том саад бэрхшээл болж байгааг Авлигын талаарх олон нийтийн ойлголт, мэдлэг тогтоох судалгаа-2019 судалгааны тайланд дүгнэсэн байна.

Эндээс, сүүлийн жилүүдэд төрийн байгууллагуудын шударга байдлын түвшин ерөнхийдөө дээшилж, өрхүүд хахууль өгөх тохиолдол бүүрч байгаа боловч улс төр, шүүх, хууль сахиулах байгууллагын шударга байдалд ахиц гарахгүй байна гэсэн дүгнэлт хийж болно. Энэ нь нийгэмд шударга ёсны үзэл санаа төлөвшиж эхэлсэн, энэ талаар иргэдийн хүлээн авч буй мэдээ мэдээллийн урсгал нэмэгдсэн, олон нийт шударга байхыг хичээж, эрхэмлэж, төр засгаас шаардаж байгаагийн бодит үр дүн, илрэл гэж үзэж болохоор байна.

Авлигатай тэмцэх газарт 2016 онд ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой 329, авлигын гэмт хэргийн шинжтэй 985 өргөдөл, гомдол, мэдээлэл ирж байсан бол 2019 онд ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой 692, авлигын гэмт хэргийн шинжтэй 894 өргөдөл, гомдол, мэдээлэл ирж, 30 орчим хувиар нэмэгдсэн нь иргэн өөрт учирч байгаа хүндрэл, бэрхшээлийг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлдэг байх нийгмийн сэтгэлгээ, хандлага өсч байгаагийн нэг илрэл юм.

Нөгөө талаас, иргэд авлигад хүлцэнгүй хандах байдал 2016 оноос хойш буурсан эерэг дүр зураг ажиглагдаж буй бөгөөд 2016 онд судалгаанд оролцогчдын 40.4 хувь нь “тодорхой хэмжээний авлигыг хүлээн

зөвшөөрнө” гэдэгтэй “санал нийлэхгүй” гэж үзэж байсан бол 2017 онд 50.1, 2018 онд 54.7 хувь нь үүнтэй санал нийлэхгүй байгаагаа илэрхийлсэн байна. Эндээс үзэхэд иргэд, олон нийтийн зүгээс шударга ёсыг үнэт зүйлээ болгох, дээдлэх нийгмийн сэтгэлгээ, хандлагад ахиц гарч, аливаа асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх ёстой гэсэн хандлага илт харагдах болсон байна.

Төрийн үйлчилгээг цахимжуулах бодлогын хүрээнд төрийн цахим мэдээлэл солилцох системийг ашиглан цахим хэлбэрээр хүргэх төрийн үйлчилгээний жагсаалтад 38 байгууллагын 320 үйлчилгээг тусгасан боловч одоогийн байдлаар Монгол Улсын хэмжээнд үзүүлж буй 420 төрлийн үйлчилгээнээс иргэд зөвхөн 28 төрлийн үйлчилгээг цахимаар авч байна. Хэдий үр дүн багатай, хүлээлт ихтэй байгаа ч авлигыг бууруулах зорилтыг хэрэгжүүлэхийн тулд төрийн үйлчилгээг мэдээллийн технологи ашиглан иргэдэд хүргэх арга зам олон нийтээс тогтмол өндөр дэмжлэг, үнэлгээ авч байгааг судалгааны үр дүнгүүд харуулж байна. Энэ нь төрийн үйлчилгээг холбогдох хууль тогтоомжийн дагуу, ашиг сонирхлын зөрчилтэй түшмэдээс хамаарахгүйгээр, чөлөөтэй, нэмэлт төлбөр, хахууль, хураамж төлөхгүйгээр, чирэгдэлгүйгээр авах гэсэн иргэдийн эрэлт, хүсэлтийн илэрхийлэл юм.

Нэгтгэн дүгнэвэл, нийгэмд шударга ёсны үзэл санаа бүрэн төлөвших цаг хугацаа, нөхцөл байдал хараахан бүрдээгүй хэдий ч тодорхой хэмжээнд ажиглагдахуйц үр дүн гарсан, иргэн өөрт учирч байгаа хүндрэл, бэрхшээлийг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлдэг байх нийгмийн сэтгэлгээ, хандлага цаашид эерэг зүгт төлөвших, улмаар нийтийн соёл болох эхлэл тавигдсан гэж үзэж болохоор байна.

### **Ес. Хэвлэл мэдээллийн эрх зүйн орчин, сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүй, хариуцлага дээшилсэн байх үр дүнгийн талаар:**

Хэвлэл мэдээллийн эрх зүйн орчин, сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/233 тушаалаар Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсэг

байгуулан ажиллуулсан. Ажлын хэсэг Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, төслийн анхны хувилбарыг боловсруулж, Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хороо, Цагдаагийн ерөнхий газар, Хууль зүйн үндэсний хүрээлэн, МУИС-ийн Хууль зүйн сургууль, Хэвлэл мэдээллийн зөвлөл, Монголын Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл, “Глоб интернэшнл төв” зэрэг байгууллагын төлөөллийг оролцуулж, санал хүсэлтийг авч, хуулийн төсөлд тусгахаар ажиллаж байна.

Хэвлэл мэдээллийн ёс зүйн өөрийн зохицуулалтын байгууллага Монголын хэвлэл мэдээллийн зөвлөл нь сэтгүүл зүйн салбарт ёс зүйн төлөвшлийг хөгжүүлэх, сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын нийгмийн өмнө хүлээх хариуцлагыг сайжруулах зорилготой 2015 онд байгуулагдсан. 2015 оны 4 дүгээр сараас ёс зүйн зөрчилтэй сэтгүүл зүйн бүтээлийн эсрэг иргэдийн гомдлыг хүлээн авч байгаа бөгөөд 2015-2019 онд нийт 333 гомдлыг хүлээн авч шийдвэрлэсэн байна. Үүний зэрэгцээ 400 орчим иргэн, 600 гаруй сэтгүүлчтэй нүүр тулсан уулзалт, ярилцлага, сургалт хийж, хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт, ёс зүйн зарчмыг таниулан сурталчлах ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулжээ.

2002-2017 оны байдлаар 48 сэтгүүлч үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрхээ хэрэгжүүлсний төлөө эрүүгийн хуулиар шүүхэд дуудагдсан байдаг. Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс санаачлан эдгээр хэргүүдийг шүүх хэрхэн шийдвэрлэсэн болон зарим хэргүүдэд хараат бус судлаачаар нарийвчилсан дүн шинжилгээ хийлгэв. Авлигатай тэмцэх газар, Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс сэтгүүлчдийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлсөн, шахалт үзүүлсэн, занахийлсэн тоо баримтыг бүрдүүлэхээр нийслэл болон орон нутгийн 300 сэтгүүлчийн дунд санал асуулгын судалгааг явуулж, үр дүнг нэгтгэн гаргав.

Глоб интернэшнл төв, Монголын хуульчдын холбоо, Хэвлэл мэдээллийн зөвлөл хамтран Монгол дахь үзэл бодолтой байх, үзэл бодлоо илэрхийлэх эрхийн хэрэгжилтэд үнэлгээ өгөх, хэвлэл мэдээллийн өнөөгийн нөхцөл байдлыг тодруулах, сэтгүүлчдийн аюулгүй байдал ямар түвшинд байгааг тодруулах зорилгоор “Сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилтийн

мониторинг” 4 төрлийн бүлэг судалгааг 2019 онд хийж гүйцэтгэсэн.

Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэлээс сэтгүүлчийн эрхийг хангах, аливаа хууль бус нөлөөллөөс хамгаалах чиглэлээр өмгөөлөгчидтэй хамтран ажиллаж, Хэвлэл мэдээллийн зөвлөл, МСНЭ, “Глоб” интернэшнл Төв” ТББ, Монголын хэвлэлийн хүрээлэн, Өдөр тутмын сонинуудын холбоо, Монголын телевизүүдийн холбоо зэрэг 15 хэвлэл мэдээллийн байгууллага, мэргэжлийн холбоод хамтран УИХ-д өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд 6 дугаар зүйлийн 6.21 дэх хэсгийг хасуулах саналыг тусгуулсан.

Засгийн газраас боловсруулж, УИХ-д өргөн барьсан Эрүүгийн багц хуулийн төслийн 13.14 “гүтгэх” заалтын томъёолмыг өөрчлөхөөр саналаа УИХ-ын Хууль зүйн байнгын хороонд хүргүүлж, төсөлд тусгуулсан болно.

Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс сэтгүүлчийн ёс зүйг дээшлүүлэх зорилгоор Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим 1.1 дэх заалт (Мэдээлэл нь үнэнд нийцсэн эсэхийг баталгаажуулж, санамсаргүй алдаа гаргахаас зайлсхийнэ)-ыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хуурамч мэдээлэлтэй тэмцэхэд бодит хувь нэмэр оруулах зорилготой “Fact Check Mongolia” хөтөлбөрийг санаачилж, “Эрэн сурвалжлах сурвалжлагчдын төлөө төв”-ийн үйл ажиллагааг дэмжин ажиллаж байна.

### **Арав. “Транспарэнси Интернэшнл” байгууллагын Авлигын төсөөллийн индексийн судалгааны талаар:**

“Транспарэнси Интернэшнл” олон улсын төрийн бус байгууллагаас дэлхийн 180 орны төрийн албан дахь авлигын талаар шинжээч, бизнес эрхлэгчдийн төсөөлөлд үндэслэн Авлигын төсөөллийн индексийн 2019 оны дүнг гаргасан байна. Энэхүү индекс нь нэгдмэл аргачлал бүхий бие даасан судалгаа биш бөгөөд харин АНУ, ХБНГУ, Их Британи, Швейцар, Хонконгод байрлан үйл ажиллагаа явуулдаг 13 байгууллагын судалгаа, үнэлгээнээс авлига болон түүнд холбогдох хэсгийн үзүүлэлтийг сонгон авч тодорхой аргачлалаар индексийг тооцон улс орнуудыг эрэмбэлдэг аж. Индексийн дүнгээр Монгол Улс 2019 онд 35 оноо авч 106-д оржээ. Манай улсын индексийг тооцоход нийт 9 эх сурвалжийг ашигласан байна.



“Транспарэнси Интернэшнл” байгууллагын индексээр 2016 онд дэлхийн 176 улсаас Монгол Улс 38 оноогоор 87 дугаарт, 2017 онд 180 орноос 36 оноогоор 103 дугаарт, 2018 онд 180 орноос 37 оноогоор 93 дугаарт, 2019 онд 180 орноос 35 оноогоор 106 дугаарт эрэмбэлэгдсэн байна.

“Транспарэнси Интернэшнл” байгууллагын авлигын төсөөллийн индексийн үзүүлэлтийг авч үзвэл 2016 оноос 2019 онд 3 оноогоор буурсан, дэлхийд эрэмбэлэгдсэн дарааллаар 19 байраар ухарсан үзүүлэлттэй байна. Өмнөх жилээс оноо буурсан үзүүлэлтэд “Ай Эм Ди” байгууллагын Үзэл бодлын судалгаа 2019, “Дэлхийн эдийн засгийн форум”-ын Үзэл бодлын судалгаа 2019, “Дэлхийн банк”-ны Улс орны бодлого, институцийн үнэлгээ 2018 судалгаа, Ардчиллын олон талт байдлын төсөл, Бертелсман сан зэрэг байгууллагын индексийн дүн нөлөөлж, Монгол Улсын авлигын төсөөллийн индексийн үзүүлэлт буурсан дүнтэй байна.

### **Арван нэг. Төрийн байгууллагын шударга байдлын үнэлгээний талаар:**

Авлигатай тэмцэх газар нь Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-т заасны дагуу “авлигын хэлбэр, цар хүрээ, шалтгааныг 2 жилд нэгээс доошгүй удаа судлан авлигын индексийг гаргаж олон нийтэд мэдээлэх”, мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.7-д заасны дагуу “төрийн үйлчилгээ авсан иргэд, байгууллагын судалгаанд тулгуурлан төрийн байгууллагын шударга байдлын түвшинд 2 жил тутамд үнэлгээ гаргаж, олон нийтэд мэдээлэх” чиг үүргийг тус тус хэрэгжүүлдэг. Энэ хүрээнд төрийн байгууллагуудын Шударга байдлын үнэлгээг зохион байгуулдаг бөгөөд шударга байдлын үнэлгээний дундаж оноо 2016 онд 69.7, 2018 онд 68.7, 2019 онд 74.1 пункт байна.

Төрийн байгууллагын шударга байдлын үнэлгээ өсөхөд үйлчилгээ авсан иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөллийн үнэлгээ 8.4 пунктээр, шинжээчдийн үнэлгээ 5 пунктээр нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

### **Арван хоёр. Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээний авлигын төсөөллийн судалгааны дүнгийн талаар:**

Авлигатай тэмцэх газраас 2008 оноос хойш жил бүр “Улс төр, хууль хяналтын

байгууллагын хүрээнд дэх авлигын талаарх төсөөллийн судалгаа”-г зохион байгуулж үр дүнг танилцуулж ирсэн. 2017 он хүртэл улс төр болон шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээнд дэх авлигын талаарх төсөөллийг нэг судалгааны хүрээнд судалж, нэгтгэсэн тайланг гаргаж байсан бол 2018 оноос хоёр хүрээг тусад нь авч үзэн судалгааг гүйцэтгэж байна.

Улс төр, хууль хяналтын хүрээний авлигын түвшин 2016 онд 3.65, 2017 онд 3.97, улс төрийн хүрээнд дэх авлигын түвшин 2018 онд 3.93, 2019 онд 4.08, шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээнд дэх авлигын түвшин 2018 онд 3.68, 2019 онд 3.86 оноогоор үнэлэгдсэн байна.

Тус судалгааны хувьд үзүүлэлтийн утгыг “1-5” гэсэн оноогоор үнэлүүлэн тооцсон ба оноо буурах тусам эерэг утгыг илэрхийлж байгаа бол өсөх тусам сөрөг утгыг илэрхийлдэг.

Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээний авлигын төсөөлөлд эерэг өөрчлөлт гараагүй байна.

### **Авлигын эсрэг эрх зүйн орчинг сайжруулах чиглэлээр Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан баталж мөрдүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай хууль тогтоомж:**

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд авлигын эсрэг эрх зүйн орчинг сайжруулах чиглэлээр тусгасан боловч дараах арга хэмжээг эрчимжүүлж, холбогдох хууль тогтоомжийн төслийг хэлэлцэн батлах, зохих нэмэлт өөрчлөлтийг оруулах шаардлагатай байна. Тухайлбал,

- 1) Зөвшөөрөл, лицензийн тоог эрс цөөлөх, олон шат дамжлагыг багасгах зорилгоор Зөвшөөрлийн тухай хуулийн төслийг боловсруулах, зарим төрлийн зөвшөөрөл олгох, хяналт тавих чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх (ЗГХЭГ, ХЗДХЯ);
- 2) Концесс олгох уралдаант шалгаруулалт болон санал үнэлэх журмыг шударга, өрсөлдөөнтэй, үр дүнтэй, ил тод болгох талаарх зохицуулалтыг шинэчлэн боловсруулах (ҮХГ);
- 3) Төрийн аудитын байгууллагын зөвлөмжийг үр дүнтэй хэрэгжүүлэх эрх зүйн орчинг бий болгох (ХЗДХЯ);

- 4) Олон улсын стандарт хангасан бараа, бүтээгдэхүүнийг дотоодын стандартаар шалгадаг зохицуулалтыг өөрчлөх (СХЗГ, ХЗДХЯ)
- 5) Стандартын тоог цөөрүүлэх, шаардлагагүй стандартыг хүчингүй болгох, Олон улсын стандарт хангасан бараа, бүтээгдэхүүнийг дотоодын стандартаар шалгадаг зохицуулалтыг өөрчлөх(СХЗГ, ХЗДХЯ);
- 6) Банкны зээлийн бодлого, түүний журмыг боловсронгуй болгох, зээл авагч, зээлдүүлэгчийн тэгш байдлыг хангасан эрх зүйн орчинг бүрдүүлэх (Монгол банк);
- 7) Төсвийн хяналтын сонсголын журмыг боловсруулж батлуулах (СЯ);
- 8) Төрийн аудитын байгууллагын зөвлөмжийг үр дүнтэй хэрэгжүүлэх эрх зүйн орчинг бий болгох (ХЗДХЯ, УАГ);
- 9) Мэдээлэл өгсөн иргэнийг урамшуулах тогтолцоог бүрдүүлэх (АТГ, ХЗДХЯ);
- 10) Хууль бус нөлөөлөл үзүүлсэн этгээдэд хариуцлага хүлээлгэх тогтолцоог боловсронгуй болгох (ЗГХЭГ);
- 11) Хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төсөлд авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр санал, зөвлөмж гаргах тогтолцоог бүрдүүлэх (АТГ, ЗГХЭГ);
- 12) Төрөөс олгодог зарим зөвшөөрөл, бүртгэл, эрх олгох үйл ажиллагааг хувийн хэвшилд шилжүүлэх асуудлыг судалж, шилжүүлж болох үйлчилгээний жагсаалт гарган хэрэгжүүлэх (ҮХГ, ЗГХЭГ, СЯ, АТГ);
- 13) Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах (ШӨХТГ, ШСАА);
- 14) Өрсөлдөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах (ШӨХТГ, ШСАА);
- 15) Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах (ШӨХТГ, ШСАА);
- 16) Төрийн байгууллага, албан тушаалтнаас зах зээлийн өрсөлдөөнд нөлөөлсөн, аль нэг аж ахуйн нэгжид давуу байдал олгосон шийдвэр, үйл ажиллагаа явуулах боломжийг хязгаарласан эрх зүйн орчинг сайжруулах (ШӨХТГ);
- 17) Эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хангах талаарх эрх зүйн орчинг бүрдүүлэх асуудлыг судалж, шийдвэрлүүлэх (ҮҮХҮЯ);
- 18) Шийдвэр гаргах шатанд иргэний нийгмийн оролцоо, хяналтын талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэд үнэлгээ хийх ажлыг төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулах (АТГ, яам, агентлаг, аймаг, нийслэл дэх ГХУСАЗСЗ);
- 19) Төрийн бодлого, шийдвэр гаргахад нийгмийн сонирхлын бүлэг, иргэний оролцоог хангах эрх зүйн зохицуулалтыг бий болгох (ХЗДХЯ)
- 20) Улс төрийн хариуцлагыг дээшлүүлэх, ил тод байдлыг хангахад иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр олон улсын туршлагыг судлан эрх зүйн орчныг боловсронгуй болгох (ХЗДХЯ);
- 21) Улс төрийн намын тухай хуулийг боловсронгуй болгох, улс төрийн намын санхүүжилт, улс төрийн намуудын санхүүгийн үйл ажиллагаанд төрийн болон олон нийтийн зүгээс хяналт тавих зохицуулалтын эрх зүйн орчинг сайжруулах (ХЗДХЯ, Улс төрийн намууд);
- 22) Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн, зөрчил гаргасан төрийн өндөр албан тушаалтны эрхийг түдгэлзүүлэх, огцруулах, эгүүлэн татах эрх зүйн орчинг бүрдүүлэх (ХЗДХЯ, АТГ);
- 23) Улс төрийн намын дарга, удирдах албан тушаалтны хөрөнгө, орлогын байдалд хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх (АТГ);
- 24) Гэмт хэргийн улмаас гадаад улсад гарсан хөрөнгийг буцаан авахтай холбоотой асуудлыг судлан Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн үзэл баримтлалд нийцүүлэн дотоодын хууль тогтоомжийг боловсронгуй болгох (ХЗДХЯ, ГХЯ, АТГ);
- 25) Хэвлэлийн эрх чөлөөний хуулийг шинэчлэн боловсруулж, эрх зүйн орчинг сайжруулах (ХЗДХЯ);
- 26) Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд аливаа нийтлэл, нэвтрүүлэг, зар сурталчилгаа, мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэхтэй холбоотой ажлаа ил тод мэдээлэх, гүйцэтгэгчийг нээлттэй сонгон шалгаруулах эрх зүйн орчинг бүрдүүлэх (ХЗДХЯ, МСНЭ, Хэвлэл мэдээллийн зөвлөл).




## Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн нэг дэх үе шатны хэрэгжилтийн байдалд хийсэн үнэлгээний нэгдсэн дүн:

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд улсын төсвөөс санхүүжүүлэхээр тусгагдсан төсвийг жил бүр бүрэн баталж өгөх нь чухал ач холбогдолтой юм. Авлигатай тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд буй 216 арга хэмжээний 205 нь хөтөлбөрийн эхний үе шат буюу 2017-2019 онд хэрэгжихээр, нэг дэх үе шатны арга хэмжээг хэрэгжүүлэхэд улсын төсвөөс 14,3 тэрбум төгрөгийг зарцуулахаар тусгагдсан бөгөөд үүнээс 21,4 хувийг шийдвэрлэж санхүүжүүлсэн болно.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явц байдлын хяналт-шинжилгээ, үнэлгээг хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагуудын тайлан, тэдгээртэй холбоотой баримт бичгүүд, үр дүнг нотлох холбогдох материалуудыг ашиглан гүйцэтгэсэн. Үйл ажиллагаа, арга хэмжээний биелэлтэд үнэлгээ өгөхдөө:

- **“Төлөвлөсөн үр дүнд хүрсэн”** – зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, хүрэх түвшиндээ бүрэн хүрсэн, зохион байгуулалт сайн, бодит үр дүн гарсан бол 100 хувь (90 – 100 хүртэл хувь);

- **“Тодорхой үр дүнд хүрсэн”** – зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, хүрэх түвшиндээ бүрэн хүрээгүй боловч тодорхой үр дүн гарсан, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, дээд шатны байгууллагад өргөн барьсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай бол 70 хувь (50 – 89 хүртэл хувь);
- **“Эрчимжүүлэх шаардлагатай”** – зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, хүрэх түвшиндээ хүрээгүй боловч тодорхой үр дүн гарах нөхцөл бүрдсэн, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай бол 30 хувь (10 – 49 хүртэл хувь);
- **“Үр дүн хангалтгүй”** – зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж дууссан боловч шалгуур үзүүлэлт, хүрэх түвшиндээ хүрээгүй, төсөв хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй, зохион байгуулалт хангалтгүй бол 0 хувь (0 – 9 хүртэл хувь) байхаар тооцсон болно.





**Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний  
төлөвлөгөөний нэг дэх үе шатны биелэлт (Статистик мэдээ)**

№	Хөтөлбөрийн зорилт	Үйл ажиллагаа	Нийт арга хэмжээний тоо	I үе шат арга хэмжээ	Хэрэгжилтийн үнэлгээ				Дундаж хувь
					100	70	30	0	
1.	Зорилт №1	10	26	25	17	7	1	-	<b>88.8</b>
2.	Зорилт №2	7	18	16	5	6	5	-	<b>66.9</b>
3.	Зорилт №3	10	35	35	2	20	12	1	<b>56</b>
4.	Зорилт №4	5	15	15	9	1	2	3	<b>68.7</b>
5.	Зорилт №5	17	34	34	4	17	13	-	<b>58.2</b>
6.	Зорилт №6	5	21	18	1	8	8	1	<b>50</b>
7.	Зорилт №7	6	18	14	3	7	4	-	<b>65</b>
8.	Зорилт №8	5	9	8	-	3	3	2	<b>37.5</b>
9.	Зорилт №9	8	17	17	1	4	6	6	<b>32.9</b>
10.	Зорилт №10	5	10	10	-	3	7	-	<b>42</b>
11.	Зорилт №11	5	13	13	-	8	5	-	<b>54.6</b>
<b>Нийт</b>		<b>83</b>	<b>216</b>	<b>205</b>	<b>42</b>	<b>84</b>	<b>66</b>	<b>13</b>	<b>58,8</b>

**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР**



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ, АВЛИГЫН ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ-2019,  
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ ( I ҮЕ ШАЛ )